

SPSIRPA FORUM 2024

Geopolitical Restructuring: Regional Issues and Policy Affairs Conference Proceedings

Date

2024.05.24-25 / 09:00-18:45

Venue:

Consensus Hall, Ministry of Foreign Affairs of Mongolia

Meeting Hall 502, Central Library of NUM

Meeting Hall 203, NUM Building 5

Host

School of Political Science, International Relations and Public Administration, NUM

Minister of Foreign Affairs of Mongolia

Mongolian National University of Education

School of Arts and Sciences, NUM

University of Internal Affairs, Mongolia

OPENING REMARKS

Venue: Consensus Hall, Ministry of Foreign Affairs of Mongolia

- 09:00-09:10 **Munkhbat S.**
Dean, School of Political Science, International Relations and Public Administration, NUM
- 09:10-09:20 **Battsetseg B.**
Minister of Foreign Affairs of Mongolia
- 09:20-09:30 **Odbayar E.**
Foreign Policy Adviser to the President of Mongolia
- 09:30-09:40 **Zayabaatar D.**
Dean, School of Arts and Sciences National University of Mongolia

KEYNOTE SPEECHES

- 09:20-09:40 **“Multilateral cooperation: Regional issues”**
Odbayar E. / Munkhbat S. Dean, NUM, SPSIRPA / Foreign Policy Adviser to the President of Mongolia
- 09:40-10:00 **“The Regional Collaboration of Future Research: The Case of the Center for Future HRM Studies”**
Lee Jin-Kyu Business School of Korea University and Center for Future HRM Studies, Korea
- 10:00-10:20 **“Building the Image of China as a ‘Responsible Major Country’ in Advanced Economies: Did Beijing’s Covid-19 Aid Campaign Work?”**
Lauri Paltemaa / Herman Aubie / Tommi Sookari Centre for East Asian Studies, University of Turku, Finland

Coffee break

KEYNOTE SPEECHES

- 10:40-11:00 **“Changing global geopolitical environment: impact on Mongolia”**
Bayasgalan S. School of Political Science, International Relations and Public Administration, NUM
- 11:00-11:20 **“Deliberative Democracy and Constitutional Reform in Mongolia”**
ONLINE James Fishkin Stanford University, USA
- 11:20-11:40 **“Navigating the new global landscape: the resurgence of state intervention in economics and the rebirth of industrial policy”**
Stefan Hanselmann Honorary doctor causa of NUM, Program of ICONES Cluster Coordinator Economic Development & Private Sector Promotion Programme Office Siem Reap, Cambodia
- 11:40-12:00 **“Israel and the Middle East: In Turbulent Times”**
P R Kumaraswamy Centre for West Asian Studies, School of International Studies, JNU, India

12:00-12:30 Panel discussion

12:30-13:45 Lunch (Bluesky restaurant)

14:00-18:00 Sessions conference

- Session 1: **Honorary doctorate degree award ceremony**
- Session 2: **Foreign policy, diplomacy, geopolitics (1)**
- Session 3: **Foreign policy, diplomacy, geopolitics (2)**
- Session 4: **Economic, regional relations and cooperation (1)**
- Session 5: **Economic, regional relations and cooperation (2)**
- Session 6: **Cultural, humanitarian, social and legal relations (1)**
- Session 7: **Cultural, humanitarian, social and legal relations (2)**
- Session 8: **Public policy**
- Session 9: **Public administration**

Venue:

- Meeting Hall 320, NUM Central Building 1
- Meeting Hall 502, Central Library of NUM
- Meeting Hall 303, Central Library of NUM
- Meeting Hall 202, Central Library of NUM
- Meeting Hall 302, Central Library of NUM
- Meeting Hall 103, NUM Building 5
- Meeting Hall 205, NUM Building 5
- Meeting Hall 203, NUM Building 5
- Meeting Hall 303, NUM Building 5

18:15-18:45 Closing remarks (Meeting Hall 502, NUM Central Library)

Эрхэм хүндэт эрдэмтэн судлаачид, зочид төлөөлөгчид өө

Эрхэм хүндэт Гадаад харилцааны сайдаа

Ноёд, хатагтай нараа

Та бүхэндээ энэ өдрийн мэндийг дэвшүүлье.

МУИС-ийн Улс төр судлал, олон улсын харилцаа, нийтийн удирдлагын сургуулиас жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “SPSIRPA FORUM” энэ жил оролцогчид болон хамтран зохион байгуулагчдын хувьд хүрээгээ тэлж, олон орны судлаачид, их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагыг хамруулан хийгдэж байгаагаараа онцлогтой болж байна.

Энэхүү олон улсын эрдэм шинжилгээний хурлыг эхнээс нь дэмжин өөрийн биеэр оролцон, Гадаад харилцааны яамны Зөвшилцөл танхимд нээлтийн нэгдсэн хуралдааныг зохион байгуулах боломжийг олгосон Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Гадаад харилцааны сайд Батмөнхийн Батцэцэг Таныд хуралд хүрэлцэн ирсэн гадаад, дотоодын эрдэмтэн судлаачид, оролцогчдынхоо нэрийн өмнөөс гүн талархал илэрхийлж байна.

Мөн энэхүү хуралд хүрэлцэн ирж мэндчилгээ дэвшүүлэхийн зэрэгцээ илтгэл хэлэлцүүлэн оролцож байгаа Монгол Улсын Ерөнхийлөгчийн Гадаад бодлогын зөвлөх Э. Одбаяр Таныд хуралд оролцогчдынхоо нэрийн өмнөөс гүн талархал илэрхийлье.

Дэлхийн улс төр, олон улсын харилцаа ээдрээтэй, их гүрнүүдийн бодлогын сөргөлдөөн түүнийг дагасан геополитикийн шинэ дэг жаяг тогтох хандлагтай байгаа энэ үед “Геополитикийн дахин хуваарилалт: бүс нутгийн тулгамдсан асуудал ба төрийн бодлого” сэдвийн дор зохион байгуулагдаж байгаа нь энэхүү олон улсын эрдэм шинжилгээний хурлын практик ач холбогдлыг илтгэн харуулна гэж дүгнэж болохоор байна.

Энэхүү олон улсын эрдэм шинжилгээний хуралд дэлхийн 12 орны 22 их сургууль, эрдэм шинжилгээний байгууллагын эрдэмтэн судлаачид Гадаад бодлого, дипломат харилцаа, Геополитик, Бүс нутгийн эдийн засгийн харилцаа, хамтын ажиллагаа, Соёл, нийгэм, хүмүүнлэгийн хамтын ажиллагаа, Төрийн бодлого, Нийтийн удирдлага гэсэн чиглэлүүдээр 9 салбар хуралдаанд хуваарилагдаж нийт 62 илтгэл хэлэлцүүлнэ. Хуралдаанаас гарсан зөвлөмж, үр дүнг төрийн байгууллагад хүргэж, эрдэм шинжилгээ, судалгааны эргэлтэд оруулан нийтийн хүртээл болгох ажлыг цаашид бид зохион байгуулж ажиллах болно.

Төгсөлд нь эрдэм шинжилгээ судалгааныхаа үр дүнг хэлэлцүүлж, харилцан мэдээлэл солилцох, шинжлэх ухааны дипломат харилцааг өргөжүүлэн хөгжүүлэх зорилгоор хүрэлцэн ирсэн гадаад, дотоодын эрдэмтэн судлаачиддаа баяр хүргэж, хурлын үйл ажиллагаанд амжилт хүсье.

Анхаарал хандуулсан Та бүхэнд баярлалаа.

Эрхэм хүндэт зочид оо,

Эрдэмтэн судлаач, багш профессорууд аа,

Эрхэмсэг хатагтай, ноёд оо

Юуны өмнө Монгол Улсын Их Сургуулийн Улс төр судлал, Олон улсын харилцаа, Нийтийн удирдлагын Сургуулиас жил бүр зохион байгуулдаг “SPSIRPA FORUM” олон улсын хуралд хүрэлцэн ирсэн Та бүхэнд халуун мэндчилгээ дэвшүүлж, чин сэтгэлийн талархал илэрхийлж байгааг минь хүлээн авна уу.

Энэхүү олон улсын хурал нь дэлхийн бодлогын цаг үеийн тулгамдсан асуудлуудыг хэлэлцдэг эрдэм шинжилгээний өндөр ач холбогдолтой уламжлалт арга хэмжээ болон хөгжиж байна. Энэ жилийн “SPSIRPA FORUM 2024” нь "Геополитикийн дахин хуваарилалт: Бүс нутгийн тулгамдсан асуудлууд ба төрийн бодлого" сэдвийн дор нийт 12 орны эрдэмтэн судлаачдын оролцоотойгоор зохион байгуулагдаж байгааг тэмдэглэхэд таатай байна.

Цар тахлын хүндхэн сорилтуудын дараа олон улсын харилцаанд үүсээд буй нэн ээдрээтэй орчин, зэвсэгт мөргөлдөөнүүд, томоохон улс гүрнүүд хоорондын талцал, хуваагдал гүнзгийрч, дэлхий дахин, бүс нутгийн хэмжээнд цоо шинэ нөхцөл байдал бий болсон нийгэм, улс төр, эдийн засгийн амаргүй цаг үе тохиож байна.

Өнөөдрийн хурлаар нэн эрчимтэй өөрчлөгдөж буй дэлхийн шинэ нөхцөл байдал, геополитикийн болон бүс нутгийн тулгамдсан өргөн хүрээтэй асуудлууд, Монгол Улсын гадаад орчин, цаашдын чиг хандлагын талаар хэлэлцүүлэг өрнүүлж, шийдвэрлэх арга замыг эрэлхийлэн, санал зөвлөмж дэвшүүлэхээр үндэсний болон гадаадын эрдэмтэн судлаачид нэгдэн цуглараад байгаад миний бие нэн баяртай байгааг илэрхийлье.

Монгол Улс Гадаад бодлогын үзэл баримтлалын “энхийг эрхэмлэсэн, нээлттэй, бие даасан, олон тулгуурт” суурь зарчмыг тууштай баримталж, байр сууриа боловсруулж, түүнийгээ хоёр хөрш болон гуравдагч хөрш улс орнуудад ойлгуулж, тэнцвэртэй харилцаж, НҮБ болон олон улсын бусад байгууллагын хүрээнд байр сууриа хадгалахын сацуу олон улсын тавцанд эрчимтэй, идэвхтэй ажиллахыг эрмэлзэж байна. Үүний дагуу өнгөрсөн хугацаанд олон чухал айлчлал хэрэгжүүлж, арга хэмжээ зохион байгуулсан.

Тухайлбал, “Гадаад хэргийн эмэгтэй сайд нарын уулзалт”-ыг 2023 онд Улаанбаатар хотноо амжилттай зохион байгууллаа. Ази тивд, тэр дундаа Монгол Улсад анх удаа зохион байгуулагдсан энэхүү уулзалт нь манай улсыг өөр нэгэн өнцгөөр дэлхий дахинд таниулах, улмаар бидний баримталж ирсэн энхийг эрхэмлэсэн, нээлттэй, бие даасан, олон тулгуурт гадаад бодлогыг сурталчлан ойлгуулахад ихээхэн ач холбогдолтой болсон. Энэхүү хуримтлуулсан туршлага, ололт амжилтдаа тулгуурлан цаашид бид жил болгон эмэгтэйчүүдийн үүрэг оролцоо, тэгш эрхийн сэдвээр өндөр түвшний арга хэмжээ зохион байгуулж, 2024 оны 8 дугаар сард “Дэлхийн эмэгтэйчүүдийн чуулга уулзалт”-ыг Монгол Улсад зохион байгуулах чиглэлээр холбогдох бэлтгэлийг хангаж байна.

НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Антонио Гутерреш 2022 онд Монгол Улсад айлчилж, манай улсыг “энх тайвны бэлэг тэмдэг” хэмээн тодорхойлж байсан бол 2023 онд Гэгээн Ширээт Улсын Төрийн тэргүүн Пап Францис Монгол Улсад хийсэн түүхэн айлчлалынхаа үеэр манай улсыг “оюун санаа, шашин шүтлэгийн эрх чөлөөний бэлэг тэмдэг” хэмээн тодорхойлсныг онцлон тэмдэглэмээр байна.

Б.БАТЦЭЦЭГ

ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД

...

Энэ бүгд нь манай улсын хэрэгжүүлж ирсэн бодлого, үйл ажиллагаа олон улсын хамтын нийгэмлэгт өндрөөр үнэлэгдэж, нэр хүнд өсөн нэмэгдсэний тод илрэл юм.

Түүнчлэн Монгол Улс НҮБ-ын гишүүн бүх улстай дипломат харилцаа тогтоох зорилгоо 2023 онд бүрэн хэрэгжүүлж дууссаныг тэмдэглэхэд таатай байна.

Орчин үеийн Монголын анхны мэргэжлийн дипломатуудын нэг Мангалын Дүгэрсүрэнгийн нэрэмжит МУИС-ийн Улс Төр Судлал, Олон Улсын Харилцаа, Нийтийн Удирдлагын Сургууль нь гадаад албаны мэргэжилтэн бэлддэг үндэсний хэмжээний сургууль билээ. Тус сургуулиас Монголын төр, нийгмийг манлайлагч олон зуун зүтгэлтнүүд, түүний дотор улсаа хилийн чанадад төлөөлөн суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд нар, чадварлаг дипломатууд, олон улсын байгууллагын ажилтнууд олноор төржээ. Миний бие мөн тус сургуульд сурч төгссөндөө гүнээ баяртай байдгийг энэ ташрамд тэмдэглэе.

Ингээд энэ удаагийн “SPSIRPA FORUM 2024” олон улсын эрдэм шинжилгээний хуралд өндөр амжилт, хуран цугларсан та бүхэнд эрүүл энх, ажил хөдөлмөрийн өндөр амжилт, сайн сайхныг хүсэн ерөөе.

Анхаарсанд баярлалаа.

KEYNOTE SPEECHES

“Mongolia's multilateral diplomacy: Some issues of theory and practice.” Odbayar E. / Munkhbat S. Foreign Policy Adviser to the President of Mongolia / Dean, NUM, SPSIRPA	15
“The Regional Collaboration of Future Research: The Case of the Center for Future HRM Studies” Lee Jin-Kyu Business School of Korea University and Center for Future HRM Studies, Korea	34
“Building the Image of China as a ‘Responsible Major Country’ in Advanced Economies: Did Beijing’s Covid-19 Aid Campaign Work?” Lauri Paltemaa / Herman Aubie / Tommi Sookari Centre for East Asian Studies, University of Turku, Finland	56
“Changing global geopolitical environment: impact on Mongolia” Bayasgalan S. School of Political Science, International Relations and Public Administration, NUM	
“Deliberative Democracy and Constitutional Reform in Mongolia” James Fishkin Stanford University, USA	
“Navigating the new global landscape: the resurgence of state intervention in economics and the rebirth of industrial policy” Stefan Hanselmann Honorary doctor causa of NUM, Program of ICONE Cluster Coordinator Economic Development & Private Sector Promotion Programme Office Siem Reap, Cambodia	64
“Israel and the Middle East: In Turbulent Times” P R Kumaraswamy	

SESSION 1 Honorary doctorate degree award ceremony

Geopolitical Implications for Mongolia's Expansion of Strategic Third Neighbour Partnership Sharad K Soni Jawaharlal Nehru University, New Delhi (India)	74
Indian Studies in Mongolia: A Review of Researchers and Their Works Jamiyan Battur Associate Professor, SPSIRPA, National University of Mongolia	89
"The multiculturalism and expansion-relationship of Korea and Mongolia" Chung Hark Serp	99

SESSION 2 Foreign policy, diplomacy, geopolitics (1)

"The security environment of Northeast Asia and the development of Japan's foreign policy" Battulga S. School of Science, NUM	
"The process of geopolitical change: analysis of central regional theory" Bazarpurev S. / Evsanaa Sh. School of Political Science, International Relations and Public Administration, NUM / School of Economics and Social Science, University of Internal Affairs	115
"Museum diplomacy in soft power politics: The case of China" Tshahinaa N. / Oyunsuren S. / Battsetseg A. School of Political Science, International Relations and Public Administration, NUM	125
"A Comparative Analysis for the Issues of Representative Democracy: case of Mongolia and other countries" Turtogtokh Janar / Tuyagerel Ganbat School of Political Science, International Relations and Public Administration, NUM	
"Digital Persuasion: Unveiling the Impact of Social Media Marketing on Electoral Choices in Indonesia" Massoud Moslehpour / Munkh-Ulzii B. California State University, San Bernardino, CA, USA, Asia University, Taiwan / School of Political Science, International Relations and Public Administration, NUM	135
"Global geopolitical change in the post-Covid era" Dolgorsuren D. / Shinebayar School of Political Science, International Relations and Public Administration, NUM	161
"United Kingdom's Indo-Pacific Policy and Mongolia" Anudari T. Institute of international studies, Science Academy	

SESSION 3 Foreign policy, diplomacy, geopolitics (2)

"Is the political alienation in Mongolia different from the international context?"	168
Turtogtokh Janar / Urtnasan Dagiidamba	
School of Political Science, International Relations and Public Administration, NUM	
<hr/>	
"Immanuel Kant's " Perpetual Peace " and idealistic ideas in international relations"	181
Myagmardorj P.	
University of Humanity of Mongolia, School of International Relations and Social Studies	
<hr/>	
"Impact of soft power policy of regional powers on Mongolia"	
Baasankhuu G.	
School of Political Science, International Relations and Public Administration, NUM	
<hr/>	
"Mongolia's participation in ensuring regional security"	
Munkh-Orgil T. Defense Research Institute	
<hr/>	
"Analyzing China's Neighborhood Diplomacy and Sino-Mongolian Relations from Multilateral Perspectives"	
Shurentana /Institute of Mongolian studies, Inner Mongolian University/	
<hr/>	
"Mongolia-Russia border relations and the evolution and changes of the regional geopolitical environment"	198
Tsatsral P. /University of Internal Affairs/	
<hr/>	
"Reform of the parliamentary electoral system of Mongolia: The pros and cons"	
Myagmartsooj N. / Gerelt-Od E. Mongolian National University of Education	
<hr/>	

SESSION 4 Economic, regional relations and cooperation (1)

“Beyond Western modernization way: China's improvement of modernization and its meaning for global development”	218
“China's Impact on Mongolian Economy” Wing-Keung Wong Department of Finance, College of Management, Asia University Department of Economics and Finance, The Hang Seng University of Hong Kong	222
“China's energy policy and strategy implemented within the framework of the commitment to reduce greenhouse gases” Shinechimeg Kh. Institute of Energy Economics of Mongolia	256
“The possibility of developing the eastern corridor of Mongolia (on the example of China, Mongolia, and Russia)” Battsetseg A. / Narantungalag School of Political Science, International Relations and Public Administration, NUM	
“Impact of economic sanctions on FDI” Unurmaa D. / Batchimeg School of Political Science, International Relations and Public Administration, NUM	
“Evolution of Belt and Road Initiative in the context of Confucian political economy and neoliberalism” Xiaoyu Jin / Munkh-Ulzii B. School of Political Science, International Relations and Public Administration, NUM	258
“Impact of climate change in Mongolia” Narantungalag B. /School of Sciences, NUM/	

SESSION 5 Economic, regional relations and cooperation (2)

“Research on the path of integrated tourism development between China and Mongolia in the Northeast Asian region”	270
<hr/>	
“Some problems of increasing the efficiency of the national innovation system” Lhamsuren P. School of Science, NUM	
<hr/>	
“Brics ascendancy: challenging western hegemony in a globalized world” Antony D. Miller, Zurich Department of International Relations and Journalism, Otgontenger University, Mongolia	281
<hr/>	
“Positive factors for further development of trade and economic cooperation between China and Mongolia within the framework of "Belt and Road"” Khujilt B. Inner Mongolian University, Institute of Mongolian studies	303
<hr/>	
“Development of multilateral humanitarian relations between China and Mongolia in accordance with the "Belt and Road" initiative” Dolood Khaskhuu Inner Mongolian University, Institute of Mongolian studies	311
<hr/>	
“The current status of China-Mongolia cooperation in combating desertification, problems and solutions” Mungunsan Inner Mongolian University, Center for Chinese Ethnology	322
<hr/>	
“БНСУ-ын экспортыг дэмжих бодлого: санхүү, татварын арга хэрэгслүүд” Myagmar D. Institute of international studies, Science Academy	327
<hr/>	

SESSION 6 Cultural, humanitarian, social and legal relations (1)

“Risk Communication during the Pandemic: A Comparative Study of Mongolia and Japan”

Battulga S. / Yumiko Nara

School of Science, NUM / Open University Japan

“The influence of cities on international relations and the formation of international law. Experiences of selected European and Asian cities”

Michał Dahl /Nicolaus Copernicus University, Poland/

“US-Mongolia Education Programs and Outcomes”

Budsuren D.

School of Political Science, International Relations and Public Administration, NUM

“International exchange and cooperation in higher education within the framework of ChinaMongolia comprehensive strategic partnership: policy, practice, and achieved results”

Yaruu

339

Inner Mongolian University, Institute of Mongolian studies

“The complex geopolitics of language and literacy reform in mongolia”

Sumiya Ch.

346

Climate Change, Energy Technology and Innovation Center of Mongolia and China

“Socio-economic dynamics in Eurasia: The cost-of-living crisis and policy responses in Mongolia, Russia and Kazakhstan”

356

Esuna Dugarova /Columbia University/

SESSION 7 Cultural, humanitarian, social and legal relations (2)

“European security and end of neutrality status of international law”

370

Ulambayar D.

“Mongolia and Europe: mapping migration and cultural exchange”

Francesca Fiaschetti

Mongolia Cluster, Vienna University

“The Development of The Field of Mongolian Studies in Iraq”

385

Abdulrahman Farttoos Haider /College of Arts of University of Baghdad/

“Employment of disabled youth”

Ariunbileg S.

School of Political Science, International Relations and Public Administration, NUM

“Internationalization of Asian universities: difficulties, opportunities and ways facing Mongolia”

395

Zolzaya G.

SESSION 8 Public policy

“Public policy” Burmaa Natsag	406
“Civil service resilience as one of the guarantees of stability of states in the face of current challenges ” Wojciech Federczyk Faculty of Law and Administration of Cardinal Stefan Wyszyński University /	426
“Generational value differences in public administration organization” Myagmar Ganbat School of Political Science, International Relations and Public Administration, NUM	432
“Implementation of the ISO 9001:2015 quality management standard in local public government organizations: comprehensive competences of civil servants” Ganchimeg Tugsuu	448
“Results of agricultural subsidies provided by the Government of Mongolia” Otgontsetseg Badarch Public Administration Management Department, the Ministry of Education and Science of Mongolia	467
“Opportunities to improve service access of art and culture organizations: in the example of Mongolian National Art Gallery” Otgonchimeg Myagmar /Mongolian National Art Gallery/	478

SESSION 9 Public administration

“The constitution amendment of Mongolia: Issue and solution”	
Amarjargal Peljid	496
School of Political Science, International Relations and Public Administration, NUM	
“Some challenges on executive governance: Case of Mongolian Government”	
Amartugs Tsendavaa	507
Permanent Member of the Civil Service Council of Mongolia	
“The consideration time challenges on activities of police human resources management”	
Gantuul Ayurzana	511
Academy of Management, University of Internal Affairs, Mongolia	
“Opportunities to improve quality of agriculture raw materials using traceability system in Mongolia”	
Batkhuu Banzai	525
Research and Development Center, the Ministry of Food, Agriculture of Mongolia	
“Mongolia’s human resource policy in the forest sector – prospects”	
Battsetseg Batjargal	548
Administration and Finance Department, the Office of the President of Mongolia	
“Participation and control of citizens in local self-government”	
Ariunbold Tumur	560
Ulaanbaatar City Council, Mongolia	
“Human resource audit in the public sector (on the example of Umnugovi aimag)”	
Munguntuul Tavkhaikhuu	583
Department of Culture and Art of Umnugovi Province	

POSTER PRESENTATIONS: Foreign policy, diplomacy, geopolitics

"Indo-pacific strategy and the transformations and challenges in mongolia's third neighbor policy"

Tenges J. / Bayasgalan S.

School of Political Science, International Relations and Public Administration, NUM

"The Influence of Culture and Personality on Small Country Diplomacy: A Case Study of Mongolia"

Ayslan Khomushku / Munkh-Ulzii Batmunkh

593

School of Political Science, International Relations and Public Administration, NUM

"Characteristics of China's Soft Power Policy"

Uyanga D. / Battur J.

609

School of Political Science, International Relations and Public Administration, NUM

POSTER PRESENTATIONS: Economic, regional relations and cooperation

"Cooperation between Mongolia-China border ports during the Covid-19 pandemic: On the geoeconomic example of the Zamyin-Uud port"

Ulzii Z. / Munkh-Ulzii B.

622

School of Political Science, International Relations and Public Administration, NUM

"Gulf Cooperation Council, policies and activities in the region"

Mend Z. /Institute of International Studies, Mongolian Academy of Sciences/

637

POSTER PRESENTATIONS: Political Science

"Issues related to the introduction of the mechanism of consultative democracy in Mongolian public policy"

Bolorttuya B. School of Political Science, International Relations and Public Administration, NUM

POSTER PRESENTATIONS: Public administration

"Certain ways to enhancing government productivity (on the example of performance audit)"

Chimedlkam Bayarsaikhan

647

Small Medium Enterprise Agency of Mongolia

"Public service values"

Tsetsenbileg Doosmaa

663

"Life Strategy" Program Initiator and Strategy Analyst

"Enhancing governance effectiveness on local administration"

Oyunbold Boldbaatar

679

Secretary of the Citizens' Representative Khural of Bulgan Province of Mongolia

SPSIRPA FORUM 2024

Keynote speeches 1

International relations theory and Multilateral diplomacy



**Олон улсын харилцааны онол ба
олон талт дипломат ажиллагаа**
(International relations theory and Multilateral diplomacy)

Э.Одбаяр, С.Мөнхбат

Хураангуй.

Олон улсын харилцааны онолын дэг сургуулиуд олон улсын харилцаанд өрнөж буй үйл явдалд дүн шинжилгээ хийх замаар дэлхийн бодлогыг тайлбарлахыг зорьдог. Реалист онолчид үндэсний эрх ашгаа гол болгосон улсуудын хоорондын харилцаанд хямрал мөргөлдөөн байнгын шинжтэй хэмээн үздэг болон идеалист онолчид энэхүү эмх замбараагүй байдлыг олон улсын эрх зүй, олон талт дипломат ажиллагааны үр дүнд зохицуулж болно хэмээн нотлодог. Олон улсын харилцааны идеалист болон неолибераль буюу либераль-институционалист онолын дэг сургуулийн төлөөлөгчдийн хийсэн судалгааны ажлын дүгнэлтүүдээс харахад олон талт дипломат ажиллагааны онолын сэтгэлгээний суурь нь яах аргагүй идеалист болон неолибераль онолын дэг сургууль болох нь энэхүү судалгааны ажлаар тодорхой болж байна. Нөгөөтэйгүүр хоёр их гүрний дунд байрладаг, эдийн засгийн хувьд хөршүүдээсээ ихээхэн хамааралтай Монгол улсын хувьд олон талт дипломат ажиллагааны талбар нь үндэснийхээ эрх ашигт нийцсэн гадаад бодлогоо эрхлэн явуулах нэг чухал арга хэрэгсэл болох нь харагдаж байна.

Summary

Theoretical schools of international relations seek to explain global politics by analyzing events in the international arena. Realist theorists believe that crises and conflicts are permanent in relations between states, which focus on national interests. In contrast, idealist theorists argue that this chaos can be managed through international law and multilateral diplomacy. Research conducted by representatives of the idealist and neoliberal (or liberal-institutionalist) schools of international relations indicates that the foundation of theoretical thinking in multilateral diplomacy is rooted in these schools of thought. For Mongolia, located between two superpowers and economically dependent on its neighbors, multilateral diplomacy is a crucial instrument for conducting foreign policy that aligns with national interests.

Түлхүүр үгс.

Олон улсын харилцааны онол, идеализм, либераль-институционалист онол, олон талт дипломат ажиллагаа.

Key words. Theory of international relations, idealism, Liberal institutionalism, multilateral diplomacy

Оршил

Хүйтэн дайны дараа тогтсон олон улсын харилцааны систем өөрчлөгдөн шинэчлэгдэх нь гарцаагүй болжээ. Геополитикийн динамик өөрчлөгдөж, дэлхийн бодлогын хүчний төвийн шилжилт эрчимжин, үр дүнг нь урьдчилан таамаглахад төвөгтэй их гүрнүүдийн улс төр, худалдаа эдийн засаг, цэрэг-стратегийн сөргөлдөөн улам идэвхжих хандлагатай боллоо. Тэр хэрээр улс орнууд үндэснийхээ ашиг сонирхлыг сайтар ханган, аюулгүй байдлаа баталгаажуулахаар гадаад бодлогынхоо зорилго, зорилтыг үр дүнтэйгээр тодорхойлон хэрэгжүүлж, шинээр бүрэлдэн тогтох олон улсын харилцааны системд өөрийн байр суурийг хадгалж, улмаар нэмэгдүүлэх тал дээр янз бүрийн арга хэрэгслийг ашиглан гадаад бодлого, дипломат ажиллагаагаа идэвхжүүлэхээр зорин ажиллаж байна. Тухайлбал, улс гүрнүүд олон улсын харилцаанд хүчний тэнцвэрийг хадгалж, өөрсдийн ашиг сонирхлыг гүйцэлдүүлэхийн тулд олон талт хамтын ажиллагааны механизмуудыг байгуулан, гишүүдийн тоо, цар хүрээг нэмэгдүүлэн, үйл ажиллагааг нь эрчимжүүлэн ажиллах болжээ.

Нөгөөтэйгүүр даяаршлын хүчин зүйлс ч олон улсын өнөөгийн болон цаашдын хэв шинжийг тодорхойлох нэг хүчин зүйл байх нь гарцаагүй юм. 1950-иас 60-аад оны үеэс эхтэй улсуудын хоорондын хамтын ажиллагааны идэвхжилт нь олон улсын харилцаанд “харилцан хамаарал”-ыг бий болгосон бөгөөд олон улсын харилцааны неолибераль онолын төлөөлөгчид болох Ж.Най, Р.Кеохэйн нар олон улсын харилцааны учир шалтгааныг улсуудын хоорондын эдийн засгийн харилцаа, хамтын ажиллагааны хүрээнд судлах ёстой хэмээн үзсэн байдаг. Эдгээр судлаачид нэгэнт эхэлсэн энэхүү “харилцан хамаарал”-ын үйл явц цаашид ч зогсолтгүй үргэлжлэх ба олон улсын харилцааны үндсэн оролцогчид болох улс гүрнүүд дундын нийтлэг асуудлаа олон талт дипломат ажиллагаа буюу олон улсын байгууллагын хүрээнд шийдвэрлэх нь зайлшгүй үйл явц болно хэмээн үзсэн. “Хүйтэн дайн”-ы дараа энэхүү олон талт хамтын ажиллагааны үйл явц улам бүр эрчээ авч улс оролцогчдын зэрэгцээ олон улсын байгууллагууд олон улсын харилцаанд гол үүрэг гүйцэтгэх болсон. Ялангуяа улсуудын хооронд хамтран шийдвэл зохих нийгэм эдийн засгийн асуудлууд, нийт хүн төрөлхтнийг хамарсан глобал шинжтэй асуудлын тоо хэмжээ нэмэгдэх болсноор олон талт дипломат ажиллагааны хүрээнд олон улсын байгууллагуудыг гадаад бодлогынхоо зорилгыг хэрэгжүүлэх нэгээхэн “талбар” болгон ашиглах болжээ.

Ийм нөхцөлд аливаа улс гүрэн олон улсын харилцааны өөрчлөлт шинэчлэлтэд хурдан дасан зохицож, цаашлаад гадаад бодлогын шийдвэрийг зөв зүйтэй боловсруулан улс төр-дипломатын үйл ажиллагаагаа идэвхжүүлэх нь зүйд нийцнэ. Ялангуяа геополитикийн хувьд нэн эмзэг байршилтай, дэлхийн томоохон хоёр гүрэнтэй хил залган оршдог Монгол улс энэхүү өөрчлөлтөд дасан зохицох, үндэснийхээ ашиг сонирхолыг баталгаатай хангахын тулд гадаад бодлогын олон хувилбарыг боловсруулан үр ашигтайгаар хэрэгжүүлэн ажиллах хэрэгтэй. Одоо хэрэгжиж буй Монгол улсын гадаад бодлогын үзэл баримтлалд Монгол улсын гадаад бодлогын үндсэн зорилго болох үндэсний ашиг сонирхлыг улс төр-дипломатын аргаар хангах тухай зааснаас харахад ч манай улс хоёр болон олон талт дипломат ажиллагааны олон хувилбарыг боловсруулан хэрэгжүүлэх нь зүйд нийцнэ. Мөн тухайн баримт бичигт Монгол улсын гадаад бодлогын тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлохдоо хөрш улсууд, “гуравдагч хөрш”-ийн улсуудтай

харилцахыг онцолсны зэрэгцээ НҮБ, түүний төрөлжсөн байгууллагууд, “77”-гийн бүлэг, ЭҮНХ зэрэг олон талын хүрээнд хамтын ажиллагаагаа хөгжүүлэхээр тусгасан.

Иймд дипломат ажиллагаа, тэр дундаа олон талт дипломат ажиллагааны талаар онолын судалгаа хийж, тэндээсээ улсын гадаад бодлогод олон талт дипломат ажиллагаа ямар үүрэг гүйцэтгэж болох тухай судалгаа хийвэл зохилтой. Ялангуяа бага буурай улсын гадаад бодлогын зорилго зорилтыг хэрэгжүүлэх үндсэн арга нь дипломат ажиллагаа байдлын хувьд ч тэр, олон улсын эрх зүйн хэм хэмжээ, олон улсын байгууллагын гүйцэтгэх чиг үүрэг, гарч буй шийдвэрүүд нь бага буурай улсын хувьд нэн чухал тул энэ талын судалгааны ажил тун шаардлагатай.

Олон талт дипломат ажиллагааны онолын үндэс

Дэлхийн I дайны дараачаас харьцангуй бие даасан байдлаар үүсэж хөгжин өнөөдрийг хүрч буй олон улсын харилцааны онол нь идеализм, реализм, неолиберализм, неореализм, конструктивизм гэх мэт нэлээд хэдэн онолын сургуулиас бүрддэг. Эдгээр онолын сургуулиас идеалист болон неолибераль¹ онолын дэг сургуулийн төлөөлөгчид олон улсын харилцааны хямрал мөргөлдөөнийг саармагжуулахад улсуудын хамтын ажиллагаа, харилцан хамаарал чухал үүрэг гүйцэтгэх боломжтой талаарх санал дүгнэлтийг дэвшүүлсэн. Дэлхийн I дайны дараа либераль-идеалист улс төрчид дипломат арга хэрэгслийг ашиглан олон талт хамтын ажиллагааны үр дүнд хүн төрөлхтөн дайн дажингүй оршин тогтнох тухай санаачлагуудыг дэвшүүлж байв. Ийнхүү энх тайван тогтооход чухал үүрэг гүйцэтгэх дундын механизм нь бүхий л улсуудын оролцоотой бий болгосон олон улсын байгууллага байх болно гэж тэдгээр улс төрчид үзсэн. Ийнхүү хүн төрөлхтөн анх удаа олон улсын энх тайван, аюулгүй байдлыг сахин хамгаалах үүрэг бүхий олон талт хамтын ажиллагааны механизм болох Үндэстнүүдийн Холбоог байгуулав. Дэлхийн II дайн гарснаар энэ байгууллагыг татан буулгасан хэдий ч түүний орыг залгасан Нэгдсэн Үндэстний Байгууллагыг Сан Францискогийн Бага Хурлын үр дүнд байгуулан улс орнууд дундын асуудлаа зохих түвшинд шийдвэрлэн өнөөдрийг хүрээд байгаа билээ.

Дэлхийн I дайны дараах үеийн олон улсын харилцааны салбарт үлэмж хэмжээний байр суурийг эзлэх болсон либераль онолын гол төлөөлөгч болох АНУ-ын ерөнхийлөгч Вудро Вильсон хамтын аюулгүй байдлын зарчим дээр энх тайвныг тогтоох саналыг дэвшүүлсэн. Дэлхийн аюулгүй байдалд үндэсний эрх ашгийг дээдлэх бус харин олон улсын эрх зүйн хэм хэмжээг бүрдүүлэх замаар олон улсын харилцаанд энх тайван тогтоох боломжтой гэж үзсэн бөгөөд "...хамтын аюулгүй байдлаар энх тайвныг тогтоох ёстой дэлхий нийтийн байгууллага болох Үндэстнүүдийн Холбоог байгуулах үзэл санааг Вудро Вильсон гаргасан.." хэмээн Хэнри Киссенжер өөрийн "Дипломат үйл ажил" бүтээлдээ дурьдсан байна.² Мөн тэрээр цааш нь "Хэдийгээр Вильсон тус байгууллага чухал гэдэгт өөрийн улс орныг итгүүлж чадаагүй ч гэсэн түүний үзэл санаа хадгалагдан үлджээ"³ хэмээн бичиж үлдээжээ.

Дэлхий дахинд эзэнт гүрнүүд газар нутаг, колонийн орон зайгаа тэлэх геополитикийн бодлогыг идэвхтэй явуулж, улс төрийн бодлогод үндэсрхэг үзэл газар авсны улмаас XIX-XX зууны зааг дээр маш олон бүс нутгийн чанартай дайн, мөргөлдөөн гарч улмаар дэлхийн I дайнд хүргэсэн билээ. Тэгвэл энэхүү дайн тулааны асуудлыг шийдвэрлэх зорилгоор дэлхийн I дайны дараа Үндэстнүүдийн Холбоо байгуулагдсан. "Дэлхий нийтийн нийгэмлэг нь улс орон тэнгис далайн усан замыг хамтдаа, чөлөөтэй ашиглахад найдвартай аюулгүй байдлыг сахиулах, гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн буюу урьдчилан анхааруулаагүй дайныг сэрэмжлэн зайлуулах болон шалтгааныг нь дэлхий нийтийн санал бодолд бүрэн захируулах-газар нутгийн бүрэн бүтэн байдал, улс

¹ Либераль-институционалист онол ч гэж бас нэрлэдэг

² Х.Киссенжер. Дипломат үйл ажил. Монсудар. УБ., 2012. 28-р тал

³ Мөн тэнд.

төрийн тусгаар тогтнолд баталгаа гаргах⁴” нь чухамдаа В.Вилсоны төсөөлсөн асуудал байсан.⁵ Гэвч “Үндэстнүүдийн Холбоо дэлхийн хоёрдугаар дайнаас урьдчилан сэргийлж чадаагүй”⁶ ба дахин дайн гарсан явдал нь ирээдүйн мөргөлдөөнөөс урьдчилан сэргийлэх, дэлхийн тогтвортой байдлыг дэмжихэд олон талт дипломат харилцааны илүү хүчирхэг тогтолцоо шаардлагатай байгааг харуулав. Үүнээс үүдэн 1945 онд Нэгдсэн Үндэсний Байгууллага байгуулагдан⁷ орчин үеийн олон талт дипломат ажиллагааны тулгын чулуу болсон билээ.

Үндэстнүүдийн Холбоог байгуулсны зэрэгцээ улс орнууд I дайны дараа дайнгүй зэрэгцэн орших зорилгоор хэд хэдэн арга хэмжээ авсан байдаг. Францын гадаад хэргийн сайд Аристид Брианы “дайныг гадаад харилцааны хэрэгсэл болгохоос татгалзах тухай” санаачлагыг тэр үеийн АНУ-ын төрийн нарийн бичгийн дарга Фрэнк Келлог дэмжсэнээр 1928 оны 8 сард олон улсын харилцаанд “дайныг үндэсний бодлогын арга хэрэгсэл болгохоос татгалзах тухай нийтлэг гэрээ” буюу “Келлог-Брианы гэрээ”⁸ -г байгуулсан байдаг. Энэхүү гэрээ нь олон талт дипломат ажиллагааны үр дүнд бий болсон дайнгүй орших тухай анхдагч олон улсын шинж чанартай гэрээ болсон. Уг гэрээнд нийтдээ тухайн үеийн хүлээн зөвшөөрөгдсөн 31 улс гарын үсэг зурсан нь дайнаас татгалзах асуудлаарх олон талт дипломат ажиллагааны үр дүн болсон юм.

Дэлхийн II дайн гарснаар олон улсын харилцааны салбарт реализмын онол давамгайлах болж үндэсний ашиг сонирхолоо дээдэлсэн үндэсний төрт улсууд л зөвхөн олон улсын харилцааны үндсэн оролцогч хэмээн тооцогдох болов. Аливаа улсын үндэсний ашиг сонирхолыг хангах хамгийн гол хүчин зүйл бол улсын хүч чадавх, зөвхөн хүч чадавх л нэр төр, аюулгүй байдлаа хамгаалахад чухал үүрэгтэй хэмээн үздэг реалист онолын төлөөлөгчид олон улсын харилцааны онолын салбарт давамгайлах болж дэлхий дахинд энх тайван тогтох боломжгүй хэмээн үзэх хандлага түгээмэл болжээ.

1960-аад оныг хүртэл олон улсын харилцааны салбарынхны хувьд олон улсын харилцааны үндсэн оролцогчид нь улс гүрэн байж, улс төрийн бодлогын үндсэн асуудлууд болох дайн ба энх, үндэсний ашиг сонирхол, аюулгүй байдал, хүчний тэнцвэрт байдал зэрэг асуудлуудыг зонхилон судлаж байв. Гэвч 1950-аад оны үеэс олон улсын харилцааны шинэ урсгалынхан буюу шинжлэх ухааны модернистууд олон улсын харилцаанд дайн гарах эсэх, энх тайван тогтох эсэх нь чухал бус, гагцхүү олон улсын харилцааны төлөв байдал, зүй тогтлыг шинжлэх ухаанчаар задлан шинжлэх нь чухал хэмээн үзэх болжээ. Өмнөх үеийн сонгодог онолын дэг сургуулийн төлөөлөгчид тухайн үеийн олон улсын харилцааны үйл явц, зүй тогтлыг тайлбарлах чадваргүй хэмээн шинжлэх ухааны модернист талын судлаачид шүүмжлэх болсон нь хожим реалист болон

⁴ В.Вильсон “Энх тайван тогтоох талаар Лигид хэлсэн үгийг нь Артур С.Линк Вудро Вилсоны баримт бичгүүд гэх 1966 онд гаргасан бүтээлдээ бичсэнийг Х.Киссенжер өөрийн “Дипломат үйл ажил гэх бүтээлдээ дурджээ.

⁵ Хенри Киссенжер. “Дипломат үйл ажил”. Монсудар хэвлэлийн газар.УБ., 2012.227-р тал

⁶ Serdar, Fatih Mohamad. ”From League of nations to the United Nations:What is next? The journal of international social research.2019. p.450

⁷ History of United Nations

<https://www.un.org/en/model-united-nations/history-united-nations>

⁸ Yale Law School. Lillian Goldman Law Library. Laws of War. https://avalon.law.yale.edu/20th_century/kbpact.asp

идеалист дэг сургуулийн төлөөлөгчид өөрсдийн дүгнэлт, судалгааны арга, арга зүйг эргэн харахад хүргэжээ.

Олон улсын харилцаа нь хамтын ажиллагаа ба дайсагнал гэсэн хоёрхон зүй тогтлоор хөгжиж байдаг бөгөөд түүхэн цаг үеүдэд аль нэгэн улс гүрэн хүчирхэгжихийн хэрээр дайнч гадаад бодлогыг түлхүү явуулж, үр дагаварт нь олон улсын харилцаанд зөрчил мөргөлдөөн голлож байв. Тэгвэл 1970-аад оны эхэн үеэс идэвхжсэн даяаршлын нөлөөгөөр улс хоорондын харилцаанд хамтын ажиллагаа зонхилох болов.⁹ Энэ үеэс тусгаар улсууд хоорондын эдийн засаг, улс төр болон нийгмийн бусад хүрээнд бий болсон хамтын ажиллагаа улам бүр эрчимжин харилцан хамаарал нэмэгдэн олон улсын харилцаа цоо шинэ түвшинд гарч үндэсний төрт улсууд урьдын адил олон улсын харилцааны гол оролцогч байхаа больж олон улсын харилцааг бүхэлд нь хянах чадвараа алдаж байна гэж үздэг неолибераль онолын талынхан гарч ирэв. Уг онолын гол төлөөлөгчид нь Жозеф Най, Роберт Кеохэйн нар юм.

Ж.Най, Р.Кеохэйн нар 1971 онд "Үндэстэн дамнасан харилцаа ба дэлхийн бодлого"¹⁰ сэдэвт судалгааны өгүүлэл, 1977 онд "Хүч чадавхи ба харилцан хамаарал: Дэлхийн бодлогын өөрчлөлт"¹¹ хэмээх бүтээлээ нийтэд танилцууснаар олон улсын харилцаа, дэлхийн бодлогыг судлах олон улсын харилцааны онолын шинэ дэг сургууль гарах үндэс нь болсон хэмээн олон улсын харилцааны судлаачид үздэг.

Ж.Най, Р.Кеохэйн нарын үзсэнээр олон улсын харилцааны бүрэн эрхт субъект нь (олон улсын харилцааны оролцогч) үндэстэн дамнасан корпорац, засгийн газар хоорондын болон засгийн газар хоорондын бус олон улсын байгууллагууд, хотууд, тэр ч бүү хэл янз бүрийн үйлдвэр худалдааны газрууд гэх мэт байх боломжтой аж. Олон улсын харилцааны шинэ оролцогчдын сацуу уламжлалт улс төр, эдийн засгийн харилцааны хэлбэрээс гадна шашны, спортын, ажил хэргийн, үйлдвэрчний эвлэлүүдийн гэх мэт харилцааны хэлбэрүүд олон улсын харилцаанд голлох байр суурийг эзэлдэг болсон.

Эдгээр неолибераль онолчид буюу транснационалистууд¹² дээрх олон улсын харилцааны орчинд гарч буй өөрчлөлтөөс дүгнэлт хийж улсуудын харилцаа ноёрхсон уламжлалт "сонгодог" олон улсын харилцаа ард хоцорч ардчилалыг бий болгож байдаг олон улсын хамтын ажиллагаа бүхий Дэлхийн Бодлого¹³ бүрэлдэн тогтож байна гэж үзсэн. Энэхүү дэлхийн бодлогын үндсэн чиглэл нь бие даасан улсуудын ганцаарчилсан үйл ажиллагаагаар бус харин дэлхийн, бүсийн, дэд бүсийн хэмжээний олон улсын байгууллага, албан болон албан бус яриа хэлэлцээрийн систем, олон улсын эрх зүйн хэм хэмжээ, мөн дэлхийн нийтийн үзэл бодолд тулгуурлагдан хэрэгжихээс өөр аргагүйд хүрэх ажээ.

⁹ Г.Баасанхүү, Д.Оюунсүрэн, Ж.Баттогтох, С.Энхцэцэг, С.Оюунсүрэн, С.Баясгалан. "Олон улсын харилцааны үндэс ба даяаршил". МУИС Пресс Хэвлэлийн Газар. УБ., 2016.8-р тал

¹⁰ Joseph S. Nye, Jr. and Robert O. Keohane. "Transnational Relations and World Politics". International Organization, Vol. 25, No. 3, (Summer, 1971), pp. 329-349

¹¹ Joseph S. Nye, Jr. and Robert O. Keohane. "Power and Interdependence : World Politics in Transition". Little, Brown and Company. Boston, 1977.

¹² Олон улсын харилцааны зарим сүүл үеийн судлаачид эдгээр судлаачдыг хийсэн дүгнэлтээс үндэслэн "транснационалистууд" хэмээн нэрлэдэг.

¹³ "World Politics"

Олон улсын харилцаа буюу дэлхийн бодлогод гарч буй өөрчлөлтүүд нь оролцогчдыг төдийгүй тэдний гадаад бодлогын арга хэрэгслийг өөрчилсөн. Ж.Най, Р.Кеохэйн нарын бичсэнээр “Цэргийн хүч нь уламжлалт номлолынхны хувьд аливаа улсын хүч чадавхыг илэрхийлэгч гол хэрэгсэл. Энэ нь улс бүр өөрсдийнхөө төлөө хариуцлага хүлээдэг, дээрээ нэгдсэн нэг дээд захиргаагүй олон улсын харилцааны системд л эрх мэдлээ хэрэгжүүлэх арга нь болдог. Харин бидний энэхүү цөмийн эрин үед цэргийн хүч нь гол хэрэгсэл байхаа болиод байгаа бөгөөд харилцаа холбооны хэрэгсэл, олон улсын байгууллагын үйл ажиллагаа гэх мэт бусад арга хэрэгсэлүүд чухал болж буй”¹⁴ ажээ.

Р.Кеохэйн, Ж.Най нар улсууд хоорондын ”харилцан хамаарал”¹⁵ олон улсын харилцааг тодорхойлж байгаа гол хүчин зүйл болохыг батлахыг зорьсон байдаг. Аливаа улс гүрэн олон улсын харилцаанд өрнөж буй үйл явдал, түүний үр дагавараас зайлсхийж чадахгүй болсон. Бага буурай улс, их гүрэн хэмээн ялгалгүй харилцан хамааралд орсноор үндэстэн улсын бүрэн эрх, тусгаар байдал нь уламжлалт агуулгаа аажмаар гээж, урьд өмнө нь цэвэр дотоодын асуудал хэмээн тооцогдож байсан асуудлууд хүртэл харилцан хамаарлын үед гадаад бодлогод шууд тусгалаа олж, олон улсын харилцааны оролцогчдын хоорондын хэлэлцэх асуудлын хамрах хүрээ тэлж ирсэн. Иймд олон улсын харилцаанд үндэсний төрт улсуудын зэрэгцээ бусад оролцогчдын үүрэг, эзлэх байр суурь, жин нөлөө маш ихээр өссөн байна. “Харилцан хамаарал хэдий чинээ өндөр байна төдий чинээ тухайн улсын үндэсний ашиг сонирхол хоёрдугаарт тавигдаж улсуудын хоорондын хамтын ажиллагааны цар хүрээ нэмэгдэнэ. Хамтын ажиллагаагаа хөгжүүлэн олон талт хамтын ажиллагааг бүрдүүлэхэд тохиолдож болох саад бэрхшээлийг арилгахад гагцхүү олон улсын байгууллагууд гол үүрэг гүйцэтгэнэ” хэмээн эдгээр судлаачид үзжээ.¹⁶

Ийнхүү неолибераль онолын төлөөлөгчид олон улсын харилцааг хамтын ажиллагаа, харилцан хамаарлын үр дүнд өөрчлөгдөж үндэстэн дамнасан шинжтэй болж буй хэмээх дүгнэлтийг хийснээр улсуудын хоорондын улс төрийн харилцаа төдийгүй улс болон улс бус оролцогчдын хоорондын нийгэм эдийн засаг, соёл хүмүүнлэг, шинжлэх ухаан технологийн гэх мэт асуудлыг ч олон улсын харилцааны салбар ухааны хүрээнд судлах шаардлага гарч иржээ.

Үндэстэн дамнасан харилцаа, улсуудын олон талт нийгэм эдийн засгийн хамтын ажиллагаа идэвхжин дэлхий нийтийн түгээмэл чиг хандлага болсноор улсуудын хоорондын хамтын ажиллагаа тогтвортой байдлаар хэрэгжих боломж бүрдсэн юм. Үүний сацуу энэхүү харилцаа, хамтын ажиллагаа нь олон улсын зөрчил мөргөлдөөн, өрсөлдөөнийг саармагжуулах боломжийг бүрдүүлж буй талаарх өөрсдийн судалгааны дүгнэлтийг нотолгоо баримтад тулгуурлан неолибераль онолын төлөөлөгчид дэвшүүлсэн байдаг.¹⁷ Неолибераль онол нь өнөөдрийг хүртэл неореализмын нэгэн адил

¹⁴ Joseph S. Nye, Jr. and Robert O. Keohane. “Transnational Relations and World Politics”. International Organization, Vol. 25, No. 3, (Summer, 1971), pp. 329-349

¹⁵ “interdependence”

¹⁶ Peter F. Cowhey, Power and Interdependence: World Politics in Transition, by Robert O. Keohane and Joseph S. Nye, Jr., *Political Science Quarterly*, Volume 93, Issue 1, Spring 1978, Pages 132–134,

¹⁷ Robert Jervis. Realism, Neoliberalism, and Cooperation: Understanding the Debate. *International Security*. Volume 24 (1). Summer, 1999. pp. 42-63

олон улсын харилцааны голлох дэг сургуулийн нэг болох талаар Калифорнийн Берклей Их Сургуулийн улс төрийн шинжлэх ухааны профессор Роберт Пауэлл бичиж тэмдэглэсэн байдаг.¹⁸ Неолибераль онолын төлөөлөгчид олон улсын харилцаанд энх тайван байдлыг тогтоох гол арга зам нь олон улсын харилцааны оролцогчдын (дан ганц улс гүрэн бус олон улсын байгууллагууд, үндэстэн дамнасан корпорац гэх мэт бусад оролцогчид) хоорондын хамтын ажиллагаа, харилцан хамаарал. Харилцан хамаарал өндөр байхын хэрээр үндэсний эрх ашиг хоёрдугаарт тавигдаж хамтын ажиллагаа нэмэгдэнэ. Харин хамтран ажиллах явцад тулгарч болох саад бэрхшээлийг арилгахад олон улсын байгууллагууд гол үүрэг гүйцэтгэнэ хэмээх неолибераль онолын төлөөлөгчдийн дээрх дүгнэлт нь даяаршлын үйл явцыг ч олон улсын харилцааны неолибераль онолын хүрээнд хамааруулан судлахад хүргэсэн билээ.

1980-аад оноос улс гүрнүүд олон улсын харилцаан дахь шинэ шинэ асуудлууд, нарийн төвөгтэй нөхцөл байдалтай тулгарахын хэрээр олон талт дипломат ажиллагааны ач холбогдлыг ойлгож, харилцаа холбоо, хамтын ажиллагааг эрчимжүүлэх болсон ба олон улсын байгууллагын тоо болон үйл ажиллагааны цар хүрээ өсөн нэмэгдсэн нь улс гүрнүүд дангаар шийдэх боломжгүй аливаа асуудлыг олон улсын байгууллагын хүрээнд зөвшилцөн хамтран шийдэх боломжийг олж харсан явдал гэж үзэж болно. Ийнхүү үндэсний төрт улсууд олон улсын харилцаанд эзэлж ирсэн давуу эрхээ алдан дэлхийн шинэ бодлого нь бүрэн эрхт улсуудын бие даасан үйлдлээр бус харин олон улсын байгууллагуудын гишүүн улс орнуудын хамтын ажиллагааны үр дүнгээр тодорхойлогдох болсон юм.

Неолибераль онолын талынхан “Нийт хүн төрөлхтний өмнө тулгарч байдаг нийтлэг асуудлууд болох глобал асуудал нь транснационал буюу үндэстэн дамнасан шинжтэй тул асуудлыг шийдвэрлэхэд бүх хүн төрөлхтний хамтын хүч, оролцоо чухал. Нэг талаас дэлхийн эдийн засгийн, олон улсын худалдааны эргэлтийн хүрээнд харилцан хамаарал өсөн нэмэгдсэнээр үндэстэн дамнасан компаниуд хүчирхэгжиж, тэдгээрийг засгийн газраас хянах боломжгүй болсон. Нөгөөтэйгүүр жижиг улсууд олон улсын харилцааны идэвхтэй субъект болж, олон улсын харилцаан дахь эрх мэдлийг хуваарилах үйл явц том улсуудыг төдийгүй жижиг улсыг ч бүхэлд нь хамарч эхэлсэн тул нийт хүн төрөлхтнийг хамарсан ардчилсан механизм буюу дэлхийн засгийн газар байгуулах явдлыг их гүрнүүд ч мөн адил хүлээн зөвшөөрч дэмждэг”¹⁹ хэмээн Принстоны Их Сургуулийн профессор, улс төр судлаач Д.А Болдвин эмхлэн хэвлүүлсэн “Неореализм ба Неолиберализм: Өнөөгийн Маргаан”²⁰ бүтээлд бичсэн талаар өмнө дурьдсан “Олон улсын харилцааны үндэс ба даяаршил” хэмээх бүтээлд тэмдэглэсэн байна.

Үүнээс үзэхэд, неолибераль онолын төлөөлөгчдийн уламжлалт буюу улс гүрэн хоорондын харилцаа ноёрхсон бус харин олон улсын хамтын ажиллагаа бүхий, бие

¹⁸ Robert Powell. Anarchy in International Relations Theory: Neorealist-Neoliberal Debate. International Organization. Volume 48 (2). Spring, 1994. pp. 313-344

¹⁹ Г.Баасанхүү, Д.Оюунсүрэн, Ж.Баттогтох, С.Энхцэцэг, С.Оюунсүрэн, С.Баясгалан. “Олон улсын харилцааны үндэс ба даяаршил”. МУИС Пресс Хэвлэлийн Газар. УБ., 2016. 36-р тал.

²⁰ David Allen Baldwin. Neorealism and neoliberalism: The contemporary debate. Columbia University Press. 1993

биенээсээ харилцан хамааралтай (ялангуяа эдийн засгийн хувьд) дэлхийн бодлого гэх ойлголт үүсэн бий болсноор энх тайван тогтоно гэх үзэл санаа нь нэг талаас яах аргагүй олон улсын харилцаанд энх тайван тогтох боломжтой хэмээн үздэг либераль онолоос эхтэй ажээ. Сонгодог либераль-идеалист онол нь улсууд ёс суртахуун болон эрх зүйн хэм хэмжээг гадаад бодлогодоо мөрдлөг болгож, энх тайван аюулгүй байдлын дундын байгууллагыг байгуулах замаар олон улсын харилцаанд энх тайван тогтох боломжтойг нотлохыг зорьдог. Харин неолибераль онолын төлөөлөгчид олон улсын харилцаанд ёс суртахууны болон хууль эрх зүйн хэм хэмжээг дагаж мөрдөхөөс гадна даяаршлаас улбаатай улсуудын хоорондын харилцаа хамтын ажиллагаа гүнзгийрч улмаар харилцан хамаарал нэмэгдэн олон улсын байгууллагуудын тоо, жин нөлөө нэмэгдсэнээр улсуудын хоорондын сөргөлдөөн саармагжиж ирээдүйд дайнгүй нөхцөл байдалд хүрэх боломжтой гэж дүгнэдэг. Ямар шалтгааны улмаас улс орнуудын хамтын ажиллагаа, харилцан хамаарлаас дэлхийн энх тайван байдал хамаарч буй нь анхаарал татахуйц асуудал юм. Харилцан хамаарал, хамтын ажиллагаа нь зөвхөн энх тайван тогтооход бус илүү өргөн хүрээний ач холбогдолтой бөгөөд үүнийг бүрэн гүйцэт ойлгохын тулд улсуудын хоорондын харилцаа, хамтын ажиллагааг чухалд тооцож буй неолибераль онолын төлөөлөгчдийн дэвшүүлж буй санал дүгнэлтийг ойлгох ёстой.

Неолибераль онолчид олон улсын харилцааны оролцогчдын хоорондын харилцаанд харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэхэд нэгдсэн нэг шийдэлд хүрэхэд тус дэм үзүүлж чадах олон талт хамтын ажиллагааны механизмыг чухалд тооцдог. Тэрхүү олон талт хамтын ажиллагааны механизм нь дундын нийтлэг гэрээгээр биелэлээ олсон олон улсын байгууллага байх ажээ. Неолибераль онол нь неореалист онолыг үгүйсгэх зорилгыг үл агуулах бөгөөд олон улсын харилцааны систем дэх анарх буюу эмх замбараагүй байдлыг хүртэл хүлээн зөвшөөрдөг. Гэхдээ энэхүү олон улсын харилцааг эмх замбараагүй, хүмүүс хоорондын харилцаанд үйлчилдэг “хүн хүндээ чоно” хэмээх зарчим олон улсын харилцаанд үйлчилдэг цор ганц зарчим гэж үздэг реалист онолчид хэтэрхий туйлширч байна хэмээн шүүмжилдэг.

Неолибераль онолчдын шүүмжлэлийн гол нотолгоо нь олон улсын харилцаанд дахь хамтын ажиллагаа нь хэлбэрийн хувьд олон янз байх ба олон улсын харилцааны систем дэх хэт төвлөрөл буюу аль нэгэн их гүрний жанжлалыг нөгөө оролцогчид ямагт эсэргүүцэж буйд гол утга нь оршиж байдаг. Неореалист болон неолибераль онолын төлөөлөгчид аль аль нь үндэсний ашиг сонирхол чухал гэдэг дээр санал нэгддэг. Гэхдээ неолибераль онолчид үндэсний ашиг сонирхол гэдэг ойлголтыг агуулгын хувьд маш өргөнөөр тайлбарладаг. Эмх замбараагүй олон улсын харилцааны системд хүртэл улсуудын хооронд хамтын ажиллагаагаа хөгжүүлж болох бөгөөд харилцан итгэсэн, нэгдсэн ашиг сонирхол бүхий нийтлэг эрх зүйн хэм хэмжээг тогтоож болно. Ингэхийн тулд нэгдсэн нэг дэг журам, нийтлэг ашиг сонирхлыг хамгаалах нэгдсэн нэг олон улсын байгууллагыг байгуулах хэрэгтэй хэмээх саналыг гаргасан байна. Нөгөөтэйгүүр неореалист болон неолибераль онолын талын судлаачид бүгдээрээ улсуудын олон талт хамтын ажиллагаа, олон улсын байгууллагын олон улсын харилцаанд гүйцэтгэх үүргийг чухалд тооцох болсон. Гэхдээ неореалистууд цэрэг, стратегийн хамтын ажиллагааг илүүд үзэж байсан бол неолибераль онолчид нийгэм эдийн засгийн хамтын ажиллагаа олон улсын харилцаанд зонхилох болно хэмээн нотлож байлаа.

Олон улсын харилцааны неолибераль онолын гол төлөөлөгчид болох Ж.Най, Р.Кеохэйн нарын 1971 онд “Олон улсын байгууллага” сэтгүүлд хэвлүүлсэн өмнө нь дурьдсан “Үндэстэн дамнасан харилцаа ба дэлхийн улс төрийн бодлого” сэдэвт өгүүлэл нь олон улсын харилцаанд неолибераль онолын дээр дурьдсан үзэл санааг хураангуйлсан анхдагч бүтээл болсон юм. Энэхүү бүтээлд эдгээр судлаачид улс төрийн реалистуудын улс хэмээх оролцогчийн үндсэн зорилго, үйл ажиллагаа нь хүч чадавх, эрх мэдлийг өөртөө бий болгоход оршдог. Энэхүү оролцогчийн төлөөлөл нь дипломат, аль эсвэл цэрэг байх бөгөөд эдгээр нь зөвхөн улс орныхоо ашиг сонирхлыг л олон улсын тавцанд хамгаалах үүрэгтэй хэмээх үзэл санааг тодорхой үндэслэлтэйгээр няцаахыг зорьсон байдаг. Францын олон улсын харилцааны судлаач, реалист онолч Р.Арон нэгэнтээ “олон улсын харилцаанд зөвхөн дипломат, цэрэг гэсэн хоёр төлөөлөл байдаг”²¹ хэмээсэн нь ч реалистуудын дээрх санаа олон улсын харилцаанд түгээмэл болсон байсны илэрхийлэл юм.

Few countries on this earth enjoy complete equality among their members without any restrictions. In this respect, it is difficult to accept multiculturalism in the framework of overly lyrical romanticism. It is also true that in reality, there is a dialectical interaction between the making of the people-state (the state's demand for minorities) and the rights of minorities (the state's demand for the state).

3. Social capital between Mongolia and Korea

3-1. the concept of social capital

Social capital is a set of norms, trusts, and networks that lead to the acquisition of social class elements and resources. Social class elements and resources act on decision-making and policy formation.

P. Bourdieu drew on the concept of social capital to explain why

class inequality persists. In addition to existing economic capital, hidden forms of capital accumulation, such as cultural capital and social capital, were reproducing class inequality. He defines social capital as 'the sum of real and potential dimensions that can be obtained through a network of continuously existing relationships (1986: 248). It was also said that 'the size of the network that a specific actor can effectively mobilize and the size of the capital owned by several individuals included in the network (1986: 249). J. Coleman viewed social capital as 'capital with the function of inducing and facilitating individuals or groups belonging to a given structure to perform certain actions'. He is approaching the effects of social capital, which can be said to be a somewhat value-neutral concept compared to Bourdieu's point of view to explain class inequality.

There have been two main flows in social capital research so far. These are the microscopic approach and the macroscopic approach. Bourdieu, Coleman, and Burt are representative scholars who are taking a microscopic approach. They focus their research on the characteristics of the various relationships found between individuals. These microscopic approaches are mainly paying attention to the issue of "Why do a particular person or group occupy an advantageous or unfavorable position in terms of resource mobilization compared to other people or groups?" Micro-social capital mainly implies trust for "people."

Those who are taking a macroscopic approach are R. Putnam and F. Fukuyama. They approach social capital by grasping it as the cultural and organizational characteristics of a given society. They generally accept social capital as a prerequisite for community maintenance and development. Macro social capital mainly implies trust for the 'institution'. Civil society is activated through the formation of social capital, and it is the basic view of Putnam and

Fukuyama that democracy is difficult to develop if civil society is not established.

Researchers who take a microscopic approach to social capital criticize this. It is argued that the source of social capital is not a voluntary association of citizens, but a primary and community organization such as family. Coleman and Bourdieu see primary human relationships such as family as the source of social capital. Newton (1997) believes that the influence of media contact and education is more important than citizens' participation in voluntary associations. Like L. Pye (1999), it is argued that the existing triangular structure of 'state-civil society-individual' cannot adequately explain the nature of social capital in Asian society. I think it is more effective to analyze how they are related to various intermediate-level communities such as family, friends, and neighbors.

On the other hand, in the process of expanding the traditional concept of capital used in economics, concepts such as human capital, cultural capital, and social capital have occurred. Amid the differences between each capital, the unique meaning of the concept of social capital can be examined. The characteristics of social capital can be summarized as follows. First, it is the relationship of social capital. It is not the capital held individually by the actors, but the nature of capital inherent in the relationship between the actors. Second, it is the sharing of profits. In other capitals, profits are attributed exclusively to their capital owners, whereas social capital has the characteristics of being shared. There is a micro dimension in which profits are shared exclusively among related members, and there is also a macro dimension in which profits are shared even among members who are not included in the relationship. Third, in order to maintain and

reproduce social capital, it is necessary to go through a continuous exchange process in which the relationship is constantly confirmed and recognized among members. Fourth, it is the boiling point of exchange. The exchange of trust is not a zero-sum relationship that decreases or increases as much as exchanged, but a positive-sum relationship that gradually accumulates through exchange. Fifth, it is the asynchronous nature of exchange. By introducing a temporal interval between exchange relationships, it forms a 'debt of the heart' that binds the relationship. Even if the transaction is repeated, the transaction has an imperfect character that can be betrayed at any time.

3-2. components of social capital

As is well known, the concept of social capital began to emerge from the recognition and reaffirmation that trust is a key issue in the living field and market. The level of trust of certain members of society, social norms, and duty to the community greatly affects market efficiency and economic growth. A proposal to name these cultural elements as social capital was raised by sociologists (Coleman, 1988; Putnam, 1995; Fukuyama, 1995; Yu Seok-chun et al., 2003).

In economics, in addition to physical capital as a factor of production, the concept of human capital (labor skill level, knowledge, personally acquired and refractory production factors, etc.) has been developed (Schultz, 1961). Apart from human capital, social capital refers to an element that benefits and cooperates with each other. It refers to trust, norms, and networks that facilitate mutual cooperation or cooperation (Putnam, 1995: 67). Compared to human capital, social capital is not embodied in individuals, but rather is capital that is established in the

'relationship' between individuals. Therefore, trust in the other person is not a characteristic of one's own or the characteristic of the other person, but a characteristic of the relationship between oneself and the other person. Compliance with social norms yourself can be seen as a relational act in terms of relying on the actions of the other person. It is true that norms have been internalized to some extent, but when they are transferred to actions, they are greatly influenced by the interdependence of actions, so they can be seen as dependent on relationships (Yonghak Kim, 2004: 125). Coleman also sees social capital as a special resource available to actors.

According to Coleman, social capital is a resource that individuals can mobilize rather than owning it, and this resource comes from social structures. In his case, he emphasizes the aspect that social capital is various forms of entities that come from social structures that perform specific productive functions (Coleman, 1988: 101). He holds social norms, trust, and networks as his main forms as various entities that come from social structures. Fortes sees the network as a key element of social capital. It argues that trust and social norms are incidental elements of the network. Like Grenolet, he distinguishes between relational and structural positions. Relational position refers to being established in a bilateral relationship, and structural position refers to being placed in a larger network. In the case of structural position, it is said that social capital can be mobilized more effectively in terms of being able to sanction rule violators and traitors than relational position (Ports, 1995: 14).

Summarizing the concept of social capital and its components, Coleman insisted on trust and a network with social norms as elements of social capital and followed Putnam-Coleman's

argument. Among these three components, Fortes and Fukuyama limited the concept of social capital by emphasizing the network and Fukuyama particularly emphasizing social norms. In the case of Lin, social norms are excluded and investment in social relations is emphasized. When putting together the discussions of various social capital-related scholars, three key components can be summarized: trust, social norms, and networks. In this way, the components of trust, social norms, and networks are deeply related and inseparable properties. The picture of the interrelationships of trust, social norms, and networks is as follows.

<Figure 1> Interrelationships between trust, social norms, and networks:

social norms
a network of connections
Trust

3-3. Social Capital between Korea and Mongolia

A healthy social capital must be established between Mongolia and Korea, as discussed in the theory and components of social capital. In terms of politics, economy, society, and culture, mutual trust must be deeply built. In addition, various laws and regulations must be enacted to form democratic relationships in mutual agreements. Thus, mutually beneficial networks must be actively and continuously established in various aspects such as politics, economy, society, culture, education, welfares, and etc.

4. Consideration for Extension of Social Capital on the Relationship between Korea and Mongolia

In order to expand the social capital between Korea and Mongolia, the Mongolian government needs to refer to the following foreign-related policies of Seoul, Korea. These policies will be extended to other local governments in Korea. By referring to these policies, the Mongolian government will be able to improve the quality of life of the Mongolian people and the relationship between the Korean and Mongolian governments.

Seoul Mayor Oh Se-hoon announced on Tuesday, 21 May 2024, the "Master Plan for Seoul Foreign Resident Policy (2024-2028)" focusing on such matters. In this regard, the city plans to invest a total of 250.6 billion won over the next five years to push for 20 key tasks.

"Seoul Metropolitan Government's Master Plan for Foreign Resident Policy"

The Seoul metropolitan government has decided to focus its efforts on attracting talented people. It will attract 1,000 master's and doctoral talents in science and engineering fields in partnership with major universities in Seoul. To this end, the government plans to select 10 universities that teach high-tech industries and provide them with up to 1.5 billion won (1.8 million U.S. dollars) per year for three years.

The city will give 20 million won per person to science and engineering students in developing countries. Starting with Jakarta, Indonesia, which has the largest school-age population (110,000) among ASEAN countries, the city will also hold a "Seoul Study Exhibition" twice a year in July.

Pregnancy, childbirth, and care services without discrimination between domestic and foreign nationals

At the same time, it will attract global companies where foreign talents can work. It will select top 100 target companies that have great ripple effects in industries such as technology and finance and support licensing and other tasks. It will also create a "Unicorn Start-up Hub," a global start-up support facility. The Seoul Metropolitan Government has set a goal of attracting more than 100 overseas start-ups here. It also established a dedicated window to help foreign students find employment in March.

The Seoul Metropolitan Government has also introduced a policy

for multicultural families. First of all, it will launch a pilot project for foreign domestic managers in September. A government-certified Filipino domestic manager aged 24 to 38 is hired by a government-certified agency and then sent to the family. A new job school will be established to train workers such as domestic manager, caregiver, and medical coordinator, and job placement will be provided to those who have completed the project.

It will also nurture foreign human resources in the K-fashion and beauty sectors. It will support employment and start-up programs at the Seoul Beauty and Fashion Hub in Dongdaemun for international students in beauty and fashion departments attending universities and graduate schools in Korea. It aims to cultivate 1,000 people in related fields by 2028.

It will also push for the supply of foreign workers in the food service and hotel sectors, where the number of workers has declined sharply since COVID-19. To this end, the government will discuss ways to expand the visa-permitted industry. In addition, the Seoul Foreign Workers Center plans to conduct communication and job training, and the Seoul Tourism and Employment Support Center plans to conduct job fairs and job counseling.

Integrated care services before and after childbirth and pregnancy, childbirth, and care services such as infant development tests will also be lowered to prevent foreigners from being discriminated against by Koreans. Starting this month, the government will provide new support for educational activities for elementary, middle and high school multicultural children (from 400,000 won to 600,000 won).

Starting in 2025, the city will hold various hands-on events at Seoul Plaza, Cheonggyecheon Plaza, and Nodul Island. In order to facilitate the master plan announced this time, the Seoul Metropolitan Government will establish the Global Urban Policy Center, a dedicated organization, in July. The center oversees immigration policies and international exchanges, and promotes foreign policy.

Currently, the number of foreigners living in Seoul (440,000 people) accounts for 4.7 percent of the city's total population. The four autonomous districts (Guro, Geumcheon, Yeongdeungpo, and Jung-gu) account for more than 10 percent. "Creative talents from diverse cultural backgrounds can bring about a boost in Seoul's economy," Mayor Oh Se-hoon said.

SPSIRPA FORUM 2024

Session 2-2

The process of geopolitical change:
Analysis of central regional theory



**ГЕОПОЛИТИКИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ҮЙЛ ЯВЦ:
ТӨВ БҮС НУТГИЙН ОНОЛД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ**

**THE PROCESS OF GEOPOLITICAL CHANGE:
ANALYSIS OF CENTRAL REGIONAL THEORY**

С.Базарпүрэв
МУИС, УТСОУХНУС,
Улс төр судлалын тэнхимийн профессор

Ш.Эвсанаа (МА)
ДХИС, ЭЗНУС,
Нийгмийн ухааны тэнхимийн ахлах багш, ахмад

Хураангуй:

Өнөө цагийн глобал геополитикийн төвөгтэй нөхцөл байдалтай тулгарч буй дэлхий дээр Хэлфорд Макиндерийн (Halford J.Mackinder) Төв бүс нутгийн онолын /Heartland Theory/ үзэл баримтлал томоохон сорилттой тулгарч байна. Энэхүү судалгаагаар тус үзэл баримтлал нь өөрчлөгдөн буй дэлхийтэй хэрхэн нийцэж байгаа тухайд шинжилгээ хийсэн болно.

Төв бүс нутгийн онол нь Евроазийн томоохон газар нутаг нь тухайн улсад эрх мэдлийг өгөх боломжтой гэж үздэг. Түүнчлэн судалгаагаар дэвшүүлж буй гол санаа нь өнгөрсөн цаг хугацааны турш ялгаатай олон улс орнууд эрх мэдлийн төлөөх тэмцэл хэрхэн эхэлсэн талаар авч үзнэ. Гэвч одоо цагт дэлхийн геополитикийн талбар технологийн хувьсал, эдийн засгийн тусгаар тогтнол болон шинэ хүчирхэг тоглогчид төрөн гарч буйтай холбоотой өөрчлөгдөж байна. Эдгээр өөрчлөлтийн сорилтууд нь Төв бүс нутгийн онолын хэрэгжилтийг эргэн харах шаардлагатай болохыг харуулж байна.

Төв бүс нутгийн онол нь геополитикийн үзэл баримтлалд чухал байр суурь эзэлсээр байгаа хэдий ч XI зууны глобал харилцааг тодорхойлж буй эдийн засаг, технологи болон газар нутгийн бус хүчин зүйлсийн эрэлтэд нийцүүлэн уг үзэл баримтлалд хэрхэн тайлбарлал хийх талаарх санааг дэвшүүлж байна.

Түлхүүр үгс: Төв бүс нутгийн онол, глобал улс төр, өөрчлөгдөж буй дэлхий, технологийн өөрчлөлтүүд, эдийн засгийн тусгаар тогтнол, шинэ эрх мэдлийн өөрчлөгдөн буй үйл явц

Abstract:

In a world facing the complex geopolitical situation of our time, the concept of The Heartland Theory / Central Regional Theory of Halford J.Mackinder faces a major challenge. This study examined how the concept fits into a changing world. The central regional theory holds that a large area of Eurasia could give power to the country. The main points being put forward by the study will also examine how many different nations have begun the power

struggle over the past time. But now the geopolitical landscape of the world is changing because of the evolution of technology, economic independence, and the emergence of powerful new players. The challenges of these changes suggest that a review of the theoretical applications of the Central Region is necessary.

While the central regional theory continues to play an important role in the concept of geopolitics, it is proposing how to interpret the concept in line with the demand for economic, technological and non-local factors that define 21st-century global relations.

Keywords: Heartland theory, global politics, changing world, technological changes, economic interdependence, new power dynamics

Удиртгал:

XIX-XX зууны зааг дээр шинжлэх ухааны мэдлэг логик хөгжлөөр төдийгүй, улс төрийн бодит шинэ үзэл санааны хэрэгцээнээс үүдэн геополитик үүссэн. Эсрэг зогссон хүчний төвүүдийн хооронд дэлхийг бүхэлд нь хуваах нэгдмэл зорилготой тэр үед энэ шинжлэх ухаан гарч ирсэн. Дэлхийн шинэ хуваалт нь “аль эрт хувааж хязгаарт хүрсэн” буюу нэг “эзэмшигчээс” нөгөөд шилжиж байсан. Харин “эзэнгүй”-ээс “эзэнтэй”-д биш байв. Дэлхийг хуваах нь дэлхий дэх мөргөлдөөнийг ихээхэн нэмэгдүүлсэн. Дэлхийн тавцан дээрх геополитикийн гол хүчний тэмцлийн арга барилыг төгөлдөржүүлэхэд чиглэгдсэн шинжлэх ухааны эрэлд энэ байдал нь түлхсэн. XX зууны эцэст геополитикийн хүчний тэнцвэрт эдийн засгийн хүчин зүйл чухал болохыг баталсан. (Н.А.Нартов, 2003)

Геополитикийн ойлголтыг ашиглахдаа түүний олон талт ач холбогдлыг ерөнхий хэлбэрийг 3 аспектад хуваадаг.

Нэгдүгээрт, ертөнцийг үзэх үзэл санааны шинжтэй, амьдралын орон зай дахь үндэсний сонирхлын олон улсын бодлогын батлан хамгаалах чиглэл буюу түрэмгийлэх бодлогод үндэслэгдсэн үзэл санааны сургаал, номлол юм. Ийм байдлаар геополитик нь янз бүрийн нэр, хэлбэрээр хүн төрөлхтний түүхийн эрт үеэс аль хэдийнээ мэдэгдэх болсон.

Хоёрдугаарт, дэлхийн хуучин гүрнүүдийн аль хэдийн эзэлсэн ба эзэмшлийн хүрээнд үндэслэсэн, шинэхэн түүхийн улсууд, ард түмний олон улсын бодлогын практик стратеги болсон олон улсын харилцааны бодит түүхэн хэлбэрийн шинжтэй. Энэ аспектад геополитик нь бас олон янзын нэрээр Газар зүйн Их Нээлтийн сүүл үеэс оршиж ирсэн ба хуучин гүрнүүд “шинэ газар”-таа колонио бэхжүүлэх, нэлээд хожуу хөрөнгөтний үед анхны колони эзлэлтээс хоцорсон улсууд эзлэн түрэмгийллээ зөвтгөхийн тулд амьдрах газар зүйн орон зайн тухай энэхүү номлолыг гаргасан.

Гуравдугаарт, геополитик бол тухайн улс, ард түмний хөгжил, үйл ажиллагаа газар зүйн орон зайн нөхцөлөөс хамаардаг олон улсын харилцааг судалдаг өвөрмөц арга зүй болон ангиллын системтэй олон салбар ухааны хоорондын идэвхтэй үйлчлэлээр нийгмийн ухааны талбар дээр бүрэлдсэн ойлголт.

Геополитик мөн чанартаа XXI зууны нийгмийн ухааны нэг гол шинжлэх ухаан юм. XXI зуун олон учир шалтгааны улмаас шинэ буюу шинэхэн үе болно. (Н.А.Нартов, 2003)

Геополитик нь глобал харилцаанд нөлөөлөх, олон улсын тавцанг бүрдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Судалгааны хамрах хүрээ нь (Acharay, 2014) газар зүй, эрх мэдэл, улс төрийн харилцан хамаарлыг судлах, тодорхой орон зайн нөхцөл байдалд улс орнууд, бүс нутгууд болон олон улсын тоглогч нарын үйл ажиллагааг дэмждэг. Геополитикийн хүчин зүйлс нь газар зүйн байршил, байгалийн нөөц /баялаг/, стратегийн асуудлууд бөгөөд улс орны гадаад бодлого, аюулгүй байдлын шийдвэрүүд болон эдийн засгийн харилцаанд ихээр нөлөөлдөг.

Геополитикийн талаарх гүнзгий ойлголт авч мэдэх нь дэлхий даяар эрх мэдлийн хуваарилалт хэрхэн явагддаг болон олон улсын харилцааг чиглүүлэгч өөрчлөгдөн буй үйл явцын талаар судлахад оршино. Геополитик нь газар зүй, улс төрийн хүчин зүйлс нь аливаа улсын стратегийн сонирхлууд, холбоод, мөргөлдөөнтэй хэрхэн холбоотой байдгийг судалдаг. Энэхүү ухагдахуун нь газар зүйн хүчин зүйл болох газар нутаг, тэнгис далай, гол ус болон бусад улс оронд нөлөөлж болох асуудал зэрэгт онцгой ач холбогдол өгч судалдаг. Түүнчлэн глобал нөлөөг бүрдүүлэгч/тогтоогч эдийн засаг, цэрэг арми, улс төрийн чадамж зэрэгт онцгой анхаарал хандуулдаг. (Johnstone, 2020) Жишээ нь, Суэцын суваг эсвэл Ормузын хоолой гэх мэт далайн чухал замуудын хяналт нь тухайн улс олон улсын худалдаа хийх болон эрчим хүчний урсгалыг хийх давуу талыг бий болгодог. Үүнтэй адил, газар зүйн хүчин зүйл болох уулс, цөл нь цэргийн стратеги болон хамгаалах үйл ажиллагаанд нөлөөлөх боломжтой.

Төв бүс нутгийн онолыг Британий улс төрч, газарзүйч Х.Макиндер 1904 онд дэвшүүлсэн байдаг. Макиндерийн онол нь Евроази тивийн ихэнх газрыг “Төв бүс нутаг” хяналтандаа байлгах нь эзэмшигчдээ геополитикийн асар давуу талыг бий болгоно гэж үздэг. Макиндерийн онол нь өөрийн амьдарч байсан үеийн геополитикийн нөхцөл байдалд үндэслэсэн байдаг. Өөрөөр хэлбэл, ХХ зууны эхэн үед эзэнт гүрнүүд хоорондын тэмцэл, нөлөөллийн талаар түлхүү судалсан онол гэж хэлж болно. Түүний онолоор улс орны стратегийн чухал ач холбогдлуудын нэг буюу глобал түвшинд нөлөөллөө бий болгох ба хадгалахад газар зүйн байршил чухал гэж үздэг. Төв бүс нутгийн онолын талаарх хэлэлцүүлэг идэвхтэй өрнөсөөр өнөө цагт олон улсын харилцааны өөрчлөгдөн буй үйл явц, технологийн дэвшил, глобал түвшний эрх мэдлийн төвүүдийн шилжилт зэрэгт хувь нэмэр, зөвлөмжөө өгсөөр байна.

Төв бүс нутгийн онолын ерөнхий ойлголт

Х.Макиндерийн 1904 онд хэвлүүлсэн “Түүхийн геополитикийн төв” /The Geographical Pivot of History/ нийтлэлд Евроазийн байгалийн нөөц ихтэй болон томоохон газар нутгийг хяналтдаа байлгах нь глобал давамгайллын баталгаа болно гэж дурдсан байдаг. Улмаар Макиндер онцлон тэмдэглэхдээ газар зүйн байршлын улмаас Төв бүс нутаг нь Евроази тивийн төв хэсгийг хамаарах нь стратегийн давуу талыг бий болгоно гэсэн билээ. Түүний тайлбарласнаар Төв бүс нутгийн стратегийн байршил болон байгалийн нөөц нь өөрчлөгдөн буй глобал эрх мэдлийн тулгуур нь болно гэжээ. Макиндер дэлхийг гурван гол геополитикийн бүсэд хуваасан. Энэ хуваагдал нь түүнийг өөрийн онолын үндсийг тодорхойлоход тус нэмэр болсон гэж тооцогддог.

- Тэнхлэг бүс (pivot area). Энэ нь Хойд мөсөн далайн голуудын ай сав, Каспийн ба Арал тэнгисийг багтаана.

- Гадаад хавирган сар (outer crescent). Үүнд, АНУ, Англи, Японы нутаг орно.

- Дотоод хавирган сар (inner crescent). Дээрх хоёр хэсэгт хавчигдсан хэсэг. Хятад, Зүүн Өмнөд Ази, Энэтхэг гэх мэт нутаг багтана. (Д.Мягмар, 2019)

Улсын хувьд хамгийн ашигтай байрлал нь дундад, төв байршил болно гэдгээс Макиндерийн гол санаа гарна. “Төв”-ийн ойлголт харьцангуй тул дэлхийн төвийн тухай санааг гаргав. Дэлхийн төвд Евразийн эх газар оршиж, түүний төвд “дэлхийн зүрх” буюу бүх дэлхийг хянах тохиромжтой нутаг, Евразийн эх газрын цул цөм “*Heartland*” гэж томъёолсон.

Соёл иргэншил эрчимтэй хөгжсөн Өмнөд, Зүүн Өмнөд, Зүүн Ази буюу Евроазийн эргийн нутгийг “дотоод хүрээ” (inner crescent) хэмээн Х.Макиндер нэрлэсэн. Их Британи, Өмнөд, Хойд Америк, Өмнөд Африк, Австрали, Японыг дотоод Евразийн газар зүй, соёлын холбоотны бүс нутаг буюу “гадаад хүрээ”-нд (outer crescent) хамруулсан. Төв газрыг хяналтдаа байлгах, хяналтад авахын тулд “дотоод хүрээ”-г хянах ёстой аж. (Н.Галиймаа) Хүйтэн дайны дараагаас Макиндерийн онолын ач холбогдол дахин сэргэсэн байна. Эдүгээ Макиндерийн дэвшүүлсэн:

“Хэн Зүүн Европыг удирдана, тэр Төв Бүс Нутгийг захирна
Хэн Төв Бүс Нутгийг удирдана, тэр Дэлхийн Арлыг захирна

Хэн Дэлхийн Арлыг удирдана, тэр Дэлхийг захирна.” гэсэн гаргалгааг судлаачид олонтаа дурддаг.

1943 онд Макиндер өөрийн загвар санаандаа засвар хийсэн байдаг ба үзэл баримтлалаа боловсруулж, доорх зүйлийг дэвшүүлсэн байдаг. (Н.А.Нартов, 2003)

1. Түүхийн үйл явцад газар зүйн хүчин зүйлс шууд нөлөө үзүүлдэг.
2. Улсын сул байдал ба хүчин чадлыг газар зүйн байрлал ихэвчлэн илэрхийлдэг.
3. Техникийн дэвшил улсын газар зүйн “орших орчин”-г өөрчилж, тэдний хүчин чадалд эерэг, сөрөг нөлөөлдөг.
4. Еврази нь глобал улс төрийн үйл явцуудын төв

Зураг 1-д Төв бүс нутгийн газар зүйн байршилыг харуулав.



Зураг 1. The Heartland theory. Эх сурвалж: <https://pbs.twimg.com/media/>

Төв бүс нутгийн онолыг өнөө цагийн үйл явдлуудтай нийцүүлэх

Евроазийн төв бүс нутагт нөлөөлж буй Оросын геополитикийн үйл ажиллагаа Төв бүс нутгийн онолтой нийцэж байна. Оросын өргөн уудам газар нутгийн тэлэлт болон төв байршил нь маш чухал стратегийн давуу талыг бий болгож байна. 2014 онд Кремиийг бүрэлдэхүүндээ оруулсан үйл явдал нь Орос улсын бүс нутагтаа түүхэн хяналтаа тогтоох бодлогоо баталгаажуулах ажил байв. Оросын засгийн газрын энэхүү хичээл зүтгэл, оролдлого нь Макиндерийн үзэл санааг хэрэгжүүлэн хөрш улсуудад нөлөөлөх, эрчим хүчний стратегийн түншлэлээ хадгалах явдал юм гэж тооцогдож байна. Үүнтэй адил, БНХАУ-ын бүс ба зам санаачилга нь Төв бүс нутгийн онолын элементүүдийн илэрхийлэл юм.

Бүс ба зам санаачилгын зорилго нь Евроазийн нутгаар хөндлөн дайран өнгөрөх дэд бүтэц болон эдийн засгийн коридоруудын сүлжээг байгуулах билээ. Улмаар Хятадын төв бүс нутаг болон Rimland буюу Төв бүс нутгийн хязгаарын бүс нутгуудтай хийх холбоо харилцааг нэмэгдүүлнэ. Хятадын төмөр зам, авто зам болон боомтын төслүүдэд оруулж буй хөрөнгө оруулалт нь газарт тулгуурласан холболт гэх онолын хэрэгжилт юм.

Төв бүс нутгийн байгалийн баялгийн асуудал өнөө цагт хэлэлцүүлгийн гол сэдэв болж байна. Төв Азийн асар их хэмжээний эрчим хүчний нөөц болох газрын тос, байгалийн хий нь бүс нутгийн геополитикийн чухал асуудал хэвээр оршдог.

Төв бүс нутгийн онолд тулгарч буй сорилтууд, геополитикийн чиг хандлага

Шинжээчид геополитикийн нөхцөл байдлын өөрчлөлтийг олон улсын глобал харилцааны түвшинд хөгжин тодорч байгаа суурь хандлагуудын (мегатренд) үндсэн дээр авч үздэг. (Д.Мягмар, 2019)

Бүс нутгийн болон олон улсын аюулгүй байдлын орчинд гарч буй глобал өөрчлөлт, дэлхийн санхүү, эдийн засгийн хямралын үр нөлөө, зах зээлийн конъюнктурын хувьсал, дэлхийн дулаарал, цаг уурын өөрчлөлт, байгалийн гамшиг, шинэ өвчний цар тахал, *hybrid* буюу уламжлалт бус аюул зэрэг геополитикийн гадаад орчин, төсөв, мөнгө, хөрөнгө оруулалтын бодлого, хүний эрхийн баталгаажилт, ардчилал, засаглалын чанар зэрэг геополитикийн дотоод орчны мэдэгдэхүйц хувьсал улс орны удирдлагыг богино хугацаанд оновчтой, шинжлэх ухааны үндэслэлтэй зөв шийдвэр гаргах, урьдчилан сэргийлэх (дипломат) ажиллагаа, хямралын менежментийг шуурхай хэрэгжүүлэхийг шаардаж байна. (Д.Уламбаяр, Геополитикийн орчны өөрчлөлт ба Монгол улсын "Гуравдагч хөрш"-ийн бодлогын парадигм, 2020)

Өнөөдөр хүн төрөлхтөн кибер дайн, мэдээллийн технологи, эдийн засгийн бие даасан буюу тусгаар тогтносон байдлын ээдрээтэй цаг үед амьдарч байна. Гэвч Төв бүс нутгийн онол нь газар зүйн байршлын хяналтыг хэн авах тухайд илүүтэй төвлөрдөг тул дээрх асуудлуудыг онолд хэрхэн нийцүүлэх нь томоохон сорилтуудтай байгаа билээ. Газар зүйн бус аргачлалууд болох кибер дайралт, эдийн засгийн хөшүүрэг нь улс орнуудад биет хил хязгаараас үл шалтгаалсан буюу давсан эрх мэдлийг олгож байна. (Keliris, 2019) Жишээ нь, 2016 онд болсон АНУ-ын сонгуульд нөлөөлсөн гаднын нөлөө нь газар нутгийн бус нөлөөлөл хэрхэн газар авч байгаа болон тэлж байгааг нотлон харуулсан.

Rimland буюу хязгаар нутгийн эрх мэдлийн өсөлт нь онолын асуудалд маргаан үүсгэж байна. Эрэг хавийн бүс нутгийн улсууд болох Сингапур, Өмнөд Солонгосын эдийн засгийн амжилт нь хязгаар нутгийн улсуудын худалдаа, инновац болон технологи нь глобал нөлөө үзүүлж болохыг харуулж байна. Түүнчлэн өнөө цагийн геополитикийн олон туйлт шинж чанар нь Төв бүс нутгийн онолын дан ганц давамгайллагч эрх мэдлийг хэрэгжүүлэх санаа нь хүнд сорилттой тулгарч байгааг илтгэдэг. Нөлөөлөл үзүүлэгч гол тоглогчид болох БНХАУ, Европын Холбоо болон Энэтхэг хүчтэй болж байна.

XI зуун нь Хүйтэн дайнаас (Ikenberry, 2018) хойших хоёр туйлт дэлхийгээс олон туйлт глобал дэг жаягт шилжиж буй шилжилтийн гэрч нь юм. Хүчирхэгжиж буй их гүрнүүд болох Хятад, Энэтхэг нь бүс нутгийн үйл ажиллагаа болон олон улсын тавцанд нөлөөллөө нэмэгдүүлж байна. Энэхүү олон туйлт сорилтууд нь Төв бүс нутгийн онолын таамаглал болон зөвхөн газар нутаг гэсэн хүчин зүйлийг дангаар тооцох нь учир дутагдалтай болж байгаа гэдгийг харуулж байна. Өөрөөр хэлбэл, дэлхий даяар олон тооны нөлөөлөгч тоглогчдын оролцоо өндөр болсон гэсэн үг.

Байгалийн баялгийн төлөөх өрсөлдөөн ялангуяа эрчим хүчний нөөц нь орчин үеийн геополитикийн онцлох хүчин зүйл нь болж байгаа нь илт байна. Газрын тосны хүртээмж, байгалийн хий, эрдэс баялгийн холбоод, өрсөлдөгчид болон глобал эдийн засгийн чиг хандлага нь орчин үеийн геополитикийн өөрчлөлтийг тодорхойлж байна.

Дээрх зүйлүүдээс XXI зууны эхээр дэлхий даяар геополитикийн шинж чанартай дараах өөрчлөлтүүд ажиглагдаж байна. Үүнд:

- Стратегийн ач холбогдол бүхий чухал газар нутаг, орон зайн төлөөх дэлхийн том гүрнүүдийн өрсөлдөөн улам бүр зах зээл, соёл иргэншлийн орон зайн дахин хуваарилалтын утга агуулгатай болж, дэлхий нийтийг бүхэлд нь хамран, хурцдах төлөвтэй байна.

- Хүн төрөлхтний хөгжлийн төв буюу эцсийн дүндээ том гүрнүүдийн геополитикийн өрсөлдөөн аажмаар дорно зүгт шилжиж байна.
- Дэлхийн болон бүс нутгуудын хүчний дахин хуваарилалтад Европ, Хойд Америкийн зэрэгцээ олон зуун саяас дээш, тэрбумаар тоологдох хүн амтай Хятад, Энэтхэг, Латин Америкийн болон лалын гэгдэх ертөнцүүд хүч түрэн орж ирж байна.

Том гүрнүүдийн геополитикийн өрсөлдөөний объектод цэрэг-стратегийн хувьд чухал болон эдийн засгийн стратегийн ач холбогдол бүхий район, бүс нутаг, далай тэнгисийн сав газрын зэрэгцээ байгалийн баялаг их хэмжээгээр төвлөрсөн болон нэгдмэл соёл иргэншилт үндэстэн ястны төвлөрөн суурьшсан газар нутаг бас хамаарах боллоо. Геополитикийн хувьд өндөр ач холбогдол бүхий тив дэлхий, бүс нутгийг өөрийн эзэмшилд буюу нөлөөндөө байлгах нь соёл иргэншлүүдийн геополитикийн өндөр статус, аюулгүй байдлын түвшин, эдийн засгийн хөгжлийн чадавхын илэрхийлэл болж байна.

Геополитикийн орон зайн төлөөх өрсөлдөөний хүч хэрэгсэл, арга хэлбэр хүн төрөлхтний амьдралын бүх салбарыг хамран өргөжиж, зөрчил, сөргөлдөөний гол талбар нь эдийн засгийн зах зээл, оюун санаа, соёл иргэншлийн үнэт зүйлсийн өрсөлдөөн болж хувирах талтай байгаа боловч үүнтэй зэрэгцэн цэрэг, зэвсгийн хүчээр асуудлыг шийдвэрлэх хандлага улам бүр түгээмэл болсоор байна. (Д.Мягмар, 2019)

Геополитикийн шинэ параметр (өгөгдөл) гэдэг нь бүс нутгийн болон глобал орон зайд их гүрнүүдийн геополитикт уламжлалт бус чиг хандлага хүч түрэн гарч ирсэн хийгээд хүчний шинэ шилжилт хөдөлгөөн эрчимжиж, дахин хуваарилалт явагдаж, геостратегийн шинэ үнэлгээтэй улс орнуудын оролцоо, тэдний чадамж, тэдгээрийн гадаад бодлогын шинэ навигацийг хэлж болохоор байна. Геополитик бол газарзүй, орон зайн байршил, хүч чадавхад суурилсан гадаад улс төрийн бодлого даруй мөн бөгөөд түүнд нөлөөлж буй гол хүчин зүйл нь олон улсын харилцааны орчин, орон зай, цаг хугацаа, таталцлын хүч, харин дотоод хүчин зүйл нь эдийн засгийн байдал, тогтолцоо, засаглалын систем, түүний чанар, ардчиллын төлөвшил юм. Наполеон Банопарт хэлэхдээ: “Аливаа улсын гадаад бодлого нь түүний оршин буй газар зүйн байршлаар тодорхойлогдоно” гэжээ. (Д.Уламбаяр, Монгол улсын үндэсний аюулгүй байдлын гадаад бодлогын шинэ парадигм, 2021)

Хүчирхэгжиж буй эрх мэдлийн төвүүд ба бүс нутгууд

БНХАУ-ын хурдтай өсөж буй эдийн засгийн өсөлт, өсөн нэмэгдэж буй глобал нөлөө нь тус улсыг XI зуунд хүчирхэгжиж буй эрх мэдлийн төв байр сууринд авчирлаа. (Hu, 2011) Бүс ба зам санаачилга нь Төв бүс нутаг болон хязгаар бүс нутгуудыг дайрсан холболтыг хийх зорилготой нь Төв бүс нутаг онолын зарим элементтэй нийцдэг.

Ийнхүү Хятадын эдийн засгийн тэлэлт болон дэд бүтцийн төслүүд нь Төв бүс нутгийн дангаар давамгайллагч байх онолын таамаглалыг үгүйсгэж байна. Түүнчлэн Энэтхэг нь бүс нутаг болон глобал түвшинд томоохон тоглогч болон гарч ирж буй нь Төв бүс нутаг онолын хэрэгжилтэд төвөгтэй байдал үүсгэж байгааг үгүйсгэх аргагүй. Цаашлаад, Ойрх Дорнод нь өөрсдийн бүс нутагт эрх мэдлээ хадгалсаар байна.

Бүс нутагтаа хүчирхэгжин гарч ирж буй Саудын Араб болон Иран зэрэг улсууд дотоодын зөрчил мөргөлдөөнтэй байгаа хэдий ч глобал харилцаанд нөлөөлөгч бүс

нутгийн хүчин зүйлсийн нөлөөллийг үүсгэсээр байна. Төв бүс нутгийн онол нь газар нутагт илүүтэй төвлөрсөн үзэл баримтлал хэдий ч түүх, шашин болон үндэстэн ястны асуудлуудаас үүдэлтэй өөрчлөгдөн буй эрх мэдлийн үйл явцыг таамаглах, шийдвэрлэхэд хангалтгүй болж байгаа нь эдгээр нөхцөл байдлаас тодорхой ажиглагддаг. Ялгаатай эрх мэдлийн төвүүд төрөн гарах болон бүс нутгийн өөрчлөлтийн үйл явц нь XI зуунд Төв бүс нутгийн онолын таамаглалын дагуу үйл явц өрнөхийг багтай илэрхийлж чадахгүй гэдгийг нотолж байна.

Дүгнэлт

Зуу гаруй жилийн өмнө Макиндерийн дэвшүүлсэн Төв бүс нутгийн онол нь геополитикийн үзэл санааны тулгийн чулуу болж өөрчлөгдөн буй глобал эрх мэдлийн үйл явцын загварчлалыг гаргах үзэл баримтлал хэвээр хадгалагдсаар байна.

Энэхүү судалгаагаар уг онолын гол санаанууд, түүхэн нөхцөл байдал болон түүний орчин үеийн чиг хандлагатай хэр зэрэг нийцэж байгаа талаар, XI зууны геополитикт онолын хэрэглээг хийх боломжийн талаар судалсан болно.

Төв бүс нутгийн онол нь газар зүй болон эрх мэдлийн харилцан хамаарлыг ойлгох суурь онол хэдий ч түүнийг өнөө цагийн геополитикийн орчин нөхцөлд ашиглах, хэрэгжүүлэх нь хэд хэдэн хүчин зүйлсээс ихээхэн хамаарч байна. Онолын цөм төвлөрөх цэг буюу газар нутгийн хяналт нь эрх мэдлийг тодорхойлогч хамгийн гол хүчин зүйл байх болно гэсэн үзэл санаа нь эдийн засгийн тусгаар тогтнол буюу бие даасан байдал, технологи, соёлын нөлөө, глобал харилцааг тодорхойлогч төрийн бус тоглогчид гэх мэт хүчин зүйлсийг хамтад нь авч үзэх ёстой гэсэн дүгнэлтэд хүргэдэг.

Олон тооны эрх мэдлийн төвүүд шинээр төрөн гарах, эрх мэдлийн таамаглалын горимууд өөрчлөгдөх, өнөө цаг үеийн мөргөлдөөнүүдийн нарийн төвөгтэй байдал зэрэг нь онолын чадамж орчин үеийн дэлхийн өөрчлөгдөн буй үйл явцыг тайлбарлахад маргаантай асуудал болсоор байгааг харуулж байна.

Ашигласан материал

- Acharay. (2014). "Global international relations (IR) and regional worlds: A new agenda for international studies". *International studies quarterly*, 58(4), 647-659.
- Hu, A. (2011). *China in 2020: A new type of superpower*. Beijing: Brookings Institution Press.
- Ikenberry, G. J. (2018). The end of liberal international order? *International Affairs*, 7-23.
- Johnstone, P. a. (2020). *World wars and the age of oil: Exploring directionality in deep energy transitions*. Energy Research & Social Science.
- Keliris. (2019). Open source intelligence for energy sector cyberattacks. . К. С. А.-Д, *Critical Infrastructure Security and Resilience: Theories, Methods, Tools and Technologies* (хуудсд. 261-281).
- Д.Мягмар. (2019). *Геополитикийн нөхцөл байдал ба Монгол улсын үндэсний аюулгүй байдал*. Геополитик судлалын хүрээлэн, Улаанбаатар хот.
- Д.Уламбаяр. (2020). Геополитикийн орчны өөрчлөлт ба Монгол улсын "Гуравдагч хөрш"-ийн бодлогын парадигм. *journal. num.edu.mn*, 92.
- Д.Уламбаяр. (2021). Монгол улсын үндэсний аюулгүй байдлын гадаад бодлогын шинэ парадигм. *Стратегийн судалгаа*, 6.
- Н.А.Нартов. (2003). *Геополитик*. (Н.Одхүү, Орч.) Улаанбаатар: Арангат Баянгол.
- Н.Галиймаа. (огноо байхгүй). Геополитикийн онол ба Монгол улсын өнөөгийн байдлыг задлан шинжлэх нь. *Политологи-11*, 173.

SPSIRPA FORUM 2024

Session 2-3

Museum diplomacy in soft power politics: The case of China





MUSEUM DIPLOMACY AS A SOFT POWER: THE EXAMPLE OF CHINA

PhD candidate in International Relations, Cha Huina

Associate Professor, PhD. Oyunsuren.S

PhD. Battsetseg.A

ABSTRACT :

Museum diplomacy has received a lot of attention in recent years. Museums are becoming increasingly important players internationally, which can greatly impact culture. The importance of museums in international cultural exchanges has increased their soft power. This article analyzes the role of museums in developing soft power and the ability of museums to exercise soft power and promote international cooperation between countries in the cultural field and explains how museum diplomacy can strengthen soft power based on the case of China.

KEYWORDS: Soft power; cultural diplomacy; museum diplomacy; China

ЗӨӨЛӨН ХҮЧНИЙ БОДЛОГО ДАХЬ МУЗЕЙН ДИПЛОМАТ АЖИЛЛАГАА: БНХАУ-ИЙН ЖИШЭЭН ДЭЭР

УТСОУХНУС, ОУХ, Докторант Н.Цахинаа

УТСОУХНУС, ОУХТ, Дэд профессор, Др. С.Оюунсүрэн

УТСОУХНУС, ОУХТ, Ахлах багш, Др. А.Батцэцэг

Хураангуй:

Сүүлийн жилүүдэд музейн дипломат ажиллагаа аажмаар хүмүүсийн анхаарлыг татах болсон. Музей нь соёлын томоохон нөлөө үзүүлэх чадвартай олон улсын тавцанд улам бүр гол үүрэг гүйцэтгэгч болж байна. Олон улсын соёлын солилцоонд музейн ач холбогдол нь тэдний бий болгож буй зөөлөн хүчийг нэмэгдүүлсэн. Энэхүү нийтлэлд музейн дипломат ажиллагааны зөөлөн хүчийг төлөвшүүлэхэд хэрхэн нөлөөлж буйд дүн шинжилгээ хийж, музейн зөөлөн хүчийг ашиглах, соёлын асуудлаарх улс орнуудын олон улсын хамтын ажиллагааг дэмжих чадамжид дүн шинжилгээ хийсэн. Дараа нь Хятад улсын жишээн дээр үндэслэн музейн дипломат ажиллагаа зөөлөн хүчийг хэрхэн сайжруулж болохыг тайлбарласан болно.

Түлхүүр үг: Зөөлөн хүч; Соёлын дипломат ажиллагаа; Музейн дипломат ажиллагаа; Хятад улс

Удиртгал

Музейн баялаг сан хөмрөгийг дипломат үйл ажиллагаа явуулах, улс орны өвөрмөц соёлыг сурталчлахад ашиглах нь үндэсний сайхан дүр төрхийг бий болгож, зөөлөн хүчийг нэмэгдүүлэх болно. Үндэсний онцлог, үндэсний эрх ашгийн тухайд төр, байгууллагаас номын сан, музей, соёлын төвд хэрэгжүүлж буй гадаад бодлого, соёлын дипломат ажиллагааны нэг зорилго нь үндэсний соёлыг гадаадын олон нийтэд сурталчлан таниулах замаар үндэсний онцлог, үзэл санааг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх явдал юм.¹ Музей бол бусад орны хүмүүст тухайн орны соёлыг судлах хамгийн сайн бөгөөд шууд арга зам юм. Музейн дипломат ажиллагаа нь олон талаараа зөөлөн хүчийг бүрдүүлдэг.

Онолын хувьд Зөөлөн хүч нь Неолиберал онолын хүрээнд тайлбарлагддаг ухагдахуун юм. Уг судалгааны суурь онол болох уг Либерал интернационализм нь олон улсын харилцааны Либерал онолын нэг урсгал бөгөөд уг онол нь либерал ардчиллын аюулгүй байдал, хүн төрөлхтний сайн сайхан байдал, дэвшлийг бэхжүүлэх, дэмжих замаар олон улсын дэг журмыг эрэлхийлэх, нэгтгэх, шинэчлэх зорилготой сэтгэлгээ, үйл ажиллагааны уламжлал юм.² Улс орнууд олон улсын тавцан дахь өөрийн нөлөө, бүтээмж, үндэсний имижийг сайжруулах зорилгоор зөөлөн хүчний бодлогыг ашигладаг. 1990-ээд оны эхээр Харвардын их сургуулийн профессор Жозеф Най “зөөлөн хүч” хэмээх ойлголтыг анх боловсруулж, түүний үзэж буйгаар зөөлөн хүч бол албадлагаар бус хүний сэтгэлийг татах замаар өөрийн хүслээ биелүүлэх буюу өөрийн улсын ашиг сонирхлоо ахиулах явдал юм. Цэрэг, эдийн засгийн хүчинд суурилсан уламжлалт хатуу хүчнээс ангид улс орны

¹ Mariano, R. and Vårheim, A. (2022), "Libraries, museums and cultural centers in foreign policy and cultural diplomacy: a scoping review", *Journal of Documentation*, Vol. 78 No. 3, pp. 651-672. <https://doi.org/10.1108/JD-05-2021-0103>.

² John Ikenberry, *A World Safe for Democracy: Liberal Internationalism and the Crises of Global Order*. (New Haven: Yale University press, 2020.) . pp. 7.

цогц хүчний нэг бүрэлдэхүүн хэсэг юм.³ Зөөлөн хүчний гурван үндсэн эх үүсвэр нь *соёл, улс төрийн үнэт зүйлс, гадаад бодлого* бөгөөд Музейн дипломат ажиллагаа зөөлөн хүчний үзэл санааг хэрэгжүүлсэн нэг жишээ юм. Жозеф Найгийн зөөлөн хүчний онол нь судлаачдын онолын хувьд сонгосон байр суурь байсаар ирсэн бөгөөд ихэнх судалгаанууд музейг улс орнуудын олон улсын сонирхол татахуйц байдлыг нэмэгдүүлэх, улмаар дэлхийн тавцанд соёл, эдийн засгийн хүчийг олж авах зөөлөн хүчний валют (currency) гэж тодорхойлсон байдаг.⁴

Уг судалгааг гүйцэтгэхэд архивын баримт материал, түүхэн болон онолын судалгааны бүтээлүүдтэй танилцаж, мөн БНХАУ-ын Музейн дипломат ажиллагаа, зөөлөн хүчний талаарх эх сурвалж, материалуудтай танилцсан. Энэхүү сэдвийг судлахдаа нийгмийн шинжлэх ухааны түгээмэл аргууд болох мэдээлэлд дүн шинжилгээ хийх арга, баримтын судалгааны арга, түүхэн анализ хийх арга, дедукцийн арга, задлан шинжлэх нэгтгэн дүгнэх зэрэг аргыг ашигласан болно. Хятадын музейг төрийн өмчийн болон төрийн бус өмчийн музей гэж ангилж, нэг, хоёрдугаар, гуравдугаар болон бусад зэрэглэлд хуваадаг. Энэхүү нийтлэлийн судалгааны объект нь Хятадын музей бөгөөд хувийн үзэсгэлэн, уран зургийн үзэсгэлэнг судалгааны хүрээнд оруулаагүй болно. Энэхүү нийтлэлд музейн дипломат ажиллагаанд дүн шинжилгээ хийж, Хятадын жишээн дээр музейн дипломат ажиллагаа зөөлөн хүчд хэрхэн нөлөөлж байгааг тайлбарлах болно.

Зөөлөн хүчний бодлого ба Музейн дипломат ажиллагаа

Олон улсын музейн зөвлөлийн (ICOM) албан ёсны тодорхойлолтын дагуу, “Музей нь биет ба биет бус өвийг судлах, цуглуулах, хамгаалах, олон нийтэд тайлбарлан таниулах, дэлгэн үзүүлэн, үйлчилгээ үзүүлдэг ашгийн бус, байнгын үйл ажиллагаатай байгууллага юм. Музей нь олон нийтэд нээлттэй, хүртээмжтэй байж, олон янз байдал болон тогтвортой байдлыг ханган ёс суртахуунтай, мэргэжлийн өндөр түвшинд, олон нийтэд боловсрол олгох, амрааж цэнгүүлэх, эргэцүүлэн бодуулах, мэдлэгээ хуваалцах үйл ажиллагаа явуулдаг”.⁵ Музейг Хятадын тодорхойлсоноор бол музей нь соёлын дурсгалт зүйлс, үзмэрүүдийг цуглуулах томоохон байгууллага, сурталчлах, боловсролын байгууллага, шинжлэх ухааны судалгааны байгууллага бөгөөд Хятадын социалист шинжлэх ухаан, соёлын үйл ажиллагааны чухал хэсэг юм.⁶ Музей нь бусад соёлын байгууллагуудын нэгэн адил хот, улс орны бэлгэ тэмдэг болж, тухайн нийгмийн соёл, үнэт зүйл, хүсэл эрмэлзлийг бодитоор тусгах чадвартай байдаг.⁷ Музей бол тухайн улсын түүх, соёлтой танилцах ашигтай арга зам юм.

Судлаач Цай Юнчи (Cai yunchi) соёлын дипломат ажиллагааг “зөөлөн хүч”-ний хэрэгсэл гэж тодорхойлсон бөгөөд музейн хамтын ажиллагаа нь соёлын дипломат ажиллагааны нэг хэлбэр юм

³ Joseph S. Nye. *Soft Power: The Means to Success in World Politics* (New Hampshire: Public Affair, 2004), pp. 28.

⁴ Mariano, R. and Vårheim, A. (2022), "Libraries, museums and cultural centers in foreign policy and cultural diplomacy: a scoping review", *Journal of Documentation*, Vol. 78 No. 3, pp. 651-672. <https://doi.org/10.1108/JD-05-2021-0103>.

⁵ International Council of museums (ICOM). Museum Definition (2022). [2022-08-24]. <https://icom.museum/en/resources/standards-guidelines/museum-definition/>

⁶ 中国民族文化资源库 (China Minzu Cultural Resources), “博物馆的定义”, <http://www.minwang.com.cn/eportal/ui?pageId=595416&articleKey=631581&columnId=595057>.

Хятадын угсаатны соёлын нөөцийн номын сан, “Музейн тодорхойлолт”.

⁷ Hoogwaerts, Leanne. "Museums, exchanges, and their contribution to Joseph Nye's concept of 'soft power'." *Museum and Society* 14.2 (2016): 313-322.

гэж илэрхийлсэн.⁸ Мөн Хао Нан судлаач Музейн дипломат ажиллагаа нь музейн түүх, соёл, нийгмийн улс төр, ёс заншил болон бусад үзмэр, тусгайлан зохион бүтээсэн орон зайг ашиглан дипломат зорилгоо илэрхийлэх эсвэл дипломат үйл ажиллагаа явуулах дипломат арга гэж үздэг.⁹ Лорд, Гэйл Декстер, Нгэйр Бланкенберг (Lord, Gail Dexter, and Ngair Blankenberg) нар музей болон зөөлөн хүч хоёрын хоорондох энэхүү тодорхой холбоосыг анх санал болгосон.¹⁰ Судлаачид Сара Э.К.Смит, Саша Приве (Sarah E. K. Smith and Sascha Priewe) нар музейн өөрийн сонирхол, үнэт зүйл, зарчим, тэргүүлэх чиглэлд үндэслэсэн бие даасан музейн дипломат ажиллагаа болохыг дэмждэг юм.¹¹

Олон улсын харилцааны онолын үүднээс авч үзвэл музейн дипломат ажиллагаа нь уламжлалт бус дипломат харилцааны шинэ дипломат ажиллагаа, өөрөөр хэлбэл орчин үеийн дипломат ажиллагаа юм. Музейн дипломат ажиллагаа нь үндсэндээ олон нийтийн дипломат ажиллагаа, соёлын дипломат ажиллагаанд музейн чухал үүргийг онцолж өгдөг.¹² Соёлын зөөлөн хүчний бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа болох соёлын дипломат ажиллагаа нь “харилцан ойлголцлыг дэмжих зорилгоор улс орон, ард түмний хооронд санаа бодол, мэдээлэл, урлаг болон соёлын бусад талуудын солилцоо юм.¹³ Үндэсний хил хязгаарыг давсан соёлын илэрхийлэл нь тухайн улсын дүр төрхийг бүрдүүлэхэд асар их үүрэг гүйцэтгэдэг. Зөөлөн хүчний чухал бүрэлдэхүүн хэсэг болох соёл бол хамгийн үр дүнтэй, эрхэм дипломат хэрэгслийн нэг юм.¹⁴

Олон улсын харилцааны онолд музейн дипломатын албан ёсны тодорхойлолт байдаггүй. Энэхүү нийтлэлд эрдэмтэн судлаачдын өгсөн тодорхойлолт, олон улсын харилцааны онолыг нэгтгэн музейн дипломат ажиллагааг олон нийтийн дипломат ажиллагааны тогтолцооны хүрээнд соёлын дипломат ажиллагаа гэж тайлбарлаж болно. Музейн дипломат ажиллагаа бол олон улсын харилцаа, музейн практикийг нэгтгэх явдал юм. Музей нь байгалийн болон хүн төрөлхтний соёлын өвийг төлөөлж буй биет зүйлийг цуглуулах, дэлгэн үзүүлэх, судлах байгууллагын хувьд зөөлөн хүчийг нэмэгдүүлж, улс орондоо хувь нэмэр оруулж чаддаг.

БНХАУ-ын музейн дипломат ажиллагаа

2012 оны 11-р сарын 29-нд БНХАУ-ын Ши Жиньпин дарга ХКН-ын XVIII сонгуулийн төв хорооны тэргүүлэгчдийг тэргүүлэн Хятадын Үндэсний музейн "Сэргэлтийн зам"-ын үндсэн үзмэртэй танилцаж, Хятад үндэстний агуу их сэргэн мандалтыг хэрэгжүүлэх “Хятад мөрөөдөл”-ийг дэвшүүлсэн. 2021 онд Төв суртал ухуулгын газар зэрэг есөн хэлтсээс хамтран гаргасан “Музейн

⁸ Cai, Yunci. “The Art of Museum Diplomacy: The Singapore-France Cultural Collaboration in Perspective.” *International Journal of Politics, Culture, and Society* 26, no. 2 (2013): 127–44. <http://www.jstor.org/stable/42636448>.

⁹ 郝楠.“中韩关系中的博物馆外交.”公共外交季刊.02(2019):99-105+127. doi:10.16869/j.cnki.pdq.2019.02.015. Hao Nan. “The Museum Diplomacy as Part of China-ROK Relations”, *Public Diplomacy Quarterly*.

¹⁰ Lord, Gail Dexter, and Ngair Blankenberg. *Cities, Museums and Soft Power*. Washington: American Association of Museums, 2015.

¹¹ Edited by Sarah E. K. Smith and Sascha Priewe. “Museum diplomacy : how cultural institutions shape global engagement”, Rowman & Littlefield, [2023].

¹² Sophia Leigh Cambare, “The Future of Museum Diplomacy: Engaging in the Future by Correcting the Past”, factsasia.org/blog/the-future-of-museum-diplomacy-engaging-in-the-future-by-correcting-the-past.

¹³ Milton Cummings, ‘Cultural Diplomacy and the United States Government: A Survey’, *Center for Arts and Culture* (2003), 1.

¹⁴ Cooper, Andrew F., Jorge Heine, and Ramesh Thakur, eds. *The Oxford handbook of modern diplomacy*. Oxford: Oxford University Press, 2013.

шинэчлэл, хөгжлийг дэмжих үндсэн чиглэл”-д 2035 он гэхэд “Дэлхийн музейн гүрэн”-ийг үндсэнд нь бий болгох амбицтай зорилт дэвшүүлсэн.¹⁵ 2016 онд Хятадын Үндэсний музей 7.55 сая үзэгчтэйгээр дэлхийн хамгийн алдартай музейн жагсаалтын нэгдүгээрт жагссан байна.¹⁶ 2022 оны байдлаар Хятад улсад нийт 6565 музей байгуулагдаад байна.¹⁷ Хятад улс нь музейн үйл ажиллагааг олон улсын хэмжээнд илүү өргөн хүрээнд сурталчилж, олон улсын музейн солилцооны механизмыг боловсруулахад оролцож, ялангуяа соёлын дипломатын үүргээ биелүүлж, барууны орнуудтай соёлын яриа хэлэлцээ өрнүүлэхийг зорьж байна.¹⁸

Олон улсын музейн ажил нь зээл, үзэсгэлэн, судалгаа, цуглуулга, хүмүүс хоорондын харилцаа, үзэгчдийн оролцоо, аяллын үзэсгэлэн, хиймэл дагуулын музей, музейн дээд хэмжээний уулзалт, дижитал санаачлага гэх мэт олон янзын арга хэлбэр юм.¹⁹

Соёлын дурсгалт зүйлсийг музейд зээлдүүлэх, бусад орноос зээлж авч өөрийн оронд үзэсгэлэн гаргах нь музейн соёлын солилцооны гол бөгөөд нийтлэг арга юм. Зээл (Loans) бол музейн цуглуулгыг гадаад, дотооддын Байгууллагын нэгж, олон нийтэд зээлдүүлэх үндсэн үйл ажиллагаа юм.²⁰ Хятадын музейн дипломат ажиллагааны нэг жишээ бол Британийн музейд Хятадаас зээлж авсан терракот дайчдын үзэсгэлэн бий. Хятадын Терракотын дайчид нь 1974 онд нээгдсэн бөгөөд 1976 оноос хойш гадаадад үзэсгэлэн гаргахаар илгээгдэж байсан. 2020 он гэхэд дэлхийн 50 орчим орны 270 гаруй газарт 150 гаруй терракот дайчин, морьдын үзэсгэлэн зохион байгуулагджээ.²¹ Ерөнхийдөө эдгээр терракота дайчид, морьдыг харуулсан үзэсгэлэн нь олон нийт, хэвлэл мэдээллийн анхаарлыг илүү татаж, жуулчдыг татах, улмаар илүү их орлого олох хандлагатай байдаг. Британийн музейн үзэсгэлэнг жишээ болгон авч үзвэл, бэлэг дурсгалын зүйлсийн борлуулалтаас олсон ашиг нь өдөрт 11,000-25,000 фунт стерлингийн хооронд байдаг.²² Энэхүү үзэсгэлэн нь 2008 оны Олимпийн өмнө Хятад улсын байр суурыг таатай байдалд оруулахад тусалсан. Энэхүү зохицуулалт нь улмаар Хятадын өөрийн гэсэн соёлын онцлогтой дүр төрхийг бий болгосон.²³ Хятад улс дэлхийн бусад улс орнуудад зохион байгуулагч орныхоо өөр дүр төрхийг амжилттай харуулсан юм.

¹⁵ 中华人民共和国国务院新闻办公室 (The State Council Information Office of the People Republic of China), “关于推进博物馆改革发展的指导意见”, http://www.scio.gov.cn/xwfb/gwyxwbgswfbh/wqfbh_2284/2021n_2711/2021n11y03rsw/wjxgzc_4238/202208/t20220808_315114.html. “Музейн шинэчлэл, хөгжлийг дэмжих талаар баримтлах үзэл бодол”.

¹⁶ Rubin, Judith, ed. “TEA/AECOM 2016 Theme Index and Museum Index: The Global Attractions Attendance Report”, Themed Entertainment Association (TEA), 2017.

¹⁷ 光明国际 (world.gmw.cn), “发挥博物馆外交功能 服务中华文化国际传播”, https://world.gmw.cn/2023-05/18/content_36570508.htm, 2023-05-18. “Музейн дипломат үүргийг бүрэн дүүрэн гүйцэтгэж, Хятадын соёлыг олон улсад түгээн дэлгэрүүлэх үйлсэд туслах нь”.

¹⁸ В.И.Фонин, Е.Э.Альц, 杨俊东译. 博物馆交流在俄中文化外交中的作用[J]. 东北亚学刊, 2020(4):9. V.I.FONIN; E.E.ELTS, “The Role of Museum Affairs in Russia-China Cultural Exchanges”, *Journal of Northeast Asia Studies*.

¹⁹ Priewe, Sascha. “Museum diplomacy: Parsing the global engagement of museums.” *CPD Perspectives on Public Diplomacy (August 2021)*, online (2021).

²⁰ Ibid.

²¹ 中华人民共和国驻纽约总领事馆, “兵马俑已在 41 个国家和地区 150 多个城市展出”, http://newyork.china-consulate.gov.cn/whsw_3/zgwhxx1/201901/t20190104_5553475.htm, 2019-01-04. Бүгд Найрамдах Хятад Ард Улсаас Нью-Йорк дахь Ерөнхий консулын газар, “Терракотта дайчид дэлхийн 41 улс орон, бүс нутгийн 150 гаруй хотод үзэсгэлэн гаргасан”.

²² Da Kong, “Terracotta Diplomacy: Challenges and Opportunities Museums”, *Museum Diplomacy: How Cultural Institutions Shape Global Engagement*, Rowman & Littlefield, 2023.

²³ Da Kong, *Museums, International Exhibitions and China's Cultural Diplomacy* (London: Routledge, 2021).

Санал хураалтад түдгэлзэх /abstention/: “Санал хураалтыг ямар нэг зүйл эсвэл эсрэг талд ашиглахгүй байхыг сонгосон үйлдэл”¹⁰ “Санал хураалтад түдгэлзэх нь оролцогч сонгуулийн өдөр санал хураалтад оролцохгүй байх, эсвэл санал өгөх үеэр байлцсан боловч санал өгөхгүй байх сонгуулийн журмын нэр”¹¹. Хэрэв хувь хүн санал өгөх чадвартай боловч санал өгөхгүй байхаар сонговол тэр хүн санал өгөхөөс татгалзаж байна. Сонгогч хангалттай мэдээлэлгүйн улмаас, тодорхой асуудлаар санал өгөх нь ашиг сонирхлын зөрчилтэй гэж үзвэл, эсэргүүцэж гэх зэрэг олон шалтгаанаар санал өгөхөөс татгалзаж болно. Парламентын гишүүд нь эсэргүүцлийн нэг хэлбэр болох санал өгөхөөс түдгэлзэж болохтой адил сонгогчид сонгуульд мөн адил ийм хэлбэрээр оролцож болно. “Санал хураалт заавал хийх шаардлагагүй газруудад тухайлбал АНУ-д ихэвчлэн нэр дэвшигчид сэтгэл дундуур байгаагийн илэрхийлэл бол санал хураалтыг заавал хийдэг тухайлбал Австрали шиг газарт санал хураалтаас татгалзах нь илүү идэвхтэй эсэргүүцлийг илэрхийлдэг.” (FindLaw's team, 2020)

Улс төрийн цинизм /Political cynicism/: Цинизм нь улс төрчдийг угийн хорон муу гэдэг дээр үндэслэсэн итгэл үнэмшил дээр бүрддэг хувь хүний хандлага ба энэ нь улс төрийн байгууллага болон тогтолцоог бүхэлд нь хамарч болдог. “Цинизм бол бусдын сэдэлд үл итгэх байдлаар тодорхойлогддог хандлага юм. Цинизм нь нийгэм, байгууллага, эрх баригчдын талаар өндөр хүлээлт бий болсны улмаас ёс зүй, нийгмийн үнэт зүйлд үл итгэх байдал юм.” (Olsen, 1969)

Дээрх улс төрийн ойлголтууд нь улс төрийн итгэл буурах, улс төрийг сонирхохгүй байхаас үүдсэн улс төрийн хөндийрөх хандлага буюу улс төрийн хүнийслийн тодорхой илрэлүүд бөгөөд үүнийг дараах схемээр дүрслэн үзүүлбэл:

⁷ Оксфордын Англи-Монгол толь бичиг


⁸ www.oxfordlearnersdictionaries.com/us/definition/english/absenteeism?q=absenteeism

⁹ www.ru.m.wikipedia.org

¹⁰ www.oxfordlearnersdictionaries.com/us/definition/english/abstention?q=abstention

¹¹ en.wikipedia.org/wiki/Abstention

Зураг 1. Улс төрийн хүнийсэл/схем/



Судалгааны арга зүй: Улс төрийн шинжлэх ухаанд улс төрийн хүнийслийг судлах, хэмжихдээ дараах судалгааны чиглэлд анхаарлаа түлхүү хандуулж байна. Үүнд:

1. Улс төрийн хүнийслийг улс төрийн тогтолцооны бүхий л хүрээнд уялдуулан судлах
2. Улс төрийн хүнийслийг хэмжих
3. Улс төрийн хүнийслийн түвшинг тодорхойлох
4. Улс төрийн хүнийслийн төрөл, шинж чанарыг тодорхойлох

Улс төрийн хүнийслийн онол болон дээрх арга зүйд үндэслэн судалгааны ажлын арга зүйг боловсруулан 6 чиглэлээр 1-10 шкалаар 60 асуултын дагуу олон нийтийн санаа бодлын судалгаа хийсэн.

1. Түүврийн хэмжээ: 1302

2. Түүврийн найдварт байдал: (i) Монгол Улсын 5 бүс нутгийн хүн амын төлөөллийг бүрдүүлэх; (ii) хүн амын тоог харгалзан үзэх; (iii) нас, хүйсийн харилцааг хангах; (iv) найдвартай байдлын шинжилгээний үр дүн гэсэн 4 үзүүлэлтийг харгалзсан.


RELIABILITY ANALYSIS (CRONBACH'S ALPHA)

	Value
Cronbach's alpha	0.86
Valid cases	1296 (99.5%)
Missing cases	6 (0.5%)

3. Судалгааны хувьсагчид:

Хүн ам зүйн 7 хувьсагч /нас, хүйс, боловсролын түвшин, өрхийн орлого, оршин суугаа газар, оршин суугаа газрын байршил/, улс төрийн мэдлэг; улс төрийн итгэлийн 5 хувьсагч; улс төрийн сонирхлын 4 хувьсагч.

Зураг 2. Улс төрийн хүнийслийн индекс, индикаторууд /Монгол/



Дээрх индикаторуудад хамаарлын шинжилгээ/ CORRELATION: SPEARMAN'S RHO/ болон шугаман регрессийн шинжилгээ / LINEAR REGRESSION/ хийхэд улс төрийн хүнийсэлтэй хүчтэй хамааралтай байгаа нь тодорхойлогдсон. Тухайлбал, УИХ-д итгэх итгэлийг хэмжих 7 үзүүлэлтийн хамаарлын шинжилгээ хийхэд:

Зураг 3. УИХ-д итгэх итгэлийг хэмжих үзүүлэлтийн хамаарлын шинжилгээ

	Чиг үүргийн хэрэгжилт	Төлөөлөх чадавх	Төсвийн хуваарилалт	Үнэнч байдал	Шударга шийдвэр	Авлига	Эх оронч байдал
Чиг үүргийн хэрэгжилт		0.439 (p=0.0000) N=1301	-0.050 (p=0.0688) N=1302	0.365 (p=0.0000) N=1302	0.510 (p=0.0000) N=1302	-0.144 (p=0.0000) N=1302	0.419 (p=0.0000) N=1302
Төлөөлөх чадавх	0.439 (p=0.0000) N=1301		-0.114 (p=0.0000) N=1301	0.390 (p=0.0000) N=1301	0.476 (p=0.0000) N=1301	-0.230 (p=0.0000) N=1301	0.488 (p=0.0000) N=1301
Төсвийн хуваарилалт	-0.050 (p=0.0688) N=1302	-0.114 (p=0.0000) N=1301		-0.107 (p=0.0001) N=1302	-0.146 (p=0.0000) N=1302	0.615 (p=0.0000) N=1302	-0.174 (p=0.0000) N=1302
Үнэнч байдал	0.365 (p=0.0000) N=1302	0.390 (p=0.0000) N=1301	-0.107 (p=0.0001) N=1302		0.535 (p=0.0000) N=1302	-0.213 (p=0.0000) N=1302	0.424 (p=0.0000) N=1302
Шударга шийдвэр	0.510 (p=0.0000) N=1302	0.476 (p=0.0000) N=1301	-0.146 (p=0.0000) N=1302	0.535 (p=0.0000) N=1302		-0.258 (p=0.0000) N=1302	0.480 (p=0.0000) N=1302
Авлига	-0.144 (p=0.0000) N=1302	-0.230 (p=0.0000) N=1301	0.615 (p=0.0000) N=1302	-0.213 (p=0.0000) N=1302	-0.258 (p=0.0000) N=1302		-0.273 (p=0.0000) N=1302
Эх оронч байдал	0.419 (p=0.0000) N=1302	0.488 (p=0.0000) N=1301	-0.174 (p=0.0000) N=1302	0.424 (p=0.0000) N=1302	0.480 (p=0.0000) N=1302	-0.273 (p=0.0000) N=1302	

УИХ-г зөв зүйл хийж байгааг илтгэх индикаторуудаас хамгийн өндөр хамааралтай нь шударга шийдвэр гаргадаг гэсэн индикатор байгаа бөгөөд УИХ-д итгэхэд шударга шийдвэр гаргах, иргэдийн эрх ашгийг төлөөлөх, эх оронч байх, үнэнч ажиллах зэрэг нь эерэг үнэлгээг авчирдаг бол төсвийг үр ашигтай зарцуулахгүй байх, авлига авах зэрэг нь УИХ-г зөв зүйл хийхгүй байна гэж үзэхэд нөлөөлж байна. Түүнчлэн тус хоёр индикатор нь иргэдийн эрх ашгийг төлөөлдөг, үнэнч ажилладаг, шударга шийдвэр гаргадаг, эх оронч байх гэсэн индикаторуудтай сөрөг хамааралтай байгаа нь УИХ-д итгэх итгэлийг бууруулах гол хүчин зүйл болж байна.

Дүгнэлт:

Судалгааны үр дүнд улс төрийн сонирхол 10 /өндөр/ - 0 /сонирхолгүй/, улс төрийн итгэл 10 /маш их итгэдэг/- 0 /итгэдэггүй/ гэсэн утгыг илэрхийлэх бөгөөд үзүүлэлтийн дундаж утга, улс төрийн сонирхлын индекс /PI/ нь 4.1, улс төрийн итгэлийн индекс /PT/ нь 3.28 гэсэн оноотой байгаа нь Монголд улс төрийн хүнийсэл байгааг тодорхойлж байна. Мөн Монгол дахь улс төрийн хүнийслийн хэв маягийн хувьд:

- Улс төр, төрийн бодлогоос шалтгаалж иргэд төрөөс, төр иргэдээсээ хүнийсэх хандлагатай байна.
- “Нийгмийн амьдралын объектив байдал доройтож, субъектив мэдрэмжийн сөрөг үнэлэмжээс үүдэн улс төрөөс хөндийрөх хандлага байна.
- Иргэдийн улс төрийн хандлага, үйл байдалд тулгуурлан идэвхтэй, идэвхгүй улс төрийн хүнийсэл гэж хоёр хуваагддаг хандлага байна.

Номзүй:

1. Alienation. (2018 оны Aug 30). Plato.stanford.edu: <https://plato.stanford.edu/entries/alienation/>-ээс Гаргасан
2. Allyssa, B., & Elise, S. (2016 оны Jun 28). Americans' Sense of Alienation Remains at Record High. www.theharrispoll.com: <https://theharrispoll.com/in-the-midst-of-the-contentious-presidential-primary-elections-the-harris-poll-measured-how-alienated-americans-feel-as-part-of-a-long-term-trend-the-last-time-alienation-was-measured-was-in-novemb/>-ээс Гаргасан
3. Amin, Z. A. (2016 оны 6 18). Attitude: Adoption and Change. slideshare.net: <https://www.slideshare.net/zulfiquer732/attitude-formation-and-change>-ээс Гаргасан
4. Berger, B. (2009). Political Theory, Political Science, and End of Civic Engagement. Perspectives on Politics Vol.7 No.2, 335-350.
5. Chuluunbaatar, G. (2018). Deliberative democracy as a possible solution to the challenges of Mongolian Democracy. Proceedings of the International Conference on "Deliberative Democracy in Asia", (хуудсд. 55-72). Ulaanbaatar.
6. Comninel, G. C. (2018). Alienation and Emancipation in the Work of Karl Marx. New York: Springer Nature America Inc.
7. Dean, D. G. (1965). Powerlessness and Political apathy, Social Science 40 (4). Social Science 40 (4), 208-213.
8. Easton, D. (1965). A systems Analysis of Political Life. New York: John Wiley & Sons.
9. Economist Intelligence Unit. (2015). Democracy Index 2015: Democracy in an age of anxiety.
10. FindLaw's team. (2020 оны Mar 18). www.findlaw.com. What does Abstention from Voting Mean?: <https://www.findlaw.com/voting/my-voting-guide/what-does-abstention-from-voting-mean-.html>-ээс Гаргасан
11. Finifter, w. (1970). Dimensions of Political Alienation. The American Political Science Review. Vol 64. No 2, 389-410.
12. Gabriel, O. W. (2011). Alienation. B. Badie (Ed), D. Berg-Schlosser (Ed), & L. Morlino (Ed)-Д, International Encyclopedia of Political Science Vol 1 (хуудсд. 57-60). SAGE Publications.
14. Gustave, L. B. (2003). The Crowd a Study of the Popular Mind. Kessinger Publishing Co.
19. Harris Poll Alienation Index Climbs Again as Two-Thirds of Americans Feel Alienated. (2013 оны Nov 12). www.prnewswire.com: <https://www.prnewswire.com/news-releases/harris-poll-alienation-index-climbs-again-as-two-thirds-of-americans-feel-alienated-231542101.html>-ээс Гаргасан

20. Jackson, S. J. (1983). The Alienation of the individual from society: A social-psychological theory and cross-cultural comparison. <https://www.semanticscholar.org/paper/The-alienation-of-the-individual-from-society%3A-A-Jackson/27539e80afa71b92ecfb43e2aff5331c8a94dc71>-ээс Гаргасан
21. Klima, M. (2017). Тоталитар дэглэмээс гажуудсан ардчилал руу. Улаанбаатар: "СЭЛЭНГЭПРЕСС" ХХК.
22. Mauk, M. (2020). Disentangling an Elusive Relationship: How Democratic Value Orientations Affect Political Trust in Different Regimes. *Political Research Quarterly*, 73(2), 366-380.
23. Nettler, G. (1957). A measure of alienation. *American Sociological Review*, 22,, 670-677.
24. Olsen, M. E. (1969). Two categories of political alienation. *Oxford Journals*, Vol 47, (Issue 3), 288-299.
25. Oskarson, M. (2007). Social Risk, policy Dissatisfaction and Political Alienation: A Comparison of Six European Countries. S. (. Svallfors-Д, *The Political Sociology of the Welfare State: Institutions, Social Cleavages, and Orientations* (хуудсд. 117-148). Stanford University Press.
26. Oskarson, M. (2010). Social and Political Marginalization i Hard Times. SSRN Abstract Database Search Results APSA 2010 Washington, D.C. Meeting. Washington: American Political Science Association.
27. Oxford University. (2006). *Colour Oxford English Dictionary*. New York: Oxford University Press.
25. Patterson, T. E. (2008). *The American Democracy*. New York: McGraw-Hill Companies, Inc.
26. Reef, M., & Knoke, D. (1999). Political Alienation and Efficacy. J. P. Robinson, R. S. Phillip, & S. Lawrence-Д, *Measures of Political Attitudes* (хуудсд. 413-464). San Diego, CA: Academic Press.
27. Schwartz, D. C. (2017). *Political Alienation and Political behavior*. London and New York: Routledge.
28. Sidney, J. J. (1983). The Alienation of the individual from society: A social-psychological theory and cross-cultural comparison. <https://lib.dr.iastate.edu/rtd/8484/>.
29. Social indicators. (2016 оны May 16). [www.progress.org: http://wikiprogress.org/articles/archive/social-indicators/](http://wikiprogress.org/articles/archive/social-indicators/)-ээс Гаргасан
30. Srole, L. (1956). Social integration and certain corollaries. *American Sociological Review*, 709-716.
31. Tomas, I. P. (2020). Alienation and fetishism in Karl Marx's Critique of Political Economy. *Nova Economia* Vol 30 No2, 605-628.

32. Viktor, D., Amna, E., & Banaji, S. (2018). Apathy or Alienation? Political passivity among youths across eight European Union Countries. *European Journal of Development Psychology* Volume 158, 284-301., 284-301.
33. Weakliem, D., & Borch, C. (2006). Alienation in the United States: Uniform or group-specific Change? *Sociol Forum* 21, 415-438.
34. Wood, M. J. (2014 оны 04 23). Political alienation in American Society. <https://scholarworks.uvm.edu>:
<https://scholarworks.uvm.edu/cgi/viewcontent.cgi?article=1007&context=hcoltheses-ээс>
Гаргасан
35. Атар, Ю. (2005). Улс төрийн системийн бүцийн өөрчилөлтөнд нөлөөлөх хүчин зүйлүүд. *Политлоги №246 /28/, 47-52.*
36. Базарпүрэв, С., & Туяагэрэл, Г. (2011). Улс төрийн сэтгэлгээний түүхэн дэх улс төрийн хямралын тухай үзэл санаа ба түүний хувьсан өөрчлөлт. *Политлоги №350 /62/, 34-51.*
37. Батболд, Ц. (2019). Бодолгын шинжилгээний онол, арга зүйн үндэс. Улаанбаатар: "Удам соёл" хэвлэлийн газар.
38. Батболд, Ц., & Түмэнжаргал, Д. (2015). Монголын сонгогдын оролцоонд нөлөөлж буй хүчин зүйлс. *Политлоги №12 /419/, 120-140.*
39. Батсүх, Ш., Долгоржав, Я., & Ганцоож, Б. (2014). Шууд ардчилал, иргэдийн оролцоо. Улаанбаатар.
40. Батсүх, Ш., & Бурмаа, Н. (2019). Орон нутгийн тогтвортой хөгжил- оролцогч талууд. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох нь (хуудсд. 176-234).-Д улаанбаатар: "Мөнхийн үсэг" ХХК.
41. Батсүх, Ш., & Дэлгэржаргал, Ц. (2019). Орон нутаг дахь иргэдийн оролцоо. Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох нь (хуудсд. 135-234).-Д Улаанбаатар: "Мөнхийн үсэг" ХХК.
42. Болд, Р. (2007). Ядуурал, тэгш бус байдал нийгэм-улс төрийн мөргөлдөөний сурвалж болох нь. *Политлоги №281 /40/, 154-166.*
43. Бумдарь, Д. (2019). Ардчиллын хөгжил, бэхжилтийн тулгамдсан асуудал, сорилтууд. Монгол дахь ардчиллын хөгжил, бэхжилт, асуудал, сорилт \1990-2019\ (хуудсд. 9-41).-Д Улаанбаатар: "Адмон принт" ХХК.
44. Ганболд, Ц., & Мягмарцоож, Н. (2011). Төрийн бодлогын үйл явц дахь иргэдийн оролцооны зарим асуудал /1990 оноос хойш/. *Политлоги №350 /62/, 129-130.*
45. Довчин, Ё. (2008). Харьцуулсан улс төр. Улаанбаатар: Бит Пресс ХХК.
46. Карл, П. Р. (2006). Нээлттэй нийгэм, түүний дайснууд: . Улаанбаатар: "Монсудар" хэвлэлийн газар.

47. Конрад Аденауэрын сан. (2022). Улс төр ба нийгэм: дээж мэдлэг. Улаанбаатар: Адмон принтинг ХХК.
48. Монгол Улсын Үндсэн Хууль. (1992). Улаанбаатар.
49. Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комисс. (2004). Монгол Улс дахь тайван жагсаал цуглаан, хийх эрхийн төлөв байдал, цаашид боловсронгуй болгох асуудал" сэдэвт судалгааны тайлан. Улаанбаатар.
50. Монголын хуульч эмэгтэйчүүдийн холбоо ТББ. (2016). Монгол улсын хүчин төгөлдөр хууль, холбогдох захиргааны хэм хэмжээний актад тусгасан төрийн байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллагаас шийдвэр гаргахад иргэдийн оролцоог хангах аливаа зохицуулалтын өнөөгийн хэрэгжилтийн байдалд хийсэн үнэлгээгээ. http://www.irgen-tur.mn/sites/default/files/documents/Irgediin_oroltsoo_legal_study.pdf.-ээс Гаргасан
51. Мөнхцэцэг, Ц. (2007). Бэлгэ тэмдэгийн улс төр: Онолын асуудал ба Монгол дахь төлөв байдал. УТБА-ийн Шинэ толь сэтгүүл №57, 51.
52. Мөнхцэцэг, Ц. (2019). Сонгуулийн үйл явц: Сонгуулийн компани, сонгуулийн систем, тулгамдсан асуудал. Монгол дахь ардчиллын хөгжил, бэхжилт, асуудал, сорилт \1990-2019\ (хуудсд. 107-131).-Д Улаанбаатар: "Адмон принт" ХХК.
53. Мягмарсүрэн, Д. (2019). Иргэний нийгмийн хөгжлийн асуудал. Монгол дахь ардчиллын хөгжил, бэхжилт, асуудал, сорилт /1990-2019/, 157-207.
54. Оргил, Д. (2020). МОНГОЛ ДАХЬ АРДЧИЛЛЫН БЭХЖИЛТ, СОРИЛТЫН ЗАРИМ АСУУДЛЫГ ОЛОН УЛСЫН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГААНЫ ҮҮДНЭЭС АВЧ ҮЗЭХ НЬ. Төрийн байгуулалтын экспертийн зөвлөл-Д, Монгол дахь ардчилал, иргэний нийгмийн өнөөгийн байдлын нийгэм-улс төрийн судалгаа (хуудсд. 231-241). Улаанбаатар.
55. Ранжит, К. (2019). Судалгааны аргазүй:Чанарын судалгаанд алхам алхаамаар чиглүүлэх хөтөч. 4 дэх хэвлэлийн орчуулга. Улаанбаатар: Аураг хэвлэлийн газар.
56. Ричард, Р. (2005). Азийн үнэт зүйлс, пост-коммунист өв болон улс төрийн итгэлцэлд үзүүлэх женерик нөлөө: агуулга аргазүйн анализ. У. т. академ-Д, Зүүн Азийн Барометр /Ардчиллын хөгжлийн харьцуулсан судалгаа (хуудсд. 119-138). Улаанбаатар.
57. Сант Марал Сан. (2010-2023). Улс төрийн барометр №8-№18. <https://mn.santmaral.org/publications>-ээс Гаргасан
58. Содном, Ш. (2020). Улс төр судлалын онол, практикийн асуудлууд. Улаанбаатар.
59. Сонгуулийн Ерөнхий Хороо. (2016). Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн дүн. <https://gec.gov.mn/uploads/ИHsonguuli2012.pdf>-ээс Гаргасан
60. Сонгуулийн Ерөнхий Хороо. (2017). Монгол Улсын Ерөнхийлөгчийн Сонгуулийн Дүн. <https://www.gec.gov.mn/uploads/erunhiilugch%202013%20book%20last.pdf>-ээс Гаргасан

61. Тамир, Ч. (2018). Ерээд оны Монголын олон нийтийн эсэргүүцлийн социологийн шинжилгээ. Социологийн шинжлэх ухааны доктор (Ph.D)-ын зэрэг горилсон бүтээл. <https://catalog.num.edu.mn>.-ээс Гаргасан
62. Төмөрбаатар, Я. (2020). Хүнийсэл. Ж. Төртогтох (Ed), & С. Мөнхбат (Ed)-Д, Улс төрийн шинжлэх ухааны нэвтэрхий толь бичиг (хуудсд. 747-750). Улаанбаатар: Адмон принт ХХК.
63. Төрийн байгуулалтын экспертийн зөвлөл 2020. (2020). Монгол дахь ардилал, Иргэний нийгмийн өнөөгийн байдлын нийгэм-улс төрийн судалгаа. Улаанбаатар.
64. Төртогтох (Ed), Ж. (2021). Улс төрийн мэдээлэл харилцаа. Улаанбаатар: Удам соёл.
65. Төртогтох, Ж., Өлзийсайхан, Ч., & Эрдэнэдалай, Б. (2011). Улс төрийн институт ба олон нийтийн итгэл: харьцуулсан судалгаа. Политологи №350 /62/, 107-123.
66. Түмэннаст, Г. (2019). Нийгмийн социал хүрээний өөрчлөлт, асуудал. Монгол дахь ардчиллын хөгжил, бэхжилт, асуудал, сорилт /1990-2109/ (хуудсд. 240-271).-Д Улаанбаатар: "Адмон принт" ХХК.
67. Удирдлагын Академи. (2016). Залуучуудын улс төрийн оролцоо /18-35 нас/. http://ivote.mn/files/kas_45694-1522-18-30.pdf-ээс Гаргасан
68. Улс Төрийн Боловсролын Академи. (2005). Зүүн Азийн Барометр: Ардчиллын хөгжлийн харьцуулсан судалгаа. Улаанбаатар.
69. Уртнасан, Д. (2020). Коронавируст халдвар ба сонгуулийн үйл явц: олон улс болон Монгол улсын зарим туршлагаас. Шинэ толь 81, Улс Төрийн Боловсролын Академи, 54-66.
70. Уртнасан, Ц., & Пүрэв, Ц. (2008). Социологийн судалгааны аргазүй, аргачлал. Улаанбаатар.
71. Үндэсний Статистикийн Хороо. (2019). Сонгуулийн санал хураалтын дүн шинжилгээ. www.esan.mn: <https://www.esan.mn/read/7082>-ээс Гаргасан
72. Фромм, Э. (2002). Эрх чөлөөнөөс дайжихуй. Улаанбаатар: Цомирлогтөв ХХК.
73. Фромм, Э. (2007). Найдвараа хувьсгах уу. Улаанбаатар: Монсудар.
75. Фромм, Э. (2015). Хайрлах урлаг. Улаанбаатар: Монсудар.
76. Хатанболд, О. (2017). Ардчилал судлал: Онол, арга зүй. Улаанбаатар: "Соёмбо принтинг" ХХК.
77. Хатанболд, О. (2017). Ардчиллыг ойлгохуй ба судлахуй Монгол орны Жишээн дээр. Улаанбаатар: "Соёмбо принтинг" ХХК.
78. Хишигням, Б. (2019). 90 оноос хойшхи нийгмийн зарим үзэгдэлд хийсэн сэтгэлзүйн шинжилгээний үр дүн. Монгол дахь эрдчиллын хөгжил, бэхжилт, асуудал, сорилт /1990-2019/ (хуудсд. 297-299).-Д Улаанбаатар: "Адмон принт" ХХК.


80. Хууль зүй, Дотоод хэргийн яам. (2007). Шүүх, эрх зүйн шинэчлэлт, Философи гарын авлага. Улаанбаатар.

81. Эрдэнэ, Б. (2011 оны Б.Эрдэнэ, (2011) 7-р сарын 1–ний үйл явдалд хийх социологийн шинжилгээ, Магистрын судалгааны ажил, Улаанбаатар, 13. Retrieved from <https://catalog.num.edu.mn>). 7-р сарын 1–ний үйл явдалд хийх социологийн шинжилгээ, Магистрын судалгааны ажил. Улаанбаатар: <https://catalog.num.edu.mn>

SPSIRPA FORUM 2024

Session 3-2

Immanuel Kant's "Perpetual Peace" and idealistic ideas in international relations



**Иммануэл Канта "Үүрдийн энх тайван" ба
олон улсын харилцаан дахь идеалист үзэл санааны сорилт**

П.Мягмардорж¹

Хураангуй: Германы сонгодог философич, соён гэгээрлийн эрин үеийн нэрт төлөөлөгч И.Канта 1795 онд бичсэн “Үүрдийн энх тайван” хэмээх бүтээл нь олон улсын харилцааны онолын голлох дэг сургуулиудын нэг болох либераль-идеализмын үзэл санааны суурь бүтээл болсон. “Үүрдийн энх тайван”-аас санаа авч хожмын улс төрчид, онолын сэтгэгчид олон улсын харилцаанд энх тайван тогтоох олон арван оролдлогуудыг хийсээр өдийг хүрчээ. Гэвч олон улсын харилцаа, дэлхийн улс төрийн системд үүрдийн энх тайван, амар амгалан байдал тогтож чадахгүй байсаар өнөөдрийг хүрсэн ба дэлхийн өнцөг булан бүрт дайн тулаан, хямрал мөргөлдөөн өрнөсөөр байна. Энэхүү судалгааны ажил нь нэг талаас олон улсын харилцааны либераль-идеалист үзэл санаанд И.Канта бүтээл ямар нөлөө үзүүлсэн болох, нөгөө талаас дайн тулаан үргэлжлэн гарсаар энх тайван байдал тогтохгүй боломжгүй байгаагийн учир шалтгааныг түүний бүтээлд контент анализ хийх замаар тодруулахыг зорьлоо. “Үүрдийн энх тайван”-ыг судлан, өнөөдрийн өрнөж буй үйл явдалд дүн шинжилгээ хийхэд дийлэнх улсуудын гадаад бодлогын шийдвэрт “үндсэрхэг үзэл” хүчтэй нөлөөлж буй нь тодорхой болж байна.

Түлхүүр үгс: Иммануэл Кант, “Үүрдийн энх тайван”, “Вильсонизм”, “үндсэрхэг үзэл”

Abstract: German classical philosopher who was one of the foremost thinkers of the Age of Enlightenment Immanuel Kant wrote "Perpetual Peace" in 1795. "Perpetual peace" became the foundation of liberal-idealism, one of the main theoretical schools of international relations. Inspired by "Perpetual Peace", later politicians and theoretical thinkers have made dozens of attempts to establish peace in international relations. However, the international relations and the world political system have not been able to establish perpetual peace until now. On the one hand, this research aims to clarify the impact of Kant's work on the liberal-idealist idea of international relations, and on the other hand, the reason why peace cannot be established due to the ongoing war, through content analysis of his work. When studying "Perpetual Peace" and analyzing the current events, it becomes clear that "nationalism" has a strong influence on the foreign policy decisions of most of countries in world stage.

Key words: Immanuel Kant, “Perpetual peace”, “Wilsonianism”, “Nationalism”

¹ ХИС-ийн Олон улс, нийгэм судлалын тэнхимийн ахлах багш, доктор (Ph.D.)
Цахим хаяг: myagmardorj@humanities.mn

Удиртгал

Орчин цагийн олон улсын харилцаа, геополитикийн нөхцөл байдлыг ойлгоход олон улсын харилцааны системийг тодорхойлж байдаг их гүрнүүдийн гадаад бодлогын талаарх судалгаа нэн чухал. Ялангуяа хүйтэн дайны дараах олон улсын харилцааны “шинэ дэг журам” өөрчлөгдөж, дэлхийн бодлого дахь хүчний төвийн шилжилт өрнөн, геополитикийн дахин хуваарилалт эхэлсэн энэ цаг үед дэлхийн бодлогыг тэргүүлэн, цаашдаа ч энэхүү байр сууриа хадгалан үлдэхийг зорьж буй АНУ-ын гадаад бодлогыг судлах нь зүйд нийцнэ. Чингэхдээ нэг талаас дэлхийн улс төр, эдийн засгийн өнөөгийн системийг ойлгоход АНУ-ын гадаад бодлого хэрхэн бүрэлдэн бий болсон талаарх судалгааны ажил ихээхэн ач холбогдолтой. Нөгөөтэйгүүр, АНУ-ын гадаад бодлогын шийдвэр гаргалтад чухал нөлөө үзүүлдэг улс төрчид, улс төрийн онолчид, олон улсын харилцааны салбарын эрдэмтдийн үзэл санааны талаар судалгаа дүн шинжилгээ хийх шаардлагатай.

Олон улсын харилцааны систем өөрчлөгдөх бүрт тухайн системийг өнгөлж буй, аль эсвэл тэргүүлэх байр суурь эзлэхийг зорьж буй гэх мэтчилэн улсуудын гадаад бодлогын шийдвэр гаргалтын өмнө тодорхой сонголт хийх шаардлага гардаг. Олон улсын харилцааны системийг тэргүүлж байх үеийн тухайн улсын гадаад бодлого, бодлогын шийдвэр гаргалт өөрийн гэсэн онцлог, арга барил, онолоор тодорхойлогддог бол системд өрсөлдөхүйц хүчтэй, хүчний тэнцвэрийг хангаж чадахуйц өөр нэг улс (өнөөдөр энэ тохиолдолд БНХАУ болон ОХУ-ын явуулж буй гадаад бодлого гол байр суурь эзлэх болов уу) их гүрний статусын төлөөх бодлого явуулж эхлэхэд бодлогын шийдвэр гаргалтыг өөр байдлаар, өөр онолд тулгуурлан гаргахаас өөр аргагүй болдог. Өнөөдөр АНУ-ын гадаад бодлого, бодлогын шийдвэр гаргалт яг ийм сонголтын үеэтэйгээ тулгараад байна.

АНУ-ын гадаад бодлого нь 19-р зуунд “изоляциялист” бодлогоор тодорхойлогдож байсан бол 20-р зуун гарснаар “вильсонист” буюу либераль-интернационалист гадаад бодлого гол байр суурь эзлэх болсон. Тэгвэл 21-р зуун гарснаар АНУ-ын гадаад бодлогын шийдвэр гаргалтад нөлөө бүхий улс төрчид, олон улсын харилцааны онолчдын дунд гадаад бодлого, геополитикийн асуудлаарх маргаан хүчтэй өрнөх боллоо. Энэ маргааны нэг талд сонгодог геополитикийн онол, реалист дэг сургуулийн үзэл санаанд тулгуурлан олон улсын харилцаа, гадаад бодлогыг тодорхойлдог консерватив чиг шугамыг баримталдаг судлаачид болоод шийдвэр гаргагчид зогсож байна. Харин нөгөө талаас либераль-идеалист уламжлалыг үндэслэл болгодог “вильсонист” буюу “либераль-интернационалист” байр суурийг баримталдаг улс төрчид, эрдэмтэд өөрсдийн байр суурийг хамгаалахаар хичээж буй нь ихээхэн анхаарал татсан сэдэв болоод байна.

Энэхүү “вильсонист” буюу олон улсын харилцаанд ардчилсан-либераль үнэт зүйлсийг түгээн дэлгэрүүлснээр АНУ-ын ашиг сохирхол, аюулгүй байдал баталгаажна хэмээн үздэг улс төрчдийн үзэл баримтлалд хамгийн хүчтэй нөлөөлсөн сэтгэгч, философич бол яах аргагүй “Соён гэгээрлийн эрин үе”-ийн Германы философийн гол төлөөлөгч Иммануэл Кант юм. Түүний 1795 онд хэвлүүлсэн “Үүрдийн Энх Тайван” хэмээх бүтээл нь олон улсын харилцааны либераль-идеалист онолын дэг сургуулийн үзэл санаа, мөн орчин цагийн олон улсын нийтийн эрх зүйн гол эх сурвалж хэмээн зүй ёсоор тооцогддог. 20-р зууны туршид АНУ-ын явуулсан гадаад бодлогын

тэргүүлэх зорилтуудын нэг нь яах аргагүй олон улсын улсын харилцаанд ардчилсан-либераль үнэт зүйлсийг түгээн дэлгэрүүлэхэд оршиж байв.

Ийнхүү либераль-интернационалист гадаад бодлогын зарчмыг баримтлах болсны учир нь АНУ-ын ерөнхийлөгч В.Вильсон болоод дараа үеийн зарим улс төрчдөд И.Кантын “Үүрдийн энх тайван” хүчтэй нөлөөлсөнд оршино. Нэг талаас И.Кантын үзэл санаа юу байв, хэрхэн дэлхийн улс төрийн бодлогод нөлөөлөв гэдгийг судлах бол нөгөө талаас өнөөдрийн олон улсын харилцаанд ямар учир дайн мөргөлдөөн үргэлжилсээр, “үүрдийн энх тайван тогтох” боломжгүй байгаагийн учир шалтгааныг тайлахыг зорьлоо.

Үндсэн хэсэг

Соён гэгээрлийн эрин үеийн Францын сэтгэгч, нийтлэлч Шарль-Ирэнэ Кастель аббат Сен-Пьер 1713 онд “Үүрдийн энх тайвны төсөл” бүтээлдээ “үүрдийн энх тайван”-ы үзэл санааг анхлан дэвшүүлсэн байдаг. Тэгвэл улсуудын хоорондын харилцаанд энх тайван тогтоож болох санааг Францын философич Жан Жак Руссо болон Английн философич Жереми Бентам өөр өөрсдийн хувилбарыг танилцуулсан байдаг. Харин “үүрдийн энх тайван” тогтоох хамгийн нөлөө бүхий бүтээл бол И.Кантын² 1795 онд бичсэн “Үүрдийн энх тайван: философийн ноорог” эссе юм. (Rentmeester, 2022) 1795 оны 3 сард Францын-Пруссын дайн дуусаж Базелийн гэрээ байгуулах үйл явц эхэлсэн. Энэхүү үйл явдал нь И.Кантыг “Үүрдийн Энх Тайван”-аа бичихэд хүргэсэн түүхэн нөхцөл болсон бөгөөд тэрээр энэхүү гэрээг “дайсагналыг зогсоосон түр гэрээ болохоос энхийн гэрээ биш” хэмээн шүүмжилсэн байдаг. (James Bohman, Matthias Lutz Bachmann, 1997)

Иммануэл Кантын дэвшүүлсэн “Үүрдийн Энх Тайван”-ы тухай үзэл санаа нь орчин үеийн олон улсын харилцаа, дипломат ажиллагаа хэлбэршин тогтоход томоохон нөлөө үзүүлсний зэрэгцээ дайны асуудлыг энхийн замаар, эв зүйгээр шийдвэрлэх арга замыг эрэлхийлж байсан олон арван философич, улс төрчдийн үзэл номлол бүрэлдэн бий болоход чухал дэм болсон билээ. Дайныг гадаад бодлогынхоо арга хэрэгсэл болгох замаар нөлөөнийхөө хүрээг тэлж, эрх мэдлийн оргилд хүрэх гэсэн хандлага өнөөдрийн олон улсын харилцаанд бодитоор оршсоор л байна. Зарим философичид “хүн хүндээ чоно”, улс төрд “ёс суртахуун” чухал биш, “дайн бол хүн төрөлхтний мөнхийн дагуул” хэмээн нотлохыг зорьдог. Тэгвэл Иммануэл Кант энэхүү эмх замбараагүй байдлаас хүн төрөлхтнийг ангижруулан үүрдийн энх тайвныг тогтоох боломжтой гэж үзсэн бөгөөд тодорхой зүйл заалтуудыг бодитой жишээнүүдээр баталгаажуулан өөрийн бүтээлээрээ санал болгосон. Тэрээр “Оюун Ухаан”, “Байгаль”-ийн хүчин зүйл, “Дээд Ёс Суртахууны Хэм Хэмжээ”, “Бурхны Таалал” “Трансцендентал”, “Космополит” гэх мэтчилэн философийн олон арван ойлголтуудыг ашиглан үүрдийн энх тайван тогтоох боломжтойг батлан харуулахыг зорьсон. Мөн “улс төр”-ийг “ёс суртахуун”-тай уялдуулан холбох

² Иммануэл Кант нь 1724 онд Кенигсбергт төрсөн ба байгалийн шинжлэх ухаанаар мэргэшсэн нэгэн байв. Амьдралын турш Кенигсбергээс холдож үзээгүй тэрээр физик, газарзүйн шинжлэх ухаанд дурлан энэ талаар лекц унших явцдаа логик, ёс зүйн талаар сонирхон судлаж эхэлсэн байдаг. “Онолын Оюун Ухааны Шүүмж” (1781), “Практик Оюун Ухааны Шүүмж” (1788), “Эргэцүүлэн Тунгаах Чадварын Шүүмж” (1790) зэрэг өмнөх бүтээлүүдийнхээ эцэст хийсэн эргэцүүлэл, дүгнэлтүүд дээрээ тулгуурлан хүн төрөлхтнийг дайн дажингүй, энх тайван байдалд хүргэх тодорхой санал санаачлагуудыг боловсруулсан юм.

замаар энэ асуудлыг шийдвэрлэх, нэн ялангуяа улс төрчид төдийгүй нийт хүн төрөлхтөн үүрдийн энх тайванд хүрэхийн тулд өөрсдийн оюун ухааныг дайчлан хүний эрхийн үндсэн зарчмуудыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгож, шударга ёсны хэм хэмжээнүүдийг үнэт зүйлсээ болгож чадвал эрт орой хэзээ нэгэн цагт зорилгодоо хүрч болно хэмээн тэрээр үзсэн. Түүний бүтээлийн бас нэг чухал санаа бол Бүгд Найрамдах засаглал бүхий улсуудаас бүрдсэн Олон Улсын Холбоо байгуулагдсанаар улсууд хоорондын харилцаанд энх тайван тогтох тухай байв. Энэ талаар АНУ-ын орчин цагийн неоконсерватив үзлийн гол төлөөлөгч Роберт Каган өөрийн бүтээлдээ “либераль засгийн газруудаас бүрдсэн дэлхий нь Кантын төсөөлсний дагуу дайн дажингүй дэлхий болох байлаа” (Каган, 2010) хэмээн дурьдсан байдаг.

Хэдийгээр түүний үүрдийн энх тайван тогтоох дээрх санаачлага нь бодит амьдрал дээр хэрэгжих боломжгүй мэт санагдаж болох ч орчин үеийн олон улсын харилцаанд улсуудын хамтын ажиллагаа, хамтын аюулгүй байдлын тогтолцоо бүрэлдэн бий болоход онолын сэтгэлгээний чухал эх сурвалж болдог. Түүний дэвшүүлсэн санал санаачлагын үр дүнд дэлхийн 1-р дайны дараачаар Үндэстнүүдийн Холбоо, 2-р дайны төгсгөлд Нэгдсэн Үндэстний Байгууллага байгуулагдаж, эдгээр хамтын нийгэмлэг нь нийт хүн төрөлхтний энх тайван, аюулгүй байдлын үйлст тодорхой хувь нэмэр оруулсаар ирсэн.

Иммануэл Кантын бас нэг чухал санаа бол хүн төрөлхтөн “Үүрдийн Энх Тайван”-д хүрэхийн тулд хувь хүний эрх, эрх чөлөөний асуудалд анхаарал хандуулах явдал байв. Хуулийн дор хувь хүний чөлөөт байдал, эрх чөлөө, эрх тэгш байхын чухлыг онцлон тэмдэглэснээр Кант улс үндэстнүүд нийтлэг үнэт зүйл, итгэл үнэмшлийн үндсэн дээр харилцан итгэлцэл, хамтын ажиллагааг бий болгож чадна гэж үзсэн. Энэхүү зарчим нь орчин үеийн олон улсын эрх зүйн тогтолцоо, олон улсын гэрээ хэлэлцээрээр баталгаажсан бөгөөд дэлхий дахинд энх тайван, аюулгүй байдлыг бий болгох хамтын хүчин чармайлтад чухал ач холбогдолтой хэвээр байна.

Дээрх бүхий л эерэг нөлөөлийг үл харгалзан Кантын үзэл санааг шүүмжлэгч зарим судлаач, философич, улс төрчид “Үүрдийн Энх Тайван”-ы тухай үзэл санаа нь хэт идеалист бөгөөд хүний төрөлхийн чанар, олон улсын харилцаан дахь ашиг сонирхлын зөрчил, дайн ба мөргөлдөөний нарийн төвөгтэй байдлыг харгалзан үздэггүй хэмээн няцаадаг. Гэсэн хэдий ч олон арван эрдэмтэн мэргэд, бодлого боловсруулагч болон шийдвэр гаргагчид дэлхийн хэмжээнд энх тайван, тогтвортой байдлыг бий болгох шинэ санал санаачлагыг боловсруулан хэрэгжүүлэхдээ түүний энэхүү бүтээлээрээ дэвшүүлсэн үзэл санааг судалж, үргэлжлүүлэн хөгжүүлсээр байна.

Хүснэгт. “Үүрдийн энх тайван” бүтээлийн агуулгын товч тайлал. (Кант, 2023)

УЛСУУДЫН ХООРОНД ҮҮРДИЙН ЭНХ ТАЙВАН ТОГТООХ ТУХАЙ УРЬДЧИЛСАН ЗҮЙЛ ЗААЛТУУДЫГ АГУУЛСАН ТЭРГҮҮН БҮЛЭГ.		ЗҮЙЛ ЗААЛТЫН ТОВЧ АГУУЛГА
<i>1-р зүйл.</i>	“Ирээдүйн дайнд хэрэглэх нууц	И.Кантын 6 зүйлээс бүрдсэн эхний бүлгийн 1-р зүйлд ямар гэрээг жинхэнэ утгаараа “энх тайвны

<p>Ямар ч нөхцөлд хүчин төгөлдөр үйлчилж байх, яаралтай хэрэгжүүлэх ёстой хатуу хориглосон зүйл заалт <i>(leges strictae)</i></p>	<p>нөөцийг хадгалан байгуулсан ямар ч энх тайвны гэрээ хүчингүйд тооцогдоно”.</p>	<p>гэрээ” хэмээн тооцогдох талаар өгүүлсэн. Зорилго нь зөвхөн гал зогсоох, түр зуурын энх тайван тогтоох зорилгоор гэрээ байгуулсан тохиолдолд улсуудын хооронд байгуулсан гэрээ нь энх тайвны гэрээ хэмээн үл тооцогдоно. Иймд “энх тайвны гэрээ” гэдэг нь жинхэнэ утгаараа бүхий л дайсагналыг төгсгөл болгосон байх ёстой” хэмээн тэрээр үзсэн байна.</p>
<p>2-р зүйл. Субъектив байдлаар агуулгыг нь өргөжүүлэн хэрэглэх зүйл заалт <i>(leges latae)</i></p>	<p>“Жижиг томоос үл хамааран тусгаар тогтносон ямар ч улс өв залгамжлал, солилцоо, ашиг хонжоо олох аль эсвэл тусламж өглөгийн замаар өрөөл бусдын мэдэлд орж болохгүй”</p>	<p>“Аливаа улс орныг түүний оршин буй газар мэт өмч, аль эсвэл өвлөж болдог эд хогшил мэт үзэж болохгүй”. Улс гэдэг нь өөрийн бүрэн эрх бүхий, өөрөөс нь өөр хэн ч захиран тушаах, удирдан чиглүүлэх эрхгүй хүмүүсийн нэгдэл юм. Энд И.Кант улсыг модны иш өөрийн үндэстэй байдгийн нэгэн адил нэг улсыг нөгөө улсад залган нэгтгэх нь ёс суртахууны хувьд түүнийг устгаж буй явдал гэж үзсэн. Ингэснээр бүрэн эрхт, тусгаар тогтносон улсыг эд хогшилтой адилтган үзэж буй ёс зүйгүй үйлдэл болно хэмээсэн.</p>
<p>3-р зүйл. Субъектив байдлаар агуулгыг нь өргөжүүлэн хэрэглэх зүйл заалт <i>(leges latae)</i></p>	<p>“Байнгын цэрэг армийг тодорхой цаг хугацааны явцад бүр мөсөн татан буулгах хэрэгтэй”</p>	<p>Дайн тулаанд байнгын бэлтгэл бүхий цэрэг арми нь нөгөө улсад аюулгүй байдлын хувьд заналхийлэл болдог. (Фукидидын “Пелопонессийн дайны түүх”-ийн үндсэн дүгнэлт болох “нэг улсын хүч чадвхийн өсөлт нөгөө улсын аюулгүй байдалд нөлөөлж байдаг тул дайн үүсдэг” хэмээх дүгнэлтийг санах хэрэгтэй) Цааш нь тэрээр “нэг улс байнгын цэрэг армитай байх нь (miles perpetuus) нөгөө улсыг цэргийн тоогоо өсгөхөд хүргэдэг ба цэргийн тоогоор нэг нь нөгөөхөө давах гэсэн энэхүү өрсөлдөөн хязгааргүй үргэлжилнэ. Энэ нөхцөлд Энх Тайвныг тогтоон хадгалах нь богино хэмжээний дайн хийхээс илүү дарамттай болох тул уг дарамтнаас ангижрах зорилгоор түрэмгий дайн эхлүүлдэг” гэж үзсэн.</p>
<p>4-р зүйл. Субъектив байдлаар агуулгыг нь өргөжүүлэн хэрэглэх зүйл заалт <i>(leges latae)</i></p>	<p>”Үндэсний өр зээлийн асуудал Улсын гадаад харилцааны хэрэглүүр болох ёсгүй”</p>	<p>Нийгмийн сайн сайхан, улс орны хөгжлийн зорилгоор удирдагчдын зүгээс гадаад болон дотоодоос зээл тусламж авах явдлыг буруу хэмээн үзэхгүй, дээрх зорилгоор олж авсан өр зээл нь ямар нэгэн хардлагыг мөн төрүүлэх ёсгүй. Харин олж авсан “зээлийг улс гүрнүүд бие биенийхээ эсрэг дайсагнах, сөргөлдөөний хэрэгсэл болгон ашиглах нь тун аюултай” хэмээн И.Кант үзжээ.</p>

<p>5-р зүйл. Ямар ч нөхцөлд хүчин төгөлдөр үйлчилж байх, яаралтай хэрэгжүүлэх ёстой хатуу хориглосон зүйл заалт <i>(leges strictae)</i></p>	<p>“Ямар ч улс бусад улсын үндсэн хууль болоод засгийн газрын үйл хэрэгт хүч хэрэглэн хөндлөнгөөс оролцох ёсгүй”</p>	<p>И.Кант нэг улс нөгөө улсын үйл хэрэгт хөндлөнгөөс оролцож хүчирхийлэл үйлдэх нь хууль бус, эрх чөлөөт нэгэн нөгөө иргэнийхээ эрхийг зөрчиж буй тааламжгүй (<i>scandalum acceptum</i>)³ жишээтэй адил хэмээн үзсэн.</p> <p>Харин үүнд тэрээр дараах жишээг оруулахгүй байх нь зүйд нийцнэ гэж үзсэн. Тухайлбал, <i>“нэг улс дотоод асуудлаасаа үүдэн хоёр хуваагдсанаар тусдаа бие даасан улс болохын тулд зөрчилдөн эмх замбараагүй байдалд оршиж буй тохиолдолд гуравдагч улсаас аль нэг улсад нь тусламж үзүүлж буй бол үүнийг нэг улсын үндсэн хууль болоод дотоод үйл хэрэгт оролцсон хэмээн тооцож болохгүй. Гэхдээ л дотоод асуудал нь шийдвэрлэгдээгүй үед гадаад улс гүрний зүгээс өнөөх улсын дотоод хэрэгт оролцох нь дотоод асуудлаа бие даан шийдэхийг оролдож буй тусгаар ард түмний эрхийг зөрчсөн үйлдэл болно. Ингэснээр бусад улсын хувьд бүрэн эрхт байдал нь эмзэг зүйл болон хувирна”</i> хэмээжээ.</p>
<p>6-р зүйл. Ямар ч нөхцөлд хүчин төгөлдөр үйлчилж байх, яаралтай хэрэгжүүлэх ёстой хатуу хориглосон зүйл заалт <i>(leges strictae)</i></p>	<p>“Дайнд оролцож буй аливаа улс ирээдүйд энх тайван тогтоох боломжийг үгүй хийдэг үй олноор хөнөөх (<i>percussores</i>), хордуулах (<i>venefici</i>), бууж өгөх болон урвахыг ятгах (<i>perduellio</i>) гэх мэт аргыг хэрэглэх ёсгүй”</p>	<p>Эдгээр аргуудыг шударга бус, ёс суртахуунгүй дайны арга залиуд гэж үзээд <i>“дайны үед ч дайсандаа итгэх зарим нэг итгэл найдвар хадгалагдаж байх ёстой. Эс бөгөөс ирээдүйд энх тайван тогтох ямар ч боломж үлдэхгүй бөгөөд дайтагч талуудын дайсагнал нь үй олноор нь хөнөөх алага болж хувирна”</i> хэмээн тэрээр үзсэн байна.</p>
<p>УЛСУУДЫН ХООРОНД ҮҮРДИЙН ЭНХ ТАЙВАН ТОГТООХ ТӨГСГӨЛИЙН ЗҮЙЛ ЗААЛТУУДЫГ АГУУЛСАН ХОЁРДУГААР БҮЛЭГ.</p>		

³ Энэ үг нь ёс суртахууны теологиос үүсэлтэй бөгөөд бидний үед олон улсын эрх зүйн хэм хэмжээний хүрээнд ойлговол зохино. Өөрөөр хэлбэл нэг улсын дотоод асуудал, муу үндсэн хууль зэрэг нь нөгөө улсыг дайн эхлүүлэх шалтгаан болж болохгүй. (П.Мягмардорж)

Харин Кантын үеийн сэтгэгчид “скандал” хэмээх ойлголтыг нүгэл гэдэгтэй зүйрлэж ойлгож байсан бөгөөд бусад нөлөөлөхгүй нүгэл байвал *“scandalum acceptum”*. Ийм учир төгс бус, тааруу үндсэн хууль нь *“scandalum acceptum”* буюу дайн өдөөх шалтгаан болж чадахгүй. Харин ийм шалтгаанаар дайн эхлүүлэх аваас энэ нь муу үлгэр жишээ болох *“scandalum datum”* буюу бусдад муугаар нөлөөлсөн нүгэл гэж тооцогдоно. (П.Мягмардорж)

<p>Үүрдийн Энх Тайвны тухай төгсгөлийн 1-р зүйл.</p>	<p>“Улсуудын Иргэний Үндсэн Хууль нь Бүгд Найрамдах засаглалын хэлбэрт тулгуурлах ёстой”</p>	<p>И.Кант “”Үүрдийн энх тайван”-ныхаа хоёрдугаар бүлэгт гурван зүйл заалтыг оруулсан ба эхний зүйлдээ энх тайван тогтооход улсуудын засаглалын хэлбэр нь Бүгд Найрамдах Засаглалтай байх нь чухал гэж үзжээ. Тэрээр <i>“Бүгд Найрамдах Улсын Үндсэн Хууль бол нэгдүгээрт, нийгмийн гишүүдийн эрх, эрх чөлөөний зарчим, хоёрдугаарт, нийгмийн бүх гишүүд нэгдсэн нэг хууль тогтоомжид захирагдах зарчим, гуравдугаарт, иргэдийн тэгш эрхийн зарчимд тус тус үндэслэн бий болсон”</i> хэмээн нотолсон бөлгөө. Учир нь гагцхүү Бүгд Найрамдах Улсын Үндсэн Хууль нь “Анхдагч Гэрээ” буюу байгалиас заяасан хүний суурь эрхүүдийг багтаасан “гэрээ” ний үзэл санааг суурь болгосон, хүний хууль ёсны үндсэн эрхүүдийг багтаасан цорын ганц үндсэн хууль хэмээн үзсэн аж. Мөн тэрээр <i>“Бүгд Найрамдах Улсын Үндсэн Хуулийн дагуу “дайн эхлүүлэх, эс эхлүүлэх” хэмээх асуудлаар цаг хугацааны хувьд хэзээ ч хамаагүй шийдвэр гаргахад тухайн улсын гишүүд болох ард иргэдийн зөвшөөрөл зайлиггүй шаардлагатай. Мэдээж хэрэг ард иргэд өөрсдийн хүсээгүй зүйлийг дэмжихгүй нь тодорхой”</i> хэмээн Бүгд Найрамдах Засаглалын давуу талыг нотолгоо болгожээ.</p>
<p>Үүрдийн Энх Тайвны тухай төгсгөлийн 2-р зүйл.</p>	<p>“Үндэстнүүдийн Эрх⁴ нь Чөлөөт Улсуудын Холбоогоор тодорхойлогдоно”</p>	<p>Хоёрдугаар бүлгийн 2-р зүйлд <i>“Тодорхой ард түмэн эсвэл үндэстнүүд улс хэмээн тооцогдохын тулд хувь хүмүүстэй адил шүүхийн өмнө хариуцлага хүлээж байх ёстой”</i> талаар бичсэн. Энэ нь юу гэсэн үг вэ гэхээр хүмүүс бие биетэйгээ ойр зэргэлдээ оршин амьдрахдаа нийтлэг хууль тогтоомжоос ангид, байгалийн хуулийн дагуу харилцах аваас нэг нь нөгөөдөө гэмтэл бэртэл болон хор хөнөөл учруулах нь гарцаагүй. Ийм нөхцөлд хүн болгон төдийгүй улс бүр аюулгүй байдлаа хангахын тулд бусдаасаа өөрсдийн эрхийг баталгаажуулж байдаг нийтлэг, нэгдсэн нэг үндсэн хуулийн (улсын дотоод үндсэн хуультай нэгэн адил) дор захирагдан, зэрэгцэн амьдрахыг шаардах</p>

⁴ Үндэстнүүдийн Эрх хэмээх ойлголтыг “Олон Улсын Эрх Зүй” хэмээн ойлговол зохино. (П.Мягмардорж)

		<p>эрхтэй. Үр дүнд нь тэрээр “Олон Улсын Холбоо” бий болно хэмээн бчисэн байна.</p> <p>Гэхдээ тэрээр энэхүү Олон Улсын Холбоо нь гишүүн улсуудаас бүрдсэн нэгдмэл нэг улсын хэлбэртэй байх албагүй. Учир нь тухайн хуулийг санаачлагч буюу хууль тогтоогч “Дээд Эрх Мэдэл” бүхий улс нь хуулийн дор захирах ард иргэд болох Доод албаттайгаа харилцаж буй адил Улс бүрийн хооронд зөрчлийг үүсгэх болно хэмээн тайлбарласан.</p> <p>И.Кантын хувьд бие биетэйгээ харилцахдаа тус тусдаа өөрсдийн гэсэн Улсын Эрхтэй, нэг үндэстэн болох боломжгүй янз бүрийн чөлөөт Улсаас бүрдсэн Холбооны тухай өгүүлсэн байдаг.</p>
<p>Үүрдийн Энх Тайвны тухай төгсгөлийн 3-р зүйл.</p>	<p>“Космополит систем дэх Дэлхийн иргэний хувьд хүний эрх нь бүх нийтийн Найрсаг Зочломтгой байдлаар тодорхойлогдох ёстой”</p>	<p>“Найрсаг Зочломтгой” байдал гэдгийг И.Кант харь улсын иргэн хүн өөр улсад зочлон ирсэн үед хүлээн авагч улсын ард иргэд нь түүний “үндсэн эрх”-ийг үл хүндлэн дайсагнаж харьцахгүй байх тухай санааг илэрхийлсэн байдаг. <i>“Харь орны хүнийг амь нас, эрүүл мэндэд нь хохирол учруулалгүйгээр өөрийн улсаас үлдэн хөөж болох хэдий ч зочин этгээд нь тайван байдлаар биеэ авч явж байгаа тохиолдолд түүнтэй дайсагнасан байдлаар харьцах нь зохимжгүй”</i> хэмээн үзсэн байна.</p> <p>“Хүн Төрөлхтний Космополит Эрх”-ийн тухай үзэл санаа нь эрхийг төлөөлөх арга биш, харин хүний болон олон улсын эрхийг “Нийт Хүн Төрөлхтний Нийтлэг Эрх” болгон хэрэгжүүлэх бичигдээгүй хууль болгоход зайлшгүй чухал үүрэг гүйцэтгэнэ. Ийнхүү найрсаг зочломтгой байдал дээр тогтсон улсуудын хоорондын харилцааны систем нь олон улсын харилцаанд “Үүрдийн Энх Тайван” тогтоох аргыг тодорхойлоход чухал үүрэгтэй аж. Мөн цааш нь тэрээр <i>“зөвхөн энэ нөхцөл байдлын үр дүнд л бид Үүрдийн Энх Тайванд зогсолтгүйгээр хүрч болно гэсэн итгэл үнэмшлийг өөрсөддөө бий болгож чадна”</i> гэж үзжээ.</p>
<p>ҮҮРДИЙН ЭНХ ТАЙВНЫ БАТАЛГАА БҮХИЙ</p>	<p>Үүрдийн Энх Тайвны баталгаа нь агуу</p>	<p>И.Кант “Үүрдийн энх тайван” бүтээлийнхээ төгсгөлд үүрдийн энх тайван тогтоох баталгаа болгож 2 нэмэлт бүлгийг оруулсан байдаг. Эндээ хүний хүсэл зорилго, шунал тачаалаас үл хамааран байгалийн тогтолцоо нь зөрчилдөөнөөс илүү эвтэй</p>

<p>НЭГДҮГЭЭР НЭМЭЛТ</p>	<p>Байгалиас ч (Natura Daedala rerum)⁵ дутахааргүй хүч чадалтай</p>	<p>найртай амьдрах амьдралын хэв маягийг бий болгох зорилго, зорилтыг өөртөө агуулж байдаг. Хүн төрлөхтний сайн мэдэхгүй хуулийн (энд “байгалийн хууль” гэж ойлговол зохино) хүрээнд ажиллаж байдаг энэхүү хүчин зүйлийг ихэвчлэн “Хувь Тавилан” хэмээн хүмүүс тайлбарладаг тухай И.Кант бичээд <i>“байгаль эхийн жам ёсны үйл явцад илэрч буй уг загварыг харгалзан “Хувь Тавилан”-г хүн төрөлхтний эцсийн зорилгыг хэрэгжүүлэхэд чиглэсэн Дээд Шалтгааны мэргэн ухаан гэж үзэх нь зөв бөгөөд бид үүнийг мөн Таалал</i> (англи хэлнээ “Providence” гэснийг ийнхүү монгол хэлнээ булгав) <i>гэж нэрлэнэ”</i> хэмээн тайлбар хийсэн байна.</p>
<p>ҮҮРДИЙН ЭНХ ТАЙВАНТАЙ ХОЛБООТОЙ НУУЦ ЗҮЙЛ ЗААЛТ БҮХИЙ ХОЁРДУГААР НЭМЭЛТ</p>	<p>"Үндэстнүүдийн хооронд энх тайван тогтоох тухай философичдын дээд ёс суртахууны хэм хэмжээг⁶ дайн эхлүүлэхээр зэвсэглэсэн Улсууд анхаарч үзэх ёстой"</p>	<p>И.Кант 2-р нэмэлт баталгаандаа улсын удирдагчид философичдын үгийг сайтар анхааран сонсох ёстой хэмээн зөвлөсөн. <i>“Бусад улстай харилцахдаа албат иргэдийнхээ үгийг сонсох, тэр дундаа философичдын зөвлөгөөг дагана гэдэг нь оюун ухаан билиг төгөлдөр, цэцэн мэргэн хэмээн бидний үздэг Улсын хууль тогтоох дээд эрх мэдэлтнүүдийн хувьд нэр хүндээ гутаан доромжилсонтой адил болно. Тэгэхээр Улс нь философичтой шууд харилцан тохиролцож шийдвэр гаргахын оронд далдуур тэдэнтэй тохиролцон, гаргаж буй шийдвэрээ нууцалж байх нь зүйтэй. Ингэснээр философичдод хэрхэн дайн хийж, энх тайвныг тогтоох тухай нийтлэг дүрэм журам бүхий үзэл бодлоо олон нийтэд чөлөөтэй, нээлттэй илэрхийлэх боломж бүрдэж өгнө”</i> хэмээх тайлбарыг хийжээ.</p>

И.Кантын энхүү олон улсын харилцаанд энх тайван тогтоох зорилго бүхий бичсэн бүтээл нь дараа үеийн олон арван улс төрчийн үзэл санаа, бодлого шийдвэр болон олон улсын гэрээ хэлэлцээрүүдэд тусгалаа олсон талаар өмнө нь өгүүлсэн. Тухайлбал, 1899 болон 1907 оны Гаагийн Конвенцийн зүйл заалтуудад түүний “Үүрдийн Энх Тайван”-ы санаанууд шингэсэн байдаг. 1899 оны Гаагийн Бага Хурлаас баталсан 4-р Конвенцийн

⁵ “Дедалусын юмс үзэгдлийн мөн чанар”. Дедалус нь эртний Грекийн домгийн зохиогч, архитектор ба уран барималч. (П.Мягмардорж)

⁶ Латин хэлний “maxim” хэмээх ойлголтыг “дээд ёс суртахууны хэм хэмжээ” хэмээн буулгав. Энэхүү нэр томъёо нь 17-18-р зууны үеийн философичдын дунд түгээмэл хэрэглэгддэг байсан бөгөөд Кантын хувьд гол төлөв ёс зүйтэй холбон хэрэглэсэн. Түүний үзэж байснаар энэ нэр томъёо нь хувь хүний хүсэл эрмэлзлэл, үйл хөдлөлийн зарчмуудын утгыг илэрхийлдэг. Энэхүү зарчим нь үйл ажиллагааны стратеги хэмээн ойлгогдох ба үйл ажиллагаа, нөхцөл байдал, үр дүн буюу зорилго гэсэн 3 хэсгээс бүрдэнэ. Эдгээр нь ёс суртахууны хувьд үнэ цэнэтэй байх ёстой. (П.Мягмардорж)

1-р зүйл (School, 1899), 2-р зүйл (School, 1899) болон 3-р зүйлд заасан заалтууд (School, 1899) нь И.Кантын “Үүрдийн Энх Тайван”-ы Тэргүүн бүлгийн 6-р зүйлд заасан “Дайнд оролцож буй аливаа улс ирээдүйд энх тайван тогтоох боломжийг үгүй хийдэг үй олноор хөнөөх (percussores), хордуулах (venefici), бууж өгөх болон урвахыг ятгах (perduellio) гэх мэт аргыг хэрэглэх ёсгүй” (Кант, 2023) хэмээх заалтын агуулгаас санаа авсан нь тодорхой. 1907 оны Гаагийн Бага Хурлын 2-р Конвенцийн (School, 1899) агуулга нь И.Кантын бүтээлийн Тэргүүн бүлгийн 4-р зүйлд заасан “үндэсний өр зээлийн асуудал улсын гадаад харилцааны хэрэглүүр болох ёсгүй” (Кант, 2023) хэмээх заалтыг давтсан байх жишээтэй.

Энх Тайвныг тогтоох “Олон Улсын Холбоо” байгуулах тухай И.Кантын саналыг хамгийн анх хэрэгжүүлэх оролдлогыг хийсэн улс төрч бол АНУ-ын 26 дахь ерөнхийлөгч Теодор Рузвельт юм. 1905 онд Теодор Рузвельт Бүгд Найрамдах намын нөлөө бүхий гишүүд болох Хенри Кабот Лож, Уильям Ховард Тафт нарын хамтаар дэлхийд энх тайвныг бэхжүүлэх зорилгоор Үндэстнүүдийн Холбоо байгуулах санаачлага гаргаж эхэлжээ. Ерөнхийлөгчийн хувиар жил бүрийн Конгресст тавьдаг илтгэлдээ олон улсын харилцаанд ноёрхох зорилго бүхий улсыг хянах ямар нэгэн арга хэрэгсэл байх хэрэгтэй гэж үзсэн бөгөөд тэр нь эцэстээ олон улсын байгууллагын үүрэг болох ёстой тухай санаагаа илэрхийлсэн ажээ. (Lind, 2006) Т.Рузвельтийн энэхүү “Шударга ёсны энх тайвны төлөөх Дэлхийн Холбоо” нь тусгаар тогтносон улсуудын хараат бус, бие даасан байдлыг хүлээн зөвшөөрөх хэдий ч цэрэг арми, зэвсэглэх эрх мэдлийг нь хязгаарлах ба зөрчсөн тохиолдолд арбитрын шүүхээр хэргийг нь хянуулах зохицуулалтыг хийхийг хүсэж байв. Энэхүү нөхцлийг зөрчсөн улс гарах аваас энх тайван, шударга ёсны нэрийн өмнөөс бусад улс нь түүний эсрэг хүч хэрэглэх ажээ. (Gamble, 2014)

Нью-Йоркийн Их Сургуулийн Глобал Асуудлын Төвийн судлаач, профессор Жон Кейн “Ардчилал ба дэлхийн энх тайван: АНУ-ын гадаад бодлого дахь Кантын сонголт” хэмээх өгүүлэлдээ АНУ-ын гадаад бодлого, тэр дундаа Вудро Вильсон Үндэстнүүдийн Холбоог байгуулах санаачлагыг хэрхэн гаргах болсон талаар судлаад И.Кантын “Үүрдийн Энх Тайван” тогтоох үзэл санаа В.Вильсоны Үндэстнүүдийн Холбоо байгуулах тухай санаачлага гаргахад томоохон нөлөө үзүүлснийг дурьдсан байдаг. (Kane, 2012)

В.Вильсоны дэлхийн 1-р дайны төгсгөлд дэвшүүлсэн 14 зүйл заалт бүхий энх тайвны зарчмын санал нь (ялангуяа олон улсын харилцаанд энх тайван тогтоох тухай тодорхой санал бүхий 6 заалт⁷) бүхэлдээ И.Кантын “Үүрдийн энх тайван”-аас санаагаа авсан. Энэ талаар Мэриландын Их Сургуулийн профессор асан Вилльям Галстон дэлхийн 1-р дайны төгсгөлд дэвшүүлсэн В.Вильсон “энх тайвны 14 зүйл” зарчмын санал нь И.Кантын “Үүрдийн энх тайван”-ы үзэл санаа тэр чигээрээ орсон (Rentmeester, 2022) хэмээн нотлодог.

⁷ Үүнд: Нууц дипломат ажиллагааг халах, нууц гэрээ хэлэлцээр байгуулахгүй байх, далайд чөлөөтэй зорчих эрхийг хангах, олон улсын худалдаанд ялгаварлан гадуурхахгүй, эдийн засгийн хориг арга хэмжээ авахгүй байх, зэвсэглэлийг хорогдуулах, колоничлогч улс болон колони улсуудын ашиг сонирхолыг харгалзан колонийн асуудлыг зохицуулах гэсэн эхний 5 заалт болон том, жижиг улсуудын газар нутгийн бүрэн бүтэн байдал, тусгаар тогтнолыг баталгаажуулан, ОУ-ын энх тайван аюулгүй байдлыг сахин хамгаалах үүрэг бүхий ОУ-ын хамтын нийгэмлэгийг байгуулах тухай 14 дэх заалт.

АНУ-ын 28 дахь ерөнхийлөгч В.Вильсон Нью Жерси Коллежид (өнөөгийн Принстоны Их Сургууль) улс төрийн философийн чиглэлээр суралцаж байв. (Berg., 2013) Энэ үедээ тэрээр И.Кантын философийн бүтээлүүдтэй танилцсаны дотор “Үүрдийн энх тайван” хэмээх бүтээл нь багтаж байв. И.Кантын “үүрдийн энх тайван” тогтох тухай үзэл санаа нь хожим АНУ-ын ерөнхийлөгчийн гадаад бодлогын үзэл баримтлал бүрэлдэн тогтоход голлох нөлөө үзүүлсэн. В.Вильсоны дэвшүүлсэн 14 зүйлт саналын үр дүнд дэлхийн 1-р дайны дараа хүн төрөлхтөн анх удаа олон улсын энх тайван, аюулгүй байдлыг сахин хамгаалах зорилго бүхий “Үндэстнүүдийн Холбоо”-г байгуулсан. Үүний зэрэгцээ Японы Зүүн Азид хийж байсан түрэмгий гадаад бодлогыг АНУ-ын зүгээс эсэргүүцэн “Стимсоны Номлол”-ыг боловсруулж, Францтай хамтран дайныг гадаад бодлогын хэрэгсэл болгохоос татгалзах тухай агуулга бүхий “Келлог-Брианы гэрээ”-г дэлхийн улсууд байгуулсан билээ.

Дэлхийн 2-р дайн гарснаар Үндэстнүүдийн Холбооны үйл ажиллагаа зогссон ч АНУ-ын ерөнхийлөгч Ф.Рузвельтийн хүчтэй оролцоотойгоор Нэгдсэн Үндэстний Байгууллагыг Сан Францискогийн хурлаас байгуулж чадсан юм. Ф.Рузвельтийн хувьд В.Вильсон ерөнхийлөгчийн үед буюу 1913-1919 оны хооронд Тэнгисийн Цэргийн Яамны дэд сайдаар ажиллаж байв. Нэг талаас В.Вилсоны улс төрийн манлайлал, Үндэстнүүдийн Холбоо байгуулах тухай санаачлага болоод либераль-интернационалист үзэл санаа Ф.Рузвельтэд хүчтэй нөлөө үзүүлсэн (Conservancy., 2022) бол нөгөө талаас түүний холын хамаатан, ерөнхийлөгч асан Т.Рузвельтийн өмнө дурьдсан “Шударга ёсны энх тайвны төлөөх Дэлхийн Холбоо”-ны санаачлага том хувь нэмэр оруулжээ. Т.Рузвельт болоод В.Вильсоны дэлхийн энх тайвныг баталгаажуулах олон улсын хамтын нийгэмлэг байгуулах тухай санал санаачлагууд Ф.Рузвельтийг Нэгдсэн Үндэстний Байгууллагыг байгуулах гэдэг санаачлагадаа хатуу зогсох итгэл үнэмшлийг бүрдүүлсэн нь гарцаагүй. Ялангуяа Сенат дээр дэмжлэг олж чадаагүй “Версалийн Гэрээ”-нээс ихээн зүйл ойлгосон тэрээр Нэгдсэн Үндэстний Байгууллагыг байгуулах Сан Францискогийн гэрээг Сенат дээр батлуулах тал дээр ихээхэн анхааран ажилласан байдаг. (Conservancy., 2022)

В.Вильсоны олон улсад энх тайван тогтоох, ардчилсан-либераль үнэт зүйлсийг түгээн дэлгэрүүлэх үзэл санаа үргэлжилсээр АНУ-ын гадаад бодлогын нэг чухал арга хэрэгсэл болон өнөөдрийг хүрчээ. АНУ-ын Конгресс дээр гадаад бодлогын шийдвэр гаргахад нөлөө бүхий оролцоотой улс төрийн бүлэглэлүүд дотор Бүгд Найрамдах Намын “неоконсервативчуудын бүлэг” (заримдаа эдгээр улс төрчдийг автомат буутай “Вильсончууд гэж нэрлэдэг), (Kaplan., 2006) Ардчилсан намын “либераль-интернационалист” бүлгүүд В.Вильсоны ардчилсан-либераль үзлийг түгээн дэлгэрүүлэх тал дээр гол анхаарлаа хандуулан ажилладаг.

Ийнхүү И.Кантын “Үүрдийн Энх Тайван”-аас эхтэй В.Вильсоны үеэс олон улсын харилцаанд хэрэгжиж эхэлсэн олон улсын харилцааны либераль-идеалист үзэл номлол түүхийн явцад олон арван сорилтуудтай тулгарч байв. 1929 оны “Их хямрал”, Германы нацизм, дэлхийн 2-р дайн, “Хүйтэн дайн” ба коммунизмын тэлэлт, “Хүйтэн дайн”-ы дараах глобал асуудлууд, “терроризм”-ын сорилтууд, хүн төрөлхтнийг хамарсан цар тахал гэх мэт олон асуудлууд олон улсын харилцааны либераль-идеалист үзэл санаанд томоохон цохилт болж байсан. Эдгээр сорилтоос хамгийн хүнд, цаашид ч либераль-идеалист үзэл санаа түгэн дэлгэрэхэд саад болох гол сорилт бол “үндсэрхэг үзэл” юм.

Норвегийн нэрт социологич Йохан Галтунг аливаа хямрал мөргөлдөөнд оролцож буй янз бүрийн оролцогчдын сэдэл, үйлдэл, нөлөөллийг ойлгоход тустай “Галтунгийн зөрчилдөөний гурвалжин”-г (Galtung, 1969) санал болгосоноор энх тайван ба хямрал судлалын салбарыг үндэслэгч хэмээн тооцогдох болжээ. Тэрээр хүчирхийллийн гурван гол элементээс бүрдсэн “гурвалжин”-г боловсруулсан. Түүний энэхүү “гурвалжин”-г харвал зөрчилдөөнд оролцогчийн “зан төлөв” буюу хүчирхийлэл, геноцид, ялгаврлан гадуурхах үзэл, “хандлага” буюу расизм, ялгаврлан гадуурах хандлага, сэтгэл зүйн гэмтэл, “зөрчилдөөн” буюу тэгш бус байдал, газар нутгийн болон байгалийн баялагийн төлөөх маргаан зэрэг нь хямрал мөргөлдөөний үндсэн шалтгаанууд болдог аж. Эдгээр шалтгаануудыг харваас “үндсэрхэг үзэл” санаа гол байр суурь эзлэж байгаа нь тодорхой харагдана.

И.Кантын бүтээлийг задлан дүгнэх аваас “үндэсний”, “үндэсний төрт улс” гэх мэт нэр томъёо хэд хэдэн удаа дурьдагдах авч түүний “Үүрдийн Энх Тайван”-д “үндсэрхэг үзэл” томоохон сорил болно гэдгийг тооцож үзээгүй нь анзаарагддаг. (Lok., 2019)

1920-1930-аад оны үеэс хэрэгжиж эхэлсэн Итали, Герман, болон Японы улс төрийн бодлого, ялангуяа А.Хитлерийн үндсэрхэг үзэлд тулгуурласан гадаад бодлого, 1960-аад оны үеийн Шарль де Голлийн явуулж байсан “эх оронч” гадаад бодлогын шийдвэрүүдээс ч “үндсэрхэг үзэл”-ийг харж болно. 1970-80-аад оны үеийн олон улсын харилцааны гол гол оролцогчдын улс төр, эдийн засгийн бодлогоос үндсэрхэг үзлийг олж харж болно. Тухайлбал, Их Британийн ерөнхий сайд Маргарет Тетчер, АНУ-ын ерөнхийлөгч Рональд Рейганы гадаад бодлогод энэхүү үзэл санаа тусгалаа олсон байдаг.

1980-аад оны эхээс барууны улс төрчдийн, тэр дундаа АНУ-ын ЗХУ болон түүний орыг залгасан ОХУ-тай харилцах бодлогын шийдвэр гаргалтад хүчтэй нөлөөлж байсан зөвлөмж боловсруулагчдын нэгэнд З.Бжежинскийг тооцож болно. Түүний Орос улсыг задлан хуваах, Украйныг Оросоос холдуулах, үндэстний хувьд хагалган бутаргах санаа нь Оросын шийдвэр гаргагчдад хүчтэй нөлөө үзүүлсэн. ОХУ-ын ерөнхийлөгч В.Путины гадаад бодлого хэлбэршин тогтоход барууныхны явуулсан гадаад бодлого хүчтэй нөлөөлсөн болохыг өнөөдрийн олон улсад өрнөж буй үйл явдал, В.Путины ярилцлага, хэлж буй үгнүүдээс харж болно. Үүний зэрэгцээ орчин цагийн Оросын улс төр, геополитикийн үзэл санаа бүрэлдэн тогтоход А.Дугины “Неовразийн бодлого” томоохон байр суурь эзлэдэг талаар судлаачид дүгнэн бичсэн. Зарим барууны судлаачдын “неофашист” хэмээн тодорхойлдог А.Дугины “Оросын хүчирхэг байдал нь түүний улс төрийн түүхийн уламжлалд орших бөгөөд үндсэрхэг үзэлд тулгуурласан гадаад бодлогыг явуулах нь ОХУ-ын хүчирхэг байдлын үндэс нь болно” хэмээх дүгнэлт ОХУ-ын өнөө үеийн гадаад бодлогод “үндсэрхэг үзэл” томоохон байр суурь эзлэхэд онолын тулгуур үзэл болсон билээ. “Үндсэрхэг үзэл болон үндэстэн өөрөө даяаршлын улмаас огтхон ч суларч доройтоогүй бөгөөд харин одоо өсөө авахаар эргэн ирж байна. Балканы орнууд болон ЗХУ-ын бүрэлдэхүүнд байсан орнуудад үндэстэн ястны үндсэрхэг үзэл буцалж байна. Гэхдээ хамгийн анхаарууштай нь их гүрний үндсэрхэг үзэл эргэн ирж буй явдал юм” (Каган, 2010) хэмээн Р.Каган өөрийн бүтээлдээ онцолсон байдаг.

Тэгвэл “ардчилсан” гэж тооцогддог Энэтхэг, Бразил тэр ч бүү хэл АНУ-ын улс төрийн бодлогын шийдвэр гаргалтад “үндсэрхэг үзэл”-ийг дэмждэг улс төрчид өнөөдөр

хүчтэй байр суурийг хадгалсаар байгаа билээ. Энэтхэгийн ерөнхий сайд Нарендра Модигийн явуулж буй бодлогыг ч үндсэрхэг үзэлд тулгуурлах болсныг судлаачид бичих болов. Тухайлбал, “...өмнө нь Энэтхэгийн улс төрийн орон зайд төдий л хүчтэй байр суурь эзэлдэггүй байсан “Хинду национализм” буюу Энэтхэгийн үнсэрхэг үзэл ерөнхий сайд Нарендра Модигийн үед Энэтхэгийн улс төрийн гол үзэл санаа болжээ.” (Krutika Pathi, 2024) хэмээн Ассошэйтед Пресс хэвлэлийн сайт дээр бичсэн байна.

19-р зуунд “изоляционист”, 20-р зуунд “либераль-интернационалист” гадаад бодлого явуулж байсан АНУ 21-р зуун гарсаар бодлогын үзэл номлолын зөрчилд орж эхэлсэн юм. АНУ-ын 45 дахь ерөнхийлөгч Д.Трампын улс төрийн бодлого “үндсэрхэг үзэл”-ийг үзэл санаагаа болгосон бөгөөд үүний нотолгоог түүний сонгуулийн уриа болох “Америкийг дахин хүчирхэгжүүлэх”⁸ болоод “Парисын хэлэлцээр”—ээс гарсан явдал, цагаачлалын хатуу бодлого, ковид-19 цар тахалын үеийн шийдвэрүүд зэргээс харж болж байв.

Канадын Торонтогийн Их Сургуулийн улс төрийн дэд профессор Роберт Шерцер, Английн Плимаутын Их Сургуулийн социологийн дэд профессор Эрик Тэйлор Вудс нарын хамтын бүтээл болох “Америк ба бусад орнууд дахь шинэ үндсэрхэг үзэл: дижитал эрин үеийн угсаатны үндсэрхэг үзлийн гүн үндэс” хэмээх 2022 онд хэвлэгдсэн бүтээлийн 5-р бүлэгт Дональд Трампын шинэ үндсэрхэг үзлийн талаар бичсэн байна. Америкийн улс төрийн түүхэнд мөрөө үлдээсэн уламжлалт “угсаатны үндсэрхэг үзэл”⁹д тулгуурлан улс төрийн бодлогоо хэрэгжүүлсэн талаар өгүүлээд улс төрийнх нь гол стратеги нь энэхүү үзэл санаа байсан талаар дурьджээ. Ялангуяа гадны иргэд, мексик цагаачид, мусульман шашинтнуудыг харлуулах замаар цагаан арьст сонгогчдын дэмжлэгийг авах зорилго бүхий улс төрийн хөтөлбөрийг боловсруулсан гэдгийг нотлон харуулахыг зорьжээ. Эдгээр судлаачид 2016 оны сонгуулийн өмнөх үеийн Д.Трампын 5000 орчим жиргээнд контент-анализ хийснээр дээрх дүгнэлтийг баталсан бөгөөд түүнийг сонгуульд ялахад гол нөхцөл нь болсон гэж үзэж болохгүй ч ялахад нь томоохон нөлөө үзүүлсэн болохыг судалгаагаараа харуулсан байдаг. (Schertzer, 2022)

Дүгнэлт

Олон улсын харилцааны онолын голлох дэг сургуулийн нэг болох либераль-идеализмын үзэл санаа нь дэлхийн 1-р дайны төгсгөлд дэвшүүлсэн АНУ-ын ерөнхийлөгч В.Вильсоны 14 зүйл заалт бүхий зарчмын саналаар биелэлээ олжээ. В.Вильсоны энэхүү либераль-интернационалист гадаад бодлого нь цаашид олон улсын харилцааны либераль ардчилсан үзэл болон түгэн дэлгэрсэн тул олон улсын харилцааны судлаачид энэхүү үзэл санааг “вильсонист” хэмээн тодорхойлдог. Энэхүү “вильсонист” буюу олон улсын харилцаанд либераль үнэт зүйлийг түгээн дэлгэрүүлснээр олон улсын харилцаанд энх тайван аюулгүй байдал хэлбэршин тогтнох тухай бодлогыг АНУ тэргүүлэн, дэлхийн 2-р дайны дараачаас Европын улсууд түүчээлсээр өнөөдрийг хүрсэн байна. Ялангуяа “хүйтэн дайн”-ы төгсгөлд өрнийн үзэл санааны давамгайлал бүхий олон улсын харилцааны дэг журам тогтон, Ф.Фукуяамагийн үзсэнээр “түүхийн төгсгөл”

⁸ “Make America Great Again”

⁹ “ethnic nationalism”

ирснээр олон улсын харилцаанд мөргөлдөөн, дайн дажингүй эрин үе ирж буй санаа өнөөдөр тодорхой шалгууруудтай тулгараад буйг олон улсын харилцааны нөхцөл байдлаас харж болно.

Тэгвэл энэхүү олон улсын харилцаанд дайн дажингүй, “үүрдийн энх тайван” тогтох онолын сэтгэлгээний уламжлал болсон гол бүтээл болох Үүрдийн энх тайван”-ыг “соён гэгээрлийн эрин үе”-ийн Германы сонгодог философич И.Кант 1795 онд бичин үлдээжээ.

Энэхүү бүтээл нь удиртгал хэсгээс (*өөрийн дэвшүүлсэн үзэл санааг онолын философчийн хувьд хамгаалсан утга бүхий*) гадна зургаан “урьдчилсан зүйл заалт”-уудыг багтаасан Нэгдүгээр Бүлэг, гурван “төгсгөлийн зүйл заалт” бүхий Хоёрдугаар Бүлэг, Үүрдийн Энх Тайвныг тогтооход шаардагдах “баталгаа” болон “нууц зүйл заалт”-ыг агуулсан хоёр Нэмэлт Бүлэг, “*ёс суртахуун болон улс төрийн хоорондын зөрчлийг хэрхэн зохицуулах*” тухай хоёр хэсэг бүхий Хавсралт болон Зүүлт Тайлбар хэсгүүд гэсэн бүтэцтэй. Уг бүтээлийн бичвэрийн хэлбэрийн гол онцлог бол тухайн цаг үед түгээмэл хэрэглэгддэг байсан гэрээ эрхийн баримт бичгийн арга барилаар бичигдсэнд оршино.

“Үүрдийн энх тайван”-ы үзэл санаа хэдийгээр олон улсын харилцааны олон арван үйл явдал, бодит шийдвэрүүд, гэрээ хэлэлцээрт тусгалаа олсон ч өнөөдрийг хүртэл олон улсын харилцаанд энх тайван, тэгш байдал, аюулгүй орчин цогц байдлаар бүрэлдэн тогтох боломжгүй байгаагийн голлох шалтгаануудын нэг нь улс орнуудын “үндсэрхэг” гадаад бодлого, тухайн улс гүрний шийдвэр гаргагчдад үзүүлж буй “үндсэрхэг үзэл”-ийн нөлөө болж байна.

И.Кантын “Үүрдийн энх тайван”-ыг задлан шинжилвээс “үндэстэн”, “үндэсний”, “үндэстэн улс” хэмээх нэр томъёо, ойлголтыг олж харж болох ч улс үндэстнүүд газар зүй, цаг уурын нөхцөл байдлаас шалтгаалан өөр өөр соёл шашин, түүхэн уламжлал бүхий үнэт зүйлийг илүү эрхэмлэдэг, өөрийн үндэстнийг бусад үндэстнээс илүүд үзэх үзэл санаа ямагт далд нуугдаж байдаг гэдгийг тооцож үзээгүй нь харагддаг. И.Кантын бүтээл нь нэг талаас “үүрдийн энх тайван”-ыг тогтоох тухай сайтар тооцолсон, философи сэтгэлгээний хувьд гайхамшигтай үзэл санааны цогц боловч, нөгөө талаас олон арван реалист судлаачдын үздэгчлэн “гэнэн”, “үл биелэгдэх” зарим нэг санаанууд агуулагдах аж. Түүний хүсэж мөрөөдөж байсан “үүрдийн энх тайван”-ыг улсуудын хоорондын харилцаанд ойрын ирээдүйд авчрах нөхцөл болон бүрэлдэхэд ихээхэн цаг хугацаа шаардах нь гарцаагүй бөгөөд улсуудын шийдвэр гаргалтад хүчтэй нөлөөлж буй “үндсэрхэг үзэл”-ийн талаар нэмэлт тайлбар, засварыг хийх зайлшгүй шаардлага гарахыг ч үгүйсгэхгүй.

Гэхдээ И.Кантын “*найрсаг зочломтгой байдал дээр тогтсон улсуудын хоорондын харилцааны систем нь олон улсын харилцаанд “Үүрдийн Энх Тайван” тогтоох аргыг тодорхойлоход чухал үүрэгтэй*” хэмээх тодотгол, мөн “*зөвхөн энэхүү найрсаг зочломтгой нөхцөл байдлын үр дүнд л бид “Үүрдийн Энх Тайван”-д зогсолтгүйгээр хүрч болно гэсэн итгэл үнэмшлийг өөрсөддөө бий болгож чадна*” гэж бичсэн сануулга хэзээ нэгэн цагт хүн төрөлхтөн асар хүчтэй “соён гэгээрэл”-ийн үр дүнд “үүрдийн энх тайван”-д хүрч болно гэдэг дүгнэлт нь бидэнд цаашид ч энх тайвныг тогтоох итгэл үнэмшлээ хадгалан үлдэхийг сануулсаар байх нь дамжиггүй.

Ашигласан эх сурвалж:

Монгол хэл дээрх эх сурвалж:

-Р.Каган. Түүх эргэн ирж мөрөөдөл төгссөн нь. Монсудар. УБ., 2010.

-И.Кант. Үүрдийн энх тайван. Монсудар. УБ., 2023

Англи хэл дээрх эх сурвалж:

Ном зохиол, эрдэм шинжилгээний өгүүлэл:

-Casey Rentmeester. Kant's Rational Freedom: Positive and Negative Peace. In *Peaceful Approaches for a More Peaceful World*. Leiden, Netherlands: (2022). pp. 230-238.

-Eben Kaplan. "U.S Political Parties and Foreign Policy". Council on Foreign Relations. 2006

-Galtung, J. Violence, Peace, and Peace Research. *Journal of Peace Research*, 6, 1969. 167 - 191.

-James Bohman, Matthias Lutz Bachmann. *Perpetual Peace: Essays on Kant's Cosmopolitan Ideal*. The MIT Press, 1997.

-John Kane. Democracy and world peace: the Kantian dilemma of United States foreign policy. *Australian Journal of International Affairs*. Volume 66, 2012. pp. 292-312

-Michael Lind. *The American Way of Strategy*. Oxford University Press. 2006.

-Richard M. Gamble. *The War for Righteousness: Progressive Christianity, the Great War and the Rise of the Messianic Nation*. Open Road Media. 2014.

-Scott Berg. Wilson. Putnam Publishing Group. NY. 2013. pp. 45-49

Цахим эх сурвалж:

-Dr. M.M. (Matthijs) Lok. The Nation in Immanuel Kant's Perpetual Peace.

https://www.academia.edu/11292297/The_Nation_in_Immanuel_Kants_Perpetual_Peace

-Krutika Pathi, Sheikh Saaliq. Once a fringe Indian ideology, Hindu nationalism is now mainstream, thanks to Modi's decade in power. *Associated Press News*, April 19, 2024.

<https://apnews.com/article/india-election-narendra-modi-hindu-nationalism-rss-79c30c8ae750a9c037d86b9e2c1b640c>

-Schertzer, Robert, and Eric Taylor Woods, 'Donald Trump and the New Nationalism in America', *The New Nationalism in America and Beyond: The Deep Roots of Ethnic Nationalism in the Digital Age* (2022; online edn, Oxford Academic, 21 Apr. 2022),

<https://doi.org/10.1093/oso/9780197547823.003.0005>, accessed 22 Apr. 2024.

-Four Freedoms Park Conservancy. Franklin D. Roosevelt's Models: Theodore Roosevelt and Woodrow Wilson

https://fdr4freedoms.org/wpcontent/themes/fdf4fdr/DownloadablePDFs/I_FDRBeforethePresidency/01_FranklinDRooseveltsModels.pdf

-Yale Law School. Lillian Goldman Law Library. Laws of War : Declaration on the Launching of Projectiles and Explosives from Balloons; July 29, 1899
https://avalon.law.yale.edu/19th_century/dec99-01.asp

-Yale Law School. Lillian Goldman Law Library. Laws of War : Declaration on the Use of Projectiles the Object of Which is the Diffusion of Asphyxiating or Deleterious Gases; July 29, 1899
https://avalon.law.yale.edu/19th_century/dec99-02.asp

-Yale Law School. Lillian Goldman Law Library. Laws of War : Declaration on the Use of Bullets Which Expand or Flatten Easily in the Human Body; July 29, 1899
https://avalon.law.yale.edu/19th_century/dec99-03.asp

-Yale Law School. Lillian Goldman Law Library. Laws of War : Limitation of Employment of Force for Recovery of Contract Debts (Hague, II); October 18, 1907
https://avalon.law.yale.edu/20th_century/hague072.asp

SPSIRPA FORUM 2024

Session 3-6

Mongolia-Russia border relations and the evolution and changes
of the regional geopolitical environment



**"ГЕОПОЛИТИКИЙН ДАХИН ХУВААРИЛАЛТ: БҮС НУТГИЙН
ТУЛГАМДСАН АСУУДЛУУД БА ТӨРИЙН БОДЛОГО"
"GEOPOLITICAL RESTRUCTURING: REGIONAL ISSUES AND POLICY
AFFAIRS"**

Илтгэгч: П.Цацрал /Дотоод хэргийн их сургууль, Хил судлалын ухааны докторант, дэд
хурандаа/

Speaker: P. Tsatsral /Doctoral student of Border Studies, University of Internal Affairs,
lieutenant colonel/

Илтгэлийн сэдэв:

**МОНГОЛ-ОРОСЫН ХИЛИЙН ХАРИЛЦАА БА БҮС НУТГИЙН
ГЕОПОЛИТИКИЙН ОРЧНЫ ХУВЬСАЛ, ӨӨРЧЛӨЛТ
MONGOLIA-RUSSIA BORDER RELATIONS AND THE EVOLUTION AND
CHANGES OF THE REGIONAL GEOPOLITICAL ENVIRONMENT**

Keywords: border relations between Mongolia and Russia, historical traditions, border security, regional security, geopolitics, current state and attitude

Abstract: The national border is a reflection of the political policy of the bordering countries, and it is the first thing that is felt there, and it is a bridge of equality and mutual respect between countries. Mongolia's friendly relations with its eternal neighbor, Russia, is a major and very important factor and a guaranteed condition for the country's fundamental interests, independence, and security.

Since the direction of the military and political policies of the neighboring countries is determined from the border relations, it is important to study and implement the trends in the border relations between Mongolia and the Russian Federation. Today, the security and geopolitical situation in the region, especially the situation in our northern neighbor Russia, and the extremely tense war situation, have become one of the problems facing Mongolia's border security.

Түлхүүр үг: Монгол, Оросын хилийн харилцаа, түүхэн уламжлал, хилийн аюулгүй байдал, бүс нутгийн аюулгүй байдал, геополитикийн өнөөгийн төлөв, хандлага

Хураангуй: Улсын хил нь хил залгаа орнуудын улс төрийн бодлогын тусгал болж, хамгийн түрүүнд тэнд мэдрэгддэгээрээ онцлог бөгөөд улс хоорондын эрх тэгш, харилцан хүндэтгэлийн гүүр юм. Монгол улс мөнхийн хөрш ОХУ-тай найрсаг харилцаатай байх нь улс орны язгуур ашиг сонирхол, тусгаар тогтнол, аюулгүй байдлын нэгэн том, ихээхэн чухал хүчин зүйл, баталгаатай нөхцөл болдог.

Хилийн харилцаанаас хөрш зэргэлдээ улсуудын цэрэг, улс төрийн бодлогын чиг хандлага тодорхойлогдож байдаг учраас Монгол улс, ОХУ-ын хилийн харилцааны уламжлал шинэчлэл, хөгжлийн чиг хандлагыг судлан алба үйл ажиллагаандаа хэрэгжүүлж байх нь чухал юм. Өнөөдөр бүс нутгийн аюулгүй байдал, геополитикийн нөхцөл байдал, тэр тусмаа манай хойд хөрш ОХУ-ын нөхцөл байдал, туулийн хурцадмал дайны байдалтай байгаа нь Монгол улсын хилийн аюулгүй байдалд тулгамдаж буй асуудлын нэг болоод байна.

Удиртгал

*Аливаа улсад мөнхийн холбоотон, мөнхийн дайсан гэж үгүй,
гагцхүү мөнхийн эрх ашиг л гэж бий. Шарль дэ Голль*

XXI зууны эхэнд даяаршлын үйл явц эрчимтэй өрнөж, олон улсын харилцаа ба бүс нутгийн аюулгүй байдал, олон талт хамтын ажиллагааны цар хүрээ улам бүр өргөжин тэлж, дэлхий нийтийн шинж чанартай болсноор улс төр, нийгэм, эдийн засаг, цэрэг-стратегийн зэрэг бүхий л салбарыг хамарч, улс хоорондын харилцааг өөр хоорондоо нягт уялдаатай, ихээхэн түгээмэл агуулгатай болгосоор байна.

Монголчууд бид болзошгүй аюулаас сэргийлэхийн тулд хоёр хөршийнхөө геополитикийн ашиг сонирхлыг сайтар судалж, Төв Азийн болон Зүүн хойд Азийн бусад орнуудад улс төр, эдийн засгийн бодлогын зохицуулалт хэрхэн явагдаж байгааг ажиглаж, хөгжлийн бодлогодоо оновчтойгоор тусгаж байх нь улс орны аюулгүй байдал, хөгжил дэвшилд эергээр нөлөөлөх болно. Монгол Улсыг хүрээлсэн орон зайд “Хүйтэн дайн”-аас хойш гарсан эрс өөрчлөлт, түүний цаашдын хандлага нь биднийг ирээдүйн хөгжил, аюулгүй байдлын асуудлаа Ази, Номхон далайн бүс нутаг, түүний дотор Зүүн Хойд Азийн хүрээнд авч үзэхэд хүргэсэн билээ.

ОХУ-ын хувьд Төв Азид хамгийн хүчтэй нөлөөлж чадах улс. Өөрөөр хэлбэл, цэрэг улс төр, эдийн засгийн хувьд Төв Азид шахалт үзүүлэх бүхий л арга хэрэгсэл бий. Төв Азийн орнуудын эдийн засгийн гол хөдөлгүүр болох аж үйлдвэрүүдийн ихэнх нь ОХУ-ынх байдаг учраас Оросгүйгээр тэд хөдлөх боломжгүй.¹ Төв Азийн улс орны газрын тос, байгалийн хийн хоолой, автозам, төмөр зам гээд бүхий л холбоо, дэд бүтэц Оросын нутгаар дайрдаг. Энэ нь ОХУ-д Төв Азийг хянах боломж, давуу талыг олгодог юм. Гэвч сүүлийн жилүүдэд Оросын эдийн засаг тогтворгүй байгаа явдал Хятадад Төв Азид эдийн засгийн бодлогоо тайван хэрэгжүүлэх шинэ боломжийг өгч, Бээжин тус бүс нутагт эдийн засгаар халхавчилсан улс төрийн бодлогоо явуулж байна. Зүүн Хойд Азид хамгийн хүчтэй нөлөөллийн нэг голомт нь Хятад улс байгаа юм. Геостратегийн хувьд Монгол Улсын хамаарч буй Төв болон Зүүн Хойд Азийн бүс нутагт гол нөлөөлөгч, хүчний тэнцвэрийг хадгалагч төвүүд нь яалт ч үгүй манай урд болон хойд хоёр хөрш улсууд байгааг бид бэлхнээ харж буй юм.

Ямар нэг их гүрний геополитикийн ашиг сонирхлын тойрогт шууд оршоогүй л бол жижиг улсуудын үйл ажиллагаа нь илүү чөлөөтэй байдаг. Харин эсрэгээрээ газар зүйн байршил, байгалийн баялаг нь аливаа улсын ашиг сонирхолд илүү өртөж байдгийг түүх гэрчилнэ.

Нэг. Хил судлал ба Геополитик судлалын ухааны нийтлэг тал, уялдаа холбоо, Монгол Улс, ОХУ-ын төрийн хилийн бодлогын мөн чанар

Аливаа улс орон хилийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаандаа өөрийн орны физик газар зүйн онцлог, улс төр, нийгэм эдийн засаг, хүн ам, тэдний шилжилт хөдөлгөөн, хөрш улс болон бүс нутгийн нөхцөл байдлаас хамаарсан төрөл бүрийн арга хэлбэр, төрийн бодлогыг баримталдаг. Ингэхдээ нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн, улсын хилийн халдашгүй дархан байх зарчмыг олон улсын гэрээ хэлэлцээр, эрх зүйн хэм

¹ How the Russia-China Strategic Partnership Marks a New Global Power Shift, by Pepe Escobar
<http://www.alternet.org/world/how-russia-china-strategic-partnership-marks-new-global-power-shift>

хэмжээний хүрээнд бүх нийтээр хүлээн зөвшөөрч хилийн аюулгүй байдлыг харилцан хүндэтгэлтэйгээр хамтран хангахыг чухалчлах болсныг хилийн аюулгүй байдлыг хамтын хүчээр хангах², хилийн нэгдмэл менежментийг нэвтрүүлэх³, хил хамгаалалтын хамтын систем үүсгэх⁴, олон улсын эрх зүйн зохицуулалтын⁵ аргаар хангах туршлага болон манай орны улсын хил хамгаалалтын “нэг хил, хоёр улс” зарчим⁶ зэргээс харж болно.

Хил судлалд ерөнхийд нь онол-арга зүйн уламжлалт болон постмодернист гэсэн хоёр хандлага давамгайлж буй бөгөөд шинэ хандлагууд хуучнаа бүрэн үгүйсгэх бус харин баяжуулан төгөлдөржүүлэх замаар явж ирэв.⁷

Уламжлалт хандлагуудад түүх-газрын зургийн, типологийн аргууд нь улс төрийн хандлага багтана. Түүх-газрын зураг, типологийн аргууд нь хилийн шугамыг хэрхэн тогтоож ирсэн, түүнд нийгэм, улс төр, газар зүй, эдийн засгийн хүчин зүйлс хэрхэн нөлөөлж ирснийг голчлон судалдаг бол функциональ хандлага нь хилийг гол төлөв гүйцэтгэж ирсэн чиг үүрэг талаас нь судалдаг.

Энэ үүднээс авч үзвэл хил нь зааглан тусгаарлан, холбон нэгтгэх, хянан шалгах гэсэн 3 үндсэн чиг үүрэгтэй. Хилийг функциональ хандлагын үүднээс судлах явдал аажмаар улс төрийн хандлагын арга буюу олон улсын харилцааны онолын парадигм руу хөтөлдөг ажээ.

Хоёрдугаарт, Улсын хил нь хөрш улсуудын төрийн, улс төрийн бодлогын нөлөө, харилцааны өөрчлөлт хамгийн түрүүнд илэрдэг толь, дотоодын нийгмийн амьдрал, үзэгдлүүдийн мөн тусгал болдог жамтай. Хил хязгаар, орон зай нутаг дэвсгэрийн хил заагийн тухай онолын тайлбар, олон нийтийн ойлголт, хандлагууд глобалчлал, шинжлэх ухаан-технологийн хөгжлийг даган ихээхэн хувьсан өөрчлөгдлөө. Сүүлийн үед их гүрнүүдийн геополитикийн өрсөлдөөн, миграцийн шинэ давлагаатай уялдан дахин шинэ голдирлоор хувьсан өөрчлөгдөх төлөв илт ажиглагдах болов.⁸

Хил судлал болоод геополитикийн эрдэмтэд доорх ерөнхий асуудлыг шийдвэрлэхэд өөрсдийн чиглэлээр хамтран судалгаа хийгдсэн байдаг. Үүнд:

- Улс хоорондын хилийн зааг, хилийн үйл ажиллагааны тогтолцоонд геополитикийн хүчин зүйлийн нөлөөлөл;
- Улс орны нутаг дэвсгэр ба улс төрийн үйл явцын харилцан холбооны диалектик;
- Улсын хилийн болон гаалийн бодлого;
- Улсын хил дээрх улс төрийн тогтвортой байдал хийгээд геополитик;
- Дэлхийн болон бүс нутгийн байдал дахь геополитикийн хөгжлийн чиглэл, хил орчмын хөгжилд үзүүлэх нөлөөлөл;

² James, R.P., Jeffrey, D., Monica, K. (2018). “Border Security”, Carolina Academic Press, Durham, 370-373.

³ Frontex, European Commission., (2010). “Guidelines for Integrated Border Management in European Commission External Cooperation”, EuropeAid Cooperation Office, 13-25.

⁴ Ганболд.Ц., (2018). “Хилийн аюулгүй байдлаа хангаж буй гадаадын зарим орнуудын туршлага, сургамж”, Хилийн аюулгүй байдалд тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам, ДХИС, Уб., 87 тал.

⁵ OSCE, “Border Security and Management Concept”, (2005). Organization for Security and Co-operation in Europe Ministerial Council, Ljubljana, MC.DOC/2/05, osce.org.

⁶ Арвай.Ш., (2018). “Үндэсний аюулгүй байдлын үүднээс хилийн аюулгүй байдлыг шинжлэх нь”, Хилийн аюулгүй байдалд тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам, ДХИС, Уб., 27 тал.

⁷ В.А.Коловсов. Теоретические подходы в изучении границ, //Введение в исследования границ/ под ред. С.В.Севастьянова., Ю.Лайне., А.А.Киреева. -Владивосток: Дальнаука, 2016. с. 36.

⁸ Ц.Ганболд. Хил судлал. Уб., 2022, 359-р тал.

- Монгол орон, түүний хилийн геополитикийн байдал;
- Хөрш зэргэлдээ орнуудын Монголтой харилцах геополитикийн байдал зэрэг болно.

Сүүлийн жилүүдэд хил судлал нь хилийн бодлогыг улсын гадаад бодлого, дипломат албаны онолтой холбон үзэх болсон. Хил судлал нь олон улсын харилцааны үндсэн зарчим, арга зүйн гадаад бодлогын болон дипломатын онолын ололт, арвин баялаг үр дүнг ашиглаж байна. Хилийн бодлогыг хэрэгжүүлэхэд олон улсын дипломатын нааштай аргуудыг тухайлбал, хөрш зэргэлдээ орнуудтайгаа найрамдалт харилцаа тогтоох, эрэл хийх, тусгаарлах/дипломатын, эдийн засгийг зохицуулагч шинжтэй хориг арга хэмжээ авах/, зэргэлдээ улсуудтайгаа бүлэглэл байгуулах, төрийн бус байгууллагын хүчийг ашиглах зэрэг аргыг хил судлал өргөн хэрэглэдэг.

ОХУ-ын ШУА-ийн Дорно дахин судлалын хүрээлэнгийн эрдэмтэн, доктор С.А.Панарин “Хил дамнан ирж болзошгүй ямар аюул заналуудаас улсын хил хамгаалж чадахгүй вэ?” (От каких трансграничных угроз не может защитить государственная граница) сэдэвт лекцэд: Тэрбээр хил дамнан нэвтрэн орж ирэх боломжтой үзэл санаа, эд зүйл, хүн гэсэн гурван зүйл, тэдгээрийн тээж ирэх аюул заналын талаар сонирхолтой санаануудыг дэвшүүлэв.⁹ “...Жилээс жилд хил дамнан асар их хэмжээгээр урсан нэвтэрч буй дээрх 3 зүйлийн дайж ирэх аюул, заналыг ямар ч улсын хил бүрэн хянаж, тогтоон хамгаалах боломжгүй гэж онцлон дурдсан байна.

Ийм аюул заналын өөдөөс хоёр хандлага байж болох бөгөөд Нэгдүгээрт, бараг төгс гэж хэлж болох хилийг байгуулах. Улсын хилийг бүхий л шаардлагатай хянах, ажиглах, шалгах тоног төхөөрөмжөөр бүрэн хангасан, засаглалын хувьд аливаа нэг дарангуйлал болон аюулгүй байдлыг дээд зэргээр чухалчлаагүй, хүчирхэг төр засагтай, авлигал, албан тушаалаа урвуулан ашиглах явдалд автагдаагүй, өндөр мэргэжлийн боловсон хүчин бүхий улсын хилийг төсөөлж болох юм.

Бодит байдал дээр ийм халдашгүй хилийг бий болгох нь бараг боломжгүй. Тэгэхлээр аливаа нэг аюул заналыг тээгч үзэл санаа, эд зүйл, хүмүүс ямарваа нэг хяналт шалгалтыг нэвтрэн гарах боломжтой. Гэхдээ ийм тохиолдолд маш цөөн, үзүүлэх нөлөө бага бол хилийн хяналт шалгалт шаардлагын түвшинд байна гэж үзэж болно. Харин байн байн, ихээхэн хэмжээнд илрээд ирэх юм бол хилийн үүрэг функц ажиллахгүй, халдашгүй дархан байдал алдагдаж буйг илтгэх ажээ.¹⁰

Хил орчмын бүс нутаг нь гадны хүчний нөлөөлөлд өртөмтгий байдаг тул засгийн газар төдийгүй орон нутгийн захиргаа илүү их хариуцлагатай хандах ёстой. Одоогийн байдлаар ОХУ 89 субъект байгаагийн 43 нь хилийн бүс нутаг бөгөөд 24 шинээр бий болжээ.

Монгол Улсын засаг захиргааны үндсэн нэгж болсон 14 аймаг, 69 сум, 150 гаруй баг, 300.000 орчим хүн ам хил орчмын нутаг дэвсгэрт оршдог. Монгол Улсын газар нутгийн 25 хувийг хил орчмын нутаг дэвсгэр эзэлдэг бөгөөд хилийн бүс, зурваст хүн амын 12 хувь, малын 30 орчим хувь нь суурьшин амьдардаг. Үүнээс хойд хилийн чиглэл,

⁹ В.А.Коловсов. Теоретические подходы в изучении границ, //Введение в исследования границ/ под ред. С.В.Севастьянова., Ю.Лайне., А.А.Киреева. -Владивосток: Дальнаука, 2016. с. 44.

¹⁰ С.А.Панарин. “От каких трансграничных угроз не может защитить государственная граница” //Российское пограничье: социально-политические и инфраструктурные проблемы./ Под ред. В.А.Колосова и А.Б.Володина. М., 2016. С-119.

ОХУ-ын Тыва Улсын 6 район, Буриад Улсын 6 район, Өвөр байгалийн хязгаарын 5 район, Уулын Алтайн Бүгд Найрамдах улсын 1 район тус тус хиллэж, хилийн харилцааг идэвхтэй явуулж байна.¹¹

Хилийн харилцааны хөгжлийн эрчим нь олон янзын хүчин зүйлээс хамаардаг. Энэхүү хөгжлийн мөн чанарт хил залгаа орнуудын төдийгүй бусад улсын үндэсний болоод төрийн ашиг сонирхол /эдийн засаг, улс төр, геополитик, нийгэм, оюун санааны гэх зэрэг/ цөм тусч байдаг билээ. Тухайлбал, орон нутгийн дайн, газар нутгийн мөргөлдөөн, бусдын тагнуул, хорлон сүйтгэх ажиллагаа, хилийн дамын наймаа, зэвсгийн хууль бус наймаа, хүн амын хяналтгүй нүүдэл, хөдөлгөөн, нөөц баялгийн дээрэм гэх мэт үйлдэл хилийн үйл ажиллагааны субъектүүдийн нэг гол үүрэг болох хилийн аюулгүй байдлыг хангахад тодорхойлогч нөхцөл, хүчин зүйл юм.

Төрийн хилийн бодлого нь улс орны амьдралын бүхий л салбар хүрээнд үүсэж буй асуудлуудыг хилийн орон зайд шийдвэрлэхэд чиглэгдэнэ. Төрийн хилийн бодлогыг хэрэгжүүлэх зайлшгүй шаардлага нь тухайн улсад үзүүлж буй гадаад, дотоод хүчин зүйлээс хамаардаг. Тухайлбал, Европын улс орнуудын хувьд хил орчмын нутаг дэвсгэрийг хүчээр булаан эзэлж байсан буюу одоогийн иргэншил, газар нутгийг хүлээн зөвшөөрөхгүй байгаа асуудал зэрэг байдаг. Жишээ нь: Өнөөгийн Орос-Украины дайны асуудал буюу өмнөх үеэс улбаатай Крымын хямралын асуудал юм. Түүнээс гадна ОХУ-ын төрийн хилийн бодлогод нөлөөлж буй дараах хүчин зүйлс байна.

ОХУ-ын төрийн хилийн бодлогын хувьд дараах гол хүчин зүйлс нөлөөлдөг.

- Зарим хөрш орнуудтайгаа улсын хилийн зарим хэсгээ тодорхойлж, тогтоогоогүй байгаа;

- Улс хоорондын томоохон мөргөлдөөнд хүргэж болзошгүй хилийн зөрчил, будилаан байсаар байгаа;

- Өмнөх төрийн тогтолцооны /ЗСБНХУ-ын/ хилийн “төмөр хөшиг”-ний бодлогоос татгалзах болсон;

- ОХУ нь өөрийн төдийгүй тусгаар тогтносон хамтын нөхөрлөлийн орнуудын гадаад хилийг хамгаалах зайлшгүй шаардлага гарч ирсэн;

- ОХУ-ын Холбооны Хилийн Албаны хүлээх үүрэг шинэчлэгдэн өргөжиж улсын хил болон хилийн орон зайд хууль бус цагаачлал болон хил дамнасан олон улсын гэмт хэрэгтэй тэмцэх үүрэг нэмэгдсэн зэрэг хүчин зүйлс;

- Орчин үед улс орон бүр төрийн тэргүүнээрээ батлуулсан төрийн хилийн бодлоготой байж, түүнийгээ хэрэгжүүлэх шаардлага зүй ёсоор тавигдсан. Энэхүү улс төрийн чухал бичиг баримтад тухайн улсаас хөрш улсуудтайгаа баримтлах хилийн асуудал, хилийн аливаа будилаантай асуудлыг шийдвэрлэх үндсэн чиглэлийг тусгадаг.

Монгол Улсын хувьд дараах хүчин зүйлүүд нөлөөлж болох юм:

- Монгол Улсын гео-улс төр, гео-стратегийн нөхцөл байдал, газар зүйн байрлал, зөвхөн хоёр том хөршөөр хүрээлэгдэн тусгаарлагдсан, тэдний дунд жийргэвч /буфер/-ийн үүрэг гүйцэтгэдэг, далайд гарцгүй, монгол үндэстнүүдээрээ хүрээлэгдсэн байдал;

- Хөрш улсуудад дотоодын хямралт байдал үүссэн үед монгол угсааны үндэстнүүдийн хяналтгүй дүрвэгсдийн урсгал орж ирэх;

¹¹ Ц.Ганболд. Хил судлал. Уб., 2022, 371-р тал.

- Баруун талаас исламын тэрс үзэлтнүүд, алан хядах бүлэглэлийн үйл ажиллагаа идэвхжин нөлөөлөө тогтоох эрсдэл, мөн салан тусгаарлах үзлийн идэвхжил;

- Хөрш орнуудын улс төр, цэргийн бодлогын өөрчлөлт, тэдгээрийн нөлөө, дотоодын улс төр, эдийн засгийн тогтворгүй байдал;

- Хязгаар нутгийн эзэнгүйдэл, ядуурал, эдийн засгийн хөгжлийн хоцрогдол;

- Төрийн хилийн бодлого, хилийн аюулгүй байдлыг хангах тогтолцооны субъектүүдийн нэгдсэн тогтолцоо, нэгдмэл удирдлагын гар нийлэмжгүй байдал зэрэг хүчин зүйлүүд болно.

Орчин үед төрийн хилийн бодлогод нөлөөлөх объектив гол хүчин зүйл бол тухайн улсын хөгжлийг тухайн бүс нутаг, олон улсын хэмжээнд тодорхойлж буй нөхцөл, нөөц бололцоог харуулсан геополитикийн үзүүлэлт болох хүчин зүйлс юм. Эрдэмтдийн дүгнэлтийг авч үзэхэд геополитикийн хүчин зүйл нь аливаа улсын гадаад бодлогын үзэл баримтлалыг боловсруулах, хөрш орнуудтай хилийн харилцааг хөгжүүлэхэд объектив үндэс суурь нь болдог ажээ.

“Геополитикийн байдал” гэдэг ойлголтын мөн чанар нь аливаа улс орон бүр дэлхий дээр өөрийн газар зүйн байрлалтай байх боловч тухайн улсын улс төрийн, цэргийн, эдийн засгийн, мэдээллийн ба бусад чадавхаас хамаарч дэлхийн амьдрал, улс төрийн бодлогод нөлөөлөх нөлөөлөл харилцан адилгүй байхыг хэлнэ. Тухайн улсын геополитикийн байдал нь цэрэг стратегийн боломж, түүний шинжлэх ухаан, технологи, мэдээллийн хөгжил, газар зүйн байрлалын онцлогоос хамааран төрийн хилийн бодлогод зохих нөлөөлөө үзүүлж, түүнийг боловсруулахад амин чухал ач холбогдолтой.

Аливаа тусгаар улсын нутаг дэвсгэр нь зах заагтай, улсын хил нь тухайн улсын төрийн хилийн бодлого бий болох, түүнийг хэрэгжүүлэх онцгой механизм хилийн стратегийг бүрэлдүүлэх, түүний аюулгүй байдлыг хангах тусгай алба байгуулах үндсэн объектив шалтгаан болдог. Улсын хил нь зөвхөн тухайн улсын геополитикийн байдлыг илэрхийлэх төдийгүй дэлхийн хамтын нийгэмлэг, улс орны өвөрмөц онцлогийг хадгалах боломжийг олгодог.

Суваг татах, газрын дээр болон доогуур инженерийн томоохон байгууламж, туннел, төмөр зам болон хоолойн тээвэрлэлтийн сүлжээ байгуулах, алсын зайг хурд хүч ихтэй нисэх болон бусад төрлийн хөлгүүдээр туулдаг болсон, мэдээлэл-технологийн хүрээнд сансрын орон зайг ашиглах болсон зэрэг нь олон улсын төрийн хилийн бодлогод нөлөөллөө үзүүлдэг. Мөн тив алгасах цөмийн зэвсгийн хөгжил нь өөрийн аюулгүй байдлын геополитикийн байдал гэсэн бодлого, байгаль-газар зүйн онцлогт тулгуурлагдсан олон улсын нийтлэг байдалд тодорхой өөрчлөлтүүдийг оруулсан.

Геополитикийн хүчин зүйлээс аливаа улсын төрийн хилийн бодлогод ихээхэн хэмжээгээр нөлөөлөх, цаашилбал дэлхийн цэрэг-улс төрийн бодлогод нөлөөлөх хэд хэдэн нөхцөлийг авч үзье. Үүнд:

- ОХУ-аас олон улсын цэрэг- улс төрийн бодлогод нөлөөлөх байр суурь зарим талаар алдагдаж байгаа, дэлхийн тэргүүлэгч гүрнүүдийн ашиг сонирхол нь түүний хил, хил орчимд илрэх аюул болсон;

- АНУ болон НАТО түүний гишүүн орнуудын цэргийн нөлөө дэлхий нийтийн хөгжлийн бүх үйл явцад хүчтэй нөлөөлөх болсон;

- Европын холбооны улсууд болон Японы эдийн засгийн үсрэнгүй хөгжилтэй холбоотойгоор тэдний геополитикийн үүрэг өссөн;
- Хятад улсаас олон улсын бодлогод нөлөөлөх нөлөө өссөн;
- Ойрх Дорнод ба Дундад Ази, Балкан, Кавказ, Төв Азийн орнуудад ислам шашинтны аюул учруулах болсон;
- Олон улсын терроризм, зохион байгуулалттай гэмт хэрэг хүрээгээ дэлхий дахинд улам тэлсээр байгаа зэрэг болно.

Аливаа улс орон нь төрийн хилийн бодлогоо боловсруулахдаа болон нэмэлт өөрчлөлт хийхдээ бүс нутгийн түвшинд геополитикийн хүчин зүйлсийн нөлөө, хилийн орон зайд үүсэж болзошгүй аюулуудыг тооцох ёстой.

Дэлхийн олон улс оронд анхаарал татаж буй асуудал бол улсын хил дамнасан хар тамхины наймаа болон олон улсын гэмт хэрэг хүрээгээ тэлж буй явдал юм. Дэлхий дахины хувьд Афганистаны хар тамхи Таджик, Казакстаны хилээр орж ирэн ОХУ, Украин, Беларусаар дамжиж баруун Европ, Япон, АНУ-д тараагдаж анхны үнээсээ хэдэн арав, зуу дахин өндөр үнээр борлогдож байна.

Төрийн хилийн бодлогод объектив хүчин зүйлүүдээс гадна субъектив хүчин зүйлүүд нөлөөлдөг. Аль ч улсын хувьд олон улсын алан хядах бүлэглэлүүд, исламын суурь үзэлтнүүд, тэдгээрийг дэмжигч улс орон, улс төрийн харгис хүчнүүд хил орчмын нутаг дэвсгэрийн цагийн байдалд нөлөөгөө үзүүлэх магадлал их байдаг.

Субъектив хүчин зүйлд төрийн хилийн бодлогыг хэрэгжүүлэгч субъектүүдийн үйл ажиллагаа ордог. (ХХБ, ГЕГ, БХЯ, ХЗДХЯ, Цагдаа, дотоодын цэрэг, ТЕГ, ОБЕГ, ГИХАЭА гэх мэт) тэдний үйл ажиллагаа нь хилийн орон зайд улс орны эрх, ашгийг хамгаалах, бодит болон болзошгүй аюулаас сэргийлэхэд чиглэгддэг.

Хил судлал болон Геополитик судлалын ухааны судлах зүйлийн нийтлэг интерграцилагдсан судлах зүйл, ойлголт нь **“Хилийн бүс нутаг судлал”** /пограничное регионоведение, border regional studies/ юм. Энэ нь бас газар зүйн шинжлэх ухааны бүрэлдэхүүн хэсэг бөгөөд физик-газар зүйн болон газар зүй- эдийн засгийн суурь дээр үндэслэгддэг. Х.Б.Н.С агуулга нь өөрийн орны болон хөрш улсын хил тэдгээрийн тэдгээрийн газар зүйн байршил, хэмжээ, өгөгдөхүүн болон хилийн бүс нутгийн ерөнхий шинж, төлөв; улсын хил хамгаалалтад нөлөө үзүүлэх физик газар зүйн ба газар зүй-эдийн засгийн орчин; улсын хил хамгаалалтад өөрийн ба хөрш орны нийгэм, улс төрийн байгуулал болон хүн ам зүйн нөлөөлөл; улсын хил хязгаар үүсэн бүрэлдэж тогтооход байгуулсан олон улсын гэрээ хэлэлцээр, үйл явдлын түүх; өөрийн болон хөрш орны улсын хилийн физик газар зүйн болон хилийн орон зайн үзүүлэлтүүд болон орон нутгийн төр, захиргааны байгууллага, түүнчлэн харилцан ажиллагаатай тагнуул, цагдаа, цэрэг, онцгой байдал, хил хяналтын байгууллагуудын байршил, үйл ажиллагааг судлах зэрэгт оршино.¹²

Хоёр. Монгол Улс, ОХУ-ын хилийн талаар баримталж буй бодлого, эрх зүйн хэм хэмжээ

Монгол Улс нь ОХУ, БНХАУ, Австрали, АНУ, АНЭУ, Казахстан, Канад, Куба, ХБНГУ, БНСУ, Турк, Энэтхэг, Япон зэрэг 36 оронтой найрамдалт хамтын ажиллагааны

¹² Улсын хилийн тайлбар толь. Уб., 2021, 118-р тал.

гэрээ, үүнээс БНХАУ, ОХУ-тай иж бүрэн стратегийн түншлэлийн; АНУ, Япон, БНЭУ-тай стратегийн түншлэлийн; БНСУ, Турк, ХБНГУ-тай иж бүрэн түншлэлийн; Канад, Австрали Улстай өргөн хүрээтэй түншлэлийн харилцаатай бөгөөд НҮБ, түүний төрөлжсөн болон бусад олон улсын байгууллагаас гаргасан 287 конвенцод, үүнээс хилийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаатай холбоотой 100 гаруй конвенцод нэгдэн орсноор олон улсын эрх зүйн хэм хэмжээний хүрээнд үйл ажиллагаа явуулах эрх зүйн орчноо бүрдүүлжээ¹³.

Түүнчлэн 1921 оноос 2017 онуудад 85 оронтой 1395 хоёр талт хамтын ажиллагааны гэрээ буюу иргэд харилцан зорчих нөхцөлийн талаар 54, Гаалийн харилцааны асуудлаар 20 оронтой 22, ургамал хорио цээрийн асуудлаар 7 оронтой 11, мал эмнэлэг, хорио цээрийн асуудлаар 15 оронтой 21, агаарын харилцааны асуудлаар 32 оронтой 36, авто тээврийн харилцааны асуудлаар 10 оронтой 17, төмөр замын харилцааны асуудлаар 3 оронтой 24 гэрээг байгуулан мөрдөн ажиллаж байна.

Монгол Улс нь хилийн асуудлаар ОХУ-тай 1931 оноос хойш 50 гаруй, БНХАУ-тай 1962 оноос 20 гаруй, Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын Засгийн газар хооронд байгуулсан 2, Дамжин өнгөрөх журмын тухай Монгол Улс, БНХАУ-ын Засгийн газар хоорондын (1993) гэрээ, хэлэлцээр зэргийг байгуулан ажиллаж байгаа нь олон улсын эрх зүйн хэм хэмжээний хүрээнд хүлээсэн үүргээ биелүүлэх үндсэн зохицуулалт болж байна.

ОХУ нь хилийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаандаа Үндсэн хууль, Төрийн цэргийн бодлого болон бусад хууль тогтоомжтой нягт уялдуулсан стратегийн урт хугацааны хөтөлбөр хэрэгжүүлж байгаа бөгөөд “иргэний эрх, эрх чөлөө, тусгаар тогтнол, газар нутгийн бүрэн бүтэн байдал, тогтвортой хөгжил, улсын батлан хамгаалалт, аюулгүй байдал” нь гадаад, дотоодын аюулаас хамгаалагдсанаар үндэсний аюулгүй байдал хангагдана¹⁴ хэмээн тодорхойлжээ.

ОХУ-ын Ерөнхийлөгчийн 2018 оны 174 тоот зарлигаар баталсан “ОХУ-ын Төрөөс хилийн талаар баримтлах бодлого” нь ОХУ-ын үндэсний аюулгүй байдлын бодлогын нэг хэсэг бөгөөд хилийн бүс нутагт үндэсний эрх ашгийг хамгаалах эрх зүй, улс төр, дипломат, эдийн засаг, батлан хамгаалах, хил хамгаалах, гааль, байгаль орчин, эрүүл ахуй, халдвар судлал, экологийн болон бусад арга хэмжээний цогц юм¹⁵ гэж заасан.

Монгол Улс, ОХУ-ын хилийн талаар баримтлах бодлогын үндсэн чиглэлээ тухайн улс орны физик газар зүй, хүн ам, улс төр, нийгэм эдийн засгийн онцлогоос хамаарч харилцан адилгүй тодорхойлсон байна. Тухайлбал, Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлогын үндсэн чиглэл нь улсын хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах, улсын хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах механизмыг боловсронгуй болгох; хил хамгаалах албаны бүтэц, үйл ажиллагаа гэж тусгасан бол ОХУ-ын төрөөс хилийн талаар баримтлах бодлогын үндсэн чиглэл нь улсын хил, хил орчмын нутаг дэвсгэр, агаарын хилийн орон зай, усан хил, эдийн засгийн онцгой бүсэд үндэсний аюулгүй байдлын тогтолцоог хөгжүүлэх, хилийн бүс нутгийн хөгжил, нийгэм, эдийн засгийн таатай нөхцөлийг бий болгох гэсэн байна.

¹³ <https://www.mfa.gov.mn>, 2021.01.06.

¹⁴ Арвай.Ш “нар”., (2016). “Хил судлалын шинжлэх ухааны онол, практикийн зарим асуудал”, ДХИС, УБ., 157 тал.

¹⁵ ОХУ-ын Төрөөс хилийн талаар баримтлах бодлого. (2018).1.4 зүйл.

Монгол Улс нь хилийн аюулгүй байдалд учирч болзошгүй аюул заналд хил дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг, хэт даврагсад, салан тусгаарлагчид, зэвсэгт бүлэглэл, терроризм, улсын хилээр нэвтрүүлэхийг хязгаарласан болон хориглосон бараа бүтээгдэхүүний хууль бус эргэлт, хууль бус шилжилт хөдөлгөөн, үй олноор хөнөөх зэвсэг түүнтэй ижил төрлийн бүтээгдэхүүний тээвэрлэлт, маргалдаан, зөрчилтэй хилийн орон зай гэх мэт хүчин зүйлсийг нийтлэгээр багтаасан байна. Харин ОХУ-ын төрөөс хилийн талаар баримтлах бодлогын баримт бичгийн “Хилийн бүс нутаг дахь үндэсний аюулгүй байдлын төлөв байдал” хэмээх 2 дугаар бүлэгт ОХУ-ын үндэсний аюулгүй байдалд заналхийлж буй гол хүчин зүйлд “Арктикийн болон Алс дорнодын стратегийн нөөцөд гадаадын орнууд, үндэстэн дамнасан корпорацууд халдах”, “... тэнгисийн орон зайг хязгаарлах асуудлыг дуусгавар болгоогүй байдал” хэмээн тодорхойлсон, мөн усны биологийн нөөцийг хамгаалах, усны биологийн нөөцийг олборлоход тавих хилийн хяналт, шалгалтын асуудлыг тусгасан зэрэг нь онцлог байна. Монгол Улсын хилийн талаар баримтлах бодлогын баримт бичигт далай тэнгис, гол мөрний ус болон усны биологийн нөөцийг ашиглах, хамгаалах талаар тусгайлсан заалт байхгүй бөгөөд нэр томъёоны хувьд “хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдал”, “хил орчмын нутаг дэвсгэр”, “бүс нутаг” гэх нийтлэг томъёоллыг ашигласан байна.

Гурав. Монгол Улс, ОХУ-ын хил орчмын нутаг дэвсгэрт үүсэж болзошгүй хилийн аюулгүй байдлын шинж төлөв, бүс нутгийн геополитикийн орчны хувьсал өөрчлөлт

Монгол улс улс хоорондын харилцаанд энхийг эрхэмлэх, итгэлцлийг бэхжүүлэх үйл хэрэгт идэвх, санаачилга гарган оролцож, дэлхийн тэргүүлэгч гүрнүүдийн зүгээс дэмжлэг олж авч чадсан хэдий ч геополитикийн аюулгүй байдлын хувьд маш эмзэг орчинд оршиж байна.

Иймээс шинээр үүсэн бий болж байгаа геополитикийн үүдэл сэдэл бүхий эрсдэл сорилтыг нээн илрүүлж, цоо шинээр ухаарч ойлгох, Монгол Улсын үндэсний аюулгүй байдалд сөргөөр хүчтэй нөлөөлж эхэлж буй эдгээр хүчин зүйлсээс урьдчилан сэргийлэх, саармагжуулах, хамгаалах практик шийдлийг хайн олох шаардлага зүй ёсоор урган гарч байна. Сүүлийн жилүүдэд Монгол Улсын эзэлж байгаа геополитикийн орон зай дэлхийн том гүрнүүдийн анхаарлыг хүчтэй татах болж, манай улс тэдгээрийн геостратегийн сөргөлдөөний шинэ талбар болон хувирч байгаа нь нэгэнт бодит зүйл болжээ. Энэ нь:

Нэгдүгээрт, нүүрс, зэс, молибден, алт, уран болон бусад ашигт малтмалын асар том ордууддаа бусад оронтой хамтран ашиглаж эхэлсэнтэй;

Хоёрдугаарт, үндсэндээ авторитар дэглэмтэй дэлхий хоёр том гүрний дунд хавчигдан оршиж байгаа боловч ардчиллыг хөгжүүлэх талаараа социализмын дараах орнуудад, ялангуяа Азийн улсуудад үлгэр жишээ болж байгаатай;

Гуравдугаарт, дэлхий нийтийн хувьд тогтворгүй байдлын нэг үндэс болоод байгаа лалын ертөнцтэй хил залгаа оршдогтой;

Дөрөвдүгээрт, магадгүй хамгийн чухал нь, Орос, Хятад гээд өөр хоорондоо болон АНУ тэргүүтэй барууны орнуудтай багагүй зөрчил, сөргөлдөөнтэй хоёр том улсын дунд оршдог стратегийн чухал байршил зэрэгтэй холбоотой юм.

Сүүлийн жилүүдэд Монгол-Оросын харилцааны хоёр болон олон талт хамтын ажиллагаа өргөжин, олон ахиц дэвшил гарч байна. Тухайлбал, хоёр орны иргэн харилцан визгүй зорчих болсон, Төмөр замаар дамжин өнгөрөх ачаа тээвэрлэх нөхцөлийн тухай Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын засгийн газар хоорондын хэлэлцээр”-т 2018 оны 6-р сард гарын үсэг зурснаар сүүлийн 10 орчим жил хоёр улсын хооронд ярьсан асуудал биеллээ олж хэрэгжиж эхэлсэн, 2018 оны 8-р сарын 24-нд Монгол-Орос-Хятад гурван улсын байгалийн хийн хоолойн төслийн бүтээн байгуулалтын хамтын ажиллагааны гэрээг байгуулан гарын үсэг зурсан, Мөн гурван улсын хамтын ажиллагааны хүрээнд Хятадын Шинэ торгоны зам, Монголын Талын зам, Оросын Транс Евроазийн бүслүүрийн үзэл санааг нэгтгэсэн гурван улсын эдийн засгийн коридор байгуулах чиглэлээр харилцаа, хамтын ажиллагаа өргөжин тэлж байна. Эдгээр Монгол-Оросын харилцаанд гарч буй эдгээр нааштай өөрчлөлтүүд нь шинэ агуулгаар улам баяжиж, гамшиг осол, хүмүүнлэг, энхийг сахиулах, терроризмтой тэмцэх, нийтийг хамарсан хүн, малын халдварт өвчин, байгалийн гамшиг зэрэг олон талт ажиллагаануудыг өөртөө багтааж, улс орны оршин тогтноход цэргийн бус шинжтэй аюул заналхийллээс сэргийлэх, үндэсний хүч хэрэгслийг нэгдмэл үйл ажиллагаанд оруулж ашиглах зайлшгүй шаардлагууд бий болгож байна.

Түүнчлэн 1998 оноос Монгол Улс, ОХУ Элчин сайдын яамдаа Хилийн албан ёсны төлөөлөгч харилцан суулгаж ажиллуулсан нь Хил хамгаалах байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлэхэд тус дөхөм болов. Хил орчмын хамтын ажиллагааны тухай ерөнхий хэлэлцээрийг 2000 онд байгуулж, түүний дагуу хулгайлагдсан болон бэлчээрээр хил давсан малыг буцааж өгч байх асуудлаар хамтарсан комисс байгуулан ажиллаж байна. Үүний үр дүнд хил дамнасан малын хулгайн хэрэг буурч байна. 2010 оноос хойш хилийн дөрвөн аймгийн Увс, Баян-Өлгий, Завхан, Хөвсгөл нутагт 360 удаагийн 704 хүн хилийн зөрчил гаргасан бөгөөд жилд жилд зөрчлийн тоо буурч байгаа нь Монгол-Оросын хилчдийн хамтын хүчин чармайлт, хууль хяналтын байгууллагын ажлын үр дүн бөгөөд 2014 онд Увс аймгийн хэсгээр улсын хилийг зургаан удаа зөрчиж, 115 мал хулгайлсан байдаг. Хулгайд алдагдсан малын 52 нь хоёр улсын хилийн хамтын ажиллагааны үр дүнд олдсон.¹⁶

2014 оны 9 дүгээр сарын 11-нд Тажикстаны нийслэл Душанбе хотноо БНХАУ, ОХУ, Монгол Улсын төрийн тэргүүн нарын нүүр тулсан анхны уулзалт болсон нь манай гурван орны найрамдал, хамтын ажиллагаанд шинэ буюу тэр үед хэвлэл, мэдээллийн зарим хэрэгслээр тэмдэглэж байснаар олон улсын харилцаанд “стандарт бус” үзэгдэл болсон юм. Дэлхийн улс орнуудын гадаад харилцаанд төрийн тэргүүн нарын нүүр тулсан хоёр талын уулзалт болдог нь байдаг уламжлал. Харин энэ уулзалт шиг гурван талын уулзалт тэр болгон болоод байдаггүй бөгөөд олон судлаачид түүхэн хэмээн нэрлэсэн байна.

Монголын хөрш орнуудын гурвалсан хамтын ажиллагаа дөнгөж эхэлж байсан тэр үед БНХАУ-ын дарга Си Жинпин “Сайн эхлэл бол хагас амжилт” хэмээн онцолсон бол ОХУ-ын ерөнхийлөгч В.Путин Монгол Улсын саналыг “зөв зүйтэй санаачилга” гэсэн байна. Гэхдээ дараагийн уулзалтуудыг аль нэг улсдаа ээлжлэн хийж байх, тэгэхдээ одоо байгаа яриа хэлэлцээрийн түвшнийг ахиулсан хэлбэр учраас ШХАБ-ын хүрээнд ч ийм

¹⁶ Д.Дашдаваа, Ц.Ганболд, А.Муратхан. Хилийн аюулгүй байдал. Уб., 2021, 202-р тал.

гурвалсан уулзалтуудыг хийж болох юм гэсэн саналыг хэлсэн байдаг.

ШХАБ-д ажиглагчаар байсан Монгол Улс энэ байгууллагад жинхэнэ гишүүнээр элсэх эсэх нь Монгол Улсын эдийн засгийн хөгжил, аюулгүй байдал, геополитикийн тэнцвэрт байдлыг хангахад шийдвэрлэх үүрэг бүхий асуудал болон тавигдаж магадгүй гэж зарим хүмүүс үзэж байхад, зарим судлаач Монгол Улс ШХАБ-д элсэхийг буруушааж, харзнах нь зүйтэй гэсэн байр суурьтай байна. Тухайлбал, *МУИС-ийн Олон улсын харилцаа, Нийтийн удирдлагын сургуулийн багш, доктор С.Баясгалан*: “ШХАБ-д элслээ гэхэд хоёр хөршөөс бодлогын шахалт ирэхийг үгүйсгэхгүй” гэж үзэл бодлоо илэрхийлсэн байна. Тэрээр үзэхдээ: “Манай улсын нэн тэргүүний бодлого бол худалдаа эдийн засгийн интеграцид орох. Гэтэл бидний ойр тойронд ямар ч интеграци алга. Хамгийн ойр нь АПЕК. Харамсалтай нь шинээр гишүүн элсүүлэхгүй гэж байгаа. Монголын хувьд ч Номхон далайн орон гэхээс илүү Төв Азийн орон учраас боломжгүй. Мөн ШХАБ худалдаа эдийн засгийн бүрэн хэмжээний интеграци болоогүй байгаа учраас Монголын эдийн засагт хувь нэмэр оруулахуйц нөлөө бүхий улс орон хоёр хөршөөс өөр алга. Тиймээс элсэж орно гэж яарах хэрэггүй гэж харж байна.” гэж үзжээ. Энэ ч өнөөгийн хөрш улсуудын ШХАБ дахь бодит нөхцөл байдалтай нийцэж буй юм.

Монгол Улсын мөнхийн хөрш ОХУ нь олон улсын хамтын нийгэмлэгт эзлэх байр суурь, нөлөө, эдийн засаг, хүн ам, цэрэг-улс төрийн хүчин чадлын түвшингөөр эрс ялгагдах хуурай газраар 18 оронтой, далайгаар АНУ, Япон гэсэн хоёр оронтой хиллэдэг, дэлхийн хамгийн урт буюу 61 мян.км урт хилтэй том гүрэн юм. Монгол Улс дэлхийн нөлөө бүхий улс ОХУ-тай 3485 км өргөн уудам газраар шууд хил залгаа оршдогийн хувьд ОХУ-ын дотоод болон бүс нутгийн үүссэн донсолгоо манай улсын хилийн аюулгүй байдлын хэмжээнд нөлөөлөхүйц эрсдэл дагуулах магадлал өндөр байна. Тухайлбал, Монгол улсад олон улсын терроризмын заналхийлэл харьцангуй бага боловч өргөн уудам нутаг дэвсгэртэй, мансууруулах бодис буюу хордуулах, цацраг идэвхт, тэсэрч дэлбэрэх бодис, галт зэвсэг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэх гэмт хэрэгт Монгол Улс өртөх магадлалтай юм.

Өнөөгийн бодит байдал гэвэл, ОХУ сүүлийн 20 гаруй жилийн хугацаанд Дагестан, Чечень, Горный Карабах, Абхаз, Гүржийн таван өдрийн дайн, Оросын Сири дэх байлдааны ажиллагаа, 2014 оноос эрчимжсэн ОХУ, Украйны хямрал эдүгээ Евро бүс нутгийн улс хоорондын дайны байдалд шилжээд даруй 2 жилийн нүүрийг үдсэн зэргээс харахад ОХУ-ын дотоод, гадаадын цэрэг-дайны үйл ажиллагаа нь дотоодын болон бүс нутгийн хүрээнээс аль хэдийн халин гарч дэлхийн хэмжээний түвшинд шилжсэн байна. Энэхүү дайн нь 1994 оны Украйны бүрэн бүтэн байдал, хилийн халдашгүй байдлыг хүлээн зөвшөөрч, гарын үсэг зурсан Варшавын Санамж бичгийг зөрчин Крымийг өөртөө нэгтгэсэн үйл явдлаас тод харагдаж байна. Орос Улс Крымд амьдардаг орос хэлээр ярьдаг цөөнхийн эрх ашиг хөндөгдсөн гэж тайлбарласан боловч тухайн үеийн нөхцөл байдлаас аваад үзэхэд Украйны НАТО-д элсэх сонирхол, олон жилийн эдийн засгийн буруу бодлого, авилгалаас үүдэн дотоод зөрчлөө шийдвэрлэж чадахгүй хурцатгаснаас нэгдмэл байдлаа хадгалж чадахгүй сул дорой улс болгосныг өөртөө таатайгаар эргүүлж чадсанд оршиж байна. АНУ, барууны орнууд Украйныг НАТО-д элсүүлнэ, НАТО хамгаална гэж олон жилийн турш зөрчлийг дэвэргэсэн.

ОХУ-Украйны дайн түүнээс үүдэлтэйгээр АНУ болон Европын улс орнуудаас тавьсан эдийн засаг санхүүгийн хориг арга хэмжээ нь дэлхийн түүхий эдийн зах зээл

дээрх нийлүүлэлтийг бууруулж, үнийн өсөлтөд хүчтэй нөлөөлж байна. Экспортын хувьд ОХУ байгалийн хий, улаан буудайн 18 орчим хувь, газрын тосны 13, наран цэцгийн тос, бордооны тус бүр 15, хөнгөн цагаан болон зэсийн 10 орчим хувийг тус тус бүрдүүлдэг. Харин Украин Улс дэлхийн наран цэцгийн тосны экспортын 55, эрдэнэ шишийн 18, улаан буудайн 10 орчим хувийг дангаар эзэлдэг. Украинд эдгээр ургамлуудыг тариалдаг гол бүс нутгийн нийт тариалангийн 70 орчим хувь нь дайны хөлд өртөөд байгаа юм. Үүнээс улбаалж 2020 оны тариалалт муу, ургацаар дамжуулан эдгээр хүнсний нийлүүлэлт ирэх онд тааруу байхыг илтгэж, нөөцлөлт хүлээлтээр дамжин үнийн өсөлтөд нөлөөлж байгаа юм. ОХУ нэг өдөрт 6,6 сая баррель газрын тос экспортолдог, ОХУ болон Украин Улс хамтдаа дэлхийн улаан буудайн зах зээлийн 30 хувийг бүрдүүлдэг. Мөн наран цэцгийн тосны худалдааны 70 хувийг эзэлдэг. Иймд дайнаас үүдэн ийм их хэмжээний нийлүүлэлт дэлхийн түүхий эдийн зах зээлд буурснаар үнийн өсөлт Монгол Улсад төдийгүй дэлхий нийтэд огцом өсөж байна. Нийлүүлэлт буурснаас болж байгалийн хийн үнэ түүхэндээ хамгийн оргил үнэдээ хүрсэн бол үр тарианы үнэ сүүлийн 10 жилд байгаагүй өндөр үнэд хүрсэн юм. Ковид-19 цар тахлаас үүдэлтэй ложистик, тээврийн зардлын өсөлт дэлхийн үнийн өсөлтөд тусгалаа олоод байсан бол одоо дайнаас үүдэлтэй нийлүүлэлтийн хомсдол дэлхий дахинд хүнд цохилт болоод байна.¹⁷

ОХУ-ын Ерөнхийлөгч Владимир Путин 2022 оны 12 дугаар сарын 22-нд Оросын армийн бие бүрэлдэхүүнийг гуравны нэгээр нэмэгдүүлэх төлөвлөгөөгөө танилцуулахад цэрэг татлага, Украинд тулалдахаас зугтсан оросуудын ээлжит давлагаа Монгол Улс руу чиглэсэн. Путины дайн олон тооны оросууд, тэр дундаа цэргийн насныхныг визгүй зорчих боломжтой улс орнууд руу дүрвэхэд хүргэсэн бөгөөд эдгээр орнуудын нэг нь Монгол Улс. Хэсэгчилсэн дайчилгаа зарласан даруйд Оросын иргэд эх нутгаасаа гарч эхэлсэн. Дайн эхэлснээс хойших хугацаанд 1.4 сая хүн эдийн засгийн хориг арга хэмжээний улмаас болон дайнд оролцохоос зайлсхийх үүднээс эх орноо орхин гарчээ. Монголд ирж буй Орос иргэдийн ихэнх нь буриад, халимаг, тува зэрэг монгол ястнууд. Мөн арай цөөн тооны якут, славянууд Монголыг зорьсон. Өнгөрсөн хугацаанд Оросын нийт 22540 иргэн Монголын хилээр оржээ. Тэдний ихэнх нь Монголоор дамжин ОХУ-ын иргэдээс виз шаарддаггүй Төв Азийн орнууд, Вьетнам, Тайланд болон Израил руу гарсан. Монголд үлдсэн оросуудын 98 хувь нь нийслэл хотод нь төвхнөжээ.¹⁸

Төв Азийн олон улсын терроризм, хил дамнасан гэмт хэргийн хүрээ өргөжин, тэдгээрийн орчин, хил хязгаар тэлж, Монгол орны эрх ашигт шууд холбоотой тус бүс нутагт байнга давтагдан гарч байгаа бөгөөд зарим нэг төрлийн гэмт хэрэг өргөжих шинжтэй байна. Төв Азийн бүс нутгийн улсуудын эдийн засгийн тарчиг, ядуу байдал, дарангуйллын дэглэм зэрэг нь исламын тэрс үзэлтнүүдийн тархалтын суурь болж, бүс нутгийг тогтворгүй болгох хүчин зүйлд тооцогдож байгаагийн дээр хар тамхины хууль бус худалдаа, хилийн маргаантай асуудал, усны нөөцийн талаарх тэмцэл, эрчим хүчний нөөцийн хуваарилалт зэрэг нь бүс нутгийг тогтворгүйжүүлэгч бусад хүчин зүйл болж байна. Түүнчлэн Афганистан хар тамхины үйлдвэрлэлээр дэлхийд нэгдүгээрт ордог ба 2017 онд 2016 онтой харьцуулахад жилийн үйлдвэрлэл 9000 тн-д хүрч, 87 хувиар өссөн¹⁹

¹⁷ <https://sonin.mn/news/culture/137598>

¹⁸ <https://www.zindaa.mn/4hh1>

¹⁹ <https://ru.wikipedia.org/wiki/Наркотик>

ба хар тамхины тариалалт 37 хувиар нэмэгдэж, хар тамхи хууль бусаар дамжин өнгөрүүлэх түшиц бүс нутаг нь Төв Азийн улс орнууд болон хувирсан.

БНСУ-ын Засгийн газрын экспортыг дэмжих арга хэрэгслүүдийг тус улсын судлаачид санхүүгийн, маркетингийн, технологийн гэж гурав ангилах нь түгээмэл. Маркетингийн дэмжлэг нь үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг гадаад зах зээлд борлуулахад чиглэгддэг. КОТРА, Солонгосын худалдааны хороо зэрэг мэргэшсэн агентлагууд нь гадаад дахь салбаруудаар дамжуулан энэ төрлийн үйлчилгээг хэрэгжүүлдэг. Технологийн дэмжлэгт үйлдвэрлэлийн технологи, инновацийг дэмжих замаар экспортыг нэмэгдүүлэхэд чиглэсэн үйлчилгээнүүдийг хамруулан авч үздэг. Туршилт судалгаа, технологи дамжуулалт, технологийн бүтээгдэхүүний худалдан авалтыг дэмжих зэрэг олон төрлийн хөтөлбөр, үйлчилгээг Технологийн баталгааны сан, Технологийн судалгааны хүрээлэн, Үйлдвэрлэлийн технологийн ассоциаци зэрэг байгууллага үйлдвэрлэгчдэд хүргэдэг. Санхүүгийн дэмжлэгт экспортын үйлдвэрлэлийг дэмжих хөнгөлөлттэй

¹ UNCTAD/DITC/TAB/2005/1

зээл, худалдааны даатгал, зээлийн баталгаа гаргах зэрэг үйлчилгээг хамруулан авч үздэг байна. Энэ төрлийн үйлчилгээ нь үйлдвэрлэгчдэд дутагдаж буй санхүүжилтийг шийдэж өгөх, мөн гадаад болон дотоод худалдаанаас үүсч болох санхүүгийн эрсдэлийг бууруулахад чиглэгддэг. Худалдааны даатгалын корпораци, Зээлийн батлан даалтын сан, Экспорт импортын банк зэрэг төрийн бодлогын хүрээнд экспортыг дэмжих санхүүгийн үйлчилгээг хэрэгжүүлдэг мэрэгшсэн байгууллагууд байдаг. Татаас болон татварын хөнгөлөлт чөлөөлөлт нь захиргааны шинжтэй нэг төрлийн санхүүгийн дэмжлэг юм. Төлөвлөлт сангийн яам, Татварын ерөнхий газар зэрэг байгууллагууд энэ төрлийн үйлчилгээг голлон хэрэгжүүлдэг.

Зураг 1. БНСУ-ын экспортыг дэмжих үндсэн аргууд

Санхүүгийн	<ul style="list-style-type: none"> • Хөнгөлөлттэй зээл • Экспортын санхүүжилт • Экспортын даатгал • Зээлийн баталгаа
Маркетингийн	<ul style="list-style-type: none"> • Судалгаа • Зуучлал • Сурталчилгаа • Сургалт
Технологийн	<ul style="list-style-type: none"> • Технологи хөгжүүлэлт • Технологийн туршилт • Технологи солилцоо • Сургалт судалгаа
Төрийн захиргааны	<ul style="list-style-type: none"> • Татвар • Татаас • Төрийн худалдан авалт • Түүхий эдийн нөөц бэлтгэх

БНСУ-ын Засгийн газар нь солонгосын дайнаас хойшхи аж үйлдвэрлэлийн хөгжлийн үе шатуудад төрийн институцийн бүтэц зохион байгуулалттай уялдуулан дээрх 3 төрлийн экспортыг дэмжихэд чиглэсэн арга хэрэгслүүдийг дагнасан, хосолсон зэрэг олон арга хэлбэрээр авч хэрэгжүүлж ирсэн байдаг. Хөнгөн үйлдвэрлэлийг дэмжиж эхэлсэн 1960-аад он нь дайны дараах санхүүгийн хямрал арилаагүй, дотоодын эдийн засаг валютын хомсдолтой байсан үе юм. Тиймээс аж үйлдвэрлэлийн хөгжлийн эхэн үеийн дийлэнх бодлого хөтөлбөрүүд нь үйлдвэрлэгчдийг санхүү, татварын механизмаар дэмжихэд чиглэж байв. Хөгжлийн тодорхой үе шатанд хүрэхтэй зэрэгцэн үйлдвэрлэгчдэд маркетингийн болон технологийн дэмжлэгийг үзүүлэх болжээ. Өнөөгийн Засгийн газар нь экспортыг дэмжих дээрх 3 төрлийн арга хэрэгслийг мэрэгшсэн агентлагуудаар дамжуулан үйлдвэрлэгчдэд шууд, мөн зорилтот хөтөлбөр хэрэгжүүлэх замаар хөнгөлөлттэй нөхцлөөр тус тус хүргэж байна. Аж үйлдвэрлэл, гадаад худалдааг хариуцсан Үйлдвэрлэл худалдаа нөөцийн яам² болон Жижиг дунд үйлдвэрлэл, гарааны бизнесийн яамд³ нь экспортыг дэмжих бодлого хөтөлбөрөө харьяа агентлагууд, орон нутгийн удирдах болон бусад олон байгууллагаар дамжуулан хэрэгжүүлж байна.

² [산업통상자원부 \(motie.go.kr\)](http://motie.go.kr)

³ [중소벤처기업부 \(mss.go.kr\)](http://mss.go.kr)

2. Аж үйлдвэрлэлийн хөгжлийн үе шатууд дахь санхүү, татварын дэмжлэг

БНСУ-ын Ерөнхийлөгчөөр ахлуулсан Эдийн засгийн төлөвлөлтийн хороо нь 1960-аад оны эхэн үеэс аж үйлдвэрлэл болон экспортыг дэмжих бодлогыг 5 жилээр төлөвлөн хэрэгжүүлж эхэлжээ. Уг цогц төлөвлөгөөнд экспортыг дэмжих санхүү, татварын зорилгот хөтөлбөрүүдийг багтаан хэрэгжүүлсэн байдаг. 1962-1992 оны хооронд харилцан уялдаатай хэрэгжүүлсэн 6 удаагийн 5 жилийн төлөвлөгөөний үр дүнд тус улсын эдийн засаг өндөр хурдацтай өссөн бөгөөд нэг хүнд ноогдох ДНБ-ий хэмжээ 1961 онд 83 ам доллар байсан бол 1992 онд 6479 ам доллар болж 80 дахин өсжээ. Мөн аж үйлдвэрлэл нь бүтцийн хувьд нэгдүгээр шатны үйлдвэрлэлээс хүнд болон химийн үйлдвэрлэлд шилжсэн. Солонгосын дайнаас хойшхи эдийн засгийн хөгжлийн түүхэн үе шатуудад төрийн бодлого зохицуулалтаар үйлдвэрлэл, экспортыг дэмжих санхүү, татварын дэмжлэгийг эрчимжүүлэх, бууруулах, зогсоох зэрэг олон хувилбараар хэрэгжүүлж иржээ. Энэхүү түүхэн өөрчлөлтийн үе шатуудыг дараах байдлаар ангилан авч үзлээ. Үүнд:

1. Хөнгөн үйлдвэрлэлийг дэмжих бодлого: 1960-1970 он
2. Хүнд болон химийн аж үйлдвэрлэлийг дэмжих бодлого: 1970-1980 он
3. Тооноос илүү чанарын өсөлтөд: 1980-аад оны сүүлээс өнөөг хүртэл

БНСУ-ын аж үйлдвэрлэлийн хөгжлийн замнал: *Өргөн хэрэглээний барааны үйлдвэрлэл → өргөн хэрэглээний барааны экспорт, завсрын бүтээгдэхүүний (үйлдвэрлэлийн процессоор дамжиж эцсийн бүтээгдэхүүн болдог төмөр, гурил зэрэг бүтээгдэхүүн) үйлдвэрлэл → завсрын бүтээгдэхүүн болон технологийн бүтээгдэхүүний экспорт*⁴.

Олон тооны хямд ажиллах хүч, Хятад, Япон, Энэтхэг, Австрали зэрэг томоохон зах зээлүүдтэй далайн тэврээр шууд холбогдох боломж бүхий газарзүйн онц таатай байршил нь экспортын хөгжилд томоохон давуу тал болж байв. Мөн хөгжлийн эхэн үед Засгийн газар нь орон нутгийн дэд бүтэц сайтай газруудад аж үйлдвэрлэлийн бүс байгуулах шийдвэр гарган, үйлдвэрлэгчдэд тухайн бүс дэх газрыг хөнгөлөлттэй үнээр олгодог байсан нь оновчтой шийдвэр байв⁵.

2.1 Хөнгөн үйлдвэрлэлийг дэмжих бодлого: 1960-1970 он

1960-аад оноос импортыг орлох өргөн хэрэглээний барааны үйлдвэрлэлийг төрийн бодлогоор дэмжиж эхэлжээ. 1965 онд торго, нэхмэл даавуу, зүймэл модон хавтан, савхи, гар урлалын бүтээгдэхүүн, шаазан эдлэл, резин бүтээгдэхүүн, радио болон цахилгаан хэрэгсэл, төмөр лааз, модон эдлэл, бэлэн хувцас зэрэг хөнгөн үйлдвэрлэлийн салбарын экспортыг төрөөс онцгойлон дэмжиж эхэлсэн. 1960-аад оны сүүлээс хөнгөн үйлдвэрлэлийн барааны экспорт, ялангуяа нэхмэл даавууны экспорт дорвитой нэмэгдэх болов. 1968 онд тус улсын нийт хөнгөн үйлдвэрлэлийн барааны экспортод эзлэх нэхмэл даавууны хэмжээ 30 орчим хувьд хүрчээ. Гадаад худалдааны бодлого нь хөнгөн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэлийг импортын ижил төрийн бараанаас өндөр тариф тогтоон хамгаалах, нөгөө талдаа уг салбарын үйлдвэрлэлд шаардлагатай түүхий эдийн импортыг чөлөөлөх бодлогыг 1967 оноос барьж эхэлжээ⁶.

⁴ [경제개발 5개년계획\(한국\) \(naver.com\)](http://naver.com)

⁵ Lee, Jaymin, "Dynamic Comparative Advantage and Korea's Industrial Policy", p. 64 in Park and Wilkinson (1995).

⁶ Yun Hwan Kim, The role of Government in export expansion in the ROK: A revisit, 1994.

Засгийн газар хөнгөн үйлдвэрийг дэмжих бодлогын хүрээнд уг салбарыг татвар болон санхүүгийн аргаар дэмжиж эхэлсэн. 1960 онд Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн тухай хуулийг баталж, 1964 оноос экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн ашгийн татварыг 80 хүртэл хувиар хөнгөлж эхлэв. 1966 онд Үндэсний татварын албыг байгуулж татварын реформ хийжээ.

1961 оноос экспортын санхүүжилтийг хөнгөн үйлдвэрлэлийн салбарт олгож эхэлжээ. Үйлдвэрлэгч нь экспортын гэрээнд үндэслэн банкнаас зээл авах замаар импортлогч талаас шилжүүлэх төлбөрийг хүлээхгүйгээр санхүүгийн асуудлаа шийдвэрлэх, үйлдвэрлэлээ хэвийн явуулахад уг үйлчилгээ тусалдаг байна. Экспортын санхүүжилт нь 1961 оноос өнөөг хүртэл хэрэгжиж буй экспортыг дэмжих санхүүгийн гол арга хэрэгслүүдийн нэг юм. Экспортын санхүүжилтийн хүү нь тухайн үеийн банкны зээлийн хүүгээс хавьгүй бага байснаараа, мөн валютын ханшийн зөрүүнээс багагүй өгөөж өгдгөөрөө үйлдвэрлэгчдэд ашигтай байв.

Засгийн газар 1969 онд үйлдвэрлэгчдийн гадаад худалдааны эрсдэлийг бууруулах зорилгоор Экспортын даатгалын тухай хуулийг баталж, Экспортын даатгалын санг байгуулснаар уг үйлчилгээ хэрэгжиж эхэлжээ. Гэвч тухайн үед экспортын даатгалын үйлчилгээний хэрэглээ тун бага байв. 1968-1972 оны хооронд нийт экспортын дүнгийн нэг хүрэхгүй хувь нь экспортын даатгалд хамрагдаж байв⁷. Мөн Засгийн газар нь хөнгөлөлттэй зээл, татаас олгох зэргээр хөнгөн үйлдвэрлэлийг дэмжиж байжээ.

2.2 Хүнд болон химийн аж үйлдвэрлэлийг дэмжих бодлого: 1970-1980 он

1970-аад оноос хүнд болон химийн үйлдвэрлэлийг төрийн бодлогоор дэмжиж эхэлсэн. Хөнгөн үйлдвэрлэл нь олон тооны ажиллах хүч шаарддаг салбар аж. Цалингийн зардлын эрчимтэй өсөлт, нэмүү өртөг бага харьцангуй бага бүтээдэг зэрэг шалтгаан нь төрөөс илүү өндөр үр өгөөжтэй аж үйлдвэрлэлийн салбарыг дэмжихэд хүргэжээ. Засгийн газар нь ган төмөр, зэвэрдэггүй метал, усан онгоц, электроник болон химийн үйлдвэрлэлийг хүнд болон химийн үйлдвэрлэлийн гол салбараар сонгон хөгжүүлсэн⁸. 1970-аад онд аж үйлдвэрлэлийн салбарын дийлэнх хувийг хөнгөн үйлдвэрлэл эзэлдэг байсан бол 2008 он гэхэд 83.5 хувийг хүнд болон химийн үйлдвэрлэл, 16.5 хувийг хөнгөн үйлдвэрлэл эзлэх болжээ⁹. Ийнхүү тус улсын эдийн засгийн гол зүтгүүр нь хүнд болон химийн аж үйлдвэрлэл болсон байна. Хүнд болон химийн аж үйлдвэрлэлийг маш өргөн хүрээнд олон төрлийн аргаар эрчимтэй дэмжжээ.

Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн тухай хуулийн дагуу 1973 оноос хүнд болон химийн аж үйлдвэрлэл эрхлэгчдийг эхний 3 жилд ашгийн татвараас бүрэн чөлөөлж, дараагийн 2 жилд 50 хувийг хөнгөлж байв. Мөн экспортын зориулалттай үйлдвэрлэлийн түүхий эдийг импортын татвараас чөлөөлөх тухай хуулийг 1975 оноос батлан хэрэгжүүлж эхэлжээ. Уг хуулинд зааснаар гадаадаас импортолсон түүхий эдийг 13 сарын дотор үйлдвэрлэлийн процессоор дамжуулан экспортод гаргасан бол импортын татварыг буцаан олгодог байв. Импортын татварын буцаан олголтын хэмжээ 1975 онд 0.1 ихнаяд вон байсан бол 1990 онд 3.2 ихнаяд вон болон нэмэгджээ. Уг хууль өнөөг хүртэл хүчинтэй хэрэгжиж байна.

Үйлдвэрлэгчдэд дотоодын болон гадаадын эх үүсвэрээр таатай нөхцөл бүхий зээл олгож байв. 1973 онд байгуулагдсан Үндэсний хөрөнгө оруулалтын сан нь дотоод санхүүгийн нөөцийг

⁷ KEIC, Annual Report and Monthly Export Insurance, various issues; K-sure, Annual Report 2009, 2010 (2010b)

⁸ [경제개발계획 \(naver.com\)](http://naver.com)

⁹ [중화학공업 \(naver.com\)](http://naver.com)

аж үйлдвэрлэлийн салбар луу чиглүүлж байв. 1960-аас 1980-аад оны сүүл хүртэл Аж үйлдвэрлэлийн банк, Эксим банк, Жижиг дунд бизнесийн банк зэрэг арилжааны банкууд төрийн мэдэлд байсан бөгөөд зээлийн хүүг төрөөс зохицуулдаг байжээ. Үйлдвэрлэл эрхлэгчдэд бага хүүтэй зээл олгохын хажуугаар зээлийн шимтгэлд ихээхэн хөнгөлөлт үзүүлж байсан. Экспортыг дэмжих зээлийн нөхцөл шалгуур нь бусад зээлтэй харьцуулахад амар, мөн зээлийн шимтгэл харьцангуй бага байсан ч зээл олгосны дараа зарцуулалтыг нарийн хянадаг байв. Зээлийн бага хүүг зарим судлаачид экспортыг дэмжих татаас гэж үзэх нь бий.

Хүснэгт 1. Экспортыг дэмжих зээлийн хүү

Он	1964	1967	1975	1977	1980	1982
Бизнесийн зээлийн хүү	14	24	15.5	16	20	10
Экспортын зээлийн хүү	8	6	7	8	12	10
Зөрүү	6	18	8.5	8	8	

Эх сурвалж: Yun Hwan Kim, The role of Government in export expansion in the ROK: A revisit, 1994.

Мөн Засгийн газар нь гадаадын банк санхүүгийн байгууллагуудаас хөнгөлөлттэй зээл, санхүүжилт авах боломжийг үйлдвэрлэл эрхлэгчдэд олгожээ. Хүнд болон химийн аж үйлдвэрлэлийг дэмжих бодлогын үндсэн хэсэг болох “Гадаадын зээлийг дэмжих журам”-ын дагуу Засгийн газраас нэр заасан тодорхой салбарын үйлдвэрлэгчид гадаадаас хөнгөлөлттэй зээл авах тохиолдолд зээлийн баталгааг Засгийн газар гаргаж өгдөг байв. Төрийн баталгаа бүхий гадаадын хөнгөлөлттэй зээлийн жилийн хүү нь дунджаар 9 хувь буюу дотоодын банкныхаас (зээлийн хүү 20 орчим хувь байсан) хавьгүй бага, эргэн төлөх хугацаа урт байсан нь үйлдвэрлэгчдэд үлэмж давуу тал олгожээ. Хөтөлбөрт хамрагдсан компани нь зээлийн гэрээний нарийвчилсан нөхцөл болон зарцуулалтаа Засгийн газарт тайлагнадаг, Засгийн газар нь эргээд хяналт тавьдаг журамтай байв. Хүнд болон химийн аж үйлдвэрлэлийг гадаадын хөнгөлөлттэй зээлээр дэмжих бодлогод хийсэн Чой Жэду, А.Левченко нарын судалгаагаар уг зээлд хамрагдсан компаниудын дараагийн 30 жилийн борлуулалт нь хамрагдаагүй компаниудтай харьцуулахад үлэмж өндөр дүнтэй гарсан байна¹⁰.

Экспортын санхүүжилтийг хэрэгжүүлдэг мэрэгшсэн байгууллага болох Эксим банк 1976 онд, Зээлийн батлан даалтын сан 1974 онд тус тус байгуулагджээ. Зээлийн батлан даалтын сангаас¹¹ гаргасан баталгаанд үндэслэн Эксим банк¹² нь экспортын санхүүжилтийг олгож иржээ. Ийнхүү экспортын санхүүжилтийн үйлчилгээ нь Хүнд болон химийн аж үйлдвэрлэлийг дэмжих бодлоготой зэрэгцэн мэргэжлийн түвшинд хүрч, илүү өргөн хүрээг хамрах болжээ. Экспортын санхүүжилтийн маш бага хэмжээтэй хүү нь 1960-1980 оны хооронд экспортлогчдод асар өндөр өгөөжтэй байв¹³.

Экспортын даатгал нь үйлдвэрлэгчдийн гадаад худалдааны эрсдэлийг бууруулах нэг төрлийн арга хэрэгсэл байсан боловч хамрагдагсдын тоо дорвитой нэмэгдэхгүй байв. 1968-1990 онуудад нийт экспортын 4 хүрэхгүй хувь нь даатгалд хамрагдаж байжээ.

¹⁰ Jaedo Choi, Andrei A. Levchenko, The long-term effects of industrial policy, NBER Working paper 29263, 2022.

¹¹ [신용보증기금 \(kodit.co.kr\)](http://kodit.co.kr)

¹² [Home : Korea Eximbank](http://www.kodit.co.kr)

¹³ Mah, Jai S., “Export Promotion and Economic Development of Korea”, Journal of World Trade, February 2006.

2.3 Тооноос илүү чанарын өсөлтөд: 1980-аад оны сүүлээс өнөөг хүртэл

Санхүүгийн хэт өргөн хүрээний дэмжлэг, мөн эдийн засаг дахь төрийн оролцоо өндөр байснаас үүдэн 1980-аад оны эхээс аж үйлдвэрлэлийн салбарын үр ашиг буурч эхэлжээ. Үүнд мөн газрын тосны хоёрдахь удаагийн хямрал ч нөлөө үзүүлсэн. Аж үйлдвэрлэлийн салбарын өндөр алдагдал болон бүтээмж бууралт, их хэмжээний гадаад валютын өр зэрэг нь тус улс бүтцийн өөрчлөлт хийх үндсэн шалтгаан болжээ. 1980-аад оны дундаас гадаад худалдааг чөлөөлөх, эдийн засаг дахь төрийн оролцоог бууруулж либералчлах замаар санхүүгийн нөөц чөлөөтэй хөрвөх боломжийг бий болгох бодлого барих болжээ¹⁴. Энэ хүрээнд аж үйлдвэрлэлийн салбарт олгож байсан таатай нөхцөл бүхий зээлийг зогсоох, гадаад худалдааны тарифыг бууруулах, дотоод зах зээлд дэх мөнгөний нийлүүлэлтийг бууруулах зэрэг хэд хэдэг чухал алхам хийсэн. Бодлогын хүрээнд арилжааны 5 банкыг хувьчилж, гадаадын банк санхүүгийн байгууллага дотоод зах зээлд нэвтрэх боломжийг нээж өгчээ. Улмаар газрын тосны хямралын нөлөө арилж, долларын ханш тогтворжиж, инфляци буурахтай зэрэгцэн 1980-аад оны сүүлээс тус улсын гадаад худалдааны тэнцэл өндөр ашигтай гарч, эдийн засаг эрчимтэй өсч эхэлсэн. Энэ үеэс БНСУ-ын Засгийн газар эдийн засгийг төрөлжүүлэх, тооноос илүү чанарыг дэмжих үүднээс тоног төхөөрөмжийн болон ур чадварын экспортод (хилийн чанадад томоохон бүтээн байгуулалтын төсөл зэрэг) түлхүү анхаарч эхэлсэн.

1970-аад оны дундаас хэрэгжүүлсэн Хүнд болон химийн аж үйлдвэрлэлийг дэмжих бодлого, Төвлөрсөн худалдаа эрхлэгч зэрэг хөтөлбөр нь үндэсний томоохон үйлдвэрлэгчдийг далайцтай дэмжсэний дүнд Самсунг, Хёндэ зэрэг томоохон корпорацууд дэлхийн хэмжээний үйлдвэрлэгч болж тус улсын эдийн засгийн гол зүтгүүр болсон¹⁵. Гэвч нөгөө талаар жижиг дунд үйлдвэрлэл (ЖДҮ) эрхлэгчид зах зээлээс шахагдах, орлого тэгш бусаар хуваарилагдах зэрэг сөрөг үр дагаварууд гарах болсон учир Засгийн газар 1990-ээд оны сүүлээс нийгэм эдийн засгийн тэнцвэрийг хангах үүднээс уг салбарыг бодлогоор дэмжих болсон. Энэ үүднээс Үйлдвэрлэл худалдаа, нөөцийн яамны жижиг дунд үйлдвэрлэл хариуцсан газрыг 2017 оноос Жижиг дунд үйлдвэр, гарааны бизнесийн яам болгон дэвжүүлжээ. Өнөө цагийн экспортыг дэмжих бодлого хөтөлбөрүүд нь экспорт хийдгүй ЖДҮ эрхлэгчдийг экспортлогч болгох, экспорт хийдэг ЖДҮ эрхлэгчдийн экспортын потенциалыг дээшлүүлэхэд чиглэж байна. Мөн улс орны эдийн засгийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх үүднээс шинэ технологи, инноваци бүхий гарааны бизнес, мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих болжээ.

Тус улсын өнөөгийн экспортыг дэмжих санхүүгийн дийлэнх арга хэрэгслүүд нь ЖДҮ эрхлэгчдийг бойжуулахад чиглэж байна. Тухайлбал Жижиг дунд үйлдвэр, гарааны бизнесийн яам нь 2023 онд 4,2 их наяд воны бодлогын санхүүжилт зарласан¹⁶. Бодлогын санхүүжилтийн хүү нь төв банкны бодлогын хүүгээс бага байдаг онцлогтой. Энэхүү онцгой хөнгөлөлттэй нөхцөл бүхий зээлд хамрагдах хүсэлтэй аж ахуйн нэгжүүд (ААН) олон байдаг. Тиймээс зээлийн нөхцөл шалгуураар дамжуулан Засгийн газраас зарим төрлийн дэмжлэг, хязгаарлалтын зохицуулалт хийх нь түгээмэл. Тухайлбал 2023 онд эрчим хүчний өндөр хэмнэлттэй, хорт хаягдал бага ялгаруулдаг үйлдвэрлэлийг маш бага хүүтэй зээлээр дэмжсэн.

2009 оноос Зээлийн батлан даалтын сан нь жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн экспортын зориулалтаар арилжааны банкнаас авах зээлд баталгаа гаргаж эхэлжээ. Уг байгууллага нь ЖДҮ эрхлэгчдийн экспортын гэрээ, шинэ технологи, өсөх ирээдүйтэй бизнес төлөвлөгөө

¹⁴ Yun Hwan Kim, The role of Government in export expansion in the ROK: A revisit, 1994.

¹⁵ Д.Мягмар, БНСУ-ын Засгийн газраас үндэсний үйлдвэрлэл, экспортоо дэмжиж буй хэлбэрүүд, Олон улс судлал сэтгүүл, №115, х.48-62, 2023 он.

¹⁶ [중소벤처기업진흥공단 \(kosmes.or.kr\)](https://kosmes.or.kr)

зэрэгт үндэслэн зээлийн баталгаа (зээл авах эрх) гаргаж өгдөг. Энэ нь барьцаа хөрөнгөгүй ААН-үүдэд үйлдвэрлэлээ тасралтгүй явуулах боломж олгох бөгөөд, шинээр эхэлж буй бизнест эргэлтийн хөрөнгө болж өгдөг байна. Хүсэлт гаргасан ААН-ийн бодит үнэ цэн, санхүүгийн чадвар, технологийн түвшин, бизнесийн ирээдүй, хүний нөөцийн чадвар зэргийг үнэлж, зээлжих зэрэглэлийг тогтоосны үндсэн дээр зээлийн баталгаа гаргадаг. ААН нь зээлийн баталгаанд үндэслэн арилжааны банкнаас зээл авч үйлдвэрлэлээ хэвийн явуулах боломж бүрддэг байна. 2023 оны 3 дугаар улирлын байдлаар тус байгууллага 10.000 ААН-ийн 4 их наяд воны зээлд баталгаа гаргажээ¹⁷.

Экспортын даатгалын үйлчилгээ 1990-ээд оноос дорвитой нэмэгджээ. БНСУ дэлхийн худалдааны байгууллагад элсэж гадаад худалдаа тус улсын хувьд харьцангуй нээлттэй болохын өмнө буюу 1992 онд Засгийн газраас үйлдвэрлэгчдийн гадаад худалдааны эрсдэлийг бууруулж, худалдааны даатгалын үйлчилгээг өргөжүүлэх үүднээс төрийн өмчит Худалдааны даатгалын корпорацийг байгуулжээ¹⁸. Ийнхүү гадаад худалдаанаас үүдэн гарах үйлдвэрлэгчдийн өндөр эрсдэлийг төр үүрэх болов. Тухайлбал даатгалын үйлчилгээний алдагдал 1992-1994 онд 187%, 2003-2004 онд 325% хүрч байв.

Хүснэгт 2. БНСУ-ын худалдааны даатгалын мэдээлэл

years	export values (A)	insured amount (B)	premium received (C)	claims paid (D)	recoveries (E)	utilization ratio (B/A:%)	loss ratio (D/C:%)
1974-1976	182.5	1.5	0.01	0.01	0.00	0.8	41.4
1983-1985	1,053.9	42.5	0.28	0.06	0.01	4.0	22.1
1989-1991	2,115.2	49.6	0.14	1.55	0.02	2.3	1,082.9
1992-1994	2,705.8	118.2	0.77	1.45	0.11	4.4	187.9
2003-2004	4,481.2	970.4	2.12	6.90	1.75	21.7	325.2
2008-2009	8,065.0	2,444.1	5.94	7.14	2.57	30.3	122.2

Эх сурвалж: Mah, Jai S., "Export Promotion and Economic Development of Korea", *Journal of World Trade*, February 2006.

1968-1990 онуудад нийт экспортын 4 хүрэхгүй хувь нь даатгалд хамрагдаж байсан бол Худалдааны даатгалын корпораци байгуулагдсанаас хойш энэ тоо өсч 2009 он гэхэд 30 хувьд хүрчээ. Уг байгууллага өнөөгийн байдлаар нь экспортын даатгал, импортын даатгал, валютын ханшийн өөрчлөлтийн эрсдлээс сэргийлэх даатгал, хөрөнгө оруулалтын эрсдлийн даатгалаас гадна хамтран ажиллахаар зорьж буйг гадаад компанийн санхүүгийн чадварыг судлах зэрэг үйлчилгээг үйлдвэрлэгчдэд үзүүлж байна. Тус байгууллага 2022 онд 238 ихнаяд воны худалдаанд даатгалын үйлчилгээ үзүүлжээ¹⁹.

Эдийн засгийн огцом өсөлтөөс үүдэн экспортод чиглэсэн үйлдвэрлэлд үзүүлж ирсэн татварын ялгавартай дэмжлэгээ 1990-ээд оноос огцом бууруулжээ. 1995 оноос тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл болон энэ чиглэлийн судалгаа хөгжүүлэлтийг татвараар дэмжиж

¹⁷ [문서뷰어 \(kodit.co.kr\)](http://kodit.co.kr)

¹⁸ [한국무역보험공사 \(ksure.or.kr\)](http://ksure.or.kr)

¹⁹ [Annual Report 2022.pdf](#)

эхлэв. 2005 оноос эдийн засгийн чөлөөт бүс дэх гадаадын хөрөнгө оруулалттай үйлдвэрлэгчдийг эхний 10 жилд орлого болон ашгийн татвараас чөлөөлөх болов²⁰. Өнөө цагт БНСУ-д үйлдвэрлэгчдийг аливаа нэг татвараас бүрэн чөлөөлөх явдал үгүй болсон боловч Татварын тусгай хуулийн /조세특례제한법/ дагуу үйлдвэрлэгчдэд татварын хөнгөлөлт үзүүлж байна. Уг хуулийн дийлэнх зүйл заалт нь ЖДҮ эрхлэгчдийг дэмжихэд чиглэдэг. Тухайн аж ахуйн нэгж ЖДҮ эрхлэгчийн ангилалд хамрагдах эсэхийг тодорхойлсны үндсэн дээр шалгуур хангасан компанид Татварын ерөнхий газраас²¹ холбогдох хөнгөлөлтийг үзүүлдэг байна.

Татварын тусгай хуульд ЖДҮ эрхлэгчдийг орлогын болон хуулийн этгээдийн албан татвараас хөнгөлөх нөхцлүүдийг тусгаж өгчээ. Тухайлбал шинээр үүсгэн байгуулагдсан цагаас хойш 5 жилийн хугацаанд орлого олоогүй ААН-ийг орлого олж эхэлсэн цагаас эхлэн 4 жилийн турш орлогын татварыг 50 хувь хөнгөлдөг байна²².

Уг хууль хувь хүн болон ААН-ийн технологийн судалгаа, хөгжүүлэлтийг 3 үндсэн хэлбэрээр татвараар дэмждэг. Эхний хэсэг болох энгийн технологийг дэмжих журмын дагуу шинээр зохиож патентжуулсан, мөн зохих журмын дагуу бусдаас дамжуулж авсан технологийг ашиглан үйлдвэрлэл эрхэлж олсон орлогын татварыг ЖДҮ эрхлэгчид 50 хүртэл, том үйлдвэрлэгчид 40 хүртэл, корпорацид 25 хүртэл хувиар тус тус хөнгөлдөг байна. Хоёрдахь буюу орчин үеийн дэвшилтэт технологийг дэмжих журмын дагуу хиймэл оюун ухаан, эрүүл мэнд, эрчим хүч, байгаль орчин гэх мэт 14 салбарын 270 төрлийн технологийн үйлдвэрлэлд, гуравдахь буюу Засгийн газраас заасан стратегийн технологийг дэмжих журамд хагас дамжуулагч, батерей, вакцин, хавтгай дэлгэц зэрэг 7 салбарын 66 төрлийн технологийн үйлдвэрлэлд тус тус татварын хөнгөлөлт үзүүлж байна²³.

Орон нутгийн татварын тусгай хуулийн дагуу хүн амын нягтрал багатай орон нутагт бүртгүүлсэн ЖДҮ эрхлэгч нь үүсгэн байгуулагдсан цагаас хойш 4 жилийн дотор худалдан авсан бизнесийн зориулалттай хөрөнгийн худалдан авалтын татварыг 75 хувь, 3 жилийн дотор хөрөнгийн татварыг 50 хувь тус тус хөнгөлдөг байна.

Экспортын зориулалттай түүхий эдийн импортын татварыг буцаан олгох тухай хууль²⁴ нь өнөөгийн байдлаар хүчинтэй үйлчилж байна. Уг хуулинд физик, химийн урвалын үр дүнд бүтэц найрлага, хэв шинж нь өөрчлөгдөн экспортын бүтээгдэхүүнд орсон бүх төрлийн түүхий эд, экспортын тоног төхөөрөмжид орсон түүхий эд, тэдгээрийн сав баглаа боодол зэргийн импортын татварыг буцаан олгож байна.

²⁰ Finance Forum, “Updating the Tax Regulations”, Korea Institute for Public Finance: Seoul, 2003.

²¹ [국세청 \(nts.go.kr\)](http://nts.go.kr)

²² [조세특례제한법 \(law.go.kr\)](http://law.go.kr)

²³ [조세특례제한법시행령 \(law.go.kr\)](http://law.go.kr)

²⁴ [수출용 원재료에 대한 관세 등 환급에 관한 특례법 | 국가법령정보센터 | 법령 > 본문 \(law.go.kr\)](http://law.go.kr)

Дүгнэлт

БНСУ 1960-аад оноос өнөөг хүртэл экспортод чиглэсэн аж үйлдвэрлэлийг тууштай дэмжин өндөр амжилт олсон. Энэ хугацаанд Татварын алба, Эксим банк, Зээлийн баглан даалтын сан, Худалдааны даатгалын корпорац, Худалдаа хөрөнгө оруулалтын агентлаг зэрэг төрийн бодлого хэрэгжүүлэх үүрэгтэй мэргэшсэн агентлагуудыг үүсгэн байгуулах замаар экспортыг дэмжих хүчирхэг тогтолцоог бүрдүүлжээ. Эдгээр агентлагууд нь Засгийн газрын хувьд төлөвлөсөн бодлого хөтөлбөрөө хэрэгжүүлэх үндсэн хэрэгсэл болж байгаа бол үйлдвэрлэгчдийн хувьд экспорт хийхэд тулгардаг саад бэрхшээлийг хөнгөвчлөх механизм болж байна. Эдгээр агентлагуудаар дамжуулан зээлийн баталгаа, худалдааны даатгал, экспортын санхүүжилт, татварын хөнгөлөлт, чөлөөлөлт, буцаан олголт зэрэг арга хэрэгслүүдийг экспортыг дэмжих хөшүүрэг болгон туйлын үр ашигтай хэрэгжүүлж иржээ. Тус улсын аж үйлдвэрлэл, экспортыг дэмжих бодлого хөтөлбөрүүд амжилт олоход дараах хэдэн хүчин зүйл голлох нөлөө үзүүлжээ. Үүнд:

1. Тууштай байдал: 1960-аад оноос өнөөг хүртэл олон засгийн газар солигдсон ч экспортыг дэмжих үндсэн зорилгоо өөрчлөөгүй. Экспортыг дэмжих зорилгоор үүсгэн байгуулсан хэрэгжүүлэгч байгууллагуудыг татан буулгалгүй, чиг үүргийг өөрчлөлгүй өнөөг хүрсэн нь үүний илрэл юм.
2. Мэргэшил: Яам болон хэрэгжүүлэгч агентлагууд олон жил нэг чиглэлээр тууштай, тогтвортой ажилласны үр дүнд асар их мэдлэг, туршлага хуримтлуулсан. Салбартаа мэргэшсэн, туршлага асар их туршлага бүхий байгууллагууд нь тус улсын экспортыг дэмжих хүчирхэг тогтолцооны гол зүтгүүр болжээ.
3. Эрсдэл үүрэх: Төрөөс үйлдвэрлэгчдэд экспорт хийх боломж бүрдүүлж өгөхийн тулд зарим төрлийн эрсдэлийг үүрч ирсэн. Тухайлбал үйлдвэрлэгчдийн гадаад худалдааны эрсдэлийг бууруулах үүднээс өндөр алдагдал бүхий худалдааны даатгалыг төр хариуцжээ. Мөн үйлдвэрлэгчдийн гадаад эх үүсвэрээс авсан өндөр дүнтэй зээлийн баталгааг төр хариуцаж байв.
4. Уян хатан бодлого: Засгийн газар нь цаг үетэйгээ нийцүүлэн уян хатан, ухаалаг, ирээдүйг харсан бодлого хэрэгжүүлж иржээ. Тухайлбал 1960-аад онд олон тооны хямд ажиллах хүчинд тулгуурлан хөнгөн үйлдвэрлэлийг дэмжсэн нь ирээдүйн хөгжлийн үндэс болсон. 1970 оноос цаг үеийн шаардлагаар өндөр бүтээмж бүхий хүнд болон химийн аж үйлдвэрлэлийг дэмжсэн нь оновчтой шийдвэр болсон. Эдийн засгийг төрөлжүүлж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор 1980-аад оноос технологи, инноваци хөгжүүлэлтэд анхаарах болсон нь мөн л цагаа олсон шийдвэр байв.

Эх сурвалж

1. Lee, Jaymin, “Dynamic Comparative Advantage and Korea’s Industrial Policy”, p. 64 in Park and Wilkinson (1995).
2. [경제개발 5개년계획\(한국\) \(naver.com\)](#)
3. KEIC, Annual Report and Monthly Export Insurance, various issues; K-sure, Annual Report 2009, 2010 (2010b)
4. [경제개발계획 \(naver.com\)](#)
5. [중화학공업 \(naver.com\)](#)
6. Д.Мягмар, “БНСУ-ын Засгийн газраас үндэсний үйлдвэрлэл, экспортоо дэмжиж буй хэлбэрүүд”, х.50-51, Олон улс судлал сэтгүүл, №16, 2023 он.
7. Jaedo Choi, Andrei A. Levchenko, The long-term effects of industrial policy, NBER Working paper 29263, 2022.
8. [Home : Korea Eximbank](#)
9. [신용보증기금 \(kodit.co.kr\)](#)
10. Yun Hwan Kim, The role of Government in export expansion in the ROK: A revisit, 1994.
11. Mah, Jai S., “Export Promotion and Economic Development of Korea”, Journal of World Trade, February 2006.
12. Finance Forum, “Updating the Tax Regulations”, Korea Institute for Public Finance: Seoul, 2003.
13. [한국무역보험공사 \(ksure.or.kr\)](#)
14. [중소벤처기업진흥공단 \(kosmes.or.kr\)](#)
15. [문서뷰어 \(kodit.co.kr\)](#)
16. [Annual_Report_2022.pdf](#)
17. [국세청 \(nts.go.kr\)](#)
18. [조세특례제한법 \(law.go.kr\)](#)

SPSIRPA FORUM 2024

Session 6-4

International exchange and cooperation in higher education within the framework of China-Mongolia comprehensive strategic partnership: policy, practice, and achieved results



Хятад, Монголын иж бүрэн стратегийн түншлэлийн хүрээн дэх дээд боловсролын олон улсын харилцаа, хамтын ажиллагааны судалгаа

Яруу, ӨМИС- Монгол Улс Судлалын Хүрээлэн

Abstract: The year 2024 marks the 10th anniversary of the establishment of the comprehensive strategic partnership between China and Mongolia, the 75th anniversary of the establishment of diplomatic relations between China and Mongolia, and the 30th anniversary of the signing of the Treaty of Amity and Cooperation between the two countries. Recently, bilateral relations between China and Mongolia have markedly improved, characterized by enhanced political trust, increased economic and trade exchanges, and strengthened cooperation in education, tourism, and science and technology. In the realm of education, international exchanges and cooperation in higher education between China and Mongolia hold a prominent position, playing a crucial role in fostering amicable bilateral relations. As the China-Mongolia comprehensive strategic partnership has deepened, international exchanges and cooperation in higher education have achieved noteworthy progress. However, these advancements are accompanied by certain challenges and issues. Looking forward, it is essential for both countries to enhance policy communication, expand areas of cooperation, and establish a robust long-term mechanism to further international exchanges and cooperation in higher education. These efforts are imperative for sustaining and advancing the friendly development of China-Mongolia relations.

Keywords: China-Mongolia Comprehensive Strategic Partnership; Higher Education, International Exchange and Cooperation

Энэ жил бол Хятад, Монгол хоёр улсын иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаа тогтоосны 10 жилийн ой, мөн ч Хятад, Монгол хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 75 жилийн ой болон хоёрлсын найрамдалт хамтын ажиллагааны гэрээ байгуулсны 30 жилийн ой тохиосон жил болно. Хятад, Монгол хоёр улсын иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаа тогтоосноос хойш хоёр улсын улс төрийн харилцан итгэлцэл тасралтгүй бэхжиж, эдийн засаг, худалдааны хэлхээ холбоо улам бүр нэмэгдэж, боловсрол, аялал жуулчлал, шинжлэх ухаан технологи болон бусад салбарын харилцаа ч цаашид бэхжиж байна. Боловсролын салбарт Хятад, Монгол хоёр улсын дээд боловсролын олон улсын харилцаа, хамтын ажиллагаа чухал байр суурь эзэлдэг бөгөөд Хятад, Монголын харилцааны найрсаг хөгжилд орлуулахын аргагүй үүрэг гүйцэтгэж байна. Үүний зэрэгцээ, дээд боловсрол бол үндэсний зөөлөн хүчийг дээшлүүлэх чухал арга зам мөн. Дээд боловсрол нь чадвартныг хүмүүжүүлэх, шинжлэх ухаан технологийн инноваци хийх болон нийгмийн үйлчилгээ зэрэг чадамжаар дамжуулан үндэсний зөөлөн хүчний дээшлэхийг шууд нөлөөлөх төдийгүй олон улсжсан сургалт, олон улстай санаа нэгдсэн шинжлэх ухааны салбарын мэргэжлийн байршуулалт, олон улсжсан чадвартныг бэлтгэх загвар зэрэг олон улсын харилцаа, хамтын ажиллагааны арга хэмжээгээр дамжуулан үндэсний зөөлөн хүчийг дамаар дээшлүүлдэг. Энэхүү өгүүлэлд Хятад Монгол хоёр улсын хооронд иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаа тогтоосноос хойших Хятадын дээд боловсролыг гадагш нээсэн бодлогыг эргэцүүлэн цэгцэлж, олон

улсын солилцоо, хамтын ажиллагааны практик болон үр дүнг хураангуйлсан болно. Үүний үндсэн дээр Хятад, Монгол хоёр улсын дээд боловсролын олон улсын харилцаа, хамтын ажиллагаанд тулгамдаж буй асуудлууд, цаашдын хөгжлийн гарцын талаар шинжлэн судлав.

Нэг. Хятад улсын дээд боловсролын гадагш нээлтийн бодлого

Хятадын дээд боловсролын гадагш нээлтийн бодлого тасралтгүй ахиж, нээлтийн хүрээгээ тэлүүлж, харилцаа, хамтын ажиллагааг эрчимжүүлж, гадаад оюутан бэлтгэх орчныг шилдэгжүүлэх зэрэг талаар холбогдох бодлого боловсруулан гаргажээ. 2016 оны 4-р сард, Хятадын Коммунист Намын Төв Хорооны Хэрэг эрхлэх газар, Төрийн Зөвлөлийн Хэрэг эрхлэх газраас хэвлэн нийтэлсэн "Шинэ эриний боловсролы гадагш нээх ажлыг сайтар хийх тухай саналууд"-ад гадаадын оюутан бэлтгэх ажлыг түргэн хөгжүүлж, гадаадын оюутан бэлтгэх боловсролын чанарыг дээшлүүлж, боловсролын салбарын хамтран ажиллаж хамтдаа хожихыг ахиулах тухай дурджээ. 7-р сард, Боловсролын яамнаас "Бүс ба Зам"-ыг хамтаар бүтээн байгуулах боловсролын компани ажиллагаа"-г хэвлэн нийтэлж, боловсролыг харилцан холбож харилцан нэвтрэлцүүлж, чадвартан хүмүүжүүлж бэлтгэх механизм болон загварыг хайж, боловсролын хамтын ажиллагаа, харилцааны өргөн хийгээд гүний хэмжээг нэмэгдүүлж, боловсролын хамтын ажиллагаа, харилцааны чанар болон үр ашгийг дээшлүүлэхэд шинэ алхам алхсан байна.

2017 онд Хятадын Засгийн газар "Хятад болон гадаад орнуудын хүмүүнлэгийн солилцооны ажлыг эрчимжүүлж, сайжруулах тахай саналууд"-ыг хэвлэн нийтэлсэн нь хүмүүнлэгийн солилцооны ажлыг өрнүүлж гүнзгийн сайтар хийх талаар үйл ажиллагааны бодитой заалт болсон байна. Мөн жилд, Хятад, Монгол хоёр тал "БНХАУ-ын Боловсролын яам болон Монгол Улсын Боловсрол шинжлэх ухаан технологи спортын яамны 2018—2021 оны боловсролын харилцаа, хамтын ажиллагааг хэрэгжүүлэх төлөвлөгөө"-нд гарын үсэг зурав.

2018 оны 9-р сард, Боловсролын яамнаас "Хятадад суралцах гадаадын оюутнуудын дээд боловсролын чанарын стандарт (туршин хэрэгжүүлэх)"-ыг хэвлэл нийтэлсэн бөгөөд энэ нь Хятадад суралцах гадаадын оюутнуудад зориулсан боловсролын стандартыг тусгайлан боловсруулж, их дээд сургуулиудын гадаадын оюутнуудад хүртээх боловсролын үндсэн хэм хэмжээ болж, Хятадад ирж суралцах гадаадын оюутнуудын боловсролын чанарын баталгааны системийн бүтээн байгуулалтад суурь тавьж өгсөн байна. 11-р сард, Боловсролын яамнаас дээд сургуулиуд шинжлэх ухаан технологийн инновац хийж "Бүс ба Зам"-д үйлчлэх санаачилгын үйл ажиллагааны төлөвлөгөө"-г хэвлэн нийтэлсэн нь "Бүс ба Зам"-ыг хамтаар бүтээн байгуулах боловсролын компани үйл ажиллагааг ахиулах зорилготой юм.

2019 оны 2-р сард, ХКН-ын Төв хороо, Төрийн зөвлөлөөс "Хятадын боловсролын орчин үежилт 2035"-ыг хэвлэн нийтэлж, "Боловсролыг гадагш нээх шинэ нөхцөл байдлыг бий болгох"-ыг боловсролын орчин үежилтийн стратегийн үүргийн нэг болгож, "Хүн төрөлхтний хувь заяаны цогц нэгдлийн" өртгийн ойлголтыг цаашид санаачилсан байна. 2020 оны 6-р сард, Боловсролын яам зэрэг 8 байгууллага хамтран "Шинэ эриний боловсролын гадагш нээлтийг түргэсгэж өргөжүүлэх тухай санал"-ыг хэвлэн нийтэлж, гадаад, дотоодыг нэгтгэн төлөвлөж, чанар, үр өгөөжийг дээшлүүлж, санаачилгатай манлайлан, эмх цэгцтэй нээлт хийж, шинэ эриний боловсролын гадаад нээлтийг голчлон тохируулав. Уг баримт бичгийг брорвсруулсан нь Хятадын гадаад ертөнцөд нээлттэй байхыг тууштай баримталж, "Бүс ба Зам" санаачилгын дагуу боловсролын олон улсын харилцаа, хамтын ажиллагааг тогтвортой хөгжүүлэхэд үр дүнтэй дэмжлэг үзүүлж байгааг харуулж байна.

2023 оны 4-р сард, Боловсролын яам болон Хайнань мужийн Ардын засгийн газар хамтран "Хилийн чанадын дээд боловсролын байгууллагууд Хайнаний чөлөөт худалдааны боомтод сургууль

эрхлэх түр хэрэгжүүлэх заалт"-ыг хэвлэн нийтэлж, хилийн чанад дахь дээд боловсролын байгууллагуудын үйл ажиллагаа явуулах үндсэн дүрмийг системтэй боловсруулж, хилийн чанадын дээд боловсролын байгууллагууд Хятадын нутаг дэвсгэрт сургалт эрхлэхэд нээлттэй болж, Хятады дээд боловсролын гадагш гээлттэй бодлого, арга хэмжээ тасралтгүй боловсронгуй болж байгаагийн илрэл боллоо.

Хоёр. Хятад, Монголын дээд боловсролын олон улсын хамтын ажиллагааны практик

(1) Гадаадын оюутан бэлтгэх

Өнөөгийн Хятад, Монгол хоёр улсын дээд боловсролын олон улсын харилцаа, хамтын ажиллагаанд гадаадын оюутнуудыг бэлтгэх нь гарцаагүй нэгэн чухал агуулга болж байна. Гадаадын оюутнуудын солилцоо нь хоёр орны боловсролын салбарын хамтын ажиллагааны үр дүн төдийгүй хоёр орны ард түмэнд гүн найрамдал тогтоох, бие биенийхээ соёлыг ойлгох гүүр болж байна. 2015 оноос хойш, Хятадад суралцаж буй Монгол Улсын оюутны тоо нэмэгдэх хандлагатай болов. 2018 онд энэ тоо 10 мянгыг давжээ (Зураг1). Үүний зэрэгцээ 2018 онд Хятад улс Азийн хамгийн том гадаадын оюутны суралцах улс болсон.¹ БНХАУ-ын Засгийн газрын Монгол Улсад олгох тэтгэлгээс гадна зарим орон нутгийн засгийн газрын тэтгэлгийг бий болгосон. Тухайлбал, Эрээн хот 2016 онд Эрээн хотын Засгийн газрын тэтгэлгийг бий болгож, гурван жилийн хугацаанд Монгол Улсын 1000 оюутныг элсүүлсэн; 2024 онд ӨМӨЗО-ны Засгийн газрын тэтгэлэг олгох оюутны тоог 150 байснаас 200 болгон нэмэгдүүлэв. Хятадад суралцаж буй Монгол Улсын оюутнуудын газарзүйн байршлаас харахад нөд болон умардынөм их дээд сургуулиудад хамрагдаж байгаа ба Өвөр монголын их сургууль Монгол Улсын оюутныг хамгийн олон хүлээн авдаг их сургууль болов.

Зураг 1



Эх сурвалж: Хятадын боловсролын яам: (moe.gov.cn).

Мөн 2015 оноос 2023 он хүртэлх хугацаанд Монгол Улсад суралцаж буй Хятадын оюутнуудын тоо өсөх хандлагатай байна. Монгол дахь гадаад оюутнуудын дийлэнх хувийг Хятадын оюутнууд эзэлж, нэгдүгээр байр эзэлж байгаа бөгөөд 2015 оныг 2023 онтой харьцуулахад өсөх хандлага илт ажиглагдаж байна (Зураг 2).

Зураг 2

¹ ХКН-ын XVIII их хурлаас хойших гадаадын оюутны ажлын байдлын танилцуулга—БНХАУ-ын Боловсролын яамны засгийн газрын вэбсайт (moe.gov.cn)



Эх сурвалж: Монгол улсын Боловсрол, шинжлэх ухааны яам;

https://www.meds.gov.mn/posts?category_id=11403

Хятад, Монголын дээд боловсролын үндэсний харилцаа, хамтын ажиллагаанд гадаадад суралцагчдын тоо эрс нэмэгдэж байгаа нь хоёр орны иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаа тасралтгүй гүнзгийрч байгаатай шууд холбоотой. Ийм байдал бий болсон нь хоёр орны улс төр, эдийн засаг, соёл болон бусад салбарт гүнзгийрүүлсэн харилцаа, хамтын ажиллагаа өрнүүлсэнтэй холбоотой бөгөөд энэ нь гадаад оюутан солилцох илүү боломж, нөхцөл бүрдэж байгааг харуулж байна. Үүний зэрэгцээ хоёр орны засгийн газар, их дээд сургуулиуд харилцан оюутан томилох ажлыг идэвхтэй дэмжиж, гадаадын оюутнуудад илүү их дэмжлэг ба баталгаа хангаж, гадаадын оюутсан хоёр улсын хоорондын урсгалд илүү их тус дөхөм ба тохь тухтай болгожээ.

(2) Эрдэм шинжилгээний харилцаа, хамтын ажиллагаа

Хятад, Монгол хоёр орон дээд боловсролын салбарын хамтын ажиллагаа, эрдэм шинжилгээний харилцаа, хамтын ажиллагааны гүн гүнзгий түүхэн улбаатай, хоёр улс өнгөрсөн 10 жилд хоорондын эрдэм шинжилгээний харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэхээр хүчлэн чармайснаар мэдэгдэм амжилтад хүрчээ. Талууд харилцан багш солилцохоос гадна газар дээр нь сургалт хийж, эрдэм шинжилгээний ажил өрнүүлж, хамтарсан судалгааны төслүүдийг идэвхтэй хэрэгжүүлж, судалгааны үр дүнг хуваалцаж, улмаар хоёр орны эрдэм шинжилгээний ажлын хөгжлийг ахиулсан байна. Үүнээс гадна эрдэм шинжилгээний хурал зохиони байгуулж, хоёр талын эрдэмтдэд солилцоо хийж суралцах платформ хангаж, эрдэм шинжилгээний хайлцаа, хамтын ажиллагааг цаашид ахиуллаа.

Сүүлийн жилүүдэд Монголын орон нутгийн их дээд сургуулиуд болон зарим хувийн их дээд сургуулиуд Хятадын их дээд сургуулиудтай эрдэм шинжилгээний харилцаа, хамтын ажиллагааг идэвхтэй өрнүүлж байна. Тухайлбал, 2024 оны 1-р сард Хөх хотын үндэстний дээд сургууль нь МУИС-ийн Ховд дахь салбар сургуультай хамтран ажиллах гэрээ байгуулсан; 2023 оны 9-р сард Өвөр Монголын Хүндэ Нийгмийн шинжлэх ухаан байгалийн ухааны коллеж, Монгол Улсын Эрдэм их сургуультай хамтын ажиллагааны гэрээ байгуулж, Хятад, Монголын дээд боловсролын салбар дахь эрдэм шинжилгээний харилцаа, хамтын ажиллагааны цар хүрээг тасралтгүй өргөжүүлжээ.

Хятад, Монголын дээд боловсролын салбар дахь эрдэм шинжилгээний харилцаа, хамтын ажиллагааны хүрээнд хэл, уран зохиол, урлаг зэрэг салбараас гадна анагаах ухаан, археологи, экологийн салбарын харилцаа, хамтын ажиллагаа нэлээд идэвхтэй байна. Эдгээр солилцоо, хамтын ажиллагаа нь хоёр талын эрдэм шинжилгээний хэлэлцүүлгийг ахиулахаас гадна хоёр орны эдийн

засаг, нийгмийн хөгжилд хүчтэй дэмжлэг үзүүлж байна.

3. Суралцсан намтар, эрдмийн зэргийг харилцан хүлээн зөвшөөрөв

Суралцсан намтар, эрдмийн зэргийг харилцан хүлээн зөвшөөрөх бол дээд боловсролын олон улсын харилцаа, хамтын ажиллагааны нэг чухал агуулга болно. Хятад, Монгол хоёр улс 1998 онд “БНХАУ болон Монгол Улсын Засгийн газар суралцсан намтар, эрдмийн зэргийг харилцан хүлээн зөвшөөрөх тахай гэрээ”-нд гарын үсэг зурж, Хятад, Монгол хоёр улсын дээд боловсролын олон улсын харилцаа, хамтын ажиллагааны хөгжлийг ахиулав. Хятад улс суралцсан намтар, эрдмийн зэргийг нотлох стандартын талаар НҮБ-ын ЮНЕСКО-гийн “Ази, Номхон далайн бүс нутгийн дээд боловсролын өөрөө хариуцах конвенц”-ийг баталгаажуулж, “Олон улсын боловсролын хандлага болон туршлагын бодлогын санал”-ыг боловсруулах ажилд оролцож, “Ази, Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагын стратеги”, “2030 он хүртэлх тогтвортой хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх Хятадын үндэсний төлөвлөгөө” зэргийг ахлан зохион байгуулж боловсруулжээ.

Гурав. Хятад, Монголын дээд боловсролын олон улсын хамтын ажиллагааны гол ололт

(1) Хятад, Монголын дээд боловсролыг олон улсын түвшинд хүргэх ажлыг эрчимжүүлэв

Хятад, Монголын олон улсын дээд боловсролын хөгжлийг ахиулж, ялангуяа Хятад, Монголын дээд боловсролын олон улсын хөгжлийг түргэтгэв. Дээд боловсролыг олон улсжуулах нь нэвтрүүлэх арга замын инноваци хийхээр дамжуулж дэлхийд нөлөө үзүүлэх нэг зүйлийн зөөлөн хүчний илрэл болно.² Одоогийн байдлаар дээд боловсролыг олон улсжуулах нь дэлхийн том гүрнүүдийн хувьд дэлхийн боловсролын төвүүдийг байгуулж, үндэсний зөөлөн хүчээ дээшлүүлэх зангилаа болж байна.³

(2) Өндөр чанартай чадвартныг бэлтгэх ажлыг ахиулав

Даяаршлын хурдацтай хөгжиж байгаа нь дээд боловсролын олон улсын хамтын ажиллагаа, харилцаа дэлхийн улс орнуудын боловсролын хөгжлийн чухал чиг хандлага болж байна. Хоёр орон дээд боловсролын салбарт олон улсын хамтын ажиллагаа, харилцаагаар дамжуулан олон улсын алсын хараатай, соёл дамнасан ур чадвартай өндөр чанартай чадвартныг нэн олон хүмүүжүүлж, хоёр орны эдийн засгийн хөгжил, нийгмийн дэвшилд хувь нэмэр оруулж байна.

(3) Хятад, Монголын ард түмний харилцааг ахиулав

Боловсрол бол харилцан ойлголцол, нөхөрлөлийг бэхжүүлэх чухал арга зам мөн. Боловсролоор дамжуулан Хятад, Монгол хоёр улс нөгөө талынхаа соёлыг илүү гүнзгий ойлгож, эндүүрэл, ташаа бодлыг арилгаж, харилцан ойлголцол, хүндэтгэлийг нэмэгдүүлж чадна. Иймээрхүү ойлголцол, хүндэтгэл нь ард түмнүүд нөхөрлөлөөрөө холбогдох үндэс, мөн ч энх тайван, тогтвортой, хөгжин дэвшсэн олон улсын нийгмийг байгуулах чухал хүчин зүйл юм. Үүний зэрэгцээ, гадаадын оюутнууд бол олон улсын найрамдлын элч, "боловсрол"-ын хоёр чиглэлд харилцан үйлдэлцүүлж, Хятад, Монгол хоёр улсын иргэдийн солилцоог ахиулах болно.

Дөрөв. Хятад, Монголын дээд боловсролын олон улсын хамтын ажиллагаанд оршиж буй асуудлууд

Хятад, Монгол хоёр улсын харилцаа гүнзгийрч буй нөхцөл байдалд, дээд боловсролын олон улсын хамтын ажиллагаа, харилцаа тодорхой үр дүнд хүрсэн ч зарим асуудал тулгарч байна. Нэлээд товойм асуудал нь Хятадад суралцаж буй монгол оюутнуудын мэргэжил нь харьцангуй дан цулгүй, гол төлөв нийгмийн шинжлэх ухаанд төвлөрч байна. Энэ байдлыг өөрчлөх шаардлагатай, нэн зүй

² WU H T,ZHA Q.A New Typology for Analy- zing the Direction of Movement in Higher Education Internationalization[J].Journal of Studies in International Education,2018,22(3):259-277.

³ Ван Жяньлян, Ян Ян. Дээд боловсролыг олон улсжуулах олон улсын туршлага ба Хятадын арга замын сонголт: Олон улсын бодлого, стратегид суурилсан дүн шинжилгээ [J]. Нийгмийн шинжлэх ухааны фронт, 2022(9): 230-239.

зохистой суралцах хичээлийн хуваарилалтыг чармайн хийж, нэн олон өндөр дээд зидааны чадвартныг хүмүүжүүлэх хэрэгтэй.

Дүгнэлт

Хятад, Монголын дээд боловсролын олон улсын хариоцаа, хамтын ажиллагааны хүрээнд харилцан томилох оюутнуудын тоо ихээхэн өсч, харилцаа, хамтын ажиллагааны цар хүрээ үргэлжлэн өргөжиж байгаа нь харилцаа тасралтгүй өргөжиж буйг харуулж байгаа бөгөөд хоёр талын боловсролын салбар дахь хамтын ажиллагаа, харилцаа тасралтгүй бэхжиж байгааг харуулж байна. Иймэрхүү хандлага нь Хятад, Монголын боловсролын салбарын хамтын ажиллагаа цаашид ч гүнзгийрэх ирээдүйтэйг илтгэж байна. Хоёр тал мөн төрийн бодлогоороо зөвшилцөн холбогдох ажлыг эрчимжүүлж, хамтын ажиллагааны хүрээгээ тэлүүлж, урт хугацааны үр ашигтай механизмыг байгуулах зэрэг талаар хүчин чармайлт гаргах шаардлагатай. Ирээдүйд хандахад өнлөр чанар чансаатай гадаадын оюутнуудыг хүмүүжүүлэх шинэ арга замыг гүнзгий шинжлэн судалж, Хятад, Монголын дээд боловсролын олон улсын харилцаа, хамтын ажиллагааг гүнзгийрүүлэн хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, Хятад, Монгол хоёр улсын харилцааны тогтвортой найрсаг хөгжилд хувь нэмрээ оруулах хэрэгтэй.

Лавлагаа болгосон сурвалж бичгүүд:

1. “Ши Жиньпин “Бүс ба Зам” олон улсын хамтын ажиллагааны дээд хэмжээний 3-р чуулга уулзалтын нээлтийн ёслолд оролцож тавьсан үндсэн илтгэл”, “Ардын өдрийн сонин”, 2023 оны 10-р сарын 19, 1-р хэвлэл
2. [Америк] Жозеф Най, “Зөөлөн хүч” Ма Жоаньжюань, Жүншинь хэвлэлийн газар, 2013 оны хэвлэл.

SPSIRPA FORUM 2024

Session 6-5

The complex geopolitics of language and literacy
reform in Mongolia



Монгол дахь хэл бичиг үсгийн шинэчлэлийн ээдрээтэй геополитик

Улаанбаатар кирилл үсэгт шилжээд 80 шахам жил болж байна. Монгол Улс яагаад одоо уламжлалт уйгаржин монгол бичгийг сурталчилж түгээн дэлгэрүүлж байна вэ?

Чингис хаан Их Монгол Улс буюу Монголын Эзэнт Гүрнийг байгуулснаас эхлээд 20-р зууны дунд үе монгол хэл бичиг үсгийн тогтолцоог шинэчилж, уламжлалт бичгийг халах хүртэл [800 гаруй жилийн турш](#) монголчууд Уйгураас гаралтай уламжлалт монгол бичиг үсгийг хэрэглэсээр ирсэн.

Харин Монголчууд 1940-өөд оноос эхлэн уламжлалт уйгаржин үндэсний монгол бичиг үсгийн оронд кирилл үсэгт суурилсан шинэ бичиг үсэг хэрэглэж эхэлсэн. Төрийн тамга бүх шатанд кирилл, монгол бичгээр хоёулаа ашиглагддаг уламжлалтай. Өнөө үед 30-аас доош насны Монгол Улсын харьцангуй залуу ард иргэд хэрэглээ багатай улмаас уламжлалт уйгаржин монгол бичиг үсгээ төдийлөн сайн ашигладаггүй.

1980 оны сүүлээс Монголын зарим дунд сургуулиуд үндэсний монгол бичгийн сургалт явуулж эхэлсэн ч зарлан таниулах түгээн сурталчлах ажил идэвхгүй, тухайн үеийн нөхцөл байдлаас хамаарч сонирхогчид төдийлөн их байсангүй. Өнөө үед монгол улсын дунд сургууль, их дээд сургууль коллежид уламжлалт монгол бичгийн хичээл заадаг ч суралцаж буй сурагч оюутнуудад энэ бичиг үсгийн мэдлэгийг төлөвшүүлэхэд эцэг эхчүүд төдийлөн сайн анхаардаггүй байдал ажиглагддаг.

Харин одоо Монгол Улс уламжлалт уйгаржин монгол бичиг үсгээ албан ёсны үндэсний бичиг болгох цаг үе тохиож байна. [2025 оноос](#) төрийн албан хэргийг кирилл болон үндэсний монгол бичгээр хөтлөн явуулах, цаашид бүх нийтээр монгол бичигт шилжих үйл явц өрнөнө.

20 дугаар зууны эхээр байгуулагдсан [ЗХУ бол](#) олон үндэстний цөөнхтэй өргөн удам газар нутагтай орон байсан. Тухайн үеийн ЗХУ-ын засгийн газар улс төр, эдийн засаг нийгмийн бүтээн байгуулалтыг түргэсгэх шаардлагын улмаас үндэстний цөөнхийн бүс нутагт бичиг үсгийн тогтолцоог шинэчилж, Орост түгээмэл [кирилл үсгээр солих шийдвэр](#) гаргажээ. Тухайн үед тусгаар тогтнолоо зарласны дараахан ЗХУ-ын дагуул улсын нэг байсан БНМАУ ч мөн адил уламжлалт уйгаржин монгол бичиг үсгээ өөрчилж, кирилл үсгийг бүхэлд нь хэрэглэж эхэлсэн.

1930-иад оноос Монгол Улс ЗХУ-ын хүсэлт шаардлагыг зарим талаар биелүүлж, бичиг үсгийн тогтолцоогоо шинэчилж, [латин үсэг](#) болон [кирилл үсэг](#) эрчимтэйгээр ашиглаж эхэлсэн. Кирилл монгол хэл бичиг хэдийгээр монгол хэлний бичиг үсгийн шинж чанаруудыг агуулсан хэдий ч оросын кирилл үсэг(слав хэл) шиг л харагддаг.

Уламжлалт уйгаржин монгол бичиг үсгийг халах нь Монголд ашигтай давуу тал

олон байсан хэдий ч сөрөг нөлөөтэй байсныг мартаж болохгүй. Ашигтай давуу тал нь кирилл монгол хэлний ярих дуудлага, бичиглэл нь ижил тул тус бичиг үсгийг сурталчлах түгээн дэлгэрүүлэхэд хүндрэл харьцангуй бага, бүх нийтээр боловсрох олон нийтийн бичиг үсэг тайлагдах явц хурдтай байв. Харин сөрөг нөлөө гэвэл ЗХУ, Монголын тухайн үеийн эрх баригчид кирилл монгол хэл бичгийг сурталчлан түгээн дэлгэрүүлэхээр шийдсэн нь зарим талаар уламжлалт соёл, түүхээ мэдэхгүй хэдэн үеэрээ монголчууд бий болоход хүргэсэн.

Ямар нэгэн хэмжээгээр хэвшиж дассан уламжлалт бичиг үсгээ шинэчлэнэ гэдэг нь өөрийн үндэстний улс орны түүхтэй нарийн холбоотой соёл дурсгал уламжлалаас холдон хөндийрнэ гэсэн үг. Кирилл монгол үсгийг сурталчилж дэлгэрүүлэн түгээж эхэлснээс хойш түүх соёлын олон баримт бичиг, эх сурвалж эд агуурсыг уншиж тайлах боломжгүй болж, нийт иргэд олонд хүртээмжгүй болсон. Кирилл үсэгт шилжсэнээр монголчуудын уламжлалт уйгаржин монгол хэл бичиг үсгийн талаарх ойлголт шинэчлэгдэн өөрчлөгдсөн.

Үүнийг харгалзан үзэхэд уламжлалт уйгаржин монгол бичиг үсгийг кирилл үсгээр сольсон эхний өдрөөс л тухайн үед Монголд эсэргүүцлийн дуу хоолой гарч байсан. Кирилл үсгийн хэрэглээ өнгөрсөн зуунд Монгол улсын нийгэм улс төр эдийн засагт асар их нөлөө үзүүлсэн. Хамгийн гол нь Монголчуудын Хятад, Түрэгийн соёл иргэншлийн түүхэн холбоог бичиг үсгийн хэлээр таслахын сацуу Зөвлөлтийн Слав Орос соёл иргэншил Монголд гүнзгий нэвтрэн орох үйл явцыг түргэсгэсэн. Хятадад Өвөрмонголд уламжлалт уйгаржин монгол бичиг үсэг хэрэглэсээр байгаа бол Түрэг Уйгуруудын эх нутаг буюу одоогийн ШУӨЗО болон баруун хойд Хятадын олон бүс нутагт тархан суурьшсан монгол түрэг угсаатнууд уйгаржин монгол бичиг үсгийг одоо ч хэрэглэсээр байна.

Кирилл бичиг үсэгтэй болсноор Монголыг зарим талаар “Хятад”-ын соёл нийгэм түүхийн нөлөөнөөс холдуулж ангижруулах үйл явц амжилттай өрнөсөн. Улс төрийн шалтгааны улмаас ЗХУ-г задран унасны дараа хүртэл энэ үйл явц өөрчлөлтийг эсэргүүцэж байсан.

1990 оноос эхлэн Монгол Улсад уламжлалт уйгаржин монгол бичиг үсгийг сэргээн ашиглах түүх соёл уламжлалаа эргэн мандуулахыг уриалсан иргэд олон нийтийн дуу хоолой хүчээ авав. Үнэн хэрэгтээ улс төр нийгэм эдийн засгийн шилжилт хийж буй Монголын төр засаг бичиг үсгийн тогтолцоог дахин өөрчлөхөд ихээр дэмжлэг үзүүлж чадаагүй бөгөөд тухайн үеийн төсөв санхүүгийн хүндрэл, техник технологийн шийдэл, багш хүний нөөцийн хомсдол зэрэг олон асуудлаас болж хойшлуулсаар ирсэн. Харин сүүлийн жилүүдэд л [үндэсний бичиг үсэг соёлыг эргэн сэргээх](#) үйл явц мэдэгдэхүйц хурдассан.

Монгол Улсын Засгийн газраас [2011 онд](#) төрийн албан хаагчид олон улсын байгууллага болон гадаад орнуудын албан ёсны төр олон нийтийн байгууллагуудтай харилцахдаа уламжлалт уйгаржин монгол бичиг үсгийг хэрэглэхийг үүрэг болгосон

журам гаргасан. Мөн уламжлалт уйгаржин монгол бичиг, кирилл монголоор зэрэг бүх төрлийн гэрчилгээ, бичиг баримтыг зэрэгцүүлэн бичихээр болсон.

УИХ 2015 онд [Монгол хэлний тухай](#) хуулийг баталсан. Тус хуульд 10 жилийн дотор буюу төрийн болон орон нутгийн өөрөө удирдах байгууллага 2025 оноос албан хэргээ кирилл, үндэсний хос бичгээр хөтлөн явуулна гэж заасан юм. Гэсэн хэдий ч кирилл монгол бичиг үсэг одоо ч нийгэм эдийн засгийн олон салбарт зонхилох байдлаар ашиглагдсан хэвээр байна.

2020 оны гуравдугаар сард Монгол Улсын Засгийн газрын хуралдаанаар, "[Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III](#)"-ыг албан ёсоор хэлэлцэн баталж, 2025 оноос цаашид бүх нийтээр монгол бичигт шилжихээр шийдвэрлэсэн. Уламжлалт уйгаржин монгол бичиг үсэг нь зарим талаар төрийн албан хэрэгт бэлэгдлийн байдлаар хэрэглэгдэж байсан бол одоо иргэний үнэмлэх, төрсний гэрчилгээ, гэрлэлтийн баталгаа, диплом зэрэг төрөөс олгосон бүхий л бичиг баримтад кирилл бичигтэй зэрэгцүүлэн ашиглагдахаар байна.

2021 онд Монгол Улсын 150 мянга орчим төрийн албан хаагчдаас "[албан хэргээ кирилл болон үндэсний бичгээр хослуулан хэрэглэхэд бэлэн эсэх](#)" талаар судалгаа авчээ. Судалгаанд олонхи (53.6 хувь) нь дэмжсэн бөгөөд тус бодлогыг дэмжих янз бүрийн үндэслэлийг дурьдсан байжээ. Мөн 2024 оны 04 сард, Монгол хэлний тухай хууль, Засгийн газраас баталсан "Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III (2020-2024)" -ийн хэрэгжилтийг үнэлэх "[Төрийн албан хаагчийн үндэсний бичгийн мэдлэг тодорхойлох судалгаа](#)"-ны мэдээлэл цуглуулах ажил хийгдэж байна.

Монгол Улс уламжлалт уйгаржин монгол бичиг үсгийг хэрэглээнд бүрэн ашиглахаар шийдсэн нь гайхах зүйл биш юм. ЗХУ задран унасны дараа хуучнаар ЗХУ-ын бүрэлдэхүүнд байсан [Азербайжан](#), [Туркменистан](#), [Узбекистан](#) зэрэг олон улс орон язгуур уламжлалт бичиг үсгээ сэргээн хэрэглэх буюу шинэ бичиг үсгийг хэрэглэх болсон. [Казахстан](#)-д хүртэл ийм үйл явц явж байна. Энэ нь олон арван жилийн Зөвлөлтийн нөлөөний дараа уламжлалт соёлыг сэргээж буйг харуулж байна.

Өнөөдөр дэлхий дахинд тодорхойгүй, геополитикийн орчинд урьдчилан тааварлахын аргагүй нөхцөл байдал үргэлжилж, цөмийн зэвсгийн заналхийлэл бодитой хүчин зүйл болсон хэвээр байна. ОХУ-ын Украины эсрэг эхлүүлсэн цэрэг дайны ажиллагаа дэлхий нийтийг эрчим хүч, түлш, хүнсний хямрал руу түлхэж, үүнээс шууд улбаатай инфляци, үнийн огцом өсөлт хөгжиж буй төдийгүй хөгжингүй орнуудын ард иргэдийн амьжиргаанд ноцтой сөрөг нөлөө үзүүлсээр байна. Зүүн Украины нутаг дэвсгэр ерөнхий төрх дэлхийн II дайны үнс нурмаас ялгагдахааргүй харагдах болов.

ОХУ-ын ҮАБЗ-ийн орлогч Д.Медведев Европын хил хязгаарыг өөрчлөх санаархлаа ч ил тод мэдэгдэж эхлэв.²

Украинд түрэмгийлэхийн өмнөхөн буюу 2022 оны хоёрдугаар сарын 19-нд В.Путины тушаалаар Оросын зэвсэгт хүчин цөмийн дайны сургуулилалтыг эхлүүлж,³ Украинд түрэмгийлснээс 3 хоногийн дараа буюу хоёрдугаар сарын 27-нд цөмийн зэвсгээ байлдааны бэлэн байдалд оруулж байв.⁴

Мөн өдрийн ням гаригт Беларусьт ОХУ-ын цөмийн зэвсэг, цэргийн бүлэглэлийг байнга байршуулах асуудлаар Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах бүх нийтийн референдум буюу санал асуулга явагдаж, санал асуулгад оролцогчдын 65.16 хувь нь нэмэлт, өөрчлөлт оруулахыг “дэмжиж”, 10.07 хувь нь эсрэг санал өгсөн, сонгогчдын ирц 78.63 хувьтай байсан гэж Сонгуулийн Төв хорооны тэргүүн Игорь Карпенко мэдэгдсэн тухай ОХУ-ын мэдээллийн агентлагууд мэдээлж байв.⁵ Ийнхүү Беларусь цөмийн зэвсэг үл дэлгэрүүлэх гэрээнээс татгалзаж, 1994 онгы Будапештын Меморандумыг⁶ илт зөрчсөн үйлдэл хийсэн юм. Чингэснээр Беларусь нь өөрийгөө сайн дураараа НАТО-гийн цөмийн цохилтын бай болгов. Улмаар 2023 оны гуравдугаар сарын 25-нд В.Путин Оросын тактикийн цөмийн зэвсгийг Беларусьт байрлуулахаар тус улсын удирдагч А.Лукашенко-той тохиролцсоноо мэдэгдэв.⁷

ОХУ Украинд түрэмгийлж, НҮБ-ын Дүрэм, Олон улсын эрхзүйн үндсэн зарчмуудын тухай 1970 оны НҮБ-ын Тунхаглалд заасан Улс гүрнүүдийн тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг хүндэтгэх, хил хязгаарын халдашгүй байдал, хүч үл хэрэглэх, хүчээр үл заналхийлэх, дотоод хэрэгт үл оролцох, аливаа

¹ Д.Уламбаяр. ХИС-ийн Олон улсын харилцаа, нийргэм судлалын сургуулийн захирал

² “Медведев предложил «отодвинуть границы угроз» к Польше” 24 фев, 2023

<https://www.rbc.ru/politics/24/02/2023/63f873789a7947f46ebbee32>

³ “Путин провел стратегические ядерные учения” 19.02.2022

<https://www.dw.com/ru/putin-nachal-strategicheskie-jadernye-voennye-ucheniya/a-60840832>

⁴ “Путин приказал перевести силы сдерживания в особый режим боевого дежурства” 27 фев. 2022

<https://ria.ru/20220227/putin-1775389742.html>

⁵ Belarus Votes to Give up Non-Nuclear Status. 28.0.2022

<https://www.france24.com/en/live-news/20220228-belarus-votes-to-give-up-non-nuclear-status>

⁶ “Budapest Memorandums on Security Assurances 1994”-*Council on Foreign Relations Journal*, Dec. 5, 1994

⁷ “Россия разместит в Беларуси тактическое ядерное оружие, заявил Путин” 25 марта 2023

<https://www.bbc.com/russian/news-65077823>

маргаантай асуудлыг эвзүйн аргаар, энхтайван замаар шийдвэрлэх, тэгш эрхийн зарчим, олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар биелүүлэх, нийгмийн байгууллаа чөлөөтэй сонгох, өөртөө засан тогтнох эрхийг хүндэтгэх, хүний эрхийг дээдлэх, энхтайвнаар зэрэгцэн орших нөхцөл дор харилцан ашигтай хамтын ажиллагаагаа хөгжүүлэх зэрэг олон улсын эрхзүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, хэм хэмжээ, 1975 оны Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны Хельсинкийн Төгсгөлийн Баримт бичгийн зарчмууд, 1990 оны Парист гарын үсэг зурсан Шинэ Европын Хартид тусгагдсан олон улсын аюулгүй байдлыг бэхжүүлэх, энхтайвныг хадгалах, хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжих, ардчилалыг өргөжүүлэн бэхжүүлэх, хууль дээдлэх, хүний эрх, үндсэн эрх чөлөөг хүндэтгэх,⁸ 1994 оны Будапештын Меморандум, ОХУ-аас Украинтай байгуулсан 1997 оны тавдугаар сарын 28⁹, 2010 оны дөрөвдүгээр сарын 22-ны хэлэлцээрээр¹⁰ хүлээсэн олон улсын үүргээ хөсөрдүүлэв.

ОХУ Украинд бүрэн хэмжээний дайны ажиллагааг эхлүүлснээр Хүйтэн дайны дараах эрин үеийг эгнэгт төгсгөл болгов.

Тиймээс эдүгээ олон улсын дүрэмд суурилсан дэлхийн дэг журмыг сэргээн сахин хангах явдал тулгамдсан сорилт болсоор байна.

II. ЕХ-ын Хамтын Батлан хамгаалахын интеграцийг эхлүүлсэн нь

2017 оны арваннэгдүгээр сарын 13-ны өдөр АНУ-ын тэргүүлсэн НАТО-гаас тусдаа Европын Холбооны (ЕХ) гишүүн орнуудын зэвсэгт хүчнийг интеграцлах үндсэн дээр нэгдсэн бүтэц буй болгох зорилгоор ЕХ-ны 28 орноос 23 орны Гадаад хэргийн болон Батлан хамгаалахын сайд нар (Австри, Бельги, Болгар, Герман, Грек, Кипр, Испани, Итали, Латви, Литва, Люксембург, Нидерланд, Унгар, Польш, Румын, Словак, Словени, Чех, Хорват, Франц, Финланд, Швед, Эстони) ЕХ-ны Гадаад хэрэг, аюулгүй байдлын бодлогын Дээд төлөөлөгч Федерика Могерини тэргүүтэй төлөөлөгчид Гадаад харилцааны зөвлөлд “Байнгын бүтэцтэй хамтын ажиллагаа”-г (Permanent Structured Cooperation-PESCO) байгуулах тухай хэлэлцээрт Брюссель хотноо гарын үсэг зуржээ.¹¹

Удалгүй Ирланд, Португаль улсууд 2017 оны арванхоёрдугаар сарын 7-нд PESCO-д элсч, тийнхүү 25 орныг эгнээндээ нэгтгэсэн PESCO-г Европын Зөвлөл 2017 оны 12 дугаар сарын 11-нд албан ёсоор баталсан байна.

Карнеги Европын судалгааны төвийн (Carnegie Europe think tank) судлаач Жуди Демпси (Judy Dempsey) “Бид энэ бүгдийг өмнө нь сонсож байсан”, ЕХ-ны Гадаад бодлого, аюулгүй байдлын тэргүүн Федерика Могерини дээрх үйл явдлыг “түүхэн”, Германы Гадаад хэргийн сайд Зигмар Габриэл (Sigmar Gabriel) “Европын хөгжлийн чухал үе шат” гэж тус тус нэрлэж байв. Еврокомиссын Хэвлэл мэдээллийн хэлтсийн

⁸ Jens-Peter Bonde. From EU Constitution to Lisbon Treaty. 2007

⁹ “Соглашение между Российской Федерацией и Украиной о статусе и условиях пребывания Черноморского флота Российской Федерации на территории Украины”. 1999 оны 7 дугаар сарын 3-ны Холбооны хурлын N 124-ФЗ тоот хуулиар соёрхон баталж, хэлэлцээр 1999 оны 7 дугаар сарын 12-нд хүчин төгөлдөр үйлчилж, улмаар 2014 оны 4 дүгээр сарын 2-ны өдрийн Холбооны хурлын N 38-ФЗ тоот хуулиар хүчингүй болгосон байна.

¹⁰ “Соглашение между Российской Федерацией и Украиной по вопросам пребывания Черноморского флота Российской Федерации на территории Украины” 2010 оны 4 дүгээр сарын 21-ний Холбооны хурлын N 67-ФЗ тоот хуулиар соёрхон баталж, хэлэлцээр 2010 оны 5 дугаар сарын 14-нд хүчин төгөлдөр үйлчилж, улмаар 2014 оны 4 дүгээр сарын 2-ны өдрийн Холбооны хурлын N 38-ФЗ тоот хуулиар хүчингүй болгосон байна.

¹¹ Defence cooperation: 23 member states sign joint notification on the Permanent Structured Cooperation (PESCO)

13 November 2017

<https://www.consilium.europa.eu/en/press/press-releases/2017/11/13/defence-cooperation-23-member-states-sign-joint-notification-on-pesco/#:~:text=EU>

удирдагч Маргаритис Шайнас (Margaritis Schinas) саран дээр буух үйл явцын “Брюссельд хийсэн жижиг алхам, Европ дахь аварга том үсрэлт” гэж нэрлэв.¹²

Тухайн үед Их Британи Brexit-ийг эхлүүлсэн байсан учир Гадаад хэрэг, хамтын нөхөрлөлийн сайд Борис Жонсон: Их Британи PESCO-гийн санаачилгад нэгдээгүй ч “дэмжиж байна” гэж мэдэгдсэн юм.¹³

Данийн Хаант улс ЕХ-ны хүрээнд аюулгүй байдал, батлан хамгаалах нийтлэг бодлогоос татгалздаг тул PESCO-гийн хэлэлцээрт гарын үсэг зураагүй юм. Харин Украинд ОХУ түрэмгийлсэнтэй холбоотойгоор ЕХ-ны гишүүн, НАТО-гийн гишүүн Дани улсын уламжлалт гадаад бодлого өөрчлөгдөв. 2022 оны зургаадугаар сарын 1-нд Дани улсад явагдсан бүх нийтийн санал хураалтад оролцогчдын 66.9 хувь нь ЕХ-ны Хамтын батлан хамгаалах гэрээнд нэгдэх сонголтыг хийж, 33.1 хувь нь нэгдэхийн эсрэг санал өгсөн юм. “Тус тивд дайн болж байгаа тохиолдолд бид төвийг сахих боломжгүй юм. ЕХ-ны бүх нийтийн санал хураалтад Дани улс хамгийн том “Тийм” гэж хариулсан нь энэ болов уу” гэж тус улсын Ерөнхий сайд Метте Фредериксен мэдэгдэв.¹⁴ ЕХ-ны 5.8 сая хүн амтай Дани улс нь НАТО-г үүсгэн байгуулцсан орнуудын нэг мөн боловч ЕХ-ны PESCO-д нэгдээгүй байсан юм.

Бүгд Найрамдах Мальт Улс 1981 оны тавдугаар сарын 14-нд Төвийг сахих статусын тухай Тунхаглал гаргасан бөгөөд цэргийн аливаа эвсэлд орохоос татгалзаж байна хэмээн зарласан тул PESCO-г цаашид хэрхэн хөгжихийг ажиглахын тулд нэгдэн ороогүй байна. Мальта 2004 оны тавдугаар сарын 1-нд ЕХ-нд нэгдэн орсон билээ. Эдүгээ Мальт улсад ч ЕХ-ны PESCO-д нэгдэх асуудлаар өргөн хүрээнд хэлэлцүүлэг өрнөөд байна.¹⁵

ЕХ-ны Байнгын бүтэцтэй хамтын ажиллагаа (The Permanent Structured Cooperation- PESCO) нь аюулгүй байдал, батлан хамгаалах бодлогын (CSDP) нэн чухал хэсэг бөгөөд Холбооны 27 гишүүн улсын үндэсний зэвсэгт хүчний 25 нь эдүгээ бүтцийн интеграцлалыг хэрэгжүүлж байна. Ийнхүү ЕХ улс төр-эдийн засгийн интеграци төдийгүй нэгдсэн армитай цэргийн эвсэл болох чиглэлд том алхам хийснээр Австри, Швед, Финландын төвийг сахих статус ч өөрчлөгдөх төлөвтэй болсон юм.¹⁶

ЕХ-ны интеграцлалд ороогүй байсан ганц салбар бол гишүүн улсуудын батлан хамгаалахын хамтын ажиллагаа байсан билээ. Тиймээс тус тусдаа үйл ажиллагаа явуулж байсан ЕХ-ны гишүүн орнуудын үндэсний батлан хамгаалах чадавхийг нэгтгэн зангидах, интеграцчлах, зэвсэг техникийн худалдан авалт, хөрөнгө оруулалт, судалгаа шинжилгээний нэгдсэн бодлогыг хэрэгжүүлэх, ажиллагааны чадавхийг шинэ шатанд гаргах, бэлэн байдал ба онцгой байдлын үеийн удирдлагын шуурхай байдлыг хангах, кибер орон зайд цэргийн ажиллагааг үр ашигтай явуулах, кибер орон зайн аюулгүй байдлыг хангах явдал тулгамдсан асуудал болон тавигджээ.

XXI зууны нэгдэх арван жилийн эхээр ЕХ-ны геополитикийн гадаад орчинд томоохон өөрчлөлтүүд дараалан гарч, хэд хэдэн ноцтой хямралыг үүсгэсэн юм. Арабын хавар, Ливи, Сирийн иргэний дайн, Сири, Иракийн нутаг дэвсгэрийг дамнасан Лалын Халифатын улс байгуулах зорилготой “Исламын улс бүлэглэл” хүчээ авснаар Европ руу чиглэсэн дүрвэгсэд, цагаачдын нүсэр давалгаа буй болж, үүнтэй холбоотойгоор олон

¹² Catalyzed by Trump and Brexit, the EU’s 23-army defense pact is unlikely to enhance security. November 17, 2017 <https://qz.com/1128999/eu-army-the-brexit-and-trump-effect-and-what-it-means-for-european-security/>

¹³ Almost the entire EU has signed up to a major joint military plan (but not Britain) <https://www.businessinsider.com/eu-nations-sign-pesco-joint-military-plan-but-not-britain-2017-11-14>

¹⁴ “Denmark to join EU defence policy after historic vote”. Jun 2, 2022 <https://www.euractiv.com/section/elections/news/denmark-to-join-eu-defence-policy-after-historic-vote/>

¹⁵ “Safeguarding neutrality and indifference: the decision to opt out of EU military cooperation” 3 March 2023 https://www.maltatoday.com.mt/news/national/121524/safeguarding_neutrality_and_indifference_the_decision_to_opt_out_of_eu_military_cooperation#.ZCV2I3ZBxPY

¹⁶ Jill Petzinger. The EU has signed a deal to integrate 23 armies. 20 Nov. 2017 <https://www.weforum.org/agenda/2017/11/the-eu-has-signed-a-deal-to-integrate-23-armies>

улсын террорист ажиллагаа идэвхжиж, хүмүүнлэгийн хямрал даамжрав. Украин-ЕХ-ны эвлэлдэх нийгэмлэгийн хэлэлцээр (association agreement)-ийн явц, үүнээс улбаатай өрнөсөн Евромайданы өнгөт хувьсгал өрнөж, ОХУ 2014 оны хавар дурдсан хэрэг явдалд хөндлөнгөөс оролцоод зогсохгүй, Крымын хойгийг өөртөө хүч түрэн нэгтгэв (annexation). Цаашлаад Украины зүүн хэсэг Донбассын нутагт зэвсэгт мөргөлдөөн дэгдэв. АНУ-ын Ерөнхийлөгч Доналд Трампын гадаад бодлогын шинэ параметр олон зүйлсийг шинээр авч үзэх шаардлагатайг харуулсан юм.

ОХУ-ын Өрнөдийг чиглэсэн геополитикийн ил, далд санаа нь НАТО-г хагалан бутлах, ЕХ-г задлах, АНУ-Европын хоорондын холбоотны түншлэлд ан цав гаргах явдал юм хэмээн барууны аюулгүй байдлын шинжээчид үсэн билээ. Сирийн иргэний дайнд ОХУ хөндлөнгөөс оролцсоноор Сирийн дүрвэгсдийн давалгааг дамжруулахад тус дөхөм үзүүлж, чингэснээрээ Европыг улам хүнд байдалд оруулах, нөгөө талд амьд байн дээр огт ашиглаж байгаагүй 30 гаруй жил нөөцлөгдсөн шинэ зэвсгийнхээ туршилтаа амжилттай хийж эхэлсэн явдал байв.

III. Швейцарь, Финланд, Швед, Австрийн төвийг сахих статусын төгсгөл

Швейцарийн өвөрмөц байдал давтагдашгүй бөгөөд “Швейцарь лугаа төвийг сахиж хөгжсөн” улсын жишээ байхгүй юм. Эдийн засгийн шинжлэх ухаанд үр ашиг бүхий хөгжлийн загвар, эдийн засгийн өсөлтийн гайхамшигийг хэзээ ч төвийг сахих статустай холбон тайлбарлаж байгаагүй юм. Эдийн засгийн шинжлэх ухааны аль ч сурах бичигт энэ талаар огт дурдаж байгаагүй юм. Төвийг сахих бодлогын гарал үүсэл нь Европт дэгдсэн 30 жилийн дайн, Наполеоны дайнтай шууд холбоотой байв. Тиймээс түүхэн зайлшгүй шаардлагаас төвийг сахих статус урган гарсан түүхтэй. 1815 оны Венийн их хурлаас их гүрнүүд Швейцарийн тусгаар тогтнолыг сэргээж, улмаар байнга төвийг сахиулж, олон улсын эрхзүйн статусыг нь тунхаглан зарлаж, мөн оны Парисын гэрээгээр Австри-Унгарын Хаант Улс, Их Британи, Орос, Прусс, Франц зэрэг таван гүрэн хүлээн зөвшөөрч, 1919 оны Версалийн найрамдлын гэрээгээр дахин баталгаажуулжээ. Швейцарь нь 1948 онд НҮБ-д ажиглагчийн статустай болсон бөгөөд хүйтэн дайны үед байнга төвийг сахих статус нь олон талт хамтын ажиллагаанд идэвхтэй оролцоход тээг болж байсан учир Холбооны болон Үндэсний Зөвлөлд 1977, 1981 онд НҮБ-д гишүүнээр элсэх асуудал хөндөгдөж 1986 онд бүх нийтийн санал асуулга явуулсан боловч хүн амын 75.7 хувь нь эсрэг санал өгсөн, 1995, 1998, 2001 онуудад дахин хөндөгдөж 2002 онд бүх нийтийн санал асуулгын дүнгээр хүн амын 54.6 хувь нь НҮБ-д гишүүнээр элссэхийг дэмжжээ. Швейцарь улс НҮБ-д гишүүнээр элссэнээр гадаад бодлого, олон улсын хамтын ажиллагаа нь үлэмж идэвхжив. Зарим судлаачид Швейцарь улс НҮБ-д гишүүнээр элссэнээр “байнга төвийг сахисан” хэмээх шинж чанараа *de facto* алдсан гэж үзэж байсан.

2021 оны нэгдүгээр сард АНУ-ын *impact factor* бүхий *Foreign Policy* сэтгүүлд “The End of Swiss Neutrality” өгүүлэл нийтлэгдсэн юм.¹⁷ Швейцарийн дипломатч Пол Видмер (Paul Widmer) дипломатч тэмдэглэхдээ: Байнга төвийг сахисан байдал нь Швейцарийн ген (DNA) бөгөөд эрхзүйн систем юм. Гэхдээ Швейцарь улс 2002 онд НҮБ-д гишүүнээр элссэнээр дээрх бодлого өөрчлөгдсөн гэжээ. НҮБ-ын дэргэд шинээр томилогдсон Байнгын төлөөлөгч элчин сайд хатагтай Паскэль Барисвил (Pascale Baeriswyl) тэмдэглэхдээ: “Төвийг сахисан байдал дэлхийн хоёр дайныг тойрч гаргахад нөлөөлсөн. Гэхдээ бид домогт найдаад цааш явж болохгүй...Бидний дараагийн зайлшгүй алхам бол Аюулгүйн Зөвлөлд суудалтай болох явдал... Одоогийн Аюулгүйн Зөвлөл хүйтэн дайн

¹⁷ Stephanie Fillion. *The End of Swiss Neutrality* January 15, 2021.

[HTTPS://FOREIGNPOLICY.COM/2021/01/15/SWITZERLAND-NEUTRAL-UNITED-NATIONS-SECURITY-COUNCIL-SEAT/](https://foreignpolicy.com/2021/01/15/switzerland-neutral-united-nations-security-council-seat/)

үеийг санагдуулам байгаа нь Швейцарийн оролцоо хэрэгтэйг харуулж байж болох юм”¹⁸ гэжээ. 2020 оны зургаадугаар сард Швейцарийн Гадаад хэргийн сайд Игнасио Казис (Ignazio Cassis) дүгнэхдээ: “Аюулгүйн Зөвлөлд суудалтай болох нь эрсдлээсээ илүү үр өгөөжийг өгөх юм”¹⁹ гэжээ.

Швейцарь Крымын хойгийг өөртөө хүч түрэн нэгтгэсэн ОХУ-ын эсрэг 2014 оны наймдугаар сараас эдийн засгийн хориг тавьж, 2022 оны хавраас ЕХ-ны өргөн хүрээтэй эдийн засгийн багц хоригт нэгдэв.

Швейцарийн Холбооны Улс НҮБ-ын Аюулгүй Зөвлөлийн байнгын бус гишүүнд 2023-2024 онд сонгогдох сунгаагаа албан ёсоор эхлүүлж, тийнхүү Швейцарийн байнга төвийг сахисан статус төгсгөл болох үе шатандаа оров.²⁰ Тийнхүү Швейцарь Мальт улсын хамт 2023 оны нэгдүгээр сарын 3-наас НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн гишүүнээр 2 жилийн хугацаатай ажиллах үйл явц албан ёсоор эхлэв.²¹

2022 оны аравдугаар сарын 20-нд Швейцарийн Холбооны Улсын төрийн тэргүүн Игнасио Кассис Украинд айлчилсан нь нийт Европ тив, хүн төрөлхтний аюулгүй байдлыг хангах онцгой сорилтуудын үед төвийг сахих боломжгүйг гэрчилж буйд Украины Ерөнхийлөгч В.Зеленский талархал илэрхийлсэн юм.²² Тийнхүү Швейцарийн төвийг сахисан статус төгсгөл болж байна.

Украины эсрэг ОХУ-ын түрэмгийллийн дараа 2022 оны тавдугаар сард Швед, Финланд улсууд төвийг сахих олон улсын статусаа хүчингүй болгож, НАТО-д гишүүнээр элсэх хүсэлтээ гаргаж, тийнхүү Финланд 2023 оны дөрөвдүгээр сард, Швед 2024 оны гуравдугаар сард НАТО-гийн 31-32 дах гишүүн болж, тийнхүү төвийг сахих статусын түүх албан ёсоор дуусгавар болж байна.

Швед, Финланд улсуудын НАТО-д элсэх хүсэлтэд Турк болон Унгар улсууд ихээхэн хойрог хандаж буй үед Оросын аюул заналаас сэргийлэхийн тулд Скандинавын дөрвөн улс агаарын зэвсэгт хүчнээ нэгтгэх тохиролцоонд хүрэв. Нордикийн нэгдсэн агаарын зэвсэгт хүчин байгуулах хэлэлцээрт Норвеги, Дани, Швед, Дани улсуудын Агаарын хүчний командлагч нар 2023 оны гуравдугаар сарын 25-нд гарын үсэг зурцгаав. Гарын үсэг зурах ёслол Германы Рамштайн дахь агаарын цэргийн баазад зохион байгуулагдаж, НАТО-гийн Агаарын хүчний командлагч Жеймс Хэкер оролцжээ.²³ Чингэснээр F-35 онгоцуудыг оролцуулан хамгийн орчин үеийн 250 байлдааны нисэх онгоцтой хүчирхэг агаарын нэгдсэн зэвсэгт хүчин буй болов.

“Эцсийн зорилго нь НАТО-гийн загварчлалд суурилсан Нордикийн хамтарсан агаарын хүчний үзэл баримтлалыг боловсруулж, нэгдсэн хүчээр саадгүй ажиллах чадвартай байх явдал юм гэж Данийн Зэвсэгт хүчний төв командлал мэдээлжээ. “Манай хамтарсан хүч Европын аль ч том улсынхтай нэг түвшинд харьцуулагдахуйц юм” гэж Дани улсын агаарын хүчний командлагч хошууч генерал Жэн Дам мэдэгдэв. Тэрбээр энэ

¹⁸ *Ibid*,

¹⁹ *Ibid*,

²⁰ Stephanie Fillion. *The End of Swiss Neutrality* January 15, 2021

<https://foreignpolicy.com/2021/01/15/switzerland-neutral-united-nations-security-council-seat/>

²¹ “Five countries elected to serve on UN Security Council” <https://news.un.org/en/story/2022/06/1120052>

Switzerland took up its work on the UN Security Council. Bern. January 3, 2023

<https://www.admin.ch/gov/en/start/documentation/media-releases.msg-id-92424.html>

²² “Volodymyr Zelenskyy met with the President of Switzerland in Kyiv”-20 October 2022

<https://www.president.gov.ua/en/news/volodimir-zelenskij-zustrivsvya-z-prezidentom-shvejcarsiyi-u-k-78601>

²³ “Norway, Sweden, Finland, and Denmark struck a deal to run their 200+ advanced fighter jets as a single fleet, creating a new headache for Russia” March 22, 2023

<https://businessinsider.mx/norway-sweden-finland-denmark-fighter-jets-one-fleet-2023-3/>

шийдвэрийг Оросын арми Украинд эзлэн түрэмгийлэх дайн эхлүүлсэнтэй холбоотой хариу арга хэмжээ²⁴ гэж онцлов.

Дани, Норвеги улсууд НАТО-гийн гишүүн юм. Норвеги улс Өрнөдийн хамгийн орчин үеийн сөнөөгч онгоц болох F-35 загвараар армия зэвсэглэсэн байдаг. Финланд, Дани улсууд

ойрын үед дурдсан загварын сөнөөгч онгоцуудыг зэвсэглэлд авахаар үйлдвэрлэгчидтэй хэдийн хэлцэл хийж байгаа ажээ. Швед нь эх орны үйлдвэрийн Gripen C болон Gripen D загварын орчин үеийн сөнөөгч онгоцнуудтай, мөн шинэчилсэн Gripen E загварыг удахгүй үйлдвэрээс нь хүлээж авах хүлээлттэй байгаа ажээ.

Наполеоны дайны дараа 1834 оны нэгдүгээр сарын 4-нд хаан XIV Карл Иохан “Швед улс төвийг сахих тухай Тунхагласан”-ыг Их Британи, Хаант Орост мэдэгджээ.²⁵ Энэ үеэс хойш Швед нь олон улсын харилцаанд төвийг сахисан байр суурьтай явж иржээ. Гэвч Швед улс хүйтэн дайны жилүүдэд төвийг сахиж байгаагүйг АНУ, Их Британи, Канад, Австрали, Шинэ Зеланд улсуудын хооронд 1943 оны тавдугаар сард байгуулсан цэрэг-тагнуулын салбарт хамтран ажиллах маш нууц “Five Eyes” хэмээх хэлэлцээрт 1954 оны арванхоёрдугаар сард Стокхольм хотноо гарын үсэг зурж нэгдсэн орсон байсныг АНУ-ын Үндэсний Тагнуулын агентлагийн мэргэжилтэн Эдуард Сноуден 2013 оны арванхоёрдугаар сард олон нийтэд ил болгосон билээ.²⁶

1947 оны хоёрдугаар сарын 10-нд дэлхийн II дайнд ялагч гүрнүүд болох АНУ, ЗСБНХУ, Их Британи фашист германы холбоотон байсан Итали, Финланд, Болгар, Унгар, Румын улсуудтай тус тус энхийн гэрээг Парис хотноо байгуулсан юм. Улмаар 1948 оны дөрөвдүгээр сарын 6-нд Москвад “Финланд, ЗСБНХУ-ын хооронд Найрамдал, хамтын ажиллагаа, харилцан туслалцах гэрээ” байгуулагдсанаар тус улс Маршаллын төлөвлөгөөний гадна үлдсэн билээ. Энэ гэрээгээр Финланд нь ЗСБНХУ-ын стратегийн онцгой ашиг сонирхлыг хүлээн зөвшөөрч, цэргийн эвсэл холбоонд нэгдэхгүй, нутаг дэвсгэрээ гадаадын цэргийн баазад ашиглуулахгүй байх төвийг сахих үүрэг хүлээж, тийнхүү тусгаар тогтнол, парламентын ардчилал, зах зээлийн эдийн засаг, чөлөөтэй үг хэлэх статусаа хадгалж үлдсэн байна. Үүнийг «Finlandization» хэмээх ажээ. Дээрх гэрээ 1991 онд цуцлагдсан юм.

Австрийн төвийг сахих статуст ч ЗХУ гол үүрэг гүйцэтгэжээ. Дэлхийн II дайны дараа Австри нь холбоотон гүрнүүдийн эзэмшилд байсан бөгөөд 1955 оны дөрөвдүгээр сарын 12-15-нд болсон Зөвлөлт-Австрийн хэлэлцээний үр дүнгээр Москвагийн Меморандум гарчээ.²⁷ Үүгээр Австри нь цэргийн аливаа эвсэлд нэгдэхгүй, нутаг дэвсгэрээ гадаадын цэргийн бүлэглэлд ашиглуулахгүй, бие даасан гадаад бодлого явуулна хэмээн үүрэг хүлээсэн байна. Улмаар 1955 оны тавдугаар сарын 15-нд Вена хотноо Австри болон АНУ, ЗСБНХУ, Их Британи, Францын хооронд Австрийн төрийн бүрэн эрхт байдал, ардчилалыг сэргээн тогтоох тусгаар тогтнолын “Төрийн гэрээ”-г (State Treaty) байгуулжээ.²⁸ Энэ гэрээгээр холбоотон гүрнүүдийн цэрэг тус улсаас гарсан байна. “Төрийн гэрээ”-гээр Австри нь ардчилсан, парламентын засаглалтай, зах зээлийн эдийн засгийн замаар хөгжих болсон юм. 1991 онд Москвагийн Меморандум цуцлагдсан байна. Үндэсний баярын өдөр 1955 оны аравдугаар сарын 26-нд Австрийн “Төвийг

²⁴“Historic agreement by Norway, Sweden, Finland and Denmark on unified air force due to Russian threat” March 24, 2023 <https://newsbulletin247.com/world/295845.html>

²⁵

https://www.academia.edu/342622/The_Triumph_of_Neutrality_Bernadotte_and_European_Geopolitics_1810_1844

²⁶ Swedish intelligence service spying on Russia for US National Security Agency. <https://www.wsws.org/en/articles/2013/12/30/swed-d30.html>

²⁷ Кружков В.А. (2022). *Нейтралитет Австрии. Становление - практика - перспективы*. М.: Аспект Пресс. ISBN 978-5-7567-1198-1.

²⁸ “1955 – State Treaty and Neutrality”. *www.parlament.gv.at*. Retrieved 2018-05-19

сахих хууль”-ийг батлан гаргасан²⁹ бөгөөд арваннэгдүгээр сарын 4-нд Холбооны Үндсэн хуулийн 211 дүгээр зүйл болон хуульчлагдсан байна.³⁰ Гэхдээ их гүрнүүд Австрийн төвийг сахих статуст баталгаа гаргаагүй юм.

Ирланд улс 1930-аад оноос хойш цэргийн салбарт төвийг сахисаар иржээ. Ирландын төвийг сахисан байдлын мөн чанар цаг хугацааны явцад харилцан адилгүй байсан бөгөөд 1970-аад оноос хойш маргаантай байсаар ирсэн. Түүхээс харахад тус улс нь дэлхийн II дайны үед “байлдааны бус” шинжтэй байсан бөгөөд хэзээ ч НАТО-д элсээгүй хэдий ч хүйтэн дайны үед коммунист бус үзэлтэй, бусад орнуудаас хөндийрсөн байдалтай байжээ. Төвийг сахих нь Ирланд ЕХ-ны гишүүнчлэлтэй нийцэх эсэх нь 1990-ээд оноос хойш ЕХ-ны гэрээний асуудлаарх бүх нийтийн санал асуулгын кампанит ажлын үеэр маргаан дагуулсаар ирсэн. Ниццагийн Гэрээний тухай Севиллийн Тунхаглалд Ирландын “цэргийн салбарт төвийг сахих уламжлалт бодлого”-ыг хүлээн зөвшөөрсөн байна.

Ирландын төвийг сахисан байдал болон уламжлалт төвийг сахисан улсуудын хооронд мэдэгдэхүйц ялгаа байдаг. Уламжлал ёсоор төвийг сахисан улсууд өөртөө батлан хамгаалах хүчирхэг хүчийг хадгалдаг. Ирландад 10500 орчим бие бүрэлдэхүүнтэй харьцангуй бага батлан хамгаалах хүчин байдаг байна.³¹

Уламжлал ёсоор төвийг сахисан улсууд нутаг дэвсгэртээ гадаадын ямар ч цэрэг оруулахыг зөвшөөрдөггүй, Ирланд улс янз бүрийн улсын цэргийн нисэх онгоцыг Ирландын Шеннон олон улсын нисэх онгоцны буудалд түлшээр цэнэглэхийг зөвшөөрдөг урт түүхтэй.

Төвийг сахисан улс нь иргэддээ бусад, магадгүй дайтаж буй үндэстний зэвсэгт хүчинд алба хаахыг зөвшөөрдөггүй. Ирланд улс иргэдээ гадаадын армид алба хаахыг хязгаарладаггүй.

Ирландын төвийг сахих байдал нь ерөнхийдөө хууль эрхзүйн шаардлага гэхээсээ илүү засгийн газрын бодлогын асуудал байдаг ажээ. Гэвч Ирланд нь ЕХ-ны батлах хамгаалахын интеграцийн гэрээнд нэгдэн орсноор аанай л цэргийн салбарт төвийг сахих статус нь алдагдсан гэж хэлж болно.

2022 оны хоёрдугаар сарын 24-нд Орос Украиныг эзлэн түрэмгийлсний хариуд Ирландын Засгийн газрын тэргүүн Лео Ерик Варадкар Ирланд улс цэргийн эвсэлд ороогүй ч тус улс энэхүү мөргөлдөөнд “ямар ч байсан төвийг сахихгүй” бөгөөд “Украиныг дэмжих нь гуйвшгүй бөгөөд болзолгүй юм” гэж мэдэгдэж байв.³² Удалгүй Гадаад хэргийн яам Украинд цэргийн тусламж үзүүлэх ЕХ-ны сангаас “бүтээлтэйгээр татгалзаж”, үүний оронд үхлийн бус тусламжийн санд хандив өргөнө гэж мэдэгдсэн юм.³³

2023 оны гуравдугаар сард Ирландын Европын армид гишүүнээр элсэх тухай бүх нийтийн санал асуулга явуулах тухай хуулийн төслийг засгийн газар эсэргүүцэж, “шаардлагагүй” гэж үзжээ.³⁴ Хэдийгээр Гадаад хэрэг, Батлан хамгаалын сайд Майкл Мартин хэрвээ бүх нийтийн санал асуулга явуулбал “өнгөрнө” гэдэгт итгэлтэй байгаагаа илэрхийлж, Ирланд төвийг сахих асуудлаар “эргэн тунгаах” хэрэгтэй гэж мэдэгджээ.³⁵ Дөрөвдүгээр сарын 14-нд АНУ-ын Ерөнхийлөгч Жо Байден Ирландад айлчилж, Гадаад

²⁹ [“Federal Constitutional Law of October 26, 1955 on Austria's neutrality”](#) (PDF).

³⁰ https://www.ris.bka.gv.at/Dokumente/BgblPdf/1955_211_0/1955_211_0.pdf

³¹ Tonra et al. 2012, Preface: [The Study of Irish Foreign Policy p.xix Archived](#) 17 October 2013

³² Burns, Sarah (24 February 2022). [“Ireland is 'not neutral', says Tánaiste as 70 Irish citizens remain in Ukraine”](#). *The Irish Times*. 24 February 2022.

³³ Murphy, David (27 February 2022). [“Ireland 'constructively abstains' from EU arms package”](#). *RTÉ News*. 28 February 2022.

³⁴ Loughlin, Elaine; Hosford, Paul. [“Government to oppose 'unnecessary' bill on holding neutrality referendum”](#). *Irish Examiner*. Retrieved 15 July 2023.

³⁵ Hosford, Paul. [“Ireland needs to 'reflect' on military neutrality — Taoiseach”](#). *Irish Examiner*. 15 July 2023.

хэрэг, Батлан хамгаалахын сайд Майкл Мартинтай биечлэн уулзсан нь Ирланд АНУ болон НАТО-той улам ойртож байгааг *Politico* сэтгүүлд бичжээ.³⁶ Майкл Мартин 2023 оны зургаадугаар сарын 22-оос 27-ны хооронд Зөвлөлдөх форумыг зохион байгуулж, Ирландын батлан хамгаалах хүчний “Гурвалсан түгжээ” системийг³⁷ хянан үзэхийн тулд Ирландын төвийг сахисан байдлыг авч үзжээ.³⁸ Ирландын Ерөнхийлөгч Майкл Д.Хиггинс (Michael D.Higgins) уг форумыг “галаар тоглож байна” гэж няцаажээ.³⁹ Варадкарын чуулга уулзалтын үр дүн Ирландыг НАТО-д элсүүлэхгүй, харин “Ирландын батлан хамгаалах, аюулгүй байдлын бодлогоо хөгжүүлэх ёстой” гэж баталсан байна.⁴⁰ Парламентын гишүүн сөрөг намын (People Before Profit) гишүүн Ричард Бойд Барретт Гадаад хэрэг болон Батлан хамгаалын сайд Майкл Мартинийг “Ирландын төвийг сахих байр сууринаас татгалзахын тулд олон нийтийн санаа бодлыг зөөлрүүлэхийг оролдсон” гэж буруутгаж олон нийтийн дунд маргаан үүсгэж байсан юм.⁴¹

Гэгээн Ширээт улсын статусын онцлог: Гэгээн Ширээт улс, Итали улсын хоорондын харилцааны эрхзүйн статусыг зохицуулсан гэрээний системийг Латераны Пакт (Lateran Pacts) гэдэг. 1870 оны Итали дахь Католик сүм хийдийн эрхзүйн статус, эрх ямбыг хуульчлан тогтоох зэрэг «Ромын асуудал»-ыг (Roman Question) зохицуулах зорилготой хэлэлцээрийг боловсронгуй болгох тухайд 1929 оны хоёрдугаар сарын 11-нд Апостолийн ордны Латераны танхимд Ромын Пап XI Пийн (Pope Pius XI) нэрийн өмнөөс кардинал Пьетро Гаспарри, Италийн Вант улсын III Виктор Эммануэл вангийн нэрийн өмнөөс Ерөнхий сайд Бенито Муссолини нар 27 зүйл бүхий Латераны Пакт, түүний салшгүй хэсэг Санхүүгийн конвенцид гарын үсэг зурж, мөн оны тавдугаар сард Италийн парламентын Доод танхим баталснаар мөн оны зургаадугаар сарын 7-нд хүчин төгөлдөр үйлчилж эхэлжээ.

Гэрээний 1 дүгээр зүйлд Католик шашин бол Италийн төрийн цор ганц шашин гэсэн зарчим мөн болохыг хүлээн зөвшөөрч нотолсон, 2 дугаар зүйлд Гэгээн Ширээт улсын бүрэн эрх, түүний дотор олон улсын үйл ажиллагаанд оролцох эрх, 3 дугаар зүйлд Гэгээн Ширээт улсын нийслэл Ватикан дахь хил хязгаар, бүрэн эрхээ хэрэгжүүлэх статусыг тус тус олон улсын эрхзүйн дагуу баталгаажуулсан байна.⁴²

Гэрээний 24 дүгээр зүйлд «Ватикан хот улс нь тиймээс үргэлж, төвийг сахисан, халдашгүй дархан нутаг гэж тооцогдоно» гэж нотолсон байна.⁴³

Дэлхийн II дайны дараа 1948 оны Италийн шинэ Үндсэн хуулийн 7 дугаар зүйлд Латераны гэрээг хүлээн зөвшөөрсөн байна. Тиймээс Гэрээн Ширээт улс НҮБ-д ажиглагчийн статустай байдаг.

³⁶ Pogatchnik, Shawn. “World needs Biden ‘in time of great danger,’ Irish foreign minister says”. *Politico*. 15 July 2023

³⁷ ‘Triple Lock’ system (Ирландын Батлан хамгаалах хүчин) Ирландын цэргүүдийг гадаадад байршуулах хууль эрх зүйн шаардлага

³⁸ Pepper, Diarmuid. “Tánaiste Micheál Martin is ‘developing proposals’ around Ireland’s neutrality”. *The Journal.ie*. 15 July 2023. Webber, Jude. “Ireland opens debate on future of military neutrality”. *Financial Times*. 15 July 2023

³⁹ O’Connor, Niall. “Tánaiste defends forum as President claims Ireland is ‘playing with fire’ in neutrality ‘drift’”. *The Journal.ie*. 15 July 2023

Downing, John; McTaggart, Maeve. “Tánaiste Micheál Martin strongly rebuffs comments by President Michael D Higgins on military neutrality and foreign policy ‘drift’”. *Irish Independent*. Retrieved 15 July 2023

⁴⁰ Sherlock, Cillian; Black, Rebecca. “Tánaiste ‘developing proposals around neutrality’”. *The Irish Times*. 15 July 2023

⁴¹ O’Halloran, Marie. “Ireland is not neutral about Ukraine, Taoiseach insists in renewed row over constitutional position”. *The Irish Times*. 15 July 2023.

⁴² Lateran Pacts of 1929, Article 1; 2; 3; <http://www.aloha.net/~mikesch/treaty.htm>

⁴³ Lateran Pacts of 1929, Article 24 <http://www.aloha.net/~mikesch/treaty.htm>

1984 оны хоёрдугаар сарын 18-нд Бүгд Найрамдах Итали Улс ба Гэгээн Ширээт улсын хоорондын хэлэлцээрээр 1929 оны Латераны Пактад нэмэлт өөрчлөлт оруулахдаа Гэгээн Ширээт улсын төвийг сахисан статусыг үл хөндсөн юм. Энэ хэлэлцээрийг 1985 оны гуравдугаар сарын 25-нд Италийн парламентын соёорхон баталснаар хүчин төгөлдөр болсон байна.⁴⁴

Туркменистан: Байнга төвийг сахихаа 1995 онд Үндсэн хуулиндаа хуульчлан зарласан улсын сүүлчийн, гэхдээ тун муу жишээ нь Туркменистан болон үлдэж байна. Туркменистаны байнга төвийг сахих статус нь тус орныг олон улсын хамтын ажиллагаа, үйл явдлаас хөндийрүүлж, зожигорход хүргэж, эдийн засаг нь зогсонги, улмаар НҮБ-ын хүрээнд хамгийн идэвхгүй улс болгож, энэ нь тус улсыг улам хаалттай, мөн авторитар дэглэмийг бэхжүүлэхэд улам дэм болсон. Мөн тус орны батлан хамгаалах чадавхи нь ч эрс суларсан байна.

ОХУ-ын тэргүүлэх шинжээч, доктор Ш. Кадыров 2015 оны 6 дугаар сард *EurAsia Daily* агентлагт ярилцлага өгөхдөө: Туркменистан пост-коммунист улсуудаас хамгийн хаалттай, мэдээлэл байхгүй, чөлөөт хэвлэл үгүй, туслалцаа хэзээд хэрэгтэй, холбоотонгүйгээр дайтах боломжгүй, Туркмен-Афганы хил дээр гарч байгаа зөрчлөөс болоод байнга төвийг сахисан орны хувьд НҮБ-д хандах тохиолдол гарвал Афганистанаас дүрвэгсдийг авах шаардлага гарна, энэ нь эргээд угсаатан, хүн амзүйн асуудалд нөлөөлнө, байнга төвийг сахих нь энхтайвны баталгаа гэсэн ид шидийн үлгэртээ ард түмнээ итгүүлсээр байна, хүлэмжийн амьдралтай төвийг сахих бодлого, дэлхийгээс тусгаарлагдсан байдал эрхгүй хоцрогдол мөн. Хэдий хурдан энэ байдлаасаа сална, тэр хэрээр бага хохирол амсана гэжээ.⁴⁵ Каспийн тэнгисийн байгалийн хийн баялаг (45 их наяд шоо метр хийн нөөцтэй Ш.К) нь ч тус орныг хөгжлийн өндөрлөгт хүргэж чадаагүй, дэлхийд дөрөвт орох байгалийн хийн нөөцтэй ч Орос, Хятадад хямдаар нийлүүлж иржээ.

Туркменистан 2008 онд Бухарест хотноо зохиогдсон НАТО-гийн дээд уулзалтад оролцож, Ерөнхийлөгч Гурбангулы Бердымухамедов АНУ-ын Ерөнхийлөгч Ж.Буштай уулзсанаар 2010 оноос 5 жилийн хугацаатай Туркменистаны армийг шинэчлэх хөтөлбөр хэрэгжүүлээд дуусаж байгаа юм. Японы Ерөнхий сайд Шинзо Абэ өнгөрсөн 10 дугаар сарын сүүлчээр Туркменистанд айлчилж, эрчим хүчний салбарт 18 тэрбум ам. долларын хөрөнгө оруулахаа мэдэгдсэн. 2015 оны 11 дүгээр сарын 3-нд АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга Жон Керри Ашхабадад ажлын айлчлал хийж Афганистаны зүгээс учирч болзошгүй терроризмын аюулыг бууруулахад ЕАБХАБ-ын хүрээнд Туркмены мэргэжилтнүүдийг сургах асуудлаар тохиролцов. Ерөнхийлөгч Гурбангулы Бердымухамедов Жон Керритэй уулзахдаа хоёр орны харилцааг «new dynamic relationship» гэж нэрлэв. 2015 оны 11 дүгээр сарын 12-нд Ерөнхийлөгч Гурбангулы Бердымухамедов Бээжинд айлчилж, стратегийн түншлэлийг гүнзгийрүүлж “нэг бүс, нэг зам” төслийн хүрээнд Хятад-Төв Ази-Баруун Азийн эдийн засгийн коридор байгуулах, хий дамжуулах транзит хоолой тавих, “гурван аюул” терроризм, сепаратизм, экстремизм болон олон улсын зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх зэрэг өргөн хүрээтэй асуудлыг хэлэлцэв. Туркменистан БНХАУ-тай 2013 онд стратегийн түншлэлийн харилцаа тогтоосон юм.

ОХУ-ын Украинд цэргийн хүчээр түрэмгийлснийг буруушаасан НҮБ-ын Ерөнхий Ассемблейн 2022-2023 оны 6 удаагийн (2014 оны НҮБ-ын ЕА-н баталсан 68/262 дугаар

⁴⁴ An Agreement between Republic of Italia and Holy amended the Lateran Pacts in 1985.

[Seehttp://home.lu.lv/~rbalodis/Baznicu%20tiesibas/Akti/Arvalstis_ligumi/Italijas&Sv.Kresla_konkordats.pdf](http://home.lu.lv/~rbalodis/Baznicu%20tiesibas/Akti/Arvalstis_ligumi/Italijas&Sv.Kresla_konkordats.pdf)

⁴⁵ Шохрат Кадыров. Нейтральная Туркмения. Война отрезвит и развенчает мифы. 8 июня 2015

<https://eadaily.com/ru/news/2015/06/08/neytralnaya-turkmeniya-voyna-otrezvit-i-razvenchaet-mify-intervyu-shohrata-kadyrova>

тогтоолыг оролцуулбал 7 дахь удаагийнх болно) тогтоолын төслийн санал хуралтад Туркменстан улс огт оролцоогүй (absent) юм.

IV. Монгол Улс төвийг үл сахихүй

НҮБ-ын болон бусад түвшинд хоёр хөрштэй шууд болон шууд бус холбоотой олон улсын харилцаа, геополитикийн нарийн түвэгтэй аливаа асуудалд Монгол Улс үндэсний язгуур эрх ашгийг дээдлэн “төвч” “голч”, “төвийг сахисан” байр суурь илэрхийлэх нь Монгол Улсын өөрийнх нь онцгой бүрэн эрхийн асуудал билээ. Харин дээрхтэй холбогдуулан Монгол Улс “төвийг сахисан олон улсын эрхзүйн статус”-тай болох асуудлыг хөндөж буй нь уг асуудлын зорилго, мөн чанарыг ойлгохгүй байгаагийн илрэл юм. Төвийг сахисан байр суурь, “төвийг сахих олон улсын эрхзүйн статус” гэсэн хоёр тэс өөр эрхзүйн ойлголтыг хооронд нь хольж хутгаж үл болно.

Газарзүйн байршилтай холбогдуулан тухайн улсын хүрээлэн буй геополитикийн хамгийн ойр орчинд хурцадмал байдал гүнзгийрэх, дайн мөргөлдөөн гарч болзошгүй нөхцөл байдал байнга үүсэх магадлалтай үед жижиг, дунд хүчний улс орнуудын өмнө төвийг сахих олон улсын эрхзүйн статусын асуудал хөндөгдөж, их гүрнүүдээс олон улсын баталгаа шаардагддаг.

2015 оны есдүгээр сард “Монгол Улс байнга төвийг сахих тухай бие даасан хуулийн төсөл”-ийг УИХ-д өргөн барьж, түүгээр ч зогсохгүй мөн оны намар Ц.Элбэгдорж ерөнхийлөгчийн хувиар НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 70 дугаар чуулганы ерөнхий санал шүүмжлэлд оролцож үг хэлэхдээ: “Монгол Улс нээлттэй олон тулгуурт гадаад бодлого хэрэгжүүлж ирсэн. Чухамдаа энэхүү бодлого, байр суурь нь Монгол Улсыг байнга төвийг сахисан улс болгон зарлах боломжийг бүрдүүлж байгаа юм. Манай дотоодын хууль тогтоомж, нэгдэн орсон олон улсын гэрээ, хэлэлцээрүүд угтаа төвийг сахих бодлоготой нийцэж байгаа юм. Иймд Та бүхнээс манай улсын энх тайванч, нээлттэй, төвийг сахисан, идэвхтэй гадаад бодлогын хүчин чармайлтыг ойлгож, дэмжихийг хүсч байна. *Монгол Улсын байнга төвийг сахих статус нь бүс нутагт төдийгүй дэлхий дахинд энх тайван, аюулгүй байдал, хөгжил дэвшлийг бэхжүүлэхэд хувь нэмэр болно гэдэгт итгэлтэй байна* (онцлов Д.У)”⁴⁶ гэсэн дэврүүн дүгнэлт хийсэн юм.

УИХ-аар хэлэлцэгдэж, эцсийн шийдвэр гараагүй байхад түүний онцгой бүрэн эрхэд халдаж, Монгол Улсын гадаад бодлого, үндэсний аюулгүй байдалтай шууд хамаатай асуудлаар НҮБ-ын Ерөнхий Ассамблей чуулганд төрийн тэргүүн нь байр сууриа илэрхийлсэн нь энэ байв. Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1-д заахдаа: УИХ төрийн дотоод, гадаад бодлогын үндсийг тодорхойлох бөгөөд энэ нь түүний онцгой бүрэн эрх хэмээн заасан билээ.⁴⁷

2015 оны есдүгээр сарын сүүлчээр УИХ-ын дарга З.Энхболдын ОХУ-ын Холбооны Зөвлөлийн урилгаар айлчлал хийх үеэр ОХУ-ын парламентад зочилоход ОХУ-ын парламентын Дээд танхим Холбооны хурлын Холбооны Зөвлөлийн дарга В.И.Матвиенко бээр хэлэхдээ: “Ерөнхийлөгч Элбэгдоржийн ярьж буй “байнга төвийг сахих” санаачилгыг та бүхэн ярилцаад санал нэгдэн зарлаж байгаа юу? Энэ юу болохыг ойлгож байгаа гэж найдаж байна. Төвийг сахина гэдэг бол ямар ч стратегийн түншлэл байхгүй гэсэн үг”⁴⁸ гэж шуудхан хэлж байсан нь чухамдаа зөв зүйтэй байр суурь байсан юм.

2015 оны НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 70 дугаар чуулганы үеэр Гадаад хэргийн сайд Л.Пүрэвсүрэн ОХУ-ын Гадаад хэргийн сайд С.Лавровтэй уулзах үеэрээ дээрх байр

⁴⁶ https://www.un.int/mongolia/statements_speeches Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 70 дугаар чуулганы Ерөнхий санал шүүмжлэлд хэлсэн үг 2015.09.29

⁴⁷ Монгол Улсын Үндсэн хууль. УБ., 1992, 13 дахь тал

⁴⁸ Монгол Улс байнга төвийг үл сахих нь (Эрхэлсэн Др.проф.Д.Уламбаяр). УБ., 2016, 86 дахь тал

сууриа нотлож, тайлбарлаж чадаагүй байна. Түүнчлэн НҮБ-ын Ерөнхий Ассемблейн тус чуулганы үеэр ОХУ-ын ГХЯ-ны төлөөлөгчид “*Та нар ямар зорилтготой ийм санал гарган ирж байгааг бид сайн ойлгохгүй байна*” гэж Монголын төлөөлөгчдөд хэлж, улмаар “*Хэрвээ та нар энэ асуудлаар НҮБ-ын Ерөнхий Ассемблейгаар тогтоолын төсөл батлуулах гээд ороод ирэх юм бол бид хатуу байр суурьтай байна*” гэсэн утга бүхий хоёр хуудас баримт бичгийг гардуулж өгсөн байх бөгөөд тэрхүү баримттай танилцаж байснаа Гадаад хэргийн сайд асан ахмад дипломатч Л.Эрдэнэчулуун тэмдэглэсэн байдаг.⁴⁹

Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн БНХАУ-д хийсэн албан ёсны айлчлалын үеэр 2015 оны арваннэгдүгээр сарын 11-нд Бээжинд гарын үсэг зурсан Монгол Улс, БНХАУ-ын Хамтарсан Мэдэгдэлд: “Монгол Улсын байнга төвийг сахих” санаачилгыг дэмжүүлж чадаагүй. Энэ үеэр ЕТГ-ын дарга П.Цагаан нь CCTV News-World Insight оролцоходоо ч байр сууриа тодорхой тайлбарлаж чадаагүй юм.⁵⁰

Өөр нэг зүйлийг тэмдэглэхэд, Монгол Улсын байнга төвийг сахих санаачилгыг АНУ-ын заавраар хийгдэж буй үйлдэл байж магад хэмээн болгоомжилсон дүгнэлт бодол, санал 2016 оны наймдугаар сард зохиогдсон ОУМЭ-ийн XI их хурлын үеэр өмнөд хөршийн төлөөлөгчдийн тавьсан илтгэлд ажиглагдаж байсан нь анхаарах асуудал байв.⁵¹ Гэтэл АНУ-ын байр суурь тэс өмнөө байв. АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга Жон Керри 2016 оны 6 дугаар сард Монголд айлчлал хийх үеэр Шангри-Ла зочид буудалд монголын залуу манлайлагч нарын төлөөлөлтэй уулзаж харилцан ярилцахдаа төвийг сахихын эсрэг байр суурьтай байгаагаа маш тодорхой илэрхийлсэн юм.⁵²

Байнга төвийг сахин суугаад хэрхэн, яаж олон тулгуурт гадаад бодлого явуулах вэ? Байнга төвийг сахих тухай хуулийн төсөл санаачлан УИХ-д өргөн мэдүүлж, улмаар Монгол Улсын Үндэсний аюулгүй байдал, Гадаад бодлогын үзэл баримтлалд өөрчлөлт оруулж, түүнийгээ хөрш хоёр гүрэн болон олон улсаар хүлээн зөвшөөрүүлэх гэж оролдсон нь гадаад бодлогын нэгдмэл байдал, залгамж чанарыг алдагдуулахаар үйлдэл байв.

«Байнга төвийг сахих статус» энхийг эрхэмлэсэн, олон тулгуурт гадаад бодлого, «гуравдагч хөрш»-ийн бодлого, идэвхтэй гадаад бодлогын баримтлалтай шууд зөрчилддөг.

Монгол Улс хоёр хөрштэйгөө “иж бүрэн стратегийн түншлэл”-ийн эрхзүйн үндсийг баттай тавьсан. Монгол Улсын “гуравдагч хөрш”-ийн бодлогын хамгийн том сорилт нь хоёр хөрш, “гуравдагч хөрш” гүрнүүдийн хоорондын геополитик, гео-эдийн засгийн сөргөлдөөн болж байна. Үндэсний язгуур эрх ашгийг хөндөөгүй хоёр хөрш хийгээд “гуравдагч хөрш” гүрнүүдийн хоорондын геополитикийн сөргөлдөөнд Монгол Улс аль нэгний талд орж өрөөсгөл байр суурь баримтлахгүй.

Их гүрнүүдийн аливаа сөргөлдөөнд Монгол Улс төвийг сахисан голч, төвч байр суурь илэрхийлж буйг “төвийг сахих олон улсын эрхзүйн статус”-тай хольж хутгаж үл болно.

Аливаа улсын хүрээлэн буй геополитикийн хамгийн ойр орчинд хурцадмал байдал гүнзгийрэх, дайн мөргөлдөөн гарч болзошгүй нөхцөл байдал байнга үүсэх магадлалтай үед л төвийг сахих олон улсын эрхзүйн статусын асуудал хөндөгддөг. Манай хоёр хөршийн харилцаа түүхэнд байгаагүй “бал сар” дээрээ явж байна гэж олон

⁴⁹ Л.Эрдэнэчулуун: “ГХЯ хариуцлагаа хүлээж энэ алдаагаа засах ёстой”- 2017.10.03

<http://www.mnb.mn/i/123747>

⁵⁰ CCTV News - World Insight. November 10, 2015 <http://cctv.cntv.cn/lm/worldinsight/video/index.shtml>

⁵¹ Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн ивээл дор “Тогтвортой хөгжил ба Монгол судлал” сэдэвт олон улсын монголч эрдэмтдийн их хурал. Илтгэлийн товчлолууд. УБ.: 2016

⁵² Secretary Kerry’s Conversation With Young Leaders, Remarks John Kerry Secretary of State, Shangri La Hotel, Ulaanbaatar.: Mongolia, June 5, 2016, Embassy of the US, Ulaanbaatar.: Mongolia

улсын төдийгүй өөрсдийнх нь шинжээчид тэмдэглэдэг. Өөрөөр хэлбэл хоёр хөршийн хооронд “иж бүрэн стратегийн харилцан ажиллагааны түншлэл” (comprehensive strategic interaction partnership) бүх салбарт идэвхтэй, эрчимтэй хөгжиж цар тахлын үед ч, Орос, Украины дайны үед ч худалдааны эргэлт нь тууштай өсч, 2023 оны эцэст 240 тэрбум ам. долларт хүргэв.⁵³ Мэдээж ЕХ-тай (856.3 тэрбум ам. доллар⁵⁴) харьцуулахад 4 дахин, АНУ-тай харьцуулахад (690 тэрбум ам.доллар⁵⁵) 3 дахин бага тоо юм. Өөрөөр хэлбэл Монгол Улсын гадаад хамгийн ойр орчин тайван байна гэж хэлж болох юм. Монгол Улс хоёр хөрштэйгээ тэнцвэртэй харьцаж, иж бүрэн стратегийн түншлэлийн эрхзүйн үндсийг баттай тавьж, гурван хөршийн хамтын ажиллагааны форматыг шинээр эхлүүлсэн. Ийм байсаар байхад дурьдсан саналыг 2015 оны намар дэвшүүлж бүр бие даасан хуулийн төслийг УИХ-д өргөн барьж байсан. Тухайн үед Монгол Улс байнга төвийг сахих тухай санаачилгыг Орос, Хятад дэмжээгүй. 2016 оны Ази-Европын дээд түвшний Улаанбаатарын АСЕМ-ХI уулзалтад оролцогчид ч дэмжээгүй. Хоёр хөрш баталгаа гаргаж өгөх ч үгүй. Үүнийг практик харуулсан.

Солонгосын хойгийн *status quo* хүйтэн дайн дууссанаас хойш шийдвэрлэгдэж чадалгүй тунаж үлдсэн цорын ганц цэг, цөмийн дайн, зэвсэгт мөргөлдөөн гарах магадлал буй. Солонгосын хойгийн хурцадмал байдал ноцтой даамжирвал Өмнөд Солонгост ажиллаж, сурч, амьдарч буй 58 гаруй мянган монгол иргэдийн⁵⁶ аюулгүй байдлын асуудал шууд хөндөгдөнө. Тиймээс Солонгосын хойгийн аюулгүй байдал Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын нэг хэсэг болсон гэж үзэж байна.

Гадаад улс оронд ажил эрхэлж буй иргэдийн эх орон руугаа гуйвуулдаг валютын 2022 оны нэгдсэн тайланг 2022 оны сүүлчээр Дэлхийн банкны Шилжилт хөдөлгөөн ба хөгжлийн мэдээллийн тайланг гаргасан байдаг.⁵⁷ Монголчууд 1998 оноос хилийн чанадаас мөнгө шилжүүлж эхэлснийг дээрх тайланд өгүүлжээ. Тухайн жилд зургаан сая, 2000 он хүртэл арван сая ам. доллараас бага хэмжээний мөнгө шилжүүлж байсан бол үүнээс хойш тасралтгүй нэмэгдэж иржээ. 2022 оны арваннэгдүгээр сарын байдлаар гадаад орнуудаас Монгол руу шилжүүлсэн иргэдийн мөнгөн дүн 500 сая ам. доллараар хэмжигдэж байгаа нь ДНБ-ий 3.2 хувьтай тэнцэж байна. Монгол Улсын тухайд 2020 оны хүн амын тооллогоор гадаадад оршин суугаа иргэн 122,301 байгааг Үндэсний статистикийн хороо танилцуулж байсан. Тэдний 58 хувь буюу хоёр хүн тутмын нэг нь Ази-Номхон далайн бүс нутагт амьдарч ажиллаж байна гэсэн судалгаа гаргаж байжээ.⁵⁸ Тиймээс БНСУ-аас Монгол руу гуйвуулж буй мөнгөн хөрөнгө жилд дунджаар 250-300 сая ам.доллар болж байна. Энэ нь улс орны нийгэм-эдийн засаг, айл гэрийн аж амьдралд маш чухал нөлөө үзүүлж байна.

Орчин үеийн олон улсын эрхзүй түрэмгий дайныг хориглосон учир өөрийгөө хамгаалахаас бусад зорилгоор дайн өдөөх нь олон улсын эрхзүйг зөрчсөн гэмт үйлдэл гэж үздэг. **Цөмийн дайнд төвийг сахина гэсэн ойлголт бүр ч байхгүй.** Энэ бол нийт

⁵³ China-Russia 2023 trade value hits record high of \$240 bln - Chinese customs By Reuters January 12, 2024 <https://www.reuters.com/markets/china-russia-2023-trade-value-hits-record-high-240-bl-chinese-customs-2024-01-12/#:~:text=>

⁵⁴ https://policy.trade.ec.europa.eu/eu-trade-relationships-country-and-region/countries-and-regions/china_en

⁵⁵ <https://ustr.gov/countries-regions/china-mongolia-taiwan/peoples-republic-china>

⁵⁶ <https://www.mlsp.gov.mn/> Яамны мэдээлэл. 2024.02.01

⁵⁷ Remittances Grow 5% in 2022, Despite Global Headwinds <https://www.worldbank.org/en/news/press-release/2022/11/30/remittances-grow-5-percent-2022>

India on track for record \$100 billion in remittances, says World Bank <https://edition.cnn.com/2022/12/01/business/india-remittances-record-2022-world-bank-intl-hnk/index.html#:~:tex>

⁵⁸ Гадаадад байгаа монгол иргэд 2022 онд \$500 саяыг эх орон руугаа шилжүүлжээ. 2022.12.02 <https://ikon.mn/n2qhi>

хүн төрөлхтний эсрэг, хүний эрх, үндсэн эрх чөлөө, ардчилалын эсрэг хийж буй ноцтой гэмт үйлдэл мөн.

Гадаад бодлогыг хуулиар зохицуулахгүй, гадаад бодлогоор туршилт явуулж болохгүй, мөн туршилага судалж төвийг сахихгүй.

Монгол Улс төвийг сахисан эрхзүйн олон улсын статустай болсон тохиолдолд эрхзүйн маш том үр дагавартай, *нэгд*, Үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын болон Гадаад бодлогын үзэл баримтлалд суурь өөрчлөлт орно. *Хоёрт*, Хоёр хөрштэй тогтоосон иж бүрэн стратегийн түншлэл, “гуравдагч хөрш” орнуудтай тогтоосон стратегийн болон иж бүрэн түншлэл, түүнчлэн өргөн хүрээтэй, өргөтгөсөн түншлэлийн баримт бичгүүдийг эргэж харах шаардлагатай болно. *Гуравт*, хөрш болон бусад их гүрнүүдийн баталгаа шаардлагатай, Их гүрний баталгаагүйгээр энэхүү статус зүгээр л цаас болно. *Дөрөвт*, гадаад худалдаа-эдийн засгийн хамтын ажиллагаа хумигдаж, өөрийн хүчинд түшиглэх шаардлагатай болно. *Тавд*, Бид байнга төвийг сахиснаар НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд оролцох боломжгүй болно. Батлан хамгаалах салбарын хоёр болон олон талт харилцаа, хамтын ажиллагаа зогсоно. Монгол Улс төвийг сахиснаар гадаад бодлого идэвхигүй сул, олон хэмжээст манёвр хийх боломжгүй, хайрцлагдана. Олон тулгуурт, нээлттэй гадаад бодлого хязгаарлагдана.

“Монгол Улс байнга Төвийг сахих хууль”-ийн төслийг УИХ-ын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаан хэлэлцээд хуулийн төслийг санаачлагчид нь буцаах нь зүйтэй гэсэн дүгнэлт гаргасныг 2016 оны арваннэгдүгээр сарын 16-ны УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаан бүрэн дэмжсэн нь⁵⁹ үндэсний аюулгүй байдлын эрх ашигт нийцсэн нэн чухал үйл болсон. Цаашлаад 2017 оны Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн дараа шинээр зохион байгуулагдсан Үндэсний аюулгүй байдлын Зөвлөлийн Нарийн бичгийн даргын газар “Монгол Улс байнга төвийг сахих санаачилгыг дэмжсэн ҮАБЗ-ийн 2015 оны есдүгээр сарын 8-ны өдрийн 39/21 дүгээр зөвлөмж”-ийг 2018 оны хоёрдугаар сарын 2-нд, ҮАБЗ-ийн есдүгээр сарын 8-ны өдрийн 39/21 дүгээр зөвлөмж”-ийг хэрэгжүүлэх тухай Монгол Улсын Засгийн газрын 2015 оны есдүгээр сарын 14-нд баталсан 375-р тогтоолыг У.Хүрэлсүхийн Засгийн газар 2020 оны тавдугаар сарын 6-нд тус хүчингүй болгож, Монгол Улс байнга төвийг сахих талаарх бодлогыг дахин сурталчлахгүй байх арга хэмжээ авахыг Гадаад харилцааны сайдад үүрэг болгосон нь⁶⁰ Монгол Улсын үндэсний язгуур эрх ашигт нийцсэн туйлын зөв зүйтэй шийдвэр байв. Тиймээс түүнийг дахин сөхөх шаардлагагүй. Төвийг сахихтай холбоотой “хавтас хэрэг” хаагдсан.

2023 оны эхээр Монгол Улсын ерөнхийлөгч агсан Н.Энхбаяр Монгол Улс төвийг сахисан олон улсын эрхзүйн статустай байх бодлого баримталж, түүнийгээ албан ёсоор зарлаж, хөрш гүрнүүдээс баталгаа авах боломжтой тухай онцлох болж, түүгээр зогсохгүй өөрийн санаачлан боловсруулсан шинэ Үндсэн хуулийн төсөлдөө дээрх санаагаа тусгах байр сууриа илэрхийлж байсан. Энэ нь аанлай л нийгмийг талцуулахад хүргэж байсныг онцлон тэмдэглэх хэрэгтэй. Болзошгүй аюулыг мэдэрсэн учраас Украин төвийг сахихаас татгалзаж, Швед, Финланд улсууд төвийг сахих статусаа хүчингүй болгож, 2022 оны 5 дугаар сард НАТО-д элсэхээр шийдсэн. Гэтэл ямар аюул заналыг мэдэрчихээд Монгол Улс төвийг сахих шаардлагатай болов?

V. Төгсгөл

ОХУ, Монгол Улсын холбоотны харилцаа үгүй болж, шинээр иж бүрэн стратегийн түншлэлийн харилцааны эрхзүйн үндсийг хэдий ч Монголын «*Buffer State*»-ын гүйцэтгэдэг геополитикийн үүрэг хэвээр, нөгөө талд XXI зуунд Өмнөд хөршийн эдийн

⁵⁹ Байнга төвийг сахих хуулийн төслийг санаачлагчид нь буцаав. 2016.11.17

<https://www.montsame.mn/read/38373>

⁶⁰ Монгол Улсын Засгийн газрын тогтоол. Дугаар 162, Тогтоол хүчингүй болгох тухай. 2020.05.06

засаг үсрэнгүй хөгжих болсон нь сайхь улс геополитик, гео-эдийн засгийн нөлөөний хүрээгээ өргөжүүлэх өргөн боломжтой болж байгааг Өрнөдийн судлаачид «*China Threat*» хэмээн нэрлэдэг нь онход үндэслэлгүй зүйл биш юм. Монгол Улсын гадаад бодлого, түүний шийдвэр гаргах ажиллагааны шинжлэх ухаан-онол аргазүйн үндсийг улам бүр боловсронгуй болгох шаардлагатай.

XXI зуунд жижиг улсын гадаад бодлого илүү прагматик, олон улсын эрхзүйн үүднээс илүү уян хатан, харилцан ашигтай, хамтаар хожихуйц, хамтдаа ашиг хүртэх, идэвхтэй, манёвр хийх чадвар сайтай, нээлттэй, тууштай, олон хэмжээст, сюрприз багатай, тогтвортой, дасан зохицох чадавхтай, идэвхтэй тоглогч байх ёстой болов уу. Жижиг улсын идэвхтэй гадаад бодлого бол өөрөө батлан хамгаалах чухал арга хэрэгсэл болдог.

Харилцан хамаарал гүнзгийрч, даяаршлын үйл явц биднээс шалтгаалахгүй эрчимтэй гүнзгийрч буй өнөөд үед түншлэл, холбоотны харилцаагүй, гадны тусламж дэмжлэггүй, бие даан хөгжих, үндэсний аюулгүй байдлаа хангах боломжгүй.

Монгол Улс идэвхтэй гадаад бодлого явуулснаар бүс нутгийн төдийгүй дэлхийн энхтайван, аюулгүй байдлыг бэхжүүлэх, хөгжил дэвшилд тус дөхөм үзүүлнэ.

THE EUROPEAN SECURITY ISSUES: THE END OF THE INTERNATIONAL LEGAL STATUS OF NEUTRALITY

Sc.D. prof. D.Ulambayar
ulambayar@humanities.mn

Abstracts: At the present, the world continues to be uncertain and unpredictable in its geopolitical environment, and the threat of nuclear weapons remains a real factor. Russia's aggression against Ukraine has pushed the world into an energy, fuel, and food crisis, and directly related inflation and price increases continue to have a serious negative impact on the livelihoods of people in developing and developed countries. The general appearance of the territory of Eastern Ukraine became indistinguishable from the ashes of the World War II. Russia also began to openly announce its intention to change the borders of Europe.

In this article talks about Russia's aggression against Ukraine, a completely new situation in the peace and security in Europe has arisen, which has led to the impossibility of Ukraine's neutrality, and moreover, the cancellation of the international status of neutrality by Sweden and Finland, which creates the conditions for NATO membership.

The article also mentions that PESCO, which was signed in November 2017 to integrate the defense sectors of the EU member states, was the first step towards revoking the neutrality status.

- Hu, G. (2005). English language education in China: Policies, progress and problems. *Language Policy*, 4(1), 5-24.
- Su, Y. (2011, December 19). Retrieved from <http://learning.sohu.com/20090326/n263029186.shtml>
- Yue, X. Z. (2010, July 31). *A blueprint for educational modernization*. Retrieved from People's Daily: http://www.moe.edu.cn/publicfiles/business/htmlfiles/moe/moe_2862/201010/109029.html
- Tsegay, S. Z. (2018). Socio-cultural adjustment experiences of international students in Chinese higher education institutions. *Millennial Asia*, 9(2), 183-202.
- Chan, D. &. (2008). University restructuring in East Asia: Trends, challenges and prospects. *Policy Futures in Education*, 6(5), 641-652.
- Lin, P. L. (2019). Internationalization of Higher Education in China: Challenges and Opportunities.

- Zha, Q. (2020, July 31). *Rebranding China's internationalisation of higher education*. Retrieved from <https://eastasiaforum.org/2020/07/31/rebranding-chinas-internationalisation-of-higher-education/>
- Galina V, P. (2018). *Internationalization of Higher Education of China*. San Gregorio.
- Zheng Chun, Y. Y. (2020). New progress and enlightenment of higher education internationalization in Japan. *Study on Higher Education*, 38(06), 80-83.
- Li, Y. (2023). Comparative Study on the Internationalization of Higher Education in China and Japan. *Journal of Education, Humanities and Social Sciences*, 17, 179-184.
- Guihong, Z. (2020). Cooperation between China and the UN and the multilateral promotion of the "Belt and Road". *Journal of Fudan University (Social Science Edition)*, 5, 168-178.
- Hailing, Z. R. (2021). The reference significance of the internationalization development practice of Japanese higher education to China. *Journal of Chifeng University (Chinese Philosophy and Social Science Edition)*, 06, 77-81.
- Hailing, Z. R. (2021). he reference significance of the internationalization development practice of Japanese higher education to China. *Journal of Chifeng University (Chinese Philosophy and Social Sciences Edition)*, 6, 77-81.
- Agawa, N. (2011). The Internationalization of Japan's Higher Education: Challenges and Evolutions. *Reperes*.
- Rose, H. &. (2017). Japan's English-medium instruction initiatives and the globalization of Higher education. *Higher Education*, 71(1), 111-129.
- Ota, H. (2018). Internationalization of Higher Education: Global Trends and Japan's Challenges. *Educational Studies in Japan: International Yearbook*, 91-105.
- Nazarbayev, N. (2017). Third Modernization of Kazakhstan.
- Sperduti, V. (2017). Internationalization as westernization in higher education. *Journal of Comparative & International Higher Education*, 9(Spring), 9-12.
- Abdeljalil Akkari, A. S. (n.d.). Internationalization of Higher Education in Kazakhstan: from political will to implementation. 2023.
- Maudarbekova, B. (2015). Development of the Internationalization Process in Higher Education of Kazakhstan. *Mediterranean Journal of Social Sciences*, 6(5).

SPSIRPA FORUM 2024

Session 8-1

Public policy



Төрийн бодлого

Проф. Др.Н. Бурмаа

МУИС-н УТСОУХНУС Нийтийн удирдлагын тэнхим

Абстракт

Удирдахуйн шинжлэх ухаанд тэсвэр, хатуужил, дасан зохицолт ач холбогдолтой болсноор хямрал, өөрчлөлтөд төрийн удирдлагын системчилсэн арга хэмжээний цогц бодлого хэмээх ойлголтыг дэлгэрүүлсэн. Төрийн удирдлагын уян хатан байдлын үзэл баримтлал нь хүрээлэн буй орчны динамик нөхцөлд үүссэн тодорхойгүй байдал, бэрхшээлийг даван туулах хандлага гэж үздэг. Орчин үеийн төрийн бодлогын үзэл баримтлалд форсайт буюу урьдчилан харах аргыг ашигласнаар зөвхөн ирээдүй рүү чиглэх бус харах ирээдүйгээс буцах арга хэрэгслийг ашиглах боллоо. Төрийн бодлогын буцаж харах буюу форсайт нь уламжлалт богино, дунд, урт хугацааны бодлогын арга хэрэгсэлтэй салшгүй уялдаатай тул системийн түвшинд нарийвчлан авч үзнэ. Систем нь юмс үзэгдлийн харилцан үйлчлэл бүхий элементүүдийн багцын хангалттай шинж чанаруудыг агуулан тэнцвэрт байдлаа хадгалахын зэрэгцээ оршин тогтнол, аюулгүй байдлаа хадгалах хуульд захирагддаг тул бодлогын арга хэрэгсэлтэй салшгүй холбоотой. Ихэнх шинжлэх ухаанд уян хатан гэдэг нэр томъёо нь системтэй холбоотой. Гадны сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэн системийн үйл ажиллагааг алдагдуулалгүй нөлөөлөлд дасан зохицох, тэдгээр нь “шинэ шилжилт” хийх тохиолдолд засч залруулах боломж юм. Уян хатан байдлын "хяналт" -ын үүргийн нөлөө үнэмлэхүй биш, амжилт нь тодорхой бус байсан ч нөлөөлөх боломжийг олгодог" гэж тодорхойлдог.¹

Бодлого зохиогдох анхны нөхцөл байдал, саад бэрхшээл эсвэл зорилтот нөхцөл байдлыг өөр өнцгөөс “харах”-аас эхэлж болно. Хэрэгжүүлж буй бодлого нь хүмүүс болон нийгэм, хүрээлэн буй орчны зүгээс гарах гэнэтийн үйлдлээс саатах эсвэл саармагжсанаар бодлогод эсэргүүцлийг бий болгодог. Бодлогын өгөгдлийг өндөр үр өгөөж бүхий бодлого, сэтгэлгээний цар хүрээг өргөжүүлж, эргэх холбооны мөн чанарыг нарийн ойлгох шаардлагатай. Үүний нэгэн шалтгаан нь аливаа үзэгдлийг

¹<https://oimurschool.ru/mn/otnosheniya/vozmozhnye-puti-korrekcii-zhiznesteikosti-i-udovletvorennosti-zhiznyu/> 2022 оны Арван хоёрдугаар сарын 5, өдөр ашигласан.

тайлбарлахдаа түүнийг үргэлжилсэн дэс дараалал бүхий үйл явц гэж үздэг нь асуудал юм. Төрийн бодлогын урьдчилан харах буюу форсайт аргачлалыг уламжлалт аргачлалтай хослуулан хэрэглэснээр бодлогын бодит хэрэгжилтийг бий болгоно.

Төрийн бодлого

Форумд оролцогчид энэ өдрийн мэндийг хүргэе.

- Монгол Улсын хөгжлийн бодлого ирээдүйг урьдчилан төлөвлөж байна уу ?

асуулгаар илтгэлээ эхэлж байна. Ирээдүйг урьдчилан “харсан” стратеги бүхий төрийн бодлого нь улс орны байгаль, нийгэм, эдийн засаг, хүн ам, технологийн хөгжлийн бодлогын макро төвшнөөс микро түвшин хүртэл холбогддог нарийн цогц системт тогтолцоо. Энэхүү илтгэлд:

Peter Knoepfel: Public policy resources 2018, В.Л. Kvint: Стратеги боловсруулах концепц 2019, Д.Бадарч: Системийн сэтгэлгээ 2014, Дэлхийн эдийн засгийн форумын тайлан 2023 Улаанбаатар “хот төлөвлөлтийн тайлан” 2019 он, 2023 оны зун Улаанбаатар хотод болсон үерийн гамшгийн мэдээлэл –Улаанбаатар хот 2023 зэрэг эх үүсвэрийг ашигласан болно.

Онолын хувьд:

- **Резиленс- уян хатан, тэсвэртэй байдал**
- **Системийн онол**
- **VUCA онол**
- **Төрийн бодлого -форсайт авч үзсэн болно.**


Резиленс: “уян хатан”, тэсвэртэй, дасан зохицох агуулгаар шинжлэх ухааны олон салбаруудад хэрэглэгддэг.

Удирдахуйн шинжлэх ухаанд тэсвэр, хатуужил, дасан зохицолт ач холбогдолтой болсноор хямрал, өөрчлөлтөд төрийн удирдлагын системчилсэн арга хэмжээний цогц бодлого хэмээх ойлголтыг дэлгэрүүлсэн.

- Төрийн удирдлагын уян хатан байдлын үзэл баримтлал нь хүрээлэн буй орчны динамик нөхцөлд үүссэн тодорхойгүй байдал, бэрхшээлийг даван туулах хандлага гэж үздэг.
- Систем нь юмс үзэгдлийн харилцан үйлчлэл бүхий элементүүдийн багцын хангалттай шинж чанаруудыг агуулан тэнцвэрт байдлаа хадгалахын зэрэгцээ оршин тогтнол, аюулгүй байдлаа хадгалах хуульд захирагдана.

- Систем өөрийн тэнцвэрт байдлаа хадгалан оршин тогтнох хил хязгаартай боловч нийтийн удирдлагын шинжлэх ухааны хамрах хүрээг тодорхойлоход бэрхшээлтэй.

1. Зураг Нийтийн удирдлага нь системт шинжлэх ухаан мөн.



Нийтийн удирдлагын үндэс Улаанбаатар хот 2018.

VUCA-ертөнцийн мөн чанар: АНУ-ын цэргийн боловсролын институт болох (Army War College)-ын номын сангийн архивын 1987-1991 онд бүтээлүүдэд volatile, uncertain, complex, ambiguous орчны талаар дурдагдсан байв. 1990-ээд оноос АНУ-ын цэрэг армид VUCA ойлголтыг өргөн хүрээтэйгээр дайны дараах дэлхийн төлөв байдлыг дүрсэлсэн бөгөөд үүнд хариу үйлдэл үзүүлэх шинэ стратеги шаарддаг болсон тухай бичиж байв. Эрдэмтэн Bob Johansen 2007 онд VUCA нөхцөл байдлын талаар тодорхой бичиж байсан бол 2017 онд Bill George; Zeger Van der Wal нар VUCA шилжилт буюу VUCA 2.0 талаар судалгааны үр дүнд суурилсан бүтээлүүдээ дурьдсан. Хожим нь бизнесийн өөрчлөлтийн хурд урьд өмнөхөөсөө илүү эрчимтэй болж, эрдэмтэд, удирдах

албан тушаалтнууд, удирдагчид байгууллагуудад тулгарч буй сорилтын нэр томьёог VUCA "шинэ хэвийн" нэрлэж байв.

Дэлхий ертөнц улам л тодорхой бус, үймээн самуунтай болж, өдөр бүр шинэ өөрчлөлтүүд болж байна. Олон улсад болж өнгөрсөн эдийн засгийн хямралын сургамжийн дараа 2010 оноос хойш иргэдийн сайн сайхны төлөө үйл ажиллагаагаа аль оновчтой сайн биелүүлэх төрийн байгууллагыг хэрхэн шинээр зохион байгуулах вэ гэдэг асуудалд илүү их анхаарал хандуулсаар байна. Энэ цаг үетэй давхцан хүн төрөлхтөн түүхэндээ дараа дараагийн ер бусын нөхцөл байдалтай тулгарсаар байгаа эрс тэс өөр нөхцөл байдлын шалгарлыг бий болгосон өөр хямралд орсоор байна. Олон улсад эрдэмтэд судлаачид, бүхий л салбар түвшний мэргэжилтнүүд энэ динамик орчныг хувьсамтгай, тодорхойгүй, нарийн төвөгтэй, тодорхой бус VUCA-ертөнц хэмээн илэрхийлдэг товчилсон нийтлэг нэрээр ойлгон тайлбар өгч байгаа билээ. VUCA-тай холбоотой гарсан судалгааны бүтээл, нийтлэлүүд нь VUCA нөхцөл байдлыг даван туулахад шаардлагатай бэлтгэл ажилд төр, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагын стратеги хөгжил, хүний нөөцийн удирдлагын чухал үүргийг онцгойлон сануулсан. Улс орнуудын хувьд VUCA ертөнцөд оршин тогтнох, хөгжихийн тулд улс орон, төрийн байгууллага, стратегийн ямар хариу арга хэмжээ авах бодлогын шийдвэр, хэрэгжүүлэх чадвар нь сорилт болон боломжийг олгодог. Түүнчлэн янз бүрийн байгууллагуудын онцлог, удирдлагын арга барил, стратеги нь тодорхойгүй нөхцөлд хэрхэн уян хатан байдлаар зохицон ажиллах, ямар асуудалд голчлон анхаарах, стратеги, суралцагч байгууллага, уян хатан баг, багийн ажиллагаа, сэтгэлгээний өөрчлөлт хэр чухал болох, шийдэл гаргалгааны хувилбаруудын онцлогийг тусгайлан авч үзэх нь зохилтой. VUCA нь хувьсамтгай, тодорхойгүй, нарийн төвөгтэй, эргэлзээтэй гэсэн дөрвөн бүрэлдэхүүн хэсгээр тодорхойлогддог тухай дээр дурьдсан бөгөөд онолын хүрээнд эрдэмтэн судлаачид хэрхэн тайлбарласныг авч үзье.

Эхний элемент болох **volatility буюу "хувьсамтгай байдал"** нь тодорхойгүй хугацаанд тогтворгүй, гэнэтийн нөхцөл байдлыг илэрхийлдэг. Тогтворгүй нөхцөл байдал нь мэдлэг дутмаг эсвэл бүтцийн нарийн төвөгтэй байдлыг илэрхийлдэггүй; харин энэ нь ихэвчлэн тасралтгүй хэлбэлзлийг илэрхийлнэ. (Bennett & Lemoine, 2014). Хувьсамтгай байдал нь ихэвчлэн хувьцааны үнэ, газрын тос, ховор элементүүд зэрэг барааны эрэлт нийлүүлэлтэд илэрдэг. Гэсэн ч тогтворгүй нөхцөл байдал нь VUCA нөхцөл байдал гэж андуурч болохгүй. Учир нь системийг бүрдүүлэгч бусад элементүүд байхгүй тул эдгээр

байдлын цаад шалтгаан нь нууц биш байж болно. Үүнийг түүхээс судалж мэдэх эсвэл одоо байгаа мэдээллээс зөвхөн урьдчилан таамаглах л боломжтой.

Uncertainly буюу "тодорхой бус" байдал нь шалтгаан, үр дагавар нь мэдэгдэж байгаа хэдий ч нөхцөл байдлын ач холбогдлын талаархи мэдлэг дутмаг байгаа үе шатыг тодорхойлоход хэрэглэгддэг. Тогтвортой бус байдлын өсөлтөөс шалтгаалан өгөгдөл нь мөн тасралтгүй өөрчлөгддөг тул тодорхойгүй байдлын түвшин өндөр. Тодорхойгүй байдлын түвшин өндөр байх магадлал нь улс төрийн үймээн (дайн) -аас үүдэлтэй байж болно; засгийн газрын бодлогын өөрчлөлт (төсвийн бодлого, худалдааны хязгаарлалт, үнийн хяналт); макро эдийн засгийн чиг хандлага (инфляци, гадаад валютын ханш, зээлийн хүү); нийгмийн асуудал (үймээн самуун, террорист халдлага); байгалийн гамшиг; өрсөлдөгчдийн зан байдал; инновацитай шууд холбоотой. Тухайн үйл явдлын шалтгаан, үр дагаврын талаарх мэдлэг дутмаг байгаагийн үр дагавар болох тодорхой бус байдал нь "үл мэдэгдэх-үл мэдэгдэх" гэж үздэг (Bennett & Lemoine, 2014).

Complexity буюу нарийн төвөгтэй байдал нь харилцан хамаарал бүхий олон хувьсагчтай нөхцөл байдлыг нэрлэх бөгөөд түүнийг зохицуулахад хэцүү байдаг (Bennett & Lemoine, 2014). Технологийн хөгжил нь харилцаа холбоо, мэдээллийн урсгалыг илүү хурдан бөгөөд жигд болгодог тул энэ элементийн нарийн төвөгтэй онцгой өвөрмөц байдал үүсдэг. Энэ нь хожим харилцан хамааралтай, олон давхаргат өгөгдлийн сүлжээг бий болгодог тул гэнэтийн үр дагаврыг урьдчилан таамаглахад хэцүү (Gandhi, 2017). Даяаршил нь байгууллагуудад тулгарч буй хүндрэлийн түвшингийн нөлөөний хүчин зүйл нэмэгдсээр байна. Илүү нэгдсэн, харилцан хамааралтай дэлхийн эдийн засаг руу шилжих шилжилт нь боломж, сорилтыг бий болгож буй худалдааны саад бэрхшээл, технологийн өөрчлөлтийн үр дүнд бий болсон (Hill, 2013). Kostova, Zaheer (1999) нар үндэстэн дамнасан аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа явуулж буй улс орнуудын тоо, төрөл зүйл их байх тусам тэдний хууль ёсны байдлыг хадгалахад илүү их бэрхшээл, сорилт тулгардаг болохыг сануулсан. Цар тахлын нөхцөл байдлаас иргэдийн эрүүл мэндийг хамгаалах болон бизнесийн байгууллагын үйл ажиллагааны зарчим, олон улсын өргөн хүрээний бүхий л системээр холбогдсон төвөгтэй асуудалтай тулгарсан нөхцөл гэрчилнэ. Хүмүүнлэг байх зарчим, ашиг олох бизнесийн зарчим, олон улсын худалдаа халдвар тархалтын тааварлашгүй аюултай орчинд ажиллах онцгой нөхцөл, улс орон бүрийн онцлог, олон улсын гэрээ хэлэлцээр, эрх зүйн орчин зэрэг ээдрээт нөхцөлд цаг хугацаатай өрсөх, давагдашгүй хүчин зүйлийн нөлөөлөл зэрэг бодитой аюул нүүрлэсэн нөхцөл юм. Дээр дурьдсан

нөхцөл байдал, зохицуулалт, өөр өөр соёл, нийгмийн хэм хэмжээ, олон талт ээдрээт хүчин зүйлийн нөлөөнд системийн элементүүд бие биенээ харилцан дэмжихээс гадна үгүйсгэх, эсэргүүцэх зэрэг тоо томшгүй ээдрээт хариу үйлдэл үзүүлдэг тул үйл явц бүрийг анхааралтай авч үзэх “онцгой” шаардлага бүхий илүү нарийн төвөгтэй байдалд хүргэдэг.

Ambiguity- эргэлзээтэй нөхцөл нь тухайн үйл явдлын шалтгаан, үр дагаврын талаарх мэдлэг дутмаг байгаагийн үр дагавар болох "үл мэдэгдэх-үл мэдэгдэх" гэж үздэг (Bennett & Lemoine, 2014). Өмнө тохиолдсон эсвэл ямар нэгэн туршлага байхгүй тул чухам юу хүлээж байгааг таамаглах нь мөн хязгаарлагдмал. Цаашилбал, тогтворгүй, тодорхойгүй, нарийн төвөгтэй байдал нэмэгдэх тусам нь нөхцөл байдлыг улам л эргэлзээтэй болгодог (Gandhi 2017). Шалтгаан, үр дагавараас эхлээд юу хүлээж, юу болох нь эргэлзээтэй тул энэ талыг дээр дурьдсан бусад гурван нөхцөл байдлын туйлын зэрэг гэж үздэг. Цоо шинэ туршилт, шинэ бүтээгдэхүүн, шинэ үйлчилгээ, инновацын төлөвшөөгүй, шинэ зах зээлд хоёрдмол утгатай нөхцөл байдал. Цар тахалтай холбоотой сорилт бэрхшээлүүд нийтийн удирдлагын бүхий л салбарыг хамарсан кластер болон системийн шинж чанарыг улам өргөтгөн хамруулсаар байна. Улс төр, эдийн засаг, нийгмийн хүчин зүйлсийн нэгдэл, технологийн дэвшил, инновацын өрсөлдөөн, урьдчилж тооцоогүй нөхцөл байдал, олон нийтийг хамарсан цар тахлын гамшиг, онцгой байдлын нөхцөл нь улс орнуудыг таашгүй сорилтуудаар сорьсон. Иймд өнөөг хүртэл нийтийн удирдлагад хэрэгжүүлж ирсэн зарим арга хэмжээ нь урьд өмнө тулгарч байгаагүй асуудлууд нь олон хэмжигдэхүүн бүхий глобал шийдвэр гаргахад хүргэж байна. Цар тахал, дайн самууны хямралын өнөөгийн нөхцөл байдлаас үүдэн гарч болзошгүй бэрхшээл түүний эсрэг авах арга хэмжээний урт хугацааны хандлага нь хүний эрх, тэгш байдал, нийгмийн оролцоо, ажилгүйдэл, ядуурал зэрэг үр дагаварын нөлөө бүхий асуудлыг дагуулсан. Улс орнуудад онцгой байдал, эдийн засгийн хүндрэл, хямрал, түүнийг даван туулахад асар их тэвчээр, холч бодлого, эв нэгдлийн шалгуур болж байгаагаас зөвхөн эрүүл мэндийн салбар гэлтгүй бүхий л салбаруудад томоохон сорилт бэрхшээлүүдийг нэгэн зэрэг авчирсан нь асуудлыг улам л системчилсэн хамаарал бүхий болгосон. Олон улсад 2020 он бүхэлдээ хүнд хэцүү байсан ч бүтээлч сэтгэлгээ, тэсвэр тэвчээртэй байснаар иргэд болон эрх баригчид шинэ орчинд харьцангуй хурдан дасан зохицон оновчтой шийдвэр гарган улс орон, иргэдээ хамгаалах бодлого, аюулгүй байдал, төлөвлөлт, хэрэгжүүлэлт, хяналтыг хэрэгжүүлэн даван туулах оролдлого хийсээр байна. Нөхцөл байдал нь төрийн

удирдлага, төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны уялдаа холбоо, нөхцөл байдлыг соргог мэдэрч хамтын хүчээр системтэй ажиллах агуулга, ач холбогдол, уян хатан байдлыг бэхжүүлэх стратегитай холбоотой байгаад оршино. Энэ нь зөвхөн эрүүл мэндийн салбарын удирдлага гэлтгүй төрийн захиргааны уян хатан байдал улс орнуудад гарч буй цар тахлыг арилгахад ихээхэн ач холбогдолтой. Үүнтэй холбоотой үндсэн нөхцөл нь төрийн захиргааны уян хатан байдлын агуулга, ач холбогдол, уян хатан байдлыг бэхжүүлэх стратеги юм. Гэвч 5, 10 магадгүй 20 жилийн дараа дахин дэлхий нийтийг хамарсан өөр төрлийн “шинэ өөрчлөлт”, “шинэ шилжилт”-д орохыг тааж мэдэх аргагүй юм. Дараагийн өөр төрлийн “өөрчлөлт болон шилжилт”-н давтамж хэзээ вэ? Магадгүй хямрал ямар төрлийн мутацаар илрэх вэ? Давтамжийн хугацаа хэзээ байж болох вэ гэх мэт олон асуултууд нээлттэй байна. Захиргааны уян хатан байдлын үзэл баримтлал нь хүрээлэн буй орчны динамик нөхцөлд захиргааны үйл ажиллагааны үр дүнд үүссэн тодорхойгүй байдал, бэрхшээлийг даван туулах хандлага гэж үздэг. Байгууллагын уян хатан байдал нь VUCA-ийн үзэл баримтлалтай шууд холбоотой. Резиленсийн онолын үүднээс үйл явц, хандлага нь “уян хатан”, тэсвэртэй, зохицох агуулгаар олон шинжлэх ухааны салбаруудад хэрэглэгддэг бөгөөд төрийн удирдлагад 2007-2009 оны дэлхийн эдийн засаг, санхүүгийн хямралд тэсвэр хатуужил гэдэг нэр томъёо хямрал, өөрчлөлтөд төрийн удирдлагад уян хатан шийдвэр гаргах сорилтыг бий болгосоор байна.

Ихэнх шинжлэх ухаанд уян хатан гэдэг нэр томъёо нь системтэй холбоотой. Гадны сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэн системийн үйл ажиллагааг алдагдуулалгүй нөлөөлөлд дасан зохицох, тэдгээр нь “шинэ шилжилт” хийх тохиолдолд засч залруулах “амьд” үлдэх чадвар юм. Уян хатан байдлын "хяналт" -ын үүргийн нөлөө үнэмлэхүй биш, амжилт нь тодорхой бус байсан ч нөлөөлөх боломжийг олгодог" гэсэн итгэл үнэмшил гэж тодорхойлдог² тул тухайн ажилтны үйл хөдлөл, үйлдэл, хүчин чармайлт, үр дүн, үйл явдал, харилцаа холбоо гэх мэт шалтгаант хамааралтай. Хяналт ил тод байх тусам хүн өөрийн идэвхтэй байр суурийг үр дүнтэй гэдэгт илүү их итгэдэг.

Уян хатан байдлын бүтцийн хяналтыг Элен Скиннер: хяналтын ойлголт нь өргөн утгаараа хувь хүмүүсийн ертөнцийг үзэх үзлийн тухай учир шалтгаант ойлголт юм. Хүссэн, эс хүссэн тааламжгүй үйл явдлын хамгийн үнэн зөв шалтгаан, үүрэг оролцоо нь бусад хүмүүс, байгууллагууд, нийгмийн тогтолцооны хариуцлагын сургамж, алдаа,

²<https://oimurschool.ru/mn/otnosheniya/vozmozhnye-puti-korrekcii-zhiznesteikosti-i-udovletvorennosti-zhiznyu/> 2022 оны Арван хоёрдугаар сарын 5, өдөр ашигласан.

дутагдал, зөрчил, эрсдэл эсвэл амжилт, үр дүн зэргийг харуулж болно. Хүмүүс нийгмийн харилцаанд орохдоо үр дүнтэй байх төрөлхийн хэрэгцээтэй тул өөрсдийгөө хянах мэдрэмжийг эрмэлздэг. Аливааг хяналтандаа авах мэдрэмж нь баяр баясгаланг авчирдаг бол хяналтаа алдах нь бухимдал, уур уцаар зэрэг сөрөг мэдрэмжийг төрүүлдэг.

Улс орнууд засгийн газар “төр эргэн ирлээ” хэмээх ойлголт буюу тогтвортой байдлын баталгаа өгч чадах найдвартай “тоглогч”-р дахин гарч ирсэн тухай хямрал, цар тахал, гамшгийн менежмент, захиргааны менежменттэй холбоотой бүтээлүүд бий. Иймд уян хатан байдал нь гадны болон урьдчилан тооцоолоогүй цочролын нөхцөл байдал, цочрол үймээний өндөр нөхцөл байдлын түвшнийг илэрхийлдэг. Тиймээс тогтвортой хэвээр байгаа, хэвийн бус нөхцөлд ажиллах чадвар бүхий зохион байгуулалтыг бий болгох удирдлагыг бий болгох шаардлага үүссэн. Гэсэн хэдий ч захиргааны уян хатан байдлын үзэл баримтлалыг зөвхөн хугацааны тасалдлаар хязгаарлахгүй. Илүү өргөн утгаараа байгууллагын уян хатан байдал нь хүрээлэн буй орчны динамик нөхцөлд төрийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнд үүссэн тодорхойгүй байдал, бэрхшээлийг даван туулах стратеги гэж үздэг. Энэхүү ойлголтод байгууллагын уян хатан байдал нь VUCA-ийн үзэл баримтлалтай холбоотой.

Стратеги нь ирээдүйн мэдэгдээгүй дохио, болзошгүй аюулаас сэргийлэн ирээдүйн шинэ боломжит амжилтад хүрэхийн тулд урьдчилан таамаглаж, хэтийг харж, өнгөрснөөс ирээдүйд хүргэх тэргүүлэх стратеги боловсруулан чиглүүлдэг.

- **Ерөнхий** (шийдвэрлэвэл зохих ерөнхий хүчин зүйлүүдийг агуулсан),
- **Цаг үеийн** (ойрын хугацаанд яаралтай шийдэх),
- **Тулгамдсан** (цаг хугацааны хувьд яаралтай бөгөөд шийдвэрлэхэд ярвигтай),
- **Үндсэн** (шийдвэрлэвэл зохих гол зүйл),
- **Зангилаа** (шийдвэрлэвэл зохих олон асуудлын хамгийн чухал нь),
- **Түвэгтэй** (шийдэхэд хэцүү),
- **Чухал асуудал** (нэн шаардлагатай, тулгамдсан асуудал) –
- **Шийдвэрлэгдээгүй асуудал** (хэлэлцэж боловсруулаагүй зүйл),
- **Нарийн хэт эмзэг** зэрэг байж болно.

Ирээдүйг урьдчилан харах

Ирээдүйг харах, урьдчилан таамаглах нь шинжлэх ухааны судалгааны бүрэн хөгжсөн ангилал

“Бидний өнөөгийн түвшний оюун ухаанаар бий болсон асуудлуудыг тэр түвшний сэтгэлгээгээр шийдэж болохгүй” хэмээн Алберт Эйнштейн хэлжээ.

Стратегич ухаан нь бусад шинжээчдийн хийсэн шинжилгээ, судалгаанд анхаарал хандуулан ирээдүйн стратегийн хувилбарын төслийг төлөвлөх боломжийг олгодог.

Стратегич нь дэлхийн хэв маягийн талаарх товч тодорхой ойлголттой байх ёстой стратегийн тэргүүлэх чиглэлүүдийг тогтоох, аюулгүй байдлыг үнэлэх, өрсөлдөөний давуу талыг ашиглах, зорилго, зорилгоо тэргүүлэх чиглэлд нийцүүлэн хамгийн үр дүнтэй арга замыг тодорхойлох чадвартай байх ёстой.

(B.L.Kvint 2019)

БИД:

- ✓ одоо хаана байна вэ?
- ✓ хаашаа хүрэх зорилготой вэ?
- ✓ хэрхэн түүнд хүрэх вэ?
- ✓ ирээдүйд орчин нөхцөлийг өөрчилж болох өөр ямар хүчин зүйлүүдийг анхаарах ёстой вэ?
- ✓ Асуудлыг амжилттай шийдвэрлэхийн тулд асуудлыг зөв таних, зөв шийдэл олох хэрэгтэй.
- ✓ Зөв тавигдсан асуудлыг буруу шийдвэрлэхээсээ илүү буруу асуудлыг шийдвэрлэснээс болж амжилт олохгүй байх нь их байдаг.
- ✓ Оршин байгаа асуудал нь тодорхой шалтгаанаас үүдэн бий болох ба тэрхүү асуудлаас тодорхой үр дагавар үүсч байдаг.
- ✓ Russell L. Ackoff (1974)

Зураг 2. Стратегийн уялдаа



Форсайт: Төрийн бодлогод урт хугацааны сорилтуудыг урьдчилан таамаглах, удирдахад тусалж, өдөр тутмын үйл ажиллагаанд тусгалаа олох нөхцөлийг бүрдүүлнэ.

Анхны нөхцөл байдал, саад бэрхшээл эсвэл зорилтот нөхцөл байдлыг өөр өнцгөөс “харах”-аас эхэлж болно. Хэрэгжүүлж буй бодлого нь хүмүүс болон нийгэм, хүрээлэн буй орчны зүгээс гарах гэнэтийн үйлдлээс саатах эсвэл саармагжсанаар бодлогод эсэргүүцлийг бий болгодог. Бодлогын эсэргүүцлийг шийдвэрлэж өндөр үр өгөөж бүхий бодлого, сэтгэлгээний цар хүрээг өргөжүүлж, эргэх холбооны мөн чанарыг нарийн ойлгох шаардлагатай.

Үүний нэгэн шалтгаан нь аливаа үзэгдлийг тайлбарлахдаа түүнийг үргэлжилсэн дэс дараалал бүхий үйл явц гэж үздэг нь асуудал юм.

- Богино болон урт хугацааны зорилго хоорондын зөрчил? -**тэнцвэржүүлэлт**
- **Одоо авах арга хэмжээ - ирээдүйг урьдчилан харах**
- Богино хугацаанд бий болсон дарамт, шахалтууд, хямралд урт хугацааны бодлогын “зураглал”-д нөлөөлөхгүй хэрхэн удирдах вэ?
- Эрсдэлийг урт хугацааны боломж болгон ашиглах ...
- Илүү дасан зохицсон, уян хатан бодлогыг хэрхэн бий болгох вэ?

- backcasting
- futures wheels
- scoping circle
- 7 questions
- pace layers
- three horizons
- scenarios
- systems mythologies
- visioning
- wind-tunneling

Зураг 3 Шийдвэр гаргалт-ирээдүйгээс буцах



- Форсайт нь ирээдүйд гарах үр дүн шийдвэрт үзүүлэх нөлөөлөлд дүн шинжилгээ хийдэг.
- **Стратегийн төлөвлөлт**
 - Өнгөрсөн рүү “харах”
 - Богино хугацаа
 - Тухайн үеийн нөхцөл
 - Хариу үйлдэл
- **Форсайт**
 - Ургагшаа “харах”
 - Үнэмшилтэй ирээдүй
 - Мэдрэх
 - Системтэй
- **Хувилбарт төлөвлөгөө**
 - Гарч болох үр дүнгүүд
 - Магадлал
 - Төсөөлөл
 - Дасан зохицох

Форсайт аргын ач холбогдол

- Төрийн байгууллагын менежерүүд, хүний нөөцийн бодлогын мэдлэг чадвар, чадавхын нөөцийг урьдчилан бүрдүүлэх
- Системтэй сэтгэлгээ, авхаалж самбаа, дасан зохицох чадварыг бий болгох
- Хямралын үед болон дараа тулгарах төвөгтэй асуудал, дарамтаас хамгаалах
- Бодлогын шийдлүүдийг бий болгох
- Урт хугацааны зорилтуудад чиглэсэн өргөн хүрээтэйгээр оролцогч талууд, олон нийтийг хамруулан оролцуулах

- Бодлогын хөтөлбөр, шаардлагыг дэмжих нотолгоо, улс төрийн асуудлуудын шийдлийг гаргаж, ирээдүйд гарч болох асуудлуудаас зайлсхийх эрсдэлийг урьдчилан тодорхойлох
- 7. Урьдчилан тооцоолоогүй, тодорхойгүй үйл явдлуудтай тулгарах, богино хугацаанд оновчтой хариу үйлдэл хийх,
- 8. Одоо байгаа төсөөлөл, амжилтад саад болж байгаа гүн гүнзгий итгэл үнэмшлийг өөрчлөхөд тусалснаар хувилбаруудыг өргөжүүлэх
- 9. Бүтээлч сэтгэлгээ, инновацийг эрчимжүүлэх

Форсайт нь төрийн бодлогод ямар үнэ цэн нэмэх вэ?

Хүлээлтийг тодорхой болгох: ирээдүйд бий болох магадлалтай асуудлууд, боломжуудыг таних, бэлтгэх;

Бодлогын шинэчлэл: ирээдүйд бий болох магадлалтай асуудлууд, боломжуудын талаарх хамгийн сайн бодлогыг төлөвлөх, хэрэгжүүлэх;


Ирээдүйн баталгаа: ирээдүйн олон төрлийн хувилбарт нийцэхүйц стратегийг санал болгох, одоогийн стратегийг турших;

Төрийн бодлого: ирээдүйг бүтээх, дасан зохицох, удирдахад шаардлагатай ур чадварыг эрэлхийлэх, бэлтгэхэд төрийн бодлогыг илүү сайн боловсруулах шаардлагатай болохыг төр, нийгэмд сануулж, уриалдаг.

Дани, Эстони, Хонгконг, Ирланд, Нидерланд, Шинэ Зеланд, Сингапур, **Финланд**, Швейцар

Форсайт-практикт

Зураг 4. НҮБ, ОУХБ, АХБ, ЭЗХАХБ, Дэлхийн банк, ОУВС



Зураг 5. Глобал эрсдлийн үзүүлэлт



Дэлхийн эдийн засгийн форум 2023 оны тайлан Урт болон богино хугацааны глобал эрсдэлийн ноцтой байдлын үзүүлэлт

38

2025		2032	
1	Амьдрах өртгийн хямрал	1	Уур амьсгалын өөрчлөлтөд нөлөөлж чадаагүйгээс үүсэх асуудлууд
2	Байгалийн гамшиг, цаг уурын аюултай үзэгдлүүд	2	Уур амьсгалын өөрчлөлтөд дасаж зохицож чадаагүйгээс үүсэх асуудлууд
3	Гео эдийн засгийн зөрчил	3	Байгалийн гамшиг, цаг уурын аюултай үзэгдлүүд
4	Уур амьсгалын өөрчлөлтөд нөлөөлж чадаагүйгээс үүсэх асуудлууд	4	Биологийн олон янз байдал алдагдах, экосистем доройтох
5	Нийгмийн эв нэгдэл доройтох, нийгмийн хуваагдал	5	Томоохон хэмжээний сайн дурын бус цагаачлал/дүрвэх
6	Томоохон хэмжээний хохирол учруулах байгаль орчны үйл явдлууд	6	Байгалийн нөөцийн хямрал
7	Уур амьсгалын өөрчлөлтөд дасаж зохицож чадаагүйгээс үүсэх асуудлууд	7	Нийгмийн эв нэгдэл доройтох, нийгмийн хуваагдал
8	Цахим гэмт хэргийн цар хүрээ өргөсөх	8	Цахим гэмт хэргийн цар хүрээ өргөсөх
9	Байгалийн нөөцийн хямрал	9	Гео эдийн засгийн зөрчил
10	Томоохон хэмжээний сайн дурын бус цагаачлал/дүрвэх	10	Томоохон хэмжээний хохирол учруулах байгаль орчны үйл явдлууд

Байгаль орчин

Геополитик

Нийгмийн

Технологийн

Эдийн засгийн

VUCA-World" орчинд төрийн байгууллагын гадаад, дотоод орчин нь эрсдэлтэй тулгараад зогсохгүй өөрчлөгдөж, тодорхойгүй байдлын орчинд шилждэг. Бюрократ төр, чадамжгүй төр, халамжийн төр, том төр, засгийг шинэчлэн бүтээх нь, идэвхжүүлэгч төр, баталгаа гаргагч төр, төр эргэн ирлээ гэх мэт ойлголтууд өнгөрсөн хугацаанд болсон түүхэн үйл явц түүний үр дүнг илтгэнэ. Сорилт нь бэрхшээл болон боломжийг авчирдаг талаар өмнөх бүлэгт дурьдсан билээ. Онцгой арга хэмжээг тогтвортой хүчин чармайлт болгон өөрчлөх талаар бусад орнуудын туршлагаас юу сурч болох вэ?

Төрийн байгууллагууд нь хууль дүрмийн хүрээнд шинээр бий болж эсвэл өөрчлөгдөж, хууль дүрмийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах үүрэг, хариуцлага хүлээн үйл ажиллагаагаа байнгын, тогтвортой, тасралтгүй явуулах үүрэгтэй. Хямралын үед төрийн байгууллага үр дүнтэй ажиллах технологийн дэд бүтцийг бий болгох, хөгжүүлэх, удирдах зайлшгүй шаардлагатай. Энэ нь мэдээллийн технологийн дэд бүтэц мэдлэг, мэдээллийн менежмент, багуудын уялдаа холбоо, үндсэн оролцогчдын сүлжээнд бүрэн ажиллах боломжийг баталгаажуулдаг. Төрийн байгууллагын дижитал бүрэн эрхт байдлын асуудал улам бүр анхаарлын төвд шилжиж байна. Тодорхой бус орчин нөхцөлд байгууллага мэдээллийн технологийн дэд бүтэц

шаардагдах өгөгдлөө хянаж чадахаа больсон тохиолдолд дасан зохицох, нөхцөл байдалд шилжин хувирч ажиллах чадвараа алддаг. Хямралын менежментэд үндсэн оролцогчдын сүлжээний үйл ажиллагаанд мэдлэг, нээлттэй өгөгдлөөр хүртээмжтэй байлгаж чадвал хямралын менежментийн бүхий л оролцогчдын хүчийг шинээр бэхжүүлдэг. Янз бүрийн сүлжээний оролцогчдын оролцооны мэдээллийг тухайн нөхцөл байдалд нэгтгэн харуулах нь тодорхой бус байдлыг шийдвэрлэх үр дүнтэй арга ба мэдлэг болон нөөцийг солилцох боломжийг бусад төрийн байгууллагын удирдлагад нэгэн зэрэг олгон бусад оролцогчидтой хамтран ажиллах уялдааг хангадаг. Төрийн байгууллагын чиг үүрэг, үүрэг хариуцлагын тодорхой байдлаас шууд хамааралтай шаталсан байгууллагын тодорхой бус байдал, эрсдлийн нөлөөнөөс хамаарч асуудал шийдвэрлэх багийг оновчтой бүрдүүлэх нь уян хатан байгууллагын чухал шинж чанар. Төрийн байгууллага үүрэг даалгавраа биелүүлэхэд зохион байгуулалтын чадвараа хадгалах, нэн түрүүнд “шинэ” чиг үүргүүдийг биелүүлэх чадварыг бий болгоход байнгын дасан зохицох стратеги боловсруулж, иргэдийн татвар, төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулахад нийтийн ашиг сонирхол тэргүүн ээлжийн зорилго болно. VUCA үйл явцын нөхцөл байдалд төрийн байгууллага нь хоёр үндсэн асуудалтай тулгардаг. Тухайн төрийн байгууллагын үйлдлээс болж тодорхой үр дагавар гарч болохыг урьдчилан таамаглах боломжгүй. Үйл ажиллагааны орчинд гарч болзошгүй өөрчлөлтүүдийн улмаас хэрэгжүүлж, батлагдсан стандарт захиргааны журмаар урьд өмнөхтэй ижил үр дүнд хүрэхээ больсон гэдгийг анхаарах шаардлагатай. Уян хатан байдал нь байгууллагууд үйл ажиллагаагаа тасалдуулж эсвэл өсөн нэмэгдэж буйгаас үл хамааран эрсдэл, өөрчлөлтийг даван туулж чаддаг системчилсэн хандлага, чадавхийг хөгжүүлэх нэг хэсэг юм. Уян хатан байдлын үзэл баримтлал нь дээр дурдсанчлан төрийн байгууллагын чадавхийг нийцүүлэх, дасан зохицох, шингээх, хэмээн тодорхойлон энэхүү гурван чиглэлд бэхжүүлэх ёстой. Дасан зохицох чадвар нь төрийн байгууллагын зохион байгуулалт, үйл ажиллагаа урьдчилан таамаглаагүй нөхцөл байдал, системийн “цочрол”-д тасалдсан чадварыг шинэ нөхцөл байдалд нийцүүлэх арга замыг тодорхойлдог. Энэ “нийцүүлэх чадвар”-ын арга замыг удирдлагын гадаад, дотоод орчны шинэ мэдээлэл, шинэлэг туршлагыг тухайн байгууллагын “нийт мэдлэг”-тэй хослуулан хэрэгжүүлэх “шинэ” үйл ажиллагааны стратеги боловсруулах чадвар гэж тодорхойлж болно. Дасан зохицолтын шилжих чадавхи нь байгууллагын урьдчилан таамаглашгүй нөхцөл байдал, эрсдлийн туршлагыг “шингээн” тохируулахын тулд шинжилгээ хийн дүгнэлт гаргах, үйл ажиллагааны чадавхийг сайжруулах чадвар юм. Төрийн байгууллага тэсвэр хатуужлыг бэхжүүлэхдээ тодорхой үйлдэл хийж чадахгүй

байсан ч, нөхцөл байдалтай холбоотой хэвээр байгааг санаж байх ёстой. Нийгэмд хүлээн зөвшөөрөгдсөн олон нийтийн үнэт зүйл, эрхэмж, нийгмийн хэм хэмжээтэй холбоотой асуудлыг орхигдуулж болохгүй. Төрийн байгууллагын үнэт зүйл, төрийн албаны ёс зүй нь засаг захиргааны хямралын үед ч гэсэн "луужингаа" алдахгүй байхыг сануулдаг. Тодорхойгүй байдал, цар тахал, дайн, үймээн самууны үед дүрэм журам, стандартыг ягштал баримтлах гэх мэт захиргааны арга хэмжээг хэрэгжүүлэх боломжгүй байж болно. Урьдчилан таамаглах боломжгүй нөхцөл байдлын зохицуулалтын тогтолцоог стандарт журамтай харьцуулахуйц хэмжээнд бий болгох боломжгүй нь мэдээжийн хэрэг юм. Гэвч төрийн байгууллага бэрхшээл, хямралыг даван туулах, үйл ажиллагааны хувилбаруудыг боловсруулах, туршилтын арга хэмжээ авах санаачлагч байх ёстой. Онолын хувьд шаардагдах туршилт хийх орон зай, удирдлагын алдааны соёл нь практикт бараг байдаггүй. Байгууллагын удирдлага тодорхой бус нөхцөлд бүх хүч бололцоо, нөөцөө дайчлан ажиллан амжилтанд хүрч чадахгүй тохиолдолд удирдлагын манлайллын чадавхитай холбон үздэг. Төрийн байгууллагын үйл ажиллагааны алдаа, оноо нийтэд ил тод байдаг тул хэвлэл мэдээллийн хэрэгслийн хяналтад байдаг. Төрийн албан хаагчдын үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангах, иргэдийн эрх ашгийг хамгаалах үүднээс төрийн байгууллагын үйл ажиллагааны онцлогийг тодорхой бус нөхцөлд тохируулан боловсруулж, тасралтгүй дасан зохицуулж байх шаардлага үүсдэг. Халдвараас хамгаалах тухай хуулиар мэдэгдэж байгаагаар нөхцөл байдалтай холбоотой дасан зохицох хүрээ шаардагдана. Жишээлбэл, Герман улс дахь цар тахлын халдвараас хамгаалах тухай хуулийн хүрээнд вирусын шинэ хэлбэр бүрийг урьдчилан таамаглах боломжгүй боловч эпидемиологийн хямралын хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагааны зарчмуудыг тодорхойлж болно гэж үзжээ.


Улс орнуудад хүн амын эрүүл мэндийн асуудлаас үүдэлтэй бизнес, санхүү, хөдөлмөрийн зах зээлийг хамарсан бүхий л салбарын эрсдэлийг хангалттай үнэлж чадахгүй нөхцөл үүссэн нь эрүүл мэнд төвтэй санхүүгийн хямрал бий болж ажилгүйдэл, ядуурал нэмэгдэн, улсын өр төлбөр, инфляци, төсвийн алдагдал бий болох нь тодорхой боллоо. Төрийн удирдлагын бодлогын үр дүн бол тухайн улсын төрийн удирдлагын чадамжийг тодорхойлох үзүүлэлт бөгөөд тодорхой бус нөхцөл байдалд богино хугацаанд оновчтой шийдвэр гаргах, төрийн байгууллага, төрийн албан хаагчид, оновчтой зохион байгуулалтад орох чадвар нь төрийн бодлогын урт хугацаат бодлого, стратегийг богино хугацааны бодлого тактикаар хэрхэн хэрэгжүүлэхтэй нягт уялдаатай.

Энэ арга хэмжээг хэрэгжүүлж буй төрийн захиргаа, тусгай, үйлчилгээний албан хаагчдын мэдлэг, зохион байгуулах ур чадвар өндөр байх шаардлагатай байдаг. Нийтийн удирдлагын уян хатан, тэсвэртэй байдлын онолын орчин үеийн чиг хандлага, ирээдүйн төлөвийг төрийн захиргааны байгууллагын үнэ цэнэ, үнэт зүйлс, аливаа асуудалд шүүмжлэлт сэтгэлгээтэй хандах бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх шаардлага болж байна.

SPSIRPA FORUM 2024

Session 8-2

Civil service resilience as one of the guarantees of stability of states in the face of current challenges





Wojciech Federczyk PhD

Assistant Professor at the Faculty of Law and Administration of Cardinal Stefan Wyszyński University; Director of the Lech Kaczyński National School of Public Administration.

Civil service resilience as one of the guarantees of stability of states in the face of current challenges

Abstract:

Modern states face a range of challenges, including geopolitical tensions, energy crises, armed conflicts, climate issues, international economic rivalries, and unforeseen crises such as the COVID-19 pandemic. To address these challenges, states must respond appropriately, depending on the nature of the crisis at hand. The preparation and implementation of suitable measures are the responsibility of public administration, with civil service serving as a specialized system within it.

Civil servants work not only for a particular government or political regime but for the state as a whole and in service to society. To make responsible decisions, they must possess internal strength and resilience against various pressures. On one hand, we understand that public officials may face temptations of corruption and the prospect of personal enrichment at the expense of public institutions. However, it is important to practice patriotism and prioritize the greater good of the nation over personal gain. Additionally, civil courage is essential in making difficult decisions, such as determining priority assistance groups during a pandemic.

The personal stance of every civil servant, grounded in ethical principles, is a crucial component in building civil service resilience. In this presentation, we aim to clarify the factors that influence civil service resilience and how they translate into appropriate responses by contemporary states to challenges and calamities. Examining these factors can help us better understand how civil service resilience contributes to effective governance and societal resilience during crises.

The complexity of contemporary challenges

Contemporary States are confronted with a multitude of complex challenges, including geopolitical tensions, energy crises, armed conflicts, climate exigencies, international economic rivalries, and unforeseen catastrophes such as the COVID-19 pandemic. Geopolitical tensions, manifested in territorial disputes and power struggles among nations, present persistent challenges to global stability. At the same time, energy crises, characterised by fluctuations in supply and demand, present complex challenges for both developed and developing nations alike. Furthermore, armed conflicts, ranging from localised skirmishes to full-scale wars, have a detrimental impact on humanitarian crises and socio-political landscapes. Climate exigencies, including rising temperatures, extreme weather events, and environmental degradation, underscore the pressing need for concerted action to mitigate their adverse impacts. At the same time, international economic rivalries, which are often manifested in trade disputes and currency fluctuations, contribute to a certain degree of uncertainty in

global markets, which in turn affects livelihoods worldwide. Furthermore, black swans such as the COVID-19 pandemic serve to illustrate the fragility of contemporary socio-economic systems and the necessity for adaptive resilience.

In light of these exigencies, it would be advantageous for the State to react in a prudent manner, tailored to the distinct nature of each challenge. The ability of States to navigate these multifaceted challenges depends on their capacity to formulate and implement effective strategies, utilising diplomatic, economic, and socio-political instruments. Such reactions must be agile and adaptive, capable of addressing the dynamic and evolving nature of contemporary crises. Furthermore, it is of the utmost importance to ensure that these reactions are guided by principles of equity, solidarity, and sustainability. This is to ensure that the burdens and benefits are fairly distributed across society. Additionally, the role of international cooperation and multilateralism takes on heightened significance.

Central to response mechanism is the pivotal role played by public administration in good governance, facilitating the implementation of policies, programmes and services that are essential for the modern states.

Adequacy of the civil service

There are various models for the organisation and functioning of public administration. However, given the challenges of the early twenty-first century, the concept of the civil service deserves special analysis. This is due to its nature. Other conceptions of the operation of administration involve the subordination of civil servants to the particular political authority for which they work. This was the situation, for example, in communist countries, where the state administration was, as a rule, composed of party members or party sympathisers. A further question arises with regard to officials appointed for the duration of the rule of a particular authority. Their loyalty is limited.

The aforementioned challenges may also influence the conduct of specific officials. These may include concerns about allegiance to the homeland in a complex geopolitical context, the potential for personal gain or a lack of impartiality.

The concept of a civil service is characterised by a nuanced and distinctive framework that diverges from mere state administration or its structural organisation. At its core is a steadfast dedication to serve the state and society at large, rather than any particular authority. It comprises a cohort of civil servants who are equally committed to any legitimate government. The advantage lies in its autonomy to execute state functions without undue interference, coupled with the enduring professionalism inherent in administrative endeavours.

The genesis of civil services can be traced back to the emergence of modern states, coinciding with the transition from absolutist regimes. This pivotal shift marked the dissolution of the perception of state and public institutions as the monarch's exclusive domain, thereby symbolising the ascendancy of societal empowerment. Spanning the seventeenth to nineteenth centuries, this transformation unfolded uniquely across European nations, precipitating varied adaptations in civil service structures in response to historical exigencies.

In France, the legacy of the Great Revolution and the era of Napoleon Bonaparte shaped its civil service paradigm. In Germany, the notion of the "rule of law" exerted profound influence.

However, a uniform blueprint for civil services failed to materialise, with each country fashioning its approach reflective of distinct historical trajectories.

Despite its enduring relevance, the concept of civil service undergoes perpetual evolution, necessitated by the imperative to modernise public administration in consonance with contemporary challenges. Consequently, the twentieth century witnessed the adoption of paradigms such as public management, the welfare state, New Public Management, and subsequently, public governance.

Within this framework, the civil service emerges as a dedicated cadre of professionals entrusted with the execution of public policy objectives and the delivery of essential services to citizens. The civil service is distinguished by its professionalism, impartiality and commitment to the public good. It embodies the ethos of public service, transcending partisan politics and serving as a bulwark against arbitrary governance. Moreover, it embodies institutional memory and continuity, ensuring the effective transmission of knowledge and expertise across successive administrations. Thus, the resilience and efficacy of the civil service are integral to the ability of States to navigate crises and safeguard the interests of society.

These concepts differ in their emphasis on either the scope of activity or the ways in which tasks are carried out. However, there is a fundamental assumption that work in the civil service has its own specificity, which can be described as public service. Indeed, studies carried out in European countries indicate that the main distinguishing feature of people working in the civil service is a special motivation that differs from that of private-sector employees.

Quality of public administration

Resilience is a fundamental aspect of civil service, intricately interwoven into the fabric of navigating challenging circumstances and surmounting obstacles. The significance of resilience in civil service is multifaceted.

Firstly, resilience equips civil servants with the capacity to effectively cope with the pervasive stressors inherent in their roles. From stringent deadlines to protracted working hours and navigating complex situations, civil servants confront a barrage of stressors. Through resilience, civil servants cultivate the ability to rebound from setbacks, maintain morale, and safeguard their overall well-being amidst adversity.

Secondly, the dynamic nature of civil service work, characterised by its inherent unpredictability and frequent shifts in policies, procedures, and priorities, underscores the imperative of resilience. By fostering adaptability and flexibility, resilience empowers civil servants to adeptly navigate the labyrinth of uncertainty that permeates their professional landscape.

Thirdly, resilience is an invaluable asset for civil servants when confronted with significant challenges and formidable obstacles. Whether deciphering intricate problems or surmounting barriers to progress, resilience provides the motivation, focus and drive to persevere and find innovative solutions. Furthermore, resilience is crucial in mediating the complex demands that often face civil servants. By developing the capacity to prioritise and allocate resources effectively, resilient civil servants are able to navigate the complex landscape of competing demands, thereby enhancing the efficiency and efficacy of their endeavours.

OECD Signposts

The importance of civil servants' resilience is highlighted in international documents, primarily those produced by the OECD Committee on Public Governance, in particular: Recommendation of the Council on Public Service Leadership and Capability. Recommendation, from the point of view of this study indicates, to build values-driven culture and leadership in the public service, centred on improving outcomes for society, by:

1. Defining the values of the public service and promoting values-based decision-making, in particular through:

- a. Clarifying and communicating the shared fundamental values which should guide decision-making in the public service;
- b. Demonstrating accountability and commitment to such values through behaviour; and
- c. Providing regular opportunities for all public servants to have frank discussions about values, their application in practice, and the systems in place to support values-based decision making,

2. Building leadership capability in the public service, in particular through:

- a. Clarifying the expectations incumbent upon senior-level public servants to be politically impartial leaders of public organisations, trusted to deliver on the priorities of the government, and uphold and embody the highest standards of integrity without fear of politically-motivated retribution;
- b. Considering merit-based criteria and transparent procedures in the appointment of senior-level public servants, and holding them accountable for performance;
- c. Ensuring senior-level public servants have the mandate, competencies, and conditions necessary to provide impartial evidence-informed advice and speak truth to power; and
- d. Developing the leadership capabilities of current and potential senior-level public servants.

Another important aspect of achieving public administration resilience is the public integrity identified by the OECD. A recommendation on this topic was adopted in 2017. Integrity is a fundamental aspect of the development of robust institutions. It serves to reassure citizens that the government is acting in their best interests, rather than merely representing the interests of a select few. Integrity is not merely a moral issue; it also has a significant impact on the productivity of economies and the efficiency of public administration.

Polish experience how to achieve resilience

One example of an organisational solution to achieve civil service resilience is the Polish Civil Service Act of 21 November 2008. This legislation provides for the existence of a special professional group of appointed civil servants in the Civil Service Corps. These are people who have graduated from the National School of Public Administration (KSAP), which has produced approximately 1,400 graduates over the 33 years of its existence. Furthermore, those civil servants who achieve the highest scores in the annual KSAP tests of clerical knowledge and analytical skills may be appointed. According to the report of the Head of the Civil Service

for 2023, there were almost 120,000 people employed in the civil service, including almost 7,700 civil servants.

In addition to their primary duties, civil servants may be transferred to another office, even to another city, in accordance with the needs of the civil service. Furthermore, they may be assigned additional duties and activities.

The glue that binds the culture of integrity and leadership in the civil service is the ethical values of civil servants. They enable the public administration to achieve an appropriate level of resilience and a guarantee of effective performance.

Among the values of the Polish set of ethical principles, the following deserve emphasis:

the principle of public service – non-evading making difficult decisions and bearing responsibility for their actions, bearing in mind that the public interest calls for prudent, yet effective actions that are resolutely implemented;

and the principle of fairness – creative approach towards the tasks and active implementation of obligations, with the best will in the social interests.


Summary

The complexity and multifaceted nature of the challenges facing modern states necessitate a response from public administrations to confront and successfully defend against threats. This response must be complex as well. The organisational formula is important – the civil service concept works best. However, a strong internalisation of ethical values is necessary in order to make decisions with courage and concern for the common good.

SPSIRPA FORUM 2024

Session 8-3

Generational value differences in public administration organization



ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА ДАХЬ ҮЕ ХООРОНДЫН ҮНЭТ ЗҮЙЛИЙН ЯЛГАА

Ганбатын Мягмар

МУИС-УТСОУХНУС-Нийтийн Удирдлагын тэнхимийн ахлах багш доктор

Хураангуй

Өсвөр үе, залуу насандаа улс төр, нийгэм, эдийн засгийн ижил төстэй үйл явдлыг тодорхой цаг үед туулсан ойролцоо насны хүмүүсээр үе бүрдэх (Jurkiewicz, 2020) бөгөөд үеийн онцлог, ялгааг судлах нь нийгмийн төдийгүй шинжлэх ухааны бусад салбарыг хамарсан ач холбогдолтой судлагдахуун болсон. АНУ тэргүүтэй олон оронд үе, үеийн ангилал, онцлогийг шинжлэх ухааны үндэслэлтэй судалж, нийгэм, эдийн засгийн онцлог шинжүүдтэй холбогдуулан бүх шинжлэх ухааныг хамарсан өргөн цар хүрээтэй судалгаа хийж байна. Нэг үеийг дараагийн үе залгамжлах нь чухал асуудал биш, харин өөр үеийнхэн нэг цаг хугацаанд хэрхэн хамтдаа оршин байх нь “үеийн судалгааны онцлог” юм (Mannheim, 1952). Өөр үеийнхэн хамтдаа нэг цаг хугацаанд амьдарч, ижил туршлагыг туулж байгаа мэт боловч үнэндээ “ижил цаг хугацаа” нь тухайн хүний хувьд зөвхөн өөрийн нас ойролцоо хүмүүстэй хуваалцаж болохуйц “*өөр цаг хугацаа*”-г илэрхийлдэг. Нөгөө талаар, энэ нь өөр үеийнхэн нэг үйл явдал, туршлагыг харилцан адилгүй хүлээн авч, хариу үйлдэл үзүүлдэг гэсэн үг юм. Тодорхой цаг хугацаанд нэг үйл явдлыг залуу, дунд, ахмад үеийнхэн ижил туулах боловч тэр үйл явдлын үр нөлөө нь нэг үеийнхний өмнө туулсан туршлагаас шалтгаалан үе бүрд өөр байдаг. Үеийн онолууд нь үе тус бүрд үнэт зүйл (эрхэмж), хандлага, үзэл баримтлал, итгэл үнэмшлийн тодорхой онцлогууд байгааг баталж байгаа бөгөөд энэхүү онцлогуудыг нийгмийн салбар бүрд практикт ашиглаж байна. Үеийн онцлогуудыг шинжлэх ухааны үндэслэлтэй судалж, системтэй ойлголттой болсноор бүх төрлийн байгууллагуудад хүний нөөцийн бүрдүүлэлт, тогтвортой ажиллах нөхцөл, харилцан ойлголцол, хамтын ажиллагааг удирдах зэрэг олон хүчин зүйлд эергээр нөлөөлөх боломжтой.

Түлхүүр үг: үнэт зүйл (эрхэмж), нийгмийн үе, X, Y, Z үе

Үндсэн хэсэг

Эртний Грекийн “ax-ios”-“эрхэм”, “амин чухал”, “үнэт” гэсэн утгатай үгнээс үүдэлтэй (Удирдлагын Академи 2022) аксиологийн (axiology) сургаал, үнэт зүйл-эрхэмжийн онол-theory of values болж тууштай хөгжиж ирсэн нь ердөө зуугаад жилийн түүхтэй. Ялангуяа үнэт зүйлийн талаарх ойлголтыг 1930-аад оноос улс төр, ёс зүй, үзэл бодол, идэвхжүүлэлт зэрэг ойлголтуудтай холбон судалж эхэлсэн. Сонгодог философи болон үнэт зүйлийг судалдаг аксиологийн онолд субъектээс объектод хандсан харилцаа, түүнээс үүссэн хэм хэмжээт үйлийн цогцыг үнэт зүйл гэж үздэг. Үнэт зүйл нь хүмүүний мэдрэмж, хэрэгцээнд тулгуурласан амьдралыг чиглүүлэх, идэвхжүүлэх, утга төгөлдөр болгож хөтлөх хүч юм (Долгорсүрэн.Ж, Алтанзаяа.О, 2019). Социологийн шинжлэх ухаанд үнэт зүйл нь 1) Нийгмийн субъект (хувь хүн, нийгмийн бүлэг, нийгэм бүхэлдээ)-д төлөвшиж тогтсон эрхэмлэн хүндэтгэдэг үзэл бодол, итгэл үнэмшлийн цогц; 2) Бодит үйл явдлыг үнэлж цэгнэх шалгуур; 3) Хүмүүсийн амьдрал, үйл ажиллагааны утга учрыг

тодорхойлох хүчин зүйл; 4) Нийгмийн харилцан үйлчлэлийн зохицуулагч гэж үздэг (СУИС 2019). Үнэт зүйл бол итгэл үнэмшил, аливаа үйлдэлд хөтөлж чиглүүлэх чухал хамаарал, олон төрлийн хандлага болон зан төлөвийн шалтгаан, ач холбогдлын дэс дараалал, стандарт болон шалгуур, хүсэж буй зорилгоор илэрхийлэгдэн ямар нэг үйлдлийг хийх сэдэл гэх мэтээр тайлбарлажээ (СЭЗДС 2015). Түүнчлэн үнэт зүйл нь хүмүүсийн ойлголт, хандлага, зан үйлд нөлөө үзүүлдэг хүсэмжит төлөв байдлын тухай үзэл баримтлал бөгөөд субъектив шинжтэй гэж олон судлаачид үздэг (Удирдлагын Академи 2018). Үнэт зүйл нь хүмүүний ертөнцийг үзэх үзэл, хандлага, төлөвшлийг чиглүүлэгч эрхэмлэн дээдлэх дэвшилтэт үзэл баримтлал, чин эрмэлзэл, зарчим, хэм хэмжээ гэж үзэж болно (СУИС 2019). Эдгээр тодорхойлолтуудаас үнэт зүйл нь хувь хүний, байгууллагын, салбарын, төрийн, нийт хүн төрөлхтний буюу универсал түвшинд чухалчилж, эрхэмлэх ойлголт бөгөөд хувь хүний хувьд хандлага, зан авир, үг үйлдэл, шийдвэрт хүчтэй нөлөөлөх шинжийг агуулна.

Үнэт зүйл нь философийн ойлголт болохын хувьд шинж чанараараа ерөнхий зүйлд төвлөрдөг хийсвэр боловч харьцангуй тогтвортой ёс суртахуун, хэм хэмжээний хүрээний ойлголт бөгөөд хувь хүний үйл хөдлөл, харилцаа, хандлагыг бүхий л амьдралынх нь туршид илэрхийлж, хүний ерөнхий зан байдал буюу нийгэмд биеэ авч явах зан үйлийг чиглүүлдэг (Алтантуяа.Г, 2016).

АНУ-ын эрдэмтэн Б.Боземан (2007) үнэт зүйлийн талаарх дараа дүгнэлтүүдийг бүтээлдээ дурджээ. Үүнд (Richard C.Vox 2014):

1. Үнэт зүйл нь хүний танин мэдэхүй болон сэтгэл хөдлөлийг хамтад нь илэрхийлдэг,
2. Үнэт зүйл нь үнэлгээ, шүүмжийг илэрхийлдэг,
3. Үнэт зүйл нь харьцангуй тогтвортой,
4. Үнэт зүйл нь хүний зан үйлдэлд хүчтэй нөлөөлөх боломжтой,
5. Үнэт зүйлийг өөрчлөхөд хүчин чармайлт, төлөвлөгөө, цаг хугацаа хэрэгтэй,
6. Үнэт зүйл нь хувь хүнийг тодорхойлоход тусалдаг гэжээ.

Үнэт зүйл (эрхэмж) судлаач эрдэмтэн Ш.Шварц (1992) онол, арга зүйн хувьд үнэт зүйл (эрхэмж)-ийн судалгаанд ихээхэн түлхэц болохуйц бүтээлүүдийг туурвисан бөгөөд бүх улс орон, соёл иргэншилд хамаарч болох хүмүүсийн суурь үнэт зүйл (эрхэмж)-ийн тухай судалсан (S.Schwartz, 2012). Тэрээр “үнэт зүйл (эрхэмж) нь хүний амьдралын туршид хэрэглэгдэх нийгэмд хүлээн зөвшөөрөгдсөн, хүнээс салшгүй холбоотой онцлогууд бөгөөд хүн сонголт хийхдээ зарчмаа болгодог, өөрийгөө болон бусдыг үнэлж, дүгнэж, шүүн хэлэлцэхэд шалгуур болгодог ойлголт, итгэл үнэмшил” гэж тодорхойлсон (Удирдлагын Академи, 2017). Хэдийгээр үнэт зүйл (эрхэмж)-ийн мөн чанарын ойлголт нийтлэг боловч хувь хүн, бүлэг бүр ямар үнэт зүйл (эрхэмж)-ийг чухал гэж үзэх нь харилцан адилгүй. Өөрөөр хэлбэл, тодорхой үнэт зүйл (эрхэмж) нэг хүнд чухал байхад өөр нэгэнд огт хамаагүй байж болно. Өөрөөр хэлбэл, тодорхой үнэт зүйл нэг хүнд чухал байхад өөр нэгэнд чухал биш байж болно. Г.Алпорт (1961), Н.Т.Фэйдэр (1995), С.Моррис (1956), М.Рокич (1973) нарын бүтээлүүдэд үндэслэж Ш.Шварц (1992, 2006) үнэт зүйлийн тухай ойлголтод дараах зургаан үндсэн шинж чанар оршино гэж үзсэн. Үүнд (Shalom H.Schwartz, 2012):

1. Үнэт зүйл бол сэтгэл хөдлөлтэй нягт холбогддог итгэл үнэмшил: Жишээлбэл, эрх чөлөө чухал үнэт зүйл нь болдог хэн нэгэнд түүний эрх чөлөөнд халдвал ихээхэн түгшүүртэй мэдрэмж төрнө.

2. Үнэт зүйл нь хүний хүсэн тэмүүлдэг зорилго бөгөөд үйл ажиллагааны сэдэл: Хүн эрхэмлэдэг үнэт зүйлээ зорилго болгож түүнийхээ төлөө үйлдэл хийж, тэмцдэг. Жишээлбэл, шударга ёсыг үнэт зүйл болгон эрхэмлэгч нийгэмд үзэл бодлоо идэвхтэй илэрхийлж болно.
3. Үнэт зүйл нь тодорхой нөхцөл байдал, үйлдлээр хязгаарлагдахгүй: Хандлага, хэм хэмжээ зэрэг ойлголт нь ихэвчлэн тодорхой үйлдэл, объект, нөхцөл байдалд хамаатай бол үнэт зүйл нь ийм хязгаарлалтад оршдоггүй. Жишээлбэл, хэн нэгний үнэнч шударга байдал нь ажил, сургууль, гэр бүл, улс төр, бизнесийн орчинд найз нөхөд, танихгүй хүнд ч хамаатай байж болно.
4. Үнэт зүйл нь хэмжүүр, стандарт: Үнэт зүйл нь бодлого, шийдвэр, үйлдэл, үйл явдал, хүнийг хүртэл үнэлэх, сонгоход хэмжүүр болдог. Хүмүүс өөрсдийн баримталдаг үнэт зүйлдээ суурилж, юу сайн эсвэл муу болох, юуг хүлээн зөвшөөрөх эсвэл зөвшөөрөхгүй байх, юуг хийх эсвэл зайлсхийх зэргийг шийддэг. Гэхдээ үнэт зүйлээ баримжаалан гаргаж буй тухайн хүний шийдвэр, үйлдлүүд өдөр тутамдаа ухамсартайгаар хийгддэггүй. Харин үнэт зүйлийн зөрчил үүсэхэд хүн ухамсартайгаар шүүж, бодож, тунгааж шийдвэр гаргана.
5. Үнэт зүйл нь ач холбогдлоор эрэмбэлэгддэг: Хүний үнэт зүйл нь ач холбогдлын эрэмбэтэй ба энэхүү эрэмбэ нь тухайн хүнийг тодорхойлдог.
6. Олон үнэт зүйлийн хамаарал, тэр дундаа хамгийн чухал нь үйлдлийг чиглүүлдэг: Хүний ихэнх хандлага, зан авир, үг үйлдэл нь нэгээс илүү үнэт зүйлийг илэрхийлж болно. Хоорондоо хамааралтай эсвэл зөрчилтэй үнэт зүйлүүдийн сонголт нь хүний хандлага, зан үйлдлийг чиглүүлдэг.

Шварцийн үзлээр үнэт зүйлээ баримтлах нь хувь хүнээс сэтгэл зүйн, практик, нийгмийн үр дагаврыг шаарддаг бөгөөд хүн хоорондоо зөрчилтэй янз бүрийн үнэт зүйлийг баримталж болох хэдий ч нэг үйлдэл, шийдвэрт аль нэг үнэт зүйлийг сонгох шаардлага үүснэ (Shalom H.Schwartz, 2012). Хүн яагаад тодорхой үйлдэл, шийдвэр гаргадаг талаар тайлбарлахад ихэвчлэн хандлага, итгэл үнэмшил, зан чанар, хэм хэмжээг шалтгаан гэж үздэг (Shalom H.Schwartz, 2012). Үнэт зүйл (эрхэмж) бол хандлага, итгэл үнэмшил, хэм хэмжээ, зан чанараас ялгаатай, хувь хүнийг тодорхойлдог чухал элемент, хандлага, зан үйлдлийн сэдэл болдог (S.Schwartz, 2012). Үнэт зүйл (эрхэмж)-ийг аливаа нийгэм, соёлын хүрээнд юуг эрхэм дээд хүслэн болгож сонгох ёстойг чиглүүлсэн оюун санааны чиглэл, төсөөлөл гэж ойлгоно. Энэ утгаараа үнэт зүйл (эрхэмж) нь нүдэнд харагдаж, гарт баригдах үзэгдэл, юмс бус харин хүн ба нийгмийн хүсэл тэмүүлэл, төсөөлөл гэх мэт оюун санааны шинжтэй. Үнэт зүйл (эрхэмж) нь ёс зүйн шийдвэр гаргалтын суурь төдийгүй хувь хүний зан төлөвт нөлөөлж, хүний амьдралын туршид хадгалагддаг (M.Rokeach 1973, Jurkiewicz 2013, Jurkiewicz 2020).

Доналд Супер (1960) үнэт зүйлийг ажил үүрэгтэй холбоотойгоор судлах схемийг боловсруулснаар энэхүү судалгааг эхлүүлэгчдийн нэгд зүй ёсоор тооцогддог (Алтантуяа.Г, 2016). Тэрээр бие хүний үнэт зүйлийг ажил үүрэгтэй холбон гадаад ба дотоод гэж хоёр ангилсан.

1. Дотоод үнэт зүйл: хувийн ололт ба амжилт, ёс суртахуунтай байдал, бие даасан байдал, бүтээлч, оюун санааны буюу дотоод урамшуулал зэрэг хийсвэр ойлголтуудыг багтаана.
2. Гадаад үнэт зүйл: амьдралын хэв маяг, тохитой орчин нөхцөл, хувийн аюулгүй байдал, нийгэмд эзлэх байр суурь, ойр дотно хүмүүсийн нөлөөлөл гэх мэт харьцангуй объектив шинжтэй.

Бие хүний хувьд дээрх хоёр төрлийн үнэт зүйлийг хоёулынх нь баримталж болох боловч аль нэг нь нөгөөгөөсөө давамгайл байх нь элбэг. Чухам аль нь эн тэргүүнд байх нь тухайн хүний хувийн онцлог шинж, амьдралын туршлага, нийгмийн орчин нөхцөл зэргээс шууд шалтгаалдаг (Алтантуяа, Г, 2016). Тухайн хүний зан төлөв, орчин нөхцөл, туршлага зэргээс шалтгаалан үнэт зүйлийн баримжаа нь бусад хүнийхээс ялгаатай, ач холбогдлын хувьд харилцан адилгүй.

Монгол хэлэнд анх орос хэлний “ценность”, “ценностная ориентация” гэх орос үгнээс 1970-аад онд орчуулан хэрэглэхдээ “үнэлэмж” “үнэлэмж баримжаалал” “үнэт зүйл” зэргээр нэвтрүүлсэн (Я.Долгоржав, 2022). 1990-ээд оноос хойш “үнэлэмж”, “үнэт зүйл” гэсэн ойлголт түгээмэл хэрэглэгдэх болсноос гадна “эрхэмлэх зүйл”, “эрхэмнэл”, “эрхэмж” гэх үгсийг хэрэглэх санал дэвшүүлэгдэх болов. Орчуулж оноосон ойлголт бүр өөрийн үндэслэлтэй ба эдгээрийг дүгнэхэд үгийн оноолт агуулгын буюу энэ үгээр илэрхийлэгдэж буй үзэгдлүүдийг ойлгохуйн хүрээний асуудлуудад холбогдож байна (Г.Чулуунбаатар, 2019). “Value” хэмээх ойлголтыг судлаачдын зүгээс олон янзаар орчуулж, тайлбарлаж, нэршил нь жигдэрч хэвшихгүй байгаа боловч судалгааны хүрээ, давтамж зэргээс харахад үнэт зүйл (эрхэмж)-д өгч буй ач холбогдол улам нэмэгдсээр байна.

Я.Долгоржав “үнэлэмж” нь үнэлгээ хийж буй процессыг харин “үнэт зүйл” нь үнэлгээний эцсийн үр дүнг илэрхийлдэг (Удирдлагын Академи, 2017) бөгөөд “value” хэмээх ойлголтыг тухайн субъектийн хувьд харьцангуй тогтвортой баримтлагдах зан суртахуун, байр суурь-хандлага, зарчмуудаар илэрхийлэгддэг ээдрээтэй нарийн чанарынхаа улмаас нийгэм, хүмүүнлэгийн ухаан, тухайлбал, ёс зүй, аксиологи, улс төр, удирдлага, сэтгэлзүй, социологи, эрхзүйн шинжлэх ухааны уулзварт ухагдах нарийн төвөгтэй, суурь ойлголт (СУИС, 2019) гэж тодорхойлоод “эрхэмж” хэмээн Монгол хэлнээ буулгах нь оновчтой гэж бүтээлдээ тэмдэглэжээ. Тэрээр хувь хүн, янз бүрийн түвшин дэх оюун санаа, сэтгэлд агуулагдах энэхүү нандин хийсвэр утгыг “үнэт зүйл” гэж нэрлэж буй нь үнэт эдлэл, үнэт металл, үнэт цаас зэрэг олон төрлийн материаллаг, биет зүйлтэйгээ хутган нэг эгнээнд ойлгож бичих, ярих тохиолдол ч гарсаар байгааг шүүмжлэн “эрхэмж” гэж оноон нэрлэх нь зүйтэй талаарх өөрийн нотолгоог дэвшүүлсэн.

Үнэт зүйл (эрхэмж) нь хүний ертөнцийг үзэх үзэл, хандлага, төлөвшлийг чиглүүлэгч эрхэмлэн дээдлэх дэвшилтэт үзэл баримтлал, чин эрмэлзэл, зарчим, хэм хэмжээ гэж үзэж болно (Г.Алтантуяа, 2016). Эдгээр тодорхойлолтуудаас дүгнэхэд үнэт зүйл (эрхэмж) нь хувь хүний, байгууллагын, салбарын, төрийн, нийт хүн төрөлхтний буюу универсал түвшинд юу чухал болох талаарх ойлголт бөгөөд хувь хүний хувьд хандлага, зан авир, үг үйлдэл, шийдвэрт хүчтэй нөлөөлөх шинжийг агуулна.

Германы нэрт социологич Карл Маннхейм “Үеийн асуудал” (Das Problem der Generationen) хэмээх өгүүллийг 1928 онд Герман хэлээр бичиж, 1952 онд англи хэлнээ хэвлэгдсэнээр үе судлалын эхлэлийг олон улсад тавьжээ. Тэрээр “түүх болон нийгмийн үйл явдлуудыг тодорхой байршилд¹ хамтдаа туулсан ойролцоо насны хүмүүсээр үе үүсдэг” гэж тодорхойлжээ (Mannheim, K, 1952). Үеийн асуудал нь тооны хувьд хэмжигдэж буюу насаар зааглаж болохгүй чанарын буюу туршлагаар хэмжигдэхэд оршдог (Mannheim, K, 1952). Өөрөөр хэлбэл, үе нь шууд хуваасан насны бүлгээс илүү өсвөр үе, залуу насандаа улс төр, эдийн засаг, нийгмийн ижил төстэй үйл явдлуудыг туулсан ойролцоо насны хүмүүсийг хэлнэ.

¹ Карл Маннхеймийн “location” буюу байршил гэж тодорхойлсон нь нийгэмд эдийн засаг, эрх мэдлийн бүтцийн хувьд хувь хүн хаана оршиж буйг илэрхийлсэн ойлголт. Гэвч энэ нь нийгэм, эдийн засгийн нөхцөлөөс үүдэлтэй нийгмийн анги, давхаргын гэхээс илүү тодорхой туршлагыг хамтдаа туулж буй хүмүүсийг нэг үеийнхэн гэж үзсэн.

Нейл Хоу, Уилльям Страусс нар “Үеийнхэн” (1991) номдоо 1584 оноос хойших АНУ-ын түүхийн дагуу 13 үед хувааж үе бүрд нэр оноосон боловч зөвхөн “Их төрөлтийн үе” (baby boom), “Мянганыхан” (millennials) зэрэг нэршил нь нийтэд түгжээ (С.Л. Jurkiewicz, 2020). Харин Дуглас Коупландын “Х үе” (1991) зохиолд тухайн үеийн хориод насны залуучуудын амьдралын хэв маягийн талаар бичсэн нь “Х” үе гэх нэршлийг бий болгосон гэж судлаачид тайлбарладаг (Duffy B, 2021). Х үе нэршлийн дараа англи хэлний үсгийн дарааллаар Y, Z үе хэмээн нэрлэж эхэлсэн. Харин англи хэлний үсгийн дараалал Z үсгээр дуусахад XXI зуунд төрсөн шинэ үеийнхний нэрийг грек хэлний үсгийн дарааллаас эхэлж альфа, бета, гамма, делта гэх мэт нэрлэж байна.

Страусс, Хоу нарын эрдэмтэд 1973 онд биологийн нөхөн үржихүй болон түүхэн чухал үйл явдлуудаас хамааран судалгаанд оролцогчдыг 17-20 насны үечлэлээр ангилсан (Carole L. Jurkiewicz 2020). 1980-аад оны үед өгөгдөлд суурилсан уг судалгаа үед хүн ам зүйн тархалтын хувьд эмэгтэйчүүдийн анхны хүүхэдтэй төрүүлэх дундаж нас 20 байжээ. Харин 2020 оны үед АНУ-д коллежийн зэрэггүй, орон нутгийн хүн амын хувьд анхны хүүхэдтэй болох дундаж нас 20 хэвээр байгаа бол коллеж болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй, хотожсон хүн амын хувьд 31 нас байна (Carole L. Jurkiewicz 2020). АНУ-ын 2019 оны статистикийн хорооны мэдээгээр хүн амын 62.7% нь хотожсон орчинд амьдарч байгаа бол эмэгтэйчүүдийн 33% нь хамгийн багадаа бакалаврын зэрэгтэй байна. Үүнээс үзэхэд 1980-аад оны үед нэг үеийн дундаж зөрүү насны буюу интервал 20 орчим жил байсан бол 2019-2020 оны үед 30 нас гэж үзэж болно (Carole L. Jurkiewicz 2020).

Монгол Улсад судлаач Б.Бүжинтуул 2013 оны Үндэсний Статистикийн Хорооны нөхөн үржихүйн насны 15-49 насны 12830 эмэгтэйг хамруулсан судалгааны өгөгдөлд дүн шинжилгээ хийж, Монгол эмэгтэйчүүдийн анхны хүүхдээ төрүүлэх дундаж нас 22 байна гэжээ (Бүжинтуул 2018). Эмэгтэйчүүдийн анхны хүүхдээ төрүүлэх нас нь биологийн хүчин зүйлсээс гадна боловсролын түвшин, ажил эрхлэлт, гэр бүл төлөвлөлт, гэрлэлтийн байдал, оршин суугаа бүс нутаг гэх мэт нийгэм, эдийн засаг, соёлын хүчин зүйлсийн нөлөөллөөс шалтгаалан харилцан адилгүй. Төрөлтийн нас хойшлох нэг хүчин зүйл бол боловсролын түвшин гэдгийг олон судалгаануудад дурдсан байдаг. Б.Бүжинтуулын судалгаагаар анхны төрөлтийн дундаж нас хотод оршин суудаг, чинээлэг өрх, дээд боловсролтой байх зэрэг нь анхны төрөлтийг хойшлуулах нөлөөтэй гэж дүгнэжээ (Бүжинтуул 2018).

Үеийн онцлогийг судлахдаа нас, цаг хугацаа, бүлэг гэсэн 3 хэмжигдэхүүнийг харгалздаг. Үүнд (Монголын Санхүүгийн Зах зээлийн Холбоо, СИКА ХХК, 2020):

- Нас – тухайн хүний амьдралын мөчлөгийн үеийг судална. Хүний нас, тодорхой амьдралын мөчлөгөөс шалтгаалж ойролцоо туршлагыг туулдаг. Жишээлбэл, хүүхэд гаргах, оюутан болох, тэтгэвэрт гарах гэх мэт амьдралын чухал мөчлөг нь нэг үеийг үүсгэдэг.
- Цаг хугацаа – тухайн цаг хугацаанд болсон нийгэм, эдийн засгийн болон бусад чухал үйл явдлуудыг судална. Нийгэмд өөрчлөлт үүсгэдэг үйл явдлууд үеүдэд харилцан адилгүй байдлаар нөлөөлдөг хэдий ч үеийг тодорхойлох нэг хүчин зүйл болдог. Жишээлбэл, 2015 онд Францад болсон террорист халдлага, 2020 оноос эхэлсэн Ковид-19 цар тахал нэг үеийг тодорхойлох онцгой үйл явдлууд юм.
- Бүлэг – тухайн насны хүний харьяалагдаж буй бүлгийг авч үздэг.

Нэг үеийг төрсөн жил, нас ойролцоо, амьдралын чухал үйл явдлуудыг хуваалцдаг бүлэг гэж тодорхойлж болох бөгөөд үе болгон өөрсдийн цаг үед тохиосон түүхийн чухал үйл явдлуудад үндэслэн янз бүрийн хандлага, итгэл үнэмшил, зан чанар болон үнэт зүйл (эрхэмж)-ийн цогцыг бүрдүүлдэг. Нэг үед хамаарагдах хувь хүмүүсийн зан чанар, үзэл бодол, хандлага, итгэл үнэмшил, амьдралын зорилго зэрэг олон хүчин зүйлээр ялгаа их байдаг ч суурь үнэт зүйл (эрхэмж)-ийн хувьд ихэнх нь ойролцоо байр суурьтай байх

хандлагатай. Жишээлбэл, АНУ-д 1946-1964 оны хүмүүсийг “Baby boom” буюу “Их төрөлтийн үе” гэж нэрлэдэг бөгөөд энэ үеийнхэн технологийг бараа бүтээгдэхүүн мэт харж, хөдөлмөрийг хувийн хөгжилд тус болох амьдралын утга учиртай хэсэг гэж үздэг талаар судлаач Куппершмидт (2000) тодорхойлжээ (Polat, S. Celik, C. Okcu, Y, 2019). Мөн ажлыг амьдралынхаа гол зүйл гэж үзэх ба ихэнхдээ ажил амьдралын тэнцвэрээ алдсан байдаг (Lester et al. 2012). Үнэхээр ч их төрөлтийн үеийнхэн ажил олгогчдоо үнэнч байдаг (Wong et al. 2008) гэж үздэг бөгөөд энэ нь тэдний эцэг эхийн бие биедээ үнэнч ханддаг байсны нэг хэлбэр байж болох юм.

Харин 1965-1980 онд төрсөн Х үеийнхэн технологийг амьдралын нэг хэсэг гэж үздэг ба ажил болон нийгмийн амьдралын тэнцвэртээ их анхаарал хандуулж, ажил дээрээ хүнээс хараат бус, бие даасан байдлаар ажиллахыг эрмэлзэж, ажил гэр бүлийн тэнцвэрт байдлыг хангахыг эрмэлздэг байна (S.Polat, C.Celik, Y.Okcu, 2019). 1981-1999 онд төрсөн Y үеийнхэн амлалтаар дүүрэн, өөртөө итгэлтэй, багаар ажиллах хандлагатай, амжилтад тэмүүлсэн, өөдрөг үзэлтэй, нийгмийн идэвхтэй, өөртөө итгэлтэй, амжилттай, нийтгэч, ёс зүйтэй, амьдралын ухаантай ба олон талыг хардаг гэж тодорхойлжээ (S.Polat, C.Celik, Y.Okcu, 2019).

Хүснэгт 1-д АНУ-д хийгдсэн судалгааны үр дүнд Х, Y, Z үеийн онцлогууд ерөнхий байдлаар хэрхэн тодорхойлогдсоныг харуулав.

Хүснэгт 1. Х, Y, Z үеийн онцлогууд

	Z үеийнхэн 1995-2015	Y үеийнхэн 1982-1994	X үеийнхэн 1961-1981	Их Төрөлт 1943-1960
Улс төр	Консерватив, хувиа хичээсэн үзэлтэй	Асуудалд төвлөрсөн, консерватив	Идеалист, төрд итгэх итгэл бага	Хүйтэн дайн, Вьетнамын дайн,
Эдийн засаг	Эдийн засгийн хямрал, өр төлбөрөөс зайлсхийх	Их уналт, их өртэй, чөлөөтэй зарцуулалт	Их өр, худалдааны эргэлт сайн	Бэлэн мөнгөний худалдааг илүүд үздэг, өрхийн зарцуулалт өндөр
Нийгэм	Жендерийн асуудал, ирээдүйд итгэх итгэл өндөр, нийгмийг өөрчлөх хүсэл тэмүүлэл, нийгмийн сүлжээ, бусдад үл итгэх	Дэг журамтай хүүхэд нас, өөртөө итгэлт, үргэлж ялагч болох хүсэлтэй, хүчирхийлэл ихсэх хандлага	Чөлөөт цагийг эрхэмлэдэг, өөртөө найддаг, амжилттай хүрэх хүсэлтэй, бие даан өөрийгөө хөгжүүлдэг	Оюутнуудын эсэргүүцэл, бослого, түргэн хоол, хотжилт ихсэх, бүх нийтийн эрүүл мэндэд анхаарах
Түүхийн чухал үйл явдал	Дэлхийн нийтийн асуудалд анхаардаг: уур амьсгалын өөрчлөлт, нууцлал, социал мэдээлэл, Ковид-19 тахал	2001/09/11 өдрийн террорист халдлага, Дундад Ази дахь дайн, реалити ТВ, нийгмийн тэмцлүүд, интернэтийн идэвхижил	Берлиний хана нурсан, өрх толгойлсон эцэг, эхчүүд нэмэгдсэн, ТВ-ийн нэвтрүүлэг үзэлт нэмэгдсэн, банк санхүүгийн байгууллагын өсөлт,	Хүйтэн дайн, Вьетнам, хар тамхи, Дэлхийн 2-р дайны дараах санхүүгийн өсөлт, саран дээр буусан, хүний эрхийн төлөөх тэмцэл

Ажил	Нийгмийн олон төрлийн мэдээлэл, харилцааны хэрэгслүүдийг ашигладаг, ажил мэргэжлээ олон солих хандлагатай	Нүүр тулан хүнтэй харилцахыг эрмэлздэг, өөрийгөө ажилтан бус хөдөлмөрийн гэрээ байгуулагч тал гэж үзэх хандлагатай	Ажил, амьдралын тэнцвэрийг олохыг эрхэмлэдэг, ажил олгогч бус ажил мэргэжилдээ илүү үнэнч	Ажил олгогчийг дуулгавартай дагадаг, гэр бүлд гол анхаарлаа хандуулдаг,
-------------	---	--	---	---

Эх сурвалж: Carole L. Jurkewicz. (2020). *Age diversity and Generational ethics, Encyclopedia of Business and Professional Ethics, Springer Nature Switzerland AG.*

Үеийн судалгааны хүрээнд сүүлийн 10 жилд үнэт зүйл (эрхэмж), итгэл үнэмшил, хандлагыг судлах нийгмийн сэтгэл зүйн судалгаа нэлээд хийгдэж байна. М.Рокичийн (1973) “Тэргүүлэх үнэт зүйл (эрхэмж)-ийн судалгаа” нь instrumental буюу хэрэгслийн 18, terminal буюу зорилгын 18 үнэт зүйл (эрхэмж)-д хуваагддаг (C.L.Jurkewicz, 2020). Зорилгын үнэт зүйл (эрхэмж) нь хүний тэмүүлдэг эцсийн зорилгуудыг илэрхийлэх бол, хэрэгслийн үнэт зүйл (эрхэмж) нь зорилгод хүрэх явцдаа баримтлах хэм хэмжээг илэрхийлнэ. Үнэт зүйл (эрхэмж) нь ёс зүйн шийдвэр гаргалт ба түүнээс үүдэлтэй зан үйлийн гол үндэс бөгөөд насан туршид харьцангуй тогтвортой хэвээр байдаг. Судлаач К.Жүркевич (2020) Рокичийн зорилгын үнэт зүйл (эрхэмж)-ийг үеийн бүлэг тус бүрийн хувьд тодорхойлсныг Хүснэгт 2-т харуулав.

Хүснэгт 2. X, Y, Z үеийн зорилгын үнэт зүйл (эрхэмж)

Д/д	Үнэт зүйл	Z үе 1995- 2015	Y үе 1982- 1994	X үе 1961- 1981	Их төрөлт 1943- 1960
1	Тухтай амьдрал (чинээлэг амьдрал)		√		√
2	Амжилтад хүрэх/хэрэгтэй байх мэдрэмж (хувь нэмэр оруулах)	√		√	√
3	Тайван байх (зөрчил, тэмцлээс хол байх)	√			√
4	Гоо зүй (урлагийг таашаах, байгальд ойр байх)	√		√	√
5	Сонирхолтой амьдрал (идэвхтэй, урам зоригтой амьдрах)		√	√	
6	Тэгш эрх (тэгш боломж, хүндлэл)	√		√	
7	Гэр бүлийн аюулгүй байдал (хайртай хүмүүсээ халамжлах, хайрлах)				√
8	Эрх чөлөө (эрх чөлөө, сонголт хийх)	√	√	√	
9	Аз жаргал (сэтгэл хангалуун байх)	√			
10	Дотоод амар амгалан (дотоод зөрчилгүй байх)	√			√
11	Хайр дурлал (дотно байх)				
12	Үндэсний аюулгүй байдал (дайн, зөрчил, терроризмоос ангид байх)	√			√
13	Баяр баясал (тааламжтай, зугаатай, чөлөөт цаг)		√	√	

14	Аврал (сүсэг бишрэл, мөнхийн амьдрал)		√		
15	Өөрийгөө хүндлэх (өөртөө итгэх итгэл)	√	√	√	√
16	Нийгэмд танигдах (хүндлэл, бишрэл)		√		√
17	Жинхэнэ нөхөрлөл (дотно найз, нөхөрлөл)			√	
18	Мэргэн ухаан (амьдралыг ойлгох)	√	√	√	

Эх сурвалж: Carole L. Jurkiewicz: *Age diversity and Generational ethics*, *Encyclopedia of Business and Professional Ethics*, Springer Nature Switzerland AG 2020.

Хүснэгт 2-г үзүүлснээр Их төрөлт, X, Y, Z үеийнхний хамгийн чухалд тооцогддог үнэт зүйл (эрхэмж)-ийн ялгааг харж болно. Их төрөлтийн үеийнхэн ажил олгогчдын тушаалд дуулгавартай хандаж, ажлаасаа өндөр түвшний сэтгэл ханамжтай, гэр бүл, хамтран ажиллагсадтайгаа дотно харилцаатай байхад ихээхэн анхаардаг. Тэд хүүхдүүдтэйгээ харилцаатай байхад анхаарч шинэ технологид уян хатан ханддаг. X үеийнхэн чөлөөт цаг ба ажлын цагийн уян хатан байдлыг шаарддаг ба хувийн хөгжил, нийгэмд хүлээн зөвшөөрөгдөх, шагнал урамшууллаар дамжуулан аюулгүй байдлаа хангадаг. Тэд нэр төрийн араас хөөцөлддөггүй, ажил олгогчдоо үнэнч бус бөгөөд удирдлагын шаталсан системийг дэмждэг. Y үеийнхэн технологийн өндөр мэдлэгтэй ч амьд харилцааг илүүд үздэг ба ур чадвараа байнга сайжруулан шинэчлэх замаар карьераа хадгалж үлддэг. Тэд өөртөө итгэлтэй, сорилгод дуртай, өөрийн ашиг сонирхлоос нийтийнхийг илүүд тавих хандлагатай. Баян чинээлэг байх нь тэдний хувьд чухал бөгөөд олсон мөнгөө хуримтлуулалгүйгээр зарцуулахыг илүүд үздэг бөгөөд ирээдүйдээ тийм ч итгэлтэй байдаггүй. Z үеийн хувьд ажлын байраа олон дахин сольдог, цахим харилцааг амьд харилцаанаас илүүд үздэг ба нийгэм, дэлхий дахинд анхаарлаа хандуулдаг. Тодорхой зорилго, хамтын ажиллагаа, шагнал урамшуулал болон зөвлөгөөг хүсдэг. Нийгэмд эерэг нөлөө үзүүлэх хүсэл эрмэлзэлтэй бөгөөд байгаль орчин, цаг уурын өөрчлөлт, тэгш байдалд анхаарал хандуулдаг.

Монгол Улсад үе хоорондын ялгаатай байдлыг тодорхойлсон судалгаа, эрдэм шинжилгээний ажлууд ховор бөгөөд Монголын Санхүүгийн Зах Зээлийн Холбоо, СИСА ХХК-ны захиалгаар 2020 онд “Монголын нийгмийн үеийг тодорхойлох судалгаа”-г 5 судалгааны нийт 7327 иргэний мэдээллийн санд дүн шинжилгээ хийсэн. Энэхүү судалгаанд социалист нийгмийн үе, 1990 оноос хойш Монгол Улсын нийгэм, эдийн засгийн шилжилт, 2000 оноос хойш өөрчлөгдөж буй хүмүүсийн амьдралын хэмнэл, мэдээллийн технологийн хурдацтай хөгжил зэрэг хүчин зүйлүүд нийгмийн үеүд бүрэлдэн тогтоход шууд нөлөөлсөн гэж үзжээ (Монголын Санхүүгийн Зах зээлийн Холбоо, СИКА ХХК 2020). Социологич Др. Д.Зоригт нийгэм дэх үеийг дараах байдлаар ангилсан боловч тодорхой судалгаанд үндэслээгүй тул судлаачийн гаргасан таамаглал гэж үздэг (Монголын Санхүүгийн Зах зээлийн Холбоо, СИКА ХХК 2020).

1. Зовогсод (1929 оноос өмнө төрөгсөд)
2. Зүтгэгсэд (1930-1945 он)
3. Алтан үеийнхэн (1946-1960 он)
4. Бэлэнчлэгсэд (1961-1974 он)
5. Давалгаанд цохиулагсад (1975-1995 он)
6. Анхны капиталистууд (1996-2010 он)
7. “Г” үеийнхэн (2011 оноос хойш төрөгсөд)

Судалгаанд оролцогчдыг (1) нийгэм, эдийн засгийг үнэлж буй байдал, (2) итгэл үнэмшил, үзэл бодол, (3) улс төрийн үзэл бодол, (4) ёс суртахууны баримжаа, (5) хэрэглээ гэсэн хүчин зүйлүүдээр судалгаа авсан. Тус судалгаагаар тухайн хүний төрж өссөн орчин, харьяалагдаж буй бүлгийн асуудалд хандах хандлагыг нийгэм, эдийн засгийн

онцлох үйл явдалтай холбон Монгол Улс дахь нийгмийн үеийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

1. Социалист үеийнхэн (1964 оныг хүртэл)
2. Завсрын үеийнхэн (1965-1982)
3. Шилжилтийн үеийнхэн (1983-1994)
4. Шинэ үеийнхэн (1995 оноос хойш)

Энэхүү судалгааг 2022 онд гүйцэтгэж, төрийн захиргааны албанд ажилладаг 552 хүнийг хамруулсан. Тоон судалгааг гүйцэтгэхдээ санал асуулгын аргыг ашигласан. Санал асуулгын асуултуудаа боловсруулахдаа судлаач К.Юркевичийн 2020 оны судалгаандаа нэгтгэсэн М.Рокичийн (1973) зорилгын буюу эцсийн 18 үнэт зүйлээр (terminal value) ажлын байранд үеийн үнэт зүйлийн харьцуулсан судалгаанд үндэслэн (Jurkiewicz.C.L, 2020) асуулгаа боловсруулав. Судалгааны асуулгаа “google forms” ашиглан онлайн аар авсан болно. Судалгааны анкет нь хаалттай 20, нээлттэй 3, Likert Scale-н 5 шатлал бүхий 2 ерөнхий асуулт; нийт 25 асуулттай. Мэдээлэл боловсруулахдаа SPSS /Statistical Package for the Social Sciences/ статистик программыг ашиглав. Тоон судалгааны хүрээнд цуглуулсан өгөгдлөө SPSS программыг ашиглан шинжлэхдээ тодорхойлох статистик шинжилгээ (descriptive statistics analysis); корреляцийн шинжилгээ (correlation analysis); регрессийн шинжилгээ (regression analysis) болон найдвартай байдлын шинжилгээг (reliability analysis) гүйцэтгэсэн.

Хүснэгт 3-т төрийн албан хаагчдын үнэт зүйлийг тодорхойлоход шаардлагатай мэдээлэл; тэдний нас, хүйс, гэрлэлт, боловсрол, тухайн байгууллагад ажилласан жил зэрэг шинж байдлын мэдээллийг нэгтгэн харууллаа. Судалгаанд оролцогчдын 68% нь эмэгтэй, 32% нь эрэгтэй, насыг таван бүлэгт хувааж авч үзэхэд 42.44% нь 31-40 насныхан, 21.31% нь 41-50 насныхан, 14.57% нь 26-30, 11.29% нь 51-60 насныхан, 9.47% нь 25 хүртэлх насныхан 0.91% нь 60-с дээш насныхан; Боловсролын түвшингээр авч үзвэл 75.42% нь бакалавр, 21.63% нь магистр, 2.77% нь дипломын, МСҮТ, 0.18% нь доктор зэрэгтэй байна. Гэрлэлтийг авч үзвэл 77.32% нь гэрлэсэн, 15.48% нь ганц бие, 4.92% нь салсан, 2.37% нь бэлэвсэн байна. Одоогийн ажиллаж буй байгуулагадаа 25.55% нь 1-5 жил, 24.36% нь 6-10 жил, 20.77% нь 1 жил хүртэл, 16.91% нь 11-15 жил, 7.9% нь 16-20жил, 4.23% нь 21-ээс дээш жил ажилласан албан хаагчид байна.

Хүснэгт 3: Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл

		Баянхонго р	Завхан	Сонгино Хайрхан дүүрэг	Сүхбаатар дүүрэг	Сүхбаатар аймаг	Сэлэнгэ аймаг	ХХАА ХҮЯ	ЦХЦ ХЯ
Тоо		98	79	45	81	95	100	25	30
Хүйс	Эр	36	28	14	24	39	21	6	7
	Эм	62	51	31	57	56	79	19	23
Нас	-25	12	10	1	5	11	3	2	8
	26-30	15	14	8	11	13	13	1	9
	31-40	43	35	21	30	45	44	9	10
	41-50	15	13	11	23	13	30	9	3
	51-59	13	6	3	15	12	9	5	0
	60+	1	0	1	0	1	1	0	0
Гэрлэлт	Гэрлэсэн	75	62	32	63	76	80	22	17
	Ганц бие	15	14	5	13	14	10	3	12
	Салсан	5	1	6	4	3	7	0	1
	Бэлэвсэн	3	1	2	1	2	3	0	0
Боловсрол	Бүрэн дунд	4	0	2	1	1	0	0	0
	Мэргэжлийн /техникийн	0	0	0	0	3	0	0	0
	Дипломын дээд	3	2	0	1	5	3	0	0
	Бакалавр	73	61	33	66	81	76	11	20
	Магистр	21	15	10	19	6	23	14	10
	Доктор	0	0	0	0	0	0	1	0
Тухайн байгууллагад ажилласан жил	1	24	13	11	9	12	15	6	24
	1-5	25	24	14	20	26	24	7	2
	6-10	19	25	16	17	28	26	4	4
	11-15	17	12	1	19	18	22	4	0
	16-20	4	7	2	9	8	10	4	0
	21+	9	1	1	7	3	3	0	0

Эх үүсвэр: Судлаач

График 1-д төрийн албан хаагчдын хувийн баримтлах үнэт зүйл, төрийн албаны үнэт зүйл, тухайн байгууллагын орчин дахь ёс зүй, нөхцөл байдлыг тодруулан, хэрхэн дүгнэж байгааг авч үзэв.

График 1. Судалгаанд оролцогчдын хувийн үнэт зүйл (эрхэмж)




График 1-д судалгаанд оролцогчдын хувийн үнэт зүйл (эрхэмж)-д гэр бүлийн аюулгүй байдал **88.7%**, тав тухтай амьдрал **87.3%**, сэтгэлийн амар амгалан байдал **83.1%**, аз жаргалтай, сэтгэл хангалуун байх **80.9%**, үндэсний аюулгүй байдал **79.59%** маш чухал гэж үзсэн бол нийгэмд танигдаж, бусдад хүлээн зөвшөөрөгдөх **42.8%**, ертөнцийг ойлгох **40.8%**, байгалийн гоо сайхан, урлагийг таашаах **37%** зэрэг үнэт зүйл (эрхэмж)-ийг хамгийн бага хувьтай сонгожээ. Өөрөөр хэлбэл, судалгаанд оролцогчдын хувьд гэр бүлийн аюулгүй байдал, тав тухтай амьдрал, сэтгэлийн амар амгалан байдал нь нийтлэг үнэт зүйл (эрхэмж) гэж дүгнэж болохоор байна.

График 2. X, Y, Z үеийн хувь хүний үнэт зүйл (эрхэмж)




Эх сурвалж: Судлаач.

График 2-с дүгнэхэд М.Рокичийн зорилгын үнэт зүйл (эрхэмж)-ийн судалгаагаар Х, Y, Z үеийн хувь хүний үнэт зүйл (эрхэмж)-ийн нийтлэг байдал ихтэй, онцлог харьцангуй бага илэрч байна гэж дүгнэж байна. Онолын хувьд Х, Y, Z үеийн хувь хүний үнэт зүйл (эрхэмж)-ийн нийтлэг байдал нь хувь хүний болон үеийн онцлогоос илүүтэй Монголчуудын чухалчлан дээдэлж буй үзэл санаа, зорилго, нийгмийн сайн сайхны тухай нэгдмэл ойлголт, итгэлийн амин чухал чанарыг агуулсан unconditional value буюу үнэмлэхүй үнэт зүйл (эрхэмж)-ийн шинжтэй холбоотой гэж дүгнэж байна.

Судалгаанд оролцогчдын Х, Y, Z үеийн хувьд гэр бүлийн аюулгүй байдал, тав тухтай амьдрал, сэтгэлийн амар амгалан байдал, аз жаргалтай сэтгэл хангалуун байх, тайван зөрчил тэмцлээс хол байх зэрэг нийтлэг үнэт зүйл (эрхэмж)-үүд байна. Харин нийгэмд танигдаж хүлээн зөвшөөрөгдөх, хайр дурлал, дотно найз нөхдийн жинхэнэ нөхөрлөл, үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө зэрэг үнэт зүйл (эрхэмж)-ийн онцлог илэрч байна.

График 3: Төрийн албаны үнэт зүйл /хувиар/




Төрийн албаны эрхэм зорилго, баримтлах зарчмуудын сайн мэднэ гэж тоон судалгааны 47.5%, чанарын судалгаанд оролцогчдын 60% үзжээ. Гэтэл төрийн албаны үнэт зүйлийг цөөн тооны тодорхой байдлаар томъёолох ёстой гэж тоон судалгаанд оролцогчдын 36.1% үзсэн нь төрийн албан хаагчид төрийн албаны үнэт зүйлийг сайн

мэднэ гэж боддог хэдий ч илүү тодорхой байдлаар шинэчлэх хүсэл байгааг илэрхийлж байна.


Судалгаанд хамрагдсан нийт төрийн албан хаагчид “Би өөрийн баримталдаг үнэт зүйлээ сайн мэднэ” /96.5%/; “Би төрийн албаны ёс зүйн үнэт зүйл, хэм хэмжээг ямагт мөрдөж ажилладаг” /96.5%/; “Удирдах албан тушаалтны өгсөн үүрэг даалгаврыг үргэлж биелүүлдэг” /96%/ хамгийн их хувьтай санал нийлсэн бол “Манай байгууллагын албан хаагчид ёс зүйн өндөр стандартыг баримталж ажилладаг” /77.1%/; “Манай байгууллагын удирдах албан тушаалтнууд өөрсдөө ёс зүйтэй байж, үлгэр дуурайлал үзүүлэхэд ихээхэн анхаардаг” /75.5%/; “Төрийн албаны үнэт зүйлийг тусгайлан онцолж тодорхойлоогүй тул сайн мэдэхгүй” /58.6%/ гэсэн хариултаудтай хамгийн бага хувьтай санал нийлсэн байна.

График 4: Манай байгууллагад залуу, дунд, ахмад үеийн хооронд үнэт зүйлийн ялгаатай.



Манай байгууллагад залуу, дунд, ахмад үеийн хооронд үнэт зүйлийн ялгаатай гэж нийтийн судалгаанд оролцогчдын 24.5% нь бүрэн санал нийлсэн; 66.1% нь санал нийлсэн бол 33.9% нь дунд зэрэг санал нийлсэн гэжээ. Үүнээс төрийн захиргааны байгууллагуудад залуу, дунд, ахмад үеийн хооронд үнэт зүйлийн ялгаа байгааг харуулж байна.

График 5. Манай байгууллагад ахмад, дунд, залуу үеийн үнэт зүйл (эрхэмж)-ийн ялгаа байдаг ба X, Y, Z үе




Эх сурвалж: Судлаач.

Нийт судалгаанд хамрагдсан оролцогчдын ажиллаж буй байгууллагад ахмад, дунд, залуу үеийн үнэт зүйл (эрхэмж)-ийн ялгаа байгааг Z үеийнхний (25-с доош нас) **39.7%** санал нийлсэн бол, Y үеийнхний (26-40 нас) **24.5%**, X үеийнхний (41-59 нас) **17.45%** нь бүрэн санал нийлж байна гэж хариулснаас дүгнэхэд нас залуу байх тусам үеийн үнэт

зүйл (эрхэмж)-ийн ялгааг илүү мэдэрч байна. Үе харгалзахгүйгээр судалгааны үр дүнг үзэхэд судалгаанд оролцогчдын ойролцоогоор 60% нь залуу, дунд, ахмад үеийн үнэт зүйл (эрхэмж)-ийн ялгаа байна гэж дүгнэжээ.

График 6: Миний үнэт зүйл төрийн албаны эрхэм зорилго, үнэт зүйлтэй ихэвчлэн



нийцдэг.

Нийт судалгаанд хамрагдсан төрийн захиргааны албан хаагчдын хувийн үнэт зүйл нь төрийн албаны эрхэм зорилго, үнэт зүйлтэй нийцдэг эсэхийг судлахад: 25 хүртэлх насныхны 50.7% нь санал нийлнэ; 26-30 насныхны 43.2% нь бүрэн санал нийлнэ; 31-40 насныхны 49% нь санал нийлнэ; 41-50 насныхны 53% нь санал нийлнэ; 51-59 насныхны 47% нь санал нийлнэ; 60-с дээш насныхны 75% нь санал нийлнэ гэсэн нь насны ангилал тус бүрд хамгийн өндөр үзүүлэлт байв. Санал нийлнэ болон бүрэн санал гэсэн хариултын нийт дүнгээр нь нэгтгэвэл төрийн захиргааны албан хаагчдын нас ахих тусам тэдний үнэт зүйл нь төрийн албаны үнэт зүйлтэй нийцдэг нь харагдаж байна.

Дүгнэлт

Монгол Улсад үеийн судалгаа, эрдэм шинжилгээний ажлууд ховор боловч сүүлийн жилүүдэд эрдэмтэн судлаачдын энэ чиглэлийн судалгаа эрчимжиж байна. Нийгмийн үе болгон янз бүрийн хандлага, итгэл үнэмшил, зан чанар болон үнэт зүйл (эрхэмж)-ийн цогцыг бүрдүүлж, нэг үед хамаарагдах хувь хүмүүсийн зан чанар, үзэл бодол, хандлага, итгэл үнэмшил, амьдралын зорилго зэрэг олон хүчин зүйлээр ялгаа их байдаг ч суурь үнэт зүйл (эрхэмж)-ийн хувьд ихэнх нь ойролцоо байр суурьтай байх хандлагатай нь тухайн улс үндэстний нийтлэг үнэт зүйл (эрхэмж) байдагтай холбоотой. Гэвч үе хоорондын үнэт зүйлийн ялгаа, онцлог байгааг олон улсын судалгаанууд нотолдог. Энэхүү судалгааны хүрээнд М.Рокичийн зорилгын үнэт зүйл (эрхэмж)-ийн судалгаагаар Х, Y, Z үеийн хувь хүний үнэт зүйл (эрхэмж)-ийн нийтлэг байдал ихтэй, онцлог харьцангуй бага илэрч байна гэж дүгнэж байна. Х, Y, Z үеийн хувь хүний үнэт зүйл (эрхэмж)-ийн нийтлэг байдал нь хувь хүний болон үеийн онцлогоос илүүтэй Монголчуудын чухалчлан дээдэлж буй үзэл санаа, зорилго, нийгмийн сайн сайхны тухай нэгдмэл ойлголтыг илэрхийлж буйг илтгэнэ. Х, Y, Z үеийн төдийгүй бусад нийгмийн

үеүдийн хооронд үнэт зүйл (эрхэмж)-ийн тодорхой ялгаа илэрч буй талаар судалгаанд оролцогчдын 60% нь залуу, дунд, ахмад үеийн үнэт зүйл (эрхэмж)-ийн ялгаа байна гэж хариулснаас дүгнэж болох бөгөөд цаашид энэ талаар илүү өргөн хүрээний, нарийвчилсан судалгаа хийх шаардлагатай гэж үзэж байна.


Ашигласан материал

- Carole L. Jurkiewicz. (2020). Age diversity and Generational ethics, Encyclopedia of Business and Professional Ethics, Springer Nature Switzerland AG.
- Duffy. B. (2021). Generations, does when you're born shape who you are. Atlantic. London.
- Mannheim. K. (1952). Essays, Routledge, republished 1972.
- Polat, S. Celik, C. Okcu, Y. (2019). School administrators' perspectives on teachers from different generations: SWOT analysis, Sage open, 1-12.
- Richard C.Box "Public service values", Routledge, USA, 2014.
- Rokeach 1973, Jurkiewicz 2013, Jurkiewicz 2020 in Carole L. Jurkiewicz. (2020). Age diversity and Generational ethics, Encyclopedia of Business and Professional Ethics, Springer Nature Switzerland AG 2020.
- S.Polat, C.Celik, Y.Okcu "School administrators' perspectives on teachers from different generations: SWOT analysis", Sage open, 2019: 1-12.
- Shalom H. Schwartz. (2012). An overview of the Schwartz theory of basic values, Online readings in psychology and culture, 2(1).
- Алтантуяа, Г. (2016). Ажилтнуудын сэтгэл ханамж ба үнэт зүйлийн баримжаалал хоорондын хамаарлыг судалсан нь, магистрын зэрэг горилсон судалгааны ажил.
- Бүжинтуул.Б "Монгол эмэгтэйчүүдийн анхны төрөлтийн нас, түүнд нөлөөлөгч хүчин зүйлс" Монголын хүн амын сэтгүүл, Дугаар 488, 28, 2018.
- Долгоржав, Я. (2022). Эрхэмж, Төрийн удирдлага онол, арга зүйн сэтгүүл, №18.
- Долгорсүрэн, Ж. Алтанзаяа, О. (2019). Монголчуудын үнэт зүйлийн хандлагад нөлөөж буй хүчин зүйл, Монголын соёл урлаг судлал сэтгүүл.
- Монголын Санхүүгийн Зах зээлийн Холбоо, СИКА ХХК. (2020). Монголын нийгмийн үеийг тодорхойлох судалгаа/ Mongolian generation study.
- СУИС. (2019). Монголчуудын үнэт зүйл судалгааны тайлан.
- СЭЗДС "Монголчуудын үндэсний үнэт зүйлийн судалгааны тайлан", УБ, 2015 он
- Удирдлагын Академи "Төрийн албаны үнэт зүйл: Тулгамдаж буй асуудлууд" судалгааны тайлан, Улаанбаатар, 2018 он.
- Удирдлагын Академи, Төрийн удирдлага онол, арга зүйн сэтгүүл, УБ, 2022 он №18.
- Удирдлагын Академи. (2017). Монголчуудын үнэт зүйлийг Шварцийн аргачлалаар тодорхойлсон нь" судалгааны тайлан.
- Чулуунбаатар, Г. (2019). Үнэлэмж үү, Үнэт зүйл үү, Монголын соёл урлаг судлал сэтгүүл.

SPSIRPA FORUM 2024

Session 8-4

Implementation of the ISO 9001:2015 quality management standard in local public government organizations: comprehensive competences of civil servants



**ОРОН НУТГИЙН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГАД ЧАНАРЫН
УДИРДЛАГЫН ISO 9001:2015 СТАНДАРТ ХЭРЭГЖҮҮЛЭЛТ: ТӨРИЙН АЛБАН
ХААГЧИЙН ЦОГЦ ЧАДАМЖ**

**IMPLEMENTATION OF THE ISO 9001:2015 QUALITY MANAGEMENT
STANDARD IN LOCAL PUBLIC GOVERNMENT ORGANIZATIONS:
COMPREHENSIVE COMPETENCES OF CIVIL SERVANTS**

МУИС-УТСОУХНУС-ийн НУТ-ийн багш Т.Ганчимэг

Хураангуй

Монгол Улсад ISO 9001:2015 стандартыг орон нутгийн ЗДТГ-ууд хэрэгжүүлж буй сайн туршлага бий болж буй боловч тус стандартыг хэрэгжүүлэлтийг дэмжих удирдлага зохион байгуулалтын бүтэц байхгүй, хэрэгжүүлэх нэгдсэн аргачлалгүй, зөвлөх байгууллагуудын мэдээлэл ил тод бус, үйл ажиллагааны уялдаа төдийлөн сайн биш байна. ISO 9001:2015 стандартыг хэрэгжүүлсэн төрийн байгууллагууд болон орон нутгийн ЗДТГ-т тус стандартын тасралтгүй сайжруулалт, дахин баталгаажуулалт эрсдэлд орсоор байгаа нь тухайн байгууллагын удирдлага, удирдлагын манлайлал, мэдлэг чадвар, төрийн албан хаагчдын цогц чадамж шууд нөлөөлж байна.

Иймд аймгийн ЗДТГ-т ISO 9001:2015 стандартын хэрэгжүүлэлт, сайжруулалт, төрийн албан хаагчдын буюу хүний нөөцийн цогц чадамжид суурилсан тасралтгүй байдлыг хангахад тулгамдаж буй асуудлыг тодорхойлох нь зүйтэй.

In Mongolia, while there has been successful implementation of the ISO 9001:2015 standard by local governors, there is a lack of management and organizational structure to support this implementation. Additionally, there is no unified implementation method, transparency in consulting organizations, or effective coordination of activities. This poses a risk to government organizations and local government agencies in terms of continuous improvement and re-certification of the standard, impacting the management, leadership, knowledge, and capabilities of government employees. It is crucial to address these issues to ensure the ongoing success and sustainability of ISO 9001:2015 implementation within provincial governments, focusing on enhancing the comprehensive competence of government employees.

Чанарын удирдлагын хөгжилд АНУ-ын эрдэмтэд, Японы эрдэмтэд ихээхэн хувь нэмэр оруулсан билээ. Америкийн компаниуд дэлхийн 2-р дайны дараа бага зардлаар чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлдвэрлэлийн үйл явцын оновчтой зохион байгуулалтыг амжилттай хэрэгжүүлжээ. Япон улс Walter Shewhart, Edwards Deming нарын тусламжтайгаар аж үйлдвэрлэлдээ чанарын удирдлагын арга барил, үйлдвэрлэл, өрсөлдөөнд чанарыг онцгойлж ажилласнаар 1970-аад онд чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэгч болж чадсан байна.

Дэлхийн 2-р дайны дараагаар Япон улс “чанарыг үндэсний "амьд үлдэх" стратеги хэмээн үзэж анхаарал хандуулж эхэлжээ¹. 1946 онд Японы эрдэмтэн, инженерүүдийн холбоо (JUSE) байгуулагдаж, 1949 онд чанарын хяналтын судалгааны бүлэг байгуулагдсан. Эрдэмтэд, инженерүүд, төрийн албан хаагчдаас бүрдсэн хороо

¹ Gibson Burrell; Mick Marchington; Paul Thompson: Management, Work and Organizations. p.20.

байгуулагдан бүтээмжийг дээшлүүлэх,². Япон улс чанарын удирдлагын амжилттай хэрэгжүүлэн 1970-аад онд чанарын хөгжлөөр тэргүүлэгч улсын нэг болсон бөгөөд АНУ-ын байгууллагууд эргүүлэн Японы байгууллагуудаас туршлага судлах үйл ажиллагаанууд өрнөж байв. Япон улсын чанарын удирдлагын тогтолцоонд хувь нэмэр оруулсан эрдэмтэд: дайны дараах амьдралын чанарыг сайжруулах үүрэг хүлээжээ.

Edwards Deming³: Байгууллагын удирдлага, зохион байгуулалт, ажилтнуудад анхаарал хандуулах, менежмент, системийн шинжлэх ухааны үзэл баримтлалыг чухалчилж байв. Тэрээр АНУ-ын компаниудын удирдлагын ажиллаж буй хэв маягийг шүүмжилж “чанарын асуудалд ажилтнуудыг “буруутгах соёл” нь сөрөг үр дагавартайг онцолж хэрвээ бурууг хэн нэгэнд хүлээлгэх шаардлагатай бол тэр нь “удирдлага” гэдгийг баталсан⁴. Удирдлага чанарын шаардлагад анхаарлаа хандуулж бүтэлгүйтлийн шалтгааныг ойлгох ёстой. Асуудлыг шийдвэрлэхийн тулд шалтгааныг тодруулж, бүтэлгүйтлийг нийтлэг болон онцгой шалтгаануудтай байдаг гэж үзсэн⁵. Үүнд:

- Нийтлэг шалтгаанууд нь системээс үүдэлтэй. Системийн асуудлууд нь тухайн байгууллагын үйл явцтай холбоотой тул тэдгээрийг зөвхөн систем, үйл явц, дүрэм, журамд өөрчлөлтөөр шийдэж, цар хүрээг нь багасгаж болно⁶.
- Харин бүтэлгүйтлийн онцгой шалтгаан нь ихэвчлэн харилцааны доголдол, үл ойлголцолтой холбоотой эсвэл дүрэм журмаас дагаж мөрдөөгүйгээс үүдэлтэй⁷.

Эдгээр шалтгаануудыг арилгахад удирдлагын үүрэг чухал, доголдол гарахад түүний шийдэл гарц гаргалгааг олох “хариуцлага” нь удирдлагад бий. Тэрээр байгууллагыг системтэй цогцоор нь хөгжүүлэх хэрэгтэй хэмээн системийн онолд тулгуурлан System of Profound Knowledge (SoPK) буюу гүн гүнзгий мэдлэгийн системийн онолын ойлголтыг гаргасан. Байгууллага нь хамтран ажилладаг хүмүүс, уялдаа холбоотой үйл явцуудаас бүрддэг тул системийн амжилт нь эдгээр бүрэлдэхүүн хэсгүүдийг амжилттай удирдах чадвараас хамаардаг. Тэрээр “бид хамтын ажиллагаа, менежментийн шинэ хэв маягт шилжих нь л хэрэгтэй энэ өөрчлөлтийг хийх арга бол “гүн гүнзгий мэдлэг” гэжээ. Мөн тогтолцоо (систем) бол системийн зорилгыг биелүүлэхийн тулд хамтран ажилладаг, бие биеэсээ хамааралтай бүрэлдэхүүн хэсгүүдийн сүлжээний сайжруулалтын чухал хэсэг нь “зорилго нь системд буй бүх хүмүүст ойлгомжтой байх ёстой”, зорилгодоо хүрэхэд бүрэлдэхүүн хэсгүүдийн уялдаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх явдал юм⁸. Байгууллага хямралаас гарах арга зам бол хүмүүс сэтгэхүйдээ гүн гүнзгий ойлголтыг нэвтрүүлснээр хэрэгжинэ гэжээ. Гүн гүнзгий мэдлэгийн систем нь 4 ойлголтыг тодорхойлсон⁹.

1. Системийн тухай ойлголт: Систем нь зорилготой байна, хэрэв зорилгогүй бол систем байхгүй. Тухайн системийн гол зорилго нь системийн үйл ажиллагаанд оролцогч бүх хүмүүст ойлгомжтой, мөн ирээдүйн төлөвлөгөөг агуулсан байна.

² Gibson Burrell; Mick Marchington; Paul Thompson: Management, Work and Organizations. p.21.

³ АНУ-ын статистикч түүнийг орчин үеийн чанарын хяналтын эцэг гэдэг. Дэлхийн 2-р дайны дараагаар Японы олон компаниудын чанарыг сайжруулахад тусалсан. Японы инженерүүд холбооноос жил бүр чанарын нэгдсэн удирдлагын тогтолцоог амжилттай хэрэгжүүлсэн байгууллагуудад Demig Prize шагналыг олгодог.

⁴ Edward Sallis: Total Quality Management in Education. Third edition. 2002. p.34-35.

⁵ Edward Sallis: Total Quality Management in Education. Third edition. 2002. p.38-39.

⁶ Edward Sallis: Total Quality Management in Education. Third edition. 2002. p.38

⁷ Edward Sallis: Total Quality Management in Education. Third edition. 2002. p.39.

⁸ Nigel Clements PRISM Consultancy Limited: Deming’s ‘System of Profound Knowledge’ in the 21st Century. p.4.

⁹ Frédéric Canard. W. E. DEMING, Pragmatism, and sustainability. 17th Annual International Deming Research Seminar, Mar 2011, New York, United States. pp.1-17. fffhalshs-00607366f

Систем дэх үйл явц хоорондын уялдаа, харилцааны үр нөлөө нь үйл явц бүрийн гүйцэтгэлийн адил чухал. Системийг оновчтой болгоход удирдлага системийн бүрэлдэхүүн хэсгүүдийн харилцан хамаарал, үйлчлэл бүрийг бүрэн мэдэж байх хэрэгтэй бөгөөд “удирдлагын оролцоо” чухал. Систем доторх үйл явцуудын харилцан хамаарал их байх тусам системийн зорилгыг тодорхой болгох, уялдуулах хэрэгцээ улам бүр нэмэгдэж дотоод харилцаа холбоо, хамтын ажиллагаа бэхжих болно. Ажилтан бүр өөрийгөө системийн бүрэлдэхүүн хэсэг гэж үзэх ёстой¹⁰.

2. Өөрчлөлт: Өөрчлөлт бидний эргэн тойронд оршдог, ирээдүйн өөрчлөлтийг таамаглах, хэрхэн урьдчилан сэргийлэх, ямар арга хэмжээ авахаа мэддэг байх. Deming: өөрчлөлтөд нөлөөлдөг олон шалтгаанууд байдаг боловч нийтлэг болон онцгой шалтгаан байдаг гэжээ. Нийтлэг шалтгаан бол системийн нэг хэсэг тул уг системийг өөрчлөхгүй бол арилдаггүй. Онцгой шалтгаан нь системийн нэг хэсэг биш цөөхөн шалтгаанууд тул мэдэгдэхүйц нөлөө үзүүлдэг тул анхааралтай хандаж арга хэмжээ авах хэрэгтэй¹¹.
3. Сэтгэл судлал: Менежерүүдэд "хүмүүс бие биеэсээ ялгаатай болохыг ойлгох"-д тусалдаг. Хүмүүс хоорондын ялгааг мэдсэнээр хүн бүрийн мэдлэг, чадвар, хандлагыг оновчтой ашиглах боломжтой. Хүмүүс янз бүрийн аргаар, өөр өөр хурдтайгаар суралцдаг. Deming: “хүмүүс ямар сэдэлтэй, тэдний үйлдлийн эх сурвалжийг мэдэх чухал тул системийн нэг хэсгийг сэтгэл судлал хэмээн тодорхойлсон. Хүний дотоод сэтгэл нь нийгмийн хариуцлагатай зан үйлийг төлөвшүүлж, хүмүүст тогтвортой байдлаар ажиллах боломжийг олгодог¹².
4. Мэдлэгийн онол: Удирдлагын шийдвэр гаргахад мэдлэг, тасралтгүй суралцах зэрэг шууд хэмжигдэхгүй үзүүлэлт чухал. Урьдчилан таамаглах, суралцах нь менежерүүд байгууллагыг ёс зүйтэй, тогтвортой удирдах, ажилтнуудын өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулах ач холбогдолтой элемент. Удирдлагын үүрэг бол урьдчилан таамаглах онолд суурилдаг гэж үзжээ. Тэрээр шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ нэвтрүүлэх, түүнийг худалдан авах хүмүүс, хэрхэн ашиглах, ямар хэрэгцээг хангахыг тодорхойлох, урьдчилан таамаглахыг шаарддаг. Урьдчилан таамаглал оновчтой байснаар байгууллага өөрт хэрэгцээтэй мэдлэгийг бий болгох боломжтой. Байгууллага дах мэдлэгийг олж авах суралцах үйл явц тасралтгүй үргэлжлэх ёстой¹³.

Deming “гүн гүнзгий мэдлэгийн систем”-ийн онолыг өөрийн 70 гаруй жилийн туршлагадаа үндэслэн боловсруулсан. Энэ онол нь байгууллагын удирдлага үйл ажиллагааг оновчтой удирдан зохион байгуулах зорилготой.

Joseph Juran: Чанар нь XXI зуунд нийгмийн өвчинтэй тэмцэх, баялгийн тэгш хуваарилалт, дээд боловсрол, эрүүл мэндийн салбарын хөгжил, дэвшлийн эх үүсвэр болж тэгш хүртээмжийг нэмэгдүүлэхэд ашиглагдана гэжээ. Чанарын ач холбогдлын мэдлэг нь үндэсний хэмжээнд хууль тогтоогчид, удирдах албан тушаалтнууд, эдийн засагчид чанарын гүйцэтгэл ба санхүүгийн үр дүнгийн харилцан хамаарал бий болж үндэсний, аж үйлдвэрийн болон бусад чанарын индексүүд хөгжинө (Maldolm Baldrige

¹⁰ Frédéric Canard. W. E. DEMING, Pragmatism, and sustainability. 17th Annual International Deming Research Seminar, Mar 2011, New York, United States. pp.1-17. fhalshs-00607366f

¹¹ Frédéric Canard. W. E. DEMING, Pragmatism, and sustainability. 17th Annual International Deming Research Seminar, Mar 2011, New York, United States. pp.1-17. fhalshs-00607366f

¹² Frédéric Canard. W. E. DEMING, Pragmatism, and sustainability. 17th Annual International Deming Research Seminar, Mar 2011, New York, United States. pp.1-17. fhalshs-00607366f

¹³Frédéric Canard. W. E. DEMING, Pragmatism, and sustainability. 17th Annual International Deming Research Seminar, Mar 2011, New York, United States. pp.1-17. fhalshs-00607366f

National Quality Award (MBNQA), European Quality Award, Canadian Awards for Business Excellence гэх мэт), чанартай холбогдолтой мэргэжлийн зэргийг коллежууд олгоно, чанарын мэдлэгийг олгох хичээлийн хөтөлбөрүүд бий болж, чанарын тухай судалгаа улам эрчимжиж мэргэжилтнүүдийн ур чадвар өснө гэсэн таамаглалуудыг дэвшүүлж байв. Түүхчид XXI зууныг чанарын зуун хэмээн нэрлэж ч магадгүй¹⁴ чанарын удирдлага дэлхийн хөгжлийн түлхүүр болж төрийн болон хувийн бүхий л байгууллагууд чанарын удирдлагын тогтолцоог бий болгоход үйл ажиллагаагаа чиглүүлж байна. Чанарын удирдлагын тогтолцоо байгууллагын үндсэн үйл ажиллагаанаас салангид ойлголт биш тул чанарын ойлголт, ач холбогдлыг байгууллагын үйл ажиллагаанд нягт шингээх хэрэгтэй.

Чанарын удирдлагын онолын орчин үеийн чиг хандлага төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд хэдийн нэвтэрч эхэлжээ. Улс орнууд төрийн байгууллага,” иргэдэд хамгийн ойр” орон нутгийн төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд онцгойлон анхаарсаар байна. Орон нутгийн төрийн байгууллага, албан хаагчдын мэдлэг, ур чадвар, хандлага нь төрийн бодлого, тогтвортой хөгжил, сайн засаглал, иргэдэд ойр, хүртээмжтэй үйлчилгээнд удирдлагын үр ашгийг нэмэгдүүлэх нь зорилгод чиглэсэн, олон талт удирдлагын арга барил, төрийн албан хаагчдын цогц чадамжаар хүрэх боломжтойг нотолсоор байна.

Armand Feigenbaum “Байгууллагын бүхий л чиг үүрэг нь чанарыг хариуцдаг хэмээх үзэл баримтлалыг дэвшүүлсэн нь багийн ажиллагааг дэмжин, хүн бүр байгууллагын үйл ажиллагаанд хувь нэмрээ оруулан ажиллаж буй мэдрэмжийг нэмэгдүүлж, илүү бүтээлч сэтгэлгээг бий болгодог тул чанар “бүх чиг үүрэг, үйл ажиллагааны асуудал” гэжээ¹⁵. Байгууллага системээрээ чанар луу чиглэж байж тогтолцоо үр дүнтэй хэрэгжинэ хэмээсэн.

Kaoru Ishikawa: “Байгууллага нэгдсэн зорилго бүхий алсын хараатай, удирдлагын бүх түвшинд, ажилтан бүр чанарын төлөө нэгэн зорилготой байх ёстой” хэмээн дотоод хэрэглэгчийн¹⁶ үзэл баримтлалыг дэвшүүлсэн. Түүний бусад эрдэмтдээс ялгагдах онцлог нь чанарын дээрээс доош (top-down) чиглэсэн удирдлагын тогтолцооноос татгалзаж доороос дээш (down-top) чиглэсэн удирдлагын тогтолцоог бий болгосон¹⁷. Тэрээр үзэл баримтлалдаа:¹⁸

1. Чанарын удирдлагад ажилтнуудыг оролцуулах;
2. Чанарын тогтолцоог шалгах дотоодын байнгын шалгалтыг зохион байгуулах;
3. Хүний нөөцийг тасралтгүй сургах;
4. Статистикийн шалгалтын арга барилыг өргөнөөр нэвтрүүлэхийг чухалчилж байв.

Өрнийн болон дорнын эрдэмтдийн чанарын удирдлагын үзэл баримтлал, онолын ойлголтуудыг нэгтгэн дүгнэвэл: (1) хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэх, (2) чанарын тасралтгүй сайжруулалтыг хангах, (3) удирдлагын манлайлал (4) ажилтнуудын идэвх, оролцоо (5) ажилтнуудын сургалт, хөгжлийн асуудлыг

¹⁴ Ben A. Maguad, Ph.D. and Robert M. Krone, Ph.D: Managing for Quality in Higher Education a Systems erspective, 2E. 2nd edition. 2017. p.27.

¹⁵ Ben A. Maguad, Ph.D. and Robert M. Krone, Ph.D: Managing for Quality in Higher Education a Systems erspective, 2E. 2nd edition. 2017. p.22.

¹⁶ Байгууллагын бүтээгдэхүүний эцсийн хэрэглэгч гадаад хэрэглэгч, харин үйлдвэрлэлийн шат дамжлагад ажиллаж байгаа ажилчид дотоод хэрэглэгч болно.

¹⁷ Н.Бурмаа: Төрийн байгууллагын чанарын удирдлага. Улаанбаатар 2017. х.56.

¹⁸ Т.Сосорбарам; Д.Баянмөнх: Үйлчилгээний чанарын удирдлага. Улаанбаатар 2013. х.140.

чухалчилжээ. Байгууллагын үйл ажиллагаанд чанарын удирдлагын тогтолцоог үр дүнтэй хэрэгжүүлэхэд хамгийн чухал оролцогчид байгууллагын удирдлага болон ажилтнууд юм.

Улс орнуудын Засгийн газрын нэн тэргүүний зорилтын нэг нь төрийн үйлчилгээний хүртээмж, чанарт анхаарах, түүнийг хэмжих, үнэлэх асуудал болж, шийдвэрлэхийн тулд чанарын удирдлагын тогтолцооны хэрэгжүүлэлтийн асуудалд анхаарал хандуулах болжээ. Европын Холбооноос төрийн захиргааны байгууллагын чанарыг сайжруулах асуудал ихээхэн анхааралд хандуулан улс орны эрх баригчид эдийн засаг, нийгэмд гарч буй өөрчлөлтөд дасан зохицох чадвартай, манлайлагч байж, өмнө хэрэгжсэн болон одоогийн бодлого нь ирээдүйд чиглэсэн үр дүнтэй байхыг зөвлөсөөр байна. Мөн Европын холбоонд элсэхийг хүсэж байгаа зарим улс иргэдийн амьдралын чанар, нийгмийн сайн сайхан байдлыг сайжруулах шаардлагыг¹⁹ хангахын тулд чанарын удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэх замаар төрийн байгууллагуудад соёлын өөрчлөлтийг хийж үйл ажиллагааны чанарыг сайжруулах арга болгон ISO 9001:2015 стандартыг хэрэгжүүлж байна.

АНУ, Япон улсуудын хувьд чанарын удирдлагын тогтолцооны хувийн салбартаа анхлан үр дүнтэй хэрэгжүүлэн цаашлаад төрийн байгууллагад хэрэгжүүлэхэд суурь үндсийг бий болгосон.

Чанарын удирдлагын ISO 9001:2015 стандартыг төрийн байгууллагуудад хэрэгжүүлэх үндэс нь төрийн албаны шинэтгэлтэй шууд уялддаг билээ. ЭЗХАХБ (OECD)-аас 2010 онд Австрали, Австри, Бельги, Канад, Дани, Франц, Япон, БНСУ, Нидерланд, Их Британи, АНУ-д төрийн албанд чадамжид суурилсан удирдлагад хийсэн дүн шинжилгээнд: “Төрийн албыг шинэчлэх суурь нөхцөл нь төрийн албан хаагчид мэдлэг, чадвартай байх” нь тэднээс хүлээх хүлээлтийг тодорхойлох, тэдний авьяас чадварыг нээн харуулах хэрэгсэл болох төдийгүй гүйцэтгэлийг сайжруулж, байгууллагын соёл, зан төлөвийг сайжруулах, хөгжүүлэх суурь гэсэн ерөнхий дүгнэлтийг гаргажээ.

ISO 9001:2015 стандартыг хэрэгжүүлэх санхүүгийн дэмжлэгийг НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс (НҮБХХ) хэрэгжүүлж байсан бол Польш улс ЕХ-нд элссэний дараа 2007-2015 оны хугацаанд гадаад санхүүжилтийн гол эх үүсвэр нь Европын Нийгмийн Сангаас (ESF) санхүүждэг хөтөлбөрүүд байсан²⁰. Улс орнуудын төрийн захиргааны байгууллагууд дийлэнхдээ Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр, Европын Холбоо зэрэг байгууллагуудын санхүүжилт, дэмжлэгээр чанарын стандартыг нэвтрүүлжээ.

Бүгд Найрамдах Польш Улсад орон нутгийн захиргааны байгууллагад шинэчлэл хийхтэй уялдуулан чанарын нэгдсэн удирдлагын ISO 9001 стандартыг²¹ 2000 оноос эрчимтэй хэрэгжүүлж эхэлсэн байна²². Тус улсын Дзерзони хотын захиргаа 2000 оны 1

¹⁹ Ivana Čandrlić-Dankoš: Implementing a Quality Management System in the Croatian Public Administration. 2021. Ekonomski vjesnik/Econviews - Review of Contemporary Business, Entrepreneurship and Economic Issues, 34(1). p.215.

²⁰ Marek Cwiklicki, Kamila Pilch, Michał Zabinski: ISO 9001 quality management systems in local government institutions in Poland: past, present and future. International Review of Administrative Sciences 2020, Vol. 86(4) pp.803.

²¹ Marek Cwiklicki, Kamila Pilch, Michał Zabinski: ISO 9001 quality management systems in local government institutions in Poland: past, present, and future. International Review of Administrative Sciences 2020, Vol. 86(4) pp.800.

²² Urszula Kobylinska: Quality management tools in local units in Poland. 2013. Przedsiębiorczość i Zarządzanie8 Wydawnictwo SAN, Vol XIV (12), pp.428.

сард ISO 9001 стандартын баталгаажуулалт²³ хийсэн нь анхдагч болжээ. Дээрх улс орнууд засгийн газрынхаа түвшинд чанарын удирдлагын үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх бодлого, хөтөлбөрүүдийг баталж, чанарын удирдлагыг дэмжих удирдлага, бүтэц зохион байгуулалтыг бий болгон шат дараалсан арга хэмжээг тууштай авч ажилласнаар орон нутгийн төрийн захиргааны байгууллагад чанарын удирдлагыг хэрэгжүүлсэн.

Польш Улсын Ерөнхий сайд 1999 онд “Төрийн удирдлагын чанарын менежмент” хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн²⁴. НҮБХХ-өөс “POL/97/001 Европын нэгтгэлд чадавхийг бэхжүүлэх” төслийг Польш улсад хэрэгжүүлсэн²⁵. Төслийн хүрээнд 1997-2001 онд шаардлагатай шинэчлэлийн хурдыг нэмэгдүүлэх, шилжилтийн үеийн нийгэмд тулгарч буй хүндрэл бэрхшээлийг арилгах, орон нутгийн захиргааны чадавхыг сайжруулах чиглэлээр хэд хэдэн чиглэлээр техникийн туслалцаа үзүүлэх²⁶ хүрээнд “Шүхэр” төслийг хэрэгжүүлсэн.

Төслийн үйл ажиллагааны хүрээнд:

1. Чанарын удирдлагын стандарт, загваруудыг (ISO 9000, EFQM) жижиг, дунд үйлдвэрүүдэд нэвтрүүлэх;
2. Риогийн хөтөлбөрийн 21 зөвлөмжид нийцсэн тогтвортой хөгжлийн төлөвлөгөөг боловсруулахад орон нутгийн болон мужийн засгийн газарт туслах;
3. Төрийн удирдлагын үйл ажиллагаанд чанарын удирдлагын стандарт, загваруудыг нэвтрүүлэх гурван үндсэн үйл ажиллагаанд анхаарсан²⁷.

Төслийн хүрээнд эдгээр үйл ажиллагаануудыг хэрэгжүүлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлсэн. Дээд удирдлагын зүгээс төрийн байгууллагад чанарын удирдлагын тогтолцоог хэрэгжүүлснээр гарсан үр дүнг түгээн дэлгэрүүлсний үр дүнд 2004 онд 70 төрийн захиргааны байгууллага²⁸ ISO 9001 стандартын баталгаажуулалт хийлгэсэн.

Польш улс ЕХ-д элссэний дараагаар төрийн захиргаа дах чанарын удирдлагын санаачилга үйл ажиллагаануудад идэвхтэй оролцож эхэлсэн²⁹. Польш улсын хувьд чанарын удирдлагыг хэрэгжүүлэхдээ дараах баримт бичиг санаачилгуудыг гаргасан. Үүнд³⁰:

- Үндэсний шинэчлэлийн хөтөлбөр 2005-2008

²³ Marek Cwiklicki, Kamila Pilch, Michał Zabinski: ISO 9001 quality management systems in local government institutions in Poland: past, present, and future. *International Review of Administrative Sciences* 2020, Vol. 86(4) pp.803.

²⁴ Konrad Głębocki: Human Resources Management and Quality Management Systems in Public Offices on Polish Examples. *International Conference on Management of Human Resources 2012 booklet*. pp.143.

²⁵ Barbara Przybylska, Tomasz Prokopowicz: Evaluation of the Umbrella Project POL/97/001 - Capacity Building for European Integration Activities from January 1 to February 28, 2001. by the United Nations Development Programme and the Government of Poland. March 5, 2001.

²⁶ Barbara Przybylska, Tomasz Prokopowicz: Evaluation of the Umbrella Project POL/97/001 - Capacity Building for European Integration Activities from January 1 to February 28, 2001. by the United Nations Development Programme and the Government of Poland. March 5, 2001.

²⁷ Barbara Przybylska, Tomasz Prokopowicz: Evaluation of the Umbrella Project POL/97/001 - Capacity Building for European Integration Activities from January 1 to February 28, 2001. by the United Nations Development Programme and the Government of Poland. March 5, 2001.

²⁸ Konrad Głębocki: Human Resources Management and Quality Management Systems in Public Offices on Polish Examples. *International Conference on Management of Human Resources 2012 booklet*. pp.143.

²⁹ Republic of Slovenia Ministry of Public Administration: *Comparative Analysis: Quality Management in Public Administrations of the EU Member States*. Ljubljana, October 2008. pp. 45.

³⁰ GIZ: Төрийн байгууллагын удирдлагын тогтолцоог сайжруулах нь: Чанарын удирдлагын тогтолцооны олон улсын стандарт ISO 9001:2008-ыг төрийн байгууллагуудад нэвтрүүлэх гарын авлага. 2013. х.104.

- Зохицуулалтын шинэчлэлийн хөтөлбөр
- Авлигын эсрэг стратеги 2005-2009
- Үндэсний стратегийн хүрээ 2007-2013
- Хүний нөөцийн үйл ажиллагааны хөтөлбөр
- Нөхөрсөг захиргааны хөтөлбөр 1999
- Байгууллагын хөгжлийн хөтөлбөр 2002-2004 эдгээр баримт бичгүүдийн хүрээнд чанарын удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэх санал санаачилгыг хэрэгжүүлсэн.

Судлаач Moczuka болон Rogala нарын Бүгд Найрамдах Польш Улсын 170 гаруй байгууллагыг хамруулан 2020 онд гүйцэтгэсэн судалгааны үр дүнгээр чанарын нэгдсэн удирдлагын стандартыг хэрэгжүүлж буй албан хаагчид “цогц чадамж”-тай байх шаардлагатай³¹-г нотолсон. Тус судалгааны үр дүнд чанарын удирдлагын стандартыг хэрэгжүүлж буй албан хаагчид “цогц чадамж”-тай байх шаардлагатай³²-г нотолжээ. Тэд орон нутгийн захиргааны байгууллагад чанарын удирдлагын стандартыг хэрэгжүүлэхэд (i) Мэдлэг; (ii) Чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардагдах ур чадвар; (iii) Хувь хүний ур чадвар; (iv) Хандлага, үнэт зүйл гэсэн цогц чадамж шаардлагатайг тодорхойлсноор³³ чанарын удирдлагын тасралтгүй сайжруулалтыг хангах, хүний нөөцийн сургалт хөгжлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх, гүйцэтгэлийн үр дүнг сайжруулахад чухал нөлөөтэйг онцолсон байна.

Хүснэгт 1. Marta Moczulska Piotr Rogala (2019): Holistic competence model/Чадамжийн цогц загвар

Мэдлэг	M1. Чанарын удирдлагын зарчмууд, аргууд, техникүүд
	M2. ISO 9001 стандартын тухай
	M3. ISO 9000 бүлэг стандартын тухай
	M4. Харилцагчийн сэтгэл ханамж, хэрэгцээг судлах арга хэрэгсэл
	M5. Зорилгуудыг тодорхойлох, түүнд хүрсэн эсэх
	M6. Үйл явцын удирдлага
	M7. Нийлүүлэлтийн зохион байгуулалт, хяналтын арга хэрэгсэл
	M8. Хүний нөөцийн удирдлага
	M9. Өөрчлөлтийн удирдлага
	M10. Зөрчилдөөний удирдлага
	M11. Байгууллагын чиг үүрэг
	M12. Байгууллагын онцлох чиг үүрэг
	M13. Зөвлөгөө, сургалт
Чиг үүргээ гүйцэтгэх ур чадвар	ЧҮ1. Баримт бичгүүдийг боловсруулах/үйл явцын зураглал
	ЧҮ2. Байгууллагын үйл ажиллагааг боловсронгуй болгох асуудалд дүн шинжилгээ хийж, санал боловсруулах
	ЧҮ3. Хурал зохион байгуулах, удирдах

³¹ Marta Moczulska, Piotr Rogala: Mapping Competences for the ISO 9001 Management representative. International Journal for Quality Research. 2020. Vol 14(3), pp.931-950.

³² Marta Moczulska, Piotr Rogala: Mapping Competences for the ISO 9001 Management representative. International Journal for Quality Research. 2020. Vol 14(3), pp.931-950.

³³ Marta Moczulska, Piotr Rogala: Mapping Competences for the ISO 9001 Management representative. International Journal for Quality Research. 2020. Vol 14(3), pp.939.

	ЧҮ4. Сайжруулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх
	ЧҮ5. Хяналтыг зохион байгуулах
	ЧҮ6. Сургалт зохион байгуулах
	ЧҮ7. Нийтэд мэдээлэл хүргэх, илтгэх чадвар
Хувь хүний ур чадвар	ХУ1. Идэвхтэй сонсох
	ХУ2. Шаргуу, тууштай байдал
	ХУ3. Шийдэмгий байдал
	ХУ4. Өөртэй итгэлтэй
	ХУ5. Нээлттэй
	ХУ6. Нөлөөлөх чадвар
	ХУ7. Дүн шинжилгээ хийх
	ХУ8. Шүүмжлэлт сэтгэлгээ
	ХУ9. Бүтээлч байдал
	ХУ10. Харилцааны чадвар
	ХУ11. Хамтын ажиллагаа
	ХУ12. Сэтгэл хөдлөлөө шинжлэх, тодорхойлох, хянах ур чадвар
Хандлага, үнэт зүйл	ХА1. Шударга, үнэнч
	ХА2. Тэвчээртэй
	ХА3. Дайчин шургуу
	ХА4. Хүндэтгэлтэй
	ХА5. Хариуцлагатай
	ХА6. Найдвартай
	ХА7. Чанарын удирдлагын үйл ажиллагаанд оролцоотой байх

Эх үүсвэр: Marta Moczulska, Piotr Rogala: Mapping Competences for the ISO 9001 Management representative. International Journal for Quality Research. 2020. Vol 14(3), pp.931-950.

Орон нутгийн захиргааны байгууллагад чанарын удирдлагын стандартыг хэрэгжүүлэхэд дараах цогц шаардлагатайг тусган гаргажээ. ISO 9001:2015 стандартын 5.2.1-д зааснаар дээд удирдлага чанарын бодлого боловсруулахдаа хүний нөөцийн чадамжийн хүрээ, хэрэгцээ, бодит чадамж, чадамжийн зөрүү, сургалт болон хөгжлийн хэрэгцээ зэргийг шинжлэх ухааны үндэслэлтэй тодорхойлох шаардлагатай. Мөн 6.2.2-д чанарын зорилтуудад хүрэх төлөвлөлт хийхийн тулд байгууллага юу хийсэн байх, ямар нөөц шаардлагатай болох, хэн хариуцаж ажиллах, хэзээ хийж дуусгах, үр дүнг хэрхэн үнэлэх тухай тодорхойлох шаардлагыг тусгасан нь хүний нөөцийн чадамжийн хэрэгцээг энэхүү төлөвлөлтийн үе шатанд хамтатган хийх боломжтойг харуулж байна³⁴. Ингэснээр чадамжид суурилсан чанарын удирдлагын тогтолцоог хэрэгжүүлнэ. Үүний тулд тус стандартын 7.1 Нөөц хэсэгт дурдсанаар чанарын менежментийн тогтолцоог бий болгох, хэрэгжүүлэх, хадгалах, үргэлжид сайжруулахад шаардлагатай нөөцийг тодорхойлж хангахад хүний нөөцийг чадамжийг хэрэгжүүлэхээр заасан.

Монгол Улсын Үндсэн хуульд “Монгол Улс нь төрийн байгууламжийн хувьд нэгдмэл³⁵”, хүн амын оршин суугаа нутаг дэвсгэрээр засаг захиргааны нэгжид

³⁴ MNS ISO 9001: 2016 Чанарын менежментийн тогтолцоо – шаардлага, Монгол Улсын стандарт

³⁵ Монгол Улсын Үндсэн Хууль 1992. §2.1.

хуваасан, нэгжийн шатлал бүр нь эрх зүйн байдал ижил “энгийн нэгдмэл” улс³⁶. Засаг захиргааны хувьд аймаг, нийслэлд, аймаг нь суманд, сум нь багт, нийслэл нь дүүрэгт, дүүрэг нь хороонд хуваагдаж³⁷ орон нутгийн удирдлагын тогтолцоо нь нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах үндсэн дээр хэрэгждэг³⁸. Монгол Улсын 21 аймагт орон нутгийн захиргааны нийт 908³⁹ байгууллага үйл ажиллагаа явуулж байгаагаас: аймаг, нийслэлийн ЗДТГ - 22, сум, дүүргийн ЗДТГ – 339, засаг даргын дэргэдэх агентлаг 547⁴⁰ үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр байгууллагын эрх зүйн байдал чиг үүргээ хэрэгжүүлж байгаа нутаг дэвсгэрийн хувьд л ялгаатай бөгөөд чиг үүргийн хувьд адил. Гол үүрэг гүйцэтгэгч захиргааны нэгж нь аймаг, нийслэлийн ЗДТГ. МУ-ын аймаг, нийслэлийн шаталсан удирдлага нь Үндсэн хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомж, эрх зүйн хүрээнд орон нутагт урт хугацааны бодлогыг төлөвлөх, хэрэгжүүлэх, зохион байгуулах, тайлагнах чиг үүрэгтэйгээс гадна дотоод шатны байгууллагуудад үүрэг чиглэл өгч ажлын үр дүнг үнэлнэ. Аймгийн ЗДТГ⁴¹ нь харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратеги төлөвлөлт, хөтөлбөр, төслийг боловсруулах; засаг даргын үйл ажиллагаанд мэргэжил, арга зүй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх, ажиллах нөхцөлөөр хангана. Засаг дарга, доод шатны нутгийн захиргааны байгууллагыг шаардлагатай мэдээллээр хангах үүрэгтэй. Түүнчлэн хууль тогтоомж, Засгийн газар, Хурал, Засаг даргын шийдвэрийг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулах, гүйцэтгэлд нь хяналт тавьж үр дүнг тооцно. Тамгын газрын бичиг хэргийг хөтлөх, байгууллага, иргэдээс ирүүлсэн өргөдөл, санал, гомдлыг шийдвэрлэх ажлыг зохион байгуулна⁴². Хүний нөөцийн бодлогын түвшинд төрийн захиргааны ажилтныг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх, тэдний ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах үүрэгтэйгээс гадна тухайн шатны хурлын хэвийн үйл ажиллагааг ханган үйлчлэх⁴³ үүрэгтэй. Монгол Улсын 21 аймгийн ЗДТГ-ын бүтцийг газар нутгийн хэмжээ, хүн амын тоо, нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалан 15⁴⁴ аймгийг 53 хүртэлх, 5⁴⁵ аймгийг 51 хүртэлх, 1⁴⁶ аймгийг 37 хүртэлх албан хаагчтай байхаар Монгол Улсын Засгийн Газрын 2021 оны 12-р сарын 14-ны 377-р тогтоолоор баталсан.

МУ-ын Засгийн газрын хэрэг эрхлэх газраас 2022 онд зохион байгуулсан ”Төрийн бүтээмж”-ийн үндэсний чуулганд орон нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд гол тулгамдаж буй асуудлыг авлига, хүнд суртал; бүтэц, зохион байгуулалт, уялдаа холбоо; хүний нөөцийн үр ашигт байдал, цалин хангамж; ил тод,

³⁶ Н.Лүндэндорж: Төрийн онол. Улаанбаатар 2008. х.162.

³⁷ Монгол Улсын Үндсэн Хууль 1992. §57.1.

³⁸ Монгол Улсын Үндсэн Хууль 1992. §52.1.

³⁹ Засгийн Газрын Хэрэг Эрхлэх Газар, Конрад Ауденауэрын сан: “Төрийн бүтээмж” үндэсний чуулган. ЗГХЭГ-ын дарга Д.Амарбаясгалан: Цомхон, чадварлаг, иргэндээ ойр төрийн үйлчилгээ илтгэл. 2022.10.06

⁴⁰ Засгийн Газрын Хэрэг Эрхлэх Газар, Конрад Ауденауэрын сан: “Төрийн бүтээмж” үндэсний чуулган. ЗГХЭГ-ын дарга Д.Амарбаясгалан: Цомхон, чадварлаг, иргэндээ ойр төрийн үйлчилгээ илтгэл. 2022.10.06

⁴¹ Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын ажлын алба нь Тамгын газар байна.

⁴² Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль. Улаанбаатар 2020.12.24. §67

⁴³ Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль. Улаанбаатар 2020.12.24. §67

⁴⁴ Архангай, Баянхонгор, Баян-Өлгий, Говь-Алтай, Дархан-Уул, Дорнод, Завхан, Орхон, Өвөрхангай, Сэлэнгэ, Төв, Увс, Ховд, Хөвсгөл, Хэнтий аймгийн Засаг даргын Тамгын газрууд.

⁴⁵ Булган, Дорноговь, Дундговь, Өмнөговь, Сүхбаатар аймгийн Засаг даргын Тамгын газрууд.

⁴⁶ Говьсүмбэр аймгийн Засаг даргын Тамгын газар.

ойлгомжтой байдал; залгамж чанар, тасралтгүй хөгжил хэмээн тодорхойлжээ⁴⁷. Эдгээр асуудлын хүрээнд ЗДТГ-ын үйл ажиллагааны уялдаа, ил байдал, хүртээмжтэй байдал зэргийг анхаарч үйл ажиллагааг тасралтгүй сайжруулах ажиллах шаардлага бий болжээ хэмээн дүгнэсэн. Олон улсын түвшинд ч орон нутгийн түвшинд иргэдэд хүртээмжтэй, чанартай үйлчилгээнд анхаарч ажиллахыг эрдэмтэн судлаачид анхааруулан сайн засаглалын бодлогын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааг үр дүнтэй болгоход чухал нөлөөлөх арга хэрэгслийн нэг нь “ISO 9001:2015” стандарт хэмээн зөвлөсөн. Монгол Улсын Засгийн газар 2008 онд “ISO 9000 бүлэг стандартыг төрийн байгууллагад хэрэгжүүлэх төлөвлөгөө”-г 265-р тогтоолоор: төрийн байгууллагын үйл ажиллагааны менежментийн шинэ тогтолцоог бий болгож эхлэх; сургалт, сурталчилгаа явуулах; чанарын удирдлагын тогтолцоог зарим төрийн байгууллагад нэвтрүүлж, хэрэгжүүлэх, баталгаажуулах арга хэмжээнүүдийг төлөвлөн баталсан билээ. Урт хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан зорилго, зорилтуудыг үр дүн, үр өгөөжтэй биелүүлэх, төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны удирдлага, төлөвлөлт, зохион байгуулалтыг оновчтой болгох, тасралтгүй сайжруулах, төрийн үйлчилгээний чанар, гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөнд чиглэсэн, ил тод, шуурхай иргэдийн хэрэгцээ шаардлага, хүсэл сонирхлыг төрийн бодлого, үйл ажиллагаанд тусгаж шийдвэр гаргах нь ардчилсан нийгмийн үндсэн зарчмыг хэрэгжүүлэхэд тустай. Тогтвортой хөгжлийн зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд гол оролцогчдын нэг нь орон нутгийн төрийн захиргааны байгууллага мөн гэдгийг Нэгдсэн үндэстний байгууллагаас тодорхойлсон энэ хүрээнд дэлхийн стандартын байгууллагаас орон нутгийн захиргааны байгууллагын хувьд ISO 9001:2015 стандартыг хэрэгжүүлэхэд удирдамж болгон ашиглах ISO 18091:2019 стандартыг батлан гаргасан. Монгол Улсын Их Хурлын 2021 оны 102 дугаар тогтоолоор баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-н хүрээнд “Төрийн бүтээмжийн сэргэлт”-ийн асуудлыг онцгойлон орон нутгийн ЗДТГ-т чанарын удирдлагын тогтолцооны хэрэгжүүлэлт, нэвтрүүлэлтийг нэгдсэн бодлогоор дэмжихийг анхаарсан.

Засгийн газрын хэрэг эрхлэх газраас орон нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны чанарт анхаарч төрийн үйлчилгээг чанартай, хүртээмжтэй хүргэх⁴⁸ талаар: төрийн байгууллагын үйлчилгээг иргэдэд илүү ойртуулах, үйл ажиллагааг илүү тодорхой, ойлгомжтой болгох; төрийн албан хаагчдын чадавх, нөөцийг үр ашигтай ашиглах; байгууллага хоорондын зорилт, чиг үүргийн давхардлыг арилгах; төр хувийн хэвшлийн гүйцэтгэх боломжтой үйл ажиллагааг эрхлэхгүй, өрсөлдөхгүй байх; байгууллагын хүний нөөцийн хөдөлгөөнөөс үл хамааран төрийн үйлчилгээ тасралтгүй, тогтвортой байх зэрэг чухал асуудлуудыг хэлэлцсэн. Түүнчлэн⁴⁹: байгууллага, нэгж, ажилтны чиг үүрэг давхардал, хийдэлгүй оновчтой болох; байгууллагын дотоод үйл ажиллагааны чиглэлийг тодорхой болох; нэгжүүд, ажилтны ажлын уялдаа сайжирч “үйлчилгээ төвтэй үйл ажиллагаа” руу шилжих; бодлогын баримт бичигт тусгагдсан зорилтын хэрэгжилт сайжрах; иргэдэд үзүүлэх үйлчилгээ ойлгомжтой, нээлттэй болох боломжууд бий болно гэж дүгнэжээ. МУ-ын ЗГ-аас бодлогын баримт бичигт тусгагдсан үйл ажиллагаануудыг үр дүнтэй хэрэгжүүлэх, мөн дэвшүүлж буй зорилтод хүрч

⁴⁷ Засгийн Газрын Хэрэг Эрхлэх Газар, Конрад Ауденауэрын сан: “Төрийн бүтээмж” үндэсний чуулган. ЗГХЭГ-ын дарга Д.Амарбаясгалан: Цомхон, чадварлаг, иргэндээ ойр төрийн үйлчилгээ илтгэл. 2022.10.06

⁴⁸ Засгийн Газрын Хэрэг Эрхлэх Газар, Конрад Ауденауэрын сан: “Төрийн бүтээмж” үндэсний чуулган. ЗГХЭГ-ын дарга Д.Амарбаясгалан: Цомхон, чадварлаг, иргэндээ ойр төрийн үйлчилгээ илтгэл. 2022.10.06

⁴⁹ Засгийн Газрын Хэрэг Эрхлэх Газар, Конрад Ауденауэрын сан: “Төрийн бүтээмж” үндэсний чуулган. ЗГХЭГ-ын дарга Д.Амарбаясгалан: Цомхон, чадварлаг, иргэндээ ойр төрийн үйлчилгээ илтгэл. 2022.10.06

хүлээгдэж буй үр дүнг бодитой болгоход олон улсын шилдэг туршлага болох ISO 9001:2015 чанарын удирдлагын тогтолцооны стандартыг ашиглана гэж үзсэн⁵⁰.

Хүснэгт 1. МУ-ын орон нутгийн төрийн захиргааны байгууллагуудын ISO 9001:2015 стандартын хэрэгжүүлэлт (2022 оны 10 сарын байдлаар)


Байгууллага	Байгууллагын тоо	Баталгаажилт авсан байгууллагын тоо	Нэвтрүүлж байгаа байгууллагын тоо	Нэвтрүүлээгүй байгууллагын тоо
Аймаг, нийслэлийн ЗДТГ	22	14	5	3
Сум, дүүргийн ЗДТГ	339	9	55	275
Засаг даргын дэргэдэх агентлаг	547	39	65	443
Нийт	908	62	125	721

Эх үүсвэр: Засгийн Газрын Хэрэг Эрхлэх Газар, Конрад Ауденауэрын сан: “Төрийн бүтээмж” үндэсний чуулган. ЗГХЭГ-ын дарга Д.Амарбаясгалан: Цомхон, чадварлаг, иргэндээ ойр төрийн үйлчилгээ илтгэл. 2022.10.06

МУ-ын орон нутгийн нийт төрийн захиргааны 908 байгууллагаас 62 байгууллага ISO 9001:2015 стандартыг нэвтрүүлэн хэрэгжүүлсэн бол 125 байгууллага нэвтрүүлэхээр төлөвлөжээ. Аймгуудын ЗДТГ-ын ISO 9001:2015 стандартыг нэвтрүүлэн хэрэгжүүлсэн байдлыг доорх зурагт харуулав.

Зураг 1. Монгол Улсын аймгуудын ЗДТГ-т ISO 9001:2015 стандарт хэрэгжүүлэлт (2023 оны 07-р сарын 01-ний байдлаар)


⁵⁰ МУ-н Засгийн газрын 2016 оны 344-р тогтоолоор “Үндэсний чанарын хөтөлбөр”-ийг баталсан ч төрийн байгууллагын үйл ажиллагааны чанар болон ISO 9001:2015 стандартыг хэрэгжүүлэх талаар тусгаагүй байна.




Эх үүсвэр: Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд үндэслэв.

МУ-ын нийт 21 аймгаас 18 аймгийн ЗДТГ ISO 9001:2015 стандартыг нэвтрүүлжээ. Зураг 2-т үзүүлсэнчлэн МУ-н Архангай, Баянхонгор, Булган, Дархан-Уул, Дорноговь, Дундговь, Орхон, Өмнөговь, Сүхбаатар, Сэлэнгэ, Төв, Увс, Ховд, Хөвсгөл аймгууд ISO 9001:2015 стандартыг нэвтрүүлжээ. Баян-Өлгий, Өвөрхангай, Хэнтий, Дорнод аймгууд нэвтрүүлэхээр ажиллаж байна. Харин Завхан, Говь-Алтай, Говьсүмбэр аймгуудын ЗДТГ тус стандартыг нэвтрүүлээгүй байна.

Монгол Улсын 21 аймгийн ЗДТГ-ын албан хаагчдаас “Аймгуудын ЗДТГ-ын чанарын удирдлагын хэрэгжүүлэлтийн өнөөгийн байдалд төрийн албан хаагчдын цогц чадамжид суурилсан дүн шинжилгээ хийж, тулгамдаж буй асуудал, түүнийг шийдвэрлэх арга замыг тодорхойлох” зорилготой “Ерөнхий мэдээлэл, Чанарын удирдлагын ISO 9001:2015 стандартын тухай, ISO 9001:2015 стандартыг хэрэгжүүлэхэд шаардлагатай цогц чадамж, ISO 9001:2015 стандартыг хэрэгжүүлэхэд нөлөөлж буй анхаарах бусад асуудлууд гэх дөрвөн үндсэн бүлэг бүхий судалгааг авсан. Судалгаанд нийт 234 албан хаагч хамрагдсанаас 154 (65.8%) эмэгтэй, 80 (34.2%) эрэгтэй. Насны ангиллын хувьд: 25 хүртэл 13 (5.6%), 26-30 нас 30 (13.7%), 31-40 нас 101 (43.2%), 41-50 нас 66 (28.2%), 51-59 нас 21 (9%), 60-аас дээш нас 1 (0.4%) албан хаагчид хамрагдсан байна.



Судалгаанд албан тушаалын ангиллын хувьд судалгаанд хамрагдсан нийт оролцогчдын 189 (81%) гүйцэтгэх албан тушаалтан байсан. Аймгийн ЗДТГ-т ажилласан жилийн хувьд 1 хүртэлх жил буюу ажилд ороод удаагүй албан хаагч 54, 1-3 жил 48, 4-7 жил 51 албан хаагч хамрагджээ.




Мэргэжил болон боловсролын зэргийн хувьд 152 (65%) бакалавр, 82 (35%) магистрын зэрэгтэй байна. Мэргэжлийн хувьд магистрын зэрэгтэй оролцогчдын 59% нь эрх зүй, 20% төрийн удирдлагын чиглэлээр магистрын зэрэгтэй байна. Бакалаврын зэргийн хувьд санхүү, инженер, багш, бизнесийн удирдлага, бусад мэргэжлийн албан хаагчид дийлэнх нь байна.



Албан хаагчдын харьяалагдах хэлтсээр нь авч үзвэл бүх хэлтсүүдийн төлөөлөл хамрагдсаныг График 3-аас харж болно. Аймгийн ЗДТГ-т чанарын удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэхэд хамгийн гол үүрэгтэй оролцдог Төрийн захиргааны удирдлагын хэлтэс – 43 (18%), Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс – 31 (13%) төлөөлөл болсон албан хаагчид хамрагдсан.


Marta Moczulska Piotr Rogala (2019) нарын тодорхойлсон чадамжийн цогц загварт суурилан Монгол Улсын орон нутгийн захиргааны байгууллагын албан хаагчдын ISO 9001:2015 стандартыг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар, хандлагыг тодорхойлох асуулгыг боловсруулан албан хаагчдаас авсан.

График 4. ISO 9001:2015 стандартын талаарх өөрийн мэдлэгийг үнэлнэ үү.
(цогц чадамжийн хүрээнд)




ISO 9001:2015 стандартыг хэрэгжүүлэх шаардлагатай цогц чадамжийг тодорхойлох хүрээнд дараах мэдлэгүүдийг тодорхойлон судалгаанд хамрагдсан албан хаагчдаар өөрсдийнх нь мэдлэгийг үнэлүүлсэн. Албан хаагчдыг хувьд тодорхойлсон 16 мэдлэгийн хувьд дийлэнх албан хаагчид “дунд” гэсэн үнэлгээг өгсөн байна. Чанарын удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэхэд албан хаагчид бүгд жигд ойлголт, мэдлэгтэй байх хэрэгтэй гэдгийг эрдэмтэд тодорхойлон гаргасан. Иймд орон нутгийн захиргааны байгууллагын албан хаагчид ISO 9001 стандартыг хэрэгжүүлэхтэй жигд мэдлэгийг олгох шаардлагатай.

График 5. ISO 9001:2015 стандарттай холбоотой өөрийн ур чадваруудыг үнэлнэ үү.




ISO 9001 стандартыг хэрэгжүүлэхэд шаардлагатай нийт 15 ур чадварыг тодорхойлсон. Албан хаагчид өөрсдийн ур чадварыг үнэлсэн үнэлгээг нэгтгэн дүгнэхэд дийлэнх албан хаагчид “маш сайн, сайн” гэсэн үнэлгээг өгсөн байна. Шүүмжлэл хүлээн авах, өөрчлөлтийг хүлээн авах, сэтгэл хөдлөлөө хянах, багаар ажиллах гэсэн ур чадваруудаа сайн хэмээн үнэлсэн. Энэ нь дийлэнх албан хаагчид ур чадварын хувьд хангалттай байна.

График 6. ISO 9001:2015 стандартыг хэрэгжүүлэхэд шаардлагатай хувь хүний хандлагыг үнэлнэ үү (цогц чадамжийн хүрээнд)




ISO 9001 стандартыг хэрэгжүүлэхэд шаардлагатай 11 хандлагыг тодорхойлон судалгаанд оролцогчдоор үнэлүүлсэн. Судалгаанд ороцогчдын дийлэнх нь “хариуцлагатай” байх нь хамгийн “чухал” хэмээн үнэлсэн байна. Дараа нь “чанарын удирдлагын үйл ажиллагаанд тогтмол оролцоотой байх; бусдыг манлайлах; найдвартай; бусдад нөлөөлж үлгэр дуурайлал болдог бусдаас суралцаж чаддаг” байх гэсэн эдгээр хандлагуудыг чухалчлан авч үзжээ.

График 7. ISO 9001:2015 стандартыг хэрэгжүүлэхэд байгууллагын удирдлага болон албан хаагчдын оролцоо хэр чухал вэ?



Чанарын удирдлагын тогтолцооны ISO 9001 стандартын хувьд удирдлагын манлайлал болон байгууллагын ажилтан, албан хаагчдын оролцоог чухалчлан үздэг. Энэ хүрээнд албан хаагчид “Засаг дарга, ЗДТГ-ын дарга, хэлтсийн дарга нар, ахлах мэргэжилтнүүд, мэргэжилтнүүд” гэсэн байгууллагын албан хаагчдын “бүх хүмүүсийн оролцоо”-г чухал гэж үнэлсэн байгаа нь оролцооны мөн чанар ач холбогдлыг ойлгож ухамсарласан байгааг илтгэн харуулж байна.

График 8. ISO 9001:2015 стандартыг хэрэгжүүлэхэд шаардлагатай цогц чадамжийг үнэлнэ үү.



ISO 9001:2015 стандартыг хэрэгжүүлэхэд “Төрийн албан хаагчдын мэдлэг, ур чадвар, хандлага” зайлшгүй чухал гэдгийг судалгаанд хамрагдсан албан хаагчдын үнэлгээнээс харж болно.

Судалгааны үр дүнг нэгтгэн дүгнэвэл судалгаанд хамрагдсан албан хаагчид “ISO 9001:2015 стандартыг хэрэгжүүлэхэд байгууллагын бүхий л түвшний ажилтан, албан хаагчдын оролцоо чухал гэдгийг ухамсарласан мөн цогц чадамж чухал гэдгийг тодорхой үнэлсэн байна. Албан хаагчдын мэдлэг, ур чадварыг үнэлүүлэхэд “мэдлэг”-ийн хувьд дийлэнх оролцогчид “сайн, дунд” гэсэн үнэлгээг өгсөн бол ур чадварын хувьд дийлэнх оролцогчид “маш сайн, сайн” гэсэн үнэлгээг харин “хандлага”-ийн хувьд дийлэнх оролцогчид “маш чухал, чухал” гэсэн үнэлгээг өгсөн байна. Мөн муу, хангалтгүй, шаардлагагүй, ойлголтгүй, чухал биш гэсэн хариулыг өгсөн оролцогчдын хувьд нэг талаасаа аймгийн ЗДТГ-т 1 хүртэл жил ажиллаж байгаа шинээр орсон албан хаагчид байгаа бол нөгөө талаас тухай байгууллага шинээр орж буй албан хаагчдад чанарын удирдлагын хэрэгжүүлэлтийн ач холбогдлыг ухамсарлан ойлгуулж, хангалттай мэдлэгийг өгөөгүй байдалтай байна.

Чанарын удирдлагын онолын орчин үеийн чиг хандлага төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд хэдийн нэвтэрч эхэлжээ. Улс орнууд төрийн байгууллага, иргэдэд хамгийн ойр” орон нутгийн төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд онцгойлон анхаарсаар байна. Зөв тодорхойлогдсон, зохих ёсоор ашиглагдаж байгаа чадамж нь хүний нөөцийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлдэг. Тухайлбал, ажилтнаас хүлээх хүлээлтийг тодорхойлох, тэдний авьяас чадварыг нээн харуулах хэрэгсэл болох төдийгүй гүйцэтгэлийг сайжруулж, байгууллагын соёл, зан төлөвийг сайжруулах, хөгжүүлэх суурь. Орон нутгийн төрийн байгууллага, албан хаагчдын мэдлэг, ур чадвар,

хандлага нь төрийн бодлого, тогтвортой хөгжил, сайн засаглал, иргэдэд ойр, хүртээмжтэй үйлчилгээнд удирдлагын үр ашгийг нэмэгдүүлэх нь зорилгод чиглэсэн, олон талт удирдлагын арга барил, төрийн албан хаагчдын цогц чадамжаар хүрэх боломжтойг нотолсоор байна.

Монгол Улсын Засгийн газраас орон нутгийн захиргааны байгууллагад олон улсын шилдэг туршлага болох ISO 9001:2015 чанарын удирдлагын стандартыг төрийн байгууллагад хэрэгжүүлэх замаар төрийн байгууллагын бүтээмжийг дээшлүүлэхийг зорин дэмжин ажиллаж байна.

Иймд Засгийн Газрын хэрэг эрхлэх газар нь аймгийн ЗДТГ-ын ISO 9001:2015 стандартын хэрэгжүүлэлтийн тасралтгүй сайжруулалтыг үнэлэх тогтолцоог бий болгож тогтвортой байдлыг хангах. СХЗГ нь талаар ISO 9001:2015 стандартын хэрэгжүүлэлтийн зөвлөх үйлчилгээ, баталгаажуулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх мөн орон нутгийн СХЗХ-ээр дамжуулан сургалтын үйл ажиллагааг зохион байгуулах нь илүү үр дүнтэй тул ТАХ-дад сургалт хийх мэргэжилтнүүдийг чадавхжуулахад анхаарах хэрэгтэй. Монгол Улсын Төрийн албаны зөвлөл нь төрийн албан хаагчдын чадамжийн нэмэгдүүлэх, шаардлагатай сургалт хөгжлийн бодлогоор дэмжлэг үзүүлж ажиллах нь хэрэгтэй. Төрийн албанд анх орж байгаа төрийн албан хаагчдад ISO 9001:2015 стандартын талаарх мэдлэгийг нэгдсэн байдлаар олгох нь үр дүнтэй.

ЗГХЭГ-аас хийдэг хяналт шинжилгээ, үнэлгээний нэг үзүүлэлтэд ISO 9001:2015 стандартын хэрэгжилт, тасралтгүй сайжруулалтын үйл ажиллагааг нэг үзүүлэлт болгон оруулж үр дүнд тулгуурлан “ISO 9001:2015 стандартыг хэрэгжилтийн тасралтгүй сайжруулалт”-ыг амжилттай хэрэгжүүлж байгаа шилдэг туршлага болох аймгийг шалгаруулан “Чанарын шагнал”-ыг олгож аймгуудын ЗДТГ-ыг идэвхжүүлэх, бодит урамшуулалтын тогтолцоо болгох нь үр дүнтэй.

SPSIRPA FORUM 2024

Session 8-5

Results of agricultural subsidies provided by the Government of
Mongolia



МОНГОЛ УЛСЫН ТӨРӨӨС ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРТ ОЛГОЖ БУЙ ТАТААСЫН ҮР ДҮН

*Илтгэгч: Бадарчийн Отгонцэцэг¹ Докторант:
Удирдагч багш: Нцагийн Бурмаа² Доктор (Ph.d), Профессор
МУИС-ийн Олон Улсын Харилцаа, Нийтийн Удирдлагын Сургууль
Цахим шуулан: otgontsetseg.mofa@gmail.com
Утас: 99186900*

УДИРТГАЛ

Монгол Улсын Засгийн газар уул уурхайд түшиглэсэн аж үйлдвэрийн бүтцээ солонгоруулж хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр болгон төрөлжүүлэхээр зорьж байгаа бөгөөд НҮБ-аас баталсан “Тогтвортой хөгжлийн зорилго”³ (ТХЗ) –ийн “Нийгэм, эдийн засаг, байгаль орчин” гурван тулгуур баганын зорилгыг хэрэгжүүлэх, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын “Алсын хараа-2050” баримт бичгийн тэргүүлэх зорилтын 8.3-т “ТОГТВОРТОЙ ХӨДӨӨ АЖ АХУЙ”-г хөгжүүлэх, энэхүү зорилт нь “Хөдөө аж ахуйг байгальд ээлтэй, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон, эрсдэл даах чадвартай, нийгмийн хөгжлийн чиг хандлага, хэрэгцээ, шаардлагад нийцсэн, хариуцлагатай, бүтээмж өндөр, тогтвортой үйлдвэрлэлтэй эдийн засгийн тэргүүлэх салбар болгон хөгжүүлнэ” гэж, мөн Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн тэргүүлэх зорилтын нэг болох “Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалтын сүлжээг хөгжүүлж, гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодоос бүрэн хангаж, импортыг орлох болон экспортын баримжаатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжинэ” гэж тус тус зорилт тавьсан байна. Мөн Улсын Их Хурлаас 2022 оны 36 дугаар тогтоолоор “Хүнсний ханамж, аюулгүй байдлыг хангах төлөвлөгөө”-г баталж ойрын 5 жилийн хугацаанд дотооддоо 19 нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, импортын хамаарлыг бууруулж, хүнсний хангамж, аюулгүй байдлаа хамгаалах зорилт тавин ажиллаж байна.

Монгол Улсын төсвөөс ажил эрхлэлтийн 28%, ДНБ-ий 14% -ийг хөдөө аж ахуйн салбар бүрдүүлдэг (FAO нар, 2022) бөгөөд түүний дотор хөдөө аж ахуй салбарт арьс шир, ноос, сүү бэлтгэн үндэсний үйлдвэрт нийлүүлсэн малчдад, нийслэлийн хүн амын хаврын хүнсний хэрэгцээ, улирлын инфляцийн нөлөөллийн бууруулах зорилгоор нөөцийн мах бэлтгэсэн аж ахуйн нэгүүдэд, дотооддоо тариалсан улаанбуудай, хүнсний ногоо тариалсан тариаланчдад төсвөөс татаас, урамшууллыг олгож байна.

Өнөөдрийн хэрэгжүүлж буй татаасын хөтөлбөрүүдийн үр дүн нь бодлогын зорилгоо биелүүлсэн эсэхэд бодлогын шинжилгээ дутмаг, дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хөдөө аж ахуйн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн өсөлт бага, эдийн засгийн үндсэн үзүүлэлтэд хөдөө аж ахуйн салбарын сүүлийн 10 жилийн өөрчлөлтийн хувь муу байгаа зэрэг нь татаасын бодлого, удирдлага, хяналт, гүйцэтгэлийн үнэлгээ зэрэг үе шат бүрт системчилсэн үйл ажиллагаа дутагдаж байгааг харуулж байна.

Монгол Улсын Засгийн газар хөдөө аж ахуйн салбарын татаасын тогтолцооны төлөвлөлт, гүйцэтгэлийн үнэлгээний тогтолцоог бий болгох нь татаасын үр нөлөөг сайжруулах, үр дүнд суурилсан төсвийн татаасыг олон улсын чиг хандлагад нийцүүлэх зайлшгүй нөхцөл байдал үүсээд байна.

Иймд төрөөс баримталж байгаа урт болон дунд хугацааны бодлогын хэрэгжилтийг хангах, зорилтод заасан үр дүнд хүрэхийн тулд төрөөс олгож буй хөдөө аж ахуйн салбарын 2010-2020 онд олгосон татаасын үр дүнг эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдэд нөлөө үзүүлсэн эсэхийг тодорхойлж үр дүнг статистик мэдээлэл, бусад улс орнуудтай харьцуулан судалгаа хийснээр

¹ МУИС, ОУХНУС-ийн докторант

² МУИС, ОУХНУС-ийн Нийтийн удирдлагын тэнхимын багш, Доктор (Ph.d), Профессор

³ 2015 оны 9-р сард НҮБ-ийн гишүүн 193 орны төрийн тэргүүд бүгд санал нэгтгэйгээр энэхүү хөтөлбөрийг баталсан.

тулгамдаж буй асуудлуудыг тодорхойлж, гүйцэтгэлийг сайжруулах арга замыг тодорхойлоход энэхүү судалгааны ажлын зорилго оршино.

Зорилт:

1. Монгол Улсын төрөөс ХАА салбарт олгож буй татаасын төсөвт эзлэх хувийн жин, бусад улс орнуудтай харьцуулахад ямар түвшинд байгааг тодорхойлох
2. Монгол Улсын эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн 2010-2020 оны төлөв байдал, түүнд хөдөө аж ахуй салбарын хувь оролцоо
3. Татаасын үр дүнг сайжруулах арга зам, боломжийг эрэлхийлэх

Түлхүүр үг: төсвөөс олгосон хөдөө аж ахуйн татаас, эдийн засгийн нийлмэл үзүүлэлтийн арга, үйлдвэрлэгчид үзүүлэх дэмжлэгийн тооцооны арга, гол нэрийн бүтээгдэхүүний нийлүүлэлт, татаасын үр дүнг сайжруулах арга зам

СУДАЛГААНЫ ТАЛБАЙ, АРГА ЗҮЙ

Судалгааны талбай: Монгол Улсын төрөөс хөдөө аж ахуйн салбарт олгож байгаа арьс шир⁴, ноос⁵, сүү⁶, улаанбуудайн⁷ урамшуулал, нөөцийн мах нийлүүлсэн аж ахун нэгжүүдэд олгох дэмжлэг⁸-ийн бодлогын зорилт үр дүнгээ өгч байгаа эсэхийг хамааруулна.

Судалгааны аргазүй: Монгол Улсын төрөөс хөдөө аж ахуйн (ХАА) салбарт олгож буй татаасын үр дүнг системийн динамик загварыг ашиглан улсын төсөвт эзэлж байгаа хөдөө аж ахуй татаасын төсвийн бүтэц, Монгол Улсын нийгэм, эдийн засагт үзүүлж байгаа үр дүнгийн үзүүлэлтийг эдийн засгийн нийлмэл үзүүлэлтийн арга, үйлдвэрлэгчид үзүүлэх дэмжлэгийн тооцооны аргаар тооцон бодлогын зорилго, зорилттой хүрч байгаа эсэхийг тодорхойлно.

Ашигласан мэдээ, материал: Энэхүү судалгаанд Монгол Улсын 2010-2020 онд Төсвийн тухай хуулийн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын багцад баталсан “хөдөө аж ахуйг дэмжих урамшуулал, татаас”-ын төсөв, гүйцэтгэл, тухайн хугацааны Үндэсний статистикийн хорооны судалгааны тайлангийн эдийн засгийн үзүүлэлт, хөдөө аж ахуйн салбарын тоон мэдээллийн хүрээнд төрөөс баталсан тогтоол, шийдвэр, бодлогын хэрэгжилтийн зорилтуудын үр дүнгийн үзүүлэлтийг шалгуур үзүүлэлтийн хүрээнд хамааруулж авч үзсэн.

ХӨДӨӨ АЖ АХУЙН ТАТААСЫН ТУХАЙ ОЙЛГОЛТ, МӨН ЧАНАР, ҮР НӨЛӨӨ

Төсвийн бодлого нь “Засгийн газрын зардал болон татварын хэмжээг өөрчлөх замаар нийт макро эдийн засагт нөлөөлж болох бөгөөд Төсвийн бодлого нь эдийн засагт маш чухал үүрэг гүйцэтгэдэг” гэсэн Кейнсийн онолд тулгуурладаг. Засгийн газрын зардал нь байгууллагын урсгал зардал, татаас шилжүүлэг, хөрөнгө оруулалтын зардлаас бүрддэг.

Засгийн газрын татаасын зан үйлийг судлах дор хаяж гурван зайлшгүй шалтгаан бий. Нэгдүгээрт, татаас нь төрийн зарлагын бодлогын гол хэрэгсэл юм. Хоёрдугаарт, дотоодын түвшинд татаас нь дотоодын нөөцийн хуваарилалтын шийдвэр, орлогын хуваарилалт, зарлагын бүтээмжид нөлөөлж, эдийн засгийн уян хатан байдлыг бууруулснаар бүтцийн болон салбарын зохицуулалтад нөлөөлдөг. Гуравдугаарт, олон улсын түвшинд худалдаа, олон талт болон хоёр талт хэлэлцээрийг түгээн дэлгэрүүлэх замаар олон улсын интеграцлал нэмэгдэж байгаа нь татаас нь өрсөлдөх чадварт нөлөөлж, олон улсын нөөцийн хуваарилалтад хэр зэрэг гажуудал үүсгэдэг вэ гэсэн асуултуудыг дагуулж байна.⁹

Одоогийн байдлаар татаасын талаар нэгдсэн тодорхойлолт байхгүй байна. Анхны тодорхойлолтын хувьд ЭЗХАХБ-ын хэвлэлд ашигласан тодорхойлолт гэж үзэж болох бөгөөд татаасыг "хэрэглэгч эсвэл үйлдвэрлэгчийн орлогоо нэмэгдүүлэх эсвэл зардлыг бууруулах

⁴ УИХ-ын 2012 оны 74 дүгээр тогтоол, Засгийн газрын 2013 оны 394 дүгээр тогтоол

⁵ УИХ-ын 2011 оны 30 дугаар тогтоол, Засгийн газрын 2019 оны 343 дугаар тогтоол

⁶ Засгийн газрын 2020 оны 130 дугаар тогтоол

⁷ Тариалангийн тухай хуулийн 19 дүгээр зүйл

⁸ Хүнсний тухай хуулийн 8 дугаар зүйл


⁹ Gerd Schwartz, Government Subsidies, · April 1999

зорилгоор ашиг тустай засгийн газрын үйл ажиллагааны үр дүн" гэж тодорхойлдог (OECD 2005, р.16).

Хөдөө аж ахуйн татаас нь Засгийн газраас хүнс, фермийн бизнес эрхэлж буй иргэдийн орлогыг нэмэгдүүлэх, ААН, байгууллагуудын зардлыг бууруулах замаар хүнсний нийлүүлэлтийг удирдах хэрэгсэл юм. Татаасын төрөл: Шууд татаас- Мөнгөн шилжүүлэг, шууд бус татаас- иргэнд нийгмийн даатгалын шимтгэл, татварын хөнгөлөлт, тэтгэлэг хэлбэрээр, компани, аж ахуй нэгжид татварын хөнгөлөлт, төрийн хяналт, шалгалтыг бууруулах, квот (г.м) олгох зэргээр татаасыг олгодог байна.

Хөдөө аж ахуйн татаасын давуу тал нь хүнсний зах зээлийг тогтворжуулах, орлого багатай фермүүдийг дэмжих, бага өгөөжтэй ХАА салбарт хөрөнгө оруулалт татах боломжийг олгох, улс орны хүнсний аюулгүй байдлыг хангах зэрэг байдаг бол сул тал нь татвар төлөгчдийн мөнгийг фермер эрхлэгчид ихэнх хувийг авах, алдагдсан боломжийн өртөг өндөр (*deadweight loss*), улс орон хоорондын гадаад худалдааг шударга бус болгох, нөгөө талдаа улсын төсөвт хүнд дарамт болж, алдагдалд хүргэдэг бөгөөд үүний үр дүнд нэмэлт мөнгө гаргах шаардлагатай болж, инфляцид нөлөө үзүүлдэг байна.

Хөдөө аж ахуйн татаасын үр нөлөө нь зах зээлийн тэнцвэрт үнийг бууруулж, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн тоог хэмжээ буюу нийлүүлэлтийг нэмэгдүүлдэг.



Татаас нь тухайн улс орныхоо төсвийн нэг бүрэлдэхүүн хэсэг болдог учраас төсвийг үр дүнд чиглүүлэх нь чухал юм. ХХ зууны сүүл үеэс төсвийн шинэчлэл, түүний дотор төсвийн зарлагын удирдлагын асуудлыг илүү анхаарах чиглэлээр А.Премчанд (1993), С.Шиаво-Кампо болон Д.Томмаси (1999), М.Холмс, Д.Чанд (2002), Төсвийн зарлагын төлөвлөлтийн аргууд, дунд хугацаанд үр дүнд чиглүүлэн төсвийн зарлагын төлөвлөх аргын талаар Аллен Шик (1999), Билл Поротински (2004), Монгол Улсад үр дүнд чиглэсэн дунд хугацааны төсвийн зарлагын төлөвлөлтийн загварыг Л.Отгонтуяа (2007), төсвийн шинэчлэлийн хэрэгжилт, хандлагыг Б.Баясгалан(2010) нар судалж, төсвийн шинэчлэлийн хэрэгжилтийг үнэлж дүгнэлт өгсөн байна.

Хөдөө аж ахуйн татаасын талаарх олон улсын туршлага, чиг хандлага

Хөдөө аж ахуйн татаасын талаар олон улсын судлаачид дараах дүгнэлтүүдийг гаргасан байна. Үүнд:

- Удирдлагын баталгаажуулсан үр дүнтэй элементүүдийг илүү сайн нөхцөлд ажиллаж байгаа аж ахуйн нэгжүүдэд ашиглах боломжтой бөгөөд ингэснээр тухайн аж ахуйн нэгж эсвэл хөдөө аж ахуйн бүхэлдээ илүү өндөр гүйцэтгэлд хувь нэмэр оруулах боломжтой (Adamisin et al. 2015).
- Хөдөө аж ахуйн нийт үйлдвэрлэлийн хэмжээ болон олгосон татаасын хэмжээ хоёрын хооронд хүчтэй хамаарал байна.(Ивана Кравчакова Возарова, Растислав Котулич. 2015)
- Ихэнх улс орнууд хөдөө аж ахуйгаа хамгаалахын тулд ямар нэгэн татаас ашигладаг (Коо, Won and Kennedy 2006)
- Хүнсний үйлдвэрлэлээрээ бие дааж чадахгүй улс орон арилжааны дарамт болон дэлхийн хүнсний хямралд илүү өртөмтгий байдаг (Henningesen et al., 2009).

- Хүнсний аюулгүй байдлын шаардлагатай түвшинг хангахын тулд зохион байгуулалт, эдийн засаг, зохицуулалт, логистик, нийгэм, мэдээллийн шинж чанартай зохицуулалтыг системчилсэн хандлагын хүрээнд хийх шаардлагатай байна (Брояка.А 2020)
- Гадаад эдийн засгийн хориг арга хэмжээ, импортыг орлох бодлогын нөхцөлд дотоодын хөдөө аж ахуйн үйлдвэрлэгчид хүн амын амьжиргаа, улсын хүнсний хараат бус байдлыг хангахад гол үүрэг гүйцэтгэдэг (Глуценко А.В., Сложенкина М.И., Самедова Е.Н, Мосолова ДА 2020)

Өндөр хөгжилтэй улс орнууд хөдөө аж ахуйн дэмжлэгийг өргөн ашиглаж ирсэн бол сүүлийн жилүүдэд шинээр хөгжиж буй улс орнууд мөн өндөр хурдацтайгаар ашиглах болсон байна. Тухайлбал Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (ЭЗХАХБ)-ын 2022 онд хийсэн “Хөдөө аж ахуйн бодлогын хяналт үнэлгээ: Цаг уурын өөрчлөлтөд дасан зохицох үүднээс хөдөө аж ахуйн бодлогыг шинэчлэн өөрчлөх” тайланд¹⁰ хамрагдсан 54 улсын хөдөө аж ахуйн салбарт үзүүлсэн Засгийн газрын дэмжлэг 2019-2021 онд жилд дундажаар 819 тэрбум ам.доллар хүрсэн нь 2000-2002 оны жилийн дундаж түвшингээс 2.4 дахин, 2018-2020 оны жилийн дундаж түвшнээс 13 хувь тус тус өссөнийг дурдсан байна. Түүний дотор шинээр хөгжиж буй 11 улсын хөдөө аж ахуйн салбарын дэмжлэг жилд дундажаар 464 тэрбум ам.долларт хүрсний 60 орчим хувийг Хятад улс дангаар эзэлсэн байна. 2019-2021 онд жилд дундажаар үзүүлсэн дэмжлэгийн 500 тэрбум ам.долларыг засгийн газрын төсвийн шилжүүлэг хэлбэрээр олгосон байна.

Олон улсын байгууллага, тухайлбал, Дэлхийн худалдааны байгууллага (ДХБ) болон Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (ЭЗХАХБ)-аас хөдөө аж ахуйн дэмжлэгийг тодорхойлох, ангилах, түүний хэмжээ далайц, үр нөлөөг тооцоход баримталсан арга барилыг улс орнууд мөрдөж байна¹¹.

Зах зээлийн “доголдол”-ыг засах, нийтийн бараа (public good)-гаар хангахад хөдөө аж ахуйн дэмжлэгийн гүйцэтгэх үүргийг хэрэгжүүлэхийн зэрэгцээ улам бүр харилцан хамааралтай болж буй дэлхий дахинд нэгэнт хүлээн зөвшөөрсөн хөдөө аж ахуйн дэмжлэгийн “хөршдөө хохирол учруулах” сөрөг нөлөөг авч үзэх явдал чухал юм. Хөдөө аж ахуйн дэмжлэгийг шүүмжлэгчид, эсэргүүцэгчид түүнийг эдийн засгийн гажуудал, үр ашиггүй байдал үүсгэхийн хамт хөдөө аж ахуйн том, чинээлэг аж ахуйн эрхлэгчид үр шимийг голчлон хүртэж буй хуваарилалтын сөрөг үр дагавар, зах зээлийн үнэд тусгалаа олоогүй гадаад нөлөөллийг хурцатгах, үнийн гажуудал үүсгэх замаар байгаль орчинд үзүүлж буй сөрөг нөлөө, хүнсний буруу хэрэглээг илүүтэй шүүмжилдэг.¹² Нөгөө талаас, хөдөө аж ахуйн дэмжлэг нь зах зээлийн доголдлыг засах бодлогын хариу арга хэмжээ, орлогын тэгш бус байдал, хөдөө аж ахуйн жижиг үйлдвэрлэл эрхлэгчдийн амьжиргааг дэмжих эсхүл амин чухал нийтийн бараагаар хангах зэрэг төрийн бодлогын зорилгыг хэрэгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг гэж хөдөө аж ахуйн дэмжлэгийг дэмжигчид үзэж байна.¹³

Их Британий Chatham House хараат бус судалгааны хүрээлэнгийн хэвлэсэн “Татаас ба тогтвортой хөдөө аж ахуй: бодлогын талбарын зураглал гаргах нь”¹⁴ бүтээлд дурдсан хөдөө аж ахуйн дэмжлэгийн төрөл тус бүрээр түүний тогтвортой хөгжилд үзүүлэх нөлөөллийг “Үйлдвэрлэл ба худалдаа”, “хөдөөгийн хөгжил ба амьжиргаа”, “хүнс ба тэжээл”, “тогтвортой хөгжил буюу байгаль орчин” гэсэн хөгжлийн 4 чиглэлд хөдөө аж ахуйн дэмжлэгийн үзүүлэх нөлөөллийг хамгийн их сөрөг дагавар (гажуудал, хохирол)-тайгаас хамгийн эерэг (үр шимтэй, гажуудал үүсгэдэггүй) гэсэн 6 үнэлгээ өгсөн байна.

¹⁰ OECD (2022) Agriculture Policy Monitoring and Evaluation 2022: Reforming agricultural policies for climate change mitigation

¹¹ Bellmann, C. (2019), Subsidies and sustainable agriculture: Mapping policy landscape, *Chatham House* December 2019

¹² Horlick, G. and Clarke, P. A. (2016), Rethinking Subsidy Disciplines for the Future, E15 Task Force on Rethinking International Disciplines, Policy Options Paper, Geneva: International Centre for Trade and Sustainable Development and World Economic Forum, <https://cht.hm/32cxj7D>.

¹³ Sykes, A. (2005), ‘Subsidies and Countervailing Measures’, in Appleton, A., Macrory, P. and Plummer, M. (eds) (2005), *The World Trade Organization: Legal, Economic and Political Analysis*, Boston, MA: Springer Verlag.

¹⁴ Bellmann, C. (2019), Subsidies and sustainable agriculture: Mapping policy landscape, *Chatham House* December 2019

Монгол Улсын төрөөс хөдөө аж ахуйн салбарт олгож байгаа татаасын судалгаа

Монгол Улс ДХБ-д гишүүнээр элсэж, УИХ-аас 1994 онд “Татаас болон саармагжуулах арга хэмжээний тухай” ОУ-ын хэлэлцээрийг соёрхон баталсан байна. Монголд Хүнсний тухай хуулиар (1995, 1996, 2012 он) “Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэхэд үзүүлэх дэмжлэг, урамшуулал” олгох хуульчилсан бөгөөд энэхүү хуулийн хүрээнд улсын төсвөөс стартегийн нөөц бүрдүүлэхэд хүнсний улаанбуудайг Засгийн газрын тусгай сангаар дамжуулан худалдан авалтыг хийж тариалчдыг дэмжиж байна. Мөн стратегийн хүсний бүтээгдэхүүн болох “мах” бэлтгэлд зориулж 2013, 2014, 2016 онуудад татаас олгож байсан бол 2017 оноос эхлэн нөөцийн мах бэлтгэсэн аж ахуй нэгжүүдэд зээлийн хүүгийн татаасыг, үндэсний үйлдвэрт сүү бэлтгэн нийлүүлсэн малчид, фермерүүдэд 2020 оноос мөнгөн урамшуулал олгож байна. Харин Тариалангийн тухай (2004, 2016 он) хуулиар “Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэхэд үзүүлэх дэмжлэг, урамшуулал” олгохоор заасны дагуу улаанбуудайн үйлдвэрлэгчдэд 2007 оноос эхлэн, хүнсний ногоо тариалсан тариаланчдад 2022 оноос эхлэн урамшуулал олгож байна. 2015 онд батлагдсан Үйлдвэрлэлийг дэмжих хуулиар өрсөлдөх чадвартай, үнэ цэнэ шингэсэн, байгаль орчинд ээлтэй бүтээгдэхүүний экспортын чиг баримжаатай, импортыг орлох үйлдвэрлэлийг төрөөс дэмжин хөгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулж байсан боловч 2020 оны 1 дүгээр сарын 01-нээс хүчингүй болсон.

УИХ-аас 2011 онд баталсан “Үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай” 30 дугаар тогтоолоор үндэсний үйлдвэрүүдэд ноос бэлтгэн тушаасан малчдад урамшуулал олгохоор, 2012 онд баталсан “Малчид, үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих зарим арга хэмжээний тухай” 74 дүгээр тогтоолоор арьс ширний урамшуулал олгохоор зааж, ноосны урамшууллыг 2011 оноос, арьс ширний урамшууллыг 2014 оноос өнөөг хүртэл төрөөс малчдад олгож байна.

Дэлхий нийтийг хамарсан ковидын цар тахал гарсантай холбогдуулан Засгийн газраас 2019 онд “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-г 47 тогтоолоор баталж, тус тогтоолоор хөдөө аж ахуйн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгж, тариаланч, малчдад банкны зээлийн хүүгийн татаасыг олгохоор заасан байна. Мөн малчдын орлогыг хамгаалах зорилгоор 2020 оны 167 дугаар тогтоолоор малчдад нэг удаа ноолуурын урамшууллыг төрөөс олгожээ.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын төсвийн бүтцийг (2011-2020)

ХХААХҮЯ мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний хангамжийг тогтворжуулах, тариаланчдын орлогыг нэмэгдүүлэх, экспортыг тэлэх зорилгоор дээрх хууль, тогтоолын хүрээнд татаасын арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж байгаа энэ нь үйлдвэрлэсэн эсвэл худалдан авсан тоо хэмжээтэй пропорциональ хуваарилагдсан бүтээгдэхүүний татаас юм. /Хүснэгт 1-ийг харна уу/
Сүүлийн 10 жилийн байдлаар төсөвт эзлэх татаасын хувь хэмжээ нийт төсвийн 68.7 хувь, урсгал зардлын 73 хувь хүртэл өсөж, жилийн дундаж үзүүлэлтээр урсгал зардлын 51.5 хувийг зөвхөн татаас эзэлж байна.

Хүснэгт 1. ХХААХҮ-ийн салбарын татаасын хэмжээ (2010–2020) (тэр.төг)

ХХААХҮ-ийн салбарын төсөв	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020
Нийт төсөв	130.6	514.2	180.7	178.0	134.8	57.4	142.2	272.5	172.5	167.2	345.9
Төсвийн зардал	81.7	92.1	78.8	93.5	101.5	89.9	113.5	99.5	102.6	121.7	325.5
Татаас	10.9	24.3	44.3	42.7	56.0	51.4	48.7	53.3	53.9	48.5	237.7
Нийт ХХААХҮ салбарын төсөвт эзлэх татаасын хувь хэмжээ											
Нийт төсөвт эзлэх хувь	8.3	4.7	24.5	24.0	41.5	32.7	34.2	19.6	31.2	29.0	68.7
Нийт төсвийн зардалд эзлэх хувь	13.3	26.4	56.2	45.7	55.2	57.2	42.9	53.6	52.5	39.9	73.0


Монгол улсад Европын Холбооноос үзүүлж буй хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлд зориулсан төсвийн дэмжлэгийн хүрээнд Техникийн туслалцааны төслийн хүрээнд хийсэн “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын төсвийн зарлагын шинжилгээ”-гээр (2021) “Урамшууллын хэмжээ нь өнгөрсөн хугацаанд тогтвортой бус, өөрчлөгдөж ирсэн бөгөөд энэ нь байгаль, цаг уур болон бусад хүчин зүйлсээс шалтгаалан тухайн жилийн ХАА-н бүтээгдэхүүний үйлдвэрлэл, нийлүүлэлтийн хэмжээ хэлбэлзлэлтэй байснаас голчлон хамаарсан байна. ХАА-н урамшууллауд нь хөдөө аж ахуй эрхлэгчдийн орлогыг нэмэгдүүлэх, ХАА-н бүтээгдэхүүний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх, дотоодын боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зэрэг олон зорилтуудыг хангахад чиглэгдэж байгаа ба энэ урамшууллын үр нөлөө, үр ашгийг тооцоход бэрхшээлтэй болгож байна” гэж дүгнэжээ.

Монгол Улсын төсвөөс хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрт зарцуулж буй зардлын үр ашгийн талаарх олон улсын харьцуулсан дүн шинжилгээг ЭЗХАХБ-ын гишүүн орнууд болон хөгжиж буй орнуудтай харьцуулахад 2020 онд хөдөө аж ахуй салбар нь Монгол Улсын төсвийн зардлын 2.5 хувийг бүрдүүлсэн нь судалгаанд хамрагдсан 39 улсаас 6-д, зардлын үр ашгийг зөвхөн эдийн засгийн үр дүнг нийлмэл үзүүлэлтээр тооцож үзэхэд 8.6 буюу 39 орноос 38-д байна. Монгол Улсын төсвийн орц харьцангуй өндөр боловч эдийн засгийн үзүүлэлт нь туйлын доогуур үнэлэгдсэн нь төсвийн орцын үр ашиг муу байгааг харуулж байна. Энэхүү харьцуулалт нь улс орон бүрийн эдийн засгийн өсөлт, зах зээлийн ялгаатай байдлыг харгалзан үзээгүй бөгөөд төсвийн зарцуулалтын үр ашиг бага байгааг харуулж байна.

Судалгааны үр дүнд Монгол Улс төсвийн зарцуулалтыг илүү үр ашигтай болгохын тулд нөөцийг дахин хуваарилах, гүйцэтгэлийг сайжруулах шаардлагатай байгааг харуулж байна.


Төрөөс хөдөө аж ахуйн салбарт олгосон татаас нь эдийн засагт хэрхэн нөлөө үзүүлсэн эсэхийг дараах Үндэсний стастикийн хороо, Эдийн засгийн хөгжлийн яам, ХХААХҮЯ, Дэлхийн банкнаас гаргасан үзүүлэлтээс харахад нөлөө үзүүлээгүй бөгөөд өсөлтийг хувь хэмжээ бага байгааг харах болно. /График 2-4/

График 2



Эх үүсвэр: ХХААХҮЯ-ны тооцоолол, (ҮСХ-ны статистик)


График 3



Эх үүсвэр: УСХ, WB, 2021 он

*2020 оны байдлаар Монгол Улсын нийт хүн ам болох 3.3 сая хүний 903.4 мянга нь ядуу амьдарч байгаа болохыг тогтоожээ. Уг тооцооллыг гаргахдаа нэг хүнд ногдох сарын хэрэглээ болох 184.747 төгрөгөөс доош хэрэглээтэй хүн амыг ядуу хэрэглээтэй хүн амд тооцжээ.


График 4



Эх үүсвэр: ХХААХҮЯ-ны тооцоолол, (УСХ-ны статистик)

Монгол улсын хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний хангамжийн түвшинг 2020 оны байдлаар авч үзвэл мах, төмс, гурилыг дотооддоо бүрэн үйлдвэрлэж харин гурилан бүтээгдэхүүн, хүнсний ногоо, сүү, сүүн бүтээгдэхүүн, өндөг, цөцгийн тосыг дотоодоос 33-67 хувийг, бусад өргөн хэрэглээний хүнсний бүтээгдэхүүн импортоос хамааралтай байна. Тэгвэл Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/74 дүгээр тушаалын 4 дүгээр хавсралтаар “Жишсэн дундаж хүний илчлэг, шимт бодисын хоногийн зөвлөмж” хэмжээгээр Хүнсний аюулгүй байдлын статистикийн 2020 оны үзүүлэлтээр монгол хүн өдөр тутмын хэрэглээнд чихрийн хэрэглээ 6 дахин, махны хэрэглээ 5 дахин, төмс болон гурилын хэрэглээ 2 дахин хэтрүүлэн хэрэглэдэг байна. Энэ нь хүн өдрийн хэрэгцээгээс илүүдэл хэрэглээ хэрэглэснээр нийлүүлэлт мөн эрэлтээ дагаад нэмэгдэж байгаа харж болно. Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний нийлүүлэлт, хүний өдөр тутмын хэрэгцээ буюу эрэлтийг матриц хийж харвал дотоодоосоо 100 хувь нийлүүлж байгаа бүтээгдэхүүнийг экспорт гаргах бодлого барих, зөв эрүүл хоололтын талаар төрөөс бодлого гаргаж хэрэгжүүлэх, дотооддоо үйлдвэрлэх боломжтой 5 нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрийн хэмжээ, хэрэглээг нэмэгдүүлэхэд татаасын бодлогыг чиглүүлэх нь илүү үр дүнтэй харагдаж байна. /График 6/

График 6



ЭЗХАХБ-ын боловсруулан ашигладаг хөдөө аж ахуйн үйлдвэрлэгчдэд үзүүлсэн дэмжлэгийн тооцоо (Producer support estimate)-ны хялбарчилсан аргачлалыг ашиглан Монгол улсын хөдөө аж ахуйн үйлдвэрлэгчдэд үзүүлж буй дэмжлэгийн тооцоог НҮБ-ийн төслийн багтай хамтран хийж үзлээ. 2014 онд Дэлхийн Банк ЭЗХАХБ-ын аргачлалд тохируулга хийх замаар Монгол улсын хөдөө аж ахуйн үйлдвэрлэгчдэд үзүүлж буй дэмжлэгийн тооцоог онд анх удаа хийсэн байна.¹⁵ Хялбарчилсан аргачлалыг ашиглан тооцоог шинэчлэснээр харьцуулах боломж олгоно гэж үзлээ.

Хөдөө аж ахуйн салбарт олгосон татаасыг үйлдвэрлэгчид үзүүлсэн дэмжлэгийн тооцоо (Producer support estimate) нь хөдөө аж ахуйг дэмжих бодлого (шинж чанар, зорилго, үйлдвэрлэл эсхүл орлогод үзүүлэх нөлөөнөөс үл хамаарч)-ын үр дүнд хэрэглэгч, татвар төлөгч нараас үйлдвэрлэгчдэд тухайн жилд төлж буй нийт төлбөрийн хэмжээ болно. Үйлдвэрлэгчид олгосон татаасны тэнцэл (PSE)¹⁶. Энэ нь Хөдөө аж ахуйн хэлэлцээрт ашигладаг нэр томъёо. Засгийн газрын дэмжлэгийг арилгахын тулд хөдөө аж ахуйн үйлдвэрлэгч нарт нөхөн олговор олгох шаардлагатай болдог тэр татаасыг тодорхойлж байна. /хүснэгт 2/

Хүснэгт 2

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020
ЗҮҮД – Зах зээлийн үнийн дэмжлэг	сая төг.	3,611.5	7,147.6	2,918.4	- 415.0	- 310.6	- 9,916.6	- 260.9	8,534.3	42,804.5	17,886.9	4,795.6
Ноос	сая төг.	3,546.7	7,017.5	2,879.6	-	321.0	8,498.0	379.9	8,445.7	42,673.8	17,968.1	-4,908.8
Арьс шир	сая төг.	36.1	66.2	79.1	66.1	35.7	18.5	7.3	5.8	3.9	8.9	1.8
Улаан буудай	сая төг.	28.7	64.0	- 40.3	- 481.1	- 25.4	- 1,437.1	126.2	82.7	126.8	90.2	111.4
Бусад	сая төг.											
Үйлдвэрлэлийн (гарцад суурилсан) шууд төлбөр	сая төг.	10,906.4	20,724.2	57,243.7	64,647.1	51,333.8	34,443.1	50,312.5	44,893.3	40,992.4	51,753.3	55,084.8
Ноос	сая төг.	-	6,253.1	29,414.3	36,614.7	18,427.5	19,350.9	22,637.2	22,408.7	18,599.9	19,419.5	32,367.7
Арьс шир	сая төг.	-	-	-	2,711.7	8,179.3	9,500.8	12,713.0	14,611.5	9,462.2	9,913.0	-
Улаан буудай	сая төг.	10,906.4	14,471.2	27,829.5	25,320.7	24,727.1	5,591.5	14,962.4	7,873.1	12,930.3	22,420.8	22,717.1
Бусад	сая төг.	(10,895.5)	(20,699.9)									
Шууд бус төлбөр:	сая төг.	30,275.6	44,045.4	47,533.8	32,271.8	31,898.7	47,278.6	49,369.6	46,726.2	65,354.7	49,522.9	45,584.5
Ноос	сая төг.	6,068.5	16,213.4	13,094.7	12,448.8	11,382.0	6,312.0	15,186.6	10,208.2	12,049.7	10,847.7	10,773.5
Арьс шир	сая төг.	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Улаан буудай	сая төг.	24,207.1	27,832.0	34,439.1	19,823.0	20,516.7	40,966.6	34,183.0	36,518.0	53,305.0	38,675.2	34,811.0
Бусад	сая төг.											
ҮҮД – Үйлдвэрлэгчид үзүүлсэн дэмжлэг	сая төг.	44,793.5	71,917.3	107,695.9	96,503.9	82,921.9	71,805.1	99,421.2	100,153.7	149,151.5	83,389.4	95,873.7
ХАА-н нийт үйлдвэрлэл	сая төг.	1,144,697.9	1,357,866.8	1,878,786.4	2,572,044.9	2,965,360.5	3,223,402.7	3,022,012.5	3,119,618.2	3,723,544.3	4,373,602.5	4,856,063.0
ХАА-н үйлдвэрлэлийн дүнд үйлдвэрлэгчид үзүүлсэн дэмжлэгийн эзэх хувь	хувь	3.9%	5.3%	5.7%	3.8%	2.8%	2.2%	3.3%	3.2%	4.0%	1.9%	2.0%

Эх сурвалж: ХХАХҮЯ, НҮБ-ийн төсөл 2022 он

¹⁵ Kisan Gunjal and Chares Annor-Frempong, World Bank, Review, Estimation and Analysis of Agricultural subsidies in Mongolia Mar 30, 2014

¹⁶ Худалдааны бодлогын нэр томъёоны тайлбар толь 2020

Хөдөө аж ахуйн нийт үйлдвэрлэлд үйлдвэрлэгчдэд үзүүлсэн дэмжлэгийн эзлэх хувь 2010-2020 онд жилд дундажаар 2 хувь байна.

ДҮГНЭЛТ:

- Хөдөө аж ахуйн салбарын татаасд хуваарилсан төсөв, үр дүнг ЭЗХАХБ-ын бусад орнууд болон хөгжиж буй хэд хэдэн улстай харьцуулан үзэхэд хөдөө аж ахуйн салбарт олгож буй төсөв эхний 6-д буюу төсөв хангалттай хуваариллагдаж байгаа боловч төсвийн зарцуулалтын үр ашиг бусад улсадтай харьцуулахад хамгийн бага байна.
- Үйлдвэрлэгчид үзүүлсэн дэмжлэгийн тооцоогоор 2010-2020 онд хөдөө аж ахуйн нийт үйлдвэрлэлд үйлдвэрлэгчдэд үзүүлсэн дэмжлэгийн эзлэх хувь харьцангуй бага буюу жилд дундажаар 2 хувь байна.
- Төрөөс олгож байгаа татаасын үр дүн, өгөөжийг үнэлж тооцохгүй, хяналтгүй байгаа нь төрийн нэг төрлийн халамжийг бий болгож, хүлээлтийг үүсгэж байна.
- Хөгжлийн бодлогод “Тогтвортой хөдөө аж ахуй” болгох зорилт тавьсан байгаа боловч нийгэм эдийн засгийн үзүүлэлтүүд дээрх шаадлагыг хангаагүй, ХАА салбар ДНБ, үйлдвэрлэл, ажиллах хүчин, ядуурал, өрхийн орлогод өсөлт ажиглагдахгүй байна.
- Б.Пунцагдорж, Д.Оросоо, Шуеши Хуо, Шианли Шиа нарын хийсэн судалгааны дүгнэлтэд “...улаан буудайн тариаланчдад олгож буй татаас нь тогтвортой хөдөө аж ахуйн туршлагыг нэвтрүүлэхэд төдийлөн нөлөө үзүүлэхгүй байна.” гэжээ.
- Татаасын нэгдсэн бодлого, хууль эрх зүйн орчинг тодорхойгүй байна.
- Бодлогын баримт бичгүүдийн шалгуур үзүүлэлтүүд завсрын үеийг тодорхойлоогүй нь үр дүнгийг хэмжих, хяналт, шинжилгээ үнэлгээ хийх нөхцөл бүрдээгүй, хяналт тавихгүй байгаа нь төсвийн хөрөнгийн үр ашгийг тодорхойлох боломжгүй байна.

Цаашид төрөөс олгосон хөдөө аж ахуйн татаасын үр дүнг сайжруулахад системийн динамик загварыг ашиглан судалгааг өргөжүүлэн судлах шаардлагатай гэж үзэж байна.

ТАЛАРХАЛ

Энэхүү судалгааны ажлыг хийхэд өөрийн үнэтэй цаг хугацааг зориулан зөвлөгөө, санал, шүүмж өгсөн удирдагч багш МУИС-ийн Олон Улсын Харилцаа, Нийтийн Удирдлагын Сургуулийн багш доктор, профессор Н.Бурмаа багшдаа болон тус сургуулийн Нийтийн Удирдлагын тэнхимын багш нартаа талархал илэрхийлье. Мөн арга зүйн зөвлөгөө өгч, хамтран судалгааны ажлыг хийсэн БНСУ-ын Эдийн Засгийн яамны “Мэдлэг хуваалцах хөтөлбөр-ийн судалгааны баг, НҮБ-ийн Европын холбооны санхүүжилттэй “Монгол Улсад тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь” төслийн зөвлөхүүдэд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын хамт олонд талархал илэрхийлж цаашдын ажил, эрдмийн их үйлсэд нь амжилтын дээдийг хүсэн ерөөе.

ЭШЛЭЛ

- Нэгдсэн Үндэсний байгууллага “Тогтвортой хөгжлийн зорилт”, <https://mongolia.un.org/mn/sdgs>
- OECD (2022) Agriculture Policy Monitoring and Evaluation 2022: Reforming agricultural policies for climate change mitigation
- Bellmann, C. (2019), Subsidies and sustainable agriculture: Mapping policy landscape, *Chatham House* December 2019
- Horlick, G. and Clarke, P. A. (2016), Rethinking Subsidy Disciplines for the Future, E15 Task Force on Rethinking International Disciplines, Policy Options Paper, Geneva: International Centre for Trade and Sustainable Development and World Economic Forum, <https://cht.hm/32cxj7D>.

- Sykes, A. (2005), ‘Subsidies and Countervailing Measures’, in Appleton, A., Macrory, P. and Plummer, M. (eds) (2005), *The World Trade Organization: Legal, Economic and Political Analysis*, Boston, MA: Springer Verlag.
- Bellmann, C. (2019), *Subsidies and sustainable agriculture: Mapping policy landscape*, *Chatham House* December 2019
- Kisan Gunjal and Chares Annor-Frempong, World Bank, *Review, Estimation and Analysis of Agricultural subsidies in Mongolia* Mar 30, 2014
- Gerd Schwartz, *Government Subsidies*, · April 1999
- Баясгалан Б, Төсвийн шинэчлэл: хэрэгжилт, хандлага, 2010
- Удирдлагын академи, Монгол Улсад хэрэгжүүлж буй төсвийн зарлагын удирдлагын шинэчлэл: туршлага, сорилт, судалгааны тайлан, 2019
- Худалдааны бодлогын нэр томъёоны тайлбар толь 2020
- <https://legalinfo.mn/mn/> эрх зүйн мэдээллийн нэгдсэн сайтаас:
 - УИХ-ын 2012 оны 74 дүгээр тогтоол, Засгийн газрын 2013 оны 394 дүгээр тогтоол
 - УИХ-ын 2011 оны 30 дугаар тогтоол, Засгийн газрын 2019 оны 343 дугаар тогтоол
 - Засгийн газрын 2020 оны 130 дугаар тогтоол
 - Тариалангийн тухай хуулийн 19 дүгээр зүйл
 - Хүнсний тухай хуулийн 8 дугаар зүйл

SPSIRPA FORUM 2024

Session 8-6

Opportunities to improve service access of art and culture organizations: in the example of Mongolian National Art Gallery



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
УЛС ТӨР СУДЛАЛ, ОЛОН УЛСЫН ХАРИЛЦАА, НИЙТИЙН УДИРДЛАГЫН
СУРГУУЛЬ,
НИЙТИЙН УДИРДЛАГЫН ТЭНХИМ

**СОЁЛ, УРЛАГИЙН БАЙГУУЛЛАГЫН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ БОЛОМЖ, АРГА ЗАМ
(МОНГОЛ УРАН ЗУРГИЙН ГАЛЕРЕЙН ЖИШЭЭН ДЭЭР)**

- Судалгааны зорилго
- Судалгааны зорилт
- Соёлын үйлчилгээний хүртээмжийн тухай онолын асуудал
- Сэдвийн судлагдсан байдал
- Соёл, урлагийн байгууллагын үйлчилгээний хүртээмжийн онцлог, мөн чанар
- Монгол уран зургийн галерейн өнөөгийн байдал, эрх зүйн орчин
- Дүгнэлт
- Санал
- Ном зүй

СУДАЛГААНЫ ЗОРИЛГО

Монгол Улсын соёл урлагийн байгууллагын нийгэмд үзүүлэх эерэг үр нөлөөг дээшлүүлэх, соёл, урлагаар хүүхдийг хүмүүжүүлэн хөгжүүлэх, Олон улсад “Монгол өв соёл”-ыг сурталчлахад үйлчилгээний хүртээмжийг сайжруулах шаардлага өнөөгийн нийгмийн тулгамдсан зорилтын нэг болж байна. Монголын уран зургийн галерей нь дээрх зорилтыг хэрэгжүүлэгч үндсэн байгууллагын нэг бөгөөд зорилтот бүлгүүдэд үйлчилгээгээ (хэрхэн хүргэвэл оновчтой вэ? ямар арга, хэрэгсэл тохиромжтой вэ?) тэгш, хүртээмжтэй хүргэх нь чухал асуудал юм.

Түүнчлэн үйлчилгээний хүртээмжийн түвшин болгонд ямар саадууд учирч байгааг илрүүлж, хэрхэн саадуудыг арилгаж хүртээмжийг нэмэгдүүлэх талаар санал зөвлөмж боловсруулах зорилготой.

СУДАЛГААНЫ ЗОРИЛТ

Монгол Улсын соёл урлагийн байгууллагын үйлчилгээний хүртээмжийг сайжруулах, зорилтот бүлгүүдэд соёлын хэрэглээний тэгш байдлын эрх, боломж, оролцоо бүхий гурван түвшний хүртээмжийн хүрээнд судалгааг хийх болно.

СОЁЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖИЙН ОНОЛЫН АСУУДАЛ

Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалын 27.1 дэх заалтад “Хүн бүр нийгмийнхээ соёлын амьдралд чөлөөтэй оролцох, урлагийн цэнгэлийг эдлэх, шинжлэх ухааны дэвшилд оролцож үр шимийг нь хүртэх эрхтэй¹” хэмээн заасан. Энэхүү эрхээ эдлэхийн тулд соёлын үйл ажиллагаанд оролцох хүртээмжийн асуудал яригдана. Боловсрол, мэдээлэл, үг хэлэх эрх чөлөө зэрэгтэй адил соёлын үйлчилгээг авах боломж хүн бүрд олгогдохын тулд үйлчилгээний хүртээмжийг судлах шаардлагатай. Соёлын үйл ажиллагаанд оролцох оролцоо, түүний хүртээмжтэй эсэх нь хүн бүрийн соёлын эрхээ эдлэхэд шаардлагатай тулгуур ойлголтууд болно².

Соёл нь нийгэм болон нийгмийн хэсэг бүлгийн оюун санаа, материаллаг байдал, мэдлэг оюун, сэтгэл санааны шинж байдлын цогц бөгөөд зөвхөн урлаг, утга зохиол төдийгүй амьдралын хэв маяг, хамтын амьдралын арга зам, үнэ цэнтэй систем, уламжлал, итгэл үнэмшлийг хамарна гэж ЮНЕСКО-ийн баримт бичигт тодорхойлжээ³.

Хэрэглээ нь хэрэглэгчийн авсан төлбөртэй үйлчилгээг илэрхийлдэг бол **“оролцоо”** нь сонирхогчийн, төлбөргүй үйл ажиллагаанд оролцох гэсэн утгаар голлон хэрэглэж ирсэн. Гэтэл амьдрал дээр хэрэглэгч, оролцогчид нь албан бус үйл ажиллагаанд ямар нэг байдлаар төлбөр төлдөг тул эдгээрийг хооронд нарийн ялгаж салгахад хүндрэлтэй⁴.

Соёлын **оролцоо** нь тодорхой соёлтой холбоотойгоор хувь хүн өдөр тутмын амьдралын үйл ажиллагаа болон урлагт оролцох оролцоо юм⁵. Энэ нь “соёлын мэдрэмж, үнэ цэнэ, зан үйл дэх үндэстэн ястны ялгаа нь зөвхөн уран сайхны ба мэдээллийг эрхэмлэх сонголтоор бус мөн амьдралын өдөр тутмын хэмнэлээр илрэн гарч ирдэг арга, мөн нийгмийн анги ба хүйс зэрэг нийгмийн чухал ач холбогдолтой онцлог шинжтэй холбоотой байх арга”-тай хамаатай⁶. Түүнчлэн соёлын оролцоо нь идэвхтэй, идэвхгүй зан байдлын аль алиныг хамарна. Энэ нь концерт үзэгч болон хөгжим сонирхдог хүмүүст хамаарна. Соёлын оролцооны асуулгын зорилго бол идэвхтэй, идэвхгүй зан байдлыг хооронд нь ялгаж салгах бэрхшээлтэй байдлыг үл харгалзан бүх үе шатанд нь үнэлгээ өгөх юм⁷. Соёлын үйлчилгээ нь соёлын ашиг сонирхол ба эрэлт хэрэгцээг хангах зорилготой⁸.

¹ Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал, 1948 он, <https://legalinfo.mn/mn/detail/1271>

² Annamari Laaksonen, 2010, “Making culture accessible: Access, participation and cultural provision in the context of cultural rights in Europe”, Council of Europe Publishing.

³ ЮНЕСКО-гийн 2009 оны Соёлын статистикийн хүрээ, НҮБ, 2009.

⁴ ЮНЕСКО-гийн 2009 оны Соёлын статистикийн хүрээ, НҮБ, 2009.

⁵ ЮНЕСКО-гийн 2009 оны Соёлын статистикийн хүрээ, НҮБ, 2009.

⁶ ЮНЕСКО-гийн 2009 оны Соёлын статистикийн хүрээ, НҮБ, 2009.

⁷ ЮНЕСКО-гийн 2009 оны Соёлын статистикийн хүрээ, НҮБ, 2009.

⁸ ЮНЕСКО-гийн 2009 оны Соёлын статистикийн хүрээ, НҮБ, 2009.

Хүртээмж нь мэдээллийн хүртээмж, эдийн засгийн боломж, орчны материаллаг хүчин зүйлс, нийгмийн хүчин зүйлс, ойлголт гэх мэт оролцооны саадыг багасгах тухай ойлголт юм⁹. Хүртээмж нь төлөвлөлтийн тухай асуудал бөгөөд стратеги, бодлого, үйл ажиллагааны төлөвлөгөө, төсөвт хүртээмжийн асуудлыг багтаахгүй бол бодитоор үйл ажиллагаа болохгүй.

Соёлын хүртээмж нь оролцооны урьдач нөхцөл болдог¹⁰. Нийгэмд тодорхой эрх, үүрэг, хариуцлага хүлээн гишүүн бүрийн нийгэмд оролцох суурь нөхцөлийг хүртээмж хэмээн үздэг¹¹. ЮНЕСКО-ийн “Хүмүүсийн соёлын амьдралд оролцох, хувь нэмрээ оруулах тухай санал зөвлөмж”¹² (1976)-д “соёлын үнэт зүйл, соёлыг таашаах, чөлөөтэй мэдээлэл олж авах, сургалт, мэдлэг, ойлголтын хүрээнд зохих нийгэм эдийн засгийн нөхцөлийг бүрдүүлэх замаар хүн бүрд бодит боломж олгох тухай ойлголтыг соёлын хүртээмж” гэж тодорхойлжээ¹³. **Соёлын хүртээмж**¹⁴ нь урлагийн хэрэглээг хүлээн авах боломж¹⁵ гэж үзэж болно¹⁶. Социологийн судалгаанд соёл/урлагийн хэрэглээ (Bourdieu 1984, Katz-Geroo 2002, Lena 2019) болон соёлын/урлагийн мэдрэмжийн (Childress 2021, Daenekindt, Roose 2017, Peterson, Kern 1996) тухай ихээхэн судалдаг хэдий ч хүртээмжийн асуудал нь соёлын хэрэглээ, мэдрэмжийг холбох шаардлагатай холбоос болох судалгаа орхигдсон¹⁷. **Соёлын хэрэглээ**¹⁸ нь музейд очих, ном унших, кино үзэх, урлагийн тоглолт үзэх зэрэг урлагтай холбоотой бараа, үйлчилгээ, туршлагыг хэрэглэх гэж судлаач Katz-Gerro (2004), Rossel (2017) нар тодорхойлсон¹⁹.

Соёлын хэрэглээ нь мэдрэмж болон хүртээмж хамтдаа үүргээ гүйцэтгэх тухай ойлголт юм. Хүртээмж нь соёлын мэдрэмж болон соёлын хэрэглээний холбогч бөгөөд соёлын хэрэглээнд тэгш бус байдлыг бий болгодог үндсэн эх сурвалж болдог²⁰. Соёлын хүртээмж нь соёлын салбарт төрөөс хөрөнгө оруулах, соёлын бодлогын зорилгыг тодорхойлох зорилгоор ихэвчлэн эдийн засагчид болон соёлын бодлогын эрдэмтэд судалдаг салбар²¹. Соёлын хүртээмж нь нийгэмд харилцан адилгүй хуваарилагдсан

⁹ SATA2 Project Finland, “Accessibility guide for children cultural centers and basic art educational institutions”, 2022.

¹⁰ Annamari Laaksonen, 2010, “Making culture accessible: Access, participation and cultural provision in the context of cultural rights in Europe”, Council of Europe Publishing.

¹¹ Annamari Laaksonen, 2010, “Making culture accessible: Access, participation and cultural provision in the context of cultural rights in Europe”, Council of Europe Publishing.

¹² Recommendation on Participation by the People at large in Cultural life and their contribution to it

¹³ Annamari Laaksonen, 2010, “Making culture accessible: Access, participation and cultural provision in the context of cultural rights in Europe”, Council of Europe Publishing.

¹⁴ Access to arts/Access to culture

¹⁵ Prospects of realizing a desired act of cultural consumption

¹⁶ Tal Feder, “Access to arts consumption: The stratification of aesthetic life-chances”, Journal of Consumer Culture, 2022, Vol 0, 1-20.

¹⁷ Tal Feder, “Access to arts consumption: The stratification of aesthetic life-chances”, Journal of Consumer Culture, 2022, Vol 0, 1-20.

¹⁸ Cultural consumption/arts consumption

¹⁹ Tal Feder, “Access to arts consumption: The stratification of aesthetic life-chances”, Journal of Consumer Culture, 2022, Vol 0, 1-20.

²⁰ Tal Feder, “Access to arts consumption: The stratification of aesthetic life-chances”, Journal of Consumer Culture, 2022, Vol 0, 1-20.

²¹ Tal Feder, “Access to arts consumption: The stratification of aesthetic life-chances”, Journal of Consumer Culture, 2022, Vol 0, 1-20.

байдаг. Хувь хүмүүсийн хувьд соёлын хүртээмжийн янз бүрийн түвшинд харилцан адилгүй саадуудтай учирдаг.

Мэдрэмж х Хүртээмж = Хэрэглээ

Соёлын хүртээмжийг онолын түвшинд илүү системтэй, нэгдмэл байдлаар судлах шаардлагатай. Хүртээмжийн хэд хэдэн түвшний хэмжээс, тодорхойлогч хүчин зүйлүүдийг ойлгосноор олон чухал ач холбогдолтой.

Судлаач О’Hagan (1998) соёлын хэрэглээнд тэгш байдлыг хангах урьдач нөхцөл нь **соёлын хүртээмж** гэж үзсэн²². Тэрээр соёлын хэрэглээнд тэгш байдлын **эрх, боломж, оролцоо** гэсэн гурван түвшний хүртээмж байна гэж тодорхойлжээ²³. Хүртээмжийн түвшин болгон төрөл бүрийн саадтай холбогдох бөгөөд энэ нь соёлын хэрэглээг хязгаарладаг. Тодорхой түвшний хүртээмжтэй байхын тулд өмнөх түвшний хүртээмжийн саадыг давах ёстой. Хүртээмжийн түвшин бүр нь бие биеэсээ харилцан хамааралтай байна. Хэрэв эхний түвшний хүртээмжийн саадтай тулгарвал дараагийн түвшний хүртээмжийн үр ашгийг хүртэхэд хэцүү байх болно²⁴. Жишээлбэл, дуурийн билет авах боломж нь зөвхөн дуурийн театр байх тохиолдолд буюу боломж байгаа тохиолдолд л үүснэ. Судлаач Tal Feder энэхүү судлаач О’Hagan (1998)-ны соёлын хүртээмж болон Eisentraut (2012) нарын онолд суурилан хүртээмжийн дөрвөн хэмжигдэхүүн нь эрх (rights), боломж (opportunity), оролцоо (participation), хүлээн авах (reception) хэмээн тодорхойлж судалгаа хийсэн²⁵.

1. **Эрх:** Соёлын хэрэглээг хязгаарлах суурь саад бөгөөд хууль, тогтоомж, дүрэм, журамд зааснаар эсвэл ялгаварлан гадуурхах институтийн практикаас бий болж, соёл, урлагийн үйл ажиллагаанд оролцох тодорхой бүлэг эсвэл хувь хүний эрхийг зөрчдөг²⁶. Жишээлбэл, АНУ-д Jim Crow хуулиар Африк гаралтай Америкчуудыг урлаг, соёлын үйл ажиллагаанд оролцох хязгаарлаж байсан²⁷. Мөн 1950-иад оны үед Саудын Араб улсад олон нийтийн газар хөгжмийн тоглолтыг хориглож байв. Ийм төрлийн хязгаарлалт нь тодорхой бүлэг хүмүүс эсвэл зарим төрлийн урлагийн төрөл, эсвэл аль алинд чиглэгдэж болно.

2. **Боломж:** Соёлын хэрэглээний эрх нь суурь шаардлага мөн боловч хангалттай нөхцөл биш юм. Боломж нь хувь хүн соёлыг боломжийн хүчин чармайлтаар

²² Tal Feder, “Access to arts consumption: The stratification of aesthetic life-chances”, Journal of Consumer Culture, 2022, Vol 0, 1-20.

²³ Tal Feder, “Access to arts consumption: The stratification of aesthetic life-chances”, Journal of Consumer Culture, 2022, Vol 0, 1-20.

²⁴ Tal Feder, “Access to arts consumption: The stratification of aesthetic life-chances”, Journal of Consumer Culture, 2022, Vol 0, 1-20.

²⁵ Tal Feder, “Access to arts consumption: The stratification of aesthetic life-chances”, Journal of Consumer Culture, 2022, Vol 0, 1-20.

²⁶ Tal Feder, “Access to arts consumption: The stratification of aesthetic life-chances”, Journal of Consumer Culture, 2022, Vol 0, 1-20.

²⁷ Tal Feder, “Access to arts consumption: The stratification of aesthetic life-chances”, Journal of Consumer Culture, 2022, Vol 0, 1-20.

хэрэглэхэд тулгарах бодит бололцоо гэж ойлгоно²⁸. Жишээлбэл, орон нутагт хүүхэлдэйн театр байхгүй байх нь хувь хүний ямар ч хүчин зүйлээс үл хамааран соёлын хэрэглээг хязгаарлах хүчин зүйл болж болно. Хүртээмжийн боломж нь соёлын хэрэглээний үйл ажиллагааны нийлүүлэлт хангагдаагүй шалтгаанаар хязгаарлагддаг. Соёлын хэрэглээнд газарзүйн буюу орон зайн нөлөөлөл байгаа бөгөөд музей, номын сан, дуурь, галерейд очиход тухайн газраас хэр алслагдсан бэ гэдэг нь хүмүүсийн хувьд чухал хүчин зүйл болж байна²⁹. Өөр нэг орон зайн хувьд саад болж буй элемент нь байршил, багтаамжийн асуудал юм. Хүн амны нягтаршил өндөр газар амьдрах нь соёлын хэрэглээнд нөлөөлж байгаа бөгөөд хүртээмжийн боломжийн нэг шалгуур үзүүлэлт нь хүн амын нягтаршил байх магадлалтай³⁰.

3. **Оролцоо:** Соёлын хэрэглээний боломж байгаа хэдий ч соёлын оролцоо бүх хүнд ижил хангагдахгүй. Хувь хүний нөөц, бололцооноос хамааран соёлын оролцоонд хязгаарлагдмал байдал оролцох саад үүснэ³¹. *Боломжтой* холбоотой саадтай харьцуулахад *оролцоо* нь хамтын, нийтлэг шинжээс илүүтэй хувь хүний нийгмийн байдалтай хамаатай хүчин зүйл юм. Мөн байнгын бус динамик шинжтэй. Оролцооны хамгийн нийтлэг саад бол хувь хүний санхүүгийн асуудал юм. Жишээлбэл, билетийн үнээс шалтгаалан зарим хүн санхүүгийн хувьд билет худалдан авах боломжгүй нь соёлын оролцоонд хязгаарлалт үүсгэдэг. Түүнчлэн, цаг хугацааны боломж нь оролцооны саадыг үүсгэж болно. Тодорхой цаг, өдөр, байршилд урлагийн тоглолт болдог нь цаг хугацаатай холбоотой оролцооны саад үүсгэнэ. Харин ном, үзэсгэлэн, цахим урлагийн төрөл нь цаг хугацааны хувьд илүү уян хатан байдаг. Хүртээмжийн оролцооны цаг хугацааны хүчин зүйлийн хувьд өндөр болон бага орлоготой иргэд нь дунд орлоготой иргэдтэй харьцуулахад цаг хугацааны хязгаарлалт бага саад болж байсан судалгааны үр дүн гарчээ³². Харин дунд орлоготой иргэдийн хувьд урлагийн хэрэглээнд зарцуулах эдийн засгийн боломж байгаа ч цаг хугацааны хувьд хязгаарлалт ихтэй гэх нэгдсэн дүгнэлтэд хүржээ. Харин өндөр орлоготой хүмүүсийн хувьд эдийн засгийн болон цаг хугацааны хүчин зүйлс хязгаарлалт болохгүй байна.


²⁸ Tal Feder, "Access to arts consumption: The stratification of aesthetic life-chances", Journal of Consumer Culture, 2022, Vol 0, 1-20.

²⁹ Tal Feder, "Access to arts consumption: The stratification of aesthetic life-chances", Journal of Consumer Culture, 2022, Vol 0, 1-20.

³⁰ Tal Feder, "Access to arts consumption: The stratification of aesthetic life-chances", Journal of Consumer Culture, 2022, Vol 0, 1-20.

³¹ Tal Feder, "Access to arts consumption: The stratification of aesthetic life-chances", Journal of Consumer Culture, 2022, Vol 0, 1-20.

³² Tal Feder, "Access to arts consumption: The stratification of aesthetic life-chances", Journal of Consumer Culture, 2022, Vol 0, 1-20.



Оролцоо	<ul style="list-style-type: none"> • Санхүүгийн боломж - билетийн үнэ (бусад соёлын үйлчилгээ ямар үнэтэй байгаад харьцуулалт хийх, музей, тоглоомын төв, кино, чөлөөт цагт зориулсан сургалтууд гэх мэт) • Цаг хугацааны хязгаарлалт
Боломж	<ul style="list-style-type: none"> • Бодит боломж - байршил • Багтаамж, тав тух, • ХБИ-дэд зориулсан орц, гарц
Эрх	<ul style="list-style-type: none"> • Хууль, эрх зүй

Reception буюу хүлээн авах ойлголт нь урлагийг ойлгох, кодыг тайлах (мэдээллийг янз бүрийн хэлбэрээр кодлодог ба түүнийг тайлж хүлээн авах тухай ойлголт), таашаах, ойлгон мэдрэх үйл явц юм³³. Жишээлбэл, урлагийн тоглолтыг зүгээр үзэх, ойлгож хүлээн авах нь өөр ойлголт бөгөөд оюун ухаан, сэтгэл хөдлөлийн түвшинд урлагийг ойлгож таашаах чадварыг энэхүү хүрээнд тодорхойлно. Хүлээн авах хүртээмжийн асуудал нь ихэвчлэн боловсрол болон оюун ухааны ур чадвараас шалтгаална гэж судлаачид үздэг³⁴. Мөн урлагийг илэрхийлж буй хэлбэр, хэл зэргээс хүртээмжийн саад үүснэ. Жишээлбэл, үндэс угсаа соёлын олон бүлэгтэй нийгэмд соёлын мэдрэмж нь үндэс угсаа болон соёлын бүлгээр өөр байдаг³⁵. АНУ-д хийсэн судалгаагаар янз бүрийн үндэстний соёлын хэрэглээ хоорондоо ялгаатай байгаа талаар дүгнэжээ³⁶. Боловсролд

³³ Tal Feder, "Access to arts consumption: The stratification of aesthetic life-chances", Journal of Consumer Culture, 2022, Vol 0, 1-20.

³⁴ Tal Feder, "Access to arts consumption: The stratification of aesthetic life-chances", Journal of Consumer Culture, 2022, Vol 0, 1-20.

³⁵ Tal Feder, "Access to arts consumption: The stratification of aesthetic life-chances", Journal of Consumer Culture, 2022, Vol 0, 1-20.

³⁶ Tal Feder, "Access to arts consumption: The stratification of aesthetic life-chances", Journal of Consumer Culture, 2022, Vol 0, 1-20.

ихээхэн цаг хугацаа зарцуулсан хүмүүс урлаг соёл, түүнтэй холбоотой үйл ажиллагаанд оролцох, туршлага хуримтлуулах, түүнтэй холбоотой танин мэдэхүйн ур чадвар хөгжсөн байх магадлал өндөртэй, харин боловсролын түвшин багатай хүмүүс урлагийн хүртээмжийн хувьд илүү их саадтай учирдаг байна³⁷. Энэхүү судалгааны хүрээнд соёлын хүртээмжийн эрх, боломж, оролцооны түвшнээр хязгаарлалт хийсэн болно. Соёлын хүртээмж нь тусдаа судлагдахуун юм.



СЭДВИЙН СУДЛАГДСАН БАЙДАЛ (МОНГОЛ УЛСАД)

Соёл, урлагийн байгууллагууд **энгийн иргэн болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан соёл урлагийн үйлчилгээний** хүртээмжтэй байдлыг бий болгоход төдийлөн бэлэн биш байна.

Түүнчлэн Монгол Улсад хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон энгийн эрүүл иргэдтэй хамт соёл, урлагийн үйлчилгээг авах, мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан дагнасан үйлчилгээ байдаггүй.

Соёл, урлагийн хэрэглээний хүртээмжийн түвшин болох тэгш байдлын эрх, боломж, оролцоо нь харилцан адилгүй байх ба энэ чиглэлээр судлагдсан судалгаа одоогоор байхгүй байна.

СОЁЛ, УРЛАГИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖИЙН ОЙЛГОЛТ, МӨН ЧАНАР

“Соёл урлагийн байгууллагын үйлчилгээний хүртээмжтэй байдал” сэдвийн хүрээнд хийгдсэн судалгаа нь гол төлөв “эрүүл” иргэдэд үйлчлэх чиглэлээр хийгдсэн байгаа нь зөвхөн нэг талыг барьсан, хүртээмжийн түвшнээр нь авч үзээгүй байна.

³⁷ Tal Feder, “Access to arts consumption: The stratification of aesthetic life-chances”, Journal of Consumer Culture, 2022, Vol 0, 1-20.

Мөн соёл, урлагийн байгууллагад “тусгай хэрэгцээт” буюу “хөгжлийн бэрхшээлтэй” иргэд үйлчилгээг тэгш авах боломжийн талаарх судалгааг одоогоор хийгдээгүй байна.

Соёл, урлагийн байгууллагын үйлчилгээг хүртээмжтэй болгох, өргөжүүлэх, хөгжүүлэх, иргэн төвтэй төрийн үйлчилгээ буюу “шилдэг үйлчилгээ”³⁸-г нийт иргэдэд хүртээмжтэй болгох үүднээс харааны болон сонсголын бэрхшээлтэй иргэдийг соёл, урлагийн үйлчилгээг авах боломжийг нээлттэй болгох нь чухал юм.

Үзэгчдийн сегментийг өргөжүүлэх, урлагийн хэлээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмээс ялгаварлан гадуурхахгүй, үйлчилгээг тэгш хүртээмжтэй түгээх нь хөгжлөөс хэнийг ч хоцроохгүй иргэдийн хүний эрх, тэгш эрхийг дээдлэхийн илрэл юм.

Энэхүү соёл урлагийн хэрэглээ болсон шалтгаан нь оролцогсдын хүсэл зориг, мэдлэгээс бүрэн хамааралгүй нийгмийн чиг үүргийг гүйцэтгэхэд оршино.

МОНГОЛЫН УРАН ЗУРГИЙН ГАЛЕРЕЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Монголын уран зургийн галерей нь Монголын орчин үеийн дүрслэх урлагийн бүтээлүүдтэй олон түмнийг танилцуулах зорилгоор 1991 онд Дүрслэх урлагийн музейгээс салж бие даан үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн. Тухайн үед Соёлын Төв өргөөний “Б” корпуст 3250 м² талбайд байнгын үзэсгэлэнгийн 2 танхим, хадгаламжийн сангийн 4 өрөөтэй үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн.

Өдгөө үзэсгэлэнгийн 5 танхим, сан хөмрөгийн 6 өрөө, урлагийн боловсролын 1 танхим, хурлын 1 танхим, соёлын бүтээгдэхүүн худалдааны хэсэг бүхий 2660 м² талбайд үйл ажиллагаагаа явуулж байна.

Монголын уран зургийн галерей нь Монголын орчин үеийн дүрслэх урлагийн бүтээлүүдийг сонгон цуглуулж, сан хөмрөгөө баяжуулах, тэдгээр бүтээлүүдийг судлан сурталчлах, хадгалж хамгаалах, нийгэм, түүх, соёлын хөгжлийн зүй тогтлыг баримтжуулах, дүрслэх урлагаар дамжуулан үзэгчдэд гоо зүйн болон урлагийн боловсрол олгох үүрэгтэй төрийн үйлчилгээний байгууллага юм.

1921 оны Ардын Хувьсгал ялснаас хойш өнөө үе хүртэл бүтээгдсэн Монголын орчин үеийн дүрслэх урлагийн шилдэг бүтээлүүд болох монгол зураг, уран зураг, зураасан зураг, баримал, сийлбэр, хөөмөл, ардын гар урлал, хатгамлын бүтээлүүдээс бүрдсэн 4000 орчим нэгж үзмэртэй ба нийт үзмэрийн 90 гаруй хувь нь сан хөмрөгт

³⁸ Бурмаа Нацагийн: төрийн үйлчилгээ. Улаанбаатар 2021, х.18

хадгалагдаж, үлдсэн 7-8 орчим хувийг үзэсгэлэнгийн танхимд дэлгэн үзэгч олонд үйлчилж байна.

Дээрх хадгаламжийн сангуудад 150 орчим уран бүтээлчийн 15.530.360.444.00 төгрөгийн бүтээлүүд хадгалагдаж байна. Өөрийн мэдээллийн сандаа 230 орчим зураач урчуудын бүртгэлтэй. Үзэсгэлэнгийнхээ танхимд сэдэвчилсэн болон төрөлжүүлсэн үзэсгэлэнг зохион байгуулахаас гадна гадаад, дотоодын уран бүтээлчдийн үзэсгэлэнг зохион байгуулдаг.

Мөн гадаад орнуудад өөрийн цуглуулгаас болон Монголын уран бүтээлчдийн үзэсгэлэнг зохион байгуулдаг. Түүнчлэн, гадаадын мэргэжил нэгт байгууллага, хувь хүмүүстэй байнгын харилцаатай ажиллаж, харилцан туршлага солилцох, хамтарч үзэсгэлэн зохион байгуулах, төсөл хэрэгжүүлэх, ерөнхий боловсролын сургуулиудын сурагчид болон мэргэжлийн их дээд сургуулиудын багш, сурагчидтай хамтран дэлхийн урлагийн болон Монголын орчин үеийн дүрслэх урлагийн талаар хамтарсан сургалт, семинар явуулах, санал бодлоо солилцох зэрэг олон талт үйл ажиллагаа явуулдаг.

Монголын зураач, урчуудын тухай мэдээллийн сан байгуулж, мэдээ мэдээллийг байнга шинэчлэн цуглуулдаг. Галерей байгуулагдсан цагаас хойш сан хөмрөгөө улсаас батлагдсан төсвийн дагуу жил бүр баяжуулах үйл ажиллагаа байнга явуулсаар ирсэн.

Галерейн сан хөмрөгийг бүрдүүлж буй дүрслэх урлагийн шилдэг бүтээлүүд нь өрнө дорнын хосолмол арга барилтайгаараа дэлхийн олон орны үзэгчдийн анхаарлыг татдаг юм.

Уран Зургийн Галерей нь үндсэн 3 хэсэгт хуваагддаг. Энэ нь:

1. Монгол зураг, зураасан зураг, ардын гар урлалын хэсэг
2. Реалист урлагийн хэсэг
3. Орчин үеийн урлагийн хэсэг юм.

Галерейн үзүүлэлэг болох Монгол зураг нь эртний хадны сүг зургаас эх авч аажимдаа хөгжиж ирсэн ба Төв Азийн уран зургийн салшгүй хэсэг ба Ардын зураг, Бурхан зургийн хэлбэрээр хөгжиж байв. Монгол зурагт байгалийн бүх үзэгдэл, хүн ардын дүрийг нэг хавтгай дээр хураан багтаасан байдаг ба хүн, амьтан, юмс, үзэгдлийг ёгт хэлбэрээр дүрсэлдэг онцлогтой юм. Зураачид Монгол зургийг голдуу эрдсийн чанартай шороон будгаас гадна есөн эрдэнийн чулуунаас боловсруулж гаргадаг байжээ. Зураасны уран нарийн татлагыг илэрхийлдэг зураг бол нагтан, гартан, мартан гэдэг. Энэтхэгээс гаралтай улаан, хар цагаан дэвсгэр дээр 9 эрдэнийн будгаар зөвхөн өнгийн зураасаар зурдаг өвөрмөц зураг юм. Монголын шинэ үеийн дүрслэх урлагийг үндэслэгч нь зураач Балдуугийн Шарав юм. Б.Шарав нь бурхны хөрөг зурдаг байсан ба түүний

уран бүтээлийг хөрөг зураг, ухуулах хуудас, номын зураг, аж байдлын зураг гэж ангилж болно. Галерейн монгол зургийн хэсэгт Б.Шаравын 1923 онд зурсан “В.И.Ленин”, А.Сэнгэцохиогийн “Марзан Шарав”, “Хоёр буур”, “Хар буур”, У.Ядамсүрэнгийн “Өрх гэрийн эзэн” Л.Дарьсүрэнгийн “Урт наст зургаа”, Ц.Даваахүүгийн “Хувьсгалын дуудлагаар” зэрэг олон шилдэг бүтээлүүдийг үзэж болно.

Монгол зургийн хэсгийн нэг хэсгийг зээгт наамал буюу “Торгон зураг” эзэлдэг. Зээгт наамлын урлаг нь эрт дээр үеэс манай ард түмний дунд уламжлан хөгжиж ирсэн бөгөөд ур чадвараараа уран зургийн хэмжээнд хүрч, улмаар дэлхийн дүрслэх урлагийн түүхэнд онцгой байр суурь эзэлдэг ардын гар урлалын нэгэн өвөрмөц төрөл юм. Зураасан зургийн урлаг нь эртний хүмүүсийн хад агуйд зосоор зурсан зургаас эхлээд хүн ба буган чулуун хөшөөний дурсгалуудаас эх үндэстэй урлаг юм.

Монголын уран зургийн галерейд Ц.Нарангэрэлийн “Хатан”, Ц.Будбазарын “Хүүгийн хөрөг”, Д.Мишигийн “Туульч Чойсүрэн” зэрэг зургууд, Ц.Дагванямын “Наадам”, “Цагаан сар” зэрэг бар зургууд бий. Ардын гар урлалын олон төрөл зүйлийг галерейн үзүүллэгт чухал байр суурь эзэлдэг. Монгол сийлбэрийн урлагт МУ-ын Урлагийн Гавьяат Зүтгэлтэн, сийлбэрч С.Сэнгээ, Л.Чуваамид, Д.Гэвшээхүү нар үнэтэй хувь нэмэр оруулсан билээ. Тус галерейн үзмэрт С.Сэнгээгийн “1921 он”, “Адуучин”, УГЗ Л.Чуваамидийн “Дэвшил” Д.Гэвшээхүүгийн “Арслан” зэрэг үндэсний уламжлалт гоёл чимэглэлийн урлагийн гайхамшигт бүтээлүүд байдаг.

Тус уран зургийн галерейн хамгийн гол хэсэг бол реалист урлагийн хэсэг юм. 1921 оны Ардын хувьсгал ялснаар Монгол орон социалист хөгжлийн замыг сонгосон ба реалист урлаг нь Монголын Дүрслэх урлагийн хөгжлийн гол чиг шугам байв. 1950-иад оноос уран зургийн боловсрол эзэмшсэн мэргэжлийн зураачидтай болсон нь Монголын уран зургийн ур чадварын түвшин, бүтээлийн цар хүрээ тэлэн нэмэгдэх шинэ алхам болсон ба анхны уран бүтээлчид Орос Улсын Москва, Санктпетербург хотуудын Уран Зургийн Академиудаас төрсөн. Монголд Европын уран зургийн аргаар туурвисан анхны бүтээлүүдэд БНМАУ-ын Төрийн хошой шагналт Ардын зураач О.Цэвэгжавын “Гүүн зэлэн дээр”, УГЗүтгэлтэн Дамдинсүрэнгийн “Жинчин”, Төрийн шагналт, Ардын зураач У.Ядамсүрэнгийн “Сүхбаатар”, Д.Чойдогийн “Партизан Мельников” зэрэг бүтээлүүд ордог бөгөөд Монгол зургийн дүрслэн илэрхийлэх онцлогийг хадгалж, Европын уран зургийн арга барилтай хослуулан ард түмнийхээ аж амьдрал, байгалийн өвөрмөц сайхныг гаргаж байв.


Уран зургийн галерейн дараагийн үзэсгэлэн бол орчин үеийн урлагийн хэсэг юм. Монголын зураачид 1990-ээд оноос модернист шинэ урлагийн урсгал чиглэлийг үндэс

болгон өөрийн арга сэтгэлгээгээр баяжуулсан өвөрмөц бүтээлүүдийг туурвисны зэрэгцээ уламжлалт реалист уран зургийн өнгө төрхийг улам хөгжүүлсээр байна. Монгол оронд Ардчилсан хувьсгал ялснаар уран бүтээлчид хязгаарлагдмал арга барилаас салж өөрсдийн ур чадвараа улам сайжруулж, уран бүтээлийн эрэл хайгуул хийх болсон ба дүрслэх урлагийн орчин үеийн хэллэг, арга барил, чөлөөт сэтгэлгээгээр бүтээлээ туурвих болж, өнөөдөр монголын дүрслэх урлаг хүн ардын хүсэл, тэмүүллийг тусган төрөл бүрийн хэлбэр, чиглэлээр хөгжиж, залуу уран бүтээлчдийн шинэ шинэ бүтээлүүдээр улам баяжигдсан.

Сүүлийн жилүүдэд гадаад харилцаагаа улам өргөжүүлэн ажиллаж байгаа бөгөөд тус галерей нь Японы Фукоука хотын Азийн урлагийн музейтэй холбоо тогтоон ажиллахын зэрэгцээ тус музейгээс 3 жил тутам зарладаг олон улсын бенеалд өөрийн орны зураач урчуудыг тогтмол оролцуулж байна. Мөн Солонгосын “Art Association” байгууллагаас жил бүр зохион байгуулдаг Азийн Орнуудын олон улсын үзэсгэлэнд 5-6 уран бүтээлчийн бүтээлийг тогтмол оролцуулж иржээ.



ТАНХИМЫН СХЕМ



**МОНГОЛЫН УРАН ЗУРГИЙН ГАЛЕРЕЙГААР
ҮЙЛЧЛҮҮЛЭГЧДИЙН ТОО /2021-2023 оны байдлаар/**



ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Монгол Улсын хэмжээнд өнөөгийн байдлаар 6562 стандарт байгаагаас 55 гаруй хувь нь заавал мөрдөх, 45 гаруй хувь нь сонгон хэрэглэх стандарт, 40 гаруй хувь нь хуучны социалист агуулгатай стандарт байгааг судлаачид тэмдэглэсэн байна. Үүнээс соёл урлагийн салбарт хамаарах 10 гаруй стандарт байна. Соёл, урлагийн байгууллагын орлогын түвшинд бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөл, агуулга, шинэ содон байдал, хэрэглэгчид үзүүлж буй нэмэлт үйлчилгээ түүний үйлчилгээний чанар чухал үүрэг гүйцэтгэдэг. Монгол Улсын Соёлын тухай хуулийн (2021) 5.1.6-д соёлын бодлого, үйл

ажиллагаанд баримтлах “тэгш, **хүртээмжтэй** байх” үндсэн зарчмыг баримтална гэж заажээ. Мөн хуулийн 32.1-р зүйлд соёлын үйл ажиллагааны санхүүжилтийн тогтолцоо нь иргэнд тэгш, **хүртээмжтэй**, чанартай соёлын үйлчилгээ үзүүлэхэд чиглэгдэнэ, 34.3.5-д соёлын арга хэмжээ, соёлын бараа, үйлчилгээг үйлдвэрлэх, түгээх, хуваарилах арга хэлбэрийг сайжруулж, **хүртээмжтэй** ашиглах нөхцөлийг бүрдүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлэхээр тус тус заажээ.

Соёл, урлагийн салбарын харилцааг зохицуулж буй үзэл баримтлал-3, төрөөс баримтлах бодлого-4, хууль-20, зарлиг-12, УИХ-ын тогтоол-15, Засгийн газрын тогтоол-48, үндэсний хөтөлбөр-15 зэрэг гол эрх зүйн баримт бичгүүд байна. Харин соёл, урлагийн талаар гарсан хууль, тогтоол, дүрэм журам амьдрал дээр сайн хэрэгжихгүй, үйлчилгээний чанар, хүртээмж муу, соёл, урлагийн байгууллагууд санхүүгийн эрх чөлөөгүй, системийн шинжтэй шинэчлэл хийх шаардлагатай байгаа талаар доктор Ж.Долгорсүрэнгийн судалгааны бүтээлээс соёл, урлагийн менежментийн тогтолцоо хөгжүүлэхэд чиглэгдсэн бодлого, эрх зүйн орчин бүрдүүлэх, олон улсын жишигт нийцсэн орчин бүрдүүлэх, хөрөнгө оруулалтын оновчтой бодлого хэрэгжүүлэх нийгмийн шаардлага хэрэгцээ байгааг Соёлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн судалгааны үр дүнгээс, мөн төрийн соёлын бодлогыг хэрэгжүүлэхэд мэргэжлийн боловсон хүчнээр хангах, соёлын үйлчилгээг чанартай хүртээмжтэй хүргэхэд стандарт шаардлагатай, төсөв хөрөнгийг нэмэгдүүлэх, төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэх, жишиг загвар байдаг ч хөрсөндөө буудаггүй учир зарим харилцааг зохицуулах, дүрэм журмыг оновчтой боловсруулах шаардлагатай байгаа талаар соёлын үйлчилгээний хүртээмжийн судалгааны үр дүнгээс харж болно³⁹.

ДҮГНЭЛТ

Соёл, урлагийн байгууллагууд инновац нэвтрүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй үйлчлүүлэгчтэй “шинэ” харилцаа үүсгэх үйл ажиллагаанд удирдлага, ажилтнууд, үйлчлүүлэгчдийн харилцаа хандлага, сэтгэлгээг өөрчлөхөд бэлэн биш, соёл, урлагийн байгууллагуудын мэргэжилтнүүд хүртээмжтэй үйлчилгээг нэвтрүүлэх, бүтээлчээр харилцах ур чадвар эзэмших мэдлэг, сэдэл дутмаг, элдэв саад бэрхшээлгүй орчинд зохицох арга хэмжээг боловсруулан хэрэглэх ур чадваргүйгээс гадна сэтгэлгээ, сэтгэлзүй, мэргэшлийн хувьд бэлэн биш хангалттай ажилтангүй байна.

³⁹ “Соёлын байгууллагын үйлчилгээний чанараар бодлогын хэрэгжилтийг үнэлэх нь” Ш.Оюундэлгэрэх, соёл судлалын докторын диссертаци. Х-84

Монголын уран зургийн галерейн үйлчилгээг өргөжүүлэн хөгжүүлэх **хүүхэд**, иргэн төвтэй төрийн үйлчилгээ буюу “шилдэг үйлчилгээ”-г нийт иргэдэд **хүртээмжтэй** хүргэх нь: “**Монголын уран зургийн галерейн** үндсэн чиг үүрэг, хариуцлага мөн боловч 20 орчим ажилтантай байгууллагын хувьд дангаараа төгс шийдвэрлэх боломжгүй юм”.

“**Иргэн** төвтэй соёл, урлагийн шилдэг үйлчилгээ” буюу “шилдэг үйлчилгээ”-г нийт иргэдэд **хүртээмжтэй** хүргэхэд төрийн бодлого, салбарын бодлого, салбар дундын бодлого, соёл, урлагийн байгууллагуудын хамтын ажиллагаа, төр, хувийн хэвшлийн түншлэл, гэр бүл, иргэдийн хамтын оролцоотой **нэгдсэн бодлогоор** шийдвэрлэж чадна.

САНАЛ

- Соёлын хүртээмжийн түвшин бүрд онолын болон эмпирик судалгааны үндсэн дээр тодорхой арга хэрэгслийг санал болгоно. Жишээлбэл, галерей орон нутагт сан хөмрөгийн зарим уран бүтээлээ түр үзэсгэлэн гаргах, галерейн явуулын болон цахим үйлчилгээг зохион байгуулснаар **соёлын хүртээмжийн боломжийг** нэмэгдүүлнэ. Ажиллах цагаа уртасгах, хямдралтай болон багцын үнээр билет санал болгох зэргээр **соёлын хүртээмжийн оролцоог** нэмэгдүүлэх юм.
- Газарзүйн байршил, орлого, боловсрол зэрэг олон хүчин зүйлийн хувьсагч соёлын хүртээмжийн түвшин бүрд харилцан адилгүй нөлөөлдөг.
- Орох хаалга, ариун цэврийн өрөө, машин тавих зай, зам, цахилгаан шат, суудал хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй хамт явж буй хүнд (туслагч, орчуулагч) үнэгүй орох эрх, мэдээллийг хүртээмжтэй хүргэх явдал.
- Орлого багатай, орлогогүй өрхийн иргэдэд галерей үзүүлэх боломж, зөвхөн орлогоос болж соёлын үйлчилгээний хүртээмжид хязгаарлахгүй байх талаар хүртээмжийг нэмэгдүүлэх шаардлагатай.

НОМ ЗҮЙ

Ашигласан ном:

- Нацагийн Бурмаа “Төрийн үйлчилгээ” Улаанбаатар 2021.
- Нацагдоржийн Борхүү “Соёл, урлагийн менежмент” Улаанбаатар 2018.
- Паул Жойс “Нийтийн салбарын стратегийн удирдлага” Улаанбаатар 2020.
- Дулдуйтын Данзанравжаа “XIX зууны Монголын нэрт соён гэгээрүүлэгч, ноён хутагт” Дорноговь 2013.
- Ж.Долгорсүрэн, Н.Сарантуяа, Б.Сумъяа “Соёл урлагийн бодлогын шинжлэх ухааны үндэс”. Улаанбаатар 2003.

- МУИС, Хамтын бүтээл "Төрийн албан хаагчийн ширээний ном IV" Улаанбаатар 2020.
- МУ-ын СУИС, Соёл урлаг судлалын хүрээлэн "Соёлын үйлчилгээний хүртээмжийн судалгаа" /тайлан/ Улаанбаатар 2019.
- ХНХЯам, Жайка олон улсын хамтын ажиллагааны байгууллага, "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал: бодлого, үйл ажиллагаа" Улаанбаатар 2020.
- Tal Feder, "Access to arts consumption: The stratification of aesthetic life-chances", Journal of Consumer Culture, 2022, Vol 0, 1-20.
- SATA2 Project Finland, "Accessibility guide for children cultural centers and basic art educational institutions", 2022.
- Annamari Laaksonen, 2010, "Making culture accessible: Access, participation and cultural provision in the context of cultural rights in Europe", Council of Europe Publishing.
- Access to arts/Access to culture
- Prospects of realizing a desired act of cultural consumption
- Recommendation on Participation by the People at large in Cultural life and their contribution to it

Монгол Улсын хуулиуд:

- Монгол Улсын "Үндсэн хууль" Улаанбаатар 1992.
- "Соёлын тухай" /Шинэчилсэн найруулга/ Улаанбаатар 2021.
- "Хөдөлмөрийн тухай" Улаанбаатар 1999.
- "Төрийн албаны тухай" Улаанбаатар 2018.
- "Хөгжлийн бодлого төлөвлөлт түүний удирдлагын тухай" /Шинэчилсэн найруулга/ Улаанбаатар 2020.
- "Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай" Улаанбаатар 2016.
- "Барилгын тухай" /Шинэчилсэн найруулга/ Улаанбаатар 2016.
- "Инновацын тухай" Улаанбаатар 2012.
- "Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай" Улаанбаатар 2012.
- "Статистикийн тухай" /Шинэчилсэн найруулга/ Улаанбаатар 1997.
- "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай" Улаанбаатар 2005.
- "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай" Улаанбаатар 2008.
- "Боловсролын тухай" Улаанбаатар 1994.

- “Иргэний хууль” Улаанбаатар 2002 он. хот
- “Гэр бүлийн тухай” Улаанбаатар 1999.
- “Хүүхэд хамгааллын тухай” Улаанбаатар 2016.

Улсын Их Хурлын тогтоол:

- “Алсын хараа - 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай №25, Улаанбаатар 2020.
- Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай №23, Улаанбаатар 2020.
- Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай №45, Улаанбаатар 2020.

Засгийн газрын тогтоолууд:

- “Сонгодог урлаг III” үндэсний хөтөлбөр батлах тухай №141, Улаанбаатар 2018.
- “Монгол уран бүтээл” үндэсний хөтөлбөр батлах тухай №252, Улаанбаатар 2014.
- “Соёлын үйлдвэрлэл” үндэсний хөтөлбөр батлах тухай №509, Улаанбаатар 2015.
- “Цахим засаг” үндэсний хөтөлбөр №101, Улаанбаатар 2012.
- Хүүхдэд зориулсан уран бүтээл туурвихад санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам №280, Улаанбаатар 2007.
- Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм №33, Улаанбаатар 2019.

Сайдын тушаал:

- Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны сайдын “Мэргэжлийн урлагийн байгууллагын үлгэрчилсэн дүрэм” №А/495. Улаанбаатар 2015.
- Сангийн сайдын “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам” №74. Улаанбаатар 2019.

Стандартын нэр:

- MNS6476:2014 Мэргэжлийн урлагийн байгууллагын орчны нөхцөл, үйл ажиллагаанд тавих ерөнхий шаардлага. Улаанбаатар 2014.
- MNS5151:2002 Хөдөлмөрийн аюулгүй байдал, үйлдвэрлэлийн эрүүл ахуй. Цахилгааны аюулгүй ажиллагаа. Улаанбаатар 2002.
- Ашигласан материал:
- Ш.Оюундэлгэрэх, “Соёлын байгууллагын үйлчилгээний чанараар бодлогын хэрэгжилтийг үнэлэх нь” соёл судлалын докторын диссертаци. 2021 он. Улаанбаатар хот

- З.Ширнэн, 2016 он. “Харааны бэрхшээлтэй хүмүүст соёлын үйлчилгээг хүргэх зарим арга зам”, соёл судлалын магистрын зэрэг горилсон бүтээл. Улаанбаатар хот

Удирдагч Проф.Др.Н.Бурмаа

Докторант Мягмар овогтой Отгончимэг /21D1NUM0011/

SPSIRPA FORUM 2024

Session 9-1

The constitution amendment of Mongolia: Issue and solution



Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт: шаардлага, үндэслэл, сургамж

МУИС-ийн УТСОУХНУС-ийн гэрээт дэд профессор, доктор П.Амаржаргал

Энэ жил Монгол Улсад анхдугаар Үндсэн хууль батлагдсаны 100 жилийн ойд зориулан энэхүү өгүүллийг туурвихыг зорьсон болно. Энэхүү өгүүллийг Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн төсөл санаачлагч, үйл ажиллагаа, зохицуулсан хууль тогтоомжийн тухай Улсын Их Хурлын архив, Парламентын номын сан, монголын эрдэмтдийн бүтээлд¹ түшиглэн бичив.

Нэг үе бодвол манайд 1992 оноос хойш Үндсэн хуулийн эрх зүй сонирхдог судлаач эрдэмтэд бий болж, энэ талаар дорвитой ном, өгүүлэл, сурах бичиг, тайлбар гарсаар байна. Түүнчлэн бид өөрсдөө ардчилсан Үндсэн хуулиа 1992 онд баталж, түүндээ 5 удаа нэмэлт, өөрчлөлт оруулж байгаа хэдий ч, бидэнд суралцах, сургамж алдаа дутагдал байсаар л байна.

Дэлхийн бараг бүх улс өөрийн гэсэн Үндсэн хуультай байдаг. Гэхдээ Үндсэн хуультай байх, түүндээ нэмэлт, өөрчлөлт оруулах нь өөр асуудал болжээ.

Үндсэн хууль гэдэг нь тогтоох гэсэн утгатай латины “constitutio” гэдэг үгнээс гаралтай ажээ. Үндсэн хууль нь 800 гаруй жилийн түүхтэй бөгөөд дэлхийн ууган Үндсэн хууль нь 1215 оны Английн Магна Харт, 1787 онд АНУ-д, 1791 онд Франц, Польшид, 1889 онд Япон Улсад батлагдсанаас хойш ихэнх улс оронд бүрэн эрхт байдлын нь илэрхийлэл, ард түмний бүрэн эрх, хүний эрх, эрх чөлөө, ардчилсан төрийн баталгаа болсон улс төр, эрх зүйн гол баримт бичиг болно.

Магна Харт нь анх одоогоос 808 жилийн тэртээ бүтээгдсэн, эрх чөлөөний эх сурвалжийг судлаагүй хуульч дэлхийд ховор бөгөөд түүний үзэл санаа шингээгүй Үндсэн хууль гэж бараг үгүй юм.²

АНУ-ын Үндсэн хууль 1789 оноос хойш 231 жил оршин тогтнох хугацаандаа 27 нэмэлт, өөрчлөлтийг оруулсан байна. Япон Улсын Үндсэн хууль 1947 оноос хойш 73 жилийн турш хүчин төгөлдөр үйлчилж байгаа бөгөөд өнөөдрийг хүртэл нэг ч өөрчлөлт хийгээгүй байна.³

Үндсэн хууль бол шууд бий болчихоогүй, нийгэм, улс төрийн амьдралаар нөхцөлдөн, түүхийн бүтээгдэхүүн болж тодорхой нөхцөл байдлын дунд үүсчээ.⁴

Монгол Улсын Үндсэн хууль-Монголын ард түмний оюун ухааны сор бүтээл юм.⁵

¹ П.Очирбат, Б.Чимид, Ж.Амарсанаа, С.Нарангэрэл, Ч.Энхбаатар, Т.Сэнгэдорж, Н.Лүндэндорж, Д.Лүндээжанцан, Н.Жанцан, Д.Ламжав, Ц.Сарантуяа, Д.Солонго, О.Батсайхан, Б.Баярсайхан, Ч.Өнөрбаяр, О.Мөнхсайхан, Л.Өлзийсайхан, Б.Батбаяр ... гэх мэт өгүүлэл, сурах бичиг, тайлбар толь, судалгааны тайлан

² П.Амаржаргал. “Эрх чөлөөний эх булаг Магна Харт”. Олон Улс судлал-2023: Монголын Британы судлал эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл (2024) 20 дахь тал Шинжлэх Ухааны Академийн Олон Улс судлалын хүрээлэн

³ Д.Лхагвасүрэн. Р.Ууганбаатар. М.Сайнбаяр. Д.Сүхболд. Д.Зоригтбаатар. Бүгд Найрамдах Монгол Ард Улс: Үндсэн хуулийн тайлбар философи. (2020) 367 дахь тал

⁴ Т.Сэнгэдорж. Дэлхийн улсуудын Үндсэн хууль ёсны хөгжил, мөн чанар, онцлог. Шинэ толь (1999) № 28

⁵ Н.Лүндэндорж. Монгол Улсын Үндсэн хууль шинжлэх ухааны тайлбар. Хянан тохиолдуулсан: Н.Жанцан (2022) 15 дахь тал

Үндсэн хуулийг цаг хугацаанд нь зөв ойлгож, ягштал мөрдөхгүй бол энэ зүгээр л “цаас” төдий зүйл болох юм. Үндсэн хууль нь тасралтгүй, хэлбэрэлтгүй хэрэгжих, нийгмийн хөгжлийн шаардлагаар өөрчлөлт оруулж байх учиртай.⁶ Гэхдээ Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа улс төрийн намууд юу хүссэнээ өөрчлөх дур зоргын ажил болгож болохгүй бөгөөд яаран хандах нь нийгмэд тогтворгүй, эмх замбараагүй, хямралт байдал үүсгэх аюултай⁷ нөхцөл байдал үүсгэдэг.

1992 оны Үндсэн хуулийн хавсралт хуульд “хуулиар” зохицуулахаар нэр заасан /44 хууль бий/ хуулийг 1993 онд баталсан байхаар заасан. 20 жилийн дараа Шүүхийн ерөнхий зөвлөлийн хуулийг баталсан /2012.04/ боловч 2021.01.05 нд багц хууль нэрээр 4 хуулийг 1 хууль болгож, Шүүхийн ерөнхий зөвлөлийн хуулийг нэгтгэсэн. Үндсэн хуулийн дагуу хууль тогтоомжийг 1996 онд дуусгана гэж заасан боловч биелэгдээгүй. 2019.11.04-ний өдрийн Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөх шилжилтийн журмын тухай хууль, мөн 2020 оны 02 дугаар тогтоолоор баталсан Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хуваарь цаг хугацааны хувьд хэрэгжиж, биелэхгүй байна.⁸ Өөрөөр хэлбэл, Үндсэн хууль батлах, түүнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг батлаад дагалдах хуулиуд нь цаг хугацаандаа батлагдахгүй бол зүгээр цаас болох, хэлбэр төдий болж хувирна.

Мөнхийн Үндсэн хууль гэж байхгүй. Бас мөнхөд өөрчилж болдоггүй Үндсэн хууль ч гэж байхгүй. Гэхдээ өөрчилж болохгүй зүйл гэж бас бий. Жишээ нь : Монгол Улсын бүрэн эрхт тусгаар улс, хүний эрхийн халдашгүй байдлыг өөрчилж болохгүй юм.⁹

Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах үйл ажиллагаа нь бусад хууль тогтоомжтой харьцуулахад нэлээд онцлог бөгөөд ард түмний оролцоо, улс төрийн намуудын зөвшилцөл, иргэний нийгмийн оролцоог шаарддаг бөгөөд Үндсэн хуулийн нийгэм, эдийн засаг, эрх зүйн хөгжлийг хангахад оршино.

Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт нь ердийн хуулийг хууль тогтоох байгууллага өөрчлөн засварлаж байдаг шиг энгийн, амар хялбар асуудал биш бөгөөд Үндсэн хуулийн эрх зүйн шинжлэх ухаанд бие даасан судлагдахуун болсон маргаан мэтгэлцээн дагуулсан ”том” асуудал юм. Асуудлын том нь Үндсэн хууль нийт үндэстний амин чухал эрх ашгийг хамгаалж байдаг оюун санааны их хүч учраас түүнийг өөрчлөх, нэмж завсарлах арга ажиллагааг төгс төгөлдөр зохицуулах нь бараг бололцоогүй шахам учраас ард түмний бүрэн эрхт байдалд байлгах, илүү дээр нэмэлт, өөрчлөлтийг ямагт түүний дотоод үзэл баримтлалд нийцүүлэн хийх ёстой гэсэн номлол өдгөө давамгайлж байна.¹⁰

Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахын тулд юу болохгүй байгааг цогцоор нь зөв оношилохоос эхлэх ёстой. Ийм оношилогоог судалгааны үндсэн дээр, иж бүрнээр хийсэн эсэхийг сайтар тунгаах хэрэгтэй. Юу болохгүй байгааг нарийн мэдэхгүйгээр юуг ч оновчтой өөрчилж чаддаггүй билээ.¹¹

⁶ Ж.Амарсанаа. “Үндсэн хуулийн хэрэгжилт ба цаг хугацааны хамаарал” Парламентын судалгаа шинжилгээ. Эрдэм шинжилгээний сэтгүүл. Тусгай дугаар I (2022) 33 дахь тал

⁷ Assessment of the performance of the 1992 Constitution of Mongolia. Ch.Enkhbaatar, Tom Ginsburg, D.Solongo, P.Amarjargal, Ts. Davaadulam, G. Zoljargal, M. Batchimeg O. Munkhsaikhan (2016) 189 p

⁸ Ж.Амарсанаа. “Үндсэн хуулийн хэрэгжилт ба цаг хугацааны хамаарал” Парламентын судалгаа шинжилгээ. Эрдэм шинжилгээний сэтгүүл. Тусгай дугаар I (2022) 33 дахь тал

⁹ Б.Чимид. Үндсэн хуулийн үзэл баримтлал Хянан тохиолдуулсан Ж.Амарсанаа (2017) 91 дэх тал

¹⁰ Н.Лүндэндорж. Монгол Улсын Үндсэн хууль шинжлэх ухааны тайлбар. Хянан тохиолдуулсан: Н.Жанцан (2022) 1018 дахь тал

¹¹ Н.Лүндэндорж. П.Амаржаргал. Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай зарим санал. Монголын төр, эрх зүй сэтгүүл (2011) № 4

Монголын бүх улс төрийн намуудын оролцоотой хийсэн Үндсэн хуулийг ганц хоёрхон нам өөрчилж байгаа буруу явдал юм. Гэтэл манайхан тавагтай шөл хөрж ч амжаагүй шахам байхад Үндсэн хуульд өөрчлөлт оруулах асуудал оруулаад, намууд анализ хийгээд, ард түмэн мэдээд, олонхи нь батлаад явчихдаг. Сүүлд нь үзэхэд гарын үсэг цуглуулаад батлуулчихсан байдаг. Иймэрхүү байдлаар Үндсэн хуулийг өөрчилнө гэдэг бол нэг ёсондоо улс төрийн хуйвалдаан юм шүү.¹²

Ард түмэнд Үндсэн хуульд ямар заалт тусгахыг шийдвэрлэхэд оролцох Үндсэн хуулийг хууль ёсны болгох үйл явц нь ардчиллын зарчмаар явагдаж, олон нийтийн оролцоог хангаж байхыг улс төрийн үгсийн санд “new constitutionalism” шинэ үндсэн хуульд ёс гэдэг нэр томъёо орж ирсэн нь үндсэн хуулийн ач холбогдлыг нотолж буй хэрэг юм.¹³

Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах журам нь бусад хуультай харьцуулахад онцлогтой. Үндсэн хууль нь урт удаан хугацаанд тогтвортой үйлчилж байвал нийгмийн тогтвортой хөгжлийг хангаж чадна. Энэ ч учраас Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах журмыг нэлээд түвэгтэй байдлаар өөрт нь зааж өгдөг.¹⁴

Үндсэн хуулийг батлах нь түүнд “амь оруулж буй” чухал асуудал. Хэдий чинээ “амь бөхтэй” Үндсэн хууль гарна төдий чинээ “урт насална”. Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах нь түүнд “засал хийж буй” явдал. Хэдий чинээ “сайн засал” авна, төдий чинээ “нас нь уртасна”. Үндсэн хуулийг “амьдруулахад түүний хэрэгжилтэд хяналт тавих асуудал нэн чухал. Үндсэн хууль гагцхүү хэрэгжиж байж л үндсэн хуульд ёс тогтдог. Үндсэн хуулийг батлах, нэмэлт өөрчлөлт оруулах нь нэг хэрэг, хамгийн гол нь түүнийг амьдруулах явдал. Үндсэн хууль батлагдсанаараа бус хэрэгжсэнээрээ жинхэнэ Үндсэн хууль болно.¹⁵

Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт гэдэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн бүлэг, зүйл, хэсэг, заалтад байхгүй шинэ томъёоллыг зохих бүлэгт оруулж байгаа зүйл, хэсэг, заалтыг Үндсэн хуулийн нэмэлт гэнэ.

Монгол Улсын Үндсэн хуулийн өөрчлөлт гэдэг нь Үндсэн хуулийн зохих бүлэг, зүйл, хэсэгт байгаа заалтын нэр томъёог тодруулах, найруулгыг сайжруулахаар оруулж байгаа заалтыг Үндсэн хуулийн өөрчлөлт юм. Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулиар нэмэлт, өөрчлөлтийг салгаж, ялгаатай гэж хуульчилжээ.

Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах гэсэн үг ярианы эргэн тойронд:

- Үндсэн хуулийг өөрчлөх
- Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах
- Үндсэн хуулийг хянан үзэх гэх ойлголт байна.

Өмнөх Үндсэн хуулийг халж (устгаж), шинийг боловсруулж гаргахыг Үндсэн хууль өөрчлөх гэнэ. Ийнхүү өөрчлөх нь нийгмийн хувьсгал гаргах буюу тэр хэмжээний

¹² Б.Чимид. Үндсэн хуулийн үзэл баримтлал. Хянан тохиолдуулсан Ж.Амарсанаа (2017) 92 дэх тал

¹³ Винлук Вахиу. Үндсэн хууль бүтээх практикийн гарын авлага. Орчуулсан. С.Энх-Амгалан. A practical guide to Constitution building an introduction (2011) 3 дахь тал

¹⁴ О.Очиржав. Парламентат ёс ба Үндсэн хууль. Шинэ толь (1999) № 28

¹⁵ Т.Сэнгэдорж. Дэлхийн улсуудын Үндсэн хуульд ёсны хөгжил, мөн чанар, онцлог. Шинэ толь (1999) № 28

шинэтгэл хийхтэй холбоотой үүсдэг зайлшгүй үйл явдал бөгөөд үр дагавар нь улсын мөн чанар бүхэлдээ өөрчлөгдөх үндэс болно.¹⁶

Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах гэдэг нь шинээр үг, үсэг, зүйл, хэсэг, заалт, нэмснийг нэмэлт, өөрчлөлт гэхээс илүүтэй Үндсэн хуулийг улам боловсронгуй болгох, сайжруулах, хөгжүүлэх зорилгоор бичвэрт оруулсан аливаа өөрчлөлтийг нийтлэгээр ойлгоно.¹⁷

Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөл гэж хууль санаачлагчаас Үндсэн хуулийн ач холбогдол, өндөр шаардлагыг хангахуйц мэргэжлийн түвшинд боловсруулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төслийн эх бичвэрийг ойлгоно.

Зарим тохиолдолд Үндсэн хуулийг бүтээх гэж бас тодорхойлдог. Доктор Нора Хедлинг тайлбарт Үндсэн хуулийг хэлэлцэх, зөвлөлдөх, боловсруулах, хэрэгжүүлэх, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулахаас үүссэн үйл явц.¹⁸

Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа Үндсэн хуулийн хэл, найруулга сүүлийн үед анхаарал татаж байна. Тухайлбал, Эр хүйсийн төлөөний үг /he, him гэм мэт/ ихэвчлэн хүн гэдэг утгаар, “Mankind- хүн төрөлхтөн”, “Founding father- үүсгэн байгуулагч эцэг” зэрэг үгсийг дурдаж болох юм.

Үндсэн хуулийн үндсэн бүтцийн номлол (basic structure doctrine of Constitution) гэх үзэл санаа нь Үндсэн хуульд тухайн үндсэн хуулийн суурь болон гол шинжийг агуулсан зарчмууд туссан гэх үзэл санаа юм. Үндсэн хуульд хэзээ ч өөрчилж үл болох гол зарчмууд байдаг үзэл санаа юм.¹⁹

Үндсэн хуулийн албан ёсны нэмэлт, өөрчлөлтөөс гадуурх өөрчлөлт гэж бас байж болно. Тухайлбал, Үндсэн хуулийн хяналтын тогтолцоо бүхий улс орнуудад Үндсэн хуульд тайлбар хийх замаар түүний зарим зохицуулалтын агуулга, утга үзэл баримтлалыг өөрчилж болдог. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журам нь хатуу, чанга байхын хэрээр Үндсэн хуульд тайлбар хийх замаар өөрчлөх явдал нэмэгдэж байна.²⁰

Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд итгэлцлийг бий болгоё.²¹ Үүнд:

1. Үндсэн хуульд өөрчлөлт оруулах төслийг нийтэд ил тод мэдээлж, олон түмний зүгээс бодол санаагаа илэрхийлэх бололцоо олгох,
2. Ерөнхийлөгч, Улсын Их Хурал санал нэгдсэн байх

¹⁶ Улсын Их Хурлын архив, Д-7, ХН-810. X 247 /Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн хувийн хэрэг. Боть 3. 2010.10.15-2010.12.23/

¹⁷ Н.Лүндэндорж. Монгол Улсын Үндсэн хууль шинжлэх ухааны тайлбар. Хянан тохиолдуулсан: Н.Жанцан (2022) 1018 дахь тал

¹⁸ Нора Хедлинг. Үндсэн хууль бүтээх практикийн гарын авлага: зарчим ба нийтлэг үндэслэл Орчуулсан. С.Энх-Амгалан. A practical guide to Constitution building: Principles and Crosscutting themes (2011) 57 дахь тал

¹⁹ Улсын Их Хурлын архив, Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журам түүний хэрэгжилт ба олон улсын жишиг. Парламент судалгааны эмхэтгэл. Боть 42 (2023) 167 дахь тал. 1960-1970 онд Энэтхэг Улсын Дээд шүүхээс Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлттэй холбоотой маргааныг хянан шийдвэрлэхдээ уг номлолыг анх томьёолсон гэж үздэг. 185 дахь тал

²⁰ Улсын Их Хурлын архив, Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журам түүний хэрэгжилт ба олон улсын жишиг. Парламент судалгааны эмхэтгэл. Боть 42 (2023) 167 дахь тал

²¹ Д.Ламжав. Монгол Улсын Үндсэн хуульд өөрчлөлт оруулах асуудалд. Шинэ толь (1999) № 25

3. Үндсэн хуулийн Цэцээс төслийг бүхэлд нь буюу тухайн заалтуудын талаар зөвшөөрөхгүй тухай санал ирүүлээгүй байх зөвхөн ийм нөхцөлд Үндсэн хуульд өөрчлөлт оруулахаар улс төрийн тохиролцоонд урьдчилан хүрэх.

Ингэхгүй бол Үндсэн хуульд өөрчлөлт оруулах асуудлыг зөвхөн УИХ-ын хүрээнд авч үзэх нь нийгэмд үл итгэх уур амьсгал бий болгодог нь болсон үйл явдлуудаас харагдлаа. Бусадтай тохиролцоонд хүрэхгүйгээр зөвхөн нэг субъект Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийг шийдвэрлэх нь тухайн субъектийн явцуу сонирхол өөрчлөлтөд тусгагдах осолтой. Иймээс дээр дурдсан тохиролцоонд хүрвэл улс төрийн хувьд итгэлцэл бий болж, асуудалд ажил хэрэгчээр хандах уур амьсгал бүрдэх үндэстэй гэж үзэж байна.

Төрийн эрх мэдлийн эх үндэс нь ард түмэн гэж хүлээн зөвшөөрсөн улс орны Үндсэн хууль ач холбогдолтой байдаг.²²

Орчин үеийн иргэний нийгэмд болон өнөөгийн ардчилсан үндсэн хуульд төрд парламентийн олонхийн зүгээс эрх мэдлээ хортойгоор ашиглах магадлал илэрхий юм.²³

Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт гэдэг бол санааны зоргоор ханддаг асуудал биш бөгөөд батлагдсан цагаас нь эхлээд шүүмжлээд эхэлсэн. Энэ байдал эдүгээ 26 дахь жилдээ орох гээд явж байна.²⁴

Төрийн жинхэнэ албан хаагчид, захиргааны ажилтан нарын Үндсэн хуультай харьцах нийтлэг хандлагыг эрс шинэчлэх цаг болсон. Хууль биелүүлэхээр суугаа тэд улс төрчдийг даган баясаж, хуулиа биелүүлэх бус, шүүмжлээд суудаг болсон.²⁵

Монгол Улсын Үндсэн хуулийг баталсаны дараа профессор Н.Лүндэндорж нэгэн эрдэм шинжилгээний хуралд Герман Улсын туршлагаар Үндсэн хуулийг шүүмжлээд байвал, Эрүүгийн хуульдаа нэмэлт, өөрчлөлт оруулаад Үндсэн хуулийн эсрэг хэвлэл мэдээллээр ийм сөрөг мэдээлэл явуулаад байвал 10 хүртэл жил хорих ийм зүйлийг манай зарим хүмүүс сануулж байсан. Энэ бол буруу хандлага юм. Энд Үндсэн хуулиа улам сайн болгохын тулд тал бүрээс нь шүүмжилж боловсронгуй болгох арга замыг ямагт хайж, энэ олсон үнэ цэнэтэй зүйлийг хамгаалж явах ёстой.²⁶ гэж хэл байв.

Үндсэн хуулийн заалтуудыг ягштал дагаж мөрдөн биелүүлэхийн тулд түүний заалт бүрийн цаана байх үзэл баримтлал, түүхэн нөхцөл байдлыг ухаж ойлгох нь Үндсэн хуулиа нэг мөр зөв хэрэглэх, эрх зүйн тогтвортой байдалд чухал үүрэгтэй юм.²⁷

Үндсэн хуульд ёсны нэг гол зарчим болох Үндсэн хуулийн тогтвортой байдлыг хамгаалах явдал нь Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журам болон Үндсэн хуулийн хяналтын механизмаар хэрэгждэг.²⁸

²² П.Амаржаргал. Парламентын бүрэн эрх: төлөвшил, хөгжлийн чиг хандлага (2016) 171 дэх тал

²³ Н.Лүндэндорж. Үндсэн хуульд төр ёсны хөгжил. Политологи сэтгүүл МУИС (2002) 60 дахь тал

²⁴ Д.Лүндээжанцан. “Үндсэн хуулийг боловсронгуй болгох хэрэгцээ шаардлага ба нэмэлт, өөрчлөлт” Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн асуудал: Монгол Улсын жишээ. Олон улсын бага хурал. Гадаад харилцааны яам (2018) 115 дахь тал

²⁵ Б.Чимид. “Ардчилсан Үндсэн хууль бол монголын ард түмний бүтээл мөн”. Ардчилсан Үндсэн хууль-20 эрдэм шинжилгээний хурал. Эмхэтгэсэн. П.Амаржаргал нар УИХТГ (2012) 33 дахь тал

²⁶ Ардчилсан Үндсэн хууль-20 эрдэм шинжилгээний хурал. Эмхэтгэсэн. П.Амаржаргал нар УИХТГ (2012) 64 дэх тал

²⁷ П.Амаржаргал. “Монгол Улсын Үндсэн хуулийн Хорьдугаар зүйл, Япон Улсын Үндсэн хуулийн Дөчин нэгдүгээр зүйлийг Үндсэн хуулийн эрх зүйн үүднээс харьцуулах нь”. Хууль дээдлэх ёс сэтгүүл (2012) № 2

²⁸ П.Амаржаргал. Үндсэн хуулийн эрх зүй: Парламентын онол үзэл баримтлалын асуудал (2015) 204 дэх тал

Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах нь ойр зуурын хэрэгцээ, шаардлагаар үүсдэг зүйл биш бөгөөд хүндтэй шалтгаан буй болсон нөхцөлд л хэрэгжүүлдэг, эмзэг нарийн ажил юм.²⁹ Тухайлбал, Үндсэн хуулийн цэг таслал, үг өгүүлбэр, бүлэг, зүйл, хэсэг, заалт, болгон нь зарчим бөгөөд Үндсэн хуульд гаргасан багахан хэмжээний алдаа нь тухайн орны засаглал, дэглэм, төрийн байгууламжийг өөрчилж, ардчиллаас дарангуйлалд унаж болохыг Наполеон, Ленин, Гитлерийн өөрчлөлтүүд харуулдаг.³⁰

Монгол Улсын Үндсэн хууль батлагдсан өдрөөс хойш (1992-2024) 32 жилийн хугацаанд Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг он дараалан авч үзвэл:

№	Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн нэр	Хууль санаачлагч	Өргөн мэдүүлсэн огноо
1	Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл	Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Үүл нарын 26 гишүүн	1999.12.23
2	Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл	Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг нарын 14 гишүүн	1999.12.23
3	Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөл	Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцан нарын 26 гишүүн	1999.12.23
4	Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл	Улсын Их Хурлын гишүүн П.Жасрай нарын 65 гишүүн	2000.11.30
5	Үндсэн хуульд өөрчлөлт оруулах тухай төсөл	Улсын Их Хурлын гишүүн Д.Энхбат	2011.05.10
6	Үндсэн хуульд өөрчлөлт оруулах тухай төсөл	Улсын Их Хурлын гишүүн Д.Энхбат нарын 15 гишүүн	2011.08.09
7	Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай төсөл	Улсын Их Хурлын гишүүн Д.Дамба-Очир нарын 5 гишүүн	2011.05.25
8	Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт оруулах тухай төсөл	Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар нарын 31 гишүүн	2011.12.23
9	Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай төсөл	Улсын Их Хурлын гишүүн Су.Батболд	2012.01.09
10	Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай төсөл	Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн нарын 4 гишүүн	2014.12.24
11	Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл	Улсын Их Хурлын гишүүн Н.Батбаяр нарын 48 гишүүн	2015.11.06
12	Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл	Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцан нарын 62 гишүүн	2019.06.06

²⁹ Н.Лүндэндорж. Монгол Улсын Үндсэн хууль шинжлэх ухааны тайлбар. Хянан тохиолдуулсан: Н.Жанцан (2022) 15 дахь тал
³⁰ Д.Лхагвасүрэн, Р.Ууганбаатар, М.Сайнбаяр, Д.Сүхболд, Д.Зоригтбаатар. Бүгд Найрамдах Монгол Ард Улс: Үндсэн хуулийн тайлбар философи. (2020) 365 дахь тал

13	Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл	Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга	2019.07.16
14	Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл	Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нарын 60 гишүүн	2022.08.25
15	Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл	Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ	2023.05.03

Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн түүх

Монгол Улсад 1924 оноос өмнө албан ёсоор батлагдсан Үндсэн хууль байгаагүй юм. Харин Анхдугаар Үндсэн хууль батлагдахын өмнө эрх зүйн баримт бичгүүд байсан. Монгол Улсын 1924³¹ оноос 1992 он хүртэл Үндсэн хуулиудад нэмэлт, өөрчлөлтийн тухай хуулийн зохицуулсан түүхийг товчлон авч үзлээ.

Социализмын үед Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмыг нарийвчлан тогтоож байгаагүй.³² Оросын Үндсэн хуулийг загвар болгож 1924 онд БНМАУ-ын Үндсэн хуулийг баталжээ. ЗХУ-д гарсан өөрчлөлтийн нөлөөгөөр 1940, 1960 оны Үндсэн хуулийг тус тус шинэчлэн баталжээ.³³

1924 оны Анхдугаар Үндсэн хуульд тусгайлан бүлэг байгаагүй бөгөөд Зургадугаар зүйлд “Улсын үндсэн хуулийг өөрчлөх батлах явдлыг гагцхүү Улсын Их Хурлаас эрхлэн шийтгэвэл зохино” гэжээ.³⁴ 1924 оны Үндсэн хуулийн тодорхой заалтыг зөрчиж өөрчлөлт оруулсан, Үндсэн хуулийн заалтууд өөр хоорондоо зөрчилтэй, мөн ердийн хуулиар Үндсэн хуулийн заалтыг зөрчиж буруу практик тогтоосон зэрэг зүйл Үндсэн хуулийн 20 гаруй зүйлд холбогдож буй.³⁵

1940 оны Үндсэн хуулийн Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Үндсэн хуулийг өөрчлөх журам гэсэн Арван хоёрдугаар бүлгийн 95 дугаар зүйлд “Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Үндсэн хуулийг өөрчлөх явдлыг Улсын Их Хурлаар гүйцэтгэх бөгөөд Их Хурлын тэргүүлэгчдийн гуравны хоёроос доош бус хувийн гар өргөж баталснаар өөрчилнө.” гэж заажээ.³⁶

³¹Захиргааны шинжлэх ухааны нэр томъёоны тайлбар толь. Конрад Аденауэр сан. Ерөнхий редактор П.Амаржаргал (2024) 266-272 дахь тал

³² Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ. Ч.Энхбаатар, Том Гинсбург, П.Амаржаргал, Д.Солонго, Ц.Даваадулам, Г.Золжаргал, О.Мөнхсайхан, М.Батчимэг (2016) 191 дэх тал

³³ О.Мөнхсайхан. Үндсэн хуулийн хяналт ба тайлбар: үндсэн эрх (2022) 55 дах тал

³⁴ Ж.Амарсанаа. О.Батсайхан. Монгол Улсын Үндсэн хууль: баримт бичиг (2004) 45 дах тал

³⁵ Б.Батбаяр. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн түүх ба үндсэн хуулийн зөрчил. Эрх зүй сэтгүүл (2019) № 45

³⁶ Ж.Амарсанаа. О.Батсайхан. Монгол Улсын Үндсэн хууль: баримт бичиг (2004) 158 дах тал

Үндсэн хууль батлагдсанаас хойш 1941, 1944, 1949, 1952, 1955, 1956, 1957, 1959 онуудад тус тус нэмэлт, өөрчлөлт орсон байдаг.³⁷

Түүнчлэн 1949 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт³⁸ нь шинэ Үндсэн хуулийн шинжтэй болсон. Энэ тухай 2017 онд Б.Баярсайхан доктор өгүүлсэн байдаг.³⁹

1960 оны Үндсэн хуулийн Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Үндсэн хуулийг өөрчлөх ба халах тухай гэсэн Аравдугаар бүлгийн 93 дугаар зүйлд “БНМАУ-ын Үндсэн хуулинд оруулах өөрчлөлтийг гагцхүү Ардын Их Хурлаар хэлэлцэж, түүний депутатуудын гуравны хоёроос доошгүй нь баталснаар оруулна.” Түүнчлэн 94 дүгээр зүйлд “Коммунизмын үед төрийн зарим үүрэг мөхөх тутам үүргийн тухай Үндсэн хуулинд бичигдсэн зүйлс хүчингүй болж байна. Социализм, коммунизм байгуулах гол зэвсэг болсон төр байх хэрэгцээгүй болж, түүний хөдөлмөрчдийн коммунист эвлэлээр сольсон цагт БНМАУ-ын Үндсэн хууль халагдана.” гэжээ.⁴⁰

1960 оны Үндсэн хуулиа 1963, 1966, 1969, 1970, 1971, 1972, 1973, 1978, 1980, 1981, 1983, 1989, 1990 онуудад тус тус нэмэлт, өөрчлөлт орсон.⁴¹

1924 оны Үндсэн хуульд дур зоргоор оруулсан өөрчлөлт, 1940, 1960 оны Үндсэн хуульд УБХ, УБХТ, УИХТ, АИХТ-ийн УИХ, АИХ-ын бүрэн эрхэд халдан, Үндсэн хуулиа зөрчиж Үндсэн хуульд зүй бусаар оруулсан өөрчлөлтүүдийн тухай дүгнэлтээр өгүүлсэн юм.⁴²

1990 онд баталсан Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Үндсэн хуулийн нэмэлтийн тухай хуулийн Хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсэгт БНМАУ-ын Үндсэн хууль батлах, түүнд нэмэлт өөрчлөлт оруулах онцгой эрхийг АИХ-д өгсөн.⁴³

1992 онд баталсан Монгол Улсын Үндсэн хуульд “Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах” гэсэн Зургадугаар бүлгийн Жаран наймдугаар зүйл⁴⁴, Жаран ес дүгээр зүйлд⁴⁵ тусгайлан зохицуулсан.⁴⁶ Гэвч энэхүү зургадугаар бүлэгт зөвхөн Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт процессын үйл ажиллагааг тусгаснаас, харин Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлал, үндсэн бүтэц, хөндөж үл болох тухай заагаагүй юм.

³⁷ Б.Батбаяр. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн түүх ба үндсэн хуулийн зөрчил. Эрх зүй сэтгүүл (2019) № 45

³⁸ Улаан од сонин. 1949.02.26. №47 (3294) Бүрэн хэвлэгдсэн.

³⁹ Б.Баярсайхан. Монгол Улсын Үндсэн хуульд ёсны уламжлал. БНМАУ-ын 1949 оны Үндсэн хуулийн эрх зүйн шинжилгээ. (2017)

⁴⁰ Ж.Амарсанаа. О.Батсайхан. Монгол Улсын Үндсэн хууль: баримт бичиг (2004) 246 дах тал

⁴¹ Б.Батбаяр. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн түүх ба үндсэн хуулийн зөрчил. Эрх зүй сэтгүүл (2019) № 45

⁴² Б.Батбаяр. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн түүх ба үндсэн хуулийн зөрчил. Эрх зүй сэтгүүл (2019) № 45

⁴³ Ж.Амарсанаа. О.Батсайхан. Монгол Улсын Үндсэн хууль: баримт бичиг (2004) 333 дах тал

⁴⁴ **Жаран наймдугаар зүйл**

1. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санаачилгыг хууль санаачлах эрх бүхий байгууллага, албан тушаалтан гаргах бөгөөд саналыг Үндсэн хуулийн цэц Улсын Их Хуралд өргөн мэдүүлж болно.

2. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар Улсын Их Хурлын гишүүдийн гуравны хоёроос доошгүйн саналаар ард нийтийн санал асуулга явуулж болно. Санал асуулгыг Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 16-д заасан үндэслэлийн дагуу явуулна. Төрийн мэдээлэл эмхэтгэл 1992 № 1

⁴⁵ **Жаран есдүгээр зүйл**

1. Үндсэн хууль, түүнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний гурваас доошгүйн саналаар батална.

2. Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийг Улсын Их Хуралд хоёр удаа авч хэлэлцэхэд ийнхүү нийт гишүүний дөрөвний гурваас доошгүйн санал авч эс чадвал уул төслийг ээлжит сонгуулиар сонгогдсон Улсын Их Хурлын шинэ бүрэлдэхүүн ажлаа эхэлтэл дахин авч хэлэлцэхгүй.

3. Улсын Их Хурал ээлжит сонгууль явуулахын өмнөх зургаан сарын дотор Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж үл болно.

4. Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт Үндсэн хуулийн нэгэн адил хүчинтэй байна. Төрийн мэдээлэл эмхэтгэл 1992 № 1

⁴⁶ Төрийн мэдээлэл эмхэтгэл 1992 № 1

1992 оноос хойш Улсын Их Хуралд хууль санаачлагаас Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 15 төсөл өргөн мэдүүлэгдэж, Монгол Улсын Үндсэн хуульд 1999, 2000, 2019, 2022, 2023 онуудад нийт 5 удаа нэмэлт, өөрчлөлт оржээ.

Түүнчлэн Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахад Монгол Улсын Үндсэн хууль⁴⁷ (1992), Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хууль⁴⁸ (2011), Ард нийтийн санал асуулгын тухай хууль⁴⁹ (2016), Зөвлөлдөх санал асуулгын тухай хууль⁵⁰ (2017) болон Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль⁵¹ (2020) зэрэг эдгээр гол таван хуулиар зохицуулж байна.

⁴⁷ Төрийн мэдээлэл эмхэтгэл 1992 № 1

⁴⁸ Төрийн мэдээлэл эмхэтгэл 2011 № 3

⁴⁹ Төрийн мэдээлэл эмхэтгэл 2016 № 09

⁵⁰ Төрийн мэдээлэл эмхэтгэл 2017 № 09

⁵¹ Төрийн мэдээлэл эмхэтгэл 2020 № 22

Дүгнэлт

Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах нь анхнаасаа Үндсэн хуулиа хөгжүүлэх, ард иргэдийнхээ төлөө юм уу, эсхүл улс төрчдийн эрх мэдлийг өргөжүүлэх, бататгах юм уу? гэсэн асуулт урган гарна.

Орчин үед иргэд өөрсдийгөө эрх мэдлийн тулгуур эх сурвалж гэдгийг ойлгож, Үндсэн хууль болон түүний нэмэлт, өөрчлөлт нь иргэдийн эрх, эрх чөлөөний төлөө, тэдний оролцоотойгоор, төрийн эрх мэдлийг хязгаарлахад чиглэгдэж, хүлээн зөвшөөрөгдөх ёстой.

Үндсэн хууль бол хэзээ ч өөрчилөгдөшгүй улс төр, эрх зүйн баримт бичиг биш юм. Харин хууль ёсны, хүлээн зөвшөөрөгдсөн, иргэдийн оролцоог хангасан, нийгмийн төлөөллийг бүрдүүлсэн, төрийн эрх мэдлийн тэнцвэрийг тодорхой болгох, хязгаарлаж байх юм.

Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт нь түүхэн хөгжлийн үе шатаар туулан, тулгамдсан асуудлыг шийдвэрлэхийг зорин, боловсронгуй болон хөгжиж байна. Гэхдээ өмнө өгүүлсэнчлэн тодорхой асуудал, Тухайлбал иргэдийн оролцоог бүрэн хангаагүй, иргэд зөвлөлдөх санал асуулгаар өгсөн санал нь гээгдсэн г.м

Түүнчлэн Ард нийтийн санал асуулга явуулаад санал асуулгын дүнг Улсын Их Хурал дахин хянах нь хэр оновчтой эсэхийг анхаарах шаардлагатай.

Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг Үндсэн хуулиасаа давсан органик, ердийн хуулиараа зохицуулах нь хэр оновчтой эсэх, Үндсэн хуульдаа тусгасан нь зөв гэж үзэж байна.

Эцэст нь хэлэхэд Монгол Улс Үндсэн хуультай байх нэг өөр, түүндээ нэмэлт, өөрчлөлт оруулах нь дахин нэг өөр асуудал болжээ.

SPSIRPA FORUM 2024

Session 9-2

Some challenges on executive governance: Case of Mongolian Government



Some perspectives on Executive governance: case of Government of Mongolia

Author: Mrs. Amartugs Tsenddavaa
Permanent member,
The Civil service council of Mongolia,
#310, Government building 11, Sambuu street, Chingiltei
district, Ulaanbaatar 15141, Mongolia.
amartugs@csc.gov.mn

Abstract

Do we need to downsize the government? Or need to increase the size of the government for the stimulation of economic growth? Is there any correlation between government size and economic growth? Is it possible to find the optimal size of government during which economic growth reaches its maximum rate? Which indicator should we use for analyzing government size? Seeking the answers to these kinds of questions here the study exposes data series and conducted analysis.

Using regression methods and the Armev curve which explains ‘intervened U’ relationship between public spending and economic growth, it attempts to review the empirical evidence on the optimal level of spending of the Government of Mongolia required to maximize gross domestic product (GDP). In recent 28 years, Mongolia has had an economic growth of an annual average of 5.7 percent with yearly fluctuations. Even though the economy of Mongolia retains effective positive impacts, share of public expenditures in GDP has been increasing continuously. Further it assesses empirical evidence of Mongolia using the Army curve analysis method.

On the other hand, it explains facts that how the government structures had been changed over the times since 1992. And it tries to explore how the interlinks of development policy goals in a government structures. In sum, it attempts to describe effective government structure to take into account those discussed above.

Keywords: *size of government, public expenditure, Armev curve, economic growth*

Гүйцэтгэх засаглалын тогтолцооны зарим асуудлууд: Монгол Улсын Засгийн газрын жишээгээр

Илтгэгч:

Ц.Амартөгс

Төрийн албаны зөвлөлийн гишүүн

Абстракт

Бид Засгийн газарт цомхотгол хийх үү? Эсвэл эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх зорилгоор хүрээ, хэмжээг нь ихэсгэх шаардлагатай юу? Засгийн газрын үйл ажиллагааны хүрээ болон эдийн засгийн өсөлтийн харилцан хамаарал нь юу вэ? Эдийн засгийн өсөлтийг хамгийн дээд хэмжээнд нэмэгдүүлэх зохистой хэмжээ, төвшин гэж байж болох уу? Засгийн газрын зохистой хэмжээг илэрхийлэх ямар үзүүлэлтүүд байж болох вэ? Эдгээр асуултад хариулах зорилгоор өгөгдлийн дүн шинжилгээ болон баримтын судалгаа хийлээ.

Регрессийн аргыг ашиглан “Армей муруй”-н шинжилгээ хийсэн бөгөөд энэ нь сөрөг ‘U’ хамаарлыг төсвийн зарлага болон эдийн засгийн өсөлт гэсэн үзүүлэлтээр тооцоолж тайлбарлав. Түүнчлэн Монгол Улсын ДНБ-ын хэмжээг нэмэгдүүлэхэд зохистой хэмжээнд тодорхойлогдсон засгийн газрын хэмжээ ямар байх вэ гэдгийг өгөгдөл ашиглан тооцоолж үзлээ. Сүүлийн 28 жилийн дунджаас харахад Монгол Улсын эдийн засгийн өсөлтөд зарим хэлбэлзэл байгаа хэдий ч жилийн дундаж өсөлт нь 5.7 хувь байжээ. Хэдийгээр эдийн засгийн эерэг үзүүлэлтүүд ажиглагдаж байгаа боловч ДНБ-д эзлэх төсвийн зарлагын хувь тасралтгүй өссөн байна. Эдгээр өгөгдлүүдийг ашиглан Армей муруйн шинжилгээг хийж үзлээ.


Түүнчлэн 1992 оноос хойш, засгийн газар бүтцийн хувьд хэрхэн өөрчлөгдөж ирснийг баримтын судалгаагаар гаргаж ирсэн. Үүний зэрэгцээ хөгжлийн бодлогын зорилгууд нь засгийн газрын бүтцэд хэрхэн тусгагдаж байсныг уялдуулан судлах оролдлого хийлээ. Ингэснээр Засгийн газрын бүтцийг тодорхойлохдоо төсвийн зарлагын ДНБ-д эзлэх хувь хэмжээ, эрх зүйн тогтолцооны өөрчлөлт болон бодлогын зорилгын уялдааг хангах нь зүйтэй гэж дүгнэлээ.

Түлхүүр үг: засгийн газрын хэмжээ, төсвийн зарлага, Армей муруй, эдийн засгийн өсөлт

SPSIRPA FORUM 2024

Session 9-3

The consideration time challenges on activities of police human resources management



ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН УДИРДЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ЦАГ ҮЕИЙН СОРИЛТЫГ ХАРГАЛЗАН ҮЗЭХ НЬ

А.ГАНТУУЛ¹

Хураангуй: Монгол Улсын төрийн албаны хөгжлийн үйл явц өнгөрсөн 30 гаруй жилийн хугацаанд олон сорилттой тулгарсан хэдий ч төрийн албаны үр нөлөөг дээшлүүлэх, тогтвортой, мэргэшсэн алба хаагчдаар төрийн албыг бэхжүүлэх үзэл санаанд тулгуурласан шинэтгэлийн бодлогыг тууштай хэрэгжүүлж ирсэн.

Гэвч улс төрийн сонгуулийн үр дүнг дагасан удирдлагын гэнэтийн халаа, сэлгээ, үүнээс үүдсэн үйл ажиллагааны бодлого, чиглэл өөрчлөгдөх байдал өдгөө ч үргэлжилсээр байгаа нь төрийн албанд тогтворгүй байдлыг дагуулж байна. Нөгөөтэйгүүр улс орнуудын хооронд өрнөж буй цэрэг-батлан хамгаалах, аюулгүй байдлын орчин дахь хямралт байдал дэлхийн бүхий л улс орнуудын улс төр, эдийн засаг, нийгмийн амьдралд нөлөөлж, урьд өмнө байгаагүй шинэ нөхцөл байдал, сорилтыг бий болгож байна.

Төрийн албанд үүссэн тодорхойгүй, олон сорилтыг дагуулсан динамик байдал нь цагдаагийн байгууллагын хүний нөөцийн удирдлагын үйл ажиллагаанд нөлөөлөх хүчин зүйл болж байгаа эсэхийг нээн илрүүлэхэд энэхүү илтгэлийн гол агуулга чиглэгдэнэ.

Түлхүүр үгс: Төрийн алба, цагдаагийн байгууллага, төрийн албан хаагч, хүний нөөцийн удирдлага, мэргэшсэн, тогтвортой байх зарчим, тогтворгүй байдал, тодорхойгүй байдал, төвөгтэй байдал, эргэлзээтэй байдал, шилжилт /сорилт/-ийн үе, уян хатан байдал.

THE CONSIDERATION TIME CHALLENGES ON ACTIVITIES OF POLICE HUMAN RESOURCES MANAGEMENT

Abstract: In Mongolia, public service development has encountered various obstacles in the last three decades. Despite this, the public service has consistently put into action reform policies that focus on enhancing the efficiency of the public service and bolstering it with reliable and skilled civil servants.

However, due to the negative consequences of the political elections, the sudden resignations and replacements of decision-makers, cause repeated changes in the policy and principle of operations, keep bringing instability to the public service. On top of that, the crisis in the military and defense sector and security environment amidst the countries affects the political, economic and social condition of the world countries, creates new situations and challenges that has not been seen before.

¹Дотоод хэргийн их сургуулийн Удирдлагын Академи., Удирдахуйн ухаан, аюулгүй байдлын удирдлага, стратегийн тэнхим

The main focus of this article is to find out whether the uncertainty and new situation in the public service is associated with the above challenges. Are those factors indeed affecting the management level human resources of the police organization?

Keywords: Public service, police organization, civil servant, human resource management, expertise, stability, volatility, uncertainty, complexity, ambiguity /VUCA/, in challenging times, resilience.

Удиртгал

Монгол Улсад 1990-ээд оноос өрнөсөн нийгмийн шилжилтийн үр дүнд манай улс эрх зүйт, хүмүүнлэг ардчилсан нийгмийн хэлбэрийг сонгож, өнөөгийн төрийн байгууллын тогтолцоо, чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалтын үндсийг тавьсан.

Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1.2 дахь хэсэгт “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэгт “Монгол Улс төрийн байгууламжийн хувьд нэгдмэл байна” хэмээн зааж, 3 дугаар бүлэгт Монгол Улсын төрийн байгууллын тогтолцоо, чиг үүрэг, зохион байгуулалтыг тодорхойлсон байдаг.

Монгол Улсын төрийн албан хаагчдын тоо хэмжээ, бүрэлдэхүүн, бүтэц-тогтолцоо харьцангуй тогтвортой шинжийг өнгөрсөн 30-аад жилийн хугацаанд хадгалж, төрийн албаны хүний нөөцийн удирдлагын тогтолцоо, албаны чадавхи, үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх, улс төрөөс ангид мэргэшсэн, тогтвортой төрийн албыг төлөвшүүлэхэд чиглэсэн үе шатыг дамжиж ирсэн.

Гэсэн хэдий ч улс төр, нийгэм, эдийн засгийн харилцаан дахь олон үйл явдал, хямралын давтамжтай байдал, улс төрийн нөлөөлөл, удирдлагын гэнэтийн болон ойр ойрхон хийгддэг халаа, сэлгээ, үүнээс үүдэлтэй төрийн бодлого, түүний залгамж чанар алдагдах байдал өнөө хүртэл төрийн албанд үргэлжилсээр байна. Энэ төрийн албанд хувьсамтгай /volatility/ хийгээд тодорхойгүй байдал /uncertainty/-ыг бий болгож байна. Түүнчлэн улс орнуудын хооронд өрнөж буй цэрэг-батлан хамгаалах, аюулгүй байдлын орчин дахь хямралт байдал дэлхийн бүхий л улс орнуудын улс төр, эдийн засаг, нийгмийн амьдралд нөлөөлж, хувьсамтгай, тодорхойгүй нөхцөл байдлыг улам бүр нэмэгдүүлэх боллоо.

Нөгөөтэйгүүр төрийн албан хаагчид бодлого боловсруулах, хэрэгжүүлэхдээ өөр хоорондоо ашиг сонирхол, нийгмийн болон үе /generation/ хоорондын зөрүүтэй байдал, үнэт зүйл, зарчим, хэв маягаараа ялгаатай олон талуудтай хамтарч ажилладаг бөгөөд техник технологийн эрин зуунд инновацид суурилсан хурдтай, бүтээлч шинэ шийдлийг төрийн албанд нэвтрүүлэх хэрэгцээ бий болж байна. Энэ нь төрийн алба улам бүр салбар хоорондын хамтын ажиллагааны болоод үе хоорондын ялгаа бүхий хэв шинжтэй болж улмаар төвөгтэй байдал /complexity/-ыг бий болгож байна.

Үүний зэрэгцээ бодлого тодорхойлж, шийдвэр гаргагчид болон төрийн үйлчилгээг авч буй иргэдийн хэрэгцээ шаардлага бүгд өөр хоорондоо ялгаатай байдлыг бий болгож, үйл ажиллагаандаа нэвтрүүлж буй техник, технологийн дэвшил, инноваци шинэ туршилтууд, тэдгээрийн үр дүн төрийн албан хаагчдад эргэлзээтэй байдал /ambiguity/-ыг ч үүсгэх болсон².

Эдгээр хүчин зүйлс нь төрийн албанд “VUCA” орчныг бий болгон, төрийн албанд олон тулгамдсан асуудлыг үүсгэж, нийгэмд хүлээлт бий болгож байгаа нь сэдвийн хүрээнд асуудлыг сонгон судлах үндэслэл болж байна.

² А.Гантуул. Төрийн тусгай байгууллагуудын алба хаагчийн нийгмийн баталгаа, тулгамдаж буй асуудал. “Төрийн тусгай байгууллагын удирдлага, тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам” ЭШХ-ын эмхэтгэл. ДХИС-ийн УА., 2022 он. 45-46 дахь тал

Төрийн алба мэргэшсэн, тогтвортой, залгамж чанартай байж, төрийн албан хаагчийн хууль зүй, эдийн засгийн болон бусад баталгаа найдвартай хангагддаг байх нь Монгол Улсын хөгжил, үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журмыг сахиулах³ төрийн тусгай албаны үндсэн чиг үүрэгт чухал нөлөө үзүүлдэг.

Иймд хувьсамтгай, тогтворгүй, төвөгтэй, эргэлзээтэй нөхцөл бүхий сорилт /шилжилт/-ын үед төрийн тусгай албаны хүний нөөцийн үйл ажиллагааг онол, арга зүйгээр хангах, цагдаагийн байгууллагын хүний нөөцийн үйл ажиллагаанд нөлөөлөх хүчин зүйлсийг тодорхойлох нь төрийн албаны тасралтгүй, шуурхай, хүртээмжтэй байх нөхцөлийг бүрдүүлнэ.

Энэхүү илтгэлд анхдагч болон хоёрдогч өгөгдлийн эх сурвалжийг ашигласан бөгөөд цагдаагийн байгууллагаас ДХИС-д суралцаж байгаа алба хаагч, хууль сахиулах, аюулгүй байдлыг хангах төрийн тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын хүний нөөцийн мэргэжилтнүүдтэй хийсэн ярилцлага зэрэг нь судалгааны анхдагч эх сурвалж болсон. Цагдаагийн байгууллагаас хийсэн судалгаа, цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд хөндлөнгийн байгууллагуудаас хийсэн судалгаа, бусад судлаач нарын эрдэм шинжилгээ, судалгааны бүтээл, хууль, эрх зүйн баримт бичиг, мэргэжлийн байгууллагуудын тайлан, статистик мэдээлэл хоёрдогч эх сурвалж болгосон. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа, албаны онцлогтой байдлыг харгалзан зарим статистик мэдээллийг хязгаарлалттай ашигласан болно.

**Цагдаагийн байгууллагын хүний нөөцийн үйл ажиллагаанд нөлөөлж буй
хүчин зүйлс,
өнөөгийн байдал**


Олон улсын түвшинд үүссэн тогтворгүй байдал улс орнуудын нийгэм, эдийн засгийн байдалд сөрөг нөлөө үзүүлж байна. Энэхүү нөлөөллөөс манай улс ч ангид орших боломжгүй бөгөөд өнөөдөр Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдал сайнгүй байгааг судлаачдын төдийгүй мэргэжлийн байгууллагын статистик, тайлангаас харж болно. Тухайлбал: Үндэсний статистикийн хороо, Дэлхийн банктай хамтран хийсэн судалгааны тайланд Монгол Улсын хэмжээнд ядуурлын түвшин 27.1 хувь буюу 914.2 мянган хүн ядуурлын түвшнөөс доогуур хэрэглээтэй амьдарч байна. Тэдний 57 хувь нь хот, сууринд, 43 хувь нь хөдөөд амьдарч байгааг дурьджээ.⁴

Зураг 1. Монгол Улсын хүн амын ядуурлын шугам /2022 оны байдлаар/⁵

³ Төрийн албаны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1 дэх хэсэг "...үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журмыг сахиулах..."

⁴ Үндэсний статистикийн хороо, Дэлхийн банктай хамтарсан "Ядуурлын түвшин-2022" судалгааны тайлан

⁵ Үндэсний статистикийн хороо. /access 2024.04.22/ https://www.1212.mn/mn/statistic/statcate/573066/table-view/DT_NSO_1900_010V1



Аливаа улсын эдийн засгийн доройтож, ажилгүйдлийн түвшин нэмэгдэх хирээр гэмт хэргийн гаралт нэмэгддэг зүй тогтолтой бөгөөд дээрх статистик мэдээллээс үзэхэд Монгол Улсын хүн амын гурван хүн тутмын нэг нь ядуу амьдарч байна.

Цагдаагийн байгууллагаас гаргасан гэмт хэрэг, зөрчлийн статистикийг үзэхэд 2023 онд иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас нийт 668.829⁶ дуудлага, мэдээлэл хүлээн авч шалгаж шийдвэрлэжээ. Дээрх бүртгэгдэж, шийдвэрлэгдсэн гэмт хэрэг, зөрчлийг 2022 оны статистиктай харьцуулан үзэхэд улсын хэмжээнд 234 буюу гэмт хэрэг, зөрчил 0.7 хувиар⁷ нэмэгджээ.

Түүнчлэн төрийн албан хаагчдын цалин хөлс өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнийн өсөлтийг гүйцэхгүй болж, цар тахлаас үүсэлтэй эдийн засаг, нийгмийн тогтворгүй байдал өнөөг хүртэл үргэлжилж, хүн амын амьжиргааны түвшин буурч, гэмт хэргийн гаралт нэмэгдэж байгаа нь хууль сахиулах, аюулгүй байдлыг хангах салбарын алба хаагчдын ажлын ачаалалд шууд нөлөө үзүүлж байна. Үүнээс үүдэлтэйгээр төрийн тусгай байгууллагуудын тэр дундаа цагдаагийн алба хаагчдын дунд ажлаас шантрах, эрхэлж буй ажилдаа сэтгэл ханамжгүй болох, улмаар албанаас чөлөөлөгдөх зэрэг үзэгдэл даамжирч, салбар, байгууллагуудын үйл ажиллагааны тасралтгүй, шуурхай байдалд ч нөлөөлөхүйц хэмжээнд хүрч байна.⁸

Улмаар Монгол Улсын Засгийн газраас цагдаа, дотоодын цэргийн алба хаагчдын эдийн засаг, нийгмийн баталгааг хангахад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлж, сарын цалинг 500-800 мянган төгрөгөөр нэмэгдүүлэх шийдвэр⁹ гарган, Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах¹⁰ замаар алба хаагчдын нийгмийн баталгааг сайжруулах зарим асуудлыг шийдвэрлэсэн байдаг.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 2023 оны байдлаар нийт 1064 алба хаагч чөлөөлөгдөж 2022 онтой харьцуулахад 604 буюу 36.2 хувиар, 1318 алба хаагч томилогдсон нь 2022 онтой харьцуулахад 39 буюу 2.8 хувиар буурсан байна. Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын хүний нөөцийн шилжилт хөдөлгөөнийг сүүлийн таван

⁶ Цагдаагийн ерөнхий газар. /access 2024.01.08/ “Цагдаагийн байгууллагад 2023 онд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн мэдээ”

⁷Цагдаагийн ерөнхий газар. /access 2024.01.08/ “Цагдаагийн байгууллагад 2023 онд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн мэдээ”

⁸ ХЗДХ-ийн Сайд-ын илтгэл. УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаан, Төрийн байгуулалтын байнгын хорооны хурал. Төрийн ордон., /2022.10.27/

⁹ Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 452 дугаар тогтоол

¹⁰ Монгол Улсын Их Хурал. /2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн нэмэлт өөрчлөлт/ Цагдаагийн албаны тухай хуулийн 86 дугаар зүйл.

жилийн дундажаар авч үзэхэд 6807 алба хаагч томилогдож, 5344 алба хаагч албанаас чөлөөлөгджээ.¹¹ Судалгааны дүнгээс харахад хүний нөөцийн шилжилт хөдөлгөөн их байгаа дүр зураг ажиглагдаж байна. Үүнийг нарийвчлан сүүлийн гурван жилээр цагдаагийн байгууллагын хүний нөөцийн тогтвор суурьшлыг тоон статистик болон хүний нөөцийн шилжилт хөдөлгөөний коэффициентоор тооцож үзэхэд:

Хүснэгт 1. Цагдаагийн байгууллагын хүний нөөцийн хөдөлгөөн¹²

Хүний нөөцийн хөдөлгөөний үзүүлэлт	Хугацаа		
	2021 он /11 сарын байдлаар/	2022 он /11 сарын байдлаар/	2023 он /11 сарын байдлаар/
Одоо ажиллаж байгаа бүрэлдэхүүний тоо	xxx	xxx	xxx
Албанд томилогдсон	1270	1357	1318
Албанаас халагдаж, чөлөөлөгдсөн	1078	1270	1064
Цагдаагийн байгууллагын хүний нөөцийн тогтвор суурьшлын коэффициент			
Зайлшгүй эргэлтийн коэффициент	0.043	0.045	0.034
Тогтворгүй байдлын коэффициент	0.056	0.070	0.056
Хүний нөөцийн гаралт коэффициент	0.100	0.115	0.090
Хүний нөөцийн оролт коэффициент	0.117	0.123	0.112
Тогтвор суурьшлын коэффициент	0.911	0.897	0.919

Дээрх судалгаанаас үзэхэд цагдаагийн байгууллагын хүний нөөцийн шилжилт хөдөлгөөн тогтворгүй, 2021 онд 1078 алба хаагч албанаас чөлөөлөгдсөн нь нийт бүрэлдэхүүний 9.9 хувь, 2022 онд 11.5 хувь, 2023 онд 9.0 хувийг тус тус бүрдүүлж байна.

Түүнчлэн 2012 оноос хойш цагдаагийн байгууллагын удирдлагын түвшинд зургаан удаагийн халаа сэлгээ хийгджээ. Энэ нь нэг даргын бүрэн эрхийн хугацаа ойролцоогоор хоёр жил орчим байх бөгөөд цагдаагийн байгууллагын удирдлагын томилгоо улс төрийн сонгуулийн үр дүнгээс хамааралтай байгааг харуулж байна.

Аливаа байгууллагын дарга хамт олноо нэг зорилго дор нэгтгэн удирдаж, манлайлан амжилт бүтээл гаргахад тодорхой хугацаа зайлшгүй шаардлагатай. Гэвч төрийн байгууллага тэр дундаа хууль сахиулах салбарын шийдвэр гаргах түвшиний даргын бүрэн эрхийн хугацаа дундажаар хоёр жил байгаа нь төрөөс цагдаагийн байгууллагын талаар баримтлах бодлого, чиглэл, үйл ажиллагааны бүтээмжид нөлөөлөхөөс гадна

¹¹Дотоод хэргийн их сургууль. “Цагдаагийн алба хаагчийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж буй хучин зүйлийг тодорхойлох судалгаа”, 2023 он

¹²Цагдаагийн ерөнхий газар. “Хүний нөөцийн оролт, гаралтын судалгаа”, 2023 он

нийгмийн харилцаа, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд ч сөргөөр нөлөөлөх талтай.

Удирдахуйн шинжлэх ухаанд байгууллагын хүний нөөцийн шилжилт хөдөлгөөн 3-5 хувь байх нь хэвийн үзэгдэл гэж үздэг бөгөөд байгууллагын хүний нөөцийн энэхүү шилжилт хөдөлгөөн нь алба хаагчдын ажлын идэвхийг нэмэгдүүлж, үйл ажиллагааны үр дүнд сайнаар нөлөөлдөг гэсэн судалгааны дүгнэлт ч бий. Дээр дурьдсан цагдаагийн байгууллагын сүүлийн гурван жилийн статистик мэдээнээс харахад “хэвийн” байх хувь хэмжээнээс хүний нөөцийн шилжилт хөдөлгөөн 2-3 дахин их байгаа нь анхаарал татсан асуудал болж, цагдаагийн байгууллагын алба хаагч тогтвор суурьшилтай ажиллах зарчим алдагдсан байна гэсэн дүгнэлтийг хийхэд хүргэж байна.

Цагдаагийн байгууллагаас сүүлийн жилүүдэд хүний нөөцийн удирдлагын үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн олон суурь судалгаануудыг хийж байна. Тухайлбал: 2022 онд “Цагдаа, дотоодын цэргийн алба хаагчдын нийгмийн байдал, эрхэлж буй ажилтай холбоотой сэтгэл ханамжийн судалгаа”-г хийжээ.

Судалгаанд цагдаа, дотоодын цэргийн 60 анги, байгууллага, нэгжийн 7295 алба хаагч буюу нийт бие бүрэлдэхүүний 60 гаруй хувь нь хамрагджээ. Судалгаанд хамрагдсан бүрэлдэхүүний 90 гаруй хувь нь 18-39 насны залуучууд, 14.6 хувь нь ахлах, 31.9 хувь нь дунд офицер, 53.5 хувь нь ахлагч бүрэлдэхүүн байна. Энэхүү суурь судалгааг “SPSS-26” программыг ашиглан боловсруулалт хийж, нэгтгэн дүгнэжээ. Судалгааны тайлангаас түүвэрлэн үзэхэд:

Алба хаагчдаас одоо эрхэлж буй ажилдаа сэтгэл ханамж ямар түвшинд байгааг тодруулах хаалттай асуултад 63.2 хувь буюу 4548 нь сэтгэл ханамжтай, 36.8 хувь буюу 2646 нь дунджаас доош буюу сэтгэл ханамжгүй гэсэн хариултыг өгчээ.

Хүснэгт 2. Алба хаагчдын эрхэлж буй ажлын сэтгэл ханамж

Д/Д	Өгөгдөл	Нийт тоо хувь	ЦЕГ-ын харьяа	Дотоодын цэрэг	Нийслэл, дүүргүүд	Орон нутаг	Ахлах офицер	Дунд офицер	Ахлагч бүрэлдэхүүн
1	Огт ханамжгүй	145	56	11	53	25	16	51	75
		2%	1%	0.2%	0.7%	0.3%	0.2%	0.7%	1%
2	Ханамжгүй	412	140	21	153	98	45	137	222
		5.7%	1.9%	0.3%	2.1%	1.4%	0.6%	1.9%	3.1%
3	Дунд зэрэг	2089	574	134	844	537	203	820	1030
		29%	8%	2%	11.7%	8%	3%	11.6%	14.6%
4	Ханамжтай	3814	975	701	933	1205	663	1114	1963
		53%	14%	9.7%	13.0%	17%	9.4%	15.8%	27.8%
5	Маш ханамжтай	734	210	74	84	366	129	175	416
		10.2 %	2.9%	1%	1%	5.1%	1.8%	2.5%	6%
	Нийт	7195	1955	941	2067	2231	1056	2297	3706
		100%	27.2%	13.1%	28.7%	31%	15%	32.5%	52.5%

Сэтгэл ханамжгүй байхад нөлөөлж буй хүчин зүйлсийг тодруулах асуултад алба хаагчдын хариулсан байдлыг авч үзэхэд 47.8 хувь буюу 2813 хувь цалин хөлс бага, 11.7 хувь буюу 687 нь өөрийгөө хөгжүүлэх боломж хязгаарлагдмал, 10.7 хувь буюу 632 алба хаагч ажлын ачаалал маш их, 7.3 хувь буюу 428 алба хаагч ажлын нөхцөл хүнд, 372 алба хаагч буюу 6 хувь нь удирдлагын зүгээс алба хаагчдын нийгмийн асуудлыг анхаардаггүй, удирдлагын арга барил, манлайлал хангалтгүй гэж 10.4 хувь буюу 606 алба хаагч хариулсан байна. Түүнчлэн “бусад” гэсэн нээлттэй асуултад цагдаа улс төрийн хэт хамааралтай болсон, шударга бус томилгоо, шагнал урамшуулал эзнээ олдоггүй, албаны бахархал, омогшил байхгүй болсон гэжээ.

Хүснэгт 3. Ажлын сэтгэл ханамжид нөлөөлөх хүчин зүйлс

Д/Д	Өгөгдөл	Нийт сонгосон	ЦЕГ-ын харьяа	Дотоодын цэрэг	Нийслэл, дүүрэг	Орон нутаг	Ахлах офицерын амьдрал	Дунд офицерын амьдрал	Ахлагч бүрэлдэхүүн
1	Ажлын нөхцөл хүнд	428	74	25	219	110	63	154	206
		7.3%	1.3%	0.4%	3.7%	1.9%	1.1%	2.6%	3.5%
2	Цалин хөлс бага	2813	700	263	1207	713	282	1018	1491
		47.8%	11.9%	4.5%	20.5%	12.1%	4.8%	17.5%	25.6%
3	Ачаалал их	632	100	35	301	196	102	242	276
		10.7%	1.7%	0.6%	5.1%	3%	2%	4%	4.7%
4	Өөрийгөө хөгжүүлэх боломж байдаггүй	687	221	39	289	138	80	272	328
		11.7%	3.8%	0.7%	5%	2%	1.4%	5%	5.6%
5	Апбан тушаал ахих эсэх нь тодорхой бус, удаан	351	110	35	147	59	54	130	164
		6%	1.9%	0.6%	2.5%	1%	0.9%	2.2%	3%
6	Удирдлагын ажлын арга барил нийцдэггүй	279	115	19	79	66	32	98	143
		4.7%	2%	0.3%	1.3%	1.1%	0.5%	2%	2.5%
7	Хамт олны уур амьсгал тааламжгүй	218	163	7	15	33	23	79	115
		3.7%	2.8%	0.1%	0.3%	0.6%	0.4%	1.4%	2%
8	Удирдлагын зүгээс алба хаагчдын нийгмийн асуудлыг анхаардаггүй	372	197	20	72	83	65	101	199
		6%	3.3%	0.3%	1.2%	1.4%	1.1%	1.7%	3.4%
9	Удирдлагын зүгээс ажлын байрны дарамт үзүүлдэг	109	69	3	19	15	12	33	58
		2%	1.2%	0.1%	0.3%	0.3%	0.2%	0.3%	1%

10	Нийт	5889	1749	446	234 8	1413	713	212 7	2980
----	-------------	------	------	-----	----------	------	-----	----------	------

Түүнчлэн ажлын ачаалал, ажлын өдрүүдэд илүү цагаар ажиллах шаардлага үүсдэг эсэх талаар тодруулах асуултад 2007 буюу 27.4 хувь нь хэвийн 8 цагаар эсхүл ээлжийн хэвийн 24 цагаар ажил үүргээ гүйцэтгэдэг гэсэн бол үлдсэн 5290 алба хаагч буюу 70 гаруй хувь нь ямар нэг байдлаар байнгын 2 буюу түүнээс дээш 24-өөс дээш цагаар илүү ажилладаг гэжээ. Дээрх статистикаас харахад алба хаагчдын сэтгэл ханамжид цалин хөлс, ажлын ачаалал их байгаа нь гол нөлөөлөх хүчин зүйл болж байх бөгөөд өөрийгөө хөгжүүлэх боломж хязгаарлагдмал, ажлын ачаалал их гэсэн хариултууд нь өндөр хувьтай хамааралтай байна.

Судалгаанд оролцсон алба хаагчдын сэтгэл ханамжид цалин хөлс хамгийн өндөр хувийн хамааралтай байх тул авч буй цалин хөлс нь амьдрал ахуйд нь хүрэлцдэг эсэх талаар тодруулсан асуултад 507 алба хаагч буюу 7.1 хувь нь хангалттай хүрэлцдэг, 62.5 хувь буюу 4415 алба хаагч арай ядан болгодог, 28.2 хувь буюу 1994 алба хаагч цалин амьдралд огт хүрэлцдэггүй гэжээ. Мөн нийт алба хаагчдын 87.2 хувь нь банк болон банк бус санхүүгийн байгууллагад ямар нэгэн зээлтэй, тэдний 30 гаруй хувь нь давхар зээлтэй гэж хариулсан байна. Өөрөөр хэлбэл судалгаанд оролцсон алба хаагчдын 90.7 хувь нь авч буй цалин хөлс нь амьдралд нь огт хүрэлцдэггүй бөгөөд өрхийн орлогын эх үүсвэр нь 100 хувь цалин, хүүхдийн мөнгө байдаг гэсэн бол дөнгөж 3 хувь нь л гэр бүлийн хүн бизнесийн орлоготой гэжээ.

Цалин хөлс амьдралд нь хүрэлцэхгүй байгаатай холбоотойгоор цаашид ажлын байран дээрээ үргэлжүүлэн ажилласаар байх эсэхийг тодруулсан асуултад 3101 алба хаагч буюу 43.5 хувь нь судалж үзээд боломжийн бол ажлаа өөрчилнө, 1107 алба хаагч буюу 15.7 хувь нь тэтгэвэрт гарах хугацаа болж байгаа учир гүрийхээс өөр сонголтгүй гэсэн бол 2551 алба хаагч буюу 36.1 хувь нь ажил мэргэжилдээ дуртай учир ямар ч тохиолдолд ажил үүргээ гүйцэтгэнэ гэсэн хариултыг өгчээ. Судалгаанд оролцсон алба хаагчдаас дунд офицер болон ахлагч бүрэлдэхүүнд ажлаа өөрчилнө гэсэн хандлага давамгайлж байгаа нь анхаарал татаж байгаа юм.

Нөгөөтэйгүүр “Цагдаа, дотоодын цэргийн байгууллага, алба хаагч нь Монгол Улсын 119 хуулийн 1637 заалт, 285 дүрэм, журмын хүрээнд 6700 гаруй үүрэг хүлээдэг, тэдгээрийн 40 орчим хувь нь доголдолтой, уялдаа холбоогүйн улмаас тус байгууллагын ажлын ачаалал жилээс жилд нэмэгдэж иргэдэд хүрэх үйлчилгээний чанарт нөлөөлж байна.”¹³, “Цагдаагийн байгууллагын бүтэц, удирдлага, зохион байгуулалт, хүний нөөцөд хомсдол үүсэж функцийн гүйцэтгэлийн хувьд гацах, үр дүн, бүтээмжийн зогсонги байдалд хүрэх эрсдэл бий болсон тул дунд хугацаандаа хөндлөнгийн мэргэжлийн байгууллагатай хамтран бүтцийн шинэчлэл, өөрчлөлт хийх, урт хугацаанд зохиомол ачааллыг багасгаж, үр өгөөжтэй бүтцийг бий болгох, хүний нөөцийн тогтвортой байдлыг хангаж, цалин хөлсийг бусад ижил чиг үүргийн байгууллагатай уялдуулан нэмэх шаардлагатай”¹⁴ гэсэн дүгнэлтийг хөндлөнгийн судалгааны

¹³ “Цагдаагийн албаны үйл ажиллагаан дахь иргэдийн сэтгэл ханамжийн түвшинг тодорхойлох судалгаа”. Залуу судлаачдыг дэмжих сан ТББ., 2023 он

¹⁴ “Цагдаагийн ажиллах нөхцөл боломж, ажлын ачаалал, ажил мэргэжилдээ хандах хандлагын судалгаа”. Максима судалгааны төв., 2022 он

байгууллагууд гаргажээ. Мөн судалгаанд “Цагдаагийн байгууллагын дунд шатны нэгжийн удирдлагын бүрэлдэхүүн нь ажил үүргийн давхардалтай, хүнд суртлын болон анхан шатны алба хаагчдаа ажлын ачааллаар дардаг, анхан шатны нэгжийн иргэдтэй шууд харьцаж ажилладаг ажил, албан тушаалын хүрэлцээгүй явж ирсэн, нөгөө талаар ажлаа мэддэг, туршлагатай алба хаагчдад бүх ачааллыг үүрүүлдэг”¹⁵ зэрэг хүчин зүйлс нь тогтвор суурьшилд нөлөөлж буй дүгнэлтийг өгчээ.

ЦЕГ-ын Дотоод хяналт, аюулгүй байдлын газрын 2022 оны тайланд албанаас өөрийн хүсэлтээр чөлөөлөгдсөн алба хаагчдын ажилласан жилийг авч үзсэн байна.

Алба хаагчийн ажилласан жил	Ажлаас чөлөөлөгдсөн алба хаагчийн тоо	Ажлаас чөлөөлөгдсөн алба хаагчийн эзлэх хувь
1-3 жил	198	47,8 хувь
4-8 жил	131	31,6 хувь
9-15 жил	78	18,8 хувь
16-20 жил	2	0,5 хувь
20-оос дээш жил	5	1,2 хувь

Дээрх хүснэгтээс дүгнэхэд 1997 оноос хойшхи буюу нийгмийн үечлэлээр “Generation Z” үе буюу шинэ үеийнхэн өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн тохиолдол хамгийн өндөр хувьтай байна. Энэ нь тэдний аливаад сэтгэл хөдлөлөөр ханддаг, бусдад тавих шаардлага өндөр, шуурхай байдалд дуртай, мэдээлэлд шүүмжлэлтэй, шүүлтүүртэй хандах байдал сул, биечилсэн харилцаанааас илүү цахим харилцааг эрхэмлэдэг зэрэг судлаачдын тодорхойлсон нийтлэг сэтгэл зүйн онцлог байдалтай холбоотой байж болох юм. Учир нь цагдаагийн албанд анх орсон ажилтан албандаа дасан зохицоход хүндрэлтэй, албан тушаал дэвшихэд тодорхой хугацаа буюу ойролцоогоор 3-5 жил шаарддаг байдал нь шинэ үеийнхэний төсөөллөөс бодит байдал зөрөх, улмаар ажилдаа сэтгэл хангалуун бус болох, хүсэл эрмэлзлэл нь буурч ажлаас чөлөөлөгдөх шалтгаан болж байна.

Өнөөдөр цагдаагийн байгууллагын дунд буюу дээд түвшинд "Generation X", "Generation Y" үеийнхэн давамгайлж байна. Тэдний үнэт зүйл, асуудалд хандах хандлага “Generation Z” үеэс эрс ялгаатай бөгөөд энэ нь байгууллагын хамт олны доторхи уур амьсгал, ажлын бүтээмж, үр дүн, цаашлаад албаны хэвийн үйл ажиллагаанд нөлөөлөхүйц түвшинд хүрснийг дээрх судалгаа, тайлангаас харж болно. Иймд цагдаагийн байгууллагын хүний нөөцийн удирдлагын үйл ажиллагаанд нийгмийн үе, үе хоорондын ялгаатай байдал, шилжилтийн үеийг зайлшгүй харгалзан үзэх шаардлагатай болж байгаа юм.

Нөгөөтэйгүүр улс орны хөгжлийн зүй тогтлыг дагаж урьд өмнө байгаагүй шинэ нөхцөл байдал нийгмийн харилцаанд бий болох, шинэ төрлийн гэмт хэрэг гарах, гэмт хэргийн үйлдэл, шалтгаан нөхцөл нийтлэг бус болсон зэрэг нь цагдаагийн байгууллагын гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэгтэй тэмцэх, илрүүлэх үйл ажиллагаанд шинэ шийдэл, инноваци, удирдлагын арга барилыг нэвтрүүлэх хэрэгцээ шаардлагыг нэмэгдүүлж байна. Цагдаагийн байгууллагаас үйл ажиллагаанд техник технологийн давуу талыг нэвтрүүлэх, олон улстай хамтын

¹⁵ “Цагдаагийн ажиллах нөхцөл боломж, ажлын ачаалал, ажил мэргэжилдээ хандах хандлагын судалгаа”. Максима судалгааны төв., 2022 он

ажиллагааг өргөжүүлэхэд чиглэсэн ажил, арга хэмжээг шат дараатай хэрэгжүүлж байгаа хэдий ч албаны харилцаа, цалин хөлс бага, нийгмийн баталгаа төдийлөн сайн хангагдаагүй, өсөн дэвших, өөрийгөө хөгжүүлэх тал дээр дутмаг гэсэн шалтгаануудаар гадаад хэл, техник технологийн өндөр мэдлэг, ур чадвартай хүний нөөцийн дутагдалд орсоор байна. Цахим мэдээллийн аюулгүй байдал хангагдаагүй, найдвартай хэвийн ажиллагааг хангах хүний нөөцийн дутагдалтай байдлаас шалтгаалж нэг ажлыг олон давтан хийх, ажлын давхардал хийдэл бий болох, зохиомол ачаалал үүсгэж байгааг “Цагдаагийн ажиллах нөхцөл боломж, ажлын ачаалал, ажил мэргэжилдээ хандах хандлагын судалгаа”-д дурьджээ. Нөгөө талаас үүнийг алба хаагчдын техник, технологийн мэдлэг хангалтгүй байгаатай холбог тайлбарлаж болох хэдий ч цахим мэдээллийн системүүдийн найдвартай үйл ажиллагааг хангах, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлж, бэхжүүлэхэд чиглэсэн цогц бодлого боловсруулж, хэрэгжүүлэх нь цагдаагийн байгууллагын хүний нөөцийн удирдлагын үйл ажиллагаанд томоохон сорилтыг бий болгож байгааг тэмдэглэж байна.

Дүгнэлт

Илтгэлийн хүрээнд ашигласан судалгаануудад түшиглэн цагдаагийн байгууллагын хүний нөөцийн тогтвор суурьшил, алба хаагчдын сэтгэл ханамжид гадаад болон дотоод орчны өөр хоорондоо холбоо хамаарал бүхий олон хүчин зүйлс нөлөөлж байна гэсэн дүгнэлтэд хүрлээ.

Төрийн алба тэр дундаа хууль сахиулах, аюулгүй байдлыг хангах төрийн тусгайласн чиг үүрэг бүхий цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд шуурхай, хүртээмжтэй, тогтвор суурьшилтай, тэгш байх зарчим алдагдахгүй байх нь төрийн үндсэн чиг үүрэг хэрэгжих нөхцөл болно.

Иймд цагдаагийн байгууллагаас хүний нөөцийн удирдлагын үйл ажиллагаанд жил бүр мониторинг хийж, алба хаагчдыг албандаа итгэх итгэл үнэмшил, омогшлыг нэмэгдүүлж тогтвор суурьшилтай ажиллуулах, нийгмийн баталгааг хангах, хувь хүний хөгжлийг дэмжиж техник технологи, гадаад хэлний мэдлэг, ур чадварыг сайжруулахад чиглэсэн сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх нь үр дүнтэй ажил болно. Түүнчлэн шинэ үеийнхэний хэрэгцээ, шаардлагад тулгуурлан албандаа дасан зохицоход чиглэсэн ажлуудыг бодлогоор дэмжиж, хэрэгжүүлэх нь чухал юм.

Монгол Улсын төрөөс чадахуйн зарчимд суурилсан, шатлан дэвших тогтолцоог төрийн албанд бүрдүүлэх, төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг сайжруулахад бодлогоор дэмжиж, тэгш байх зарчмыг баримтлан цалин хөлсний оновчтой тогтолцоог бүрдүүлэх чиглэлээр дорвитой арга хэмжээ авахгүй, одоогийн аргацаасан байдлаар цааш үргэлжлэх тохиолдолд төрийн бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх болон төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх үйл ажиллагааны түвшинд “урам нь мохсон ажиллах хүч” /unmotivated workforce/ бий болж, улмаар төрийн албаны үйл ажиллагааны тасралтгүй, шуурхай, хүртээмжтэй, үр дүнтэй байхад сөргөөр нөлөөлөх юм.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Ном зүй

а/ Монгол Улсын хууль, тогтоомж

- Монгол Улсын Үндсэн хууль;
- Төрийн албаны тухай хууль” /шинэчилсэн найруулга/;
- Цагдаагийн албаны тухай /шинэчилсэн найруулга/;
- “Тэгш шан хөлс олгох тухай” олон улсын конвенци /1951/;
- “Цагдаагийн байгууллагын талаар зарим авах арга хэмжээний тухай” Засгийн газрын 99 дүгээр тогтоол. /2014.03.28/;
- “Хөтөлбөр батлах тухай” Засгийн газрын 79 дүгээр тогтоол. /2014.03.14/;
- Цалин хөлсний талаар үндэсний хэмжээнд баримтлах бодлого /Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурвант талт Үндэсний хорооны 2019 оны 2 дугаар тогтоол. 2019.09.06/;
- “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалигийн сүлжээ, хэмжээг шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 452 дугаар тогтоол /2022.12.09/.


б/ Судалгааны тайлан, цахим эх сурвалж:

- “Алба хаагчийн ниагмийн байдал, эрхэлж буй ажилтай холбоотой сэтгэл ханамжийн судалгааны тайлан”, ЦЕГ /2022.07.01/;
- “Цагдаагийн ажиллах нөхцөл боломж, ажлын ачаалал, ажил мэргэжилдээ хандах хандлагын судалгаа”. Максима судалгааны төв. 2022 он;
- “Цагдаагийн албаны үйл ажиллагаан дахь иргэдийн сэтгэл ханамжийн түвшинг тодорхойлох судалгаа”. Залуу судлаачдыг дэмжих сан ТББ. 2023 он;
- Дотоод хэргийн их сургууль. “Цагдаагийн алба хаагчийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж буй хучин зүйлийг тодорхойлох судалгаа”. 2023 он;
- Цагдаагийн ерөнхий газар. “Хүний нөөцийн оролт, гаралтын судалгаа”. 2023 он;
- Төрийн албаны шинэтгэл ба тулгамдсан асуудал. Эрдэм шинжилгээний бага хурал. Төрийн ордон /2017.04.04/;
- “Төрийн тусгай байгууллагын удирдлага, тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам” ЭШХ-ын эмхэтгэл. ДХИС. 2022 он;
- УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаан, Төрийн байгуулалтын байнгын хорооны хурал. Төрийн ордон /2022.10.27/;
- Төрийн албаны удирдах ажилтны улсын зөвлөгөөн. Төрийн ордон /2018.09.21/;
- Үндэсний статистикийн хорооны цахим мэдээллийн сан.

SPSIRPA FORUM 2024

Session 9-4

Opportunities to improve quality of agriculture raw materials using traceability system in Mongolia



ХӨДӨӨ АЖ АХУЙН ТҮҮХИЙ ЭД БЭЛТГЭЛИЙН ТОГТОЛЦООГ ЭРГЭН МӨШГӨХ СИСТЕМ НЭВТРҮҮЛЭХ ЗАМААР САЙЖРУУЛАХ БОЛОМЖ

/Монголын арьс ширэн түүхий эдийн жишээн дээр/

Б.Батхүү

Улс төр судлал, олон улсын харилцаа, нийтийн удирдлагын сургууль

Монгол Улсын Их Сургууль

Улаанбаатар хот, Монгол Улс

Batkhuu.b@gmail.com

Хураангуй

Манай улсын өмнө тулгамдаад буй томоохон асуудал бол мал сүргийн тоо толгой жил дараалан өсч байгаа хэдий ч мал аж ахуйн гаралтай түүхий эд түүний дотор арьс ширэн түүхий эдийн чанар алдагдаж таваарлаг шинж чанараа алдсан явдал юм. Энэ нь нэгт малчдын орлого, хоёрт үйлдвэрлэгчдийн ашигт ажиллагааг бууруулан манай улсын арьс ширний үйлдвэрлэлийн салбарыг доройтуулах гол шалтгаан болоод байна. Арьс ширэн түүхий эд нь малын нядалгааны дараах ашиг шимд тооцогдох бөгөөд түүний чанар амьд үеийн, нядалгааны үеийн, нядалгааны дараах гэмтлээс хамаардаг. Дээрх гэмтлүүд нь хүний ухамсарт үйл ажиллагаанаас шууд хамаарах бөгөөд салбарын эрдэмтэд, үйлдвэрлэгчид “түүхий эд бэлтгэлийн тогтолцоо” алдагдсанаас үүдэлтэй хэмээн үзэж байгаа юм.

Малчид, түүхий эд бэлтгэгч, нийлүүлэгч, үйлдвэрлэгч зэрэг нэмүү өртгийн сүлжээнд оролцогчдоос гадна төрийн бодлого ч түүхий эдийн чанар алдагдахад томоохон сөрөг нөлөөг үзүүлж байгаа юм. Энэхүү үзэгдлийг салбарын эрдэмтэд, мэргэжлийн холбоодын зүгээс социалист нийгмээс ардчилсан нийгэмд шилжихэд хуучин түүхий эд бэлтгэлийн тогтолцоо алдагдсан ба зах зээлийн зарчмаар хөгжихдөө тохирох тогтолцоонд шилжээгүйтэй холбож тайлбарладаг авч оновчтой арга зам, шийдлийг хараахан тодорхойлоогүй байна.

Дэлхий дахинд өрнөж буй аж үйлдвэрийн IV хувсгал нь бидэнд хэмжээлшгүй их боломж олгож байгаагийн нэг нь ХАА-н бүтээгдэхүүний ханган нийлүүлэлтийн сүлжээг хянах, ул мөрийг эргэн мөшгөх, дижитал систем юм. Энэхүү судалгаанд арьс ширэн түүхий эдийн гэмтлийг үүсгэгч субъектүүдийг хамруулан гэмтлийн шалтгаан, суурь түвшнийг тодорхойлох, хариуцлагыг өндөржүүлэх, чанарыг эргэн мөшгөх системийг нэвтрүүлэх замаар түүхий эдийн гэмтлийг бууруулж, чанарыг сайжруулах гарц шийдлийг боловсруулахыг зорьсон билээ. Ингэснээр арьс ширний үйлдвэрлэлийн салбарын ашигт ажиллагааг нэмэгдүүлэх боломж бүрдэх юм.

Түлхүүр үг: Арьс шир түүхий эдийн чанар, ханган нийлүүлэлтийн сүлжээ, эргэн мөшгөх систем

I. УДИРТГАЛ

Монгол улс 2023 онд 64,7 сая мал тоолуулсан. Үүнээс жилд 14-20 орчим сая толгой мал хэрэгцээлдэг ба үүнээс 250 мянга нь адууны шир, 600-700 мянга нь үхрийн шир, 5-7 сая нь хонины арьс, 5-8 сая нь ямааны арьс ширэн түүхий эдийг бэлтгэдэг байна. Зөвхөн 2019 онд нийт өвчиж хуулагдсан арьс, ширний 55.5% буюу 6.3 сая ширхэг нь энэхүү нядалгааны үеийн гэмтэл ихтэй нь улмаас хаягдсан байдаг. [1]

Энэхүү үзэгдлийг түүхий эд бэлтгэлийн тогтолцоо алдагдсантай холбоотой тухай салбарын эрдэмтэд, төрийн болон төрийн бус байгууллагууд нотолдог хэдий ч түүнээс гарах арга зам, шийдлийг хараахан бүрэн тодорхойлоогүй байна. Европын холбооны улсын арьс ширний үйлдвэрлэлийн салбарт түүхий эдийн чанарын асуудал хурцаар тавигдаж байгаа бөгөөд үүнээс үүдэлтэй нийт бүтээгдэхүүний 70% шаардлага хангахгүй байгаа ба 800 сая еврогийн алдагдлыг жил бүр хүлээж байна.¹ [2]

Сэдвийн хүрээнд гол судлах асуудал нь арьс ширэн түүхий эдийн гэмтлийн түвшнийг тодорхойлох, ханган нийлүүлэлтийн сүлжээнд оролцогчдын сөрөг нөлөө, алдаа оноог илрүүлэх, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх гарц шийдлийг тодорхойлох явдал юм.

Түүхий эдийн гэмтлийн судалгаа манай улсад сүүлийн 20 гаран жил огт хийгдээгүй бөгөөд одоогийн байдлаар НҮБ-ын Аж үйлдвэрийн хөгжлийн байгууллага, Монголын арьс ширэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн холбоо ТББ болон ААН-үүдийн төвшинд хийгдсэн жижиг судалгааг эс тооцвол харьцуулсан шинжилгээ хийх өөр дотоодын эх сурвалж хомс байна.

Арьс ширэн түүхий эдэд холбогдох стандартын дагуу малын амьд үедээ авсан хачиг хувалз, шивээ, им тамганы гаралтай гэмтлүүд, нядлах үеийн зүсэлт, эсгэлт, цоорхой, нядалгааны дараах тордолт, чанарын хамгаалалт, тээвэрлэлтийн горим алдагдсантай холбоотой гэмтлийн тогтоох үзлэг хийж холбогдох стандартын дагуу тоон аргаар судалсан. [3] [4] Өртгийн сүлжээний шинжилгээгээр малчин, төхөөрөх үйлдвэр, түүхий эд бэлтгэн нийлүүлэгчид, арьс шир боловсруулах үйлдвэрүүдээс тулгамдсан асуудал, гарц шийдлийн талаарх чанарын судалгааг олон удаагийн хэлэлцүүлэг хийж, ярилцлагын аргаар гүйцэтгэсэн. [5] Мөн ӨАБНУ-ын үхрийн арьсны өртгийн сүлжээний шинжилгээг Монгол улсын арьс ширний салбартай харьцуулан шинжилж ханган нийлүүлэлтийн сүлжээний нөхцөл байдлыг тодруулав. [5]

Арьс ширний салбарт төрөөс баримталж буй бодлогын баримт бичгийн шинжилгээг хийж эерэг сөрөг нөлөөллийг МАШҮХолбоо ТББ, Арьс шир боловсруулах үйлдвэрүүдийн төлөөллөөс ярилцлагын аргаар судалж тогтоосон. Эцэст нь ул мөрийг эргэн мөшгөх системийн /traceability system/ туршилтыг хоёр удаа зохион байгуулж ажиглалтын аргаар судалгаагаа хийснээр манай улсын нүүдлийн мал аж ахуйн онцлогт тохирсон байдлаар нэвтрүүлэх хувилбарыг дэвшүүлэв. Улмаар арьс ширний урамшууллаар тус системийг хөшүүрэгдэх загварыг боловсруулсан болно. [6] [7]

Энэхүү судалгаа нь түүхий эд бэлтгэн нийлүүлэгч малчид, завсрын наймаачид болон мал төхөөрөх болон арьс шир боловсруулах үйлдвэрүүдийн хувьд чухал гарын авлага болохын зэрэгцээ төрийн байгууллагуудын хувьд бодлого тодорхойлох, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээгээ төлөвлөхөд чухал үүрэгтэй юм.

Судалгааны ажлын зорилго

¹ <https://leathercouncil.org/fair/hide.htm>

Энэхүү судалгааны ажлын зорилго нь арьс ширэн түүхий эд бэлтгэлийн тогтолцоог зах зээлийн нийгэмд тохируулан шийдвэрлэх арга замыг судалж тодорхойлон, түүхий эдийн чанарыг сайжруулахад чиглэсэн санал, зөвлөмжийг боловсруулахад оршино.

Зорилт

1. Арьс ширэн түүхий эдийн гэмтлийг судалж тодорхойлох
2. Өртгийн сүлжээний шинжилгээ хийж түүхий эд бэлтгэлийн тогтолцооны гажуудлыг тодруулах
3. Мөшгөх систем нэвтрүүлэхэд тулгамдсан асуудлыг тодорхойлох, шийдвэрлэх арга замыг боловсруулах
4. Арьс ширний салбарт төрөөс үзүүлж буй бодлогын баримт бичгийн шинжилгээ хийх
5. Түүхий эдийн чанарыг сайжруулах дүгнэлт зөвлөмжийг боловсруулах.

Судалгааны ажилд дэвшүүлсэн таамаглал

- Арьс ширний салбарт төрөөс хэрэгжүүлж буй арга хэмжээ алдаатай байна.
- Түүхий эд бэлтгэлийн тогтолцоо алдагдсанаас арьс ширэн түүхий эдийн чанар муудсан.
- Арьс ширэн түүхий эд бэлтгэлийн тогтолцоог мөшгөх системээр шийдвэрлэж түүхий эдийн чанарыг сайжруулах боломжтой.

Судлах зүйл

Арьс ширэн түүхий эдийн чанарт шууд болон дам нөлөөлж буруулсан хүчин зүйлсийг тодорхойлох, үнэлэх, түүхий эдийн бэлтгэлийн тогтолцоог цахим шилжилтээр шийдвэрлэж чанар сайжруулах гарц шийдлийг боловсруулна.

Судалгааны объект

Арьс ширний үйлдвэрлэлийн өртгийн сүлжээнд хөндлөнгөөс нөлөөлөгч талууд болох төрийн байгууллагууд, Мал эмнэлгийн ерөнхий газар, мэргэжлийн холбоод болон шууд оролцогчид болох түүхий эд бэлтгэн нийлүүлэгчид, арьс шир боловсруулах үйлдвэрүүд, мал төхөөрөх үйлдвэрүүд, малчдыг хамруулан судалгаа хийнэ.

Судалгааны ажлын шинэлэг тал

Манай улсын арьс ширэн түүхий эд бэлтгэлийн тогтолцоонд цахим эргэн мөшгөх системийг нэвтрүүлэх цогц судалгааг хийж, зах зээлийн нийгэмд үр ашигтай шинэ тогтолцоог шийдвэрлэх арга замыг тодорхойлох нь энэхүү судалгааны ажлын шинэлэг тал болно.

Судалгааны ажлын практик ач холбогдол


Энэхүү судалгааны ажлыг арьс ширний үйлдвэрлэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага суурь мэдээлэл болгож арьс ширэн түүхий эдийн чанарыг сайжруулахад мөшгөх тогтолцоог нэвтрүүлэхдээ ашиглах, салбарын экспортын борлуулалтын орлогыг нэмэгдүүлэх, нэмүү өртгийн сүлжээний тоглогчдын ашиг орлогыг нэмэгдүүлэх, бэлтгэн нийлүүлэлтийн сүлжээг төлөвлөх, удирдан зохион байгуулах, хянах, дэмжих менежментийг хэрэгжүүлэхэд ашиглагдах ач холбогдолтой.

II. ОНОЛЫН ТОЙМ СУДАЛГАА

1. Мөшгөх систем

Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний мөшгөлтийг анх хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах зорилгоор бий болгожээ. Өнөөдөр олон улсын хүнсний аюулгүй байдлын санаа зовоосон дээрх асуудлыг шийдвэрлэх, орчин үеийн хөдөө аж ахуйн шаардлагад нийцүүлэн мөшгөх системийг өргөнөөр дэмжиж нэвтрүүлж байгаа ба цаашлаад даяарчлагдаж буй дэлхийд дахинаа экспортын бүтээгдэхүүнд тавигдах томоохон шаардлага болоод байна.

Зураг 1. ХАА-н бүтээгдэхүүний эргэлт [10]



Хөдөө аж ахуйн эргэн мөшгөх систем нь хөдөө аж ахуйн чанарын мэдээллийг илрүүлж, дамжуулж, өсөн нэмэгдэж буй хөдөө аж ахуйн аюулгүй байдлын асуудлыг үр дүнтэй шийдвэрлэх боломжтой. Мөшгөх системийн үндсэн зорилго нь нийлүүлэлтийн сүлжээн дэх төрөл бүрийн бүтээгдэхүүний түүх, байршлыг нарийн бүртгэх явдал юм.

Мөшгөх системээр цуглуулсан мэдээлэл нь бүтээгдэхүүний багцыг эргүүлэн татах хүртэл шийдвэр гаргах стратегийн ач холбогдолтой юм. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах, нийлүүлэлтийн сүлжээний ил тод байдлыг сайжруулах үр дүнтэй арга хэрэгсэл бол эргэн мөшгөх систем гэж үзэж байна. [8]

Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг мөшгөх систем гэдэг нь хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлээс эргэлт хүртэл үйлдвэрлэлийн гинжин хэлхээний бүх холбоосыг урагш, урвуу мөрдөхийг хэлнэ. [9]

Эргэн мөшгөлт /Traceability ISO 8402:1994/ Энэхүү олон улсын стандарт нь чанарын тухай стандартыг бэлтгэх, ашиглах, олон улсын харилцаанд харилцан ойлголцох бүх салбарт хамаарах чанарын үзэл баримтлалтай холбоотой үндсэн нэр томъёог тодорхойлдог. Энэхүү стандартын тодорхойлсон нөхцлүүдийн нэг нь эргэн мөшгөлт бөгөөд байгууллагын түүх, бүтээгдэхүүн, үйл ажиллагаа, байршлыг бүртгэсэн таних тэмдгүүдийн тусламжтайгаар хянах асуудал юм. Энэхүү стандартыг 1994 онд Австралийн Стандарт, Шинэ Зеландын Стандартууд баталж, нийтэлсэн. [11]

Мэдээллийн технологийн давуу талыг ашиглан эргэн мөшгөх системийг хөгжүүлэх, системийн зардлыг бууруулах, ханган нийлүүлэх сүлжээг удирдах хянах хялбар

шийдлийг Германы технологийг харгалзан өөрийн орны онцлогт тохируулан боловсруулж туршилтыг зохион байгуулах нь томоохон сорилт байсан юм.

2. Арьс ширэн түүхий эдийн гэмтэл

Арьс ширэн түүхий эдийн гэмтлийг “Арьс ширэн түүхий эдийн гэмтлийн нэр томъёо, тодорхойлолт” MNS 3121:2013 стандартаар тодорхойлсон байдаг. Тус стандартад “Мал, амьтны бие махбодын биологийн болон гадна орчны физик, механик, химийн нөлөөллөөс арьсанд үүссэн арьс, ширний таваарлаг чанар, үнэлгээг бууруулж, бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд бэрхшээл учруулдаг төрөл бүрийн өөрчлөлтийг арьс ширэн түүхий эдийн гэмтэл гэнэ.” гэж тодорхойлсон байдаг. [3]

Судалгаанд хамруулсан нийт арьс ширний талбайн ангиллын эзлэх хувь, талбайн ангилал бүр дэх гэмтлийн тоо, ямар талбайтай арьсанд гэмтэл их байгаа зэрэг мэдээллийг нарийвчлан тогтоох, ашигтай талбайн эзлэх хувийг тогтооход “Боловсруулаагүй арьс шир” Техникийн шаардлага MNS 0060:2013 стандартыг мөрдлөг болгосон ба MNS 3121:2013 стандартад заасны дагуу малын амьд үеийн гэмтэл хачиг, гуур, хамуу, шивээний гэмтлүүд, нядалгааны үед голлон тохиолддог уранхай, цоорхой, эсгэлтийн, нядалгааны дараах буюу тордолт, тээвэрлэлт, хадгалалтаас үүссэн гэмтлийн судалгааг хийв. [3], [4]

Арьс ширний гэмтлийн онцлог, шинжлэх боломжийг харгалзан гүн боловсруулах үйлдвэр болон түүхий эдийн агуулахыг сонголоо.

I. Хонь, ямаа, үхэр, адууны нядалгааны болон нядалгааны дараах үеийн гэмтлийг түүхий эдийн агуулахууд дахь бог ба бод малаас бэлтгэсэн арьс ширэн түүхий эдийг ангилж түүврийн аргаар судалгаа авах, арьс ширний жин, талбайн хэмжээгээр ангилах түүврийн тоо 500-аас дээш, чанараар А, В, С, D үнэлэх нэгтгэх; [4]

II. Хонь, ямаа, үхэр, адууны амьдын, нядалгааны үеийн болон нядалгааны дараахь гурван түвшний гэмтлийг гүн боловсруулах үйлдвэрүүдийн анхан шатны боловсруулалт хийсэн бог, бодын вет блү, ветвайт, краст бүтээгдэхүүнд түүвэр үзлэг хийж судлах, түүврийн тоо 500-аас дээш, арьс ширний жин, талбайн хэмжээгээр ангилах, чанараар А, В, С, D үнэлгээ өгөх, дүгнэх. [4]

Ш. СУДАЛГААНЫ ҮР ДҮН

1. АРС ШИРЭН ТҮҮХИЙ ЭДИЙН ГЭМТЛИЙН СУДАЛГАА

Монгол Шевро ХК-ийн 1119 ширхэг хонины хагас боловсруулсан вет блю арьсанд амьдын үеийн болон нядалгааны үеийн гэмтлийг тодорхойлох, Их эргэлт ХХК-ийн 524 ширхэг адууны арьсанд амьдын болон нядалгааны үеийн, Мон-Ирээдүй ХХК-ийн 1011 ширхэг Ямааны ветблю арьсанд амьд үеийн, Ерөөлт интернэйшнл ХХК-ийн 331 ширхэг үхрийн хагас боловсруулсан ветблю ширэнд амьдын үеийн болон нядалгааны үеийн, Эмээлт дэх түүхий эдийн захад байрлалтай Спарк кашмир ХХК /Spark cashmere LLC/-ийн агуулахад ямааны 1076 ширхэг, Их зам транс ХХК-ийн задгай талбайд хонины 1051 ширхэг арьсанд нядалгааны үеийн арьс ширэнд гэмтлийн үзлэг хийж гэмтлийн зэргийг тодорхойллоо. [5]

Зураг 2-г үзүүлснээр амьд үеийн болон нядалгааны үеийн гэмтэл түүхий эдийн чанарыг бууруулах гол нөлөөг үзүүлж байгаа ба энэ нь малчин, мал төхөөрөгчдөөс шууд шалтгаалж байгааг илтгэж байна. Судалгааны үр дүнгээс тоймлон зонхилж буй гэмтлүүдийг авч үзье.

№	Арьсны төрөл	Амьдын гэмтэл	Нядлагын үеийн гэмтэл	Нядалгааны дараах гэмтэл
1	Үхрийн шир	20,8	76,4	-
2	Адууны шир	98,0	95,5	-
3	Хонины нэхий	92,8	61,8	9,8
4	Ямааны арьс	72,3	76,9	-

1.1 Адууны ширний амьдын болон нядалгааны үеийн гэмтэл тодорхойлох судалгаа

Их Эргэлт ХХК-ийн агуулахад хагас боловсруулсан краст арьсан дээр нядалгааны гэмтлийг тоолох болон талбайд эзлэж байгаа хувийн хэмжээгээр арьсыг А, В, С, D ангиллаар, амьдын гэмтлийг ажиглан тоолох аргаар тус тус тодорхойлов. Судалгаанд “Арьс ширэн түүхий эдийн гэмтлийн нэр томъёо, тодорхойлолт” MNS 3121:2013 стандартын 5.2 дугаар заалтад заагдсан нядалгааны үеийн голлон тохиолддог гэмтлүүдийг авав. [3]

Тухайлбал, “Боловсруулаагүй арьс шир” Техникийн шаардлага MNS 0060:2013 стандартыг мөрдлөг болгон адууны ширийг

- хөнгөн жинтэй /8 кг хүртэл/
- дунд жинтэй /8,1-12,0 кг хүртэл/
- хүнд жинтэй /12,1 кг-аас дээш/ гэж ангилж ангилал бүр дээр амьдын болон нядалгааны үеийн гэмтлийн судалгааг хийв. [4]


Түүнчлэн, ашигтай талбайн эзлэх хувийг “Боловсруулаагүй арьс шир” Техникийн шаардлага MNS 0060:2013 стандартын дагуу авав. Үүнд:

- А 80,1%-иас дээш (хэвийн)
- В 61,1-80,0% (бага гэмтэлтэй)
- С 31,1-60,0 (дунд гэмтэлтэй)
- D 31,1% хүртэл (их гэмтэлтэй) [4]

Судалгааны дүнгээс үзэхэд:

1. 524 ширхэг хагас боловсруулсан адууны краст ширэнд үүссэн амьдын гэмтлийн судалгаа хийхэд судалгаанд хамрагдсан нийт ширний 99,0% нь тамганы сорвитой байна.
2. Адууны краст шир нь нядалгааны үеийн маш ихтэй гэмтэлтэй буюу нийт ширний 95,6% зөвхөн эсгэлтийн, 46,4% нь өвчилтийн цоорхойтой байна.
3. Судалгаанд хамрагдсан ширний 4,8% нь уранхай, 46,4% нь цоорхой, 95,6% эсгэлтийн гэмтэлтэй байна.
4. Судалгаанд хамрагдсан краст ширний 99,0% гэмтэлтэй, 1,0% нь гэмтэлгүй байна.
5. Адууны краст ширний гэмтлийг ашигтай талбайн эзлэх хувиар нь хувилж үзэхэд 1,0% нь хэвийн (A), 2,3% нь бага (B), 76,7% нь дунд (C), 20,0% нь их (D) гэмтэлтэй байна. [3]

Зураг 3. Адууны ширний гэмтэл



1.2 Үхрийн ширний амьдын болон нядалгааны үеийн гэмтлийг тодорхойлох судалгаа

Ерөөлт Интернэйшнл ХХК-ийн нойтон боловсруулах цехэд үхрийн хагас боловсруулсан вет блю 331 ширхэг ширэнд амьдын болон нядалгааны үеийн гэмтлийг тодорхойлох судалгааг хийсэн ба үхрийн вет блю ширний нядалгааны гэмтлийг шар махан талыг нь дээш харуулан дэлгэж гэмтлийг ажиглалтаар тоолж, амьд үеийн гэмтлийг ширний өнгөн талыг нь дээш харуулан дэлгэж гэмтлийг адил аргаар тодорхойллоо.


Судалгаанд хамрагдсан ширийг хүндийн жингээр нь MNS 0060:2013 стандартад заагдсаны дагуу ангилж жингийн ангилал бүр дээр гэмтлийн тоо, эзлэх хувийг тодорхойлов. [4]

Нядалгааны өмнөх үеийн буюу амьдын гэмтэлд гуур болон эврийн сорвийг, нядалгааны үеийн гэмтэлд MNS 3121:2013 стандартад заагдсан өвчилтийн үед үүссэн уранхай, цоорхой, эсгэлтийн гэмтлүүдийн судалгаа хийв. [3]

Судалгааны дүнгээс үзэхэд:

Зураг 4. Үхрийн ширний нядалгааны үеийн гэмтэл

1. Түүхий эд нь өвлийн улиралд бэлтгэгдсэн учраас гуурын гэмтэл илэрсэнгүй, 331 ширнээс зөвхөн 1 шир гуурын гэмтэлтэй байлаа. Эврээс болон амьд үед нь үүссэн зураас, сорви 20,8%-ийг эзэлж байна, харин тамганы болон самналтын гэмтэл илрээгүй.



2. Судалгаанд хамрагдсан 331 ширхэг үхрийн хагас боловсруулсан вет блю ширний

76,4% нь өвчилтийн буюу нядалгааны гэмтэлтэй, зөвхөн 23,6% нь гэмтэлгүй байна.

3. Үхрийн уранхайн гэмтэл бага (1,8%), цоорхойн гэмтэл их (53,8%), эсгэлтийн гэмтэл маш их буюу судалгаанд хамрагдсан нийт ширний 70,9%-ийг эзэлж байна. [3]

1.3 Хонины арьсны амьдын болон нядалгааны үеийн гэмтлийг тодорхойлох судалгаа

Судалгааг Монгол Шевро ХК-ийн нойтон боловсруулах цехд түүврийн аргаар явуулсан бөгөөд судалгаанд 1119 ширхэг хонины вет блю арьсыг хамруулсан ба хонины хагас боловсруулсан вет блю арьсан дээр хийсэн. Судалгааг хийхдээ арьсыг бүх талбайгаар нь тэнийлгэн дэлгэж, түүний өнгөн тал дээр амьдын үеийн гэмтлийг, шар махан тал дээр нь нядалгааны үеийн гэмтлүүдийг харааны ажиглалтаар тоолж явуулав.

Судалгаанд хамрагдсан гэмтлүүд нь арьс ширийг боловсруулахад хүндрэл учруулдаг, боловсруулсан арьс ширний ашигтай талбайн хэмжээг ихээхэн бууруулдаг гэмтлүүд юм.

Богийн арьсыг MNS 0060:2013 стандартад талбайн хэмжээгээр нь


- жижиг буюу 40-55 дм²
- дунд буюу 55,1-85,0 дм²
- том буюу 85,1 дм²-ээс дээш талбайтай гэж ангилдаг ба үүний дагуу судалгаанд хамрагдсан хонины вет блю арьсны гэмтлийн судалгааны дүнг талбайнхэмжээ тус бүрээр, гэмтэлтэй арьсны тоог ширхэгээр болон хувиар тодорхойлов.

Судалгааны дүнгээс үзэхэд:

1. Судалгаанд хамрагдсан хонины вет блю арьсны 77,2% нь амьдын гэмтэлтэй, 22,8% нь амьдын гэмтэлгүй байна. Амьдын гэмтлүүдийг ангилж үзвэл 55,3% хачигны, 10,4% нь хамууны, 10,8% шивээний гэмтэл байна. Амьдын гэмтлүүдийн ихэнх хувийг хачигны гэмтэл эзэлж байна.

Зураг 5. Хонины арьсны амьдын гэмтэл

2. Судалгааны дүнгээс үзэхэд хонины вет блю арьсны 39,1% нь нядалгааны үеийн гэмтэлгүй, 60,9% нь нядалгааны гэмтэлтэй байгаа ба гэмтлийг түүний төрлөөр нь ангилвал уранхайн гэмтэл 10,6%, цоорхойн гэмтэл 21,7%, эсгэлтийн гэмтэл 23,2% тус тус байна.



3. Хонины арьсны нядалгааны үеийн гэмтлийн 44,9%-ийг уранхайн болон цоорхойн гэмтэл эзэлж байгаа нь мал өвчилтийн арга ажиллагааг технологийн дагуу явуулах шаардлагатай байгааг харуулж байна.

4. Өвлийн улиралд бэлтгэгдсэн түүхий эд учраас нядалгааны дараах үеийн гэмтэл илрээгүй. Нядалгааны дараах гэмтэл нь ихэвчлэн удаан хадгалах үед хортон шавьжнаас шалтгаалж хивэн, цохонд идэгдсэн, уринд идэгдсэн, эвэршсэн болон зуны улиралд чанарын хамгаалалтыг хийгээгүй эсвэл буруу хийснээс үүсэж ялзарсан, хөгцөрсөн, хорчгор болсон, өтөнд идэгдсэн, хэт хатаагдсан, хугарсан гэмтлүүд зонхилдог.

1.4 Ямааны арьсны амьдын үеийн гэмтлийн судалгаа

Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн 3 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлалтай, арьс шир боловсруулдаг Мон-Ирээдүй ХХК-ийн үйлдвэрлэлийн нойтон тасагт ямааны хагас боловсруулсан вет блю 1011 ширхэг арьсан дээр амьдын үеийн гэмтлийн судалгааг хийв.

Нийт судалгаанд хамрагдсан арьсны талбайн ангиллын эзлэх хувь, талбайн ангилал бүр дэх гэмтлийн тоо, ямар талбайтай арьсанд гэмтэл их байгааг нарийвчлан тогтоохын тулд Түүхий эд бэлтгэл. Арьс шир. “Боловсруулаагүй арьс шир” Техникийн шаардлага MNS 0060:2013 стандартыг мөрдлөг болгон ямааны вет блю арьсыг

- жижиг /40-55 дм²/
- дунд /55,1-85,0 дм²/
- том /85,1 дм²-ээс дээш/ талбайтай гэж ангилж талбайн ангилал бүр дээр амьдын үеийн гэмтлийн судалгааг хийв.


“Арьс ширэн түүхий эдийн гэмтлийн нэр томъёо, тодорхойлолт” MNS 3121:2013 стандартын 5.2 дугаар заалтад заагдсан малын амьдын үед голлон тохиолддог хачиг, хамуу, шивээ болон самналтын гэмтлүүдийг авав.

Ямааны арьс бүрийг шар махан талыг доош харуулж дэлгэн харааны ажиглалтаар шалгаж нэг арьсан дээр байгаа гэмтлийг гэмтлийн төрөл бүрээр нь тоолж судалгаа явуулав.

Судалгааны дүнгээс үзэхэд:

Зураг 6. Ямааны арьсны амьдын гэмтэл

1. Ямааны арьсанд нядалгааны дараах гэмтэл илрээгүй.
2. Судалгаанд хамрагдсан нийт арьсны 939 ширхэг буюу 92,9% нь амьдын үеийн гэмтэлтэй, 7,1% нь гэмтэлгүй байна.
3. Амьдын үеийн гэмтлийн хамгийн их хувийг самны (56,2%) болон хачигны (37,8%) гэсэн 2 төрлийн гэмтэл нийт гэмтлийн 94,0%-ийг эзэлж байна.
4. Судалгаанд хамрагдсан арьсны гэмтлийг талбайн ангиллаар авч үзвэл жижиг талбайтай арьсан дээр хамгийн их буюу 28,1% нь хачигны, харин том талбайтай арьсан дээр самны гэмтэл хамгийн их буюу 21,5%-ийг тус тус эзэлж байна.
5. Жижиг талбайтай арьсны самны гэмтэл дунд болон том талбайтай арьсны самны гэмтлээс 6,1-7,2%-иар бага байна. [3]



1.5 Хонь, ямааны арьсны нядалгааны үеийн гэмтлийн судалгаа

Улаанбаатар хотын СХД-ийн Эмээлт дэх түүхий эдийн захад байрлалтай Спарк кашмир ХХК /Spark cashmere LLC/ -ийн агуулахад ямааны 1076 ширхэг, Их зам транс ХХК-ийн задгай талбайд хонины 1051 ширхэг арьсанд нядалгааны үеийн гэмтлийг тодорхойлох судалгааг хийв.

“Арьс ширэн түүхий эдийн гэмтлийн нэр томъёо, тодорхойлолт” MNS 3121:2013 стандартын 5.2-т нядалгааны үеийн гэмтлийн нэр томъёо, тодорхойлолтыг хүснэгтэд заасны дагуу гэмтлийн дийлэнх хувийг эзэлдэг уранхай, цоорхой, эсгэлт, шар махны гэмтлүүдийг судалгаанд хамруулав. Нядалгааны үеийн бусад гэмтлүүд болох арьсны өнгө улайлт, нуранхайдалт, шар махны бохирдолт, хэлбэрээ алдсан арьс, хэт сунгалтын гэмтэл зэрэг гэмтлүүд өвлийн улиралд бэлтгэгдсэн арьс байгаа учраас гарахгүй гэж тооцсон.

Ямаа, хонины арьс бүрийг дэлгэн, шар махан тал дээр нь харааны эрхтэнээр шалгаж гэмтлийг тоолох аргаар тодорхойлсон ба нэг арьсан дээр байгаа гэмтлийг, гэмтлийн төрлөөр нь судалснаас гадна нэг арьсан дээр байгаа нэг төрлийн гэмтлийн нийт тоог давхардуулж тооцсон болно.

Ямааны арьсны гэмтлийн судалгааг Спарк кашмир ХХК-ийн түүхий эдийн агуулахад хийсэн ба арьсыг шар махан талаар нь хооронд нь хавсран хөлдөөж бэлтгэн цементэн шалан дээр үелүүлэн хураасан байсан. Хавсарсан ямааны арьсыг биеийн хүчээр хуулж арьсны шар махан тал дээр үүссэн гэмтлүүдийг тоолж тэмдэглэн авах зарчмаар судалгааг хийсэн.

Хонины нэхийний судалгааг Их зам транс ХХК-ийн хашаанд задгай хураасан “овоолго” гэж нэрлэж байгаа нэхийн дээр хийв. Нэхийг шар махан талаар нь хооронд хавсран хөлдөөж чанарын хамгаалалт хийсэн байсан. Судалгаа хийх үед гадна орчны температур нэмэх градустай байсан тул хуулахад хялбар байсан бөгөөд хуулсан арьсыг шар махан талаар нь дээш харуулан дэлгэн тавьж гэмтлийг тодорхойлсон.

Судалгааны дүнгээс үзэхэд:

1. Судалгаанд хамрагдсан ямаа болон хонины нийт арьс шар махтай байна.

2. Судалгаанд хамрагдсан 1076 ширхэг ямааны арьсны 76,3% нь нядалгааны үеийн гэмтэлтэй байсан ба уранхайн гэмтэл 12,1%, цоорхойн гэмтэл 20,0%, эсгэлтийн гэмтэл 44,2% буюу нийт гэмтэлтэй арьсны хамгийн их хувийг эзэлж байна.
3. Нэг арьсан дээр хэд хэдэн төрлийн гэмтэл болон ижил төрлийн гэмтэл олноор давхардаж байна. Тухайлбал эсгэлтийн гэмтэлтэй ямааны арьс 476 ширхэг илэрч байхад тэдгээр арьсан дээр үүссэн эсгэлтийн гэмтлийн нийт тоо 978 байна.
4. Хонины нэхий, ямааны арьснаас харьцангуй бага гэмтэлтэй байна. Хонины нэхийний 37,1% нь нядалгааны үеийн, 9,0% нь уранхайн, 13,5% нь эсгэлтийн, 14,6% нь цоорхойн гэмтэлтэй байна.
5. Хонь, ямааны арьсны талбайн хувьд жижиг буюу 40-55 дм² талбайтай, том буюу 85,1 дм²-ээс дээш талбайтай арьсанд дунд буюу 55,1-85,0 дм² талбайтай арьсны гэмтлээс 4-2 дахин бага гэмтэл илэрч байна. [3]

ДҮГНЭЛТ

1. Дэлхийн арьс ширэн түүхий эдийн нөхцөл байдлыг Бангладешийн жишээгээр авч үзвэл одос үхрийн ширэнд шимэгч, цэцэг, шарх, үрчлээ, мэнгэ, зураас, зүсэлтийн шарх, эдгэрэлтийн дараах сорви нь одос үхэрт их хэмжээгээр тохиолддог ба манай адууны хувьд тамганаас өөр амьдын гэмтэл бараг байдаггүй. Судалгаанаас харахад арьс ширний дундаж агуулга A-D 15%, E-F 25%, G-H 30%, HH 12.5%, байгаа бол манай адууны ширний гэмтлийг ашигтай талбайн эзлэх хувиар нь хувилж үзэхэд 1,0% нь хэвийн (A), 2,3% нь бага (B), 76,7% нь дунд (C), 20,0% нь их (D) байгаа нь манай түүхий эдэд хүний нөлөөгөөр үүсгэгддэг гэмтлийн хувь асар өндөр байгааг илтгэж байна. [11]

Хүснэгт 1. Үхэр, ямаа, одос үхрийн ширний гэмтлийн үзүүлэлт /Бангладеш/

Major Cause of Rejection	Cow	Goat	Buffalo
Parasite	10-12%	5-8%	8-10%
Pox	15-18%	3%	5-10%
Wound	8%	-	15-18%
Branding	0.5%	-	2-5%
Growth mark	20%	1-2%	30%
Wrinkle	5%	-	10%
Jam wrinkle	5%	-	5%
Mole	8-10%	2-3%	8-10%
Burning	1-2%	-	-
Scratch	12-13%	1-2%	15-20%
Flay cut	21%	18%	21%
Curing / Hair ship	17%	8-10%	18-20%
Mechanical fault (Rare case)	1-2%	1-2%	1-2%

Эх сурвалж: (*International journal of Scientific & Technology research*, november 2015)

3. Эмээлтийн түүхий эдийн захын агуулахуудад байгаа хонь, ямаа, үхэр, адууны арьс ширэнд түүвэр үзлэг хийх аргаар нядалгааны болон нядалгааны дараах гэмтэл, Улаанбаатар хот дахь гүн боловсруулах үйлдвэрүүдийн хагас боловсруулсан бүтээгдэхүүнд амьд үеийн, нядалгааны үеийн болон нядалгааны дараах гэмтлийг тодорхойлж үзэхэд, адууны ширний амьдын гэмтэл (тамга) 99% , нядалгааны үеийн гэмтэл (эсгэлт, урагдалт, цооролт) 99%, үхрийн ширний амьдын гэмтэл (эврийн сорви, шарх) 20,8%, нядалгааны үеийн гэмтэл 76,4%, хонины арьсны амьдын гэмтэл

(паразит хачиг, хувалз, хамуу, шивээ) 77,2%, нядалгааны үеийн гэмтэл 60,9%, ямааны арьсны амьдын гэмтэл (хачиг, хамуу, шивээ, самны) 92%, нядалгааны үеийн гэмтэл (өвчилтийн) 76,3% байна. Арьс ширний гол гэмтэл болох нядалгааны үеийн гэмтлийг мах боловсруулах үйлдвэрүүд дээр өндөр чанарын зориулалтын хутга, ар хуулагч тоног төхөөрөмж ашиглан, мал нядалж өвчих дадлагыг үйлдвэрийн нийт ажилчдыг хамруулан зохион байгуулснаар 2-3 дахин бууруулах боломжтой. [2]

4. Өлөн гэдсийг нь арьсан дотор нь боосон, цусаар бохирдуулсан, тээвэрлэлтийн үед үүсгэсэн зэрэг гэмтлүүд харьцангуй багассан байгааг дурьдах нь зүйтэй. Энэ нь өвлийн цагт өлөн гэдсийг нь тусд нь авч зардаг, өвлийн улиралд арьсыг тээвэрлэхэд хялбар байлгахад хооронд нь хавсарч хөлдөөдөгтэй холбоотой байна. Цусаар бохирдуулсан болон өлөнг нь дотор нь боосон арьсны судалгаа нь өвлийн улиралд бэлтгэгдсэн арьсан дээр хийгдсэн учир зуны улиралд бэлтгэсэн арьсанд тохиолддог гэмтлүүд илрээгүй байна.
5. Судалгааны дүнгээс харахад арьс ширэн түүхий эдийн амьдын болон нядалгааны үеийн гэмтэл харьцангуй их байгаа нь малчид бэлчээрээ зөв сонгон бэлчээрлүүлдэггүй, хашаа хороогоо ариутгадаггүй, мэл эмнэлгийн үйлчилгээнд технологийн хугацаанд хамрагддаггүй, бойны газрууд шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангагдаагүй, шуллагааны стандартыг барьж ажилладаггүй, тордолт, тээвэрлэлтийн технологийг баримталдаггүй, зохих ёсны боловсрол, туршлага эзэмшээгүй гол нь мал маллагааны зардалд арьс ширний зардал тооцогдож байдгийг ухамсарлаагүйтэй холбоотой байна. [2] Иймээс нэмүү өртгийн сүлжээний оролцогчид болох малчид, завсрын наймаачид, бойны ажилчид, махны үйлдвэрийн ажилтан ажиллагсдыг системтэй сургах, арьс ширэн түүхий эдийн бэлтгэлийн тогтолцоог сайжруулахад чиглэсэн дараах гол арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатайг харуулж байна. Тухайлбал,
 - Арьс ширэн түүхий эдийн гэмтлийг бууруулах, малыг эрүүлжүүлэх талаар төрөөс тодорхой төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, төр, хувийн хэвшил, мэргэжлийн байгууллага, холбоодын оролцоог сайжруулах;
 - Малчид, хоршоод, махны үйлдвэрүүд дээр танхимын болон зайн /телевиз, цахим/ сургалт зохион байгуулж, гэмтлээс шалтгаалан учирч байгаа эдийн засгийн хохирлыг сурталчлан таниулах;
 - Мал нядалгаанд ажиллаж буй ажилчдыг зөв өвчих, хуулах арга технологид сургах, өвчилтийн зориулалтын хутга хэрэглүүлэх;
 - Стандарт шаардлага хангасан махны үйлдвэр, нядалгааны цэгүүдийг орон нутагт байгуулах, тэднийг ар хуулагч төхөөрөмжөөр хангах зэрэг ажлуудыг зохион байгуулах;
 - Арьс ширний мөшгөх тогтолцоог нэвтрүүлэхдээ арьс ширний урамшууллыг уялдуулах, урамшууллыг стандарт шаардлага хангасан мал төхөөрөх үйлдвэр, хоршоодоор олгуулах зохицуулалтыг журамд тусгаж хөшүүрэгдэх зэрэг болно.

IV. ӨРТГИЙН СҮЛЖЭЭНИЙ ШИНЖИЛГЭЭ

Арьс ширний өртгийн сүлжээний ширжилгээг хийхдээ дотооддоо нэмүү өртөг шингээж чадаж байгаа ӨАБНУ-ын үхрийн ширний өртгийн сүлжээний шинжилгээг манай улсын арьс ширний салбартай харьцуулах байдлаар ханган нийлүүлэлтийн сүлжээн дэх доголдлыг тодорхойлов.

Зураг 7-д үзүүлснээр бодлогын түвшинд ӨАБНУ-ын өртгийн сүлжээ нь түүхий эд бэлтгэлээс бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэн экспортлох хүртэл харьцангуй зөв дүр зурагтай буюу дийлэнх түүхий эдээр автомашины суудлын бүрээс үйлдвэрлэж Герман улсад экспортолж байна. Гэсэн хэдий ч өртгийн сүлжээний түвшинд бага хэмжээний түүхий эдийг импортоор авдаг ба жишээ нь гутал жижиг эдлэлийн зориулалтаар гэхэд Энэтхэгээс 2 сая м2 боловсруулсан арьс импортолжээ.


Тус улс жилд 2,2 сая ш үхрийн түүхий шир бэлтгэдэг ба гар аргаар, чанар муутай бэлдсэн 10 орчим хувь түүхий ширийг экспортолжээ.

Хагас боловсруулсан хөх ширний 25 орчим хувийг экспортод үлдсэн дийлэнх хувийг автомашины эд ангид, бага хэмжээтэйг гутал, жижиг эдлэлийн дотоодын үйлдвэрт нийлүүлж байна.


Голлох экспортын жинг авто суудлын бүрээс, бага хэмжээний дотоодын автомашины зориулалттай үйлдвэрлэл эзэлж байна.

Гэсэн хэдий ч Алс Дорнодоос их хэмжээний арьс ширэн бэлэн бүтээгдэхүүн импортолж валютын урсгалыг гадагш алдаж байгаа дүр зураг харагдаж байна.

Зураг 7. ӨАБНУ-ын үхрийн арьсны өртгийн сүлжээ



Зураг 8. Монголын арьс ширний салбарын өртгийн сүлжээ



Зураг 8-д үзүүлнээс манай улс жилд дор хаяж 14 орчим сая.ш арьс ширний нөөцтэйгээс 200-250 мян.ш адууны арьс түүхийгээр, бог малын махыг арьстай нь дулааны аргаар боловсруулж экспортолж байна.

Түүхийгээр экспортлох боломжгүй үхэр, хонь, ямааны арьс хагас боловсруулсан байдлаар БНХАУ, БНТУ зэрэг улсуудад нийлүүлж байна. Үүнээс жилд дунджаар 27 орчим тэрбум төгрөгийн борлуулалтыг хийж үлдсэн дийлэнх арьс ширийг хаяж байна.

Гүйцэд боловсруулсан арьс ширний хувьд гутал, хувцас, жижиг эдлэлийн зориулалтаар боловсруулж бага хэмжээний экспортыг Англи, Турк, Итали улсруу хийж байна. Үүний хажуугаар БНХАУ, Солонгосоос их хэмжээний хагас болон гүйцэд боловсруулсан арьс ширийг импортолж байна.

Бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хувьд цэрэг, цагдаагийн болон тендерийн дүрэмт хувцас, дотоодын жижиг зах зээлд борлуулах нэхий дээл хувцас, савхин хувцас, жижиг эдлэл үйлдвэрлэж бага хэмжээний экспортыг Япон, БНХАУ, Казакстан улсруу экспортолдог.

Иргэдэд чиглэсэн арьс ширэн бэлэн бүтээгдэхүүний хэрэглээ 98 хувь импортоос хамааралтай байгаа дүр зураг ажиглагдаж байгаа нь төрийн бодлого гэлтгүй өртгийн сүлжээн оролцогчдын чадавхитай шууд хамааралтай гэж дүгнэж болохоор байна. Үүнд хүний нөөцийн чадвар, дэд бүтцийн доройтол, техник технологи эзэмшсэн байдал, зах зээлийн эрэлт гэх мэт олон хүчин зүйлс нөлөөлж байна.

V. МӨШГӨХ СИСТЕМИЙН ТУРШИЛТ


ТУРШИЛТ 1. "Малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний нэмүү өртгийн сүлжээ, мөшгих тогтолцооны загвар арга хэмжээ" 2018 он

Манай улсад мөшгөх системийн туршилтыг анх 2018 онд "Малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний нэмүү өртгийн сүлжээ, мөшгих тогтолцооны загвар арга хэмжээ" нэртэйгээр ХХААХҮЯ, МЭЕГ, ХААБ, МХЕГ, НЗДТГ, Нийслэлийн ХХААГ, ДЦС-4 ТӨХК, 58 дугаар сургууль зэрэг төрийн байгууллагууд, ШХА НАМЭС төсөл, НҮБ-ын ХХААБ-ын SECIM 2 зэрэг олон улсын байгууллага, Монголын махны холбоо, Арьс ширний үйлдвэрлэлийн холбоо зэрэг мэргэжлийн холбоод, Мах импекс ХК, Мах маркет ХХК, Эрдмийт ХХК, Дархан мийт фүүд ХХК, Булган мах маркет ХХК, Баяндэлгэр хүнс ХХК, Хатант интернэшнл ХХК, Дархан нэхий ХК, Номадс сүлжээ ресторан, И-март сүлжээ дэлгүүр, Номин их дэлгүүр, Лавай зах, Гүүд прайс сүлжээ дэлгүүр зэрэг аж ахуйн нэгжүүд хамтран зохион байгуулсан.

Туршилтын үед арьс ширэн түүхий эд бэлтгэлийн үед тулгамдсан асуудлууд, мөшгөх системийг нэвтрүүлэх үеийн саад бэрхшээлийг тодруулах уулзалт хийж, чанарын судалгаа авсан ба оролцогчдын хувьд бүрэн дэмжиж санал онолоо хуваалцсан.

Мөшгөх системийн сургалт болон бусад үйл ажиллагааны үр дүнд нядалгааны үеийн гэмтэл 15% болж буурсан талаар МАШҮХ ТББ-аас мэдэгдсэн. Дархан мийт фүүд ХХК-ийн захирал н.Энхбаатар "Мал төхөөрөгч, арьс шир бэлтгэгчдийнхээ цалинг нэмэгдүүлж хариуцлагажуулах, Дархан, Сэлэнгийн бүх малыг ээмэгжүүлэх зардлыг ААН-ээс шийдвэрлэх саналыг хэлж, мах экспортлоход мөшгөх системийн үр өгөөжийг өндрөөр үнэлж байсныг онцлон тэмдэглэх нь зүйтэй.

Зураг 9. Туршилт 1. Хэрэглэгчид гар утсан дээр махны гарал үүсэл, бэлтгэгдсэн огноо, эрүүл ахуйн мэдээлэл харагдаж байна



ТУРШИЛТ 2. "Арьс ширэн түүхий эд, бүтээгдэхүүний нэмүү өртгийн сүлжээ, мөшгих тогтолцооны загвар арга хэмжээ" 2023

Арьс ширний мөшгөх системийн туршилтыг өмнөх туршилтаар илэрсэн асуудлуудыг шийдвэрлэж техник тоног төхөөрөмж, програм хангамжийн түвшинд хөгжүүлэлт хийж бэлэн болгосноор 2023.04.10-11.30 хүртэлх хугацаанд мал ээмэглэхээс эхлэн арьс ширэн эцсийн бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүртэл бүхий л дамжлагуудыг хамруулан хийж гүйцэтгэсэн.

Өмнөх туршилтын үйл ажиллагааг бодвол илүү цомхон хүрээнд ХХААХҮЯ, ХХААХҮСХТ, МЭЕГ, ХААБ зэрэг төрийн байгууллагууд, Дэлхийн банкны Экспортыг дэмжих төсөл зэрэг олон улсын байгууллагууд, Монголын Арьс ширний үйлдвэрлэлийн холбоо төрийн бус байгууллага, Дижитал Медик ХХК, Занаду Разорбак ХХК, Их Эргэлт ХХК, Хүннү Фэйшн ХХК зэрэг аж ахуйн нэгжүүд оролцон зохион байгуулсан.

Туршилтын үр дүн: Энэ удаагийн туршилтад зөвхөн арьс ширний нэмүү өртгийн сүлжээнд оролцогчид хамрагдсан нь илүү мэргэжлийн түвшинд үйл ажиллагаагаа нарийвчлан харах боломжтой байсан.

1. Мөшгөх системийн туршилт тавих ажлыг Занаду разорбак ХХК-ийн Булган аймаг дахь ферм дээр нийт оролцогчдыг хамруулан гүйцэтгэсэн ба системийн бүх үе шатны сургалтыг зохион байгуулсан. Үүний үр дүнд үхрийн ширний нядалгааны үеийн гэмтэл 10 хүрэхгүй хувьд хүрч буурсан нь дэвшүүлсэн таамаглал оновчтой байсныг харуулсан үр дүн байлаа.

2. Тус туршилтын онцлог нь Германы мөшгөх системийн аргын давуу тал болох арьс ширэн дээр лазерын тоног төхөөрөмжийг ашиглан малын ээмэгний мэдээллийг шивэх, шивсэн мэдээлэл гүн боловсруулалтын дараа арьс ширэнд тод үлдэх технологийг ашигласан нь нэн чухал шийдэл байлаа.

3. Арьс ширний мөшгөх системийг нэвтрүүлэхэд урамшууллаар хөшүүрэгдэх тухай санал авахад нийт судалгаанд оролцогчдын 86 хувь нь бүрэн дэмжиж, одоогийн урамшууллын журмыг чанарт чиглүүлж өөрчлөх нь зүйтэй гэсэн саналыг өгсөн.

4. Мөшгөх системийг хэрэгжүүлэхэд шаардлагатай програмын алдааг илрүүлж програм хангамжийг хөгжүүлж хэрэглэгч ашиглахад илүү ойлгомжтой болголоо.

5. БОДЛОГЫН ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

Монгол Улсын арьс ширний үйлдвэрлэлийн салбарт хэрэгжүүлж буй арга хэмжээний талаарх төрийн бодлогын баримт бичгийн судалгаанд өнгөрсөн хугацаанд хэрэгжүүлсэн, одоо хэрэгжүүлж байгаа, ирээдүйд баримтлах бодлогуудыг УИХ, Засгийн газрын тогтоол, хэрэгжүүлэгч байгууллагуудын гаргасан шийдвэрийн хүрээнд судалж зэрэг сөрөг нөлөөллийг тодорхойлов.

- **2012 оноос хойш хэрэгжсэн 24 бодлогын баримт бичигт шинжилгээ хийв.**

/Эерэг нөлөөтэй 14, сөрөг нөлөөтэй 10/

- **2012 оны УИХ-ын 74-р тогтоол, МУЗГ-ын 394-р тогтоол**

Зураг 10. Туршилт 2. Арьс ширний мөшгөх системийн процедур



/2013 оноос 2019 оны хооронд 7 жилийн хугацаанд 67,2 тэрбум төгрөгийг 351,5 мянган малчинд урамшуулал хэлбэрээр олгосон/

Дээрх тогтоол шийдвэрүүдээс арьс ширний салбарын тогтвортой үйлдвэрлэлд эерэг тогтоол, шийдвэр 14 байсан бол бусад тогтоол шийдвэрүүдийн хувьд нүүлгэн шилжүүлэх, хэт өндөр стандарт тогтоосон, технологийн усаар хангах, үйлдвэрлэлийг тогтвортой үйл ажиллагаа явуулах тухай маргааны шинж чанартай шийдвэрүүд байжээ.

Төрөөс арьс ширний салбарыг дэмжихээр олон чухал шийдвэрүүд гарч байсан боловч хэрэгжилтийн байдал хангалтгүй байна. Харин салбарт одоог хүртэл хэрэгжиж байгаа онцгой ач холбогдолтой шийдвэр бол Малчид үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих зарим арга хэмжээний тухай 2012 оны УИХ-ын 74-р тогтоол юм. Тус тогтоол хэрэгжиж эхэлснээс хойш 2019 оныг хүртэлх долоон жилийн хугацаанд нийт 325 мянган малчин, мал бүхий этгээдэд 67,3 тэрбум төгрөгийн урамшууллыг олгосон байна.

Тус тогтоолд:

1. Арьс, ширийг дотооддоо гүн боловсруулах болон түүгээр бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үндэсний үйлдвэрлэгчдэд хөнгөлөлттэй нөхцөлөөр зээл олгоход зориулж 140,4 тэрбум төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 5 жилийн хугацаатай үнэт цаас гарган арилжаалахыг Засгийн газарт зөвшөөрсөн.
2. Малаа гарал үүслийн баталгаажуулалтад хамруулсан малчин, мал бүхий этгээдэд үндэсний боловсруулах үйлдвэрт тушаасан бог малын арьс тутамд 3000 төгрөг, адуу, үхрийн шир тутамд 15000 төгрөгийн урамшуулал олгохоор тогтсон.

“Малчид, үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих зарим арга хэмжээний тухай” УИХ-ын 2012 оны 74 дүгээр тогтоол болон Засгийн газрын 2013 оны 394-р тогтоолын 2-р хавсралтаар баталсан “Үндэсний боловсруулах үйлдвэрт арьс, шир бэлтгэн тушаасан хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгох журам”-ын хэрэгжилтийг шинжилж дүгнэлээ. Үүнд:

Малчдын түвшинд:

- 1.Малыг гарал үүслийн баталгаажуулалтад хамруулах /бүртгэлийн нэгдсэн сан/
Биелэлт: Сумын малын эмчийн гараар бөглөсөн гарал үүслийн бичиг авч байгаа боловч энэ нь экспортын худалдан авагчдын хувьд итгэл төрүүлэхгүй, чадамжгүй байна.
- 2.Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд технологийн хугацаанд нь тогтмол хамруулах, эрүүл болохыг баталгаажуулсан эрүүл мэндийн гэрчилгээ
Биелэлт: Малыг угаалга, тарилга, туулга, хашаа хорооны ариутгал хийхгүй байгаагаас түүхий эдийн амьдын гэмтлийн хувь өндөр байна. Нөгөө талаар мал эмнэлгийн үйлчилгээний төлбөр нь түүхий эд борлуулах ханшнаас өндөр байгаа нь малчдад хөшүүрэг болохгүй байна.
- 3.Арьс, ширийг стандартын дагуу бэлтгэх
Биелэлт: Арьс, ширэн түүхий эдийг стандартын дагуу бэлтгэж хэвшээгүйгээс түүхий эдийн гэмтлийн хэмжээ их байгааг түүхий эдийн гэмтлийн судалгаагаар тодорхойлсон
- 4.Малчдад бэлтгэн нийлүүлсэн түүхий эдийн тоо, чанараар урамшуулал олгох
Биелэлт: 2013 оноос 2019 оны хооронд 7 жилийн хугацаанд 67,2 тэрбум төгрөгийг 351,5 мянган малчинд урамшуулал хэлбэрээр олгосон хэдий ч түүхий эдийн чанар алдагдсан, малчид “арьс ширний урамшуулал авч үзээгүй” тухай мэдэгдэж байсан.

5. Малчдад хөнгөлөлттэй нөхцөлөөр зээл олгох

Биелэлт: Малчдад олгох зээлийн үндэслэл болж чадаагүй

6. Малчдыг хоршиж ажиллах, хоршоо байгуулахыг дэмжих

Биелэлт: 2018 онд ХХААХҮЯ-наас хөдөө аж ахуйн анхан шатны 3020 хоршоодод хийсэн үнэлгээгээр 43,8% нь идэвхгүй гэж дүгнэгдсэн байна. Энэ нь түүхий эдийн урамшуулалд хамрагдах, хоршоог дэмжих дэмжлэг авах зорилгоор байгуулагдсан зохиомол хоршоод гэж хэлж болохоор байна.

Үйлдвэрлэгчдийн түвшинд:

1. Арьс ширийг дотооддоо гүн боловсруулах, бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд зориулж чанарын шаардлага хангасан түүхий эдээр хангах

Биелэлт: Хагас боловсруулсан арьсны тоо 2013 онд 5975,6 мянга, 2018 онд 3486,1 мянга болж буурсан; гүн боловсруулсан арьсны тоо мөн онуудад 694,6 мянгаас 1721,7 мянга болж өссөн байна. Нийлбэр дүнгээр 6670,2 мянгаас 5207,8 мянга болж буурсан байна /МАШҮХ/.

2. Арьс ширийг дотооддоо гүн боловсруулах, бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд зориулж хөнгөлөлттэй зээл олгох

Биелэлт: 2014 онд арьс 140,4 тэрбум төгрөгийн зээлийг баталж 90 гаран тэрбум төгрөгийн зээлийн 94 ААН-үүдэд олгосон ба үйлдвэрүүд технологи, тоног төхөөрөмжөө 80% шинэчилсэн байна

3. Арьс ширний үйлдвэрүүдийг үйлдвэрийн шинэ бүс рүү шилжүүлэх арга хэмжээг 2017 оны 12 дугаар сарын 31-ний дотор үе шаттайгаар зохион байгуулах

Биелэлт: 2020-2030 онд байгуулагдах Эмээлт-Аргалантын шинэ суурьшлын бүсэд Эмээлт ҮТП-г байгуулан, өргөжүүлэн хөгжүүлэхээр төлөвлөгдөж байсан хэдий ч улсаас бодит хөрөнгө оруулалт хийгээгүй шалтгаанаар зогсонги байдалтай байна.

4. МАШҮХ ТББ-ын болон мах бэлтгэлийн төлөөлөгч нь малчдаас худалдан авсан арьс, ширэн түүхий эдэд чанарын тордолт хийх

Биелэлт: Түүхий эдийн тордолт хийх дэд бүтэц бүрэлдээгүй, стандарт мөрдөгддөггүй, эдийн засгийн үр өгөөж муутай тул тордолт хийгддэггүй

5. Гүн боловсруулалт хийж буй үйлдвэрүүдийг тоо, нэрсийг жил бүр олон нийтэд зарласнаар үйлдвэрүүдийг хариуцлагыг дээшлүүлэх

Биелэлт: Тус арга хэмжээг малчдад хүргэх хэмжээнд зохион байгуулдаггүй тул хэрэгжилт сул байна.

АРЬС ШИРНИЙ ЭРГЭН МӨШГӨХ СИСТЕМ, ТҮҮНИЙГ НЭВТРҮҮЛЭХ АРГА ЗАМ

Арьс ширэн түүхий эдийг Герман улс энгийн, найдвартай, нарийвчлалтай, хямд аргаар мөшгөлт хийх боломж бүрдүүлэхийн тулд 10 жилийн хугацаатай төсөл хэрэгжүүлж, боловсруулсан арга зам нь үйлдвэрлэлд нэвтэрсэн. Мөшгөлтийн энэхүү концепц нь дөрвөн үе шат дамжлагатай.

Нэгдүгээрт, махны мөшгөлтийг нядалгааны шугам дахь арьс ширэнд шилжүүлэх. Энэ шатанд малыг ялган таних дахин давтагдашгүй дугаарыг арьс ширэнд буулгах. Үүнд ашиглагдах тоног төхөөрөмж нь харьцангуй өртөг багатай учир нядалгааны газруудад ашиглах боломжтой.

Хоёрдугаарт, мөшгөлт арьс ширэнд шилжсэн эсэхийг нягтлах. Арьсны аль хэсэгт ямар арга замаар буулгах талаар нэлээд олон хувилбараар туршсаны эцэст зооны шугамаас зүүн тийш 15 см, хүзүүний зүүн ирмэгээс доош 15 см-т үүссэн талбайд тэмдэглэгээ хийх нь тохиромжтойг тогтоосон байна. Тэмдэглэгээг 150 ватт хүчдэлтэй нүүрсхүчлийн хийн лазерыг боловсруулан үхэр, матар, могойн арьсанд туршсан ба хонины арьсан дээр туршилт үргэлжилж байна.

Гуравдугаарт, боловсруулалтын үе шатанд кодыг автоматаар унших. Боловсруулах арьс ширний хэмжээ нэмэгдэх хэрээр гараар уншуулах боломж бага учир үүнийг хиймэл оюун ухаанд түшиглэн автоматжуулах гурван үе шаттай цэгийг боловсруулан нэвтрүүлж, патентаар баталгаажуулсан.


Дөрөвдүгээрт, мөшгөлтийн дата, материалын чанарын төвлөрсөн удирдлагын систем. Төгсгөлийн үе шатанд илэрсэн мэдээлэл дээр тулгуурлан арьс ширэнд илэрсэн гэмтэл, согог, алдааг залруулах арга хэмжээг авах боломж бүрдүүлэх юм (Т.В.Poncet, 2019).

Манай улс мөшгөх системийг ашиглан арьс ширний бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоог шийдвэрлэхдээ Герман улсын туршлага, техник, тоног төхөөрөмжийг ашиглах нь зүйтэй ба ШХА-ийн Ногоон алт-Малын эрүүл мэнд төслийн дэмжлэгтэйгээр Дижитал медик ХХК-ийн хөгжүүлсэн Мал эмнэлгийн ерөнхий газарт ажиллаж буй мөшгөх системийн технологитой уялдаж ажиллуулах шаардлагатай юм.

Арьс ширний мөшгөх системийн програмчлалыг цоо шинээр боловсруулах шаардлагагүй бөгөөд “Мал эмнэлгийн гэрчилгээ” системд нэмэлт модуль хийх замаар шийдвэрлэх нь нэгдүгээрт цаг хугацаа, хоёрдугаарт санхүүгийн хэмнэлтийн өндөр ач холбогдолтой.

"Малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний нэмүү өртгийн сүлжээ, мөшгөх тогтолцооны загвар арга хэмжээ"-г зохион байгуулах үед хэрэгжүүлсэн мах, махан бүтээгдэхүүний мөшгөх системийн үйл ажиллагааны дараалал болон Арьс ширний мөшгөх системийн үйл ажиллагааны дарааллыг дараах хүснэгтээр үзүүлэв. Үндсэн үйл ажиллагааны дарааллын хувьд малчнаас мал төхөөрөх үйлдвэрт малын ээмгэн дэх мэдээллийг QR код болгох хүртэлх бүх процесс ижил байх ба арьс ширнийг махнаас салгамагц арьс шир бэлтгэлийн шугамд шилжих ба ээмэгний кодыг арьс ширний зооны шугамаас зүүн тийш 15 см, хүзүүний зүүн ирмэгээс доош 15 см-т лазераар шивж тэмдэглэгээ хийснээс цааш худалдаанд гарах хүртэлх нийлүүлэлтийн сүлжээний бүх дамжлагад арьс ширний мөшгөх системийн хөгжүүлэлтийг хийх шаардлагатай.

Зураг 11. Мөшгөх системийн үйл ажиллагаа



Судалгааны ажлын хүрээнд зөвхөн арьс ширний гэмтлийг бууруулахад чиглэсэн малчнаас мал төхөөрөх үйлдвэр, мал төхөөрөх үйлдвэрээс арьс шир боловсруулах үйлдвэр хүртэлх нийлүүлэлтийн сүлжээний менежментийг шийдвэрлэхийг зорилго болгосон ба арьс шир боловсруулах үйлдвэрээс хэрэглэгч хүртэлх мөшгөх систем нь дараах зурагт үзүүлсэн байдлаар үргэлжилж нийлүүлэлтийн сүлжээний шат дамжлага бүрд хяналт хэрэгжих болно.

VI. ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

1. Арьс ширний салбарын бодлогын орчны судалгааны хүрээнд хийгдсэн бодлогын баримт бичгийн шинжилгээнээс үзэхэд бодлогыг тогтвортой байлгах хууль эрх зүйг бий болгох, нэмүү өртгийн сүлжээг бүрэн харгалзаж өөр хоорондоо уялдаатай байдлаар төлөвлөж бодлого боловсруулах, бодлогын хэрэгжилтийг өндөр төвшинд зохион байгуулах, байнгын хяналт, идэвхжүүлэлт, сурталчилгааг хийснээр нэмүү өртгийн сүлжээнд оролцогчдын үйл ажиллагааг дэмжих, арьс ширний мөшгөх тогтолцоог бодлогоор дэмжиж бий болгох, төрийн оновчтой дэмжлэгээр ханган нийлүүлэлтийн сүлжээг хөгжүүлэх бүрэн боломжтой байна.

2. Арьс ширний салбарын өртгийн сүлжээний судалгаагаар манай үйлдвэрлэлийн үнэн бодит дүр төрхийг илрүүлсэн ба нийлүүлэлтийн сүлжээний шинжилгээг жил бүр хийж төрийн бодлогын шийдвэрүүдийг гаргах, дэмжлэгийг чиглүүлэх, хянах, дүгнэх байдлаар арьс ширний ханган нийлүүлэлтийн кластерийг хөгжүүлэхэд мөшгөх систем нь гол үүрэг гүйцэтгэнэ.
3. Арьс ширний гэмтлийн хувьд нэмүү өртгийн сүлжээнд оролцогч малчдын буруутай үйл ажиллагаанаас үүдэлтэй малын амьд үеийн паразитын гэмтэл (хачиг, хувалз, хамуу, шивээ) мал төхөөрөх үйлдвэр, цэгийн буруутай үйл ажиллагаанаас үүдэлтэй нядалгааны үеийн гэмтэл зонхилох хувийг эзэлж байгаа тул малчид малын амьд үеийн гэмтлээс хамгаалах зорилгоор хашаа хороогоо ариутгах, тарилга туулга, угаалганд малаа оруулж хэвших, төхөөрөх үйлдвэр, бойны газрууд ар хуулагч төхөөрөмжөөр хангагдах, гэмтэлгүй бэлтгэх талаар ажилчдыг чадавхижуулах шаардлагатай. Ингэснээр мал төхөөрөх үйлдвэрүүд малчдаас гэмтэлгүй арьстай малыг авч урамшууллыг олгох, урамшуулал олгосон арьс ширнийг гэмтэлгүй бэлтгэж арьс ширний үйлдвэрт нийлүүлэх хариуцлага үүрэх боломжтой.
4. Энэхүү сөрөг нөлөөллийг бууруулахад шаардлагатай сургалт, мэдээлэл, сурталчилгаагаар хангах, мөшгөх системд оролцох хөшүүргийг бий болгосноор гэмтлийг бууруулахад чухал үүрэг гүйцэтгэнэ гэж дүгнэж байна.
5. Дэлхий дахинд өрнөж буй аж үйлдвэрийн 4 дүгээр хувьсгал, цахим засаглалын ололттой талыг ашиглан бэлчээрийн мал аж ахуй бүхий өөрийн орны онцлогийг тусгасан байдлаар арьс ширний мөшгөх тогтолцоог нэвтрүүлснээр арьс ширэн түүхий эдийн гэмтлийг бууруулах, үнэ цэнийн гинжин хэлхээний тоглогчдын ашигт ажиллагааг нэмэгдүүлэх бүрэн боломжтой байна.
6. Мөшгөх систем нь салбарын эрдэмтдийн үзэж буйгаар хяналтын систем гэхээс илүүтэй хариуцлагын тогтолцоо, үйлдвэрлэлийн үр ашгийг мэдэгдэхүйц нэмэгдүүлэх боломжийг олгох, худалдан авагчийн итгэлийг хүлээх боломжийг олгох юм.
7. Энэхүү судалгааны ажлын үр дүнд Монгол Улс арьс ширний салбартаа мөшгөх системийг төрийн зохистой дэмжлэгтэйгээр нэвтрүүлэхдээ хууль эрх зүйн орчныг уялдаатай хөгжүүлж, нэмүү өртгийн сүлжээнд оролцогчдыг хариуцлагажуулснаар арьс ширэн түүхий эд бэлтгэлийн тогтолцоог сайжруулж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх боломжтой ба улсын эдийн засгийг сайжруулан үр ашгийг хүртэхэд томоохон түлхэц болно гэдэгт эргэлзэхгүй байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ


- [1] НҮБ-ийн Аж үйлдвэрийн хөгжлийн байгууллага, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, МАШҮХолбоо Иван Крал, Али Бадарнех, Г. Мөнхболор, *Арьс ширний бэлтгэлийн чанар сайжруулах нь: Ар хуулах (SFF) төхөөрөмж турших, гэрээт ажлын тайлан-2020 (Хуудас 4, 14)*
- [2] *Монгол улсад хөдөлмөр эрхлэлтийг дэмжих /SECIM/ төслийн хүрээнд Монголын арьс ширний үйлдвэрлэлийн холбоо хамтран ажиллаж байгаа ажлын эцсийн тайлан 4, 5*
- [3] *“Арьс ширэн түүхий эдийн гэмтлийн нэр томъёо, тодорхойлолт” MNS 3121:2013 стандарт*
- [4] *“Боловсруулаагүй арьс шир” Техникийн шаардлага MNS 0060:2013*
- [5] *Арьс ширэн түүхий эдийн гэмтлийн судалгааны тайлан ХХААХҮСХТ 2022*

- [6] ХХААХҮЯ "Малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний нэмүү өртгийн сүлжээ, мөшигх тогтолцооны загвар арга хэмжээ" тайлан 2018 он
- [7] ХХААХҮЯ, ХХААХҮСХТ "Арьс ширэн түүхий эд, бүтээгдэхүүний нэмүү өртгийн сүлжээ, мөшигх тогтолцооны загвар арга хэмжээ" тайлан 2023 он
- [8] Cheng, Changxiu & Jiang, Ping & Liu, Junhua. (2013). *A Common Traceability Method for Agricultural Products Based on Data Center* 1269-1273. 10.1166/sl.2013.2847.
- [9] Prashar D., Jha N., Jha S., Lee Y., Joshi G. P. Blockchain-based traceability and visibility for agricultural products: a decentralized way of ensuring food safety in India. *Sustainability* . 2020;12(8):p. 3497. doi: 10.3390/su12083497.
- [10] Changxiu Cheng, Ping Jiang, and Junhua Liu *A Common Traceability Method for Agricultural Products Based on Data Center*
- [11] Md.Farhad Ali, Umme Habiba Bodrun Naher, Md.Mahamudul Hasan, Md.Shakil Nawze, Shahanama Ferdous *Analyzing The Factors For Rejection Of Leather In Bangladesh. International journal of scientific & technology research volume 4, issue 11, november 2015*
- [12] АНУ-ын Азийн Сан Монгол болон IRIM Судалгааны Хүрээлэн *Монгол дахь арьс ширний үйлдвэрлэлийн судалгаа, IRIM Судалгааны Хүрээлэн Тайлан 2017/2018 хуудас 41*
- [13] DGVI of the European Commission *FAIR Project Improving Hide and Skin Qualitya project report Available: <https://leathercouncil.org>*

SPSIRPA FORUM 2024

Session 9-5

Mongolia's human resource policy in the forest
sector – prospects



Монгол Улсын Ойн Салбарын хүний нөөцийн бодлого-ирээдүйн төлөв

Абстракт: Хүний нөөцийн бодлого нь төлөвлөлт, хамрах хүрээ, ажиллах хүчний үнэлгээ, харьцуулалт, хүний нөөцийн бодлогын хэм хэмжээг тодорхойлох, байгууллагын өнөөгийн ба ирээдүйн стратегийн зорилтуудтай холбогдсон үйл явц¹. Хүний нөөцийн стратегийн бодлого ба төлөвлөлт байгууллагын стратегид нийцүүлсэн, тодорхой хугацааг хамарсан ажиллах хүчний төлөвлөлтийг тусгасан бодлогын баримт бичиг юм.

Хүний нөөцийн удирдлагын чиг үүрэг нь байгууллагын болон салбарын өсөлт, хөгжил төдийгүй улс орны түвшинд хүмүүн капиталын нөөцийг оновчтой удирдахад чухал ач холбогдолтой. Монгол Улсын Ойн салбарын хүний нөөцийн бодлогыг оновчтой болгоход салбарын хүний нөөцийн бодлогын хүрээнд ажил эрхлэлт ба сургалтын үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах нь чухал.

Ойн салбарт хамаарал бүхий бодлого, үндэсний хөтөлбөр болон үйл ажиллагааны төлөвлөгөөнүүд:

- 2021-2050 “Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого
- Үндсэн бодлогын бичиг баримт болгон ашигладаг (e.g. in the Gobi region)
- 2021-2024 Монгол улсын засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр
- 2010-2023 Хөрс хамгаалах, газрын доройтлыг бууруулах үндэсний хөтөлбөр
- 2015-2025 Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөр
- Саяхан хүчингүй болсон бодлого, хөтөлбөрүүд /2021 онд цуцалсан /:
- 2014-2030 Ногоон хөгжлийн бодлого,
- Төрөөс экологийн талаар баримтлах бодлого
- 2021-2025 REDD+ REDD+ Үндэсний стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөө
- 2005-2035 Ногоон хэрэм үндэсний хөтөлбөр
- Саяхан хүчингүй болсон бодлого, хөтөлбөрүүд /2021 онд цуцалсан/:
- 2015-2030 Төрөөс ойн талаар баримтлах бодлого
- Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр зэрэг олон чухал баримт

бичиг хөтөлбөрүүд хэрэгжихээр төлөвлөгдөж байгаа боловч ойн салбарын 2021 онд хүчингүй болсон эрх зүйн баримт бичгүүдэд тус салбарын хүний нөөцийн бодлогыг оновчтой тодорхой тусгаагүй орхигдуулсан байсан нь хэвээрээ байна.

Энэхүү илтгэлд МУ-н ойн салбарын хүний нөөцийн бодлогыг боловсронгуй болгох асуудлын талаар илтгэх болно.

(Түлхүүр үг: Ойн салбарын хүний нөөц, бодлого, сургалт, хөтөлбөр, ирээдүй)

Илтгэл

Хүний нөөцийн бодлого нь төлөвлөлт, хамрах хүрээ, ажиллах хүчний үнэлгээ, харьцуулалт, хүний нөөцийн бодлогын хэм хэмжээг тодорхойлох, байгууллагын өнөөгийн ба ирээдүйн стратегийн зорилтуудтай холбогдсон үйл явц. Бодлого төлөвлөлт нь байгууллагын төлөвлөлтийн мөчлөгтэй уялдсан тодорхой хугацааг хамрах ба ажиллах хүчний стратеги төлөвлөлттэй холбоотой мэдээлэл цуглуулах, шинжилгээ хийх, тайлагнахад чиглэсэн үйл ажиллагаа юм. Хүний нөөц, хүмүүн капиталын стратегийн бодлого ба төлөвлөлт байгууллагын стратегид нийцүүлсэн, тодорхой хугацааг хамарсан ажиллах хүчний төлөвлөлтийг тусгасан бодлогын баримт бичиг юм.

ХНУ-ын чиг үүрэг нь байгууллагуудын өсөлт, хөгжил, хүмүүн капиталын оновчтой удирдахад чухал ач холбогдолтой. Хүмүүн капиталын хөрөнгө оруулалт нь хүний нөөцийн бодлогын үндсэн үзүүлэлт тул технологи, хөрөнгө оруулалтад нийгмийн хөгжил, дэвшил, байгууллагын хэмжээ, хүний нөөцийн онцлог, авьяасын чадварын санг харгалзан үздэг онцлогтой.

Хүний нөөцийн бодлого, төлөвлөлтөд байгууллагын онцлог, алсын хараа, эрхэм зорилго, хөрөнгө оруулалт, урт хугацааны стратеги, өсөлт хөгжил, зохион байгуулалт, цалин, урамшууллын менежментийн систем, хүний нөөцийн бүтэц, зохион байгуулалт, техник технологийн дэвшил, эрх зүйн орчин, гадаад, дотоод орчны нөлөөллийг нарийвчлан тооцно. Бодлогын стратеги, төлөвлөлтийн үндэс байгууллагын өрсөлдөх чадварыг хадгалах, нэмэгдүүлэхийн тулд хүний нөөцийн хэмжигдэхүүн, оновчтой арга хэрэгслийг ашиглан үр ашгийг нэмэгдүүлэх боломжтой.

Хүний нөөцийн удирдлагын зорилго нь төрийн байгууллага, хүний нөөцийг чадавхыг бэхжүүлэх, хөгжүүлэхээс гадна засгийн газрын урт хугацааны хөгжлийн зорилгод хүрэхэд хүний нөөцийг оновчтой, үр дүнтэй, үр ашигтай уялдуулж зохицуулан удирдах юм. Өргөн утгаараа дараах шинжийг агуулна. Үүнд:

- Хүний нөөцийн стратеги, бодлого, төлөвлөлт, үйл ажиллагаанд нөлөө бүхий субъектүүд (засгийн газар, бусад төрийн байгууллагууд)-тэй харилцах харилцааг оновчтой удирдах,
- Хүний нөөцийн удирдлагын чиг хандлага, өөрчлөлтөд тохирсон төрийн албаны өндөр хариуцлага бүхий соёл, сэтгэлгээний шилжилтийг оновчтой зохицуулах,
- Засгийн газрын стратеги төлөвлөгөө, алсын хараа, хөгжлийн бодлогын зарчимд нийцсэн нийгэм, эдийн засгийн өөрчлөлтөд хувь нэмэр оруулах мэргэжлийн, чадварлаг төрийн албыг бүрдүүлэх, тогтвортой байлгах, сургах хөгжүүлэх,
- Албан хаагчдыг дасан зохицох, нөхцөл байдлыг өөрчлөлтөд хариу үйлдэл үзүүлэх чадвартай, өндөр түвшний мэргэжлийн, мэргэшсэн, шударга, хүний нөөцийн тогтолцоогоор дэмжих, хөгжүүлэх зэрэг болно.

Ойн салбарын хүний нөөцийн бодлого нь засгийн газрын стратеги төлөвлөгөө, хөгжлийн бодлогыг төлөвлөх, хэрэгжүүлэх, үр дүнтэй, уялдаатай зохион байгуулахад төрийн хүний нөөцийг оновчтой, инновацлаг зохицуулан удирдана. Улс орны хүмүүн капитал, хүний нөөцийн удирдлагыг орчин үеийн чиг хандлагаар удирдах, зохион байгуулах системтэй цогц үйл ажиллагаа төрийн хүний нөөцийг бүрдүүлэх, сонгон шалгаруулах, сургаж хөгжүүлэх, хадгалах, сэдэлжүүлэх, нийгмийн баталгааг хангахад оршино.

Хүний нөөцийн төлөвлөлт нь байгууллагын хүмүүн капиталтай холбоотой байгууллагын эрэлт, хэрэгцээнд шинжлэх ухааны үндэслэлтэй судалгаа, дүн шинжилгээ хийн тодорхойлох, төлөвлөх дэс дараатай цогц үйл ажиллагаа. Энэхүү цогц үйл ажиллагааны үйл явц нь ирээдүйн байр сууриа бэхжүүлэх зорилготой бүтцийн болон хөгжлийн өөрчлөлтөд бэлэн байх боломжийг олгох, байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлж буй гадаад, дотоод орчны одоо ба ирээдүйн нөлөөллийг мэдээлэх удирдахуйн ухаан.

Байгууллагын үйл ажиллагааны одоогийн байдал, цаашдын чиг хандлага, үйл ажиллагаа нь ирээдүйд тасралтгүй өсөх хандлагатай, амжилттай үед хүний нөөцийн хэрэгцээ шаардлага их байна гэсэн утгыг илэрхийлнэ. Харин үйл ажиллагаа нь зогсонги, одоо байгаа хүний нөөцөө багасгах хандлагыг илэрхийлсэн үзүүлэлт нь байгууллагын үр ашиггүй, амжилтгүй байгааг илэрхийлнэ.

МУ-н ойн салбарын хүний нөөцийн удирдлагын онцлог, төрийн албаны тогтолцоо, онцлогоос шалтгаалж төрийн албаны хүний нөөцийн удирдлагын зорилгыг системтэйгээр хөгжүүлэхэд оршино. Хүний нөөцийн удирдлага нь байгууллагын үйл ажиллагааны үр дүн, чадавхад нөлөөлөх бодлого, хөтөлбөр, журмыг боловсруулж хэрэгжүүлэхэд чиглэсэн удирдлагын арга, аргачлал. Удирдахуйн шинжлэх ухааны үүднээс хүний нөөцийн удирдлага нь байгууллагын стратегийг дэмжих зорилго бүхий хүний нөөцийн нэгдсэн бодлогыг бий болгоход оршино.

Хүний нөөцийн удирдлага нь байгууллагад хүний нөөц бүрдүүлэх үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, хянах, удирдахаас гадна байгууллагын хүрээнд сонгон шалгаруулалт, сургалт, карьер, зохион байгуулалтыг хөгжүүлэх санаачлагыг хэрэгжүүлэх үүргийг давхар агуулдаг.

Хүний нөөцийн удирдлагын зорилго нь тэдний Монгол Улсын төсвөөс ойн ашиглалт, хамгаалалт, нөхөн сэргээх үйл ажиллагаанд зориулж 2022 онд 0.3 тэрбум төгрөг, 2023 онд 14 тэрбум төгрөг зарцуулсан бөгөөд, 2024 онд 45.1 тэрбум төгрөг болж нэмэгдсэн. Улсын төсвөөс санхүүждэг ойн ангийн үйл ажиллагаанд (аж ахуйн нэгж) энэхүү санхүүжилтийн хэмжээ нь хүрэлцэхгүй байгаа нь дараах байдлаар тайлбарлагдана. Үүнд:

- Цөөн тооны мэргэжлийн ур чадвартай хүмүүс ойн ангийн үйл ажиллагааг эрхэлдэг
- Хууль тогтоомжуудаар зохицуулагдах үүрэг хариуцлагыг хэрэгжүүлэх хүний нөөцийн чадавх сул
- Гүйцэтгэл, ур чадвар сайжруулах идэвхжүүлэлтийн систем сул
- Үйл ажиллагаа явуулахад санхүүжилт дутмаг (тухайлбал шинэ бүтээгдэхүүн, технологид шаардлагатай хөрөнгө оруулалт дутмаг)
- Засаглалын стандартад суурилсан үйл ажиллагааг ил тод явуулах сонирхол бага
- Холбогдох байгууллагуудаас ойн ангийн үйл ажиллагаанд хяналт, үнэлгээ хийх арга ажиллагаа, үйл явцын уялдаа хангалттай бус зэргийг нэрлэж болно.

Төсвөөс санхүүждэг ойн байгууллагын бизнесийн чадавхыг бэхжүүлэхэд тухайн салбарт ажиллагсдын тоо, мэргэжлийн чадавхад анхаарах хэрэгтэй. Мөн байгууллагын тогтолцоог сайжруулахад тодорхой хэмжээний хөрөнгө оруулалт шаардлагатай нь ойлгомжтой.

Сүүлийн гурван жилийн хугацаанд ойн үйл ажиллагаа эрхэлж байгаа байгууллагуудад улс орон нутгийн төсвөөс (улс болон орон нутгийн түвшинд) оруулсан хөрөнгө оруулалтаас дүгнэхэд тус салбарт бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлтийг хэрэгжүүлэх шаардлагатай нь харагдаж байна. Энэхүү өөрчлөлтийг хэрэгжүүлэхэд

санхүүжилтийн бодит хэрэгцээг тодорхойлох шаардлагатай. Хөрөнгө оруулалтын сан, бизнес-эхлэлийн-капитал нь бизнесийн болон бизнесийн тогтвортой нөхцөлийг бүрдүүлэн хөгжүүлэх үндсэн нөхцөл болно.

Ойн салбарт бизнес хөгжүүлэх зээлийн боломж, зэрэглэлийг сайжруулахад дотоодын болон олон улсын эх үүсвэрээс хөрөнгө оруулалтыг шийдэхэд анхаарах хэрэгтэй. Өөр нэг чухал боломж нь ойн салбарыг хөгжүүлэхэд банк, санхүүгийн бусад байгууллагуудтай хамтран ажиллах явдал юм. Үйл ажиллагааны чиг үүргүүдийг цогц байдлаар сайжруулах шаардлагатай. Үүний тулд “ISO 9001:2015¹” чанарын удирдлагын стандарт, үйл явцын менежментийг нэвтрүүлэх хэрэгтэй. Энэ нь бизнесийн төлөвлөлт, стратегийн хөгжил, хүний нөөцийн удирдлага, санхүүгийн удирдлага, эрүүл ахуй, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, худалдан авах үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын төлөвлөлт зэрэг үндсэн үйл ажиллагааг сайжруулах нөхцөл болно.

Санхүүгийн болон стратегийн менежментийг боловсронгуй болгох нь ойн салбарын удирдлага, төлөвлөлтийг мэргэжлийн түвшинд хүргэж (дунд болон урт хугацаан дахь үйл ажиллагааны төлөвлөлт) ашиг орлогыг нэмэгдүүлнэ. Түүнчлэн ойн салбарын инновацийг хөгжүүлэх, тухайлбал сайжруулсан үр, нөхөн сэргээгдэх материалын үйлдвэрлэл зэрэг нь ойн аж ахуйн нэгжүүдийн сонирхлыг татна. Ингэснээр орлогын эх үүсвэрүүдийг нэмэгдүүлэх боломжтой.

Зах зээлийн судалгаа хийн бүтээгдэхүүн, шинэ бүтээгдэхүүнийг бий болгон, тэдгээрийн чанарт онцгой анхаарал хандуулах шаардлагатай. Зах зээлийн өргөтгөл, шинэ болон сайжруулсан бүтээгдэхүүн, ойн аж ахуйгаас ашиг хүртэгчид болон менежерүүд орлогын шинэ эх үүсвэрүүд бий болж, ойн үйл ажиллагаанаас нэмүү өртөг олох боломжтой.

Эцэст нь хэлэхэд, ойн салбарын санхүүжилтийн үндэсний стратегийг боловсруулах хэрэгтэй. Энэ нь санхүүгийн зарцуулалт, тавигдах шаардлагууд, санхүүжилтийн хэрэгцээний талаар тодорхой ойлголт өгөх болно. Санхүүжилтийн стратеги нь санхүүгийн төлөвлөгөө, төсвийн төлөвлөлтийг тусгадаг. Энэ нь ойн сангийн үйл ажиллагааны менежмент, бүтцийн өөрчлөлтийг улсын төсвөөс шууд санхүүжүүлдэг механизмтай холбогддог. Санхүүжилтийн стратеги нь олон янзын үйл ажиллагааны хөрөнгийн зохицуулалтыг тодорхойлох төдийгүй санхүүжилтийн хамгийн оновчтой эх үүсвэрийг олж тогтоох, ойн салбарын оновчтой менежментийн үр дүнд санхүүгийн бэрхшээлийг даван туулах шаардлагатай бусад арга хэмжээг тодорхойлоход тусална.

Хүний нөөцийн үйл ажиллагаа, үр ашгийг оновчтой болгох замаар байгууллагын ажилтнуудыг үнэ цэнэтэй нөөц хэмээн үзэж ажилтнуудын бүтээмжийг нэмэгдүүлэх, нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх, байгууллага болон ажилтнуудын оролцоо, ур чадвар, авьяас, үнэ цэнийг стратегийн зорилго, зорилтуудад системтэй ашиглахад оршино.

Ойн салбарын тогтвортой менежментийг хэрэгжүүлэхэд ойн салбарын хүний нөөцийн бодлогын хүрээнд ажил эрхлэлт ба сургалтын үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах нь чухал.

234 орныг хамруулсан Дэлхийн ойн нөөцийн үнэлгээ 2015¹²-д тусгаснаар, ойн нөөц бүхий газрын хэмжээ 1990 онд 4128 сая га байснаас 2015 онд 3999 сая га-д хүрч буурсан үзүүлэлттэй байна. Дэлхийн хэмжээнд ойгоор бүрхсэн газрын хэмжээ 1990 онд нийт газар нутгийн 31.6%, 2015 онд 30.6% эзэлж буурсан үзүүлэлттэй байна.

Ойн салбарт нийт 13.7 сая ажиллагсад ажиллаж байгаа нь нийт ажиллах хүчний нэг хувийг, ойн салбараас олох орлого ДНБ-ний 0.4%-г тус тус эзэлж байна¹⁴. Ойн салбарын ажиллагсдын тоо хэмжээ, цар хүрээ их өргөн ба орон тооны бус ажиллагсад энэ салбарт ихээр ажилладаг. Ялангуяа хөгжиж буй орнуудад энэхүү дүр зураг их ажиглагддаг. Ойн салбар нь орон тооны бус ажиллагсдын тоо их, газар эзэмшлийн маргаантай, зах зээлд дутууунэлэгддэг, ажиллагсад нь нийгмийн хамгааллаас гадуур үлддэг, бага цалин хөлс, ажлын байрны аюулгүй байдал хангагдаагүй зэрэг сул талууд бий. Эдгээрээс үүдэн биологийн олон янз байдал ба экологийн асуудлууд, ажиллагсдын ажиллах орчин нөхцөлтэй холбоотой хүний нөөцийн ба хууль эрх зүйн зохицуулалтууд судлаачдын дунд нэлээдгүй хэлэлцэгддэг. Ойн салбарын энэхүү үзүүлэлтүүд нь тогтвортой хөгжлийн зорилтуудын хүрээнд идэвхтэй судалгаа шинжилгээ хийгдэх шаардлагатайг харуулдаг.

Ойн салбараас хүртэх үр өгөөж нийгмийн тогтвортой хөгжлийн зорилтыг хангахад хувь нэмрээ оруулдаг, үүний зэрэгцээ тогтвортой менежменттэй байснаар хүмүүсийн амьдралын чанар нэмэгдэж, ойн нөөцийг зүй зохистой ашиглах, хамгаалах нөхцөл бүрдэнэ.

Хүснэгт 1. Ойн салбарын ажил эрхлэлт, бүсчлэлээр, 2014 он

Д/д	Бүсчлэл	Нийт (мянган хүнээр)	Өөрчлөлт
1	Ази (48 орон)	9,939	↓
2	Африк (58 орон)	1,109	↑
3	Европ (50 орон)	671	↓
4	Хойд ба Төв Америк (39 орон)	186	↓
5	Далайн эргийн (25 орон)	16	өөрчлөгдө өгүй
6	Өмнөд Америк (14 орон)	734	
7	Нийт	12,655	↓

Эх үүсвэр: Global Forest Resources Assessment 2015 - How are the world's forests changing? х.10 - 11

Дэлхий нийтээр ойн салбарт ажиллаж буй ажиллагсдын тоо 2010 онд буурсан үзүүлэлттэй байна. Ажиллагсдын тоо Ази, Европ, хойд болон төв Америк-т буурсан бол, Африк, өмнөд Америкт өссөн. Ойн салбарын нийт ажиллагсдын 79% нь Азид, тэр дундаа Энэтхэг, Бангладеш, Хятад улсуудад байна. 29 орны харьцуулалтаар¹⁵ Бангладеш, Хятад, Мали улсуудад ойн салбарт ажиллаж буй эмэгтэй ажиллагсдын тоогоор, Мали, Монгол, Бангладеш орнууд эмэгтэйчүүдийн нийт ажиллагсдад эзлэх хувиар тэргүүлж байна.

Ойн салбарын хүний нөөцийн талаарх мэдээлэл дутмаг. Ялангуяа ойн нөөцийн ашиглалтын үзүүлэлтүүдийн тайлан хангалтгүй, ойн ашиглалтад ажиллаж буй хүний нөөцийн мэдээлэл байдаггүй. Ойн салбарын ажил эрхлэлтийн үзүүлэлтүүдийг олон

улсын хэмжээнд ойгоос орлого олдог өөр хоорондоо хамааралтай гурван ангилалд хувааж үздэг¹⁶. Үүнд ойн салбараас амжиргаагаа залгуулдаг хүмүүс; орон тооны бус ажил эрхлэлт; ойн салбарын үндсэн (орон тооны) ажиллагсад багтана.

Ойн салбарын үндсэн (орон тооны) ажиллагсад: хөгжлийн хөтөлбөрүүдэд ойн салбарын ажил эрхлэлтийн үндсэн хэлбэр болох орон тооны ажил эрхлэлтийг тусгасан. Орон тооны ажиллагсад бусад хэлбэрийнажиллагсдаас илүү давуу талтай гэсэн таамаглал байна. Гэхдээ бодит байдал дээр үндсэн (орон тооны) ажил эрхлэлтийн давуу эсэхийг нотлох баримт, мэдээ одоогоор алга байна. Олон хүчин зүйлүүдээс шалтгаалж орон тооны ажиллагсад ядуу, амьжиргааны доод түвшинд байх тохиолдол бий.

Ажил эрхлэлтийн хэлбэрүүдийн давуу болон сул талыг ажиллагсад ажил эрхлэлтийн нөхцөл байдлыг хэрхэн хянаж байгаагаар тодорхойлно. Тухайлбал, орон тооны (цагаач) ажилчдын паспортыг хураан авах, ажлын цагийн хязгаарлалт тавих, хөдөлмөрийн аюулгүйбайдал хангагдаагүй зэрэг тохиолдолд орон тооны ажил эрхлэлт орон тооны бус ажил эрхлэлтээс муу нөхцөлтэй байх талтай. Хувь хүн орон тооны хэлбэрээр ажил эрхлэх эсэх нь дийлэнхдээ тухайн хүний эзэмшсэн боловсрол, хамрагдсан сургалтуудаас шалтгаалдаг.

Сургалтаар аливаа хүн мэдлэг чадвараа нэмэгдүүлдэг тул сургалт хүний нөөцийн хөгжлийнгол цөм байна. Хойд Америк, Европ, Ази, Номхон далай, Латин Америкийн олон их дээд сургуулиуд ойн чиглэлээр сургалт явуулж, мэргэжилтэн бэлтгэдэг. Тэдгээрийг эрэмбэлэн жагсаасан дэлхийн түвшний үзүүлэлтүүдээс тэргүүлэх зэргийн 50 их сургуулиудын 21 нь АНУ-д, 11 нь Европд, 7 нь номхон далайн орнуудад, 5 нь Азид, 3 нь Латин Америкт байна. Ойн салбарын мэргэжлийн боловсрол олгох энэхүү үзүүлэлтээр АНУ тэргүүлж байгаа бөгөөд бэлтгэгдэж буй мэргэжилтнүүд нь ойн менежмент, үйлдвэрлэл, ашиглалт, хамгаалалтын чиглэлээр ихэвчлэн хүний нөөцөө бэлтгэж байна.

Төрийн тогтолцооны, удирдлагын олон шатлал, үйл ажиллагааны хүнд суртал, бюрократ удирдлагын зарчим нь бүх үйл явцыг илүү төвөгтэй болгож, төрийн хүний нөөцийн удирдлага нь үр ашиггүй хэмээх ойлголтод хүргэдэг. Төрийн үйл ажиллагаа нь засгийн газрын стратеги зорилт, тэргүүлэх чиглэлтэй шууд хамааралтай нь бусад байгууллагуудаас ялгагдах онцлог бөгөөд хүний нөөцийн удирдлагын зорилго нь төрийн байгууллага, хүний нөөцийг чадавхыг бэхжүүлэх, хөгжүүлэхээс гадна засгийн газрын урт хугацааны хөгжлийн зорилгод хүрэхэд хүний нөөцийг оновчтой, үр дүнтэй, үр ашигтай уялдуулж зохицуулан удирдах юм. Өргөн утгаараа дараах шинжийг агуулна. Үүнд:

- Хүний нөөцийн стратеги, бодлого, төлөвлөлт, үйл ажиллагаанд нөлөө бүхий субъектүүд (засгийн газар, бусад төрийн байгууллагууд)-тэй харилцах харилцааг оновчтой удирдах,
- Хүний нөөцийн удирдлагын чиг хандлага, өөрчлөлтөд тохирсон төрийн албаны өндөр хариуцлага бүхий соёл, сэтгэлгээний шилжилтийг оновчтой зохицуулах,
- Засгийн газрын стратеги төлөвлөгөө, алсын хараа, хөгжлийн бодлогын зарчимд нийцсэн нийгэм, эдийн засгийн өөрчлөлтөд хувь нэмэр оруулах мэргэжлийн, чадварлаг төрийн албыг бүрдүүлэх, тогтвортой байлгах, сургах хөгжүүлэх,
- Төрийн албан хаагчдыг дасан зохицох, нөхцөл байдлыг өөрчлөлтөд хариу үйлдэл үзүүлэх чадвартай, өндөр түвшний мэргэжлийн, мэргэшсэн, шударга, хүний нөөцийн тогтолцоогоор дэмжих, хөгжүүлэх зэрэг болно.

“Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030”-д тогтвортой хөгжлийн боловсролын талаар тусгагдсан. Үүнд дараах зорилтуудыг дэвшүүлсэн байна:

- I үе шат (2016-2020):
Нийгмийн түншлэл дээр үндэслэн мэргэжлийн боловсрол, сургалтын багшлах боловсон хүчнийг чадваржуулж, техникийн баазыг өргөжүүлж, суралцагчдын тоог 60.0 мянгад хүргэх.
- II үе шат (2021-2025):
Мэргэжлийн боловсрол, сургалтын эрэлтэд нийцсэн тогтолцоог төлөвшүүлж, суралцагчдын тоог нэмэгдүүлэх.
- III үе шат (2026-2030):
Үндэсний ажиллах хүчний хэрэгцээг мэргэжлийн өндөр ур чадвартай ажиллах хүчнээр бүрэн хангах³² зэрэг болно.

Монгол Улс нь нэг хүнд ногдох орлогоороо дунд орлоготой орнуудын тэргүүлэх эгнээнд хүрсэн, тогтвортой өсч байгаа эдийн засгийн олон салбартай, нийгмийн хүрээнд дундаж болон чинээлэг дундаж давхарга давамгайлсан, экологийн тэнцвэртэй байдлыг хадгалсан, тогтвортой ардчилсан засаглалтай улс болох зорилтыг тавьсан. Тогтвортой хөгжлийн зорилго 2030 хүрээнд 2016-2030 онд одоогийн 8,2% ойн нөөц бүхий талбайн хэмжээг 9%-д хүргэх зорилготой.

Ойн тухай тусгагдсан хууль эрх зүйн орчныг Монгол Улсын Үндсэн хууль, холбогдох бусад хууль тогтоомж, УИХ болон ЗГ-н тогтоолууд, Байгаль орчин аялал жуулчлалын яамны сайдын тушаалуудыг авч үзсэн болно³.

Монгол Улсын “Үндсэн хууль”-д:

6.1 Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна;

6.2 Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн өмч мөн;

17. 2. Хөдөлмөрлөх, эрүүл мэндээ хамгаалах, үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх, байгаль орчноо хамгаалах нь иргэн бүрийн журамт үүрэг мөн гэж заажээ.

УИХ, Засгийн газрын тогтоол, БОАЖЯ-ны тушаал, шийдвэрүүд жил тутам нэмэгдсээр байна. Засгийн газраас 2010 оноос хойш хэд хэдэн шийдвэр гаргасан. Үүнд⁴:

- Иргэд, хоршоо, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах журам нь ойн хортой нөлөөллийг бууруулах, дэвшилтэт арга, технологийг нэвтрүүлэх зорилготой⁵;
- Норм, хэм хэмжээ⁶;
- Ойн менежментийн журам⁷;
- Ойн түймрээс урьдчилан сэргийлэх, хохирлыг тооцох журам⁸;
- Ойн цэвэрлэгээний тухай хөтөлбөрүүд⁹;
- Ойн салбараас байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зориулсан орлогын тодорхой хэсгийг хуваарилах журам¹⁰ зэрэг болно.

БОАЖЯ бодлогын түвшинд ойн үйл ажиллагаатай холбоотой ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх болон ой хээрийн түймрээс хамгаалах, байгаль орчны тэнцэл хангах талаар төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах үндсэн үйл ажиллагааг гүйцэтгэнэ. Ойн тухай хуулиар БОАЖЯ болон орон нутгийн засаг захиргаа нь хувийн хэвшлийн ойн аж

ахуйн нэгж, орон нутгийн ойн нөхөрлөлийн бүлгүүдтэй гэрээ байгуулан менежментийн зохицуулалт хийж хамтран ажиллах эрхтэй.

БОАЖЯ: Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээг төлөвлөх, зохион байгуулах, санхүүжүүлэх, таримал ойг үнэлэх, улсын ойн санд худалдан авах, өмчлүүлэх журам; Ойгоос мод бэлтгэх эрхийн бичиг, гарал үүслийн гэрчилгээний загвар, түүнийг олгох журам; Ойн мэргэжлийн байгууллагад тавигдах шаардлага, ажиллах журам; Ойд арчилгаа, цэвэрлэгээ хийх журам; Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийг тогтоох мужлал; Ойн мэдээллийн сангийн бүртгэл, тайлангийн маягт, тэдгээрийг хөтлөх журам; Ойгоос хуш модны самар түүж бэлтгэхийг хориглох тухай; Ойн дагалт баялгийг хамгаалах, зохистой ашиглах журмуудыг¹¹ батлан гаргасан (2-р хавсралтыг үзнэ үү), гэхдээ үүнд сайн дурын байгаль хамгаалагчийг ажиллуулах журам байхгүй. Хууль, эрх зүйн орчны хувьд 1995 онд батлагдсан Байгаль орчныг хамгаалах тухай хууль (Байгаль орчныг хамгаалах тухай Монгол Улсын анхны хууль), 2007 оны 5-р сарын 17- ны өдрийн "Ойн тухай хууль" нь ойн салбарын удирдамж болж байв.

Мөн түүнчлэн Монгол Улсын Улсын Их Хурал ойг хамгаалах, ашиглах, нөхөн сэргээх, ойжуулах талаар төрөөс баримтлах бодлогыг тодорхойлж, ойн сангийн ашиглалтын дээд, доод хэмжээг тогтоох; ой, хээрийн түймрийн талаарх олон улсын гэрээ, хэлэлцээрийг соёрхон батлах буюу хүчингүй болгох эрхтэй¹².

Улсын Их Хурал 2012 оны 5-р сарын 17-нд “Ойн тухай хууль”-ийг шинэчлэн баталсан бөгөөд 2012, 2013, 2015, 2017 онд нэмэлт өөрчлөлт оруулжээ. "Ойн тухай хууль" нь ой, хээрийн түймрийг ойг хамгаалах, нөхөн сэргээх, үржүүлэх, эзэмших, ашиглах, урьдчилан сэргийлэх зохицуулалтын орчинтой холбоотой. Түүнчлэн Засгийн газар; БОАЖЯ; Онцгой байдлын ерөнхий газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар; Орон нутгийн засаг захиргааны нэгж, түүний агентлагууд ойн менежмент, хяналтыг хэрэгжүүлэх үүрэгтэй оролцоно.

Монгол Улсын УИХ-н 2015 оны 5 сарын 14-ний өдрийн 49-р тогтоолоор Төрөөс ойн талаар баримтлах бодлогыг “Монгол Улсын эдийн засаг, нийгэм, байгаль орчны асуудлыг цогцоор нь ногоон хөгжлийн бодлоготой уялдуулан хүний сайн сайхны төлөө ой модны нөөцийг хамгаалах, ашиглах, нөхөн сэргээхтэй холбоотой асуудлаар ирээдүйд гаргах шийдвэр, үйл ажиллагааг чиглүүлсэн, ойн бодлогын зорилго, баримтлах зарчим, хэрэгжүүлэх зорилтыг тодорхойлсон” баримт бичиг бөгөөд баримтлах дараах зарчмыг баталсан:

- ✓ Ойн нөхөн сэргээлт, ойжуулалтын хэмжээг өсгөх замаар ойгоор бүрхэгдсэн талбайг нэмэгдүүлэх;
- ✓ Ойн биологийн олон янз байдлыг хадгалах, хамгаалах;
- ✓ Ойн эрүүл ахуй, амьдрах чадвар болон бүтээмжийг нэмэгдүүлэх;

Ойн экологийн болон эдийн засаг, нийгмийн ач холбогдлыг нэмэгдүүлэх зэрэг болно.

Монгол Улсын ойн салбарын мэргэжилтэн бэлтгэж буй өнөөгийн байдал:

Монгол Улсын ойн салбарын хүний нөөцийг тодорхойлохын тулд хөдөлмөр эрхлэлт, боловсрол, мэргэжлийн сургалт, ур чадварын түвшинг авч үзье. Төрөөс ойн талаар баримтлах бодлогыг Засгийн Газрын 49-р тогтоолд тусгасан байдаг. Үүнд:

- Эрдэм шинжилгээний байгууллага, их, дээд сургуулийн дэргэд ойжуулалт, нөхөн сэргээлт, ой хамгаалал, мод ашиглах, боловсруулах үйлдвэрлэлийн дэвшилтэт технологи боловсруулах, нэвтрүүлэх, дамжуулах нэгж,

инкубаторын төв, өндөр технологийн жижиг, дунд үйлдвэр байгуулахыг төрөөс дэмжих;

- Ойн мэргэжлийн их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн материаллаг баазыг бэхжүүлэх, багш нарын чадавхыг дээшлүүлэх ажилд бүхталын дэмжлэг, туслалцаа үзүүлэх, улмаар ойн мэргэжилтэн, мэргэжлийн ажилтан, ажилчин бэлтгэх шаталсан сургалттай тогтолцоо бий болгох;

Төрөөс ойн талаар баримтлах бодлогын хүрээнд ойн салбарт сургалт, боловсролын чиглэлээр дараах байгууллагууд үйл ажиллагаа явуулж байна. Үүнд:

МУИС, ХААИС, ШУТИС-ийн дэргэдэх сургалт-үйлдвэрлэлийн лаборатори, дендрохнологийн лаборатори, ойн экосистемийн мониторингийн лаборатори; ойн генетик, эко-физиологийн лаборатори; Төв азийн бүсийн түймрийн менежментийн төв; Төв аймаг, Батсүмбэр дэх МУИС-ийн ойн сургалт, судалгааны төв; Төв аймгийн Баянчандмань сумын “ХААИС-ийн мод үржүүлгийн сургалт-судалгаа үйлдвэрлэлийн төв; Сэлэнгэ аймгийн Мандал сумын “ШУТИС-ийн ой модны сургалт, судалгааны хүрээлэнгийн ойжуулалт, мод үржүүлэг, ойн механикжуулалтын хээрийн сургалтын полигон.

Үндэсний ажил мэргэжлийн албан тодорхойлолтод (ҮАМАТ) их дээд сургуульд бэлтгэгдэж буй ойн салбарын хүний нөөц нь ой зүйч, ой судлал, ой судлаач, ойн зөвлөх, ойн аж ахуйн инженер, ойн инженер, механик, ойжуулагч гэсэн мэргэжлүүдээр суралцдаг.

Монгол Улсад 11 их сургууль ойн чиглэлээр мэргэжилтэн бэлтгэж байна. МУИС-д ой судлал, хүрээлэн буй орчин судлал, экологи, байгаль хамгаалах технологи, ойн үйлдвэрлэлийн технологи, ойн аж ахуй, ой зохион байгуулалт, ой үржүүлэг, ой инженерчлэл, зайнаас тандах судалгаа мэргэжлүүдээр боловсрол олгодог бөгөөд энэ нь эрдэм шинжилгээ, судалгааны чиглэл рүү түлхүү чиглэдэг. Харин ШУТИС ойн үйлдвэрлэл, инженерчлэл, ХААИС экологи, байгаль хамгааллын чиглэлд дээд боловсрол олгох сургалттай.

Монгол Улсад ойн чиглэлээр суралцах мэргэжилтнүүдийг БШУЯ-ны тогтоосон квотоор элсүүлдэг. Квотын дагуу жил бүр 450-500 орчим дээд боловсролтой ойн мэргэжилтэн бэлтгэгдэж байна. Төгсөгчдийн ажил эрхлэлтэд сөргөөр нөлөөлж буй шалтгаануудыг дараах байдлаар тодорхойлж болно. Үүнд:

- Ажлын байрны алслагдмал байдал
- Ойн салбарын цалин хөлс, хангамж бага
- Мэргэжлийн чиглэлээр ажил олдохгүй
- Ажлын байрны хүрэлцээ муу
- Тухайн салбарт өрсөлдөөн их
- Ойн салбарын хөдөлмөрийн зах зээл бага

Монгол Улсад одоогийн байдлаар 16 мэргэжлийн сургалтын байгууллага (МСҮТ) ажиллаж, дунд түвшний боловсрол олгож байна. Тэдгээрт ойжуулагч, ой арчилгаа ашиглалтын ажилтан, ойн аж ахуйн ажилтан, ойн нөхөрлөлийн ажилтан гэсэн мэргэжлүүдээр сургадаг.

Ойн салбарын хүний нөөцийн бодлогын үндэсний стратегийг боловсруулах шаардлагатай. Энэ нь санхүүгийн зарцуулалт, тавигдах шаардлагууд, санхүүжилтийн хэрэгцээний талаар тодорхой ойлголт өгөх болно. Санхүүжилтийн стратеги нь

санхүүгийн төлөвлөгөө, төсвийн төлөвлөлтийг тусгадаг. Энэ нь ойн сангийн үйл ажиллагааны менежмент, бүтцийн өөрчлөлтийг улсын төсвөөс шууд санхүүжүүлдэг механизмтай холбогддог. Санхүүжилтийн стратеги нь олон янзын үйл ажиллагааны хөрөнгийн зохицуулалтыг тодорхойлох төдийгүй санхүүжилтийн хамгийн оновчтой эх үүсвэрийг олж тогтоох, ойн салбарын оновчтой менежментийн үр дүнд санхүүгийн бэрхшээлийг даван туулах шаардлагатай бусад арга хэмжээг тодорхойлоход тусална.

Дүгнэлт

Монгол Улсад ойн мэргэжлээр төгсөгчид төрийн байгууллага, төрийн бус байгууллага, хувийн хэвшил, их дээд сургууль, судалгааны байгууллага, олон улсын байгууллага, төсөл хөтөлбөрт ажилладаг. Аймаг нийслэлийн ойн алба, ойн ангиудаас авсан судалгааны үр дүнд ойн ангийн хүний нөөцийн ажлын ачаааллын 50%-г захиргааны ажилд, 20%-г хяналт болон шалтгалтанд, 20%-г ойн нөхөрлөлд зөвлөгөө өгөхөд, үлдсэн 10%-г ойн үндсэн үйл ажиллагаанд зарцуулж байна. Энэ нь ойн салбарт нэгжийн удирдлага, зохион байгуулалтыг хэрэгжүүлж буй төрийн байгууллагуудын ойн үйл ажиллагааны оролцоо чамлалттай байна.

Ойн салбарт ажиллаж буй өнөөгийн ажилтнуудын чадавхид үнэлгээ хийн сургалт, дахинсургалтыг тэдний өдөр тутам хийж гүйцэтгэж буй ажил, тэдний үндсэн эрэлт хэрэгцээнд тулгуурлах нь зүйтэй. Ойн салбарын ажиллагсдад зориулан зохион байгуулагдсан сургалтын сэдвүүдийг авч үзвэл: ажлын байран дахь нарийн мэргэжлийн сургалтын хэрэгцээ их байна хэмээн судалгаанд оролцогсдын 80% хариулсан. Дэвшилтэт технологи нэвтрүүлэх, инноваци шингэсэн шинэ нэр төрлийн бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжин урамшуулах, үр ашигтай, хэмнэлттэй байх зарчмыг баримтлах эдийн засаг, нийгмийн бүх салбарт уялдаатай чанд баримтлах шаардлагатай.

Ашигласан материал²

- Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг/ОНТХИ (INCOSAD) “Монгол Улсын ойн ангийн үйл ажиллагааны өнөөгийн байдал, сайжруулах арга зам” 2017
- HessenForst “Монгол Улсын ойн салбарын мэргэжлийн байгууллагын гэрчилгээ”;; Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн судалгаа 2013
- Development of Administrative Organizational Structure Model Based on an Ongoing Organizational Analysis in the Forest Sector of Mongolia and into Consideration of the MET Concept of Forest Economic Self-Management By Forest User Groups”, GIZ 2017
- Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ойн Стратеги Төлөвлөгөө, 2017-2030
- <http://www.un.org/esa/forests/wp-content/uploads/2016/12/UNSPFAdvUnedited.pdf>
- Тогтвортой хөгжлийн зорилтууд ба ой: НҮБ-ын ЕЭЗК-ийн оролцоо, хэтийн төлөвийн тойм, 2015
- Дэлхийн ойн нөөцийн үнэлгээ 2015 - Дэлхийн ой хэрхэн өөрчлөгдөж байна вэ?, х.21
- ¹UNECE Committee on Forests and the Forest Industry Statement, 2016
- Global Forest Resources Assessment 2015 - How are the world’s forests changing?
- ILO (2011) International Year of Forests 2011: What about the labour aspects of forestry? Geneva: International Labour Organization
- See BWI Position Paper - January 2017 “Development of a global core set of forest indicators to support the implementation of the 2030 Agenda on Sustainable Development and the IAF Strategic Plan: Identifying economic and social core indicators for the forestry and forest products workforce in a carbon constrained environment”
- Байгаль Орчин Аялал Жуулчлалын Яам, 2018
- Монгол Улсын Боловсрол, сургалтын тухай хууль, 2009
- Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны статистик мэдээлэл, 2018.01.01
- Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газрын мэдээлэл, 2018.
- Монгол орны байгаль орчны төлөв байдлын тайлан 2013-2014
- Монгол орны байгаль орчны төлөв байдлын тайлан 2015-2016
- Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030

SPSIRPA FORUM 2024

Session 9-6

Participation and control of citizens in local self-government





**МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ОЛОН УЛСЫН ХАРИЛЦАА, НИЙГИЙН УДИРДЛАГЫН СУРГУУЛЬ
НИЙГИЙН УДИРДЛАГЫН ТЭНХИМ**

**НУТГИЙН ӨӨРИЙН УДИРДЛАГАД
ИРГЭДИЙН ОРОЛЦОО, ХЯНАЛТ**

Т.АРИУНБОЛД
/ Төрийн удирдлагын докторант /

Улаанбаатар
2024

АГУУЛГА

- Удиртгал
- Нутгийн өөрөө удирдах ёсны онолын үндэс
- Нутгийн удирдах ёсны байгууллагын хөгжил
- Иргэдийн оролцоо хяналт
- Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага иргэдийн оролцооны байгууллага болох нь
- Нутгийн өөрийн удирдлагад оролцох иргэдийн оролцоо
- Зарим орон нутаг дахь Иргэдийн оролцооны байдал
- Тулгарч буй бэрхшээл
- Санал дүгнэлт

Ашигласан материал

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ИТХ - Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал

ТЗ – Төрийн захиргааны

УТ – Улс төрийн

ТҮ - Төрийн үйлчилгээний

ХАА - Хөдөө аж ахуй

АДХ - Ардын депутатуудын хурал

ОХУ - Оросын холбооны улс

ЗДТГ-Засаг даргын Тамгын газар

ЗЗНДНТУТХ- Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль


1.Удиртгал:

Төрийн байгууламжийн хэлбэрээс үл хамааран аливаа тусгаар улсад Төв, Орон нутаг гэсэн ойлголт байдаг бөгөөд газар нутаг хүн ардаа удирдан зохион байгуулахдаа засаг захиргааны нэгжид хуваан авч үздэг.

Нөгөө талаас тусгаар улс нь газар нутаг засаг захиргааны нэгжээс бүрддэг.

-Монгол Улс төрийн байгууламжийн хувьд нэгдмэл байна.

-Монгол Улсын нутаг дэвсгэр зөвхөн засаг захиргааны нэгж/аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хороо буюу орон нутаг/ -д хуваагдана./МУ-ын Үндсэн хуулийн 2-р зүйл/



Эх сурвалж: Б.Чимид (2002). *Багийн өнгөрсөн, одоо, ирээдүй.* УБ, хууд 26.

Нутгийн өөрөө удирдах ёс буюу нутгийн удирдлага хэмээх ойлголт нь “орон нутаг хэмээх ойлголттой нягт уялдаатай бөгөөд орон нутаг гэдэг нь улс орны удирдлага Засаг захиргааны удирдлагын шатлалтай холбоотой юм. “Орон нутаг” бол газарзүйн байршлыг бус эрх мэдэл, эрх хэмжээний хүрээ хязгаарыг илэрхийлдэг төр-хууль зүйн тухайлсан нэр томъёо юм. Тухайлбал улсын хэмжээнд ажиллах эрх хэмжээтэй байгууллагыг “Төв байгууллага” харин аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг хорооны нутаг дэвсгэрийн хэмжээнд хэрэгждэг, түүнээс хальж гарах ёсгүй эрх хэмжээтэй байгууллагыг “орон нутгийн” гэж ангилдаг. Энэ нь хотод ч байдаг. (Б.Чимэд, 2003)

2. Нутгийн өөрөө удирдах ёсны онолын үндэс

Нутгийн өөрөө удирдах ёсны онолын үндэслэлүүд XIX зуунд анх Европын улс орнууд болон Америкт тавигджээ. Нутгийн өөрөө удирдах ёсны онолын үндсийг тавихад Д.Морган, А.Токвиль, Л.Штейн, Р.Гнейст нарын эрдэмтэд чухал үүргийг гүйцэтгэж байв. Эрдэмтэн А.Токвиль өөрийн бүтээлдээ “Засаглалын анхдагч үндэс нь төр улс, тэр ч байтугай ард түмэн биш, харин өөрсдийн хувийн хэргийг өөрсдөө зохицуулж, сайн дурын үндсэн дээр нэгдсэн бие хүмүүс мөн” хэмээн тэмдэглэсэн байна. XIX зууны эхний хагаст эрх чөлөөт хүй элгэн /Доктор Я.Долгоржав Нутгийн өөрөө удирдах ёс (2000) бүтээлдээ 1985 оны 10 дугаар сард батлагдсан Нутгийн өөрөө удирдах ёсны Европын харти дурдагдсан “коммун” хэмээх үгийг “хүй элгэн” буюу нутаг усныхан хэмээн тодорхойлсон/- ий тухай онол илүү нөлөөтэй байж. Уг үзлийг баримтлагчид нь “Нутаг усныхны өөрийн ажил хэрэг, ахуй амьдралаа эрхлэх нь хүний эрх чөлөөний нэгэн адил зүй ёсны ангижруулшгүй шинжийг агуулж байдаг ба хүй элгэний удирдлага нь

-Төрийг удирдахаас ялгаатай

-Төрөөс бус дотроосоо бий болох

-Хуулийн хүрээнд ажиллах ба гагцхүү хуулиар төрөөс тусгаарлагдана” хэмээн үзэж байжээ.

Суурин соёл иргэншилтэй орнуудын хувьд өөрөө удирдах ёсны эрх олж авах үзэгдэл анх хот суурин газруудад эхэлж бий болсон байдаг.

Манай орны хувьд нутгийн өөрөө удирдах ёсны зарчим анх албан ёсоор хуульчлагдсан хэлбэрээр бус ч зан заншлын хэлбэрээр эрт үеэс хөдөө орон нутагт үйлчилж байсан гэж үзэх үндэстэй. Энэ нь эхэн үедээ цусан болон ураг төрлийн харилцаанд цаашдаа шашин, зан заншил, орон нутгийн аж ахуй эрхлэх буюу хадлан тэжээл бэлтгэх, хашаа хороо барих, худаг ус гаргах зэргээр соёл, уламжлал, аж ахуйн нийлээд өргөн нийтлэгт тулгуурласан нэгэн нутаг усны хүмүүс хамтын зохион байгуулалтад орж өөрсдийн эрх ашигт нийцүүлэн, өөрсдийн хүчээр үйл хэргээ явуулах зайлшгүй шаардлагаар нөхцөлдөж байсан буюу шууд утгаараа “Өөрөө удирдах ёс” хэрэгжиж байжээ.

Энэ мэтээр хүмүүс нийгмийн хөгжлийн эхэн үед байгалиас заяасан жам ёсны амьдралаараа овог аймгаараа амьдарч тэдний хоорондын харилцаа нь овгийн хүрээнд тогтсон жаяг, журам, зан заншлын хэм хэмжээгээр зохицуулагдаж байснаа яваандаа нийгмийн амьдрал нарийсаж “хэлэлцээрт төр” үүсэж, тэр нь иргэдийг төрийн харьяалалд оруулж, албадан сахивал зохих хууль эрх зүйн хэм хэмжээг бий болгож эхэлсэн. Өөрөөр хэлбэл хүмүүс байгалийн жам ёсны байдлаас иргэний нийгэмд шилжиж эхэлснээр жам ёсны дагуу өөрийгөө удирдах хэлбэр нь төлөөллийн байгууллагад эрх хэмжээ олгох хэлбэрт шилжиж эхэлсэн байна. Энэ нь “Нутгийн өөрийн удирдах байгууллага” (Монгол Улсын Үндсэн хууль, 59.2, 1992) бий болох үндэс суурийг тавьсан.

“Local self-government” буюу “Орон нутгийн өөрийн удирдлага- нутгийн өөрөө удирдах байгууллага” дараах хэв шинжүүдтэй нөхцөлд түүнийг өөрийн удирдлага гэж үздэг (Gissur Erlingsson, 2014, хууд 4) байна. Үүнд:

- Иргэдийн ашиг сонирхлыг илэрхийлдэг, иргэдээс сонгогдсон мандаттай
- Хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулдаг, төв засаг ба дээд шатны засаг захиргааны байгууллага аль алинд нь харьяалагддаггүй
- Төв засаг үйл ажиллагааных нь зөвхөн хуульд нийцсэн байдалд хяналт тавьдаг, түүний гаргаж буй шийдвэр, бие даасан байдал нь шүүхээр хамгаалагдсан
- Хуулийн этгээдийн статустай, өмчөө чөлөөтэй захиран зарцуулах эрхтэй
- Өөрийн орлогоо захиран зарцуулдаг, санхүү, улсын төвлөрсөн төсвөөс олгож байгаа татаасыг захиран зарцуулах эрхтэй
- Төрийн захиргааны төв байгууллагаас тусдаа, бие даасан захиргааны албан хаагчидтай гэжээ.

Европын орнуудад нутгийн өөрийн удирдлагын үзэл санаа дэлгэрэх, нутгийн өөрийн удирдлагын байгууллагын ач холбогдлыг нэмэгдүүлэхэд түлхэц болсон томоохон үйл явдал бол 18 дугаар зуунд Францын болон Бельгийн үндсэн хуулиудад Нутгийн өөрийн удирдлагын байгууллагыг 4 дэх засаглал болгож тусгай бүлэг бий болгосон явдал байлаа.

Европын ихэнх орнуудын нутгийн удирдлагын эрхзүйн үндэс нь 19–р зууны “Нутгийн удирдлагын реформ”-ын явцад тавигджээ. Тухайлбал:

Англи Улс: Англо-саксоны гэсэн нэр авсан АНУ, Австрали, Канад, Шинэ Зеланд зэрэг орнуудад хэрэгждэг нутгийн удирдлагын хэлбэр эндээс үүсэлтэй бөгөөд энэ

системийн онцлог нь Засгийн газрын бүрэн эрхээс татгалзсан орон нутгийн сонгуулийн байгууллагын бүрэн эрхийг бий болгон хөгжүүлсэнд оршино. Англид 1835 онд “Нутгийн өөрийн удирдлагын зөвлөл/корпорац”-ийн тухай хууль батлагдаж, 178 хотод хуулийн этгээдийн статусыг тодорхойлсон. Улмаар 1985 онд Нутгийн өөрийн удирдлагын тухай хууль баталж нутгийн удирдлагын томоохон өөрчлөлт хийжээ. Нутгийн удирдлагын онцлог нь нутгийн удирдлагын байгууллагууд хуулийн этгээдийн статустай байх, нутаг дэвсгэртээ захиргааны эрх мэдлийг хэрэгжүүлэх, татвар тогтоох зэрэг санхүүгийн эрх мэдэлтэй байх, орон нутгийн байгууллагын удирдлагыг зөвлөлөөсөө сонгодог.

Франц Улс: Гол онцлог нь төвлөрөл хүчтэй буюу төв засгийн газраас нутгийн удирдлагын байгууллагад тавих хяналт хүчтэй байдаг. Нутгийн удирдлагын анхан шатны нэгж нь коммун бөгөөд коммун нь өөрийн зөвлөлийг сонгож зөвлөлөөс сонгогдсон “Мээр” буюу захирагч нь зөвлөлийн хяналт дор ажилладаг. Мээр нь нутгийн өөрийн удирдлагын тэргүүний болон Засаг төрийн төлөөлөгчийн үүргийг хамт гүйцэтгэдэг. 1980-аад онд Францад “Бүс нутгууд”/18 регион/ гэсэн өөрийн удирдлагын эрхтэй орон нутгийн Засаг захиргааны нэгж бий болжээ. Энэ нь бүс нутгийн эдийн Засаг нийгмийн хөгжлийн чиглэл, Төлөвлөгөө боловсруулах, биелэлтийг хангуулах үүргийг хүлээдэг. 1982 он хүртэл энэхүү зөвлөлийг төв засгийн газраас томилогдсон “Префект” зөвлөлийн даргын үүргийг гүйцэтгэж байсан ба одоо зөвлөлийн шийдвэрийн хуулийн үндэслэлд хяналт тавих болжээ.

Холбооны бүгд найрамдах Герман Улс: Нутгийн өөрөө удирдах ёсны үзэл санаа нь Герман улсад бүр дундад зууны үеэс эхлэн хөгжсөн түүхтэй. 19 р зуунд Пруссийн язгууртан Фрайхерр фон Штайн Пруссийн хотын дүрмийг боловсруулсан бөгөөд энэ нь Германы нутгийн удирдлагын тогтолцоонд онцгой үүрэг гүйцэтгэсэн. Энэхүү дүрмээр нутгийн удирдлагын байгууллагууд орон нутагт өөрийн үүргээ хэрэгжүүлэхийн хамт төрийн даалгавраар түүний зарим чиг үүргийг гүйцэтгэх тухай зааж өгсөн. Гэвч Герман нь Холбооны Улс тул муж улс бүрийн нутгийн удирдлагын тогтолцоо нь харилцан адилгүй байдаг онцлогтой ба нутгийн удирдлагын /обшины/ зохион байгуулалтын дараах хэлбэрүүд байдаг (Б.Баттүвшин, 2017, хууд 46).

1. Магистратын хэлбэр
2. Бургомистерийн буюу хотын даргын хэлбэр
3. Умард Германы Зөвлөлийн хэлбэр
4. Өмнөд Германы Зөвлөлийн хэлбэр

Германд нутгийн удирдлагын харилцааг зохицуулдаг бие даасан хууль байдаггүй бөгөөд холбооны Үндсэн хууль болон муж Улс бүрийн үндсэн хууль бусад хуулиар зохицуулдаг. Засаг захиргааны хувьд хот, район, тойргоос бүрддэг. Засаг захиргааны анхан шатны нэгж нь “обшин” бөгөөд дараах үүрэгтэй байдаг.

- а. Нутаг дэвсгэртээ хуулиар өөр байгууллага хэрэгжүүлэхээр зааснаас бусад бүх захиргааны чиг үүргийг гүйцэтгэдэг
- б. Өөрийн үйл ажиллагааны хүрээг хуульд харшлаагүй дүрмээр зохицуулдаг
- в. Орон нутгийн зорилтыг өөрийн бүрэн эрхийн хүрээнд хуульд нийцүүлэн шийдвэрлэдэг

Швед: Засаг захиргааны нэгжийн хувьд муж, коммун д хуваагддаг бөгөөд 24 муж 288 коммунтай. Засаг захиргааны нэгжүүд нь тус тусдаа харьцангуй бие даасан үйл ажиллагаа явуулдаг байна.

Мужийн зөвлөл нь:

1. Гүйцэтгэх хороо

- Сонгуулийн салбар хороо
- Зөвлөгөө өгөх салбар хороо
- Удирдлагын салбар хороо

2. Нийтийн үйлчилгээний хороо

- Нийгмийн аюулгүй байдлын салбар хороо
- Байгаль орчны салбар хороо
- Хүүхэд ба залуучуудын салбар хороо
- Амралт соёл урлагийн салбар хороо
- Боловсролын салбар хороо гэсэн бүтэцтэй.

- Эрүүл мэндийн үйлчилгээ
- Нийтийн тээвэр
- Мэргэжлийн сургалт
- Насанд хүрэгчдийн боловсрол
- Соёлын үйлчилгээнд туслах чиг үүрэгтэй Засгийн газраас томилогдож түүнд шууд харьяалагддаг мужийн захирагч төрийн удирдлагыг хэрэгжүүлдэг.

Швед Улсын хувьд Засаг захиргааны анхан шатны нэгж болох коммуны түвшинд иргэдийн ая тухтай амьдрах орчин нөхцөлийг хангах нэлээд үүргийг гүйцэтгэдэг онцлогтой. Нутгийн өөрөө удирдах байгууллагууд нь өөрсдийн эрх ашгийг хамгаалах үйл ажиллагаагаа уялдуулах, төр засгийн байгууллагуудтай харилцах, эрхзүйн таатай орчныг бүрдүүлэх, орон нутгийн боловсон хүчнийг сургах, мэргэшүүлэх, давтан сургах зэрэг асуудлыг Шведийн нутгийн удирдлагын холбоо/SALA/-оор дамжуулан гүйцэтгэдэг байна. Энэ туршлагыг манай Улсад нэвтрүүлж Монголын нутгийн удирдлагын холбоо, Монголын нутгийн удирдлагын нийгэмлэг зэрэг байгууллагууд байгуулагдаж ажиллаж байгаа бөгөөд орон нутгийн боловсон хүчнийг сургах, мэргэшүүлэх, давтан сургах зэрэг ажлыг Монголын нутгийн удирдлагын холбоо бие даан, Монголын нутгийн удирдлагын нийгэмлэг нэгдсэн үндэстний байгууллага болон олон улсын бусад байгууллагатай хамтран зохион байгуулж байна.

Тажикстан: Засаг захиргааны хувьд хот, тосгонд хуваагддаг нутгийн удирдлагыг Джамоат-аар удирдуулсан Орон нутгийн Зөвлөл хэрэгжүүлдэг. Нутгийн өөрийн удирдлагын байгууллагын чиг үүрэг нь тэдгээрийн түвшнээс хамаарч дараах байдлаар хуваагддаг.

- Ерөнхий чиг үүргүүд
- Онцгой чиг үүргүүд
- Гэрээний үндсэн дээр төлөөлөн гүйцэтгэх чиг үүргүүд

- Сайн дурын чиг үүргүүд мөн нийтийн өмчийг хувьчлах, газрын харилцаатай холбоотой асуудлыг шийдвэрлэх чиг үүрэг нэмэгддэг. Чиг үүргээ хэрэгжүүлэх санхүүжилтийг төсвөөс санхүүжүүлэх бөгөөд санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлохгүйгээр төрийн байгууллагууд чиг үүргээ нутгийн өөрийн удирдлагын байгууллагад шилжүүлэх эрхгүй байдаг.

Кыргызстан: Нутгийн нутгийн өөрөө удирдах ёсны янз бүрийн хэлбэр нь нутгийн зөвлөлд бүртгүүлснээс хойш статусаа олж авдаг. Нутгийн өөрөө удирдах байгууллага нь Киргиз улсын хууль тогтоомжоор тогтоосон журмаар хуулийн этгээдийн статус авах эрхтэй. Нутгийн шинж чанартай үйл хэргийг шийдвэрлэхийн тулд хүн ам өөрсдөө үүсгэн байгуулсан төлөөллийн гүйцэтгэн захирах бусад байгууллагууд нь нутгийн өөрийн удирдлагын байгууллагууд мөн гэж Үндсэн хуульдаа тусгасан. Энэхүү нутгийн удирдлагын байгууллага нь Кениш буюу иргэдийн төлөөлөгчдийн хурал юм. Айыл окмоту буюу Засаг дарга нь Кениш -тээ ажлаа тайлагнадаг нь манай улсынхтай адил юм.

Оросын холбооны Улс: ОХУ-ын Үндсэн хуульд заасны дагуу “Холбооны хууль”/ Федеральный закон/-аар нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын хууль эрх зүй, нутаг дэвсгэрийн, зохион байгуулалт, эдийн засгийн ерөнхий зарчмуудыг тогтоож, түүнийг хэрэгжүүлэх төрийн баталгааг тодорхойлдог. Энэхүү хуульд нутгийн өөрийн удирдах байгууллагын эрх хэмжээг ихээхэн нарийвчилж зохицуулсан. Тухайлбал нутгийн өөрөө удирдах байгууллагын бүтцийг иргэд тогтоох боломж олгосноос гадна нутгийн өөрөө удирдах байгууллага нь төрийн байгууллагын тогтолцоонд орохгүй үйл ажиллагаа нь иргэдийн өмнө хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгаагаар үнэлэгддэг байна. Тухайлбал нутгийн өөрөө удирдах байгууллагын бүтцийг иргэд тогтоох боломж олгосноос гадна нутгийн өөрөө удирдах байгууллага нь төрийн байгууллагын тогтолцоонд орохгүй үйл ажиллагаа нь иргэдийн өмнө хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгаагаар үнэлэгддэг байна. Нутгийн өөрөө удирдах байгууллага нь орон нутгийн чанартай ямар ч асуудлыг хуулийн хүрээнд шийдвэрлэх бүрэн эрхтэй. Нутгийн өөрөө удирдах ёс нь ОХУ-ын үндсэн хуулийн тогтолцооны үндэс суурийг тавьдаг, үүнийг ОХУ-ын нутаг дэвсгэрт хүлээн зөвшөөрч, баталгаажуулж, хэрэгжүүлдэг байна.

Дээрх Улс орнуудын жишээнээс харахад нутгийн өөрөө удирдах ёс, нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын талаар нэгдсэн ойлголт байхгүй байна. Судлаачдын тодорхойлсноор нутгийн өөрөө удирдах ёсны 3 төрлийн онол байна.

- 1.Чөлөөт хүй элгэний онол
- 2.Нийгэм аж ахуйн удирдлагын онол
- 3.Төрийн онол (О.Тунгалаг, 2011)

-Чөлөөт хүй элгэний онолын онцлог нь нийгмийн харилцааны анхдагч нь “Хүй элгэн” буюу нутаг усныхан хоёрдогч нь төр улс, нутгийн өөрийн удирдлагыг иргэд өөрсдөө сонгож байгуулах ба хүй элгэн өөрийн асуудлаа өөрөө шийдвэрлэнэ төр засгийн байгууллагаас эрх мэдлээ хэтрүүлж байгаа эсэхэд нь л хяналт тавих ёстой.

-Нийгэм аж ахуйн удирдлагын онолын онцлог нь хүй элгэн болон төр засгийн газрын эрх мэдлийн асуудал чухал бус тухайн нутаг дэвсгэрийн аж ахуйн үйл ажиллагаа чухал байна.

-Төрийн онолын онцлог нь хүй элгэн нь төв засгийн бодлогын доод шатны байгууллага бөгөөд энэ нь тухайн орон нутагт амьдарч байгаа иргэд засаг захиргааны нэгжийг хөгжүүлэх орон нутгийн сонирхлыг хэрэгжүүлэгч байна.

3. Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын хөгжил

Өнөөдөр Нутгийн өөрийн удирдлагын байгууллагуудын нийтлэг дүр төрх нь төв Засгийн газрын шийдвэрийг тухайн нэгждээ хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулдаг, дээрээс өгөх үүрэг даалгаврыг хүлээсэн шинжтэй эдийн засаг санхүүгийн хувьд хараат

байдалтай байгаа ч улс төр, нийгмийн харилцааны хувьд тогтвортой улс орнуудад өөрийн онцлогтой дараах тогтолцоонууд бий болсон байна.

Үүнд:

-Харьцангуй бие даасан орон нутгийн удирдлагын тогтолцоо буюу нутгийн удирдлагын байгууллага, албан тушаалтнууд шууд сонгуулиар эрх мэдлээ авч хэрэгжүүлдэг тогтолцоо

-Орон нутгийнхаа иргэдийн өмнөөс сонгогдсон байгууллага, албан тушаалтнууд ажилладаг тогтолцоо

-Нутгийн удирдлагын байгууллагууд нь харилцан хамааралгүй боловч төв засгийн газраас тусгайлан байгуулсан байгууллага тэдгээрийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс хяналт тавьдаг тогтолцоо.

Өнөөдрийн байдлаар Нутгийн өөрөө удирдах ёсны загварыг дараах байдлаар хувааж үзэж болохоор байна.

1. Хамтын ажиллагааны загвар:

Энэ нь АНУ, Швейцари, Голланд зэрэг улсуудад хэрэгжиж байгаа төрийн үйлчилгээг нийгэд хүргэх нэгэн зорилгын үндсэн дээр орон нутгийн болон төв засгийн газрын хоорондын харилцаа адил түвшинд хэрэгждэг орон нутгийн иргэд өөрийн асуудлыг доороос тавьж шийдвэрлүүлдэг онцлогтой.

2. Агентын буюу төлөөллийн загвар

Энэ нь төв засгийн газарт эрх мэдэл төвлөрч нутгийн удирдлагын байгууллага нь төв засгийн газрын шийдвэрийг зохион байгуулагч орон нутаг дахь төлөөлөл болж ажилладаг. Нутгийн удирдлагын байгууллагууд төв засгийн газрын шийдвэрийг нутгийн иргэдийн ашиг сонирхлыг үндэслэн хэрэгжүүлэх бөгөөд Засгийн газар ч орон нутгийн эрх мэдлийн баталгааг ханган ажиллана.

3. Харилцан ажиллах загвар

Нэг талаас орон нутгийн удирдлагын харьцангуй бие даасан байдал, нөгөө талаас нутгийн удирдлагын байгууллага нь төрийн байгууллага гэдэг утгаараа төв засгийн газраасаа төсөв санхүүгийн хамааралтай байдаг.

Ихэнх Улс орнуудад нутгийн өөрийн удирдлагын байгууллагын эрх үүргийг хуулиар тодорхойлсон байгаа ба энэ нь нутгийн удирдлагын байгууллагын удирдлагуудын үйл ажиллагаанд төрийн болон иргэдийн зүгээс тавих хяналтыг хуульчилж өгсөн байдлаар илэрч байна. Тухайлбал Герман, Франц, Япон, Португал, Унгар, Энэтхэг улсад нутгийн өөрийн удирдлагын байгууллагыг татан буулгаж үүргийг төв засгийн байгууллагад шилжүүлэх, орон нутгийн засаг захиргааны байгууллагад ажиллагсдыг ажлаас нь чөлөөлөх, орон тоог цөөлөх, санхүүжилтийг зогсоох зэрэг хариуцлага оногдуулахаар тусгажээ. Мөн нутгийн өөрийн удирдлагын байгууллагад тавих хяналтыг шүүхийн байгууллагаас хяналт тавих боломжтой бөгөөд энэ нь хэн нэгний өргөдлөөр хэрэг үүсгэж гаргасан шийдвэрийг үнэлэх замаар хэрэгждэг.

Нийтлэг жишгээс харахад нутгийн өөрийн удирдлагын байгууллагын эрх хэмжээг анхдагч ба хоёрдогч гэж ангилна.

-Анхдагч:

Гудамжны зохион байгуулалт, цэвэрлэгээ, барилгажилт, тохижилт, иргэдийн эрүүл мэндийн асуудал, нийгмийн асуудал гэх мэт орон нутгийн хэмжээнд өөрсдөө шийдвэрлэдэг эрх хэмжээ хамаарна

-Хоёрдогч:

Сонгуулийн компани ажил, цэрэг татлага, вакцинжуулалт зэрэг гол төлөв дээд шатны байгууллагын шийдвэрээр хийгдэж байгаа ажил хамаарч байна.

Одоогоор дэлхийн Улс орнуудад эрх мэдлийн хуваарилалтаасаа хамаараад тогтсон Нутгийн удирдлагын байгууллагын дараах загварууд байна.

-Англи-Саксоны загвар

Сонгуульт албан тушаалтнууд хэн нэгэн дээд албан тушаалтнаас хараат бус байж зөвхөн өөрийн сонгогчдоос хамааралтай байх боломжоор хангагдсан гэж үздэг Австрали, Шинэ Зеланд гэх мэт орны загвар.

-Францын буюу эх газрын загвар

Төлөөлөгчдийн байгууллагын сонголт, төрийн байгууллагын томилолт хослуулдаг. Сонгогдсон төлөөллийн байгууллага захиргаагаа байгуулдаг ба төрийн төлөөлөгч нь нутгийн захиргааны байгууллагын тэргүүн байдаг. Гол зарчим нь Хурал, захиргааны байгууллага хоорондын харилцаа нь эрх мэдлийг хуваарилах замаар тэнцвэртэй байдаг. Франц, Итали, Латин америк, ойрх дорнодын зарим орны загвар.

-Холимог загвар

Дээрх хоёр загварын аль алины хэв шинжийг агуулсан байдаг. Жишээлбэл, Япон, ХБНГУ, Австри зэрэг улсуудад ийм загварын шинж түүхүү ажиглагддаг.

Харин манай Улсын хувьд өнөөгийн нутгийн удирдлагын байгууллагын суурь үндэс болсон “Ардын депутатуудын хурал” нь 1923 онд батлагдсан “Монгол Улсын нутгийн захиргааны дүрэм”-ийн 1 дүгээр зүйлд “ 10 гэрээс дээш баг, сум, хошуу, аймаг, Улсын Засгийн газар хүртэл ардын төлөөлөгчдийг сонгон хуралдуулж, дэс дараалан хурал байгуулан элдэв хэрэг зүйлийг шүүмжлэн хэлэлцүүлж, олонхын саналаар таслан тогтоож, ардын хэргийг эрхэмлэн хүндэтгэвэл зохино” хэмээх заалтад үндэслэсэн бөгөөд энэ тогтолцоо нь:

- 10 гэрийн
- Багийн
- Сумын
- Хошууны
- Аймгийн хурал
- Улсын их хурал

гэсэн шатлалтай байжээ. 1924 оны анхдугаар Үндсэн хуульд төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагыг “Хурал” гэж албан ёсоор нэрлэсэн байна. Улмаар 1940 онд “Хөдөлмөрчин ардын хурал” 1949 онд “Хөдөлмөрчдийн депутатуудын хурал” 1960 онд “Ардын депутатуудын хурал” хэмээн өөрчлөгдөж 1992 оныг хүртэл дараах шатлалтай байжээ.

- Дээд- Ардын их хурал
- Дунд-Аймаг, хотын АДХ
- Доод-Сум, хороо, район, орон нутгийн АДХ

Эдгээр нь нэгдэж Төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагын нэгдмэл системийг бүрдүүлж байсан бөгөөд хурал бүр тухайн нутаг дэвсгэртээ өөртөө засах эрхийг хэрэгжүүлэхгүй Хурлын нэгдмэл системийн нэг хэсэг болж ажилладаг байсан нь өнөөгийн тогтолцооноос онцлог юм. (М.Сандаг-Очир, 2003) Өөрөөр хэлбэл дээд шатны

хурал нь доод шатны хурлаа удирддаг байжээ. Мөн Хурлын дарга гэж орон тооны хүн байгаагүй АДХ-ын гүйцэтгэх захиргааны дарга энэхүү үүргийг хэрэгжүүлж байсан бөгөөд 1990-1992 онд бие даасан Хурлын даргатай байх анхны оролдлого хийж тухайн үеийн МАХН-ын үүр, хороодын дарга нараар гүйцэтгүүлж байжээ. Сумын түвшинд ХАА-н нэгдэл, сангийн аж ахуйн дарга нар энэхүү үүргийг гүйцэтгэж үүнийгээ дагаад нэгдэл сангийн аж ахуйн бригад, тасгийн дарга засаг захиргааны зарим үүрэг гүйцэтгэдэг байсан. Энэхүү харилцааг зохицуулах эрхзүйн үндэс нь Бүгд найрамдах Монгол Ард Улсын Сайд нарын зөвлөлөөс баталдаг “Засаг захиргааны зарим үүрэг гүйцэтгэгчийн ажлын заавар” хэмээх баримт бичиг болж байжээ. АДХ-ын гүйцэтгэх захиргааны даргыг дээд шатны байгууллагаас томилдог бөгөөд Хурлын чуулганаар ёсчлох үүргийг гүйцэтгэдэг байв.

1992 онд баталсан Монгол Улсын шинэ үндсэн хуульд:

-Монгол Улс төрийн байгууламжийн хувьд нэгдмэл байна.

-Монгол Улсын нутаг дэвсгэр зөвхөн засаг захиргааны нэгжид хуваагдана (Монгол Улсын Үндсэн хууль, 1992).

1.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага нь нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах үндсэн дээр хэрэгжинэ.

2.Нутгийн өөрөө удирдах байгууллага бол аймаг, нийслэл, сум, дүүрэгт тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, баг, хороонд иргэдийн Нийтийн Хурал, тухайн Хурлын хуралдааны чөлөө цагт түүний Тэргүүлэгчид мөн. (Монгол Улсын Үндсэн хууль, 1992) хэмээн тодорхойлж нутгийн өөрөө удирдах байгууллага, төрийн удирдлагын байгууллага 2-ыг зааглаж чиг үүргийг тодорхойлж өгсөн байна. Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар Нутгийн удирдлага нь нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах үндсэн дээр хэрэгжих ба Нутгийн өөрөө удирдах байгууллага бол аймаг, нийслэл, сум, дүүрэгт тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, баг, хороонд иргэдийн Нийтийн Хурал, тухайн Хурлын хуралдааны чөлөө цагт түүний Тэргүүлэгчид байхыг хуульчилжээ.

Мөн 2006 онд батлагдсан Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуульд Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын тогтолцоог:

- Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал;
- Баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал;
- Хурлын хуралдааны чөлөө цагт тэдгээрийн Тэргүүлэгчид;
- Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга байна гэж тодорхойлон үүнээс
- Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал;
- Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал;
- Баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал нь “Нутгийн өөрөө удирдах байгууллага” байна гэж хуульчилж өгсөн бол.

2021 онд Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухайн хууль шинэчлэгдэн батлагдсанаар орон нутгийн чиг үүргийг тодорхойлж, орон нутгийн санхүүгийн эрх хэмжээг нэмэгдүүлэх томоохон ахиц гаргасан.

Энэ хуулиар бүх шатны Хурал Тэргүүлэгчгүй болж аливаа асуудлыг нэгдсэн хуралдаанаар эцэслэн шийдвэрлэхээр зохицуулагдсан ба нэгдсэн хуралдааны өмнө санал дүгнэлт гаргах үүрэг Ажлын хороод, улс төрийн намын бүлгүүдээс гадна “Хурлын зөвлөл” хэмээх 5-7 хүний бүрэлдэхүүнтэй шинэ бүтцэд өгөгдсөн.

Мөн -Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал

-Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь иргэдийн төлөөллийн байгууллага, баг, хорооны Иргэдийн нийтийн хурал нь иргэдийн өөрийн удирдлагын байгууллага гэж онцолж иргэд нутгийн өөрийн удирдлагад хэрхэн оролцохыг тодорхойлж өгсөн.

Нутгийн өөрийн удирдлагын байгууллага нь:

1. Орон нутгийн хэргийг шийдвэрлэхэд иргэдийн оролцоог хангаж өгөх
2. Орон нутгийн өмч санхүүгийн нөөцийг удирдах
3. Тухайн нутаг дэвсгэрийн хөгжлийг хангах
4. Нутаг дэвсгэрийнхээ нийгэм ахуй, нийгэм соёлын болон амьдралын шаардлагатай бусад нөхцөлийг хангах
5. Нутаг дэвсгэртээ хууль ёс нийгмийн дэг журам сахиулах
6. Хуулийн хүрээнд нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх ашиг, сонирхлыг хамгаалах зэрэг чиг үүргүүдийг хэрэгжүүлдэг.

Харин нутгийн өөрийн удирдлагын байгууллагуудын нийтлэг эрх ашгийг хамгаалах сум, дүүрэг, аймаг, нийслэлийн ИТХ-ын төлөөлөгчдийн төлөөлөл оролцсон “Нутгийн удирдлагын төлөөллийн байгууллага” байх ба дүрмийг Монгол Улсын Засгийн газраас баталж (тогтоол, 2021)

2021 онд хүчин төгөлдөр мөрдөгдөж буй 650 гаруй хуулиудыг нягтлан, шинээр батлагдсан, нэмэлт өөрчлөлт орсон хуулиудыг нэмж судлан, нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх хэмжээтэй холбоотой 124 хуульд 609, 28 дүрэм, журамд 62 заалт тусгасныг нийслэл, дүүргийн ИТХ, хорооны ИНХ-ын түвшин бүрээр, Захиргааны эрх хэмжээ бүрээр ангилж үзэхэд:

Хүчин төгөлдөр мөрдөгдөж буй 124 хуулиас 118 хуулийн 496 заалтаар нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд, 100 хуулийн 432 заалтаар дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд, 40 хуулийн 96 заалтаар хорооны иргэдийн Нийтийн Хуралд эрх үүрэг олгосон байна.

Хурлын бүрэн эрхтэй холбоотой 28 журмын 62 заалтаар эрх, үүрэг олгосны 22 журмын 43 заалтаар нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд, 14 журмын 24 заалтаар дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд, 4 журмын 10 заалтаар хорооны иргэдийн Нийтийн Хуралд эрх үүрэг олгосон байна.

Нутгийн өөрөө удирдах байгууллагын чиг үүргүүдийг аргачлалын дагуу ангилбал:

- ✓ Ерөнхий чиг үүрэг -1 /Нутгийн өөрөө удирдах ёсыг хэрэгжүүлэх/
- ✓ Үндсэн чиг үүрэг -8 /Төлөөлөх, Хэм хэмжээ тогтоох, Хянах эрх хэмжээний хүрээнд/
- ✓ Дэд чиг үүрэг -28 /Үндсэн чиг үүрэгт хамаарах үйл ажиллагааны нарийвчилсан чиглэл / байна.

Хуулиар олгосон эрх үүргүүдэд захиргааны эрх хэмжээний шинжилгээ хийхэд:

✓ Хууль

- Бодлого боловсруулах – 225
- Хяналт шинжилгээ үнэлгээ хийх – 167
- Санхүүжүүлэх - 62
- Зохион байгуулах -167
- Зохицуулах - 57
- Хүний нөөцийн бодлого - 13

✓ Журам

- Бодлого боловсруулах- 5
- Зохион байгуулах - 45
- Хүний нөөцийн бодлого-4
- Хяналт шинжилгээ үнэлгээ- 5
- Үйлчилгээ үзүүлэх-2

(алба, 2021)

4. Иргэдийн оролцоо, хяналт.

Иргэдийн оролцоо тэр тусмаа нийтийн үйл хэрэгт оролцох оролцооны асуудал нь эртний Грек, Ромын ардчилалалаас эхтэй бөгөөд аливаа шийдвэрийг олонхийн эрх ашигт нийцүүлэх үндсэн арга хэлбэр гэж хэлж болох юм. Судлаач Стив Мартин “Иргэд болон сонирхогч бусад талын оролцоог хангах нь” бүтээлдээ иргэдийн оролцооны ач холбогдлыг дараах байдлаар тодорхойлжээ. (Г.Чулуунбаатар, 2021)

1. Мэдээллийн өргөн эх сурвалж, асуудлыг шийдэх олон хувилбаруудаас ашиглах боломжыг засгийн газарт олгож бодлого боловсруулах явцыг чанартай болгох

2. Төр иргэдийн хоорондын харилцаа холбоог хөнгөвчлөх

3. Хариуцлага, шилэн байдлыг нэмэгдүүлэх

4. Төлөөллийн зарчим олон нийтийн итгэлийг бэхжүүлэх хэмээгээд оролцооны хүрээг:

-Мэдээллэх

-Зөвлөлдөх

-Хамтран бүтээх гэсэн бүрдэл хэсгээр тодорхойлжээ.

5. Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага иргэдийн оролцооны байгууллага болох нь.

-Нутгийн өөрөө удирдах ёс нь чөлөөт сонгуулиар сонгогдсон төлөөлөгчтэй, түүнд тайлагнадаг гүйцэтгэх байгууллагатай, тухайн нутаг дэвсгэрийн эдийн засаг,

нийгмийн асуудлыг иргэдийн ашиг сонирхолд нийцүүлэн хуулийн хүрээнд бие даан шийдвэрлэх эрх зүйн бодит чадвар гэж хэлж болох юм.

А/ Иргэдийн Төлөөллийн байгууллага

-Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал;

-Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал;

Б/ Өөрийн удирдлагын байгууллага

-Баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал.

Өөрөөр хэлбэл бүх шатны хурлын байгууллага нь иргэдийн оролцооны байгууллага болж байгаа ба үүнээс баг, хорооны иргэдийн нийтийн хурал нь иргэдийн шууд оролцооны байгууллага болж байна.

6. Нутгийн өөрийн удирдлагад оролцох иргэдийн оролцоо

Нутгийн өөрийн удирдлагын байгууллага нь бодлогын шийдвэр гаргагчийн хувьд судалгаанд үндэслэн, иргэдийн нэгдмэл санааг тусган, төлөвлөгөөний дагуу хязгаарлагдмал нөөцийг зөв зохистой хуваарилах үүрэг хүлээдэг. Үүний тулд иргэдийнхээ өмнө үйл ажиллагаагаа ил тод явуулдаг, хариуцан тайлагнадаг байх явдал чухал юм. Ингэснээр иргэдийн тусын тулд хамгийн ашигтай, хамгийн эрх тэгш шийдвэр гаргах боломжтой. Үүнийг Монгол Улсын үндсэн хууль болон Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуульд дараах байдлаар зохицуулж өгчээ.

-Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ (хууль, 1992).

-Иргэд шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй. Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. (хууль, 16.9, 1992)

- "Нутгийн өөрийн удирдлага" гэж иргэд шууд, эсхүл нутгийн өөрөө удирдах байгууллага энэ хуульд заасан орон нутгийн чиг үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг хэлнэ (хууль М. У., 2020)

-Иргэн Монгол Улсын Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэг, Арван дөрөвдүгээр зүйл, Арван зургадугаар зүйлийн 9 дэх хэсэгт заасны дагуу шууд болон төлөөллийн байгууллагаараа уламжлан нутгийн өөрийн удирдлагыг хэрэгжүүлэхэд оролцох эрхтэй. (хууль М. У., 2020)

-Иргэн аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд сонгогдох, төлөөлөгчийг сонгох, баг, хорооны иргэдийн Нийтийн Хуралд өөрөө оролцох, нутгийн өөрийн удирдлагын байгууллагад өргөдөл, гомдол гаргаж шийдвэрлүүлэх, хууль тогтоомжид заасан журмын дагуу мэдээлэл авах эрхтэй. (хууль М. У., 2020)

-Сум, баг, дүүрэг, хорооны тулгамдсан асуудлыг хэлэлцэх, зөвлөмж гаргах зорилгоор сонгуулийн эрх бүхий иргэд сайн дураараа хамтарч үзэл бодол, хүсэл зоригоо илэрхийлэх эрхтэй. (хууль М. У., 2020)

-Энэ хуулийн 31.1-д заасны дагуу гаргасан санал, зөвлөмжийг сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал хэлэлцэх үүрэгтэй. (хууль М. У., 2020)

-Иргэн сум, дүүргийн эдийн засаг, нийгмийн тулгамдсан асуудлаар нэг удаагийн, эсхүл хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргахыг санаачлах эрхтэй. Энэ санаачилгыг сумын

сонгуулийн эрх бүхий иргэдийн 10-аас доошгүй, дүүргийн сонгуулийн эрх бүхий иргэдийн таваас доошгүй хувь нь дэмжиж, гарын үсэг зурсан тохиолдолд сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хэлэлцэх үүрэгтэй. (хууль М. У., 2020)

Дээр дурьдагдсан эрх хэмжээний хүрээнд иргэд орон нутгийн түвшинд шийдвэр гаргах үйл явц болон төрийн үйлчилгээг сайжруулахад оролцох дараах нийтлэг хэлбэрүүд байна.

6.1 Оролцооны хэлбэрүүд

➤ ОЛОН НИЙТИЙН ЦУГЛААН, ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ ОРОЛЦОХ:

- Энэ бол хүмүүсийн хэдийн мэдэх болсон баг, хорооны Иргэдийн Нийтийн Хурал юм.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газраас 2014 онд Монгол Улсын бүх сум, дүүргүүдэд Иргэний танхим байгуулах тухай зөвлөмж өгсөн. Иргэний танхим нь ихэвчлэн тухайн сум, дүүргийнхээ төв хэсэгт байрладаг, иргэд цуглан уулзаж, асуудлаа хэлэлцдэг газар бөгөөд зарим үед Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Иргэдийн Нийтийн Хурлуудыг энд зохион байгуулдаг. Түүнчлэн орон нутгийн засаг захиргаа нь сум, орон нутагтаа тулгамдаж буй асуудлаар иргэдийнхээ дунд хэлэлцүүлэг зохион байгуулдаг.

Ийм хэлэлцүүлгүүдийн үеэр төр, засгаас хэрэгжүүлж буй хөтөлбөр, төслүүдэд хэрхэн хамрагдах, бэлчээрийн менежмент, газрын гэрчилгээ олгох, сум, дүүргийн хөгжлийн төлөвлөгөө зэрэг иргэдийн амьдралд нөлөөлөх асуудлуудтай холбоотой бодлогын шийдвэрүүдийн талаар иргэдэд мэдээлэл өгдөг. Иргэний танхимын хэлэлцүүлгүүдийн зарыг багийн Засаг дарга, хороодын хэсгийн ахлагч нараар дамжуулан тараадаг. Түүнчлэн олон нийтийн мэдээллийн самбар, электрон самбар, орон нутгийн радио, телевизээр иргэд, олон нийтэд зарыг хүргэдэг.

Иргэн сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар эсвэл хорооны захиргаандаа хандан өөрийн болон хөршүүдийн тань сэтгэлийг зовоож буй аливаа асуудлаар хэлэлцүүлэг хийх санал гаргаж болно. Хэрэв Иргэний танхимын уулзалт, хэлэлцүүлгийг ажлын цагаар, эсвэл энэ арга хэмжээг иргэдийн амьдран суугаа газраас хол газарт зохион байгуулахаар төлөвлөсөн бол багийн Засаг дарга эсвэл Иргэдийн Хурлын Төлөөлөгчөөрөө дамжуулан саналаа өгч, уулзалт, хэлэлцүүлгийн дараа тэднээс мэдээлэл авч болно. Тухайн баг, хорооноосоо нэр дэвшин төлөөлөгчдийг иргэд өөрийн төлөөлөл болгохоор сонгодог тул тэдэнд хандах нь иргэдийн эрх юм.

➤ СУДАЛГААНД ОРОЛЦОХ:

- 2013 оноос мөрдөгдөж эхэлсэн Төсвийн тухай хуульд бүх өрх, оршин суугаа орон нутагтаа нэн тэргүүнд хэрэгжүүлэх шаардлагатай хөрөнгө оруулалтын төслүүдийн судалгаанд оролцож, саналаа өгөх эрхтэй болсон. Энэ судалгааны маягтыг жил бүрийн хавар буюу 3-5 дугаар сарын хооронд баг, хорооны Засаг дарга нар айл өрхүүдэд тараадаг. Харин иргэн судалгааны маягтыг бөглөж, сум, хорооны захиргаанд буцааж өгөх хэрэгтэй. Иргэдийн санал шийдвэр гаргах түвшинд хүрсэн эсэхийг тухайн иргэн өөрөө нягтлах боломжтой. ОНХС-ийн хөрөнгийг юунд зарцуулах тухай шийдвэр гаргахад иргэдийн өгсөн санал чухал ач холбогдолтой. Үүнээс гадна жил бүрийн 6-7 дугаар саруудын аль нэгэнд баг, хороонд болдог ОНХС-ийн төсөлд санал авах хэлэлцүүлэгийг зохион байгуулдаг.

➤ ХУДАЛДАН АВАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОХ:

- ОНХС-ийн хөрөнгө оруулалтын төслүүдийг иргэд өөрсдөө бүлэг зохион байгуулан хэрэгжүүлж, гүйцэтгэх боломжтой. Нийт төсөвт өртөг нь 20 сая төгрөгөөс

бага хэмжээтэй төслүүдийн хувьд сум, дүүргийн Засаг дарга иргэдийн бүлгүүдтэй шууд гэрээ байгуулж болдог. ОНХС ба төрийн худалдан авах үйл ажиллагааны талаар судлах нь зүйтэй. Түүнчлэн хэсэг иргэд хамтран хоршоолол, аж ахуйн нэгж байгуулахыг хүсвэл энэ талаар баг, хорооныхоо Засаг даргад хандан, шаардлагатай дэмжлэг авч болно.

6.2 Иргэдийн хяналт

➤ ОНХС-ИЙН ЗАРЦУУЛАЛТАД ХЯНАЛТ ТАВИХ

- Сангийн яамнаас баталсан шинэ журам /2014 оны 43 тоот тушаал/ нь ОНХС-ийн худалдах авах үйл ажиллагаа ба ОНХС-ийн төслүүдийн хэрэгжилтэд хяналт тавих иргэдийн хяналтын бүлгийг хэрхэн зохион байгуулах чиглэлийг орон нутгийн засаг захиргаанд өгсөн байдаг. Энэ нь иргэдийн сэтгэлд нийцсэн, чанартай төслүүдийг хэрэгжүүлэх зорилготой. Хэрэв иргэн энэ ажилд сайн дураараа оролцохыг хүсвэл өөрийн сум, хорооны Засаг дарга эсвэл Иргэдийн Хурлын Төлөөлөгчдөд хандах боломжтой.

➤ ТӨСВИЙН ХЯНАЛТ:

- Шилэн дансны тухай хуулийн дагуу иргэд Засгийн газрын төсөв, санхүүжилтийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл авах эрхтэй. Орон нутгийн засаг, захиргаа төсвийн мэдээллийг иргэд, олон нийтэд ил тод мэдээлэх үүрэгтэй. Энэ нь төрөөс иргэн Танд хүргэж буй төрөл бүрийн үйлчилгээнд хэдий хэмжээний мөнгө зарцуулдаг болохыг ойлгоход тусална.

Мөн төрийн үйл ажиллагааг олон нийтэд ил тод байлгах ач холбогдолтой. Ингэснээр иргэн таны төлсөн татварын мөнгө юунд зарцуулагдаж буйг мэдэх боломжтой. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль болон Шилэн дансны тухай хуулиар зохицуулагдана.

➤ ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАРТ ТАВИХ ХЯНАЛТ

- Сургууль, цэцэрлэг, эмнэлэг, нийтийн тээврийн үйлчилгээ зэрэг орон нутагт төрөөс иргэдэд үзүүлж буй үйлчилгээний чанарт олон иргэд сэтгэл зовниж байдаг. Үйлчилгээ үзүүлэгчид иргэдтэйгээ хамтран асуудлаа тодорхойлдог, бодит шийдлийг гаргахдаа иргэдтэй зөвлөдөг болох нь дээрх асуудлыг шийдвэрлэх нэг арга юм. Үйлчилгээ үзүүлэгчдийг хэрэглэгчтэй нь шууд холбож, төрийн үйлчилгээг сайжруулахыг нийгмийн хариуцлага гэж нэрлэдэг. Үйлчилгээг сайжруулах нийгмийн хариуцлагын олон аргууд бий. Манай улсад хамгийн түгээмэл хэрэглэгдэж буй нь үйлчилгээ хүртэгчдээс судалгаа авч "тайлангийн карт" буюу "онооны карт" боловсруулах арга юм. Төрийн үйлчилгээнд иргэдийн өгсөн үнэлгээний оноог үйлчилгээ үзүүлэгчидтэй хамтран хэлэлцэж, үйлчилгээг хэрхэн сайжруулах талаар ярилцан шийдэлд хүрдэг.

➤ САЙН ДУРЫН ХЯНАЛТ

- Төр, засаг иргэдэд өөрийн нөөц, боломжийн хэмжээнд чанартай үйлчилгээг хүргэх үүрэгтэй. Гэвч төрийн төсөв мөнгө хязгаарлагдмал, боловсон хүчний хүрэлцээ зэргээс шалтгаалаад дангаараа хийх боломжгүй байдаг. Тухайн орон нутагт сэтгэлд нь хүрэхгүй ямар нэгэн зүйл байгаа бол энэ байдлыг засаж сайжруулахын тулд иргэн өөрөө юу хийж чадах талаар бодож үзэх боломж нь нээлттэй. Тухайлбал иргэн бүх нийтийн их цэвэрлэгээ хийх нэг өдрийн компанит ажил зохион байгуулах эсвэл хөршийн

нөхөрлөлтэйгөө хамтран гадаад орчныхоо өнгө үзэмжийг сайжруулах ажил санаачилах эрхтэй. Энэ ажлыг зохион байгуулахад баг, хорооны Засаг дарга болон Хурлын Төлөөлөгчөөсөө туслалцаа авах боломжтой байна.

7. Зарим орон нутгийн ИТХ-аас иргэдийн оролцоог хангах чиглэлээр хийж хэрэгжүүлсэн ажил 2020-2023 он

Хүснэгт: 1

	Тайлант хугацаа			
	2020	2021	2022	2023
Багахангай дүүрэг ИТХ	х	57 заалт бүхий Хурлын Ажлын албаны төлөвлөгөөнд 3 заалтад хэлэлцүүлэг сургалт зохион байгуулахаар төлөвлөж тайлагнасан	44 заалт бүхий Хурлын Ажлын албаны төлөвлөгөөнд 3 заалтад уулзалт, сургалт зохион байгуулах, төсвийн хяналтад иргэдийг оролцуулахаар төлөвлөж тайлагнасан	56 заалт бүхий Хурлын Ажлын албаны төлөвлөгөөнд 2 заалтад шийдвэр гаргах түвшинд иргэдийн оролцоог хангах, сургалт зохион байгуулахаар төлөвлөж тайлагнасан
Багануур дүүрэг ИТХ	х	х	42 заалт бүхий Иргэний оролцооны хэлтсийн төлөвлөгөөнд 8 заалтад шийдвэр гаргах түвшинд иргэдийн оролцоог хангах, хамтран ажиллах, хяналт хэрэгжүүлэх сургалт зохион байгуулах гэх мэт арга хэмжээ төлөвлөж тайлагнасан	43 заалт бүхий Иргэний оролцооны хэлтсийн төлөвлөгөөнд 4 заалтад шийдвэр гаргах түвшинд иргэдийн оролцоог хангах, хамтран ажиллах, хяналт хэрэгжүүлэх сургалт зохион байгуулах гэх мэт арга хэмжээ төлөвлөж тайлагнасан
Баянзүрх дүүрэг ИТХ	х	11 заалт бүхий Иргэний	х	33 заалт бүхий Иргэний

		оролцооны хэлтсийн төлөвлөгөөнд 5 заалтад сурталчлах, түгээх, соён гэгээрүүлэх арга хэмжээ төлөвлөж тайлагнасан		оролцооны хэлтсийн төлөвлөгөөнд 5 заалтад сурталчлах, түгээх арга хэмжээ төлөвлөж тайлагнасан
Налайх дүүрэг ИТХ	15 заалт бүхий Хурлын Ажлын албаны төлөвлөгөөнд 4 заалтад хэлэлцүүлэг сургалт зохион байгуулахаар төлөвлөж тайлагнасан	х	х	х
Сүхбаатар дүүрэг ИТХ	51 заалт бүхий Хурлын Ажлын албаны төлөвлөгөөнд 4 заалтад хэлэлцүүлэг сургалт зохион байгуулахаар төлөвлөж тайлагнасан	х	х	х
Чингэлтэй дүүрэг ИТХ	Шинэ бүтэц батлагдаж Иргэний танхим Засаг даргын Тамгын газар шилжсэн тул ажлын тайлан байхгүй. (дарга, 2024)			
Нийслэлийн ИТХ	х	х	Хурлын Ажлын албаны төлөвлөгөөнд хэлэлцүүлэг, нээлттэй сонголт зэрэг ажил зохион байгуулахаар төлөвлөж тайлагнасан	Хурлын Ажлын албаны төлөвлөгөөнд хэлэлцүүлэг, нээлттэй сонголт зэрэг ажил зохион байгуулахаар төлөвлөж тайлагнасан

Нийслэлийн төсвийн төсөлд иргэдийн саналыг тусгасан байдал

Хүснэгт: 2

Огноо	Оролцсон иргэд	Ирсэн санал	Шаардагдах хөрөнгө
2023	300	455	112632,2 сая
2024	230	637	947,9 тэрбум

(НЗДТГ, 2022, 2023)

Дээрх тайлангуудаас харахад нутгийн өөрийн удирдлагад иргэдийн оролцоог хангах асуудал хангалтгүй байгаа бөгөөд

-Мэдээлэх

-Зөвлөлдөх

-Хамтран бүтээх оролцооноос мэдээлэх түвшинд түлхүү зарим тохиолдолд зөвлөлдөх төдий байгаа бөгөөд хамтран бүтээх оролцоо огт хэрэгжихгүй байна гэж дүгнэж болохоор байна. Иймээс шийдвэрлэвэл зохих тодорхой асуудлууд үүсчээ

8.Тулгарч буй бэрхшээл

1.Өмнөх жилүүдэд иргэд харьяа баг, хорооны Иргэний танхимын ажилтанд хандаж, иргэний танхимдаа хэлэлцүүлэг зохион байгуулж, хэлэлцүүлгээс гарсан санал, зөвлөмжөө орон нутгийн засаг захиргааны сонорт хүргэх боломжтой байдаг байсан.

Иргэний танхимын ажилтан байснаар ИНХ-ын бэлтгэл ажил, ИНХ-ын үйл ажиллагаа, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах, архив, бичиг хэргийн ажлууд эмх цэгцтэй, нэг журамд орж байсан юм. 2021 оноос ИТХ-ын Ажлын алба хороодын иргэний танхимын ажилтны орон тоог хасаж жигдэрч байсан ажил зогссон байна.

2. ЗЗНДНТУТХ-д нэмэлт өөрчлөлт орж Баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал /32 дугаар зүйл/ заалтыг 2023 оны 1 дүгээр сарын 1-нээс мөрдөн ажиллаж байна. Одоог хүртэл Иргэдийн нийтийн хурал хуралдаагүй хуралдсан ч зөвхөн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын асуудал хэлэлцсэн үүрэг гүйцэтгэгч Засаг даргатай хороод цөөнгүй байна. Энэ нь иргэдийн шууд оролцоог хаагдуулж байна.

3. 2020 оны хууль батлагдсанаар өмнө байсан ИНХ-ын Тэргүүлэгчид, ИНХ-ын дарга хэмээх статус байхгүй болсон нь иргэдэд тэр бүү хэл зарим хороодын Засаг даргын үүрэг гүйцэтгэгч нар ч ИНХ гэж байхгүй болсон гэж ойлгоход хүргэжээ

9. Санал дүгнэлт

Манай улсад 1992 оноос хойш нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын хөгжилд томоохон ахиц дэвшил гарах эрхзүйн үндэс тавигдсан боловч орон нутгийн төсвийн эрх хэмжээг нарийвчлан зохицуулж өгөөгүйгээс гадна 2003 онд батлагдсан Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хуулиар уг эрх хэмжээг төрийн захиргааны төв байгууллагаас ихээхэн хараат болгох зохицуулалтыг хийж өгсөн нь нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын хараат бус төрийн удирдлагатай зэрэгцэн орших эрх хэмжээг хязгаарлаж өгсөн гэж зарим судлаачид үздэг байна. 2019 онд Монгол Улсын үндсэн хуульд орсон нэмэлт өөрчлөлт болон 2020 онд батлагдсан Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль нь Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын чиг үүргийг тодорхой болгож Орон нутгийн эрх хэмжээг тодорхой хэмжээгээр нэмэгдүүлэх тодорхой ахиц гаргаснаас гадна Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 401 дүгээр тогтоолоор “Нутгийн удирдлагын төлөөллийн байгууллагын дүрэм” баталж эрх үүргийг тодорхойлж Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага хараат бус нэгдсэн удирдлагатай болох суурийг тавьж өгсөн нь Үндсэн хуульд заасан Төрийн удирдлагыг нутгийн удирдлагатай хослуулах зарчмын хэрэгжилтийг хангах, нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын хөгжилд томоохон ахиц дэвшил гаргах хүлээлт үүсгэж энэ нь цаашид холбогдох бусад хуулиудад /150 орчим хууль/ яаралтай нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагыг бий болгож зарим хуулиудад өөрчлөлт ороод байгаа ч шинээр батлагдсан зарим тодорхой эрхзүйн зохицуулалт нь учир дутагдалтай илүү нарийвчилсан зохицуулалт шаардаж байна

Тухайлбал: Шинэчлэн батлагдсан Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 54.2-т ИТХ-ын Ажлын албаны бүтэц орон тооны хязгаарыг Монгол Улсын Засгийн газраас тогтоож өгөхөөр тусгаж Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 375 дугаар тогтоолоор баталгаажуулснаар хурлууд бүрэн эрхийн хүрээнд шинэ бүтэц хийхдээ хороо бүр дээр байсан Иргэний танхим хариуцсан ажилтанаа ЗДТГ-т шилжүүлсэнээр иргэний оролцоог хангах асуудалд цалгар хандах болсон байна,

-Иргэдийн Нийтийн Хурал нь шууд ардчиллын зарчмын үндсэн дээр үйл ажиллагаагаа явуулдаг, хуулиар олгогдсон бүрэн эрхийг хамтын удирдлагын зарчмын үндсэн дээр хэрэгжүүлдэг, иргэдийн өөрийн удирдлагын байгууллага мөн. (хууль М. У., 2020)

-Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн дараах баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлын хуралдааныг сум, дүүргийн Засаг дарга шинээр томилогдсоны дараа зохион байгуулахаар хуульчилсан ч тодорхой хугацаа заагаагүй нь үүрэг гүйцэтгэгч Засаг даргын хувьд ИНХ хуралдуулахгүй байх нь бүрэн эрхээ хадгалж үлдэх нэг боломж учраас энэ асуудалд цалгар хандаж байна.

-Баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлын Зөвлөлтэй байх болж үүнд иргэдийн төлөөллөөс гадна баг, хорооны Засаг дарга болон Хуралдааны дарга, хорооны хэсгийн ахлагч нараас бүрдэх бөгөөд гагцхүү иргэдийн Нийтийн Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, дараагийн хуралдаанд бэлтгэх, хуралдааныг товлон зарлах үүрэгтэй. Зөвлөлийн хурлыг Хуралдааны дарга тэргүүлэхээр зохицуулсан ч зарим хороонд Хорооны Засаг дарга Зөвлөлийн даргаар сонгосон тохиолдол байна

-Иргэдийн Нийтийн Хурлын ээлжит бус хуралдааныг Хурлын Зөвлөл, Засаг даргын санаачилгаар, эсхүл баг, хорооны сонгуулийн эрх бүхий иргэдийн арваас доошгүй хувь

нь санал болгосноор хуралдуулна. Иргэд саналаа гарын үсэг зурах хэлбэрээр илэрхийлэхээр зохицуулсан ч иргэд энэ эрхийн талаар ойлголтгүй байна.

Иймээс:

1.ИНХ-ын хурлын анхдугаар хуралдааныг сум, дүүргийн ИТХ-аас зарлан хуралдуулдаг болох

2.ИНХ-ын анхдугаар хуралдаан зарлах хугацааг тогтоож өгөх

3.Иргэдийн оролцоог хангах ажлыг ИТХ-ын чиг үүрэгт тусгаж өгөх /одоогийн мөрдөгдөж буй хуульд зарчим хэлбэрээр байгаа (хууль М. У., 2020)/ шаардлагатай байна.

ЭХ СУРВАЛЖЫН ЖАГСААЛТ

Монгол Улсын Үндсэн хууль (1992).

Авлигын эсрэг хууль. (2006).

Захиргааны ерөнхий хууль (2015).

Төсвийн тухай хууль (2011).

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль.
(2006, 2020).

Төрийн албаны тухай хууль (2017).

Шилэн дансны тухай хууль (2014).

Холбооны хууль (2003). ОХУ

Нийгмийн шинжлэх ухааны судалгааны арга зүй. Баатартогтох, Ц. (2012)..

Нутгийн удирдлагын практик Баттүвшин.Б. (2017). Улаанбаатар

Нутгийн өөрөө удирдах ёс Долгоржав, Я. (2000). Улаанбаатар

Монгол Улсад нутгийн өөрийн удирдлагыг төлөвшүүлэх тулгамдсан асуудал
/Докторын бүтээл/ Нармандах. С (2002). Улаанбаатар

Монгол Улсад нутгийн өөрийн удирдлагыг шинжлэхүй
Нармандах. С (2010) Улаанбаатар

Нутгийн удирдлага Сандаг-Очир, М. (2003). Улаанбаатар.

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Төлөөлөгч хэрхэн ажиллах вэ?
Тунгалаг, О., Бямбаяр, Я. (2011) Улаанбаатар.

Нутгийн удирдлага-эрхзүйн шинэчлэл Тунгалаг, О., Дондог, Д. (2007). Улаанбаатар

Иргэдийн төлөөлөгчдийн хурал-түүнтэй холбоотой зарим асуудал. Тунгалаг О. (2012).

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн
хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ.

“Монгол Улсад төлөөллийн байгууллагын чадавхыг бэхжүүлэх нь” төслийн хүрээнд
ажилласан экспертийн баг. (2019). Улаанбаатар

Монголын ардчилал.

“Конрад Аденаурын сан, Г.Чулуунбаатар, Ш.Батсүх, Б.Ганцоож. (2021). Улаанбаатар

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын тогтолцоог
боловсронгуй болгох нь./судалгааны үр дүн, бодлогын зөвлөмж.

“Конрад Аденаурын сан, Монгол Улсын Их сургууль. (2019). Улаанбаатар

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай
хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ/судалгааны үр дүн, бодлогын
зөвлөмж.

“УИХ Тамгын газар, НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр (2019). Улаанбаатар

ИТХ-ын төлөөлөгчдийн сургалтын гарын авлага.

“Нутгийн өөрийн удирдах байгууллагын чадавхыг бэхжүүлэх нь төслийн нэгж. (2016).

Улаанбаатар

Монгол хэлний товч тайлбар толь Цэвэл, Я. (1966).

Улаанбаатар

Нутгийн өөрөө удирдах байгууллагын талаар авах зарим арга хэмжээний тухай.

УИХ-ын тогтоол (1997).

Улаанбаатар

Нийслэл, дүүргийн ИТХ-ын Ажлын албаны бүтэц орон тооны хязгаарыг тогтоох тухай

ЗГ-ын тогтоол 2021

Дүрэм батлах тухай


ЗГ-ын тогтоол 2021

www.legalinfo.mn.

SPSIRPA FORUM 2024

Session 9-7

Human resource audit in the public sector
(on the example of Umnugovi aimag)



ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН АУДИТ
(ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЖИШЭЭНД)

2024.05.1

Улаанбаатар хот

Т. Мөнгөнтуул

munguntuul555@gmail.com

Өмнөговь аймгийн Соёл, урлагийн газрын дарга

1. Төрийн байгууллагын хүний нөөцийн аудитын тухай ойлголт

Хүний нөөцийн аудит байгууллагын хүний нөөцийн бодлого, стратеги, төлөвлөлт, үйл ажиллагаа, журам, шилдэг туршлагыг бий болгох, сайжруулах боломжийг тодорхойлоход оршино. Байгууллагын хүний нөөцийн удирдлага нь аттестатчилал, цомхотгол, халаа сэлгээний төлөө бус харин хүний нөөцийн стратеги, зөв төлөвлөлт, бүрдүүлэлтийг хангах, авьяас чадварын санг бүрдүүлэх, тогтвортой ажил эрхлэлтийн нэгдсэн бодлогыг хэрэгжүүлэх хэрэгсэл юм.

Төрийн албаны тухай хуулийг Монгол Улсын Их Хурлаас 2017 онд шинэчлэн найруулж баталсан бөгөөд 2019 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс дагаж мөрдүүлсэн билээ. Төрийн албаны шинэтгэлийн бодлогын хүрээнд Төрийн албаны төв байгууллага болох Төрийн албаны зөвлөлд урьд өмнө байгаагүй зарим чиг үүрэг, эрх хэмжээг энэ хуулиар тодорхойлсны нэг нь хүний нөөцийн аудит хийх бүрэн эрх юм.

Тус хуулийн 66 дугаар зүйлийн 66.1.4 дэх заалтад “төрийн албаны тухай хууль тогтоомж, энэ хуулийн 3.1.3-т заасан чадахуйн зарчмын хэрэгжилтийн талаар төрийн байгууллагын үйл ажиллагаанд хүний нөөцийн аудит хийх” гэж тусгаснаар “хүний нөөцийн” гэсэн нэршилтэй төрийн аудитын шинэ төрөл бий болсон юм.

Монгол Улсын Их Сургуулийн Улс төр, олон улсын харилцаа, нийтийн удирдлагын сургуулийн Профессор, доктор Нацагийн Бурмаа нь “Төрийн байгууллагын хүний нөөцийн аудит” номоо 2021 онд хэвлүүлсэн бөгөөд тус номын Зохиогчийн үг хэсэгтээ хүний нөөцийн аудитын талаар монгол хэл дээр бичигдсэн анхны сурах бичиг гэж цохож тэмдэглэсэн байдаг. Үүнээс үзэхэд “хүний нөөцийн аудит” гэдэг шинэ үйл ажиллагаа

бий болж, эрх зүйн зохицуулалт ч бүрдэж байгаа хэдий ч төрийн албан хаагчийн мэдлэг дутмаг байсаар байна.

2. Төрийн албаны мэргэжлийн хүний нөөцийн хомсдол

Хөдөө орон нутагт мэргэжлийн хүний нөөц дутагдалтай байна. Үүнийг Өмнөговь аймгийн хэмжээнд судалж үзлээ.

ХҮНИЙ НӨӨЦИЙН СУДАЛГАА (ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЖИШЭЭН ДЭЭР)

Аймгийн төрийн байгууллагуудаас 2021-2024 оны хооронд дутагдалтай хүний нөөцийн судалгааг авч, нэгтгэж, дүгнэж үзлээ.

Үүнд: Сумдад нийт

Он	2021	2022	2023	2024
Нийт-370	222	87	32	29

Бэлтгэгдэж байгаа эсэх		
Нийт	Тийм	Үгүй
370	31	339

№	Салбарын нэр	Тоо	Хувь
1	Боловсрол	88	39.6
2	Соёл	12	0.54
3	Эрүүл мэнд	90	40.5
4	Хөдөө аж ахуй	16	0.07

5	Төрийн захиргаа	16	0.07
	Нийт	222	

3. Төрийн албаны тухай хууль тогтоомжийн хэрэгжилт, төрийн албанд чадахуйн зарчмыг баримталж буй эсэх:

Өмнөговь аймгийн төрийн захиргааны байгууллагын сүүлийн 6 жилийн хугацаа дахь хүний нөөцийн өөрчлөлтийг судалж үзэхэд:

Төрийн захиргааны албан хаагчийн өөрчлөлт

2016 он: Нийт 37 орон тоог судалж үзлээ. 15 төрийн захиргааны албан хаагч ажлын байрандаа хэвээр үлдсэн. 3 хүн тэтгэврийн насанд хүрч, өндөр насны тэтгэврээ тогтоолгосон. 19 хүн ажлаа өөрчлөх, өөр аймаг хотруу шилжих болон ажлаасаа гарсан байна. 40.5 хувь нь ажлаа байраа хэвээр хадгалж, үргэлжлүүлэн ажил үүргээ гүйцэтгэсэн бөгөөд 3 хүн нь мерит зарчмаар хэлтсийн дарга болж дэвшсэн байна.

2020 онд: Нийт 36 орон тоог судалж үзлээ. 23 төрийн захиргааны албан хаагч ажил үүргээ үргэлжлүүлэн гүйцэтгэж байна. 2 хүн тэтгэвэр тогтоолгох насанд хүрч, тэтгэврээ тогтоолгон ажлаасаа чөлөөлөгдсөн. 11 албан хаагч өөрчлөгдсөн бөгөөд 6 нь удирдах албан тушаалтан, 5 нь гүйцэтгэх албан тушаалтан байна. 30.5 хувь нь өөрчлөгдсөн байна.

2016, 2020 оныг сонгосон шалтгаан нь орон нутгийн сонгууль зохион байгуулагдсан жил бөгөөд сонгуулийн дараагаар гарсан өөрчлөлт, хөдөлгөөнийг судалж үзсэн болно.

Шинээр томилогдсон албан хаагчид албан тушаалын тодорхойлолтын шаардлага хангахгүй байгаагийн зэрэгцээ 2 жилийн хугацаа өнгөрч байхад 6 албан хаагчийн 50 хувь нь тусгай шалгалтаа өгч, жинхлэн томилогдоогүй байна.

Шинээр томилогдож байгаа нийт албан хаагчийн 1.5 хувь мерит зарчаар томилогдож байна.

Төрийн албаны ерөнхий шалгалт жилийн хугацаанд 2 удаа зохион байгуулагдаж байсан бөгөөд тухайн үед шалгалтад орсон иргэдийн 70 хувь нь тэнцэхгүй байгаа

нь төрийн захиргааны албаны хүний нөөцийг хангах боломжгүй байсан. Сүүлийн 2023 оноос төрийн албаны ерөнхий шалгалтыг улирал бүр буюу жилдээ 4 удаа зохион байгуулж байгаа хэдий ч шалгалтад орсон иргэдийн 70 хувь тэнцэхгүй байгаа байдал үргэлжлэсээр байна.

Төрийн албаны зөвлөлийн шийдвэрүүд:

Тогтоол 02. "Төрийн жинхэнэ албаны удирдах, гүйцэтгэх албан тушаалд тавигдах тусгай шаардлагыг батлах тухай" /2019.01.11/

Тогтоол 03. "Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам" /2019.01.11/

Тогтоол 05. "Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам"

Тогтоол 14. "Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам" /2019.03.25/

Тогтоол 15. "Төрийн албаны ерөнхий шалгалт өгөх болзол, журам" /2019.03.25/

Тогтоол 16. "Төрийн албан тушаалд шатлан дэвшүүлэх журам" /2019.03.25/

Тогтоол 17. "Төрийн жинхэнэ албаны нөөц бүрдүүлэх журам" /2019.03.25/

Тогтоол 25. "Төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийг сонгон шалгаруулах журам" /2019.05.28/

Тогтоол 27. "Төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг өргүүлэх тухай" /2019.05.30/

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын хамтарсан тушаал:

Тогтоол 34/31. "Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журам" /2019.04.01/

Тогтоол 36/32. "Төрийн жинхэнэ албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах, түүнд гомдол гаргах журам" /2019.04.01/

ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬ

Төрийн албаны 64 дүгээр зүйлд Засгийн газрын бүрэн эрхийг зааж өгсөн байна.

Үүнд: Дээрх хуулийн 64 дүгээр зүйлийн 64.2.6 дахь заалтад төрийн албаны шинэтгэлийн бодлого, стратеги, хүний нөөцийн бодлогын хэрэгжилтийн явц, үр дүнд

хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, түүний үр дүнг дээшлүүлэх талаар санал, зөвлөмж боловсруулах;

64 дүгээр зүйлийн 64.3 дахь хэсэгт Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэргэд төрийн албан хаагчийг сургах, давтан сургах, төрийн албаны хүний нөөцийн менежментийн талаар судалгаа, шинжилгээ хийх, энэ талаар бодлого боловсруулагчид мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх үндсэн үүрэг бүхий Засгийн газрын харьяа төрийн албаны сургалтын байгууллага ажиллана.

66 дугаар зүйлд Төрийн албаны төв байгууллага буюу Төрийн албаны зөвлөлийн бүрэн эрхийг зааж өгсөн. Үүнд:

1. 66 дугаар зүйлийн 66.1.4 дэх заалтад төрийн албаны тухай хууль тогтоомж, энэ хуулийн 3.1.3-т заасан чадахуйн зарчмын хэрэгжилтийн талаар төрийн байгууллагын үйл ажиллагаанд хүний нөөцийн аудит хийх;

2. 66 дугаар зүйлийн 66.1.8 дахь заалтад төрийн албаны шинэтгэлийн бодлого, стратеги, хүний нөөцийн бодлогын хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, түүний үр дүнг дээшлүүлэх талаар санал, зөвлөмж боловсруулах, улсын болон орон нутгийн төсвийн удирдлагын зардлын төслийг боловсруулах, хянаж батлахад зохих журмын дагуу санал гаргах; гэсэн төрийн албаны хүний нөөц, хүний нөөцийн аудиттай холбоотой эрх зүйн зохицуулалтууд байна.

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБА

Төрийн албаны зөвлөлийн Ажлын алба:

"Төрийн албаны зөвлөлд болон төсвийн байгууллагын ерөнхий менежерүүдэд иргэдэд ойр, уян хатан, цомхон, чадварлаг, үр дүнд чиглэсэн бөгөөд идэвхитэй, санаачлагатай манлайлагч менежер бүхий төрийн захиргаа, төрийн албыг бүрдүүлэхэд чиглэгдсэн бодлогын зөвлөгөө өгөх, зохицуулалт хийх, тусгай үйлчилгээ үзүүлэх" юм.

Төрийн албаны зөвлөлийн Ажлын албанд Хүний нөөцийн удирдлага, аудитын газар 9 орон тоотойгоор төрийн жинхэнэ албаны чадахуйн зарчмын хэрэгжилтэд хүний нөөцийн аудит хийх, төрийн албаны шинэтгэлийн бодлого, стратеги, хүний нөөцийн бодлого, төрийн албан дахь жендерийн эрх тэгш байдлын баталгааны хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, төрийн байгууллагын чиг үүргийн шинжилгээ хийх, төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг

хэрэгжүүлэхэд мэргэшил, арга зүйн зөвлөгөө өгөх, албан тушаалын тодорхойлолтыг хянан баталгаажуулах, төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлүүдийг арга зүйн удирдлагаар хангах үндсэн чиг үүрэгтэй ажилладаг.

Газрын дарга, Ахлах референт, Чадахуйн зарчмын хэрэгжилт хариуцсан референт, Хүний нөөцийн бодлогын хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан ахлах шинжээч, Ахлах шинжээч-2, Төрийн албан хаагчийн нийгмийн баталгааны асуудал хариуцсан шинжээч, Төрийн албаны тухай хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилт хариуцсан ахлах мэргэжилтэн, Шуурхай ажлын зохион байгуулалт хариуцсан ажилтан тус тус ажиллаж байна.

Хүний нөөцийн бүрдүүлэлт (Өмнөговь аймгийн жишээн дээр)

Өмнөговь аймаг нь 2012 оноос Оюутны тэтгэлэгт хөтөлбөрийг хэрэгжүүлж, сүүлийн 6 жилд давхардсан тоогоор 600 гаруй оюутныг хамруулсан байна.

Орон нутгийн тэтгэлгээр их, дээд сургуульд суралцаж байгаа оюутнуудаас жилдээ 40-45 оюутан төгсдөг бөгөөд 80 хувь нь хүний нөөцийн дутагдлыг нөхөж, орон нутагт хэрэгцээтэй мэргэжлээр ажилладаг юм. Бусад 20 хувь хүүхэд төрүүлэх, өөр аймаг орон нутагт ажиллах, үргэлжлүүлэн суралцах, гадаад оронд суралцахаар явах гэсэн шалтгаанаар орон нутагт ажилладаггүй байна.

Өмнөговь аймгийн төрийн байгууллагад хүний нөөц дутагдалтай байгаа шалтгааныг тодруулж үзэхэд:

Боловсролын салбарт сүүлийн 4 жилд 600 хүүхдийн 4 цэцэрлэг шинээр байгуулагдсан.

Сумдын ЗДТГ-ын Мал эмнэлгийн тасагт ажиллах мэргэжлийн малын эмч, мал зүйч бэлтгэгдээгүй. Нийт 46 мэргэжилтэн ажиллахаас 45 хувь нь ажиллах хүний нөөцгүй сул орон тоо байна.

Сумдын эрүүл мэндийн төвд хүний их эмч, сувилагч дутагдалтай. Сул орон тоо байгаагийн зэрэгцээ тэтгэврийн насны хүн ажиллуулж байна.


2022-2024 онд Боловсролын салбарт 2160 хүүхдийн 2 сургууль, 300 хүүхдийн 2 цэцэрлэгийн барилга шинээр ашиглалтад орж, ойролцоогоор 280 гаруй шинэ орон тоо бий болно.

Соёлын салбарт 850 хүний суудалтай Хөгжимт жүжгийн театр, дэлхийн жишигт нийцэх Музейг тус тус ашиглалтад оруулсан байгаа бөгөөд одоо 59 ажилтантай ХЖТ-

т стандарт нормоороо 108 хүн ажиллахаар төлөвлөгдөж байна. Гэтэл орон нутагт бэлтгэгдсэн мэргэжлийн дуучин, бүжигчин, хөгжимчин, жүжигчин болон бусад соёлын мэргэжлийн хүний нөөц бэлтгэгдээгүй байна. Мөн Музейд стандартаараа 37 хүн ажиллахаар төлөвлөж байгаагийн зэрэгцээ 2022 онд шинээр Номын сангийн барилгын ажлыг эхлүүлсэн. Энэхүү барилга нь одоо ашиглаж байгаа номын сангийн барилгаас 4 дахин том хэмжээтэй тул орон тоо нэмэгдэх юм. Иймд соёл, урлагийн салбарт мэргэжлийн хүний нөөцийн хэрэгцээ шаардлага бий болж байна.

Өмнөговь аймгийн төрийн албан хаагчийн хүний нөөц

Өмнөговь аймаг нь төрийн байгууллагын цахим сүлжээ И-Оффис программыг 8 дахь жилдээ ашиглаж байна.



Нийт 41 байгууллага, 15 сумын ЗДТГ, Сургууль, цэцэрлэг, эмнэлэг, соёлын төвийн удирдах ажилтнууд болох 1500 гаруй төрийн албан хаагчийг холбосон байдаг.

Төрийн байгууллагын үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх, төрийн албан хаагчийн ажлыг хөнгөвчлөх зорилготой бөгөөд аймгийн хэмжээний төрийн байгууллагын хүний нөөцийг үүнээс харах боломжтой.

Төрийн албан хаагчдын ажлын цаг ашиглалт, үүрэг даалгаврын биелэлт, өргөдөл, гомдол, хариутай бичгийн хариуг цаг хугацаанд нь гүйцэтгэсэн байдлыг “Хар жагсаалт” гэсэн цонхоор дүгнэдэг. **Хар жагсаалтыг судалж үзэхэд:**

2023 оны байдлаар нийт 44 албан хаагчийн “Хар жагсаалт”-ыг судалж үзлээ. 506 хар жагсаалт бүртгэгдсэн байна. **Үүнээс:** Хамгийн олон тоотой хар жагсаалт : ЭГ гэдэг албан хаагч хамгийн их буюу 133 хар жагсаалт бүртгэгдсэн байна. Задалж үзвэл: 335 албан бичиг ирснээс 78 бичгийг хугацааг хэтрүүлж шийдвэрлэсэн, 51 удирдлагын үүрэг даалгавар өгөгдсөнөөс 47 хугацаа хэтрүүлж биелүүлсэн байна.

Хамгийн цөөн тоотой хар жагсаалт: Т.М - 4 хар жагсаалт бүртгэгдсэн. 154 албан бичиг ирснээр 3 албан бичгийн хугацааг хэтрүүлж шийдвэрлэсэн. 60 өргөдөл ирснээс 100 хувь хугацаанд нь шийдвэрлэж хариуг нь өгсөн байна. 52 үүрэг даалгавар өгөгдсөнөөс 1 үүрэг даалгаврыг хугацаа хэтрүүлж биелүүлсэн байна.

Ажлын цаг ашиглалт: Ажлын цагийн хоцрогдол- 3273 минут буюу 54 цаг 55 минут ажлаасаа хоцорсон байна. Үүнд: Э.Ө- 10 цаг.48 минут хоцорсон бол 20 хүн хоцроогүй байна. Үүнээс 7 нь удирдах албан тушаалтан байгаа бөгөөд цагаа бүртгүүлэхгүй байх магадлалтай гэж үзлээ.

Энэхүү программд байгаа 1500 гаруй төрийн албан хаагчийн ажлын цаг ашиглалт, ажлын гүйцэтгэл, ажлын ачааллыг судлах боломжтой юм.

Дүгнэлт

1. Төрийн албаны хууль түүнийг даган гарсан дүрэм журмын хэрэгжилт хангалтгүй байгаа тул хэрэгжүүлж хэвшүүлэх
2. Төрийн албан хаагчийн хүний нөөц дутагдалтай байгаа тул мэргэжлийн хүний нөөцийг бэлтгэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулдаг тогтолцоог бий болгох хэрэгцээ байна.
3. Төрийн албаны залгамж чанар, тогтвортой байдал алдагдсан бөгөөд орон нутгийн сонгуулийн үр дүнд төрийн захиргааны албан хаагчийн 30-40 хувь нь шалтгаангүйгээр өөрчлөгдөж байна.
4. Төрийн албан хаагчийн ерөнхий шалгалтад орж байгаа иргэдийн 70 хувь тэнцэхгүй байгаа тул шалгалтад орох иргэдийг нэгдсэн зохион байгуулалтаар бэлтгэж, чадваржуулах шаардлага байна.
5. Төрийн захиргааны албанд чадахуйн зарчмыг баримталж томилгоо хийдэг зарчмыг хэвшүүлэх.
6. Төрийн албаны хүний нөөцийн аудитыг үе шаттайгаар тогтмол зохион байгуулж, төрийн албыг мэргэшсэн, тогтвортой байлгах нь чухал гэж үзэж байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ, НОМ ЗҮЙ

1. Н.Бурмаа “Төрийн байгууллагын хүний нөөцийн аудит” 2021 он
- 2.Төрийн албаны тухай хууль
- 3.Төрийн албаны зөвлөлийн вэб сайт
4. Өмнөговь аймгийн төрийн албаны и-оффис программ
5. Өмнөговь аймгийн төрийн байгууллагын хүний нөөцийн 2021-2024 оны судалгаа
- 6.Өмнөговь аймгийн оюутны тэтгэлэгт хөтөлбөрийн журам

SPSIRPA FORUM 2024

Poster presentation 2

The Influence of Culture and Personality on Small Country Diplomacy: A Case Study of Mongolia



“Жижиг улсын гадаад бодлого дипломат ажиллагаан дахь соёл ба зан төлөвийн нөлөөлөл: Монгол Улсын жишээн дээр”

"The impact of culture and behavior on the foreign policy and diplomacy of small countries: in the case of Mongolia"

Б. Мөнх-Өлзий¹, Х. Айслан²

Хураангуй

Судалгааны үндэслэл: Жижиг улс гэдэг нь хүн ам, газар нутгийн хэмжээ, эдийн засгийн хүчин чадлаараа дэлхийн том улсуудаас харьцангуй бага улсыг хэлнэ. Жижиг улс орнуудын гадаад бодлого нь тухайн улсын онцлог шинж чанар, давуу тал, сул талыг тодорхойлдог. Монгол Улс нь жижиг улсын нэг бөгөөд гадаад бодлогын хувьд соёл, зан төлөвийн хүчин зүйлсийг хэрхэн харгалзан үздэгийг судлах нь чухал юм. Энэ нь тухайн улсын гадаад харилцааны онцлогийг илүү гүнзгий ойлгоход тусална. Монгол Улс нь Орос, Хятадын дунд орших геополитикийн өвөрмөц байрлалтай, олон мянган жилийн нүүдэлчин соёлтой ард түмэн билээ. Монголын соёл, зан чанарын өвөрмөц хэв маяг болон гадаад бодлогын хандлага, дипломат ажиллагааны хооронд тодорхой уялдаа холбоо, нөлөөлөл оршиж байгаа гэж үзэж байна. Дэлхийн удирдагчдын хэлсэн үг, гадаад бодлогын сургаал, стратегиас уншихад соёл, дэлхийн соёлын өвийн тухай дурдах нь улам бүр нэмэгдэж байна.

Судалгааны зорилго: Энэхүү судалгааны зорилго нь хоёр том гүрний дунд орших жижиг улсын хувьд Монголын гадаад бодлогын хандлага, дипломат ажиллагаанд үндэсний зан төлөв, соёл хэрхэн нөлөөлж байгааг олж тогтооход оршино.

Судалгааны арга зүй:

Судалгааны зорилгын хүрээнд бид Их-тав загвар, Хофстидын соёлын загвар, материалын хагас системчлэн шинжилгээ зэрэг судалгааны аргазүй хэрэглэнэ. Тус судалгаа нь олон улсын харилцаа, дипломат ажиллагаа, зан төлөв, соёлын холбогдох онолууд дээр үндэслэгдэнэ. Монголын соёл, зан төлөвийн онцлогийг судлах, тэдгээрийг гадаад бодлогод хэрхэн нөлөөлж буйг тодорхойлоно. Монгол Улсын гадаад бодлого, дипломат ажиллагаан дахь практик жишээнүүдийг цуглуулж, дүн шинжилгээ хийнэ.

¹ ОУХТ, PhD, дэд профессор.

² ОУХ-ны мэргэжлийн докторант, 20D1NUM0179.

Судалгааны шинэлэг тал: Монгол Улс нь нүүдэлчин соёлтой ард түмэн учраас энэ талаар өмнө нь судалгаа цөөхөн буюу нарийн хийгдэж байгаагүй эсэхийг шинэлэг тал гэж авч үзнэ.

Судалгааны ач холбогдол: Монгол Улсын гадаад бодлогын хандлага болон дипломат ажиллагаанд ард түмний соёл ба зан чанар ямар нөлөөлөл үзүүлж байгаа, эдгээрийн хооронд ямар уялдаа холбоо байгааг Монголын жишээн дээр сонгож судалж байгаад оршино.

Судалгааны үр дүн: Монгол Улсын гадаад бодлогод соёлын нөлөөллийг дараах байдлаар тодорхойлж болно. Монгол Улс үндэсний уламжлалт соёл, зан заншлаа хадгалж, хөгжүүлэх замаар үндэсний онцлогийг гадаад бодлогодоо тусгадаг. Монгол Улс бусад орнуудтай соёл, урлаг, боловсрол, шинжлэх ухааны салбарт хамтран ажиллах замаар соёлын нөлөөллийг өргөжүүлдэг. Соёлын дипломат үйл ажиллагаа: Монгол Улс соёлын өдрүүд, үзэсгэлэн, арга хэмжээ зохион байгуулах замаар өөрийн соёлыг сурталчилж, гадаад бодлогодоо ашигладаг. Монгол Улс өвөрмөц байгаль, түүх, соёлоо ашиглан аялал жуулчлалыг хөгжүүлж, гадаад бодлогодоо эерэг нөлөө үзүүлдэг. Монгол Улс олон соёл, ястан угсаатны харилцаанд нээлттэй хандаж, тэдгээрийн соёлын нөлөөллийг хүндэтгэн үздэг. Тийм учраас, Монгол Улсын гадаад бодлогод соёлын нөлөөллийг хэрэгжүүлэх гол арга замууд юм. Монгол Улс үндэсний онцлогоо хадгалж, хөгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж байна.

Монгол Улсын гадаад бодлогод зан төлөвийн уялдаа холбоо нь чухал ач холбогдолтой. Монголчууд эв нэгдэл, зөвшилцөл, шударга ёс, хүндэтгэл зэрэг зан төлөвийг эрхэмлэдэг нь гадаад харилцаанд ч чухал үүрэгтэй. Монголчууд бусад орны соёл, зан төлөвийг хүндэтгэж, тэдэнтэй харилцан ойлголцохыг эрмэлздэг нь гадаад бодлогод эерэг нөлөө үзүүлдэг. Монгол Улс олон соёл, үндэстнийг хүндэтгэж, тэдгээрийн зан төлөвийг судалж, өөрийн бодлогодоо тусгах замаар гадаад бодлогодоо ашигладаг. Тиймээс, Монгол Улсын гадаад бодлогод зан төлөвийн уялдаа холбоог илэрхийлж байна. Монгол Улс үндэсний онцлогоо гадаад бодлогодоо тусган ашиглах замаар олон улсын тавцанд өөрийн байр суурийг бэхжүүлэхийг эрмэлздэг.

Ийнхүү Монгол Улсын гадаад бодлого, дипломат ажиллагааны соёл, зан төлөвийн нөлөөллийг судалснаар тус улсын олон улсын харилцааны онцлогийг илүү гүнзгий ойлгоход тус дөхөм болох юм.

Түлхүүр үгс: жижиг улс, гадаад бодлого, дипломат ажиллагаа, соёл, зан төлөв, олон улсын харилцаа.

1. Оршил:

Юуны түрүүнд соёл болон зан төлөв тухай мэдэх хэрэгтэй. Соёл нь хүний байнгын, идэвхтэй, чөлөөт үйл ажиллагааны үр дүнд бий болж уламжлагдаж байдаг хэм хэмжээ, итгэл үнэмшил, билэг тэмдэг, үнэт зүйлсийн цогц, хүний хөгжлийн түвшин юм. Өөрөөр хэлбэл соёл нь хүний ололт амжилтын цогцол юм.³ Зан төлөв бол хувь хүний бодит, тогтвортой сэтгэц зүйн үзэгдлийн нийлбэр цогц бөгөөд тухайн хүний хүрээлэн буй орчинд хандах хандлага, биеэ авч явах байдлаар илэрнэ. Грек хэлнээс орчуулахад "зан төлөв"⁴ гэдэг нь онцлог шинж гэсэн утгыг илэрхийлнэ.

Дэлхий өнөөгийн үеийн байдлаар олон улсын харилцааны хүрээнд харилцан уялдаатай ба харилцан хамааралтай юм. Тиймээс "жижиг улс орнуудын" хувьд олон улсын харилцааны хүрээнд дотоод болон гадаад бодлого их нөлөө үзүүлдэг тул чухал ач холбогдолтой юм.⁵ Монгол Улс бол олон улсын харилцаанд "ажиглагч" байр суурь баримталдаг улс тул өнгөрсөн зууны дэлхийн түүхийн салшгүй хэсэг юм. Дэлхий ертөнцийн хувьсан өөрчлөлтийн нөлөөгөөр жижиг улс төдийгүй, их гүрнүүдийн оршин тогтнол, улс төрийн нөлөөлхүйц хүчин зүйлүүд урган гарсаар байна. Энэ асуудлыг судалж, цаашид түүнд хэрхэн хандах нь улс бүрийн тулгамдсан асуудал учир уг сэдвийг сонгон судлах болсон.

Монгол Улсын ардчилсан өөрчлөлтийн эхний үе шатанд дэлхийн үйл явцаас тусгаарлалтыг даван туулах ёстой байв. Харин одоохондоо Монгол Улсын хоёр их гүрэн хөрш нь тогтвортой байгаа нь аюулгүй байдалд нь сайнаар нөлөөлж байна гэж дүгнэдэг. Өөрөөр хэлбэл, Орос болон Хятад хоёр улс бүрэн бүтэн хүчирхэг байгаа учраас хоорондоо бас найрсаг харилцаатай байна. Гэвч ийм байдал хэр удаан үргэлжлэх вэ гэдгийг мэдэх боломжгүй юм. Эндээс хоёр их гүрэн хөрш Монголын улс төрийн соёлын хүрээнд аль хэн нэгэн ирээдүйд илүү нөлөө үзүүлэх нь магадгүй болно.

Монгол Улс нь жижиг улсын нэг⁶ бөгөөд гадаад бодлогод соёл, зан төлөвийн хүчин зүйлсийг чухалчилдаг. Монголын уламжлалт соёл, түүхэн уламжлал, энгийн зан төлөв, байгаль орчин, бүс нутгийн хамтын ажиллагаа зэрэг нь Монголын гадаад бодлогын чухал хэсэг болдог. **Уламжлалт нүүдэлчин соёл, түүх нь** Монголын өв соёлыг хадгалах, дэлхийд таниулах, хөрш орнуудтай найрсаг харилцаа тогтооход нөлөөлдөг. Түүхэн уламжлал нь эзэнт гүрний үеийн харилцааг бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой.

³ Д. Буян (2006). Нийгмийн тухай мэдлэг. х.123.

⁴ Прохоров А.М. "Большой энциклопедический словарь". (1997). х.72

⁵ Khalel, Agnur, Fatima Mamedova, and Elnara Dulaeva. "Diplomatic discourse in cross-cultural dimension." *Orpción: Revista de Ciencias Humanas y Sociales* 26 (2020): 407-422.

⁶ Г. Баасанхүү нар (2016) Муис, "Олон Улсын харилцааны үндэс ба даяаршил", УБ, Муис пресс,

Монголчуудын энгийн, нээлттэй, зөөлөн хандлага нь олон улсын тавцанд идэвхтэй оролцогч байдлыг бий болгодог бөгөөд бүс нутгийн интеграцид идэвхтэй оролцож, Евразийн эдийн засгийн холбоо зэрэг байгууллагуудтай хамтран ажилладаг. Монгол орны байгалийн үзэсгэлэнт газар нутаг, эрс тэс уур амьсгал нь аялал жуулчлалыг хөгжүүлэхэд түлхэц болж, эдийн засгийн бие даасан байдлыг хангахад чухал үүрэг гүйцэтгэдэг. Цаашид ч Монгол Улс өөрийн онцлог шинж чанар, соёл, зан төлөвийг гадаад бодлогодоо тусган хөгжүүлэх нь зүйтэй юм.

Сэдвийн судлагдсан байдал:

Ien Ang, Yudhishtir Raj Isar & Phillip Mar нарын "Cultural Diplomacy: Beyond the National Interest?"⁷ өгүүлэлд соёлын дипломат үйл ажиллагаа нь улс орнуудын үндэсний ашиг сонирхлыг өргөжүүлэх, олон улсын харилцаанд эерэг нөлөө үзүүлэх тухай авч үзсэн байдаг. Тэд соёлын дипломат үйл ажиллагаа нь улс орнуудын хоорондын ойлголцол, итгэлцлийг бэхжүүлэх, соёл хоорондын харилцан ойлголцлыг дээшлүүлэхэд чухал үүрэгтэй гэж үзсэн байна.

Wiarda, Howard J судлаачийн "Culture and Foreign Policy: The Neglected Factor in International Relations"⁸ номонд соёл нь гадаад бодлого, дипломат ажиллагаанд хэрхэн нөлөөлдөг талаар авч үзсэн байдаг. Тэрээр соёл нь улс орнуудын үзэл бодол, үнэт зүйлс, хандлага, үйл ажиллагаанд шууд болон шууд бусаар нөлөөлдөг гэсэн байна.

Авторитар хувь хүний шинж чанар нь тухайн улсын гадаад бодлогод хэрхэн нөлөөлдөг талаар Daniel J. Levinson – ы "Authoritarian personality and foreign policy"⁹ судалгааны өгүүлэлд авч үзсэн байдаг. Тэр авторитар удирдагчид нь улс төрийн эрх мэдлийг төвлөрүүлэх, хяналтаа тогтоохыг эрмэлздэг нь тухайн улсын гадаад бодлогод заримдаа сөргөөр нөлөөлдөг гэж үзэж байна.

Felix S. Bethke судлаачийн "Cultural Bias in the Perception of Foreign-Policy Events"¹⁰ бүтээлд соёл, үндэсний онцлогоос шалтгаалж гадаад бодлогын үйл явдлыг өөр өөрөөр ойлгох, үнэлэх нь байдаг талаар авч үзсэн байдаг. Энэ нь тухайн улсын гадаад бодлогод хэрхэн нөлөөлж болохыг дурдсан байна.

⁷ Ien Ang, Yudhishtir Raj Isar & Phillip Mar (2015) Cultural diplomacy: beyond the national interest?, International Journal of Cultural Policy, 21:4, 365-381, DOI: 10.1080/10286632.2015.1042474

⁸ Wiarda, H. J. (2016). Culture and foreign policy: The neglected factor in international relations. Routledge.


⁹ Levinson, D. J. (1957). Authoritarian personality and foreign policy. Conflict Resolution, 1(1), 37-47.

¹⁰ Bethke, Felix S. (2016). Cultural Bias in the Perception of Foreign-Policy Events. No. 14. Global Cooperation Research Papers.

Caitlin Smith-ийн "Personality in Foreign Policy Decision-Making"¹¹ судалгааны өгүүлэлд улс орны гадаад бодлогын шийдвэр гаргалтад тухайн улсын удирдагчийн хувийн шинж чанар хэрхэн нөлөөлдөг талаар авч үзсэн байдаг. Тэрээр авторитар, демократик зэрэг удирдагчийн шинж чанарын ялгаа нь гадаад бодлогод хэрхэн нөлөөлдөг талаар жишээ, баримтуудаар тайлбарласан байна.

Zaara Zain Hussain судлаачийн “The effect of domestic politics on foreign policy decision making”¹² өгүүлэлд дотоод улс төрийн бодлого нь гадаад бодлогын шийдвэр гаргалтад хэрхэн нөлөөлдөг талаар авч үзсэн байна. Тэрээр дотоод улс төрийн хүчин зүйлс нь гадаад бодлогын шийдвэрт хэрхэн нөлөөлдөг эсэхийг судалсан байна.

Онол, аргазүйн бүдүүвч



Хофстидийн онол¹³ нь улс орнуудын хөгжлийн загварыг тодорхойлдог чухал онол юм. Энэ онолын дагуу улс орнууд өөрсдийн онцлогт тохирсон хөгжлийн загварыг сонгох ёстой гэж үздэг. Монгол Улсын хувьд Хофстидийн онол нь үндэсний соёлд хэрхэн нөлөөлж байгааг авч үзье:

1. **Power Distance Index:** Эрх мэдлийн зай гэдэг ойлголт нь тухайн нийгмийн эрх мэдэл багатай гишүүд эрх мэдлийн тэгш бус хуваарилалтыг хүлээн зөвшөөрч, хүлээж буйг илэрхийлдэг. Монголын соёлд шаталсан бүтцийн түүхэн нөлөө, ялангуяа уламжлалт нүүдэлчин нийгмийн нөхцөл байдал нь хүч чадлын харьцангуй өндөр зайд нөлөөлж болох юм. Эрх мэдэл, нас, гэр бүл, нийгмийн

¹¹ Smith, C. (2012). Personality in foreign policy decision-making. E-International Relations, 16.

¹² Hussain, Z. Z. (2011). The effect of domestic politics on foreign policy decision making. E-International Relations, 7.

¹³ Hofstede, G. (2009). Geert Hofstede cultural dimensions.

хүрэн дэх шаталсан бүтцийг хүндэтгэх нь Монголын соёлд эрх мэдлийн өндөр зайг илэрхийлж болно.

2. **Individualism vs. Collectivism:** Монгол Улс түүхэндээ нэгдэлч үзэл баримтлалтай, гэр бүл, хамт олон, бүлгийн эв найрамдлын чухал ач холбогдлыг чухалчилдаг нийгэм байсаар ирсэн. Хотжилт, модернизаци нь хувь хүн рүү шилжих шилжилтэд нөлөөлж болох ч Хофстидийн хэмжүүрийн дагуу нэгдэлч үзэл баримтлал нь Монголын соёлд чухал үүрэг гүйцэтгэсэн хэвээр байна.
3. **Masculinity vs. Femininity:** Хофстидийн эрэгтэй ба эмэгтэйлэг байдлын хэмжигдэхүүн нь хүйсийн хоорондын сэтгэл хөдлөлийн үүргийн хуваарилалтыг илэрхийлдэг. Хатуу ширүүн орчин, нүүдэлчин амьдралын хэв маягийг даван туулахад тэсвэр хатуужил, хүч чадлыг түүхэн онцолдог монгол соёл нь эрэгтэй хүний шинжтэй илүү ойртож магадгүй юм. Гэсэн хэдий ч нийгмийн янз бүрийн салбарт, ялангуяа нүүдэлчин мал аж ахуйд эмэгтэйчүүдийг хүндэтгэх, оролцуулах уламжлалт ёс заншил нь соёлын хүрээнд эмэгтэйлэг шинж чанарыг илтгэж магадгүй юм.
4. **Uncertainty Avoidance Index:** Тодорхой бус байдлаас зайлсхийх гэдэг нь нийгэм тодорхой бус нөхцөл байдлын аюул заналхийллийг мэдэрч, түүнээс зайлсхийхийг оролдохыг хэлнэ. Монгол Улс нүүдэлчин ахуйдаа дасан зохицож ирсэн түүхтэй, хүнд хэцүү, ихэвчлэн урьдчилан таамаглах боломжгүй орчинд тодорхойгүй байдлыг тэсвэрлэх, өөрчлөгдөж буй нөхцөл байдалд дасан зохицох хүсэл эрмэлзэлтэй байж болох бөгөөд энэ нь тодорхойгүй байдлаас зайлсхийх хандлагатай нийцэж магадгүй юм.
5. **Long-Term Orientation:** Энэ хэмжигдэхүүн нь соёл нь өнгөрсөн, одоо, ирээдүйтэй холбоотой буяныг төлөвшүүлэх түвшинг илэрхийлдэг. Нүүдэлчдийн өв уламжлал, байгалийн мөчлөгийн хэв маягт гүн гүнзгий шингэсэн Монголын уламжлалт соёл нь урт хугацааны чиг баримжааг онцолж, тэсвэр тэвчээр, хэмнэлттэй, тогтвортой дадал зуршилд анхаарлаа хандуулдаг.

Товчхондоо, Хофстедегийн онол нь Монголын соёлын хэмжүүрүүдэд дүн шинжилгээ хийж, ойлгоход үнэ цэнэтэй болж өгдөг. Гэсэн хэдий ч соёл нь хөгжих бөгөөд байнга хувьсан өөрчлөгдөж байдаг. Хотжилт болон бусад нөлөөллийн нөлөөгөөр цаг хугацааны явцад өөрчлөлт гарч болзошгүй гэдгийг анхаарах нь чухал юм.

Их тав зан төлвийн онолын¹⁴ загвар нь Монгол Улсын үндэсний зан төлөвт хэд хэдэн талаар нөлөөлж байна:

1. **Extraversion vs. Introversion:** Монголчууд нийгмийн идэвхтэй, бусадтай харилцахдаа эерэг хандлагатай байдаг нь экстравертын шинж чанартай холбоотой. Гэхдээ хувь хүний онцлогоос хамаарч энэ нь харилцан адилгүй байж болно.
2. **Agreeableness vs. Disagreeableness:** Монголчууд энэрэнгүй, бусдыг хүндэтгэдэг зан төлөвтэй нь сэтгэл хөдлөлийн тогтвортой байдлыг илэрхийлнэ. Харин маргаантай асуудалд шударга, шүүмжлэлтэй хандах нь эл зан төлөвт нийцнэ.
3. **Openness to experience:** Монголчууд уламжлалт соёлоо хүндэтгэх хандлагатай ч шинэ санаа, өөрчлөлтийг хүлээн авахдаа нээлттэй хандах хандлага ажиглагддаг.
4. **Conscientiousness:** Монголчууд хариуцлагатай, зохион байгуулалттай байх үүрэг хариуцлагыг чухалчилдаг нь өөртөө итгэлтэй, хариуцлагатай зан төлөвтэй холбоотой.
5. **Neuroticism:** Монголчууд шинэ сорилт, бэрхшээлийг даван туулахдаа тэвчээртэй, шийдэмгий байдаг нь тогтвортой, тэсвэртэй байдлыг харуулна.

Эдгээр хүчин зүйлс нь Монгол Улсын үндэсний зан төлөв, соёлын онцлогийг бүрдүүлж, тодорхойлдог. Гэхдээ хувь хүний онцлог, нийгэм, цаг үеийн өөрчлөлтөөс шалтгаалан энэ бүхэн аажмаар хувьсаж, шинэчлэгдэж байгаа юм.

Тиймээс, Хофстидийн онол ба Их тав зан төлвийн онол нь өөр өөр зорилготой, өөр өөр хүрээг хамарсан онолууд юм. Орчин үеийн Монгол Улсад эдгээр онолууд хэрхэн нөлөөлж байгаа талаар судалгаа хийгээгүй байна. Гэхдээ улс орны хөгжил, нийгмийн өөрчлөлт нь соёл, зан төлөвийг өөрчилж, шинэ хандлага, үнэт зүйлсийг бий болгож байдаг. Эдгээр өөрчлөлт нь олон улсын харилцаа, гадаад бодлого, улс төр, бизнес, боловсрол, хүмүүнлэгийн салбарт нөлөөлж, шинэ соёл, зан төлөв бий болгох хандлагатай байна. Иймд соёл, зан төлөвийн өөрчлөлтийг судлах, ойлгох нь чухал юм.

Баруун судлаачдын өнцгөөс "**Personality traits and Foreign policy attitudes: A Cross-National Exploratory Study**"¹⁵ – гэдэг судалгааны өгүүлэлд дурдсанаар хувь хүний хувийн зан төлөв (personality traits) нь тухайн улсын гадаад бодлогын хандлага (foreign policy attitudes)-д нөлөөлдөг гэсэн онол гаргасан байна. Өөрөөр хэлбэл, хувь хүмүүсийн

¹⁴ Roccas, Sonia, Lilach Sagiv, Shalom H. Schwartz, and Ariel Knafo. "The big five personality factors and personal values." *Personality and social psychology bulletin* 28, no. 6 (2002): 789-801.

¹⁵ Gravelle, Timothy B., Jason Reifler, and Thomas J. Scotto. "Personality traits and foreign policy attitudes: A cross-national exploratory study." *Personality and Individual Differences* 153 (2020): 109607.

хувийн зан чанар нь улс орны гадаад харилцааны чиг хандлагад нөлөөлдөг гэж үзжээ. Харин, Монгол Улсын жишээн дээр авч үзвэл:

1. Монголчуудын хувьд эв нэгдэл, зөвшилцлийг эрхэмлэх нь түгээмэл зан төлөв юм. Энэ нь Монгол Улсын гадаад бодлогод ч мөн адил тусгалаа олсон байж болох юм. Жишээлбэл, олон улсын хамтын ажиллагааг чухалчилж, энхийг эрмэлзэх замаар гадаад бодлогоо хэрэгжүүлдэг.

2. Монголчууд уламжлалаа дээдлэх, шинэ зүйлийг туршихдаа болгоомжтой ханддаг. Энэ нь гадаад харилцаанд ч мөн адил нөлөөлж, шинэ хамтын ажиллагаа, гэрээ хэлэлцээрийг нарийн нягтлан үзэж, эрсдэлийг сайтар тооцох хандлагатай байж болно.

3. Монголчууд нээлттэй, найрсаг зан төлөвтэй. Энэ нь гадаад бодлогод ч мөн адил нөлөөлж, бусад улс орнуудтай харилцахдаа нээлттэй хандаж, хамтын ажиллагааг бэхжүүлэхийг эрмэлздэг.

4. Монголчууд уламжлалт ардчилсан ёс, ардчилсан сонгуулийн тогтолцоог эрхэмлэдэг. Энэ нь гадаад бодлогод ард түмний санаа бодлыг тусгах, тэдэнтэй харилцахад чухал үүрэгтэй.

Тиймээс, дээр дурьдсан жишээнүүд нь хувь хүний хувийн зан төлөв нь улс орны гадаад бодлогод нөлөөлдөг гэсэн онолыг орчин үеийн Монгол Улсын жишээн дээр тайлбарлахад ашиглаж болох юм. Гэхдээ энэ бол зөвхөн нэг талын харьцуулалт бөгөөд бусад хүчин зүйлс ч гадаад бодлогод нөлөөлдөг гэдгийг анхаарах хэрэгтэй юм.

Ж. Мондак судлаачийн "**Personality and the Foundations of Political Behavior**"¹⁶ номын гол санаа нь хувь хүний зан чанар, хувийн шинж чанар нь улс төрийн үйл ажиллагаанд нөлөөлдөг гэдгийг онцолсон байдаг. Уг номд хувь хүний зан чанар, үнэт зүйлс, итгэл үнэмшил нь сонгуулийн үйл явцад хэрхэн нөлөөлдөг, ямар үр дагавартай байдаг талаар судалсан байна. Түүнчлэн энэ нь улс төрийн шийдвэр гаргалтад хэрхэн нөлөөлдөг талаар ч дурдсан байдаг. Орчин үеийн Монгол Улсын хувьд энэхүү онол нь гадаад бодлогод ч хувь хүний хувийн шинж чанар хэрхэн нөлөөлж буйг харуулж болох юм. Жишээлбэл, Монгол Улсын гадаад бодлого, гадаад харилцааны үйл ажиллагаанд Ерөнхийлөгч, Гадаад харилцааны сайд нарын хувийн уламжлал, үнэт зүйлс, итгэл үнэмшил хэрхэн нөлөөлж буйг авч үзэж болох юм. Түүнчлэн Монгол Улсын гадаад бодлогын чиглэл, байр суурь, үйл ажиллагаанд ч энэ нь чухал үүрэгтэй байж болох юм. Ерөнхийдөө хувь хүний хувийн шинж чанар нь улс төрийн шийдвэр гаргалт, улс төрийн бодлого, сонгуулийн үйл явц, гадаад бодлогод ихээхэн нөлөөтэй байдаг нь тус номын гол

¹⁶ Mondak, J. J. (2010). *Personality and the foundations of political behavior*. Cambridge University Press.

санаа юм. Энэ нь Монгол Улсын дотоод, гадаад амьдралд ч ажиглагдаж буй үзэгдэл гэж харж болохоор байна.

2. Монгол Улсын үндэсний соёл, зан төлөв нь гадаад бодлого, дипломат ажиллагаанд ямар нөлөө үзүүлж байгаа вэ?

Монгол Улсын үндэсний соёл, зан төлөв нь гадаад бодлогын хандлага, дипломат ажиллагаанд дараах байдлаар нөлөө үзүүлдэг гэж авч болно:

1. Найрсаг байдал: Монголчууд бусдыг хүндэтгэх, найрсаг байх үндэсний онцлогтой. Энэ нь гадаад харилцаанд эерэг хандлага, хамтын ажиллагааг бэхжүүлдэг.

2. Шударга байдал: Монголчууд шулуун шударга, үнэнч шударга байдлыг эрхэмлэдэг. Энэ нь олон улсын харилцаанд итгэлцэл, үнэнч байдлыг бий болгодог.

3. Зөвшилцөх чадвар: Монголчууд зөвшилцөх, эв нэгдлийг эрхэмлэх зан төлөвтэй. Энэ нь олон талт хэлэлцээ, яриа хэлэлцээнд ач холбогдолтой.

4. Хүлээцтэй, тэвчээртэй байдал: Монголчууд хүндрэл бэрхшээлийг даван туулахдаа тэвчээртэй, хүлээцтэй байдлыг харуулдаг. Энэ нь урт хугацааны харилцаанд тустай.

5. Эх оронч үзэл: Монголчууд эх орондоо хайртай, эх оронч үзэлтэй. Энэ нь гадаад бодлогод тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг хамгаалахад анхаардаг.

Тийм учраас, эдгээр хүчин зүйлс нь Монгол Улсын гадаад бодлого, олон улсын харилцаанд үндэсний онцлог, давуу талыг бий болгож байна. Гэхдээ орчин үеийн нөхцөл байдалд нийцүүлэн гадаад бодлогоо уян хатан, оновчтой байлгах шаардлагатай гэж бодолтой юм.

3. Монгол Улсын улс төрчдийн соёл ба зан төлөв яаж гадаад бодлого, дипломат ажиллагаанд нөлөөлөлж байгаа вэ?

Орчин үеийн Монгол Улсын хувьд соёлын дипломат үйл ажиллагаа нь гадаад бодлогын чухал хэсэг болж, улс орны гадаад харилцаа, нэр хүнд, соёлын дэлхий нийтийн танилцуулгад ихээхэн хувь нэмэр оруулж байна. Тухайлбал, Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газрын тэргүүн нар гадаад орнуудад айлчлахдаа Монголын уламжлалт соёл, өв уламжлалыг сурталчлан таниулах, соёлын арга хэмжээ зохион байгуулах замаар соёлын дипломат үйл ажиллагаа явуулдаг. Монгол Улсын Элчин сайдын яамд, Консулын газрууд тухайн орны соёл, түүх, зан заншлыг судалж, монголчуудад таниулах, монголын соёлыг түгээн дэлгэрүүлэх чиглэлээр идэвхтэй ажилладаг.¹⁷

¹⁷ Д. Уламбаяр (2018). Гадаад дүн шинжилгээ, бодлогын шийдвэр гаргах механизм, ХУИС, лекц.

Монгол Улсын хувьд дотоод улс төрийн нөхцөл байдал нь гадаад бодлогын шийдвэр гаргалтад нөлөөлдөг хэдий ч ардчилсан үнэт зүйлс, хууль дээдлэх ёсны үндсэн дээр улс төрийн шийдвэр гаргах үйл явц илүү тогтвортой, нээлттэй байдаг. Гэхдээ эдийн засгийн хүндрэл, улс төрийн тогтворгүй байдал зэрэг дотоод хүчин зүйлс нь гадаад бодлогын шийдвэрт нөлөөлж болзошгүй юм.¹⁸ Нөгөө талаас, Монгол Улс нь бүс нутаг, дэлхийн хэмжээнд өрнөж буй үйл явцад өөрийн байр суурийг илэрхийлэх, ашиг сонирхлоо хамгаалахын тулд гадаад бодлогын шийдвэр гаргадаг. Энэ нь эргээд дотоод улс төрийн орчинд нөлөөлж, улс төрийн шийдэлд тусгалаа олдог байна. Дотоод, гадаад бодлогын уялдаа холбоо нь улс орны тогтвортой хөгжил, аюулгүй байдалд чухал ач холбогдолтой юм.

Монгол Улсын улс төрчдийн соёл, зан төлөв нь гадаад бодлого, дипломат ажиллагаанд дараах байдлаар нөлөөлж байгаа гэж үзэж байна:

1. **Уламжлалт арга барил:** Монголчууд уламжлалаа дээдлэх, зөвшилцөх, эв найрамдал бий болгох арга барилтай. Энэ нь гадаад харилцаанд ч мөн адил илэрдэг бөгөөд бусад улстай харилцахдаа эелдэг, нээлттэй хандах хандлагыг бий болгодог.
2. **Нээлттэй байдал:** Монголчууд нээлттэй, найрсаг зан чанартай нь гадаад харилцаанд ч эерэг нөлөө үзүүлдэг. Бусад улстай харилцахдаа нээлттэй, чин сэтгэлээсээ хандах нь харилцан ойлголцоход тустай.
3. **Зөвшилцөх чадвар:** Монголчууд маргаантай асуудлыг эв зүйгээр шийдвэрлэх, зөвшилцөх чадвартай. Энэ нь олон улсын харилцаанд ч хэрэг болдог бөгөөд маргаантай асуудлыг эвийн журмаар шийдвэрлэхэд тустай.
4. **Уян хатан байдал:** Монголчууд уян хатан, дасан зохицох чадвартай. Энэ нь гадаад орчны өөрчлөлтөд хурдан дасан зохицож, шаардлагатай үед бодлогоо өөрчлөхөд хэрэгтэй.
5. **Түүхэн уламжлал:** Монголын эзэнт гүрний өв, түүхэн уламжлал нь Монголын нэр хүнд, байр суурийг олон улсад бэхжүүлдэг. Үүнийг гадаад бодлогодоо ашиглаж явдаг.

Гэхдээ орчин үеийн улс төрийн соёл, зан төлөв нь уламжлалт соёлоос ихээхэн ялгаатай болсон. Иймд улс төрчид өөрсдийн болон бусдын соёлыг ойлгох, хүндэтгэх, зохистой хандах нь гадаад бодлогын үр дүнд эерэгээр нөлөөлнө.

¹⁸ Mwagiru, Makumi. "The Diplomacy of Partition Revisited: African–Asian Relations and the Economic Diplomacy of Security." *Africa Review* 5, no. 2 (2013): 148

4. Монгол Улсын ард түмний соёл ба зан төлөв яаж гадаад бодлого, дипломат ажиллагаанд нөлөөлөлж байгаа вэ?

Монголын ард түмний соёл, зан төлөв нь улс орны гадаад бодлого, дипломат ажиллагаанд чухал нөлөө үзүүлдэг юм. Тухайлбал, ахмад настныг хүндэтгэх, зочломтгой, найрсаг харилцаанд суурилсан уламжлалт Монгол соёл нь олон улсын харилцаанд эерэгээр нөлөөлж, дипломат ажилагааг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулж нөлөөлдөг. Мөн Монголын ард түмний үндэсний онцлог, бахархал нь олон улсын хэлэлцээ, шийдвэрт тэдний байр суурьт нөлөөлж чадах чухал хүчин зүйл юм. Соёлын үнэт зүйл, уламжлал нь гадаад бодлогын стратегийн үндэс болж, дэлхийн тавцанд Монгол Улсын байр суурийг бэхжүүлэхэд тустай.

Монголчуудын нүүдэлчин соёл нь байгаль орчноо хайрлан хамгаалах, эв найртай байх үзэл санааг төлөвшүүлсэн. Энэ нь байгаль орчны хамтын ажиллагаа, энх тайвны төлөөх үйл ажиллагаанд эерэг нөлөө үзүүлдэг. Монголчууд шударга ёс, үнэнч байдлыг эрхэмлэдэг. Энэ нь олон улсын харилцаанд итгэлцэл бий болгох, шударга ёсыг тогтооход чухал үүрэг гүйцэтгэнэ. Монголчууд эв нэгдэл, хамтын ажиллагааг чухалчилдаг. Энэ нь бүс нутгийн болон олон улсын түвшинд хамтын ажиллагааг бэхжүүлэхэд хувь нэмэр оруулна. Монголын байгаль, өвөрмөц соёл нь аялал жуулчлалыг хөгжүүлэх боломжийг олгодог. Энэ нь эдийн засгийн хувьд ач холбогдолтой бөгөөд соёл, үнэт зүйлсийг сурталчлахад боломжтой.¹⁹

Тиймээс, Монголын ард түмний соёл, зан төлөв нь улс орны гадаад бодлого, дипломат ажиллагаанд тэргүүлэх чиглэл, стратегийг тодорхойлоход чухал үүрэг гүйцэтгэхээс гадна бусад улстай олон улсын харилцаа, хамтын ажиллагааг сайжруулахад хувь нэмэр оруулдаг.

5. ОХУ, БНХАУ нь Монгол Улсын гадаад бодлого, дипломат ажиллагаан дах оруулж буй онцлог

Монгол Улс хоёр хөрштэйгөө найрсаг харилцаатай байх нь гадаад бодлогын тэргүүлэх чиглэл юм.²⁰ Монгол, Орос, Хятад улсын геополитикийн харилцаа нь Монгол Улсын гадаад бодлого, олон улсын эвсэл, стратегийн чиг баримжаа зэрэгт нөлөөлдөг. Энэ нь дипломат харилцааны талаархи үндэсний сэтгэлгээ, зан үйлийг тодорхойлж чадна. Монголын үндэсний соёл, зан төлөвт чухал ач холбогдолтой. Түүх, газарзүй, эдийн засаг, геополитикийн хүчин зүйлээс шалтгаалаад Монголын үндэсний соёл, зан үйлд Орос,

¹⁹ Г. Дробот, Роль личности в принятии внешнеполитических решений (2015), https://i-sng.ru/observer/observer/N04_96/4_13.htm

²⁰ Монгол улсын гадаад бодлогын үзэл баримтлал, 2011 он.

Хятад хоёрын нөлөө их байна. ОХУ, БНХАУ-тай аюулгүй байдал, батлан хамгаалах салбарт идэвхтэй хамтран ажилладаг нь Монгол Улсын үндэсний ашиг сонирхол, аюулгүй байдлыг хангахад чухал ач холбогдолтой.

Монголын улс төрийн байдал, үзэл суртлын чиг баримжаа нь Орос, Хятадтай харилцаанд нөлөөлсөн. ЗХУ тогтоосон түүхэн хэлхээ холбоо, социализмын Монголын улс төр, эдийн засгийн тогтолцоонд үзүүлсэн мөнхийн үр нөлөө, мөн Монгол Улс хөрш орнуудаа стратегийн тэнцвэржүүлэх үйл ажиллагаа нь эдгээр нөлөөг тусгадаг. Монголчууд ОХУ, БНХАУ-тай эртнээс уламжлалт харилцаатай, найрсаг байдлыг эрхэмлэж ирсэн. Энэ нь хоёр хөршийн соёлын нөлөөг үндэсний соёлд суулгахад нөлөөлсөн. Олон зуун жилийн харилцан үйлчлэл, түүний дотор ойр дотно дипломат ажиллагаа, худалдаа, соёлын солилцоо зэрэг нь нийтлэг уламжлал, хэл шинжлэлийн нөлөө, соёлын дадлагыг бий болгосон гэж үзэж болно.

ОХУ, БНХАУ-тай хэл, соёлын солилцоо өрнүүлснээр Монгол Улс соёлын нөлөөнд автаж, өөрсдийн соёлыг баяжуулж ирсэн. Орос, Хятад хоёулаа Монголын боловсролын тогтолцоо, хэлний сургалтыг төлөвшүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж байна. Монголд орос, хятад хэлийг өргөнөөр сургаж, ярьж байгаа нь эдгээр хөрш зэргэлдээ үндэстнүүдтэй хэл шинжлэлийн нөлөө, түүхэн хэлхээ холбоог илтгэх боломжтой юм. ОХУ, БНХАУ-тай соёл, боловсрол, шинжлэх ухааны салбарт идэвхтэй хамтран ажилладаг нь үндэсний соёл, боловсролыг хадгалах, хөгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж байна.

Буддын шашин нь Монголын үндэсний соёлд гүнзгий нөлөөлсөн бол ОХУ, БНХАУ-ын үүсэлтэй зарим шашин, сүсэг бишрэл монголчуудын дунд дэлгэрсэн нь үндэсний соёлд нөлөөлөл үзүүлж байна.²¹

Аль ч улсын өдөр тутмын амьжиргааны зүйл бол хоол хүнс, уламжлалт зан үйл юм. ОХУ, БНХАУ-ын хоол хүнс, уламжлалт зан үйл монголчуудын амьдрал, соёлд их нөлөөлсөн. Жишээ нь, бууз, хуушуур, пирожки, котлет зэрэг хоол нь монголчуудын өдөр тутмын хоолны нэг хэсэг болсон.

ОХУ, БНХАУ-тай дэд бүтэц, эдийн засгийн салбарт идэвхтэй хамтран ажиллах нь монголчуудын амьдрал, үндэсний соёлд эерэг нөлөө үзүүлж байна. Монгол Улс Орос, Хятад улстай байгуулсан худалдааны харилцаа нь эдийн засгийн хөгжил цэцэглэлт, үндэсний зан төлөвт чухал нөлөө үзүүлдэг. Хоёр улс нь бизнесийн үйл ажиллагаа,

²¹ Batmunkh, M.-U., Khomushku, A. (2022). Political culture and foreign policy of a buffer country: In the case of contemporary Mongolia.

хэрэглэгчдийн зан төлөв, эдийн засгийн бодлогод нөлөөлдөг худалдааны гол түнш бол Монголын хөрөнгө оруулалтын эх үүсвэр юм.

Дүгнэж хэлэхэд, Орос, Хятадтай харилцах харилцаа нь хэл, боловсрол, худалдаа, дипломат харилцаа, нийгмийн зан үйл зэрэг янз бүрийн хэмжигдэхүүнээр Монголын үндэсний соёл, зан үйлийг гүнзгийрүүлэн хөгжүүлж байна. Монгол Улс хүчирхэг хөршүүдтэйгээ харилцах харилцаагаа зохицуулахын зэрэгцээ дэлхийн тавцанд өөрийн өвөрмөц онцлог, тусгаар тогтнолоо бататгах тусам эдгээр нөлөө улам бүр нэмэгдсээр байна. Эдгээр хүчин зүйлс нь Монгол Улсын үндэсний соёл, зан төлөвт ОХУ, БНХАУ-ын нөлөөг тусгаж, хоёр хөршийн соёлын өв, нөлөөг үндэсний онцлогтой уялдуулахад нөлөөлж байна.

6. Дүгнэлт:

Монгол Улс зэрэг жижиг орнуудын гадаад бодлогын дипломат харилцаанд соёл, зан үйлийн нөлөөлөл нь жижиг улс орнууд гадаад бодлогын зорилгодоо хүрэхийн тулд соёлын өвөрмөц нөөцийг хэрхэн ашиглаж байгааг ойлгох судалгааны чухал чиглэл юм. Гадаадад улс орныхоо имижийг төлөвшүүлэх, бусад улстай харилцаа тогтооход уламжлал, түүхийн өв, зөөлөн хүч зэрэг соёлын тал ихээхэн үүрэг гүйцэтгэдэг болохыг Монгол Улсын жишээнээс харж байна.

Гадаад бодлогын хандлагыг судлах нь улс төрийн сэтгэл зүй ба олон улсын харилцааны огтлолцол дээр оршдог. Улс төрийн үзэгдлийн сэтгэл зүйн үндсийг судлах хоёр салбарт нийтлэг сонирхолтой хэдий ч хувь хүний шинж чанар болон гадаад бодлогын хандлага хоорондын уялдаа холбоог судалсан судалгаа ховор байдаг.

Том таван хүний зан чанар болон гадаад бодлогын хандлага хоорондын уялдаа холбоог судлах судалгаа ховор хэвээр байна.

Одоо байгаа зан үйлийн олон улсын харилцааны ном зохиолууд нь бусад хувь хүний түвшний сэтгэлзүйн үзэл баримтлалд анхаарлаа төвлөрүүлдэг бол "Их тав"-ыг олон нийтийн санаа бодол, улс төрийн зан үйлтэй холбосон судалгаа нь ихэвчлэн нам, үзэл сурталд анхаарлаа хандуулдаг.

Аливаа улс орны гадаад бодлогын шийдвэр гаргах үйл явцыг урьдчилан таамаглахдаа гадаад бодлогын тоглогчдын үнэлгээ, үйл ажиллагаа нь ихэвчлэн сэтгэл зүй, субъектив шинж чанарт тулгуурладаг тул тэдгээрийн үнэлгээ, үйл ажиллагааг бүрдүүлдэг хүчин зүйлсийн цогцыг харгалзан үзэх шаардлагатай.

Жижиг улсын хувьд Монгол Улс өөрийн соёл, зан төлөвийг үр дүнтэй ашиглаж, олон улсын тавцанд өөрийн байр суурийг бэхжүүлэх, нэр хүндээ өсгөхөд анхаарч ирсэн. Монгол Улс бол жижиг улс хэдий ч гадаад бодлого, дипломат ажиллагаан дахь соёл ба

зан төлөвийн нөлөөллийг өндөр түвшинд ашиглах боломжтой. Дипломат ажиллагаан дахь соёл, зан төлөвийн нөлөөллийг Монгол Улс идэвхтэй хэрэгжүүлснээр гадаад бодлогодоо амжилттай оролцож, үндэсний соёлоо хадгалж, хөгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж болно.

Тиймээс, Монгол Улс зэрэг жижиг орнуудын гадаад бодлогын дипломат ажиллагаанд соёл, зан төлөвийн нөлөөг судлах нь дэлхийн тавцан дахь стратегийг илүү сайн ойлгох, үндэсний ашиг сонирхол, зорилгодоо хүрэхийн тулд дипломат ажиллагааг оновчтой болгоход тусалдаг.

Эх сурвалж:

1. Batmunkh, M.-U., Khomushku, A. (2022). Political culture and foreign policy of a buffer country: In the case of contemporary Mongolia.
2. Bethke, Felix S. (2016). Cultural Bias in the Perception of Foreign-Policy Events. No. 14. Global Cooperation Research Papers.
3. Gravelle, Timothy B., Jason Reifler, and Thomas J. Scotto. "Personality traits and foreign policy attitudes: A cross-national exploratory study." *Personality and Individual Differences* 153 (2020): 109607.
4. Hofstede, G. (2009). Geert Hofstede cultural dimensions.
5. Hussain, Z. Z. (2011). The effect of domestic politics on foreign policy decision making. *E-International Relations*, 7.
6. Ien Ang, Yudhishtir Raj Isar & Phillip Mar (2015) Cultural diplomacy: beyond the national interest?, *International Journal of Cultural Policy*, 21:4, 365-381, DOI: 10.1080/10286632.2015.1042474
7. Khalel, Agnur, Fatima Mamedova, and Elnara Dulaeva. "Diplomatic discourse in cross-cultural dimension." *Opción: Revista de Ciencias Humanas y Sociales* 26 (2020): 407-422.
8. Levinson, D. J. (1957). Authoritarian personality and foreign policy. *Conflict Resolution*, 1(1), 37-47.
9. Mondak, J. J. (2010). *Personality and the foundations of political behavior*. Cambridge University Press.
10. Mwangiru, Makumi. "The Diplomacy of Partition Revisited: African–Asian Relations and the Economic Diplomacy of Security." *Africa Review* 5, no. 2 (2013): 148

11. Roccas, Sonia, Lilach Sagiv, Shalom H. Schwartz, and Ariel Knafo. "The big five personality factors and personal values." *Personality and social psychology bulletin* 28, no. 6 (2002): 789-801.
12. Smith, C. (2012). *Personality in foreign policy decision-making*. E-International Relations, 16.
13. Wiarda, H. J. (2016). *Culture and foreign policy: The neglected factor in international relations*. Routledge.
14. Г. Баасанхүү нар (2016) Муис, “Олон Улсын харилцааны үндэс ба даяаршил”, УБ, Муис пресс,
15. Г. Дробот, Роль личности в принятии внешнеполитических решений (2015), https://i-sng.ru/observer/observer/N04_96/4_13.htm
16. Д. Буян (2006). *Нийгмийн тухай мэдлэг*. х.123.
17. Д. Уламбаяр (2018). *Гадаад дүн шинжилгээ, бодлогын шийдвэр гаргах механизм*, ХУИС, лекц.
18. Монгол улсын гадаад бодлогын үзэл баримтлал, 2011 он.
19. Прохоров А.М. "Большой энциклопедический словарь". (1997). х.72.

SPSIRPA FORUM 2024

Poster presentation 3

Characteristics of China's Soft Power Policy



Хятадын зөөлөн хүчний бодлогын онцлог

Characteristics of China's Soft Power Policy

Д.Уянга, Ж.Баттөр

МУИС-ийн Улс төр судлал, Олон улсын харилцаа, Нийтийн удирдлагын сургууль

Хураангуй: China's rapid development and strengthening of its position on the international stage is a topic of concern for neighboring countries. The scope of China's foreign policy has expanded to neighboring countries, Asia, and even the world, and the main methods of realizing its long-term foreign policy goals are based on elements of soft power. China, which has refrained from implementing hard power policies over the years, is one of the countries that successfully implements soft power policies. In the last ten years, China has jumped from 30th place to 3rd place in the global soft power index, which clearly demonstrates this success.

We may not notice China's soft power policy in our daily social life, but the amount of positive information we receive about the country has increased dramatically. China, the birthplace of one of the earliest cultures in human history, is increasing the number of people who are warm and friendly toward the country through its cultural influence.

Chinese researchers, such as Yang Xuetong, have played a key role in developing China's soft power policy as a theoretically independent concept, and it has been successfully implemented in practice by the Chinese government as the core of its soft power policy. The basis of China's soft power policy is traditional Chinese culture. The characteristics and success of China's soft power policy are expressed through three elements of traditional culture: harmony, the “golden mean (zhongyong)”, and confucianism.

Түлхүүр үг: БНХАУ-ын зөөлөн хүчний онолын судалгаа, үндэсний соёл, соёлын зөөлөн хүч


I. Удиртгал

БНХАУ-ын үсрэнгүй хөгжил, олон улсын тавцан дах байр суурь бэхжиж буй явдал нь хөрш улсуудын хувьд анхаарал татсан сэдэв юм. Хятадын гадаад бодлогын цар хүрээ хөрш орнууд, бүс нутаг, Ази тив, цаашлаад дэлхийн хэмжээнд тэлэн өргөжиж, гадаад бодлогын урт хугацааны зорилгоо хэрэгжүүлэх гол аргууд нь зөөлөн хүчний элементүүдэд тулгуурлаж байна. Жил ирэх тусам хатуу хүчний бодлогыг хэрэгжүүлэхээс татгалзаж буй БНХАУ зөөлөн хүчний бодлогыг тун амжилттай хэрэгжүүлж байгаа орны нэг. Сүүлийн арван жилийн дотор Хятад зөөлөн хүчний индексээр дэлхийд 30 дугаар байраас 3 дугаар байр хүртэл үсрэнгүй урагшилж чадсан нь үүний тод нотолгоо юм. (Forum, 2015) (Brandfinance, 2024)

Зөөлөн хүчний бодлогын тухай Ж.Найн онолын ном гарсан 2004 онд Google Scholar хайлтын системд зөөлөн хүч утгаар 178 000 илэрц, үүнээс АНУ-ын зөөлөн хүч утгаар 64 600 илэрц, Хятадын зөөлөн хүч утгаар 19 100 илэрц, 2014 онд зөөлөн хүч утгад хамааруулах 384 000, АНУ-д хамааруулах 167 000, Хятадад хамааруулах 80 800, харин

2024 онд уг хайлтын системд зөөлөн хүч утгаар 82 600 илэрц, АНУ-ын зөөлөн хүч утгаар 22 200, Хятадын зөөлөн хүч утгаар 40 200 илэрц байна. 2024 оны 4 сарын байдлаар зөөлөн хүч утгад хамаарах нийт илэрц 3 920 000, АНУ-ын зөөлөн хүч утгаар 3 790 000, Хятадын зөөлөн хүч утгаар 2 780 000 байна. Эндээс үзэхэд Хятадын зөөлөн хүчний талаарх судалгаа эрс идэвхжсэнийг харж болно.

График 1: Google scholar хайлтын систем дэх Soft Power утгын илэрц 2024 оны 4 сарын байдлаар



Энэ нөхцөлд XXI зууны БНХАУ-ын гадаад бодлогын зөөлөн хүчний бодлогын онцлогийг тодорхойлох, хэрэгжилж буйг байдлыг онолын болон практик талаас үнэлэх нь судалгааны ач холбогдолтой юм. Эдүгээ олон улсын болон Хятадын судлаачид БНХАУ-ын зөөлөн хүчний бодлогын талаар эерэг сөрөг талаас үнэлэн бичихдээ өсөн нэмэгдэж буй нөлөөг нь хүлээн зөвшөөрч байна.

Зөөлөн хүчний онолыг анх дэвшүүлсэн Жозеф Най 2023 онд АНУ, БНХАУ-ын зөөлөн хүчний бодлогыг харьцуулсан бүтээл туурвисан. (S.Nye, 2023) Алдарт эрдэмтэн сүүлийн 30 жилийн судалгаагаа нэгтгэн зөөлөн хүчний бодлого онолын болон практик хэрэгжүүлэх аргын хувьд хэрхэн шинэ зуунд хурдтай хөгжиж байгааг дүгнээд, Барак Обама, Дональд Трамп, Жой Байден нарын засаг захиргааны жилүүдэд АНУ-ын гадаад бодлогод дэлхийн дэг журамд тэргүүлэх байр суурийн төлөө Хятадтай харилцах харилцаа хэрхэн чухал болж ирснийг онцолсон. Тэрбээр даяаршлын үеийн их гүрнүүдийн хүчний тэнцвэр дээр тогтох дэг журам нь зөөлөн хүчний бодлогоор тодорхойлогдохыг сануулж, Хятадын зөөлөн хүчний бодлогын өсөлт, боломжийг анхаарах шаардлагатай гэж үзсэн. Ингэхдээ Хятад хэрхэн зөөлөн хүчний бодлогын хөрөнгө оруулалтанд анхаарч байгаа хийгээд энэ нь тус улсын дэвшүүлдэг Энхээр хөгжих бодлогын стратегитай нягт уялдаж байгааг онцлоод БНХАУ зөөлөн хүчний бодлогыг “ухаалаг” ашигладаг их гүрэн болж байна гэж дүгнэсэн байна. (S.Nye, 2023)

Хятадын зөөлөн хүчний бодлогын онцлогийг ойлгохын тулд онолын судалгааны хөгжлийг нь үнэлэх шаардлагатай юм.

II. Хятадын зөөлөн хүчний бодлогын онолын судалгааны хөгжил

Зөөлөн хүчний талаарх ойлголт Хятадын төрд хоёр мянганы тэртээд ч байсан гэж судлаачид үздэг. Хятадын соёл хийгээд эзэнт гүрний арвин их түүх нь бусад орны анхаарлыг ихэд татдаг байжээ. Хэдийгээр өөрсдийн соёлыг зорилготойгоор сурталчилдаггүй байсан ч Тан улсын үед харьцангуй хөгжсөн иргэншил, гадны гийчин зочдод нээлттэй байдал, өвөрмөц хийгээд сүр жавхлантай соёлын онцлог нь гадаадын худалдаачдаар дамжин дэлхий нийтэд тарж тэр дундаа Европ, Ойрх дорнод, Азийн ард иргэдийн сонирхлыг ихээхэн татаж олон тооны худалдаачид жуулчид, элч төлөөлөгч, жүжигчид, оюутнууд зорьж ирдэг байв. (d'Hooghe, 2015, p. 114) Харин сүүлд нь хэдийгээр зөөлөн хүч гэх нэр томъёог хараахан ашигладаггүй байсан ч Хятадын Коммунист нам өөрийн улсын талаарх эерэг дүр төрх бий болгохын ач холбогдлыг үйл ажиллагаандаа тусгадаг байсан. Хожим 1990-иэд оны эхээр зөөлөн хүч (хятадаар: guan shili) гэх нэр томъёог ашиглаж эхэлсэн байна. (Li M. , 2009) Зөөлөн хүчний талаарх ойлголт хамгийн анх 1970-аад оны сүүлээр Дэн Сяопины эхлүүлсэн шинэчлэлийн үр дүнд тавигдсан ч АНУ-ын судлаач Ж.Найн зөөлөн хүчний талаарх бүтээлүүдийг хятад хэлнээ орчуулснаар илүү судалгааны түвшинд өргөжжээ. Энэхүү ойлголтын ач холбогдлыг 1993 онд БНХАУ-ын дарга Зян Зэмний улс төрийн зөвлөх Ван Хунин академик сэтгүүлд хэвлүүлсэн өгүүлэлдээ дурджээ. (Huning, 1993) Ингэхдээ улсын зөөлөн хүчний бодлогын гол нөөц нь тухайн улсын соёл байдгийг онцолсон байдаг. Анх өрнөдийн үзэл баримтлалаар тайлбарлагдан Хятадад нэвтэрсэн зөөлөн хүчний тухай ойлголт нь 1990-иэд оны эхээр Хятадын үндэсний цогц хүч чадлын үзэл баримтлалд тусгагдсан. (Lampton, 2008, p. 21) 2006 онд Хятадын дарга Ху Жиньтао Хятадын олон улсад эзлэх байр суурьд зөөлөн хүч чухал үүрэгтэйг дурдсанаас нэг жилийн дараа Хятадын Коммунист Намын XVII их хуралд танилцуулсан илтгэлдээ зөөлөн хүчний асуудлыг олон нийтийн өмнө дурдсан. (PRC, October 15 2007) Ийнхүү зөөлөн хүчний тухай ойлголт Хятадын удирдагчид, төрийн өндөр дээд албан тушаалтнуудын анхаарлын төвд орсон гэж хэлж болно. Тэгэхдээ, ерөнхий ойлголт нь өрний үзэл баримтлалаар тайлбарлагдаж байсан тул Хятадын эрдэмтэд, судлаачид АНУ тэргүүтэй зөөлөн хүчийг гадаад бодлогоо хэрэгжүүлэх гол хэрэгслээ болгосон улсуудаас туршлага судлан өөрийн улсдаа ашиглаж, ингэхдээ Хятадын үндэсний онцлог, өвөрмөц нөхцөл байдалд тохирохоор хөрвүүлэн, хөгжүүлэн нэвтрүүлж эхэлсэн.

2014 онд Ши Жиньпин зөөлөн хүчийг хөгжүүлэх замаар Хятадын олон улсын тавцанд харилцах чадвар болон харилцаа холбооны сайн тогтолцоог бүрдүүлэх зорилгодоо хүрнэ гэж мэдэгджээ. (Beith, 2022) Хятадын засгийн газар өөрсдийн зөөлөн хүчний өсөлтөө энх тайвныг эрхэмлэсэн, эсхүл энх тайван хөгжлийн төлөө стратеги гэж нэрлэдэг. Энэ нь өөрөөр Хятад өөрийн хөгжил, хүчирхэгжилтийг бусад улс орноор хүлээн зөвшөөрүүлэх стратеги юм. (Huiyun Feng, 2019) Уг стратегийг хэрэгжүүлэхдээ Хятад улс энх тайвны замыг эрхэмлэх бөгөөд зөвхөн өөрийн улсын хөгжлийг нэгд тавих бус хөрш зэргэлдээ, бүс нутаг, дэлхийн улсууд бүгд хамтдаа хөгжин энх тайвнаар зэрэгцэн орших санаачилгыг дэвшүүлдэг. Товчоор бол энэ нь энх тайвны төлөө энхийн аргаар хүчирхэгжих бодлого юм. (Wang Y. , 2004)

Сүүлийн жилүүдэд Хятад өөрийн гэсэн үндэсний онцлог бүхий зөөлөн хүчний бодлогын онолын үзэл баримтлалтай болоход ихэд анхаарч байна. Хятадын зөөлөн хүчний онолын судалгаа нэг талаас уламжлалт Күнзийн суртлыг дахин сэргээх, нөгөө

талаас Хятадын олон улсын манлайллыг хангахад практик үнэ цэнэтэй гадаад бодлогын нөөц талаас хийгдэж байна. Энэ нь БНХАУ өөрийн үндэсний онцлог бүхий үзэл санаагаар зөөлөн хүчний онолыг баяжуулж, бие даасан үзэл баримтлалтай болохыг хичээж буйн илрэл мөн. (Г.Баасанхүү, 2021) Зөөлөн хүчний бодлогыг бодит болгохын тулд эдийн засгийн үлэмж хэсгийг Хятад улс дотооддоо болон гадаадад хэвлэл мэдээллийн хэрэгсэл, соёл, урлагийн байгууллагыг дэмжихэд ашиглах болсон. Мөн үүгээрээ БНХАУ бусад олон орны хөгжлийн тусламж, засгийн газрын хөрөнгө оруулалтын хөтөлбөрүүдэд гол үүрэг гүйцэтгэх боломжтой юм. (Lewis, 2023) Зөөлөн хүчний бодлогын зорилго нь Хятадын үнэт зүйлийг дэлхий дахинд түгээх, энх тайван замаар асуудалд хандахад оршино. Энэ ч утгаараа Хятад улс статус кво-г өөрчилж, зөөлөн хүчний стратегийг хэрэгжүүлэх замаар Америкийн дэлхийн “ноёрхлыг” эцэс болгохвий гэсэн болгоомжлол байгаа нь “PAX America”-аас “PAX Sinica” хүртэл боломжийн тухай ярианд хүргэж байна. (Тоје, 2018) Гэсэн хэдий ч эдийн засгийн асар их ололттой харьцуулбал Хятадын зөөлөн хүч дөнгөж бий болоод байгаа бөгөөд өрсөлдөх чадвар хязгаарлагдмал байна гэж өрнөдийн тухайлбал, АНУ-ын судлаачид шүүмжилж буй. (Ikenberry, 2014) Харин Хятадын судлаач Хон Ю Лай (Hongyi Lai), Вуй Айюу Лю (Yiyi Lu) нар Хятад улс хэрхэн шинэ мянган гарсаар өөрийн улсын талаарх олон улсын эерэг төрхийг амжилттай бүтээж байгаа талаар дурдаад БНХАУ-ын гадаад бодлогын чиглэл, олон улсын хүрээлэл, соёлын дипломат ажиллагаа, гадаад хүмүүнлэгийн тусламж нь үүний тод жишээ болж байгааг онцолсон. Тэд Хятадын зөөлөн хүчний онол, гадаад бодлогын стратегийг АНУ-тай харьцуулаад, олон нийтийн дипломат ажиллагаа, олон нийтийн санаа бодлын индексээр дамжуулан Хятад өөрийн онцлогтой зөөлөн хүчний бодлогыг хэрэгжүүлж байна гэж дүгнэсэн юм. (Hongyi Lai, 2012) Шанхайн Jiao Tong их сургуулийн судлаач Ву Юү (Wu You) 2018 онд туурвисан “The Rise of China with Cultural Soft Power in the Age of Globalization” гэх нэг сэдэвт бүтээлдээ өнөөгийн даяаршиж буй дэлхий ертөнцөд хятадын соёл нь үндэсний гол онцлог болоод зогсохгүй олон улс дах Хятадын дүр төрхийг бүтээхэд улам их нөлөө үзүүлж байна хэмээн үнэлжээ.

Хятадын судлаачдын дийлэнх нь соёлыг зөөлөн хүчний гол цөмд тавьдаг онолын “соёлын сургууль”-д (вэнхуа пай 文化派) хамрагддаг. Хятадын зөөлөн хүчний онолчид соёлын сургуулийг үүсгэж, “соёлын зөөлөн хүч” (энэ нь зөөлөн хүчтэй ижил утгатай болсон) үзэл баримтлал үүсгэсэн нь Ху Жинтаогаас эхлээд Ши Жиньпин хүртэл дээд удирдагчдын олон удаагийн уриалга, илтгэлд дурдагдан дэлгэрснийг харж болно. Ухуаний их сургуулиас эрхлэн гаргадаг шинэ сэтгүүлийг “Соёлын зөөлөн хүч” (wenhua ruanshili 文化软实力) хэмээн нэрийдсэн нь энэхүү судалгааны тулгамдсан шинжийг илэрхийлж байна. (Repnikova, 2022)

Хүснэгт 1: Зөөлөн хүчний онолын харьцуулалт

	Ж.Найн зөөлөн хүч	Хятадын зөөлөн хүч
Гол санаа	АНУ хэрхэн ухаалгаар дэлхийг удирдах тухай	“Ёс суртахуун”-ыг ашиглан төрөө удирдаж, дэлхийд шударга ёс, сайн үйлсийг авчрах 以德--治国, 平天下

Зорилго	Сэтгэл татам байдал, бусдыг татах байдлаар бусад улс орныг өөртөө татаж давуу талыг бий болгох Дэлхийн улс төрд Америкийн манлайллыг бэхжүүлэх	Хятадын соёлын өвөрмөц байдлыг бэхжүүлэх Хятадын олон улсын дүр төрхийг сайжруулах (Хятадын дуу хоолойг санал болгох замаар) Хятадын соёл, Хятадын загварыг сурталчлах (Олон туйлт) дэлхийн засаглалын нэг хэсэг байх
Хэрэгжүүлэх нөөц	Соёл, ялангуяа, поп соёл Улс төрийн үнэт зүйл(эрх чөлөө, ардчилал, хүний эрх) Гадаад бодлого	Соёл (хэл, өв, түүх, үндэсний үзэл) Хятадын ёс суртахууны үнэт зүйлс (социалист эв хамт гэх мэт үндсэн үнэт зүйлс) Гадаад бодлого (худалдааны түншлэлийн хэлэлцээр/эдийн засгийн хамтын ажиллагаатай холбоотой яриа хэлэлцээ, олон нийтийн дипломат ажиллагаа)

Хятадын зөөлөн хүчний судалгаанууд Ж.Найн дэлхий нийтийн анхаарлыг татах замаар хүч чадлыг нэмэгдүүлэх төлөвлөгөөтэй нийцдэг. Гэсэн хэдий ч хятадын мэргэжилтнүүд зөөлөн хүчийг нэг дор илүү уян хатан, илүү тулгамдсан санаа гэж үздэг. Ж.Най хатуу ба зөөлөн хүчийг ялгаж салгадаг бол хятад судлаачид ихэвчлэн энэ хоёрыг нэгтгэдэг бөгөөд өдөөгч хүчин зүйлүүдээс шалтгаалан энэ хоёрын таталцал салшгүй гэж үздэг. Ж.Най зөөлөн хүчний эх үүсвэрийг гадаад бодлого, үнэт зүйл, соёл гэж танилцуулдаг бол Хятадын судалгаануудад үүнийг үзэл суртлаас эхлээд үнэт зүйл, эртний түүх, үндэсний оюун санаа, засаглалын үйл ажиллагаа, эдийн засгийн чадавхи гэх мэт онцлог шинж чанаруудын эклектик холимог байдлаар харуулдаг. Харин АНУ-ын судалгаа нь олон улсын нэр хүнд эсвэл гадаад бодлогын үр өгөөжийг голчлон анхаардаг бол Хятадын бичвэрүүд дотоодын үр дагавараас гадна, гадаад нөлөөг онцолдог. Судлаач Шин Лю(Xin Liu)-гийн бичсэнээр зөөлөн хүчний бие даасан онолыг боловсруулахаар эрдэмтэн судлаачид нь Хятадын түүхээс орчин үе хүртэлх дэлхийн соёлд Хятадын байр суурийг шинэчлэн боловсруулж, эрдэм шинжилгээний судалгааны шинэ чиглэлийг бий болгосон. Соёл, үзэл суртлын аль аль нь дэлхийн соёлын тэмцлийн талбарт жанжлалыг тогтоох боломжийг олгож байдаг. (Liu X. , 2020) Энэ нь Хятадын удирдагчдыг “дотоод болон олон улсын харилцаанд” аль алинд нь онцгой анхаарал хандуулахад хүргэж байдаг. (Deng.Y., 2009, p. 73) Онолын хувьд Хятадын эрдэм шинжилгээний болон бодлогын бичвэрүүд зөөлөн хүчний дотоод болон гадаад чиг баримжаа, Хятадын соёлын нэг хэсэг болох социалист үнэт зүйлс, үзэл суртлын ач холбогдол, Ши-гийн санааг нэгтгэж, бататгах хандлагатай байна.

Хятад улсын зөөлөн хүчний үндсэн сувгууд бол хятад хэл, соёлыг түгээх хүрээлэнгүүд (Күнзийн институтууд), гадаад харилцаа холбоо, боловсролын солилцоо, олон нийтийн дипломат ажиллагааны томоохон арга хэмжээнүүд юм. БНХАУ-ын удирдлага үндэсний цогц хүч чадлыг олж авахад зөөлөн хүчний чухал үүргийг хүлээн

зөвшөөрч, соёл нь зөөлөн хүчний гол цөм юм гэсэн эрдэм шинжилгээний үзэл баримтлалыг баримталжээ. Өнөө үед Хятадын уламжлалт соёл нь хүчтэй, сонирхол татсан хэвээр бөгөөд зөөлөн хүчний онол нь Хятадын уламжлалт соёлтой нийцэж байгаа. Хятадын зөөлөн хүчний бодлого соёлыг онцолж, заналхийлэл хүч хэрэглэх явдлыг түр зуурын, гол төлөв реактив шинжтэй гэж үздэг.

III. Хятадын зөөлөн хүчний бодлогын онцлог буюу Хятадын онцлогтой зөөлөн хүчний бодлого

“Хятадын онцлогтой” гэсэн хэллэг нь 1980-аад оны эхээр капитализм ба социализмын хоорондох үзэл суртлын зөрчилдөөнийг ардаа орхиж, эдийн засгийн хөгжилд анхаарлаа хандуулах зорилгоор Дэн Сяопиний Хятадын нөхцөлд социализмыг тодорхойлох зорилгоор ашигласан ойлголт юм. Дараа нь энэ нэр томъёог Хятад дахь ижил нэртэй мөртлөө өөр мөн чанар, практик бүхий бараг бүх зүйлд Хятадын нөхцөл байдлын “өвөрмөц” байдлыг тайлбарлахад ашигласан, тухайлбал “Хятадын онцлогтой ардчилал”, “Хятадын онцлогтой чөлөөт зах зээл”, “Хятадын онцлогтой хүний эрх”, “Хятадын онцлогтой хууль эрх зүйн тогтолцоо” гэх мэт өргөнөөр ашиглах болсон бөгөөд энэ жагсаалт үргэлж уртассаар байна. Зарим хүмүүсийн хувьд “Хятадын онцлогийг” шүүмжлэлээс ангижрах халхавч болгон ашиглах хандлагатай байдаг: хэрвээ та санал нийлэхгүй бол Хятадыг хүлээж авахгүй, эсвэл түүний өвөрмөц “үндэсний нөхцөл байдлыг” ((guoqing) гуочин) ойлгохгүй байна гэж үздэг. Эсвэл өрнөдийн бус аливаа үзэгдлийг хятад хэлээр тайлбарлаж болохуйц болгон ашигладаг.

Хятадын онцлогтой зөөлөн хүчний бодлого нь онолын тайлбар, түүнийг хэрэгжүүлэх арга хэрэгслийн хувьд тус улсын түүхэн соёл сэтгэлгээний өвөрмөц байдлыг онцолсноороо ялгардаг.

Зөөлөн хүч гэдэг нь албадлагаас илүү сонирхол татахуйц хэрэгслүүдээс хамаардаг хүч юм. Жозеф Найн үзэж байгаагаар аливаа улс орны зөөлөн хүч нь үндсэндээ соёл (соёлын ерөнхий дүр төрх, хэл, урлагаар дамжуулан), улс төрийн үнэт зүйлс (ардчилал, хүний эрх, чөлөөт сонгууль), гадаад улс орнуудын хууль эрх зүй (хууль ёсны ба ёс суртахууны эрх мэдэл) гэсэн гурван нөөцөд тулгуурладаг. (S.Nye, 2004, p. 11) Тиймээс зөөлөн хүчний эх үүсвэрийг чиглүүлэхэд улс орон, түүний засаг захиргааны чадвар, нөөц маш чухал юм. Харин хятад судлаачдын хувьд өөр байр сууринаас ханддаг. Жишээ нь, Хятадын эрдэмтэн Ян Шуэтон (Yang Xuetong) “Зөөлөн хүчний гол элемент нь улс төрийн үнэт зүйл гэхээсээ илүүтэй улс төрийн манлайлал” гээд “зөөлөн хүч”-ний сонирхол татахуйц байдал соёл, улс төрийн үнэт зүйлсээс илүүтэй зөөлөн хүчийг удирдахаас, буюу улстөрийн манлайллаас хамаарна.” гэжээ. (Xuetong, 2019, pp. 13-14)

Олон улсын тавцанд нөлөөгөө нэмэгдүүлэх зорилгоо биелүүлэхийн тулд БНХАУ зөөлөн хүчний бодлогыг дэлгэрүүлэх олон арга хэрэгслийг ашигладаг. Үүнээс хамгийн том, нөлөө бүхий нөөц нь Хятадын соёл, соёлын дипломат ажиллагаа юм. Аливаа улс өөрийн үндэсний ашиг сонирхлыг хамгаалж, стратегийн зорилгодоо хүрэхийн тулд олон нийтийн дипломат ажиллагааны нэг төрөл болох соёлын дипломат ажиллагааг хэрэгжүүлдэг. Соёлын дипломат ажиллагаа нь олон улсын тавцан дээр нэр хүндтэй болох, хууль ёсны улс болохын тулд нийтлэг сонирхол болон өөрийн улсын сонирхлыг аль алийг нь хангахын төлөө хоёрдмол тоглолт хийхэд хүргэдэг. (B.Harvey, 2001) АНУ, БНХАУ аль аль нь зөөлөн хүчний аргаар соёлыг ашигладаг боловч өөр өөр арга барилын

сонголттой. Зөөлөн хүчний америкийн үзэл баримтлалд орчин үеийн, алдартай соёлын бараа үйлчилгээнд глобал анхаарал хандуулахад чиглэдэг бол Хятадын удирдлагын хувьд “Хятадын эртний түүх, уламжлалт соёл” нь зөөлөн хүчний чухал үнэ цэнтэй эх үүсвэр болдог. (Angang.H., 2006) Анх 2005 он Ази, Африкийн дээд хэмжээний уулзалтын үеэр Ху Жинтаогийн хэлсэн “эв зохилдолт дэлхийн” тухай үзэл баримтлал, арга билгээр зэрэгцэн орших санаа нь “хятадын аюул занал”-ын талаарх олон улсын сөрөг төсөөллийг бууруулах, арилгаж, улмаар итгэлцлийг бэхжүүлэхэд чиглэж байв.

Хятадын зөөлөн хүчний бодлогын цөм болсон хятадын соёлын онцлогийг ойлгохын тулд соёлыг бид хэрхэн ойлгож, тодорхойлох вэ гэдэг асуудал чухал юм. Соёлын талаар хэдэн зуун тодорхойлолт бий ч, зөөлөн хүчний бодлогын арга талаас үнэлбэл “Соёл” гэж янз бүрийн ард түмний “өөрийгөө илэрхийлэх” арга зам, соёл бол “нийгмийн үзэл бодол, үнэт зүйлсийн танилцуулга”, соёл бол нийгмийн “үзэл бодол” юм. (Albro, 2016) Харин соёлын дипломат ажиллагаа нь “улс үндэстнүүд өөрсдийн нийгэм, үнэт зүйлсээ харуулахын тулд хийж буй хүчин чармайлт” юм. Соёлыг хилийн чанадад “төсөөлсөн” тохиолдолд зөөлөн хүчний бодлого амжилттай хэрэгжлээ, соёлын дипломат ажиллагаа амжилтанд хүрлээ гэж үнэлж болно. “Соёлыг тайлбарлах хамгийн сайн арга бол үүнийг харуулах явдал юм”. Соёлын дипломат ажиллагаа нь “Илүү олон үзэгчдэд хүрч үйлчлэх хамгийн харагдахуйц хэлбэрийг” ашиглах үед үр дүнтэй байдаг. Өөрөөр хэлбэл, соёлын дипломат ажиллагаа бол “өөрсдийн үнэн зөв төрх”-ийг “үзүүлэх” замаар өөрсдийгөө бусдад “тайлбарлах” гадаад бодлогын үйл ажиллагаа юм. Хятадын судлаач Дэшун Ли (Deshun Li)-ийн бодлоор соёлын үүрэг нь “хүмүүнлэгжүүлэх” бөгөөд, “хүнээр хүн хийх”-ийг “соёл иргэншил” хэмээн үзэж буй. Тэрбээр соёлын талаар дүн шинжилгээ хийх, хэлэлцэхдээ хүний амьдралын хэв маяг, сэтгэлгээний арга барил, онцлогт ач холбогдол өгөх хэрэгтэй бөгөөд хүний амьдралын туршид дагалдах эрх үүргийн хэм хэмжээтэй соёлыг нягт холбон тайлбарлах нь зүйтэй гэжээ. (Li D. , 2016) Соёлын хувьд Хятад улс эртний уламжлалт соёл иргэншлийг Ази тивд хадгалж ирсэн. Энэ нь ч БНХАУ-ын зөөлөн хүчийг хөгжүүлэх үндсэн нөөц болдог. (Huang, 2006) АНУ-ын зөөлөн хүчний бодлогод соёлыг олон улсын харилцаанд ятгах, үнэмшүүлэх зорилгоор ашигладгаас ялгаатай нь Хятадын удирдлагын хувьд “зөөлөн хүч” (ruan shili) нь уламжлалт үндэсний соёлын үнэт зүйлс, үзэл баримтлалтай шууд холбоотой байдаг. “Эв зохицол” нь Хятадын зүрх сэтгэл, оюун санааны илэрхийлэл бөгөөд түлхүүр юм. (Hayden.C, 2012)

Хятадын зөөлөн хүчний бодлогын цөм болсон уламжлалт соёлд зөөлөн хүчний үндсэн элементүүд багтдаг гэж үзэж болно. Тухайлбал, Хятадын уламжлалт соёлын yishen zuoze (以身作则) үлгэрлэн манлайлах) үзэл нь захирч тушаахгүй, өөрөө үлгэрлэн удирдах буюу манлайллын номлолын үндсэн мөн чанарыг илэрхийлж, Күнзийн суртлын “Хүмүүс эрдэм сурахаар багш дээр очдогоос, багш бусдыг сургахаар явдаггүй” (Li wen lai xue, bu wen wang jiao, 礼闻来学, 不闻往教) гэсэн сургаалийн тайлбар болж байдаг. (Xuetong, 2019, pp. 13-14) Хятадын соёл эртнээс улбаатай хятад ухаанаар илэрхийлэгдэх итгэл үнэмшил, үнэт зүйлтэй. Хятад ухаан (mind) буюу хятад сэтгэлгээ нь нь хятадуудын ажил хэрэг, нийгмийн харилцаанд чухал үүрэг гүйцэтгэж, Хятадын уламжлалт үнэт зүйлс, зан үйлийн салбарыг нарийн тодорхойлдог. Хөгжихийн хэрээр Хятадын

уламжлалт соёлд зах зээлийн эдийн засаг, даяаршлын нөлөөгөөр өрнөдийн соёлын бусад элементүүд нэвтэрсээр байгаа. Энэ нөхцөлд орчин үед хадгалагдан үлдсэн Хятадын уламжлалт соёлын гол элементүүдийн мөн чанар, үүргийг соёлын дархлаа болсон “түлхүүр үгс” тодорхойлсоор байна. Эдгээр түлхүүр үгс нь Хятад ухаан, дахин давтагдашгүй Хятад соёлын мөн чанарыг илэрхийлсээр байдаг. Эдгээрийн заримаас дурдвал, Yin & Yang-, бүх зүйлд тэнцвэрийг эрэлхийлэх буюу арга билгийн сургааль; Mianji- “Нэр нүүртэй байх” буюу өөрийн нэр хүндийг эрхэмлэх; Hong- Аливааг цогцоор нь бүрэн дүүрэн харах; De- Буяны хүч; Guo sui- Хятадуудын үндэсний мөн чанар; Zhong fu-олгохыг эрмэлзэх, ухаарал эрэлхийлэх; Vi- Хятад аргаар нэгдэх юм. (Mente, 2008)

Хятадын үндэсний соёлыг ойлгохын тулд хамрах хүрээг нь тодорхойлох нь чухал. “Хятад” ба “хятад үндэстэн” гэдэг нь явцуу утгаараа 56 үндэстэн, түүний дотор БНХАУ-ын харьяат бүх иргэдийг багтаасан Бүгд Найрамдах Хятад Ард Улсыг хэлдэг. Өргөн утгаараа энэ нь эх газрын Хятад, Тайвань, Хонконг, Макао зэрэг “нэгдмэл” Хятадыг илтгэнэ. Хятадын соёлын хувьд хоёр хэсэгт хувааж болно: эхний хэсэг нь гадаад дахь Хятад болон Хятад үндэстний бүлгүүд; хоёрдахь хэсэг нь Хятадын соёлд гүн гүнзгий нөлөөлсөн захын соёлууд (голчлон Huaxia - Хуася соёл эсвэл Хань үндэстний соёл) юм. Хань үндэстний соёл нь бусад ард түмэнд гүн гүнзгий нөлөөлж ирсэн бөгөөд голчлон “хүлцэнгүй байх ба үнэнч байх”, “өгөөмөр сэтгэл ба зөв байдал”, “шударга ёс ба амар амгалан”, “байгальтай эв зохистой амьдрах” зэрэг сургаалиудаар илэрхийлэгдэх Тэнгэр болон өвөг дээдсээ шүтэх ёсонд голчлон анхаардаг. Өөрөөр хэлбэл, БНХАУ-ын нийгэмд зонхилж буй эх газрын хань үндэстний соёлыг бид ерөнхийд нь “Хятадын соёл” хэмээдэг. Хятадын соёлын мөн чанар ёс суртахууны таван үндсэн багана дээр бий болж, хөгжиж ирсэн. Эдгээр таван үндэс нь халамж(хор хөнөөлийн эсрэг), шударга ёс(хууран мэхлэлтийн эсрэг), үнэнч байдал(урвах, эрх мэдэл, хорлон сүйтгэхийн эсрэг), ариун байдал(доромжлолын эсрэг) юм. (Xuetong, 2019) Хятадын соёлын гадаад илрэх онцлогийг “зөвшилцөл” (хүмүүсийн өдөр тутмын амьдралдаа дагаж мөрддөг нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн оюуны үнэт зүйлс, “хамтын бүтээн байгуулал” (нийгмийн бүх давхаргын төлөөлөл хамтран бүтээсэн соёл), “хамтын хэрэглээ” (Хятадын бүх үндэстэн хуваалцах соёл, оюуны санааны эх орон) хэмээн хятадын судлаачид тодорхойлдог. (Li D. , 2016, p. 288) Хятадын соёлыг дэлхийн бусад үндэстнүүдийн дунд сурталчлах олон янзын арга бий. Энэ нь телевиз, радио, интернет, нийгмийн сүлжээ, кино, урлаг, хэвлэл мэдээллийн хэрэгслээр эсвэл бусад оронд соёл, хэлний байгууллагууд байгуулах замаар илэрдэг.

БНХАУ гадаад бодлогын зорилгодоо хүрэхийн тулд зөвхөн хүчээр өдөөхөд бус, харин зөөлөн хүчний нөөцөө ашиглан бусад оролцогчдыг татах, ятгах, хамтран ажиллах, тэдний сонирхлыг татах аргыг ашиглахыг эрмэлздэг. (S.Nye, 2023) Ийм байдлаар ашиглаж болох янз бүрийн нөөцүүдийн дотроос БНХАУ соёлд маш их ач холбогдол өгдөг. Мэдээж соёл нь олон талт байдгаас Хятадын соёлын бүх элементүүд зохистой гэж үздэггүй. Өөрөөр хэлбэл, Хятадын онцлогтой зөөлөн хүчний бодлого бол Хятадын уламжлалт соёлд суурилсан зөөлөн хүчний бодлого мөн. Одоо байгаа эрдэм шинжилгээний бичиг, маргаан мэтгэлцээнд үнэлэлт өгөхдөө хятад судлаачдын “соёлын зөөлөн хүч” –ийн талаарх ойлголтыг гурван хэсэгт хуваан үзэж болно.

Нэгдүгээрт, зарим шинжээчид “зөөлөн хүч” гэсэн санааг соёлтой дүйцэхүйц зүйл гэж хүлээн зөвшөөрдөг, ялангуяа энэ сэдвээр хийсэн судалгаанд бүр эхнээс нь соёлын үүднээс тайлбарлахыг хичээдэг. Жишээлбэл, Ван Хунин энэ ойлголтыг Хятадад нэвтрүүлэхдээ “соёл нь бодлого тодорхойлох үндэс суурь төдийгүй бусад улс орны олон нийтэд нөлөөлөх хүч мөн” гэж үздэг. (Wang.H.N., 1993, pp. 23-28) 2002 онд ХКН-ын XVI их хуралд танилцуулсан улс төрийн тайланд энэхүү үзэл баримтлалын талаархи ижил тайлбарыг хийн “соёл нь эдийн засаг, улс төрийн нэгэн адил өнөөгийн ертөнцөд үндэсний хүч чадлын төлөө өрсөлдөөнд илүү тодорхой байр суурь, үүрэг гүйцэтгэж байгааг харуулж байна” гэж онцолжээ. (Full text of Jiang Zemin's Report at the 16th Party Congress, 2002) Гэсэн хэдий ч илүү их соёлын нөөцийг эзэмшсэн үндэстэн илүү хүчтэй зөөлөн хүч чадалтай гэж үзэх нь тийм ч оновчтой биш. Бүх соёлын нөөцийг зөөлөн хүч болгон ашиглах боломжгүй бөгөөд зарим нь гадныханд сонирхолгүй байвал тухайн үндэстний хувьд зөөлөн хүчний элемент болгон ашиглаж чадахгүйд хүрнэ. Товчхондоо тухайн үндэстний соёлын өвийн оновчтой хэсэг нь үндэсний имижийг бүрдүүлэх, өөр улс орны олон нийтийн санаа бодлыг татах чухал үүрэг гүйцэтгэдэг. Өөрөөр хэлбэл соёлын арвин их нөөц бол үндэстний зөөлөн хүчний бодлогын зайлшгүй үндэс суурь мөн.

Хоёрдугаарт, олон судлаачид Хятадын соёл олон улсын зах зээлд өрсөлдөх чадвар сул байгаад ихээхэн санаа зовдог. Тэдний үзэж байгаагаар соёлын зөөлөн хүч нь соёлын өрсөлдөх чадвартай тэнцүү юм. (You, 2018) (Jian, 2006) (Tian Feng, 2007) Аж үйлдвэрийн салбарын худалдааны тэнцэлтэй харьцуулахад Хятадын соёл, үйлчилгээний салбар гадаад худалдааны асар их алдагдалд орж, өрнөдийн улсууд болон хөрш Япон, Өмнөд Солонгосоос хол хоцорчээ. Харин энэхүү хоёр дахь хандлага нь соёлын аж үйлдвэрийг хөгжүүлэх замаар улс орны соёлын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд анхаардаг. Тэдний санаа зовниж буй асуудал нь Хятад улс барууны соёл, ялангуяа АНУ-ын зонхилох байр сууринаас болж олон улсын тавцанд голлох орон болж чадахгүй байна гэсэн байр суурин дээр тулгуурладаг. Соёлын өрсөлдөх чадварыг бэхжүүлэх нь Хятадад нэн яаралтай шаардлага мөн боловч зөөлөн хүчний хүрээнд соёлын өрсөлдөх чадварын ач холбогдлыг хэт их онцлон тэмдэглэх нь заримдаа Хятад улс соёлын нөөцөө ашиглан дэлхийд ноёлох стратеги баримталж байна гэх ойлголтыг олон улсын хамтын нийгэмлэгт хүргэдэг.

Гуравдугаарт, зарим шинжээчид үе үеийн улс төрийн үнэт зүйлийг тухайн үндэстний соёлын бүрэлдэхүүн хэсэг болгон улс төрийн үнэ цэнэ нь шууд соёлын зөөлөн хүч болж чаддаг гэж үздэг. Түүнчлэн гадаад бодлого нь Хятадын зөөлөн хүчний эх үүсвэр гэж маргадаг. (Li M. , 2009) Гэсэн хэдий ч Хятадад олонхи эрдэмтэн судлаачид, бодлого боловсруулагчид энэхүү үзэл бодлыг батлаагүй тул улс төрийн үнэт зүйл нь үзэл суртлын ач холбогдол бүхий нэр томъёо бөгөөд зөвхөн хэлэлцүүлгийн шинж чанартай. Хятадын улс төрийн үнэт зүйлийн гол цөм нь хүчтэй ангийн шинж чанартай улс төрийн үзэл суртал бөгөөд өөр улс, намтай хуваалцах боломжгүй юм. Соёл бол дэлхийн соёл иргэншилд хувь нэмрээ оруулах, бусад орны олон нийтийн талархлыг хүлээх сонирхолтой эх сурвалж бөгөөд улс төрийн үнэт зүйл бол онцгой албадлагын хүч юм. Үүнээс харахад улс төрийн үнэ цэнийг соёлын зөөлөн хүчний хүрээнд оруулах нь зохисгүй юм.

Хятадын нөхцөлд зөөлөн хүчийг хэрхэн тодорхойлох вэ гэсэн асуултын талаархи эрдэм шинжилгээний бичиг баримтуудыг авч үзвэл соёл нь Хятадын зөөлөн хүчний гол цөм бөгөөд үүнд Хятадын уламжлалт соёлыг хамгийн үнэ цэнэтэй гэж онцолсон. Эцэст нь Хятадын зөөлөн хүчний бодлогын онцлогийг Хятадын соёлын гурван ойлголтоор тодорхойлж болох билээ. Үүнд,

Нэгдүгээрт, Хятадын уламжлалт соёл нь “мэргэн ухаанаар хүндлэл хүлээх”, “хүнд давуу эрх олгох” –ыг онцолсон ёс суртахуун, хүмүүнлэг үзлийг дээдэлдэг. Жишээлбэл, Күнзийн үзэл баримтлал “Analects”(Луню) –д хаан ширээнд нинжин сэтгэлтэй засаглал (Вандао) нь ноёрхлын засаглал (Бадао)-ыг үргэлж ялна гэж итгэж, бие махбодийн хүч биш харин ёс суртахууны хүч чадалд найдах ёстой гэж тэмдэглэсэн байдаг. (Li M. , 2009, p. 292)

Күнзийн үзэл суртал, Даосизм, Буддизм болон бусад сонгодог бүтээлүүдээс олдсон Хятадын уламжлалт соёлд агуулагдах эдгээр үнэт зүйлс нь “Эв захирол” (“Хармони”) хэмээх ойлголтонд бүрэн шингэсэн байдаг бөгөөд энэ нь соёлын төрөлжилт, даяаршлын эрин үед Хятадын соёлын онцгой уриалгын үндэс болж өгдөг.

Хоёрдугаарт, тэнцвэрийн үнэ цэнийг эрхэмлэдэг Хятадын сэтгэлгээ, уран зургийн гүн гүнзгий уламжлал болох Алтан дундаж (Жунгён - 中庸- zhōng yōng) нь Хятадын соёлын зөөлөн хүчний онцлогийг багтаасан. Дундаж ёс бол эрт дээр үеэс улс хоорондын харилцааг зохицуулах Хятадын уламжлал юм. Чен Жианфенгийн хэлж буйгаар энэ мэргэн ухаан нь Хятадын удирдлагад олон улсын томоохон асуудлуудад тэнцвэртэй байдлаар хандах оюуны чадавхийг бий болгож өгдөг бөгөөд энэ нь Хятадын дэлхийн тогтвортой байдал, хөгжил цэцэглэлтэд оруулсан хувь нэмрийг Европ, АНУ ардчиллын ойлголттой адилтгадаг. (Chen.P., 1999)

Гуравдугаарт, нийгэм дэх уламжлалт дүрмийг дагаж мөрдөх ёстой гэсэн ухуулга Хятадын уламжлалт соёлд бас чухал байр суурь эзэлдэг. Хятад улсад газар нутгийг шударгаар өмчлөх, зөв шударга байх зохистой зарчим Күнзийн суртлын гол үнэ цэнэ мөн бөгөөд уг түүхэн хандлагаас харахад Хятадын төр хатуу хүчний бодлогоос илүүтэй зөөлөн хүчний бодлого явуулсаар иржээ. (You, 2018, p. 767) Күнзийн сургаалийн ёс зүйтэй байх нь орчин үеийн БНХАУ-ын гадаад бодлогод ёс зүйтэй байж, олон улсын итгэлцлийг бэхжүүлэх бодлогоор тод илэрч байдаг.

Соёлын хүч нь Хятадын бүс нутгийн, цаашлаад глобал манлайллыг бэхжүүлэх гол арга хэрэгсэл бөгөөд эдийн засгийн хувьд улам бүр нягт уялдаа холбоотой болж байгаа тул Азийн хөршүүдтэйгээ харилцах харилцаанд зөөлөн хүчний гол арга нь болдог. Хятадын эртний түүх, уламжлалт соёл нь Күнзийн өвийг хуваалцдаг Зүүн Азийн хөрш орнуудаа татах зөөлөн хүчний үнэ цэнэтэй эх үүсвэр юм. БНХАУ-ын хэрэгжүүлж буй зөөлөн хүчний бодлого нь уламжлалт соёлоо сэргээн дэлгэрүүлэх, харийн соёлын нөлөөг бууруулах оролдлого ба өөрийн нөөц дээр тулгуурлан явуулж буй үйл ажиллагаа билээ. Аливаа улсын соёл бол улсын нэр нөлөөг өргөжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг “үнэт зүйл, итгэл үнэмшлийн хүчирхэг түгээн дэлгэрүүлэгч” юм. Хятадын уламжлалт соёл, сэтгэл татам түүхэнд тулгуурласан Хятадын түгээмэл соёлын нөлөө, Хятадын зөөлөн хүч дэлхийд өсч байна.

Дүгнэлт

Ши Жиньпин “Бичиг соёлоор, эрдэм ухаанаар бусдыг бишрүүлж, гадаад орнуудтай харилцах соёлын солилцооны түвшинг дээшлүүлж, хүмүүнлэгийн солилцооны механизмыг боловсронгуй болгон, солилцооны арга хэлбэрийг шинэчлэн, олон түмэнд, хамт олонд, хүмүүс хооронд түгээн дэлгэрүүлэх явдлыг цогц шийдлээр, олон төрлийн хэлбэрээр явуулж, Хятадын соёлын татах хүчийг харуулах ёстой” хэмээсэнчлэн соёл, хэл нь Хятад улсын олон улсын харилцаанд үзүүлэх нөлөөллийг нэмэгдүүлэх зөөлөн хүчний бодлогын гол цөм болж байна. (Xi, 2014)

Сүүлийн арав гаруй жилийн хугацаанд Хятадын эрдэм шинжилгээний бүтээлүүд болон албан ёсны баримт бичиг, алдартай сонин, сэтгүүлд “Зөөлөн хүч” –ийг ихээр дурьдаж, “соёлын зөөлөн хүч” гэж нэрлэх болжээ. Зөөлөн хүч дэх соёлын үндсэн үүргийг албан ёсоор 2007 онд Хятадын Коммунист Намын XVII их хуралд “Хятадын соёлын зөөлөн хүч” гэсэн нэр томъёогоор тайлагнах хэсэгт багтааж байсан гэж үздэг.

2017 онд БНХАУ-ын ирээдүйн таван жилийн ажлыг удирдан чиглүүлэх баримт бичгийг ХКН-ын XIX их хуралд тайлагнахдаа “Соёл бол улс орон, үндэстний амин сүнс” гээд, “Соёлын илүү хүчтэй итгэл үнэмшлийг бий болгож, социализм цэцэглэн хөгжихөд туслах арга болгоно” хэмээн Хятадын соёлын зөөлөн хүчийг нэмэгдүүлэхэд онцгой анхаарлаа хандуулж байна. (Callahan.W.A., 2019)

БНХАУ нь зөөлөн хүчний бодлого хэрэгжүүлэх эдийн засгийн асар их нөөц боломжтой тул өөрийн өвөрмөц соёлоо түгээх, улсынхаа түүх зан заншлаа таниулах, оюутан болоод мэргэжилтнүүдийг улс хооронд солилцох, гадаад улсын ард иргэдэд өөрсдийн талаар эерэг ойлголтыг орчин үеийн чиг хандлагатай уялдуулан ХМХ, нийгмийн сүлжээгээр дамжуулан түгээх зэрэг олон арга хэлбэрээр хэрэгжүүлж байна.

Хятадын онцлог бүхий зөөлөн хүчний бодлогын үндэс нь хятадын уламжлалт соёл юм. Хятадын зөөлөн хүчний бодлогын онцлог, амжилт нь уламжлалт соёлын 3 элемент болох эв зохирол, дундаж ёс, Күнзийн суртлаар илэрхийлэгдэж байна.

Ашигласан эх сурвалж:


1. Arif, B. H. (2017). *The Role of Soft Power in China's Foreign Policy in the 21st Century*.
2. Brandfinance. (2024). *Global Soft Power Index 2024*. London.
3. Cao, W. (2016). Is China's Public Diplomacy Effective? *The Chinese Journal of International Politics*, 1-36.
4. d'Hooghe, I. (2015). *China's Public Diplomacy*. Leiden.
5. Hartig, F. (2016). How China Understands Public Diplomacy: The Importance of National Image for National Interests. *International Studies Review*, 1-26.
6. Hongyi Lai, Y. L. (2012). *China's Soft Power and International Relations*. Routledge.
7. Hubbert, J. (2019). *China in The World: An Antropology of Confucius Institutes, Soft Power, and Globalization*. University of Hawaii Press.
8. Kingsley Edney, S. R. (2020). *Soft Power with Chinese Characteristics: China's Campaign for Hearts and Minds*. London: Routledge.
9. Li, M. (2009). *Soft power. China's Emerging Strategy in International Politics*.
10. S.Nye, J. (2004). *Soft Power: The Means To Success In World Politics*. NY.

11. S.Nye, J. (2023). *Soft Power and Great Power Competition: Shifting Sands in the Balance of Power Between the United States and China*. Cambridge: Springer.
12. Wang, J. (2011). *Soft power in China: Public Diplomacy through Communication*. Palgrave Macmillan.
13. Yang Xuetong (2019). *Leadership and The Rise of Great Powers*. Princeton University Press.
14. You, W. (2018). *The Rise of China with Cultural Soft Power in the Age of Globalization*. Singapore: Springer.

SPSIRPA FORUM 2024

Poster presentation 4

Cooperation between Mongolia-China border ports during the Covid-19 pandemic: On the geo-economic example of the Zamyin-Uud port



Монгол-Хятадын хилийн боомтын Ковид-19 цар тахлын үеийн хамтын ажиллагаа: Замын-Үүд боомтын гео-эдийн засгийн жишээн дээр

З.Өлзий^{1*}, Б.Мөнх-Өлзий²

^{1,2} Олон улсын харилцааны тэнхим
Улс Төр Судлал, Олон Улсын Харилцаа, Нийтийн Удирдлагын Сургууль
Монгол Улсын Их Сургууль

Хураангуй

Жилээс жилд хөгжиж ирсэн Монгол-Хятадын худалдаа эдийн засгийн харилцаа, хил гаалийн тасалдалгүй ажиллагаа Ковид-19 цар тахал гарах хүртэл хэвийн явж ирсэн байна. Ковид-19 цар тахлын улмаас хоёр орны худалдаа эдийн засгийн харилцаа зогсонги байдалд орж, хилийн боомтуудад бэрхшээлтэй нөхцөл байдал үүссэн билээ. Ялангуяа Замын-Үүд боомт нь хоёр орны худалдаа эдийн засгийн харилцааны стратегийн ач холбогдолтой гол суваг учир цар тахлын нөхцөл байдлаас үүдэлтэй хямралууд шууд нөлөө үзүүлсэн байдаг. Иймд энэхүү өгүүллийн зорилго нь Ковид-19 цар тахлаас үүдэн гарсан худалдаа эдийн засгийн хүндрэл бэрхшээлтэй үед Замын-Үүд боомтын үйл ажиллагаан дээр үнэлэлт дүгнэлт өгөх, цаашид ийм асуудлаас хэрхэн даван туулах талаар хэлэлцэхэд оршиж байна.

Түлхүүр үгс: Ковид-19, цар тахал, Замын-Үүд боомт, Монгол-Хятадын худалдаа эдийн засгийн харилцаа, гео-эдийн засаг

Удиртгал

Монгол-Хятадын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаа 1989 оноос тогтворжиж, шинэ шатанд гаран өнөөг хүртэл хөгжиж байна. Хоёр улсын худалдааны эргэлт, 1993-1994 оны хооронд бага зэрэг буурсан ч, 1990 онд 33.6 сая ам.доллар, 1999 онд 286 сая ам.долларт тус тус хүрч тасралтгүй нэмэгдсээр Монгол Улсын нийт гадаад худалдааны 60 гаруй хувийг Хятад улс дангаараа эзлэх болсон байна². Сүүлийн жилүүдэд Ковид-19 цар тахлын улмаас хоёр улсын худалдаа, эдийн засгийн харилцаанд саад бэрхшээл үүссэн боловч хоёр талын засгийн газрын хүчин чармайлтын үр дүнд нөхцөл байдал дээрдэж байна³. Иймд тус судалгаа нь Ковид-19 цар тахлаас үүдэн хоёр орны худалдааны харилцаанд тулгамдаж ирсэн байгаа худалдаа эдийн засгийн асуудлуудыг тоймлох, цаашид ийм асуудлаас хэрхэн даван туулах тухай дүгнэн хэлэлцэх юм.

БНМАУ болон БНХАУ-ын хилийн гэрээ анх 1962 онд байгуулагдсан бөгөөд, үүгээр БНМАУ нь өмнөд хилээ албан ёсоор баталгаажуулсан байна. Улмаар 1962-1964 онд улсын хилийг газар дээр нь тогтоон тэмдэглэжээ. Монгол Улсын нутаг дэвсгэрийн

* Холбоо баригч зохиогч (докторант), имэйл: xxxulzii5@gmail.com

² Erina (2023). Retrieved on December 20, 2023, from https://www.unii.ac.jp/erina-unp/archive/wp-content/uploads/2023/02/se16802_tssc.pdf

³ Ganbaatar, Bayarmaa, Juan Huang, Chuanmin Shuai, Asad Nawaz, and Madad Ali. "Empirical analysis of factors affecting the bilateral trade between Mongolia and China." Sustainability 13, no. 7 (2021): 4051.

долоон аймаг, нийт 49 боомтын 13 нь БНХАУ-тай хиллэж байна. Тэдгээрийн нэг Замын-Үүд боомт нь байнгын ажиллагаатай ба БНХАУ-ын Эрээн боомттой хил залгаа оршдог билээ⁴.

Судлаачдын үзэж байгаагаар гео-эдийн засаг нь геополитикийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд эдийн засаг, орон зай, цаг хугацаа, улс төрийн арга хэрэгслүүдийг ашигладаг үйл ажиллагаа юм⁵. Замын үүд, Эрээний боомт нь Монгол Улс болон БНХАУ-ын худалдаа, бүс нутгийн эдийн засгийн харилцаанд голлох үүрэгтэй газар юм. Үүний учир, Монгол Улсын болон БНХАУ-ын худалдаа, бүс нутгийн гео-эдийн засгийн хүчин зүйлд Замын үүд, Эрээний боомт хэрхэн нөлөөлж буйгаас олон зүйл шалтгаалж байна. Тиймээс бид энэхүү судалгааны ажилдаа Монгол-Хятадын худалдааны харилцаа ба бүс нутгийн гео-эдийн засгийн хүчин зүйлсэд Замын-үүд, Эрээн хилийн боомт ямар үүрэг гүйцэтгэж байгаа хийгээд цаашид хэрхэн үр ашигтай ажиллах, ямар боломж бололцоо байгааг судлан тодруулахыг хичээв⁶.

1. Монгол Улс, БНХАУ-ын худалдааны харилцаа ба хилийн боомтууд

Хоёр орны Засгийн газар хоорондын гэрээний дагуу байгуулагдах эдгээр 13 боомт нь Монгол Улс, БНХАУ-ын худалдааны харилцааг улам хөгжүүлэх, найрсаг хамтын ажиллагааг бэхжүүлэхэд туйлын ач холбогдолтой хэмээн хоёр тал санал нэгдсэн байдаг. Монгол улсын БНХАУ-тай харилцан тохиролцож байгуулсан хилийн боомтоос зөвхөн Замын-Үүд боомт л төмөр замын боомт болно. Төмөр замын боомт олон улсын хуурай замын тээвэр ложистикийн хамгийн боломжит өндөр үр ашиг бүхий харилцаанд зүй ёсоор тооцогддог. Хилийн Замын-Үүд боомт нь 1956 оны 01-р сарын 01-ны өдөр Дорноговь аймгийн Замын-Үүд суманд байгуулагдсан анхдагч гол боомтын нэг болно. Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын 2004 оны “Монгол, Хятадын хилийн боомт, тэдгээрийн дэглэмийн тухай” хэлэлцээрийн дагуу олон улсын зэрэглэлтэй, байнгын горимтой боомтоор тогтсон байна⁷.

Монгол Улсын Засгийн газраас тус боомтын үйл ажиллагааг сайжруулах талаар хөрөнгө оруулалт хийж шинэчлэхээр болсон байдаг. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Гаалийн шинэчлэл”-ийн хүрээнд Замын-Үүд боомтыг олон улсын жишигт нийцүүлэн шинээр барих, хүчин чадлыг нэмэгдүүлэх төслийн бүтээн байгуулалтын ажлыг 2019 оны 9-р сарын 12-нд шав тавих ёслолын арга хэмжээ хийснээр эхлүүлсэн билээ⁸⁹.

Монгол Улсын БНХАУ-тай харилцах ачаа тээвэр, төмөр замын гол боомт болох Замын-Үүд боомтыг шинэчлэх, өргөтгөх бүтээн байгуулалт хийгдсэнээр нийт талбай 8 дахин, өдөрт нэвтрэх зорчигчийн тоо 4 дахин, том оврын ачаа тээврийн хэрэгслийн тоо 3 дахин, суудлын тээврийн хэрэгслийн тоо 7 дахин нэмэгдэж зорчигч, тээврийн хэрэгсэл хилийн боомтоор түргэн шуурхай нэвтрэн, ая тухтай үйлчлүүлэх боломж бүрдэж

⁴ Ganbaatar, Bayarmaa, Juan Huang, Chuanmin Shuai, Asad Nawaz, and Madad Ali. "Empirical analysis of factors affecting the bilateral trade between Mongolia and China." *Sustainability* 13, no. 7 (2021): 4051.

⁵ Luttwak, Edward N. "From geopolitics to geo-economics: Logic of conflict, grammar of commerce." *The national interest* 20 (1990): 17-23.

⁶ Khatik, Mukesh H., and Upasana Bhandari. "Indo-Mongolian Relations in Present Era." *Electronic Journal of Social and Strategic Studies* 2 (2021): 118-131.

⁷ Chu, Amanda MY, Zhihui Lv, Niklas F. Wagner, and Wing-Keung Wong. "Linear and nonlinear growth determinants: The case of Mongolia and its connection to China." *Emerging Markets Review* 43 (2020): 100693.

⁸ Williams, Edward T. "The Relations Between China, Russia and Mongolia." *American Journal of International Law* 10, no. 4 (1916): 798-808.

⁹ Dygas, R. (2022). Multilateral Economic Ties of Mongolia with its Asian Trading Partners in period of 2011-2021. *Mongolian Journal of International Affairs*, 23(1), 23–39. <https://doi.org/10.5564/mjia.v23i1.2403>

Монгол Улсын гадаад худалдаа, эдийн засгийн хөгжилд томоохон нөлөө үзүүлэх юм. Эхний ээлжид зорчигч тээврийн цогцолбор, дараа нь ачаа тээврийн цогцолборыг ашиглалтад оруулахаар төлөвлөсөн байдаг. Гэвч Ковид-19 цар тахлын халдварын нөхцөл байдлаас шалтгаалж энэ ажил зогсонги байдалд орсон.

Ковид-19 цар тахлын халдварын нөхцөл байдлаас шалтгаалж БНХАУ-ын талаас боомтын тодорхойгүй хугацаагаар хаах, ачаа бараа нэвтрүүлэхгүй байх зэрэг хүндрэлүүд гарсан. БНХАУ-ын Засгийн газраас Ковид-19 цар тахлын халдварын эсрэг баримталж буй хатуу бодлогоос шалтгаалж Замын-Үүд боомтын асуудлууд бүрэн шийдэгдэж чадахгүй байв. Монгол, Хятадын хилийн боомт тэдгээрийн дэглэмийн тухай Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу хоёр талын зэрэглэлтэй, түр горимтой боомт юм. Монгол Улсын хилийн мэдээллээс үзвэл, Зүүн буюу Дорнод бүс нутагт олон улсын зэрэглэлтэй, байнгын горимтой (Бичигт авто замын боомт), олон улсын зэрэглэлтэй боловч түр горимтой боомт (Сүмбэр авто замын боомт) тус бүр нэг, хоёр талын зэрэглэлтэй, түр горимтой боомт хоёр (Баянхошуу, Хавирга авто замын боомт) тус тус ажиллаж байна. Харин өмнөд бүсэд олон улсын зэрэглэлтэй, байнгын горимтой (Замын-Үүд авто замын боомт), хоёр талын зэрэглэлтэй, байнгын горимтой боомт тус бүр нэг (Шивээ хүрэн авто замын боомт), хоёр талын зэрэглэлтэй, түр горимтой боомт нэг (Ханги авто замын боомт) тус тус ажиллаж байна¹⁰.

Баруун бүс нутагт олон улсын зэрэглэлтэй, байнгын горимтой нэг боомт (Булган авто замын боомт), хоёр талын зэрэглэлтэй, түр горимтой гурван боомт (Байтаг, Бургастай, Даян авто замын боомт) ажиллаж байна.

Хүснэгт 1. Монгол, Хятадын хилийн боомтуудын мэдээлэл.

Монгол, Хятадын хилийн боомтууд 17 /ажиллаж байгаа 13, ажиллахгүй байгаа 4/					
Олон улсын		Хоёр талын байнгын ажиллагаатай		Хоёр талын түр ажиллагаатай	
1	Булган-Такашикэн	7	Бургастай-Лаоэмля	16	Даян-Хуншаньзюй
2	Замын-Үүд /АЗ/-Эрээн	8	Шивээхүрэн /АЗ/-Сэхээ	17	Байтаг-Улиастай
3	Замын-Үүд /ТЗ/-Эрээн	9	Шивээхүрэн /ТЗ/-Сэхээ	Тайлбар: Шинээр нээхээр төлөвлөж буй боомтуудыг улаан өнгөөр тодотгоов. "Монгол, Хятадын хилийн боомт, тэдгээрийн дэглэмийн тухай Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын 2004 оны хэлэлцээр"-т 2020 онд нэмэлт оруулж шинээр 4 боомтыг байгуулахаар тусгасан.	
4	Бичигт /АЗ/-Зүүн хатавч	10	Цагаандал Уул-Өлзий		
5	Бичигт /ТЗ/-Зүүн хатавч	11	Гашуунсухайт /АЗ/-Ганц мод		
6	Сүмбэр /түр/-Рашаан	12	Гашуунсухайт /ТЗ/-Ганц мод		
		13	Ханги-Мандал		
		14	Баянхошуу-Өвдөг		
		15	Хавирга-Ар хашаат		

Эх сурвалж: Цэдэв, Энх-Уянга, and Цолмон Энхжаргал. "БНХАУ-тай хиллэх боомтын менежментийг сайжруулах нь: Гашуунсухайт боомтын нүүрс тээврийн жишээн дээр." (2023). Wuyn, Oyun. "Issues on trade and economic cooperation of Mongolia-China." Journal of International Studies (2018): 81-101.

Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын 2004 оны "Монгол, Хятадын хилийн боомт, тэдгээрийн дэглэмийн тухай" хэлэлцээрийн дагуу Монгол, Хятадын хилд дараах 13 боомтыг нээн ажиллуулахаар тогтсон:

1. Даян - Хуншаньзюй боомт
2. Булган- Такашикэн боомт

¹⁰ World Bank. "Mongolia Economic Update, January 2020: Macroeconomic Stability and Credit Growth." (2020).

3. Байтаг-Улиастай боомт
4. Бургастай - Лаомяо боомт
5. Шивээ хүрэн - Сэхээ боомт
6. Гашуун сухайт-Ганц мод боомт
7. Ханги- Мандалын боомт
8. Замын-Үүд-Эрээн хот боомт, төмөр зам,
9. Замын-Үүд-Эрээн хот боомт, авто зам
10. Бичигт-Зүүн хатавч боомт
11. Сүмбэр-Рашаан боомт
12. Баянхошуу-Өвдөг боомт
13. Хавирга-Ар Хашаат боомт эдгээр болно.

БНХАУ дахь хилийн боомтууд

БНХАУ-ын хилийн боомтууд Өвөр Монголын Өөртөө Засах Орон болон Шинжаан Уйгурын Өөртөө Засах Орны нутаг дэвсгэрт байрлаж байгаагаараа онцлогтой юм. БНХАУ-ын хилийн боомтуудаас ӨМӨЗО-ны хилийн боомтууд, тэдгээрт хийсэн хөрөнгө оруулалтын мэдээллийг харж болно. Энэхүү мэдээлэлд тулгуурлан Монгол Улсын хилийн боомтын үйл ажиллагааны чиглэлийг уялдуулж чадвал хоёр улсын худалдаа, хилийн харилцаа амжилттай хөгжих боломж бүрдэх талтай юм¹¹.

Хүснэгт 2. БНХАУ-ын хилийн ӨМӨЗО-ны нутагт байрлах боомтууд.

Боомтын нэр	Тээвэрлэлтийн хэлбэр	Газарзүйн байрлал	Үйл ажиллагаа	Хил залгаа боомт
Эрээн хот	Төмөр зам	2-р шугаман терминал, хилийн 815-р шугам	I зэрэг бүтэн жил нээлттэй	Замын Үүд
	Авто зам		I зэрэг бүтэн жил нээлттэй	Замын Үүд
Сэхэ	Авто зам	ӨМӨЗО-ны Алшаа аймаг	I зэрэг бүтэн жил нээлттэй	Шивээ хүрэн
Өвдөг	Усан зам	Хөлөнбуйр хот хилийн 1423-р шугам	II зэрэг улирлын чанартай	Баян хошуу

¹¹ Nasanbayar, Alatan, and Bazardorj Damdindorj. "Sumber-Rashaan port on the Mongolian-Chinese border: Current situation and development opportunities." *Journal of International Studies* 44, no. 112 (2021): 95-107.

Рашаант	Авто зам	Хянган аймаг Рашаан хот	II зэрэг улирлын чанартай	Сүмбэр
Ганц мод	Авто зам	Хилийн 679-р шугам	I зэрэг бүтэн жил нээлттэй	Гашуун сухайт
Ар Хашаат	Авто зам	Хөлөнбуйр хот, хилийн 1495-р шугам	I зэрэг бүтэн жил нээлттэй	Хавирга
Зүүн хатавч	Авто зам	Шилийн гол аймаг, Зүүн Үзэмчин хошуу	I зэрэг бүтэн жил нээлттэй	Бичигт
Мандал	Авто зам	Бугат хот, хилийн 757-р шугам	II зэрэг улирлын чанартай	Ханги
Баг мод	Авто зам	хилийн 679-р шугам	II зэрэг	Бүдүүн мод

Эх сурвалж: БНХАУ-ын Өвөр Монголын өөртөө засах орны Худалдааны танхимын вэб сайт, Боомтын вэб сайт.

Хилийн боомтуудын зэрэглэлээс харахад үйл ажиллагааны чиглэл боломжийн харагдаж байгаа боловч Замын-Үүд авто замын боомтыг эс тооцвол бусад боомтууд Монгол Улсын уул уурхайн бүтээгдэхүүнийг БНХАУ-д тээвэрлэн хүргэх зориулалтайгаар ажиллаж байгаа гэж тодорхойлж болохоор байна. Өөрөөр хэлбэл, Монголын зүүн, өмнөд, баруун бүс нутагт байгуулагдсан тэдгээр хилийн боомтуудын үйл ажиллагааны чиглэлээс авч үзвэл дийлэнх нь тухайн бүс нутгийн байгалийн ашигт малтмалыг тээвэрлэхэд чиглэгдсэн байна¹². Энэ нь нэг талаараа Монгол Улсын эдийн засагт чухал ач холбогдолтой бараа бүтээгдэхүүний эргэлт мөн боловч иргэдийн харилцан зорчих, аялах, харилцан худалдаа хийх хилийн боомт харьцангуй бага байгаа нь ажиглагдана. Худалдаа эдийн засгийн харилцааны гол үүд болох Замын-Үүд боомт нь БНХАУ-ын цар тахлын эсрэг авч хэрэгжүүлсэн арга хэмжээтэй холбоотойгоор байнгын үйл ажиллагаа тасалдаж, ачаа тээвэрлэлтэд түгжрэл, гацаа үүссэн билээ. Тэгэхээр энэ байдалд дүгнэлт хийж 2-3 байнгын ажиллагаатай боомтуудыг зохион байгуулах шаардлага юм.

БНХАУ-ын хилийн боомтуудын хөрөнгө оруулалт харьцангуй нээлттэй тодорхой бөгөөд олон нийтэд мэдээлэл түгээх чанараараа сайн байна. Хилийн боомтыг хөгжүүлэхэд дан ганц улсын төсөв санхүүгийн дэмжлэгээс гадна түүнд оролцох хувь,

¹² Mongolian Statistical Database (2023). Retrieved on January 15, 2024, from https://www2.1212.mn/Stat.aspx?LIST_ID=976_L14&type=sectorbook

хүн бусад аж ахуйн нэгжийн оролцоо чухал учир тэднийг оролцоог нэмэгдүүлэхэд анхааран ажиллаж байгаан байна. Өөрөөр хэлбэл, тухайн боомтод хийж буй хөрөнгө оруулалт цаашид уг боомт хэр өргөжих тэлэх ирээдүй, нөхцөл бололцоог байгааг нээн харуулж байгаа хэрэг болно¹³.

Хилийн боомтын хөрөнгө оруулалт, нөхцөл байдлын сайжралд тулгуурлан хувь хүн, аж ахуйн нэгж уг хилийн боомтыг түшиглэн аж ахуй эрхлэх, худалдаа арилжаа хийх, хоол цайны газар ажиллуулах, аялал жуулчлал хөгжүүлэх зэрэг олон талын үйлсийг өрнүүлэх таатай бололцоо бүрдэнэ. Тийнхүү хилийн боомт түшиглэсэн суурин байгуулагдаж, түүгээр дамжин хилийн худалдаа эргэлт нэмэгдэх, богино хугацаанд хямд бараа бүтээгдэхүүн харилцан ашигтай нийлүүлэх боломж бололцоо бүрдэнэ гэж үздэг.

БНХАУ-ын зүгээс энэхүү бодлогын хүрээнд хилийн боомтын дэд бүтцийг сайжруулж, цахилгаан эрчим хүч зэрэг суурин аж төрөхөд шаардлагатай, таатай нөхцөлийг бүрдүүлэхээр олон төсөл хөтөлбөр, хөрөнгө оруулалт хийсэн байна. Хоёр улсын хилийн худалдаа, харилцааны гол гарц, орц болох хилийн боомтуудын үйл ажиллагааг харьцуулж үзэхэд багагүй ялгаатай байна. Үүнд, Монголын хилийн боомтуудын хөрөнгө оруулалтын талаарх мэдээлэл хомс байхаас гадна тэдгээр боомтуудын хэтийн төлөвийн талаарх бодитой бодлого зохицуулалт, төлөвлөлтийн төлөвлөгөө тодорхой биш байдаг.

Монголын хилийн боомтуудын дэд бүтцийг сайжруулах зайлшгүй шаардлагатай байна. Хилийн боомтын дэд бүтцийн асуудлыг шийдсэнээр БНХАУ-ын хил залгаа хилийн боомтуудын үйл ажиллагааны чиглэлтэй уялдуулж хөгжих, хөрөнгө оруулалт татах, улмаар түр зуурын үйл ажиллагаатай боомтуудыг өргөтгөх нөхцөл бүрдэх болов уу. Энэ тохиолдолд байнгын үйл ажиллагаатай хилийн боомт нэмэгдэж, Монгол Улсын эдийн засагт асар их нөлөө үзүүлэх боломжтой юм. Нөгөө талаас, Замын-Үүд гэх ганц гарцаас олон гарц бүхий хилийн боомттой болох нөөц боломж байна¹⁴.

2. Монгол Улс, БНХАУ-ын худалдааны харилцаа: Шинэ нөхцөл байдал


Орчин үеийн худалдааны харилцаанд хэзээ ч хэн ч төсөөлж байгаагүй бэрхшээл тулгарсан нь Ковид-19 гэх цар тахал юм. Олон улсын худалдаа, эдийн засгийн онолуудад орчин үед дэлхий дахинд үүссэн шиг тийм нөхцөл байдал үүснэ гэдгийг таамаглаж байсангүй. Цар тахлын нөхцөл байдал дэлхийн улс орнуудад тээвэр логистикийн маш хүнд бэрхшээл авчирсан байна. Тиймээс шинэ шийдэл, гарц эрэх, уламжлалт тээврийн маршрут, харилцааг шинэчлэх нь зайлшгүй боллоо гэж олон судлаач нар санал нэгтэй тэмдэглэсэн байдаг¹⁵. Тээвэр ложистикийн энэхүү хүндрэл дэлхийн бүх улс орнуудад нөлөөлж тээврийн зардлын нэмэгдлийг авчирсан бөгөөд тэр хирээр тухайн улс орны эдийн засагт сөргөөр нөлөөлж, бараа бүтээгдэхүүний хомсдолд орох, улмаар үнэ нэмэгдэх үндэс суурь болжээ. Тухайлбал, дэлхий даяар тээврийн үнэ 2021 оны 8-сард өмнөх оны мөн үеэс 3 дахин өсөж стандарт контейнер буюу чингэлэг тээвэрлэх үнэ 10 мянган доллар дөхөж очсоныг Drewry компаниас тооцож зарладаг индексээс харж болохоор байна. Уг судалгаанд 2019 оны 10-р сараас 2021 оны 10-р сар хүртэлх чингэлэг

¹³ Liu, Manlu, Seung Ho Kang, and Woo Chul Ahn. "Analysis of the market structure and shift-effects in North China ports." *The Asian Journal of Shipping and Logistics* 32, no. 3 (2016): 179-186.

¹⁴ Mongolian Statistical Database (2023). Retrieved on January 15, 2024, from https://www2.1212.mn/Stat.aspx?LIST_ID=976_L14&type=sectorbook

¹⁵ Bazar, S. A. N. J. M. Y. A. T. A. V. "The Most favourable direction for Mongolia in regional integration: the Eurasian economic union." *Erina report* 6 (2018): 142.

тээврийн үнийн өсөлтийг таш тодорхойгоор тооцож гаргасан байна. Түүнээс гадна ачаа тээврийн 83% нь цар тахлын өмнөх үед буюу 2019 онд тогтоосон хугацаандаа хүрдэг байсан бол энэ үзүүлэлт 2021 оны байдлаар 39 % болтлоо буурсан болохыг Freightos компани мэдээлсэн байна.



Зураг 1. Drewry компаний худалдааны индекс.

Стандарт буюу 40 фунт контейнер буюу чингэлэг тээвэрлэх дундаж үнэ.

Эх сурвалж: Drewry (2023). Retrieved on October 10, 2023, from

<https://www.drewry.co.uk/supply-chain-advisors/supply-chain-expertise/world-container-index-assessed-by-drewry>

Дэлхийн олон улс орнууд БНХАУ-аас худалдан авч буй барааныхаа ихэнхийг далайгаар тээвэрлэдэг бөгөөд тийм ч учраас тус улсад 20 орчим том, 100 гаруй жижиг далайн боомт ажилладаг. Эдгээр боомтын заримд нь цар тахалтай холбоотой хорио цээрийн дэглэм тогтоосны улмаас чингэлгүүдийг ачиж буулгах ажил графикаас хоцорч эхэлсэн бөгөөд энэ нөхцөл байдлаас үүдээд асар их хэмжээний бараа бүтээгдэхүүн товлосон хугацаанаас хоцорч хугацаа нь тодорхойгүйгээр сунжрах нь хэвийн үзэгдэл болж, түүнээс гарах арга зам цар тахлын сэжигтэй тохиолдол намдах, БНХАУ усан боомтуудын үйл ажиллагааг нээхийг тэвчээртэй хүлээж харахаас өөр арга зам байхгүйд хүргэсэн. Ковид-19 цар тахлын тархалтаас сэргийлэхийн тулд улс орнууд хилээ хааж, хөл хорио тогтоон, улмаар дэлхийн эдийн засгийн идэвхжил суларч, үйлдвэрлэл тасалдаж улмаар дэлхий дахинд гадаад худалдааны эргэлт 2020 онд саармагжсан байдаг¹⁶.

Энэхүү үүсээд байгаа нөхцөл байдлаас шалтгаалж далайн тээвэр, ложистикийн компаниуд зөөх ачааны хомсдолд орж, алдагдлаа бууруулахын тулд олон улсын тээвэр хийх онгоцны тоогоо цөөрүүлсний зэрэгцээ сул контейнероо эргэн татахаа багасгах арга хэмжээ авч эхэлсэн байна. Нөгөө талаар, Азийн улс орнууд, тухайлбал БНХАУ 2021 оны эхнээс цар тахлыг бүрэн хяналтдаа авч чадсанаар, эдийн засаг нь сэргэн, үйлдвэрлэл, гадаад худалдаагаа тэлэх боломжтой болсон байна. Иймд цаашид худалдааны эргэлтийг нэмэгдүүлэх, дэд хангалт нийлүүлэлтийн сүлжээг хөгжүүлэхийн тулд Зам тээвэр,

¹⁶ Kiyota, Koza. "The COVID-19 pandemic and the world trade network." Journal of Asian Economics 78 (2022): 101419.

логистикийн хөгжил байршлын төлөвлөлтийн судалгааны¹⁷ ажил нь дараах хүрээг хамран хийхээр болжээ. Үүнд:

- МУ-ын зам тээврийн салбарын өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийх;
- МУ-ын зам тээврийн салбарт мөрдөгдөж байгаа хууль, бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилт, уялдаж буй байдалд дүн шинжилгээ хийх, холбогдох дүгнэлт, саналыг боловсруулах;
- МУ-ын ачаа эргэлт, ачаа үүсэх ба шингээх цэг, хэтийн төлвийг тодорхойлох;
- Ачаа тээврийн үйлчилгээний зохицуулалт, зохион байгуулалтыг сайжруулах, эдийн засгийн үр ашигтай тээвэрлэлтийн нөхцлийг бүрдүүлэх боломж, нөхцлийг тодорхойлох;
- Ачаа тээврийн логистик төвийн төрөл, зориулалт, хүчин чадал, зэрэглэлийг тоймлон тогтоох, санал боловсруулах;
- Үндэсний логистикийн сүлжээг төлөвлөн, логистик төвийн байршлыг тогтоон, зураглал гаргах;
- Олон улсын тээвэр логистикийн сүлжээнд нэгдэх гарцыг тодорхойлох, энэ чиглэлээр дүгнэлт, санал боловсруулах.
- Тээврийн үйлчилгээний түвшинг олон улсын жишигт нийцүүлэх зөвлөмжийг боловсруулахад гол зорилго оршиж байсныг тэмдэглэжээ.

Монгол Улсын Засгийн газрын тохируулагч агентлаг Үндэсний хөгжлийн газар, Монгол Улсын Их Сургуулийн Эдийн засгийн хүрээлэнгийн дээрх судалгаа нь логистикийн чиглэлийн улсын гол баримт бичиг болж байна. Мөн логистикийн чиглэлийн цөөнгүй судалгаа, олон улсын байгууллагатай хамтран хэрэгжүүлсэн, хэрэгжүүлж байгаа төсөл хөтөлбөрүүд байна. Жишээ нь, БНСУ-тай хамтран хэрэгжүүлж байгаа Монгол Улсад ухаалаг логистик, тээврийг хөгжүүлэх стратеги (Smart Logistics and Transportation Strategy for Mongolia) төсөл юм¹⁸.

3. Монгол-Хятадын худалдааны харилцааны өнгөрсөн ба өнөөгийн байдал

Далайд гарцгүй, хоёр хөрш оронтой Монгол Улсын худалдааны харилцаанд мэдээж хэрэг хоёр хөршийн оролцоо маш их байх нь мэдээж. Гэхдээ хоёр хөрш орны гадаад худалдааны харилцаа тэнцэл харилцан адилгүй байна. БНХАУ нь Монгол Улсын хувьд эдийн засгийн харилцааны гол түнш орон гэдгийг олон судалгаа харуулдаг. Тухайлбал, Монгол Улсын экспортыг бүтцийг авч үзвэл тухайн хоёр орны худалдааны харилцааны илүү тодорхой харагдана.


¹⁷ Ж.Сэрээтэр, Зам тээвэр, логистикийн хөгжил, байршлын төлөвлөлтийн судалгаа, Улаанбаатар, 2018, тал.5-8

¹⁸ Asian Development Bank (2023). Retrieved on December 01, 2023, from <https://www.adb.org/sites/default/files/publication/400826/mongolia-transport-sector-fact-sheet.pdf>




Зураг 2. Гадаад худалдааны тэнцэл, оноор, мөнгөн дүнгээр.
 Эх сурвалж: Mongolian Statistical Database (2023). Retrieved on January 15, 2024, from https://www2.1212.mn/tables.aspx?TBL_ID=DT_NSO_1400_001V1

Монгол Улсын статистикийн үндэсний хорооны гаргасан дээрх баримтаас үзэхэд, нийт экспортын 75 хувийг БНХАУ дангаараа эзэлж байна. Өөрөөр хэлбэл, Монгол-Хятадын худалдааны өнөөгийн байдал энэ хэмжээнд байна гэж үзэж болох юм. Энэ нөхцөл байдал чухам юутай холбоотой байна гэвэл гео-эдийн засгийн асуудалтай шууд холбогдоно.



Зураг 3. Монгол Улсын экспортын бүтэц.
 Эх сурвалж: Mongolian Statistical Database (2023). Retrieved on January 15, 2024, from https://www2.1212.mn/tables.aspx?TBL_ID=DT_NSO_1400_001V1



Зураг 4. Ачааны экспортуудын боомтуудын эзлэх хувь.
Эх сурвалж: Зам, тээврийн салбарын статистик мэдээлэл 2021.

БНХАУ-ын хилээр гарч байгаа ганц бүтээгдэхүүн бол нүүрс байна. Гашуун Сухайт, Шивээ хүрэн боомтоор нэвтэрч байгаа нүүрсний экспортод хэт найдах нь маш их эрсдэл дагуулна. Гэхдээ дээрх хоёр боомтоор гарч байгаа нүүрсний хэмжээтэй тэнцэхүйц, ядаж 50 хувьтай тэнцэхүйц бараа бүтээгдэхүүнийг харилцан нэвтрүүлэх боломжийн судлах хэрэгтэй болов уу. Эдгээр боомт нүүрс тээврийн боомт учраас Замын- Үүд, Эрээний хилийн боомтыг 100 хувь биш гэхэд 80 хувь ашиглах шаардлага тулгарч байна. Гэтэл цар тахлаас шалтгаалж Замын-Үүд, Эрээний хилийн боомтоор зөвхөн “Чингэлэг тээвэр” –ийг нэвтрүүлэх болсон билээ.

Үүнээс харвал чингэлэг тээвэр нь эерэг, сөрөг талтай байна. Гэхдээ эерэгээс илүүтэй, сөрөг тал давамгайлж байна гэж хувь судлаачийн хувьд үзэж байна.

Монгол Улсын эдийн засагт, үнийн хөөрөгдөлд гол нөлөө үзүүлэх хүчин зүйлийн нэг бол яах аргагүй чингэлэг тээвэр юм. Чингэлэг тээврээр юу авч болно гэвэл хүнсний зүйл, хувцас хунар, ахуйн өдөр тутмын хэрэглээний зүйлийг л авна. Энэ нь өмсөж зүүх, идэж уух хэрэглээний зүйл болохоос эдийн засагт нөлөөлөх суурь бараа бүтээгдэхүүн биш юм. Чингэлэг тээвэр нэвтэрснээс барилгын гол материал болох арматур төмөр, том оврын техник, тоног төхөөрөмж, түүний сэлбэг хэрэгсэл орох боломжгүй болсон байна. Тиймээс Замын-Үүд боомтын гео-эдийн засгийн хүчин зүйлийг шинээр тооцож гаргах, түүнд тулгуурласан бодлого хэрэгжүүлэх нь хойшлуулашгүй зорилт болох ёстой гэж бодож байна.

Монголоор дамжуулан нийлүүлэлт хийх маршрут нь тээвэрлэлт болон бусад нөхцөл байдлын хувьд илүү үр дүнтэй байх бол “Алтай”¹⁹ төслөөр нийлүүлэлт хийх нь Хятадын хамгийн өндөр хэрэглээтэй зах зээлд байгалийн хийг хүргэж чадахгүй, үр ашгийн хувьд алдагдалтай байх юм. Харин ОХУ-ын хувьд "Алтай" төсөл нь илүү өгөөжтэй. Учир нь Баруун Сибирь дэх Оросын хамгийн том орд газраас "Алтай" төсөл эх авч байгаагийн зэрэгцээ Европ руу нийлүүлж буй хий улс төрийн шалтгаанаар

¹⁹ Altai project (2023). Retrieved on December 10, 2023, from <https://itoim.mn/a/2023/10/31/article/kki>

эрсдэлд орлоо гэхэд тэр алдагдлыг “Алтай” төсөл нөхөх боломжтой юм. Ингэснээр ОХУ-ын байгалийн хийн өрсөлдөх чадвар нэмэгдэнэ. Харин БНХАУ-ын хувьд “Алтай” төсөл ямар ч ашиггүй гэж Эдвард Чоу дүгнэжээ.

Монголоор дамжуулах хийн хоолойн хувилбар Хятадад ашигтай. Яагаад гэвэл зүүн мужуудаа байгалийн хийгээр хангах боломжтой болно. Хятадын баруун хэсэгт байгалийн хий хэрэггүй. Баруун мужаасаа тэр шугамыг Хятадын бүх нутгаар татаж, Бээжин, зүүн мужуудад хүргэх нь эдийн засгийн хувьд хохиролтой. Харин Монголоор дайруулбал байгалийн хийгээ Бээжинд шууд хүргэж чадна. Хятадад хийн хэрэглээ нэмэгдэж байгаа ч ОХУ-аас авахаас өөр хувилбар байхгүй. Тийм болохоор Монголоор дамжуулах хийн хоолойн гэрээ түргэн хугацаанд байгуулагдах байх гэж үзэж байгаан байна.

Дүгнэлт

Дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахлын хорио цээр нь олон улсын хил гаалийн нөхцөл байдал, боомтын ачаа тээврийн хүчин чадал, тээвэр ложистикийн чадавхи зэрэг олон хүчин зүйлийн өнөөгийн байдалд дүн шинжилгээ өгөх боломж олгосон гэж дүгнэж болно.

Үүнд,

- дайн байлдаан, сэргэлдөөнөөс бус, дэлхий нийтийг хамарсан цар тахлаас болж олон улсын худалдааны харилцаа саатах эрсдэл байж болохыг,
- хэзээ ч тохиолдож байгаагүй ч далайн тээвэр гацах боломжтойг,
- контейнер чингэлэгийн бөөгнөрөл нэг талд үүсэж байхад, нөгөө талд контейнер чингэлэгийн хосдол үүсэх эрсдэл байж болохыг,
- бараа болон хүнсний бүтээгдэхүүний хувьд хэзээ ч нэг улс болон ер нь экспортын хараат байж болохгүйг,
- тээвэр, ложистикийн хувьд ч мөн нэг зам, нэг улс оронд хэт төвлөрсөн шинжтэй байх тээвэрлэлт эрсдэлтэй болохыг
- Дэлхий дахин даяаршиж харилцаа өргөжсөн хэдий ч худалдаа, эдийн засгийн харилцаа цөөн хэдэн улсын цөөн хэдэн улсаас шууд хамааралтай болохыг тус тус харуулсан байна.

Далайд гарцгүй, БНХАУ-аар дамжин орж ирэх төмөр замын тээвэрт түшиглэсэн Монголын хувьд гол боомтуудын нэг болох Замын-Үүдийн боомт нь геополитик, геоэдийн засгийн хувьд ямар үнэ цэнэтэйг харуулсны зэрэгцээ түүнд чиглэсэн тууштай бодлого тасралтгүй хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатайг илтгэж байна. Энэ талаар Монгол Улсын Засгийн газрын зүгээс олон удаа БНХАУ-ын талтай уулзаж яриа хэлэлцээр хийсэн боловч тодорхой үр дүнд хүрэхгүй байж ирсэн байна. Энэ нь нэг талаас БНХАУ-ын зүгээс баримталж буй “Тэг-Ковид” бодлоготой тодорхой хэмжээгээр холбоотой байсан. Нөгөө талаас Монгол Улсын стратегийн чухал боомтын хүчин чадал, техник технологи, дэд бүтцийн асуудалтай шууд холбоотой билээ.

Монгол Улсын зүгээс геополитик, геоэдийн засгийн хамгийн чухал амин цэг болох Замын-Үүд боомтын үйл ажиллагаанд онцгой анхаарал хандуулж тодорхой, тууштай бодлого хэрэгжүүлээгүй тохиолдолд Монгол Улсын эдийн засагт сөрөг хандлага, нөлөө үзүүлсээр байх төлөвтэй байна. Үүнээс гарах арга зам нь Замын-Үүд

боомтын шинэчлэлтийг түргэтгэж цаашид хөгжүүлэх, гео-эдийн засгийн эргэлтэд оруулах явдал юм. Нөгөө талаас БНХАУ-ын “Тэг-Ковид” бодлого дахин хэрэгжих, олон улсын агуулах, барилгын цогцолбор байгуулахад гадаад хөрөнгө оруулалтад ОХУ, БНХАУ-ын хандлага харилцаанд сөргөөр нөлөөлж тэдгээр улсын геополитик болон хөгжлийн урт төсөл, хөтөлбөрт харшилж байна гэж үзээд саатуулах, зогсоох эрсдэлтэй.

Цаашлаад, эдийн засгийн батлан хамгаалалт нь улс орныг түгжигдмэл байдал бус ухаалаг нээлттэй бодлогод тулгуурлах, улстөржсөн парламентын дарамтаас харьцангуй ангижирсан тохиолдолд гео-эдийн засгийн бодлого амжилттай хэрэгжих боломжтой нь ажиглагдаж байна. Гэхдээ гео-эдийн засгийн бодлогод хамгаалалт байр суурь баримтлах, эсвэл давшилтын байр суурь баримтлах эсэхээс цаашдын үр дүн ихээхэн хамаарах нь лавтай юм.

Хамгаалалтын байр суурь баримталсан тохиолдолд олон улсын зах зээлд оролцохоос илүүтэй тухайн үеийн нөхцөл байдлыг анхааралтай ажиглана гэсэн үг. Хэдийгээр анхааралтай ажиглаж байгаа нь давуу тал мэт боловч асар богино хугацаанд асар хурдацтай хөгжиж буй өнөөгийн эдийн засгийн үйл явдлаас хоцрох, гээгдэх эрсдэл их байна гэсэн үг. Харин давшилтын байр суурь баримтлах тохиолдолд үйл явдлаас хоцрох бус тухайн нөхцөл байдлаас ашиг олох, эдийн засгийн үйл явцыг өөрт ашигтайгаар эргүүлэх боломж бололцоо нээгдэнэ гэсэн үг.

Тиймээс гео-эдийн засгийн бодлого хэрэгжүүлэхийн тулд гео-эдийн засгийн стратегийг зөв боловсруулах залшгүй шаардлагатай. Гео-эдийн засгийн стратеги боловсруулж баримтлаагүй тохиолдолд дэлхийн эдийн зах зээлд өөрийн байр суурийг эзлэх бүрхэг, магадгүй боломжгүй болох магадлалтай. Гео-эдийн засгийн бодлого хэрэгжиж буй өнөөгийн нөхцөлд баялаг материаллаг чанараа алдаж технологийн дэвшил, цахим хөгжлийн үйл явцаар тодорхойлогдох болсоор байгаа билээ.

Далайд гарцгүй Монгол Улсын хувьд гурван улсын эдийн засгийн коридорыг ашиглан гео-эдийн засгийн бодлого хэрэгжүүлэх нь хөгжлийн хүрэх гол зам гэдгийг судалгааны үр дүнгүүд баталсаар байна. Замын-Үүд боомтын хөгжил, өнөөгийн байдал Монгол Улсын эдийн засаг, гадаад худалдааны харилцааны хамгийн гол боомт. Өнгөрсөнд Замын-Үүд, Эрээний хилийн боомтын хөгжил маш өндөр түвшинд гарсныг олон тоо баримтаар хэлж болно. Гэтэл дэлхий нийтийн хамарсан цар тахлаас шалтгаалж урьд өмнө төсөөлж байгаагүй тийм нөхцөлд байдал үүссэн байна. Өнгөрсөн хоёр жил Монгол Улсад дэгдсэн цар тахлаас үүдэлтэйгээр Замын-Үүд, Эрээний хилийн боомтын хэвийн нөхцөл байдлаар үйл ажиллагаа явуулж чадаагүй. Үүнээс үүдээд, бараа таваарын хомсдол, ачаа тээврийн бөөгнөрөл бий болсон бөгөөд тэдгээрийг зөв зүйтэй зохицуулах шаардлага гарсан. Харин Монгол Улсад 2022 он гарсаар цар тахлын асуудал үндсэндээ намжиж гадаад харилцаагаа эрчимжүүлж эдийн засгаа хөгжүүлэх таатай боломж гарч ирсэн билээ.

Ном зүй

Asian Development Bank (2023). Retrieved on December 01, 2023, from <https://www.adb.org/sites/default/files/publication/400826/mongolia-transport-sector-fact-sheet.pdf>

Altai project (2023). Retrieved on December 10, 2023, from <https://itoim.mn/a/2023/10/31/article/kki>

Bazar, S. A. N. J. M. Y. A. T. A. V. "The Most favourable direction for Mongolia in regional integration: the Eurasian economic union." *Erina report* 6 (2018): 142.

Chu, Amanda MY, Zhihui Lv, Niklas F. Wagner, and Wing-Keung Wong. "Linear and nonlinear growth determinants: The case of Mongolia and its connection to China." *Emerging Markets Review* 43 (2020): 100693.

Drewry (2023). Retrieved on October 10, 2023, from <https://www.drewry.co.uk/supply-chain-advisors/supply-chain-expertise/world-container-index-assessed-by-drewry>

Dygas, R. (2022). Multilateral Economic Ties of Mongolia with its Asian Trading Partners in period of 2011-2021. *Mongolian Journal of International Affairs*, 23(1), 23–39. <https://doi.org/10.5564/mjia.v23i1.2403>

Erina (2023). Retrieved on December 20, 2023, from https://www.unii.ac.jp/erina-unp/archive/wp-content/uploads/2023/02/se16802_tssc.pdf

Ganbaatar, Bayarmaa, Juan Huang, Chuanmin Shuai, Asad Nawaz, and Madad Ali. "Empirical analysis of factors affecting the bilateral trade between Mongolia and China." *Sustainability* 13, no. 7 (2021): 4051.

Khatik, Mukesh H., and Upasana Bhandari. "Indo-Mongolian Relations in Present Era." *Electronic Journal of Social and Strategic Studies* 2 (2021): 118-131.

Kiyota, Kozo. "The COVID-19 pandemic and the world trade network." *Journal of Asian Economics* 78 (2022): 101419.

Luttwak, Edward N. "From geopolitics to geo-economics: Logic of conflict, grammar of commerce." *The national interest* 20 (1990): 17-23.

Liu, Manlu, Seung Ho Kang, and Woo Chul Ahn. "Analysis of the market structure and shift-effects in North China ports." *The Asian Journal of Shipping and Logistics* 32, no. 3 (2016): 179-186.

Nasanbayar, Alatan, and Bazardorj Damdindorj. "Sumber-Rashaan port on the Mongolian-Chinese border: Current situation and development opportunities." *Journal of International Studies* 44, no. 112 (2021): 95-107.

Mongolian Statistical Database (2023). Retrieved on January 15, 2024, from https://www2.1212.mn/Stat.aspx?LIST_ID=976_L14&type=sectorbook

Mongolian Statistical Database (2023). Retrieved on January 15, 2024, from https://www2.1212.mn/tables.aspx?TBL_ID=DT_NSO_1400_001V1

Williams, Edward T. "The Relations Between China, Russia and Mongolia." *American Journal of International Law* 10, no. 4 (1916): 798-808.

World Bank. "Mongolia Economic Update, January 2020: Macroeconomic Stability and Credit Growth." (2020).

Wuyun, Oyun. "Issues on trade and economic cooperation of Mongolia-China." *Journal of International Studies* (2018): 81-101.

Ж.Сэрээтэр, Зам тээвэр, логистикийн хөгжил, байршлын төлөвлөлтийн судалгаа, Улаанбаатар, 2018, тал.5-8

Цэдэв, Энх-Уянга, and Цолмон Энхжаргал. "БНХАУ-тай хиллэх боомтын менежментийг сайжруулах нь: Гашуунсухайт боомтын нүүрс тээврийн жишээн дээр." (2023).

SPSIRPA FORUM 2024

Poster presentation 5

Gulf Cooperation Council, policies and activities in the region



ПЕРСИЙН БУЛАНГИЙН ОРНУУДЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЗӨВЛӨЛ, БҮС НУТАГТ ЯВУУЛЖ БУЙ БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА

ШУА-ийн ОУСХ-ийн ЭША 3. Мэнд

Магистр

2024 оны 5 дүгээр сарын 6-ны өдөр

Хураангуй: Энэхүү өгүүллээр Персийн булангийн Арабын орнуудын хамтын ажиллагааны зөвлөл тухайн бүс нутагтаа ямар бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлж буй талаар, булангийн орнууд нь Ойрхи дорнод дахь улс төр, нийгэм, эдийн засгийн чиг хандлагын гол чиглүүлэгч хүч болсон учир шалтгааныг авч үзнэ.

Түлхүүр үгс: Gulf Cooperation Council, Булангийн орнуудын хамтын ажиллагааны зөвлөл, Ойрхи дорнод (Баруун Ази), бүс нутгийн интеграци, Арабын улсуудын холбоо, АНЭУ, Бахрейны Хаант Улс, Кувейт Улс, Катар Улс, Оманы Султант Улс, Саудын Арабын Хаант Улс.

I. Удиртгал

1981 оны 5 дугаар сарын 25-ны өдөр Арабын Нэгдсэн Эмират Улс (АНЭУ)-ын Абу Даби хотод Булангийн орнуудын хамтын ажиллагааны зөвлөл (Зөвлөл)-ийг үүсгэн байгуулах баримт бичгийг албажуулан баталжээ. Уг зөвлөл нь бүс нутгийн шинжтэй институт болж үүсгэн байгуулагдсан бөгөөд Персийн булангийн хаант засаглалтай улсууд өөр хоорондоо түншлэх бүтцийг байгуулах замаар улс орноо бэхжүүлэн хөгжүүлэх зорилгоор Иран-Иракийн зөрчил мөргөлдөөний цаг үед анх байгуулагдсанаараа онцлог юм.

Персийн буланд орших хаант засаглалт улсууд болох АНЭУ, Бахрейны Хаант Улс, Кувейт Улс, Катар Улс, Оманы Султант Улс, Саудын Арабын Хаант Улс Зөвлөлийн гишүүн ажээ. Ойрхи дорнодын эдгээр зургаан орны байгуулсан уг эдийн засаг, улс төрийн эвсэл нь хэл, соёлоор ижил төстэй гишүүн улсууд хоорондын эдийн засгийн интеграци, улс төрийн эв найрамдлыг өргөжүүлэн бэхжүүлэх гэсэн алсын хараан дор гишүүдийн нэгдмэл байдлыг хангах үндсэн зорилготой.

Зөвлөлийг байгуулах шийдвэр гаргах тухай 1981 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн хуралдааны тэмдэглэлд, “Зөвлөл нь дээд зэргээр уялдуулан зохицуулах, нэгдэн нийлэх, нягт харилцааг бий болгох арга хэрэгсэл болж үйлчилнэ. Зөвлөл нь мөн эдийн засаг, санхүү, боловсрол, соёл, нийгмийн асуудал, эрүүл мэнд, харилцаа холбоо, мэдээлэл, паспорт болон иргэний харъяалал, аялал, худалдаа, гааль, ачаа тээвэр, хууль

зүйн болон хууль тогтоох асуудлаар дүрэм журам боловсруулна”¹ гэж тусгагдсан байдаг.

2003 оны 1 дүгээр сард Зөвлөлийн гишүүд гаалийн нэг бүсийг нэвтрүүлэн хэрэгжүүлж, 2013 оны 9 дүгээр сард Сингапур зэрэг бусад улс оронтой хоёр талт хэлэлцээрийг, 2014 оны 7 дугаар сард Европын чөлөөт худалдааны холбоотой тус тус гэрээ хэлэлцээр байгуулсан.


Засаглалын хувьд Саудын Арабын Хаант Улс, Катар Улс, Оманы Султант Улсууд нь бүрэн эрхт хаант засаглалтай бол, Бахрейн Улс, Кувейт Улс, АНЭУ нь холимог хэлбэрийн засаглалтайд тооцогддог. Эдийн засгийн хувьд эдгээр булангийн орнууд нь газрын тос, байгалийн хий зэрэг баялгаас олох орлого нь үндсэн орлогыг бүрдүүлж байдаг буюу дундажаар дотоодын нийт бүтээгдэхүүний 60 орчим хувийг зөвхөн байгалийн баялаг бүрдүүлж байдаг тул үйлдвэрлэл эрхлэгч гэхээс илүүтэй өөрсдийн өмчлөлийн баялгийг ашиглагч эдийн засагтай гэх тодотголд хамаардаг. 1970-аад онд явагдсан газрын тосны үнийн өсөлтийн үр дүнд эдгээр улс орнууд нийгмийн дэд бүтэц, нийтийн үйлчилгээг хүртээмжтэй хөгжүүлж эдийн засгаа бэхжүүлэх зорилгоо хангах үүднээс гадаадын ажиллах хүчийг их хэмжээгээр оруулж ажиллуулсан бөгөөд булангийн орнуудын иргэд нь өөрсдөө гол төлөв төр, олон нийтийн албанд ажил эрхэлж, төсвийн зарлага, ажлын байрны хүртээмжтэй байдал нь тухайн орны иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлэхэд эерэг нөлөөг үзүүлсэн байна². Зөвлөлийн гишүүн орнуудын дотоод нийт бүтээгдэхүүн³, хүн амын тоог⁴ хүснэгтээр харуулав.

¹ Rouhollah K. Ramazani, *The Gulf Cooperation Council: Record and Analysis* (University of Virginia Press, 1988).

² Ж. Баяр. Ойрхи дорнотын асуудал. УБ. 1973. х. 6-9

³ Дэлхийн банк: Булангийн орнуудын хамтын ажиллагааны зөвлөлийн гишүүдийн эдийн засгийн үзүүлэлт. <https://data.worldbank.org/indicator>

⁴ Зөвлөлийн гишүүн орнуудын хүн амын тоо 2024 оны байдлаар. <https://worldpopulationreview.com/country-rankings/gcc-countries>



II. Зөвлөл бүрэлдэх хүчин зүйл, Зөвлөлийн мөн чанар

“Араб үндэстэн бол хуваагдашгүй бөгөөд улс гүрний дунд өөрийн байр суурь бүхий бат орших хэсгийг буй болгоно” хэмээн 1913 онд Парист хийгдсэн Арабынхны анхны их хурлаас бүх араб үндэстэнд хандан уриалж байсан нь арабчуудын үндэсний үзэл, нармай арабын үзэл санаа, эвсэн нэгдэх эрмэлзлийг илэрхийлдэг. Арабчууд бол “Атлантын далайн эргээс Персийн булан, Арабын тэнгисийн эрэг хүртэлх Умард Африк, Дундад дорнод болон Ойрхи дорнодын өргөн уудам дэвсгэрт орших араб хэлтний аймаг, араб дахин”⁵ юм. АНЭУ-ын хүн амын 42 хувь, Бахрейны Хаант Улсын хүн амын 67.7 хувь, Кувейт Улсын хүн амын 78.1 хувь, Катар Улсын хүн амын 40.7 хувь, Оманы Султант Улсын хүн амын 76.7 хувь, Саудын Арабын Хаант Улс 88 хувь тус тус араб хэлээр ярьдаг⁶ бөгөөд эдгээр улсуудын төрийн албан ёсны хэл нь бүгд араб хэл болой. Эдгээр улс орнуудын хүн ардын ярианы хэлэн дэх орон нутгийн шинжтэй аялгууны ялгаа байдаг хэдий ч араб дахины нийт бичиг соёлын өв, утга зохиол, шашны суртахууны ном судар, лалын шашны сургаалын эх судар Коран зэрэгт тэрхүү үл ялих ялгаа нь төдийлөн нөлөөлөөгүй учир араб хэл нь аливаа аймаг угсаатныг арабын

⁵ Ж. Баяр. Ойрхи дорнотын асуудал. УБ. 1973. х. 6-9

⁶ World Data сан: Араб хэлээр ярьдаг улс орнууд. <https://www.worlddata.info/languages/arabic.php>

ертөнцөд хамаарагдах эсэхийн гол тэмдэг болсон хэвээр, соёл, шашин, сэтгэхүйн арга, зан үйлийн тээгч болсоор иржээ.

Арабчууд түүх, шашин мөргөл, хүмүүсийн сэтгэхүй, зан заншил, газар зүйн болон ашиг сонирхлын нийтлэг сэжмээр холбогдсоны хувьд улс орноо сэргээн мандуулах үндэсний эрмэлзлээр нэгдэхийн сацуу өөр хоорондын улс төр, эдийн засгийн хэлхээ холбооны хэтэрхий сул тал, тархай бутархай, хөгжлийн түвшин харилцан адилгүй байдал, хүн амын тоо, байгалийн баялаг, амьжиргааны түвшин, ашиг орлого зэрэг үзүүлэлтээрээ эрс тэс ялгавартай байдал зэргийг даван туулах, түүнчлэн гадны томоохон гүрэн улсуудын сарнин бутаргаж хуваан эзэмших бодлогыг⁷ сөрөн зогсох зэрэг хэрэгцээ шаардлагаар эвлэлдэн хамсах, нэгдэн нийлэх үйл явц руу түүхийн бүхий л цаг үеүүдэд, тэр дундаа ХХ зуунд эрчимтэйгээр тэмүүлсэн. Нэг талаас арабчууд өөрсдийн тархай бутархай байдлыг арилган хүчээ нэгтгэх, эзэнт улс эсхүл их бага нэгдлүүдийг байгуулах эрмэлзэл түүхэн бүхий л цаг үед байсан, нөгөө талаас Их Британи зэрэг дэлхийн томоохон гүрэн улсууд араб үндэсний энэхүү хөдөлгөөнийг Туркийн эсрэг ашиглах зорилгоор нармай арабын үзэл санааг дэмжиж байсан⁸, улмаар дэлхийн II дайны төгсгөл ойртох тутам арабчууд арабын улсуудын холбоог байгуулах асуудлыг 1944 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн Арабын орнуудын бага хурлын хэлэлцэх хэргийн төлөвлөгөөнд оруулан албан ёсоор хэлэлцэх болж, 1945 оны 3 дугаар сарын 22-ны өдөр Кайро хотод Египет, Сири, Ливан, Ирак, Йордан, Саудын Араб гэсэн улсууд хамтран Арабын улсуудын холбоог⁹ анх байгуулсныг зарлаж бөгөөд хожим Йемен, Алжир, Бахрейн, Коморос, Джибути, Кувейт, Ливи, Мавритан, Марокко, Оман, Палестин, Катар, Сомали, Судан, Тунис, АНЭУ улсууд гишүүнээр элссэнээр нийт 22 гишүүн улс бүхий, бүс нутгийн холбоо болон өргөжсөн байна.

Арабын улсуудын холбоо нь үндсэн зорилгын хувьд “гишүүн улс хоорондын харилцааг бэхжүүлэх, хоорондын хамтын ажиллагааг нөхцөлдүүлэх бодлогын нийцлийг хангах, тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг батлан хамгаалах, Арабын улс орнуудын ашиг сонирхол, үйл хэрэгт анхаарал хандуулах”¹⁰, эдийн засаг, санхүү, худалдаа, гааль, мөнгөн тэмдэгт, хөдөө аж ахуй, харилцаа холбоо, төмөр зам, авто зам, агаарын тээвэр, шуудан харилцаа, соёл, иргэний харъяалал, паспорт, виз, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, гэмт хэрэгтэн шилжүүлэх, нийгмийн асуудал, эрүүл мэндийн салбар зэрэгт нягт хамтын ажиллагааг бий болгох зорилготой.

Хэдийгээр Зөвлөлийн зургаан гишүүн орнууд нь бүгд Арабын улсуудын холбооны гишүүн орнууд байсан хэдий боловч “Персийн булангийн бүс нутагт хамааралтай байсан болон одоо ч хамааралтай хэвээр буй түүх, нийгэм, соёл, улс төр, стратегийн бодит байдалд тохируулан авах хариу арга хэмжээ болгож Персийн булангийн улс орнуудын дунд хамтын ажиллагааны зөвлөл шинээр байгуулах”¹¹ нэн

⁷ Ж. Баяр. Ойрхи дорнотын асуудал. УБ. 1973. х. 6-9

⁸ Мөн тэнд.

⁹ Монгол хэлэнд Арабын барилдлага, Арабын лиг гэх зэргээр хөрвүүлэн ашиглах нь бий.

¹⁰ Арабын улсуудын холбооны дүрмийн 1 дүгээр зүйл.
<https://www.refworld.org/legal/constinstr/las/1945/en/13854>

¹¹ АНУ-ын Гадаад нэвтрүүлгийн мэдээний алба. FBIS-MEA, V-81-107, June 4, 1981, A10-A13.

даруй хэрэгцээ шаардлагатай болсныг Зөвлөлийг үүсгэн байгуулах баримт бичгүүдэд 1981 оны 5 дугаар сарын 16-ны өдөр дурдсан байна. Өөрөөр хэлбэл, 1970-аад оны нефтийн хямрал, 1979 оны Ираны хувьсгал, 1980-аад оны үед дэгдсэн Ирак-Ираны дайн, түүнээс шалтгаалсан эдийн засгийн уналт, тогтворгүй байдал, олон улсын харилцааны олон зөрчил, тэмцэл зэрэг нь Зөвлөлийг үүсгэн байгуулах болсон улсуудын хувьд байгалийн баялаг, газрын тос, бусад хүчин зүйлийн улмаас гадаад, дотоод орчны хямралд өртөх байнгын аюул занал буйг хүлээн зөвшөөрөхөд хүргэж, дэлхий дахин, олон улс, бүс нутгийн шинжтэй асуудлуудад хариу арга хэмжээ авах, дасан зохицоход хамтарсан бүлгийн хэлбэрээр оролцоход хүргэжээ.

Энэхүү агуулгаар Зөвлөлийн онцлог, мөн чанарыг судлаачид дараахь үндсэн гурван суурь чиглэлтэй холбон тайлбарладаг байна¹². Үүнд:

- Нэгдүгээрт, гаднаас ирэх аюул занал нь гишүүн улс орны оршин тогтнох үндэс суурийг алдагдуулахгүй байх бүс нутгийн аюулгүй орчныг бий болгох¹³ явдал. Энэ зорилгыг биелүүлэх ажлын хүрээнд 1983-1987 онуудад хамтарсан цэргийн сургуулилтуудыг хийж, гишүүн орнуудын зэвсэгт хүчний жанжин штаб, батлан хамгаалахын сайд нар батлан хамгаалах хамтарсан хөтөлбөрийг боловсруулах, цэрэг-батлан хамгаалахын дундын сүлжээ, хамтын удирдлагын тогтолцоог бүрдүүлэх зайлшгүй шаардлагатай хэмээн үзэж зохих ажлуудыг хийж гүйцэтгэсэн¹⁴;
- Хоёрдугаарт, эдийн засгийн урт хугацааны хөгжлийг хангах, улс орны амьжиргааны түвшинг тогтмол дээшлүүлэх, үндэсний уламжлал, үнэт зүйлсийг хамгаалах замаар дотоодын сайн сайхан амьдралыг тэтгэн өргөжүүлэх явдал;
- Гуравдугаарт, дэлхийн хэмжээнд өрнөж буй өөрчлөлт хувьсал болон дотоодын аюул заналд хариу арга хэмжээ авах чадамж бүхий, бүс нутагтаа хүчирхэг нэгдлийг байгуулах явдал.

Зөвлөлийн улсууд нь 1981 онд анх уг нэгдлийг нэн даруй байгуулах болсон цаг үеийн хэрэгцээ шаардлага түүнээс хойшхи хугацаанд, одоо ч арилаагүй болох нь Саддам Хуссейн 1990-1991 онд Кувейтийг эзэлсэн зэрэг үйл явдлаар нотлогдсон буюу нөхцөл байдал зөвхөн хэлбэр, хэв маягийн хувьд хувьсан өөрчлөгдсөн боловч нэгдлийг байгуулах суурь шалтгаан өөрчлөгдөөгүй хэмээн үздэг. Дээрх агуулгаар энэхүү байгууллын мөн чанарыг тайлбарлан авч үзвэл, Зөвлөл нь үүсгэн байгуулагч гишүүн улс орнуудын нийтлэг болон өвөрмөц ашиг сонирхлыг хангах, олон улс, бүс нутгийн сорилтуудыг даван туулах зорилготой цэрэг-батлан хамгаалах, улс төр, эдийн засгийн эвсэл, нэгдлийн шинж чанартай зохион байгуулалт мөн.

III. Зөвлөлийн бодлого, үйл ажиллагаа, бүс нутаг дахь байр суурь

¹² Riccardo Dugulin. *A Neighborhood Policy for the Gulf Cooperation Council*. (Gulf Research Center, 2010) https://www.files.ethz.ch/isn/125707/A_neighbourhood_policy_2633.pdf

¹³ Gulf Cooperation Council, <http://www.globalsecurity.org/military/world/gulf/gcc.htm>

¹⁴ Riccardo Dugulin. *A Neighborhood Policy for the Gulf Cooperation Council*. (Gulf Research Center, 2010). 9-10



Зөвлөлийн гишүүн орнуудын газар зүйн байршил, геостратегиар дамжуулан бүс нутгийн онцлог, хөрш орнуудын хүчин зүйл, худалдаа эрхлэх харьцангуй давуу тал, Их Британи зэрэг томоохон гүрнүүдийн ашиг сонирхлын холбоос, нөлөөллийг танин мэдэх боломжтой. Ойрхи дорнодын бус нутаг нь дэлхийн нефтийн зах зээлд чухал суурийг эзэлж ирсэн бөгөөд бүх дэлхийн нефтийн нөөцийн 60 хувьтай тэнцэх нөөцтэй гэгддэг.

Саудын Араб, Бахрейн улсууд нь дэлхийн II дайны өмнө нефть үйлдвэрлэж эхэлсэн бол, Кувейт, Катар зэрэг улсад 1960-аад он гэхэд нефтийн асах их нөөц шинээр нээгдэж, 1966 он гэхэд Кувейт жилд 114 сая тонн нефть үйлдвэрлэх хүчин чадалтай болсон. 2021 оны тоон мэдээгээр Зөвлөлийн гишүүн улс орнууд өдөрт 17.8 сая баррель (159 литр) нефть үйлдвэрлэдэг¹⁵, ОПЕК-ийн нөөцийн тэн хагасыг эзэмшдэг¹⁶ болсон. Улмаар Зөвлөлийн улсууд нь дангаараа дэлхийн газрын тосны батлагдсан нөөцийн 30 шахам хувийг бүрдүүлж, Перс/Арабын булангийн улсууд нь дангаараа 50 шахам хувийг тус тус эзэлдэг болжээ. Энэ нь Зөвлөл болон тус бүс нутгийн орнууд дэлхийн эдийн засгийн нийлүүлэлтийн гинжин хэлхээнд онцгой байр суурийг эзэлж буй болохыг нотлох үзүүлэлт бөгөөд Зөвлөлийн улсууд нь бүс нутагтаа онц чухал байр суурийг олсон суурь шалтгааны нэг нь энэхүү байгалийн баялаг мөн.

Дэлхийн газрын тосны батлагдсан нөөцийн хувь хэмжээ, 2016 оны байдлаар ¹⁷			
Үйлдвэрлэгч улс	Батлагдсан нөөцөд эзлэх хувь (%)	Үйлдвэрлэгч улс	Батлагдсан нөөцөд эзлэх хувь (%)
Саудын Араб	15.7	Ирак	8.4
АНЭУ	5.8	Иран	9.3
Оман	0.3	Орос	6.0
Кувейт	6.0	Канад	10.1
Катар	1.5	Венесуэл	17.7
Зөвлөлийн улсууд	29.3	Булангийн улсууд	47.0

1981 оны 11 дүгээр сард Зөвлөлийн гишүүн улсууд Нэгдмэл эдийн засгийн хэлэлцээрийг баталж, үүгээрээ илүү ойр нягт эдийн засаг, худалдааны харилцааг бий болгох, мөнгөн хөрөнгийн харилцан шилжүүлэг чөлөөтэй хийгдэх, шинжлэх ухаан, технологи, тээвэр, харилцаа холбоо, санхүүгийн түншлэлийн салбарт үйл ажиллагаа хамтран явуулах, уялдуулан зохицуулах зорилгыг дэвшүүлсэн. Уг хэлэлцээрийг 2001 онд өргөжүүлж, Зөвлөлийн гишүүн улсын иргэд иргэншил үл хамааран эрх тэгш, эн

¹⁵ Зөвлөлийн статистик, тоон мэдээний төв. https://gccstat.org/en/statistic/economic/oil_production_uae

¹⁶ Linda Low, Lorriane Carlos Salazar. *The Gulf Cooperation Council: A Rising Power and Lessons for ASEAN*. (Institute of Southeast Asian Studies, 2011).

¹⁷ BP Statistical Review of World Energy, 2016.

тэнцүү байх баталгааг бүрдүүлснээрээ Зөвлөлийн “эдийн засгийн иргэншил”¹⁸-ийг бий болгосонд тооцогддог.

2001 оны Эдийн засгийн өргөтгөсөн хэлэлцээрээр Зөвлөлийн гишүүд гаалийн нэг бүсийг байгуулах, гишүүн улсуудын иргэн, хуулийн этгээдүүд аливаа ялгаварлалгүйгээр, ижил тэнцүү эрхтэй оролцох дундын зах зээлийн бүсийг тогтоох, тодорхой шат дараалласан ажиллагааны дагуу дундын мөнгөн тэмдэгтийг эргэлтэд оруулах, эдийн засгийг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих, газрын тос, байгалийн хий, байгалийн бусад баялгийг ашиглах таатай орчныг бүрдүүлэх, хамтарсан төсөл хөтөлбөрүүд хэрэгжүүлэх, нийгмийн эв нэгдлийг хангах, Араб, Исламын өвөрмөц төрхийг бататгах, энэ үйлсэд хүчин зүтгэх ажиллах хүчин, боловсрон хүчнийг бэлтгэн сургах хүний нөөцийг бэхжүүлэх, оюуны өмчийг хамгаалах, шинжлэх ухаан-технологийн мэдээллийн санг баяжуулах чиглэлд хамтран ажиллах, тээвэр, харилцаа холбоо, дэд бүтцийг хөгжүүлэх, цахим худалдаа эрхлэх эрх зүйн орчныг ижилсүүлэх, газар, ус, агаарын тээврийн дэд бүтцүүдийг холбон нэгтгэх талаар тохирсон.

Энэхүү суурь тохиролцооны дагуу Зөвлөлийн хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагааг тоймлон авч үзэхэд:

<p><i>Зөвлөлийн гаалийн нэгдмэл бүс:</i> 2003 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс албан ёсоор хэрэгжүүлж эхэлсэн. Зөвлөлийн бус орноос импортлон оруулах бараанд нэгэн ижил тариф мөрдүүлэх; Гаалийн тухай хууль тогтоомж нь нэгэн ижил зохицуулалттай байх; Гаалийн татвар хураах нэг цэгийн үйлчилгээ; Зөвлөлийн гишүүн орнуудын нутаг дэвсгэр дотор барааны шилжилт хөдөлгөөн явагдахад ямар нэгэн тариф тогтоохгүй, тарифын бус бүхий л хязгаарлалтуудыг халах; Зөвлөлийн гишүүн оронд үйлдвэрлэгдсэн аливаа бараанд үндэсний харьцааны зарчмаар хандах¹⁹.</p>	<p><i>Зөвлөлийн дундын зах зээлийн бүс:</i> 2008 оны 1 дүгээр сараас албан ёсоор хэрэгжүүлж эхэлсэн. Нэг зах зээлийн бүс байгуулж, үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлж, нөөцийн зохистой хэрэглээг бий болгох; Олон улсын эдийн засгийн талбаруудад Зөвлөлийн хэлэлцэн тохирох чадавхи суурийг сайжруулах; Зөвлөлийн гишүүн улсын иргэд тэгш боломжийг олгох, хөдөлмөр эрхлэх, хөрөнгө оруулах, үл хөдлөх эд хөрөнгө худалдан авах, боловсрол эзэмших, эрүүл мэндийн үйлчилгээ авахад тэгш эрхтэй байх нөхцлийг хангах; Худалдааны эргэлтийг өсгөх.</p>
<p><i>Зөвлөлийн мөнгөн тэмдэгтийн нэгдмэл бүс:</i> 1981 онд анх Зөвлөл байгуулагдахдаа мөнгө, банк, санхүүгийн бодлогыг</p>	<p><i>Хойгийг хамгаалах зэвсэгт хүчин:</i> Зөвлөлийн гишүүн улсууд батлан хамгаалах, аюулгүй байдлын чиглэлд хүчин чармайлтаа уялдуулан нэгтгэх</p>

¹⁸ Зөвлөлийн гишүүд хооронд 2001 онд байгуулагдсан Эдийн засгийн хэлэлцээрийн 3 дугаар зүйлд тусгагдсанаар.

¹⁹ Linda Low, Lorriane Carlos Salazar. *The Gulf Cooperation Council: A Rising Power and Lessons for ASEAN*. (Institute of Southeast Asian Studies, 2011).

<p>уялдуулах зорилго тавьснаас хойш 1985-1987 онуудад ОУВС-гийн SDR-ийг удирдлага болгосон дундын мөнгөн тэмдэгтийг нэвтрүүлэх хувилбарыг судлан үзэж тодорхой үр дүнд хүрээгүй бөгөөд 2000 онд америк долларыг валют арилжааны ханш чиглүүлэгч болгох шийдвэрийг гаргасан боловч мөн л гишүүн улсуудын эдийн засаг, төсөв, санхүүгийн гүйцэтгэл, үзүүлэлтийн ялгаатай байдлаас болж нэг мөнгөн тэмдэгтийг нэвтрүүлэх ажил бүрэн гүйцэд хэрэгжээгүй байна.</p>	<p>зорилгын хүрээнд 1984 онд Хойгийг хамгаалах зэвсэгч хүчнийг байгуулсан²⁰ бөгөөд энэхүү зэвсэгч хүчнийг байгуулсан явдлыг “Зөвлөлийн үйл ажиллагааны явцад бий болгож чадсан хамгийн чухал ач холбогдолтой ололтуудын нэг, бахдал төрөх шалтгаан”²¹ хэмээн Зөвлөлийн Ерөнхий нарийн бичгийн дарга ноён Жассем Мохамед Албудаиви цохон тэмдэглэсэн. Уг зэвсэгт хүчнийг Зөвлөлийн гишүүд бие даасан байдлаар байгуулах санал санаачилга гаргах болсныг “АНУ-тай цэргийн эвсэл байгуулах тохиолдолд Иран, Ирак зэрэг улсууд Зөвлөлийг Барууны хүчнийхэнтэй хэт ойр холбоотой гэж үзэж магадгүй”²² гэсэн болгоомжлолоос эх үндэстэй хэмэн үздэг бөгөөд Зөвлөлийн Цэргийн дээд хороо нь аюулгүй байдлыг хангах хөтөлбөрийг боловсруулж, гишүүн улс хооронд тагнуулын мэдээ солилцох гэрээг 2004 онд байгуулжээ²³.</p>
--	--

IV. Дүгнэлт

Персийн буюу Арабын булангийн орнуудын хамтын ажиллагааны зөвлөлийн гишүүн орнууд болох АНЭУ, Бахрейны Хаант Улс, Кувейт Улс, Катар Улс, Оманы Султант Улс, Саудын Арабын Хаант Улсуудын нэгдмэл ашиг сонирхол нь тухайн орнуудын оршин тогтнох, аюулгүй байдлаа хамгаалах бодлого, алсын хараатай холбоотой байхаас гадна, Зөвлөлийн үйл ажиллагаа нь эдгээр улсуудын байгалийн баялагт түшиглэсэн ашиглагч хэв маягийн эдийн засгийн бүтэцтэй, дэлхийн газрын тосны зах зээл, нефтийн бүтээгдэхүүний нийлүүлэлтийн гинжин хэлхээнд томоохон байр суурь бүхий, хэл, соёл, шашин шүтлэг, уламжлал, засаглалын хэв маягаараа ойр төстэй шинж чанартай, ард түмнийхээ энх тунх амьдрал ахуй, аж ахуй эрхлэх орчин нөхцлийг тогтвортой тэтгэн хамгаалах гэсэн үнэт зүйлстэй салшгүй холбогдоно. Өөрөөр хэлбэл, Ойрхи дорнодын бүс нутагт, хажуу зэргэлдээ хөрш орнуудад өрнөсөн дайн мөргөлдөөн, эзлэн түрэмгийлэл, энэ лугаа бусад гадаад, дотоодын аюул заналхийллийг

²⁰ Булангийн орнуудын хамтын ажиллагааны зөвлөл – олон улсын байгууллагын тухай. <https://www.britannica.com/topic/Gulf-Cooperation-Council>

²¹ Зөвлөлийн Ерөнхий нарийн бичгийн даргын албан ёсны цахим хуудас. <https://www.gcc-sg.org/arsa/MediaCenter/NewsCooperation/News/Pages/news2023-5-8-5.aspx>

²² Robert Mason. *The Omani Pursuit of a Large Peninsula Shield Force*. 360

²³ Daniel Kurtzer, Maira Seeley. *The Middle East's Evolving Security Landscape: Prospects for Regional Cooperation and US Engagement*. (Istituto Affari Internazionali (IAI) (2020)).

сөрөн зогсох улс төр, эдийн засаг, цэргийн эвслийн чиг үүргийг Зөвлөл гүйцэтгэж байна гэж дүгнэж болохоор байна.

Ном зүй

- Ж. Баяр. Ойрхи дорнотын асуудал. УБ. 1973. х. 6-9
- Ж. Нарантуяа. Ойрхи дорнодын асуудал. УБ. 1989.
- С. Оюунсүрэн. Монгол ба Ойрхи дорнодын улсуудын харилцаа: эрт, эдүгээ. УБ хот. 2009.
- Rouhollah K. Ramazani, *The Gulf Cooperation Council: Record and Analysis* (University of Virginia Press, 1988).
- Linda Low, Lorriane Carlos Salazar. *The Gulf Cooperation Council: A Rising Power and Lessons for ASEAN*. (Institute of Southeast Asian Studies, 2011).
- Robert Mason. *The Omani Pursuit of a Large Peninsula Shield Force*. 360
- Daniel Kurtzer, Maira Seeley. *The Middle East's Evolving Security Landscape: Prospects for Regional Cooperation and Riccardo Dugulin. A Neighborhood Policy for the Gulf Cooperation Council*. (Gulf Research Center, 2010)
https://www.files.ethz.ch/isn/125707/A_neighbourhood_policy_2633.pdf
- *US Engagement*. (Istituto Affari Internazionali (IAI) (2020)).
- Дэлхийн банк: Булангийн орнуудын хамтын ажиллагааны зөвлөлийн гишүүдийн эдийн засгийн үзүүлэлт. <https://data.worldbank.org/indicator>
- Зөвлөлийн гишүүн орнуудын хүн амын тоо 2024 оны байдлаар. <https://worldpopulationreview.com/country-rankings/gcc-countries>
- World Data сан: Араб хэлээр ярьдаг улс орнууд. <https://www.worlddata.info/languages/arabic.php>
- Арабын улсуудын холбооны дүрмийн 1 дүгээр зүйл. <https://www.refworld.org/legal/constinstr/las/1945/en/13854>
- АНУ-ын Гадаад нэвтрүүлгийн мэдээний алба. FBIS-MEA, V-81-107, June 4, 1981, A10-A13.
- Gulf Cooperation Council, <http://www.globalsecurity.org/military/world/gulf/gcc.htm>
- Зөвлөлийн статистик, тоон мэдээний төв. https://gccstat.org/en/statistic/economic/oil_production_uae
- BP Statistical Review of World Energy, 2016.
- Зөвлөлийн гишүүд хооронд 2001 онд байгуулагдсан Эдийн засгийн хэлэлцээрийн 3 дугаар зүйлд тусгагдсанаар.
- Булангийн орнуудын хамтын ажиллагааны зөвлөл – олон улсын байгууллагын тухай. <https://www.britannica.com/topic/Gulf-Cooperation-Council>
- Зөвлөлийн Ерөнхий нарийн бичгийн даргын албан ёсны цахим хуудас. <https://www.gcc-sg.org/ar-sa/MediaCenter/NewsCooperation/News/Pages/news2023-5-8-5.aspx>

SPSIRPA FORUM 2024

Poster presentation 7

Certain ways to enhancing government productivity (on the example of performance audit)



ТӨРИЙН БҮТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХАД ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ

(Гүйцэтгэлийн аудитын жишээн дээр)

Б.Чимэдлхам¹, МУИС-УТСОУХНУС-ын төрийн удирдлагын докторант

Хураангуй: Дэлхийн эдийн засгийн форум 2006 оноос эхлэн улс орнуудын өрсөлдөх чадварыг “тухайн улсын институтууд, бодлого болон бусад хүчин зүйлүүдийн нэгдэл, тэдгээрийн үр дүнд бий болсон улс орны бүтээмжийн түвшнээр тодорхойлдог” болсноор төрийн бүтээмжийг өргөн хүрээнд судалж, улс орнууд бүтээмжээ хэмжиж, үнэлж, сайжруулах арга хэмжээг авч байна.

Төрийн бүтээмжийг хэмжих, үнэлэх нь нэлээд ярвигтай хүнд асуудал боловч Засгийн газрын байгууллагуудын бүтээмжийг үнэлэхийн тулд төрийн ажил үйлчилгээ, хөрөнгө санхүү, эдгээрийг зохицуулж буй эрх зүйн орчин, хэрэгжүүлж буй бодлого хөтөлбөрийг шинжлэн судлах, хяналт шалгалт, аудит хийх замаар гүйцэтгэл, үр нөлөөг тодорхойлсноор цаашид боловсронгуй болгох нөхцөл бүрдэнэ гэж үздэг.

Төрийн бүтээмжийн талаарх онолуудаас “Төрийн бүтээмжийн хэмжүүрт үр дүн, гүйцэтгэлийг чухалчлахаас илүүтэй Засгийн газрын хийж буй өөрчлөлтийн үр нөлөөнд төвлөрөх ёстой” гэсэн судлаач Путнамын үзэл баримтлалын дагуу төрийн бүтээмжийг сайжруулахад Төрийн аудитын байгууллагын хяналтын гүйцэтгэл, үр нөлөөг төрийн бүтээмжтэй уялдуулан судлахыг зорьсон.

Судалгаагаар төрийн бүтээмж, бүтээмжийн удирдлагыг сайжруулахад Төрийн аудитын байгууллагын гүйцэтгэж буй аудитын зорилт, дүгнэлт, аудитын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээг тоон үзүүлэлтээс илүү чанарын болон тогтолцооны шинжтэй асуудлуудад түлхүү чиглүүлэх шаардлага байгааг анхаарах нь зүйтэй.

Түлхүүр үг: Төрийн бүтээмж, гүйцэтгэлийн аудит, үр нөлөө, өөрчлөлт

1. Удиртгал

Бүтээмж нь хувь хүн, хамт олонд өсөлт хөгжил, хөрөнгө оруулагчид ашиг, хэрэглэгчдэд чанартай бүтээгдэхүүн, нийгэмд амьдралын чанарыг дээшлүүлэх, улс оронд зөв бодлого, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх чухал хүчин зүйл бөгөөд өргөн утгаар нь харвал нийгэм, эдийн засгийн хөгжлийн аливаа зорилтот үйл ажиллагааны үр дүн буюу тодорхой “гарц-орц”-ын харьцаагаар тодорхойлогддог.

Төрийн бүтээмжийг сайжруулах нь олон нийтийн хэрэгцээ шаардлага, хүсэл сонирхолыг хязгаарлагдмал нөөцтэй уялдуулан төрийн зүгээс зохицуулалт хийх, нийгэм, эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэхэд чиглэгдэх бөгөөд төрийн буюу Засгийн газрын үйл ажиллагааны үр нөлөө, өөрчлөлт нь иргэдийн амьдралд эерэг нөлөө үзүүлж чадаж байгаа эсэхийг, мөн улс орны

¹ И-мэйл хаяг: namskar264@gmail.com

өрсөлдөх чадварыг хэмжих үзүүлэлт болж байна.

“Бүтээлч нийгэм нь бүтээлч Засгийн газраас хамаарна” буюу төрийн бүтээмжид төрийн үйлчилгээний болон төрийн захиргааны бүтээмжийг хамтад нь хамруулж, түүнийг сайжруулах стратегийг улс орнууд боловсруулж, хэрэгжүүлэхдээ “төсвийг хэмнэх”, “төрийн албан хаагчдын тоог бууруулах”, “хувьчлал явуулах”, “хэмнэлт гаргах”, “ухаалаг ажиллах”, “хувийн салбарын менежментийг ашиглах” зэрэг нийтлэг арга хэрэгслүүдийг ашиглаж (С.Энхсайхан, Төрийн бүтээмжийн удирдлага, 2010, хууд. 61) үр дүн нь туршигдаж, төрийн бүтээмж, гүйцэтгэлийг сайжруулах үйл явц одоо ч үргэлжилж байна.

Онол, үзэл баримтлалын хувьд төрийн бүтээмжийг агентлагийн түвшин буюу орц-гарцын харьцааг голчилдог байсан бол орчин үед орц-гарцын үр ашгийн үзүүлэлтээс агентлагын үр нөлөө буюу тухайн үйл ажиллагаанаас гарч буй өөрчлөлт, түүний чанар хүртээмжид илүү төвлөрөх ёстой гэсэн хандлага давамгайлж (С.Энхсайхан, Төрийн бүтээмжийн судалгаа, 2018 II №03) байна.

Судлагдсан байдлын хувьд “Монгол улсад орчин үеийн төрийн бүтээмжийг хэмжих, үнэлэх, сайжруулах чиглэлээр төрийн бүтээмжийн удирдлагын арга зүй шинэ тутам байгаа нь уг асуудлыг шинжлэх ухааны үндэстэй судлах хэрэгцээ шаардлагатай” байгааг доктор С.Энхсайхан цохон тэмдэглэсэн бөгөөд судлаач 2010 онд “Төрийн бүтээмжийн удирдлага” ном, мөн онд “Төрийн захиргааны салбарт бүтээмжийн удирдлагыг боловсронгуй болгох нь” сэдвээр Удирдахуйн ухааны докторын зэрэг, 2018 онд “Төрийн бүтээмжийн судалгаа” эрдэм шинжилгээний өгүүллэгийг тус тус туурвисан

байна. Эдгээр бүтээлүүдэд төрийн бүтээмжийг онол арга зүй, төрийн захиргааны салбар дахь бүтээмжийн удирдлагын тогтолцоо, түүнийг сайжруулах чиглэлээр судалгаа, шинжилгээ хийсэн байна.

Түүнчлэн бүтээмж гэсэн ерөнхий сэдвийн хүрээнд эдийн засгийн бүтээмж, хөдөлмөрийн бүтээмж, төрийн захиргааны байгууллага дахь гүйцэтгэлийн бүтээмж, төрийн байгууллагын бүтээмж-чанарын удирдлага, төрийн бүтээмж ба үнэлгээ, мониторинг, төрийн албаны шинэтгэл ба бүтээмж зэрэг чиглэлүүдээр судалгаа, сургалтыг судлаачид болон төрийн байгууллагын түвшинд зохион байгуулж ирсэн байна.

Тухайлбал, 2002 онд төрийн захиргааны байгууллагын бүтээмж, сэдэвт эрдэм шинжилгээний бага хурал зохиогдож “Үндэсний бүтээмжийн стратеги, бүх нийтийн бүтээмжийн ухамсар суулгах хөдөлгөөн”-ийг өрнүүлж байсан. (С.Энхсайхан, Төрийн бүтээмжийн удирдлага, 2010, хууд. 69).

Мөн бодлого төлөвлөлт, хэрэгжүүлэлтийн хүрээнд Монгол улсын хөгжлийн урт хугацааны бодлогын баримт бичиг болох “Алсын хараа-2050”, “Шинэ сэргэлт”-ийн бодлогын хүрээнд төрийн бүтээмж, төрийн бүтээмжийн сэргэлтийг эрчимжүүлэх, төрийн чадамжийг бүрдүүлэх чиглэлээр удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээг Засгийн газраас хэрэгжүүлж 2022 онд Төрийн бүтээмжийн Үндэсний хороог байгуулсан.

Үндэсний хороо нь иргэндээ үйлчилдэг, мэргэшсэн, чадварлаг, ил тод төрийн албыг төлөвшүүлэх, цахим технологид суурилах, төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн үр ашиг, засаглалыг сайжруулж, олон нийтийн шууд хяналтад

оруулах, Засгийн газрын бүтэц, зохион байгуулалтад цогц шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгч, оновчтой бүтцийг тогтоон, төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшилд шилжүүлэх зорилт тавин ажиллаж байна.

Төрийн бүтээмжийг хэмжих, үнэлэх, сайжруулах, удирдах нь “хялбар биш ажил” бөгөөд төрийн ажил үйлчилгээ, хөрөнгө санхүү, эдгээрийг зохицуулж буй эрх зүйн орчин, хэрэгжүүлж буй бодлого хөтөлбөрийг шинжлэн судлах, хяналт шалгалт, аудит хийх замаар гүйцэтгэл, үр нөлөөг тодорхойлноор цаашид боловсронгуй болгох нөхцөл бүрдэнэ гэж үздэг.

Энэхүү судалгаагаар төрийн бүтээмжийг сайжруулахад Төрийн аудитын байгууллагын хяналтын чиг үүргийн хэрэгжилт ямар түвшинд байгааг судлаж, цаашид сайжруулах чиглэлээр санал зөвлөмж дэвшүүлнэ.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит, гүйцэтгэлийн болон нийцлийн аудитын төрөл, хэлбэрээр хяналтын чиг үүргээ хэрэгжүүлж байгаагаас судалгааны зорилготой нийцүүлэн “...Засгийн газрын үйл ажиллагаа, хэрэгжүүлж буй хөтөлбөр, арга хэмжээ, зохион байгуулалт арвилан хэмнэлттэй, үр ашигтай, үр нөлөөтэй байх зарчмын дагуу хийгдэж байгаа эсэх болон тэдгээрийг сайжруулах боломжтой эсэхийг тогтоох хараат бус, бодит, үнэн зөв шалгалт” болох гүйцэтгэлийн аудитын төрлөөр, сүүлийн 3 жилийн хугацаанд боловсрол, эрүүл мэндийн чиглэлээр хийгдсэн аудитын үр нөлөөг судалснаараа онцлогтой. Аудитын үр нөлөөг товчоор илэрхийлбэл тухайн аудитаар тавьсан зорилго, зорилт хангагдахыг хэлнэ.

2.Төрийн бүтээмжийн онол, төрийн бүтээмжийн удирдлага, судлах арга зүй

Хөгжиж буй орнуудын хувьд бүтээмж нь эдийн засгийн хөгжилд түлхэц болдог бол өндөр хөгжилтэй орнуудын хувьд тогтвортой эдийн засгийн өсөлтийг бий болгох үндэс бөгөөд бүтээмж, үр ашгийг нэмэгдүүлэх нь улс орнуудын хөгжлийн өмнөө тавьдаг чухал зорилтуудын нэг болсон. (С.Билгүүнзул, 2020)

1970-аад оноос АНУ-д “Бүтээмжийн үндэсний хороо” байгуулагдаж бүтээмжид ач холбогдол өгч төрийн ба хувийн хэвшлийн эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлж, бүтээмжийн өсөлтийг хангахад нийгмийн, эдийн засгийн, шинжлэх ухааны, бизнесийн, хөдөлмөрийн, засгийн газрын оруулж буй хувь нэмрийг тодорхойлох, хөгжүүлэх, дэмжих хэрэгцээ шаардлагын зорилго нь “эдийн засаг, байгаль орчин, удирдлага, ажиллагсад ба хэрэглэгчдийн эрх ашигт нийцсэн бүтээмжийн өсөлтийг дэмжих бодлого”-ыг бий болгох байв. Гэвч үүнийг хэрхэн бий болгох арга зам болон онол, үзэл баримтлалын хандлага, улс төрийн дэмжлэг тодорхойгүй байсан.

Төрийн захиргааны шинжлэх ухааны үзэл баримтлалын хөгжилд сонгодог эдийн засагч Кейнс эдийн засагт төрийн оролцоо зайлшгүй шаардлагатайг, судлаач Вагнер төрийн бүх үүрэг эдийн засагтай холбоотой гэж үзэн төсөв мөнгөний бодлогоор дамжуулан капитал баялагыг хуримтлуулж болохыг тус тус заасны дотор “*төрийн бүтээгдэхүүн*” гэдэг ойлголтыг шинээр томъёолсон нь төрийн бүтээмжийн удирдлагын тухай гаргасан анхдагч санаа байсан бөгөөд үргэлжлүүлэн Марк Холзер, Герг Вукерт нар төрийн бүтээмжийн онолын арга зүйн хөгжилд, Хатри, Фиск нар төрийн

бүтээмжийн үнэлгээнд, Мари Грейнберг, Гай нар бүтээмжийг сайжруулахад судалгаагаа түлхүү чиглүүлсэн байна. (С.Энхсайхан, Төрийн бүтээмжийн удирдлага, 2010, хууд. 11)

1990-ээд оноос төрийн удирдлагын шинэ үзэл баримтлал гарч ирсэнээр төрийн ажил үйлчилгээг хэрхэн үр ашигтай удирдах, мэдээлэл, технологийн өндөр хурдцыг төрийн үйл ажиллагаатай хэрхэн уялдуулах чиглэлээр онол үзэл баримтлалыг боловсруулсаны нэг нь “Хамгийн цомхон төр”-ийн онолын практик жишээ болох Д.Рейганын үзэл баримтлал бөгөөд “Засгийн газрын үндсэн үүрэг нь төсвийг багасгах, эрх мэдлийг төвлөрүүлэх, цомхон бөгөөд мэдрэмж сайтай улс төрийн тогтолцоог бүрдүүлэх арга замаар хамгийн өндөр бүтээмжтэй, хамгийн цомхон төрийг бий болгох явдал” гэж үзсэн бол, судлаач Жэмис Кювилсон “Засгийн газар нь хязгаарлагдмал эд баялагын хүрээнд өндөр бүтээмжтэй ажиллах арга барилыг олж ашиглан шаардлагатай өөрчлөлтийг хийхийг гол зорилгоо болгох, ингэхдээ олон нийтэд хүргэх үйлчилгээг төр өөрөө хариуцах шаардлагагүй төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлж болохыг санал болгосон.

Мөн байгууллагын бүтээмжийн онолын судлаачид “Төрийн үндсэн чиг үүрэг нь нийгмийн сайн сайхан байдлыг хангах явдал учраас тэр нь бүтээмжийг дээшлүүлэх гол эх сурвалж” гэж үзэн бүтээмжийн сайжруулалтад нөлөөлөх хүчин зүйлсэд үндэстний оршин тогтнох эх сурвалж бүхий нийгмийн үзүүлэлтийг голлон авч үзсэн байдаг. Үүгээр бүтээмжийн үүрэг ролийг төрийн цогц бодлогын түвшинд авч үзэх шаардлагатай гэсэн санааг илэрхийлсэн.

2006 онд Дэлхийн эдийн засгийн форумаас гаргасан “өрсөлдөх чадвар”-ын тодорхойлолт нь валютын ханшийн өрсөлдөх чадварын тодорхойлолтоос халин өрсөлдөх чадварыг “бүтээмж”-тэй холбон үзснээр (форум, 2006) бүс нутаг болон дэлхийн хэмжээнд төрийн бүтээмжийн байгууллагууд бий болж, Дэлхийн эдийн засгийн форум, Азийн хөгжлийн банк, Дэлхийн банк, OECD² зэрэг байгууллагууд төрийн бүтээмжид өргөн цар хүрээний ач холбогдол өгсөөр байна.

Орчин үеийн төрийн бүтээмжийн судалгааны хандлага нь “төрийн бүтээмж нь улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилд хувийн салбарын бүтээмжээс дутахгүй чухал үүрэгтэй” гэдгийг эрдэмтэн Торонхил дараах үндэслэлээр тодорхойлсон. Үүнд:

- 1.Төр өөрөө том хэмжээний ажил олгогч;
- 2.Төр эдийн засагт гол үйлчилгээ үзүүлэгч;
- 3.Татварын орлого буюу эдийн засгийн их хэмжээний нөөцийг ашиглагч (Managerial Perceptions 2010) гэж үзэн төрийн бүтээмжийг тооцох, хэмжих шинэ арга зүйг боловсруулан ашиглах болсон.

2.1.Төрийн бүтээмжийг хэмжих, үнэлэх:

Бүтээмжийн ерөнхий тодорхойлолтоор төрийн бүтээмж нь орц-гарцын үзүүлэлт боловч төр үйлчилгээгээ зах зээлийн зарчмаар явуулдаггүй, олон нийтэд нийтлэг үйлчилгээ үзүүлдэг учир төрийн салбарт бүтээмжийг гарцаар хэмжсэн үнэлгээний хувилбар хэрэгтэй” гэсэн хандлага 2010 оноос дэлгэрч эхэлсэн

² Эдийн засгийн хамтын ажиллагаа ба Хөгжлийн байгууллага

бөгөөд судлаач Поллит болон Букерт нар “хэрэв гарцын үзүүлэлт үнэхээр өөрчлөгдөж байгаа бол энэ нь орцын өөрчлөлттэй тэнцүү биш байж болно” гэж тодорхойлсон байна.

Цаашлаад “төрийн үйлчилгээний эцсийн үр дүн хэдий хэмжээний гарцыг бий болгосон” гэхээс илүүтэй “*нийгэмд ямар өөрчлөлт гаргав гэдгээр хэмжигдэх*” шаардлага хөгжлийн зүй тогтлоос урган гарсан бөгөөд судлаач Путнам “төрийн бүтээмжийн хэмжүүрт үр дүнгийн оронд Засгийн газрын хийж буй өөрчлөлтийн үр нөлөөнд төвлөрөх ёстой” гэж үзсэн. Тухайлбал, өвчтөний эдгэрлээс илүүтэй эрүүл мэнд, амьдралын чанарт гарч буй өөрчлөлт, сургалтад хамрагдсан тооноос илүүтэй боловсролд гарч буй өөрчлөлт гэх мэт буюу Засгийн газар төрийн хөрөнгийн зарцуулалтаар дамжуулан ямар үр өгөөжийг нийгэм, эдийн засаг, олон нийтэд бий болгож буйгаар нь хэмжих нь зүйн хэрэг гэж үзэх болсон.

Төрийн бүтээмжийг хэмжиж, үнэлэх, үнэлгээнд тулгуурлан сайжруулах нь нилээд ярвигтай асуудал бөгөөд Азийн орнуудад төрийн бүтээмжийн судалгаа боловсруулалтын шатандаа байгаа бол Америк, Англи, Герман, Австрали зэрэг орнууд төрийн бүтээмжийн гүйцэтгэлийг хэмжих, үнэлэх арга зүйгээ боловсруулан (i)байгууллагын түвшний бүтээмж, (ii)салбарын болон үндэсний бүтээмж, (iii) олон улсын хэмжээний харьцуулсан бүтээмжийн судалгааг хийж, төрийн удирдлагын арга хэрэгсэл болгон ашиглаж байна. (С.Энхсайхан, Төрийн бүтээмжийн судалгаа, 2018 II №03, хууд. 31)

2.2. Монгол улсын төрийн бүтээмжийн удирдлагын өнөөгийн байдал, эрх зүйн орчин:

Төрийн байгуулалтын тогтолцоог Үндсэн хуульд хуульчилж өгсөнөөр төрийн байгууллагуудын үйл ажиллагааны зорилго чиглэл, бүрэн эрхийг салбарын хуулиудаар зохицуулж, төрийн үйлчилгээг хүртээмжтэй, чанартай хүргэх зорилт, ард түмний хүсэл зориг, хууль ёсны ашиг сонирхолыг хамгаалах, ардчилсан ёс, хүний эрх, эрх чөлөөг хангах нь төрийн эрхэм зорилго болсон.

Төрийн байгууллагуудын нийгэм, эдийн засгийн хүрэн дэхь оролцоог сайжруулах чиглэлээр манай улс бодлого, эрх зүйн орчны хүрээнд дараах тогтолцоог бүрдүүлж, хөгжүүлсэн гэж судлаачид дүгнэсэн (Ц.Самбаллхүндэв, 2002). Тухайлбал:

- 1.Төрийн захиргааны байгууллагын шинэ тогтолцоог бүрдүүлэх (1990-1993 он);
- 2.Төрийн албыг шинээр бүрдүүлэх (1993-1996 он);
- 3.Төрийн захиргааны үйл ажиллагааг дэлхийн нийтийн чиг хандлагад нийцүүлэх (1996-2002 он);
- 4.Төрийн захиргааны байгууллагын цомхон чадварлаг, үр дүн, үр ашиг, бүтээмж, үр нөлөөг дээшлүүлэхэд чиглэсэн үе (2002 оноос одоог хүртэл).

Дээрх үечлэлд тулгуурлан төрийн бүтээмжийн удирдлагыг зохицуулж байсан голлох хууль тогтоомжийн онцлогыг товч дурдвал:

1. *Төрийн албаны тухай хууль, түүний хэрэгжилт*: 1994 он, 2002, 2017 онуудад тус тус шинэчлэн батлагдсан бөгөөд тухай бүр төрийн алба мэргэшсэн тогтвортой байх, ард түмэнд үйлчлэх, ил тод байх зарчмуудыг баримтлаж ирсэн бөгөөд одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Төрийн албаны тухай хуульд “...төрийн алба төрийн чиг үүргийг

хэрэгжүүлэх гол арга хэрэгсэл мөн бөгөөд...төрийн албаны чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх...” зорилтыг ханган ажиллах нь үйл ажиллагааны гол зорилт байна гэж тусгагдсан байна.

2. *Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль, түүний хэрэгжилт* (2002): Энэ хуулиар төрийн байгууллагын үр ашгийг сайжруулахын тулд төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулж үр дүнг тайлагнах, тогтолцоог бүрдүүлэх, Засгийн газарт төсвийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулж, улсын төсвийн байгууллагаас нийлүүлэх бүтээгдэхүүний чанарын шаардлагыг хангуулах, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүнд төрийн өмч, улсын төсвийн хөрөнгө, эрсдэлийг үр ашигтай удирдах бүрэн эрхийг олгосон. Хууль хэрэгжиж эхэлснээр нөөцийг санхүүжүүлэх зэргээр орцоор төлөвлөх аргаас татгалзаж, гарц буюу үр дүнд чиглэсэн төсвийн аргад шилжиж, жилийн эхэнд үйл ажиллагааны зорилтыг тогтоож, хүрэх үр дүнг тодорхой болгон, санхүүгийн жилд бүтээгдэхүүнийг гэрээний үндсэн дээр нийлүүлж, санхүүжилт авах зарчмуудыг баримтлах болсон нь төрийн захиргааны салбарын болон төсвийн үр ашгийг дээшлүүлэх хууль эрх зүйн орчин бүрдсэн (С.Энхсайхан, Төрийн бүтээмжийн удирдлага, 2010, хууд. 81) гэж судлаачид үздэг. Мөн уг хуулиар төсвийн байгууллагын хөрөнгийн удирдлагыг сайжруулах, зардлыг бууруулах нэг арга нь нэмэлт орлого, зарлагын хэмнэлтээс “урамшуулал олгох” явдал байсан бөгөөд энэ нь төрийн байгууллага зөвхөн хэрэглэгч,

зарцуулагч гэсэн үзэл санаанаас татгалзаж, “баялагийг бүтээгч” байж болох ойлголтыг бий болгосон гэж зарим судлаачид үзсэн. Харин зарим судлаачид нь уг хууль нь Монгол улсын эрх зүйн тогтолцоонд нийцээгүй, гадны туршлагыг шууд хуулбарласан, төсвийн зохицуулалтын хувьд орон нутгийн бие даасан байдлыг хязгаарлаж, төвлөрлийг нэмэгдүүлсэн, мөн санхүүгийн дотоод хяналт, аудит, улсын хөрөнгө оруулалт, хариуцлагын тогтолцоо зэрэг олон чухал харилцааг бүрэн зохицуулаагүй гэж шүүмжилж байсан бөгөөд уг хууль 2013 онд хүчингүй болсон байна.

3. *Төсвийн тухай хууль, түүний хэрэгжилт* (2011): Төсвийн бодлогын зорилго, зохицуулалт нь эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах, ажил эрхлэлтийг дэмжих, үнэ цэнийг нэмэгдүүлэхэд чиглэгдэх бөгөөд “төсөв нь төрийн мөнгөн хөрөнгийн зарцуулалтын төлөвлөгөө”, “төсөв бол төлөвлөгөө төдийгүй хууль” гэж судлаачид үздэг. Монгол улсын төсвийн эрх зүйн орчин өнгөрсөн хугацаанд шинэчлэгдэж эдийн засаг, санхүүгийн гадаад, дотоод орчинд үүссэн өөрчлөлт, төсвийн харилцаанд бий болсон шинэ нөхцөл байдлаас үүдэн тавигдаж байгаа олон асуудлыг түүний дотор төсвөөр дамжуулж макро эдийн засгийн урт, дунд хугацааны тогтвортой байдлыг хангахад энэхүү өөрчлөлтүүд чиглэгдэж ирсэн боловч үр нөлөө хангалтгүй байна гэж судлаачид үзэж байна. Тухайлбал, “...төрийн бүтээмжийг нэмэгдүүлэх, баялагийн сан байгуулах, баялагийн орлогыг иргэдэд бэлэн мөнгөөр тараах, баялагийн орлогыг удирдах цөөнгүй

зохицуулалтыг өнгөрсөн хугацаанд хэрэгжүүлсэн боловч бодит байдал дээр эдгээр арга хэрэгслийн үр нөлөө хангалтгүй байна. (А.Энхбат, 2020, хууд. 302) Иймд баялагийн орлогын төсөв санхүүгийн менежментийг зохицуулж буй хууль тогтоомжуудыг боловсронгуй болгох, хуулийн хэрэгжилтийг хангах үүрэгтэй гол субъектүүд болох парламент, Сангийн яам, Төсвийн тогтвортой байдлын болон Ирээдүйн өв сан, Төрийн аудитын байгууллагын оролцоо чухал шаардлагатай.

4.Төрийн аудитын тухай хууль, түүний хэрэгжилт (2003, 2020)-Улс орны тогтвортой хөгжлийг сайн засаглал, түүнд нийцсэн удирдлага, хяналтгүйгээр төсөөлөх боломжгүй. (Н.Бурмаа, 2018, хууд. 50) Төрийн санхүүгийн хяналт, шалгалтыг хэрэгжүүлж байгаа Төрийн аудитын нийгэмд оруулж байгаа үнэ цэнэ ба өгөөж, улсын хөгжилд оруулах бодит нөлөө, олон улсын чиг хандлагыг харгалзан үзэж, эрх зүйн орчныг боловсронгуй болгох шаардлага зүй ёсоор тавигдаснаар (А.Энхбат, 2020, хууд. 305) 2003 онд батлагдсан Төрийн аудитын тухай хуулийг 2020 онд дахин шинэчлэн баталсан. Төрийн аудитын байгууллагын хуулиар хүлээсэн үүрэг нь төрийн санхүү, төсөв, нийтийн өмчийг хууль ёсны дагуу арвилан хэмнэлттэй, үр ашигтай, үр нөлөөтэйгээр төлөвлөх, хуваарилах, ашиглах, зарцуулахад хяналт тавих, түүнчлэн төрийн санхүүгийн удирдлагыг сайжруулж, эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангахад дэмжлэг үзүүлэхэд оршино (сэтгүүл, 2020). Дээрх чиг үүргийн хүрээнд төрийн бүтээмж, удирдлагын шийдвэр гаргалт, төсвийн төсөвлөлт, ашиглалт, зарцуулалтын үйл

ажиллагаанд хяналт тавихаас гадна зөвлөх үүргийг гүйцэтгэж, ил тод, хариуцлагатай байдлыг хангуулах ёстой. Энэ утгаараа Засгийн газар, төрийн байгууллагын бүтээмжийг хэмжин үнэлэх, боловсронгуй болгох асуудлыг Үндэсний аудитын газар зохих түвшинд хариуцан боловсронгуй болгох асуудал зүй ёсоор тавигдаж ирсэн. (С.Энхсайхан, Төрийн бүтээмжийн удирдлага, 2010, хууд. 83)

Дээрх хууль эрх зүйн орчны хэрэгжилтийн үр дагаварыг нэгтгэн тоймловол Монгол улсад төрийн бүтээмж, бүтээмжийн удирдлагыг төлөвлөх, үнэлэх, гүйцэтгэлийг сайжруулах үйл явц дараах үечлэлээр буюу орц-гарцад суурилсан тогтолцооноос үр дүн, үр нөлөөнд чиглэсэн гүйцэтгэл, бүтээмжид төвлөрч байна гэж үзэж болохоор байна.



Төрийн бүтээмжийн онолуудаас “төрийн бүтээмжийн хэмжүүрт үр дүн, гүйцэтгэлийг чухалчлахаас илүүтэй Засгийн газрын хийж буй өөрчлөлтийн үр нөлөөнд төвлөрөх ёстой” гэсэн судлаач Роберт Путнамын үзэл баримтлалын дагуу төрийн бүтээмжийг хэмжих, үнэлэх, сайжруулахад хяналт чухал үүрэгтэй тул Төрийн аудитын байгууллагын хяналтын гүйцэтгэл, үр нөлөөг дараагийн бүлэгт үргэлжүүлэн судалсан.

3.Төрийн бүтээмж, бүтээмжийн удирдлагад төрийн аудитын гүйцэтгэх үүрэг

Хуулиар олгосон бүрэн эрхийн хүрээнд Засгийн газрын тогтолцоо, үйл ажиллагаа, чиг үүргийн хэрэгжилт, төрийн санхүү, нийтийн өмчийн ашиглалт, төрийн байгууллагуудын үйл ажиллагаа (*санхүүгийн үйл ажиллагаа мөн хамаарна*), төсөл хөтөлбөрийн үр дүн, үр нөлөө, эрх зүйн актын хэрэгжилт, тэдгээрийн нийцэлд хяналт хэрэгжүүлж, төрийн аудит хийж³ төрийн санхүүгийн удирдлагыг сайжруулж, эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангахад дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий субъект нь Төрийн аудитын байгууллага юм.

Төрийн аудитын байгууллагаас дээр дурдсан чиглэлүүдэд хяналтыг хэрэгжүүлэхдээ санхүүгийн тайлангийн аудит⁴, гүйцэтгэлийн⁵ болон нийцлийн⁶ аудитын төрөл, хэлбэрээр гүйцэтгэж, татвар төлөгчдөөс хуулийн дагуу бүрдүүлсэн төсвийн хөрөнгийг хэрхэн бүтээмжтэй зарцуулсныг олон нийтэд нээлттэй тайлагнах (С.Энхсайхан, Төрийн бүтээмжийн удирдлага, 2010, хууд. 140), алдаа зөрчилд хариуцлага тооцох, сайжруулах чиглэлээр дүгнэлт зөвлөмж гаргах, биелэлтийг хангуулах нь төрийн

бүтээмж дэх төрийн аудитын үүрэг гэж судлаачид үзэж байна.

Гүйцэтгэлийн аудитаар нөөцийн зардлыг хамгийн бага байлгах буюу арвилан хэмнэлт хийгдсэн эсэх, боломжит нөөцөөс хамгийн их үр ашгийг гаргасан эсэх, аудитад хамрагдаж буй төрийн байгууллага, түүний үйл ажиллагаа (*тогтолцоо, бодлого, хөтөлбөр гэх мэт*) тавьсан зорилго, зорилтдоо хүрсэн эсэх буюу үр нөлөө гарсан эсэхийг шалгаж тогтоодог (С.Энхбаатар, 2019, хууд. 55) тул төрийн бүтээмжийг хэмжих, үнэлэх гүйцэтгэлийн хэмжүүрийн үзүүлэлтээс⁷ боловсрол, эрүүл мэндийн салбарыг сонгон авч, сүүлийн 3 жилийн хугацаанд гүйцэтгэлийн аудит хийгдсэн боловсрол, эрүүл мэндийн салбарын тодорхой хэсгүүдэд аудитын үр нөлөө, өөрчлөлт гарсан эсэхийг шалгуур үзүүлэлт болгон ашигласан.

Хамрах хугацааны хувьд тухайн онд гүйцэтгэсэн аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн дүнд шалгагдагч байгууллага⁸ өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хөрөнгө нөөцөө хэмнэсэн, үр ашгаа дээшлүүлсэн, бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйл ажиллагааны чанарыг сайжруулсан бол аудитаас үр өгөөж бий болсон (журам",

³ Төрийн аудитын тухай хууль (2020) Төрийн мэдээлэл сэтгүүл №20

⁴Төрийн аудитын тухай хуулийн 4.1.8."санхүүгийн тайлангийн аудит" гэж шалгагдагч этгээд санхүүгийн тайлангаа холбогдох хууль тогтоомж, стандарт, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн актын шаардлагад нийцүүлэн үнэн зөв, шударгаар тайлагнасан эсэхэд аудит хийж баталгаажуулахыг;

⁵Мөн хуулийн 4.1.9."гүйцэтгэлийн аудит" гэж шалгагдагч этгээдийн бодлого, тогтолцоо, үйл ажиллагаа, чиг үүргийн хэрэгжилт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний үйл явц, үр дүн, гүйцэтгэлд аудит хийхийг;

⁶Мөн хуулийн 4.1.10."нийцлийн аудит" гэж шалгагдагч этгээдийн үйл ажиллагаанд мөрдөж

байгаа төрийн санхүү, төсөв, нийтийн өмчтэй холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн актын хэрэгжилт, тэдгээрийн нийцэлд аудит хийх;

⁷Төрийн салбарын гүйцэтгэлийн хэмжүүр үзүүлэлт: төрийн захиргаа, боловсрол, эрүүл мэнд, дэд бүтэц, эдийн засгийн үзүүлэлт, тогтвортой байдал, өрх гэрийн хэрэглээ гэсэн 7 бүлэг үзүүлэлт хамаарна.

⁸ Мөн хуулийн 4.1.4."шалгагдагч этгээд" гэж төсвийн байгууллага, тусгай сан, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, төрийн чиг үүргийг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр шилжүүлэн авсан этгээд болон хуульд заасны дагуу төрийн аудит хийгдэх аливаа этгээдийг;

2021.07.20 А/82) гэж үздэг тул аудитын үр нөлөө, үр өгөөжийн хэрэгжилтэд дунджаар 1-3 жилийн болон түүнээс ч урт хугацаа шаардагдах тохиолдол байдаг.

Төрийн аудитын байгууллагаас 2020-2023 онд дараах аудитуудыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

- Боловсролын чиглэлээр:

-Төрөөс сургуулийн өмнөх боловсрол олгож байгаа өнөөгийн байдал, үр дүн (2020 он);

-Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсрол олгож байгаа өнөөгийн байдал, үр дүн (2021);

-Дээд боловсрол олгож буй өнөөгийн байдал, үр дүн (2022);

- Эрүүл мэндийн чиглэлээр:

-Төрөөс эмийн талаар баримтлах бодлогын хэрэгжилт, үр нөлөө (2021);

-Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо, үр нөлөө (2023) сэдэвт аудитыг тус тус гүйцэтгэсэн байна.

Аудитын үр нөлөө буюу тухайн аудит анх тавьсан зорилгодоо хүрсэн эсэхийг text mining (текст олборлолт) болон дискрептив (тодорхойлох) аргыг ашиглан аудит тус бүрийн үр дүнг нэгтгэн харуулбал:

1.Төрөөс сургуулийн өмнөх боловсрол олгож байгаа өнөөгийн байдал, үр дүн аудит (ҮАГ-"Төрөөс сургуулийн өмнөх боловсрол олгож байгаа өнөөгийн байдал, 2020):

Аудитын зорилт	Аудитын дүгнэлт	дүн,
Төрөөс сургуулийн өмнөх	Хуульд заасан журам, бүрэн	дүрэм, стандартыг батлаагүй,

боловсролын талаар баримтлаж буй хэрэгжүүлэх тогтолцоо оновчтой байгаа эсэх?	зарим, норм, дүрэм, журмыг хуульд нийцүүлэн шинэчлээгүй байна.
--	--

Бодлогын хэрэгжилт нөлөөтэй, дүнтэй байгаа эсэх?	Хамран сургалт нэмэгдэж байгаа ч нэг ангид байх хүүхдийн тоо хүчин чадлаас 2 дахин хэтэрсэн, сургалтын чанарыг үнэлж, дүгнэх боломж бүрдээгүй, бодлогын хэрэгжилтэд үр нөлөөтэй хяналт хэрэгжээгүй байна.
--	---

2.Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсрол олгож байгаа өнөөгийн байдал, үр дүн аудит (ҮАГ-"Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсрол олгож буй өнөөгийн байдал, 2021):

Аудитын зорилт	Аудитын дүгнэлт	дүн,
Ерөнхий боловсрол олгож буй өнөөгийн нөхцөл хэрэгцээ шаардлагад нийцэж байгаа эсэх?	Эрх зохицуулалтыг шинэчлэх, хөрөнгө оруулалт, санхүүжилтийг үндэслэлтэй төлөвлөж, хэрэгжүүлэх замаар хамран сургалт, сургалтын орчныг сайжруулах шаардлагатай байна.	зүйн
Ерөнхий боловсрол олгох үйлчилгээний зорилго, хангагдаж байгаа эсэх?	Сургалтын сурагчдын хэрэглэх хангалтгүй, сургуулийн хөндлөнгийн чанар, мэдлэгээ чадвар болон	

үнэлгээний өндөр байна.	зөрүү
----------------------------	-------

3. Дээд боловсрол олгож буй өнөөгийн байдал, үр дүн аудит (ҮАГ-"Дээд боловсрол олгож буй өнөөгийн байдал, 2022);

Аудитын зорилт	Аудитын дүгнэлт	дүн,
Боловсролын тухай хууль, Төрөөс боловсролын талаар баримтлах бодлогод нийцүүлэн дээд боловсрол олгох эрх зүйн орчныг бүрдүүлсэн эсэх?	Олон улсын жишигт нийцүүлэн дээд боловсролын хууль, эрх зүйн орчныг шинэчлэх шаардлагатай байна.	
Дээд боловсролын сургалтын байгууллагын стандарт, сургалт, судалгааны үйл ажиллагаа нь хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээг хангаж байгаа эсэх?	Дээд боловсрол олгож буй мэргэжлийн чиглэл хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээг бүрэн хангахгүй байна.	

4. Төрөөс эмийн талаар баримтлах бодлогын хэрэгжилт, үр нөлөө аудит (ҮАГ-"Төрөөс эмийн талаар баримтлах бодлогын хэрэгжилт, 2022):

Аудитын зорилт	Аудитын дүгнэлт	дүн,
Төрөөс эмийн талаар баримтлан бодлого	Салбарын хөгжлийг систем	тогтвортой хангасан бүрдээгүй,

хэрэгжиснээр хүн төрийн бодлогын амын өвчлөл буурч, эмийн зохистой хэрэглээ төлөвшсөн эсэх?

хүний бодлогын чанар алдагдсанаас төрөөс эмийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг хангаагүй, үр дүнг үнэлээгүй байна.

Хүн амыг эмчилгээний өндөр идэвхитэй, аюулгүй, чанарын баталгаатай эм, эмнэлэгийн хэрэгслээр хангах, түгээх тогтолцоо бүрдсэн эсэх?

Хүн амыг эмчилгээний өндөр идэвхитэй, аюулгүй, чанарын баталгаатай эм, эмнэлэгийн хэрэгслээр жигд, хүртээмжтэй хангах ил тод, дүн шинжилгээнд суурилсан, хяналтын тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай байна.

Хүн амыг эмчилгээний өндөр идэвхитэй, аюулгүй, чанарын баталгаатай эм, эмнэлэгийн хэрэгслээр жигд, хүртээмжтэй хангах санхүүжилтийн үр нөлөөг сайжруулах шаардлагатай байна.

5. Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо, үр нөлөө аудит (ҮАГ-"Эрүүл мэндийн даатгал үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо, 2023):

Аудитын зорилт	Аудитын дүгнэлт	дүн,
Эрүүл мэндийн даатгалын тогтолцоо, үйл ажиллагааны үр дүн, төрөөс баримтлах	Эрүүл мэндийн салбарын баримт тусгагдсан тогтолцооны шинэчлэлийн	бодлогын бичигт даатгалын тогтолцооны шинэчлэлийн

бодлогын баримт бичгийн хэрэгжилт хангагдсан эсэх?	хүрээнд дэвшүүлсэн зорилтыг хангахад чиглэсэн арга хэмжээний явц удаашралтай байна.
Эрүүл мэндийн байгууллагаас даатгуулагчийн эрэлт, хэрэгцээ, шаардлагад нийцсэн эрүүл мэндийн чанартай тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа эсэх?	Даатгуулагчийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн эрүүл мэндийн чанартай тусламж, үйлчилгээг бүрэн үзүүлж чадахгүй байна. Эрүүл мэндийн даатгалын салбарын хяналт, шалгалт дотоод аудитын үйл ажиллагааны үр нөлөө хангалтгүй байна.

Аудит тус бүрт арга зүй, шалгуур үзүүлэлтийг төрийн аудитын стандарт, аудитын дээд байгууллагын олон улсын стандарт 300, 3000-3100, гүйцэтгэлийн аудитын журмыг баримтлан холбогдох байгууллагуудын санхүү, үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, бусад материал, ярилцлага, асуулга лавлагаа зэргээр нотлох зүйл цуглуулсан талаар тайлангуудад дурдсан байгаа боловч (ҮАГ-"Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсрол олгож буй өнөөгийн байдал, 2021, хууд. 6) шалгаж буй бодлогыг (*тогтолцоо, үйл ажиллагаа*) хэрэгжүүлэхэд шаардлагатай үндсэн элементүүд (Ц.Батболд, 2019, хууд. 322) болох:

- хэрэгжилтийг гүйцэтгэх байгууллагыг бүрэн хамруулсан эсэх;
- бодлогыг хэрэгжүүлэх чиглэлээр гарсан шийдвэр гаргалтууд;

- бодлогын зорилт, зорилтуудад хүрэхэд шаардлагатай нөөцийн асуудал;
- бодлогын хэрэгжилтийн талаар олон нийтэд өгөх ойлголт тайлбар зэрэг асуудлууд аудитад бүрэн тусгагдаагүй байгаа нь нийтлэг байдлаар аудитын зорилго зорилт, мөн шалгаж буй бодлогын үр нөлөө, өөрчлөлтийг аудитын тайлангаар тодорхойлж чадаагүй буюу аудитын зорилт аудитын дүн, дүгнэлтээр бүрэн хариулагдаагүй байгааг харж болохоор байна.

Өөрөөр хэлбэл дээрх бодлого, үйл ажиллагаанд гүйцэтгэлийн аудит хийгдсэнээр:

1.Бодлого, үйл ажиллагаа (*бүрэн болон аудитын хязгаарлалтын хүрээнд хэсэгчлэн*) хэрэгжсэн эсэх? Хэрэгжилтийн үр нөлөө нийгэм, эдийн засагт өөрчлөлт, чанарын үзүүлэлт авчирсан эсэх? Төрийн бүтээмжийг нэмэгдүүлж чадсан эсэх?

2.Бодлого, үйл ажиллагаа хэрэгжээгүй, хэрэгжилт хангалтгүй гэж дүгнэсэн тохиолдолд шалтгаан нөхцөл (*бодлого төлөвлөлтийн эрх зүйн орчин, тогтолцоо, үйл ажиллагаа, санхүүжилт, нөөцийн хуваарилалт, сахилга хариуцлага гэх мэт*)-ийг аудитын тайланд тодорхой тусгаж, цаашид сайжруулах чиглэлээрх санал дүгнэлт нь албан шаардлага, зөвлөмжийн хэлбэрээр тухайн бодлого, үйл ажиллагааны хэрэгжилтийг хангах чиг үүрэг бүхий байгууллага, албан тушаалтанд хүргэгдсэн байх ёстой буюу төрийн бүтээмжийн өсөлтийг хязгаарлаж байгаа хүчин зүйлсийг илрүүлэхэд чиглэдсэн байна.

Аудитын чанар, үр нөлөөг дээшлүүлэхэд тухайн аудитаар өгч байгаа зөвлөмж, албан шаардлага нь шалгагдагч

байгууллагын хэрэгцээ шаардлагад нийцсэн, бодитой бөгөөд, хэрэгжүүлэх шаардлагатай бөгөөд боломжтой байх, хүлээн зөвшөөрөгдсөн байх нь чухал. Аудитын тайланд удирдлагад зориулсан мэдээлэл багтах бөгөөд түүнд аудитын дүн дүгнэлтэд үндэслэсэн аудитын зөвлөмжийг бэлтгэж хүргүүлдэг. Энэ нь аудитын гол үр дүн буюу шийдвэр юм. (Б.Мөнхцэцэг, 2023, хууд. 1)

Судалгаанд хамруулсан 5 аудитаар өгөгдсөн нийт 48 зөвлөмжийн агуулга, ач холбогдолыг тодорхойлбол:

1. Бодит нөхцөл байдалд тохирсон оновчтой шийдэлгүй;
2. Хэрэгжүүлэх арга зам тодорхойгүй;
3. Үр дүнг хэмжих боломжгүй байдлаар тодорхойлогдсон зөвлөмж 21 байна. Жишээлбэл:

Аудитын нэр:	Зөвлөмж хүргүүлсэн субъект, зөвлөмжийн товч утга:
“Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсрол олгож буй өнөөгийн байдал, үр дүн” аудитаар:	Засгийн газрын хэрэг эрхлэх газарт: 1.Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого, боловсрол үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд холбогдох хуульд заасны дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлгэх, хэрэгжилтийг хангуулах.
“Дээд боловсрол олгож буй өнөөгийн байдал, үр дүн” аудитаар:	Боловсрол, шинжлэх ухааны сайдад: 1.Төрөөс дээд боловсролын талаар баримтлах урт, дунд хугацааны хөгжлийн

бодлого, зорилтыг хэрэгжүүлэх ажлыг төлөвлөж, биелэлт, үр дүнг тооцож ажиллах.

2.Багшийн хөгжлийн хөтөлбөрийг хуульд заасны дагуу хэрэгжүүлэх.

3.Боловсролын зээлийн сангийн...эргэн төлөлтийг эрчимжүүлэх...хөнгөлөлт чөлөөлтийг хууль, журамд нийцүүлэн шийдвэрлэх.

“Төрөөс эмийн Ерөнхий сайдад: талаар баримтлах бодлогын хэрэгжилт, үр нөлөө” аудитаар:

1.Нийгмийн эрүүл мэнд, амьдралын чанарыг сайжруулах урт хугацааны тогтвортой бодлого хэрэгжүүлэх.

2.Эм, эмнэлэгийн хэрэгсэл, уламжлалт эмийн дотоодын үйлдвэрлэлийг дэмжих тогтвортой, үр дүнд чиглэсэн бодлого хэрэгжүүлэх.

“Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо, үр нөлөө” аудитаар:

Эрүүл мэндийн сайдад:

1.Эрүүл мэндийн зөвлөлийн ажлын алба болон даатгалын байгууллагын үйл ажиллагааг үр дүнтэй удирдан зохион байгуулах...,

2.Сангийн орлогыг судалгаанд үндэслэн бодитой төлөвлөх...,

Эрүүл мэндийн даатгалын газрын даргад:

1...тусламж, үйлчилгээний чанар стандарттай холбоотой илэрсэн зөрчил дутагдлыг нэгтгэн дүн шинжилгээ хийх, цаашид давтан гаргахгүй байх талаар холбогдох арга хэмжээг авах,

2.Эм, эмнэлэгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрыг эрдэм шинжилгээний байгууллага, эмийн үйлдвэр, эм ханган нийлүүлэх байгууллага, эм, эмнэлэгийн хэрэгслийн худалдан авах ажиллагаанаас хараат бус, бие даасан, зохион байгуулалтын оновчтой бүтэц, чанарын удирдлага, хяналтын тогтолцоо бүхий байгууллага болгон үйл ажиллагааг жигдрүүлэх.

Зөр

Мөн зөрчлийг ерөнхий томьёолсон, шалтгаан үр дагаварыг дутуу тодорхойлсон эсхүл огт тодорхойлоогүй зөвлөмжүүд ч байгааг дурдах нь зүйтэй.

Ирүүлсэн алдаа, зөрчлийг арилгах шаардлага нь үндэслэл муутай байвал тухайн шийдвэрийн ач холбогдол, үр нөлөө буурах, хэрэгжилт хангалтгүй байх, Төрийн аудитын байгууллагын хүлээн

зөвшөөрөгдөх түвшин буурах эрсдлийг дагуулна. Ямар төрлийн алдаа зөрчилд ямар шийдэл, шийдвэр гаргах талаар Төрийн аудитын байгууллагаас баталсан журам, зааварт тусгагдсан зохицуулалтууд байгаа боловч хэрэгжилт нь хангалтгүй байна. (Б.Мөнхцэцэг, 2023, хууд. 9)

Дээрх нөхцөл байдал нь илэрсэн алаа дутагдлыг залруулах, шалгагдагч байгууллагын гүйцэтгэлийг сайжруулах шалгуур үзүүлэлт болж чадахгүй байх, нөгөө талаас шалгагдагч байгууллагын хувьд зөвлөмжийг хэрэгжүүлэхэд ойлгомжгүй, үр нөлөөгүй, цаашлаад аудитын мөрөөр тавих хяналтыг үр дүнгүй болгох шалтгаан болж байна.Энэхүү үр дагавар нь төрийн бүтээмж, бүтээмжийн удирдлагыг сайжруулахад төрийн аудитын байгууллагын гүйцэтгэх үүрэг, функцийг сулруулах эрсдэлийг дагуулж байна.

4.Төрийн бүтээмжийг сайжруулахад төрийн аудитын гүйцэтгэх үүрэг, асуудал, шийдэл

Төрийн бүтээмж буюу Засгийн газрын байгууллагуудын бүтээмжийг үнэлэхийн тулд төрийн ажил үйлчилгээ, хөрөнгө санхүү, эдгээрийг зохицуулж буй эрх зүйн орчин, хэрэгжүүлж буй бодлого хөтөлбөрийг шинжлэн судлах, хяналт шалгалт, аудит хийх замаар гүйцэтгэл, үр нөлөөг тодорхойлох нь бүтээмжийг сайжруулах үндэслэл болдог.

Төрийн бүтээмжийг сайжруулах чиглэлээр Азийн орнуудад төрийн бүтээмжийн судалгаа боловсруулалтын шатандаа байгаа бол Америк, Англи, Герман, Австрали зэрэг орнууд төрийн бүтээмжийн гүйцэтгэлийг хэмжих, үнэлэх арга зүйгээ боловсруулан (i)

байгууллагын түвшний бүтээмж, (ii) салбарын болон үндэсний бүтээмж, (iii) олон улсын хэмжээний харьцуулсан бүтээмжийн судалгааг хийж, төрийн удирдлагын арга хэрэгсэл болгон ашиглаж байна.

Энэхүү судалгаагаар төрийн бүтээмжийн талаарх онолуудаас “Төрийн бүтээмжийн хэмжүүрт үр дүн, гүйцэтгэлийг чухалчлахаас илүүтэй Засгийн газрын хийж буй өөрчлөлтийн үр нөлөөнд төвлөрөх ёстой” гэсэн судлаач Путнамын үзэл баримтлалын дагуу төрийн бүтээмжийг сайжруулахад Төрийн аудитын байгууллагын хяналтын гүйцэтгэл, үр нөлөөг төрийн бүтээмжтэй уялдуулан судлахыг зорьсон.

Төрийн аудитын байгууллагаас татвар төлөгчдөөс хуулийн дагуу бүрдүүлсэн төсвийн хөрөнгийг хэрхэн бүтээмжтэй зарцуулсныг олон нийтэд нээлттэй тайлагнах, алдаа зөрчилд хариуцлага тооцох, сайжруулах чиглэлээр дүгнэлт зөвлөмж гаргах, биелэлтийг хангуулах нь төрийн бүтээмж дэх төрийн аудитын үүрэг гэж судлаачид үзэж байна.

Судалгаагаар (судалгаанд хамруулсан аудитын хүрээнд) Төрийн аудитын байгууллагын гүйцэтгэж буй аудит, түүний дүгнэлт, аудитын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээг тоон үзүүлэлтээс илүү чанарын болон тогтолцооны шинжтэй асуудлуудад түлхүү чиглүүлэх шаардлагатай гэсэн дүгнэлтэд хүрсэн. Тухайлбал,

1. Аудит анх тавьсан зорилго, зорилтдоо хүрээгүй;
2. Аудитын гол үр дүн, шийдвэрийг илтгэх зөвлөмж нь бодит нөхцөл байдалд тохирсон оновчтой шийдэлгүй, хэрэгжүүлэх арга зам тодорхойгүй, үр дүнг хэмжих боломжгүй байдлаар тодорхойлогдсон;

3. Зөвлөмжийн чанараас хамаарч аудитын үр өгөөж болон аудитын мөрөөр тавих хяналт суларсан;
4. Төрийн аудитын байгууллагын хяналтын хүлээн зөвшөөрөгдөх байдал буурсан үзүүлэлттэй байна.

Аудитын шийдвэрийн чанар нь төрийн хяналтад итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэх, зөрчил дутагдлыг арилгах, сахилга, хариуцлагыг нэмэгдүүлэх, зөвлөн туслах, эрсдэлээс сэргийлэх замаар төрийн бүтээмж, засаглалын үйл ажиллагааг сайжруулах, тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулах чухал үүрэгтэй. Иймд төрийн аудитын байгууллага аудитын шийдвэрийн чанарт сөргөөр нөлөөлж буй гадаад болон дотоод хүчин зүйлсийг илрүүлэх, хариу арга хэмжээ авах, аудитын чанараас үр нөлөө, үр өгөөж (санхүүгийн болон санхүүгийн бус)-ийг бий болгох, аудитаар илэрч буй алдаа зөрчлийн шалтгаан нөхцөлийг тогтолцоо, эрх зүйн орчин, хууль тогтоомжийн давхардал хийдэл, зөрчил, нөөцийн хуваарилалт зэрэг өргөн цар хүрээтэй, цогц байдлаар тогтоож, хяналт тавих нь төрийн бүтээмжийн удирдлагад чухал нөлөө үзүүлнэ.

Иймд төрийн бүтээмжийг сайжруулахад төрийн аудитын байгууллагын гүйцэтгэх үүргийг аудитын бусад төрөл, хэлбэрийн хүрээнд үргэлжлүүлэн судлах нь судалгааны болон практик ач холбогдолтой гэж үзэж байна.

Ном зүй

Ц.Батболд. (2019). *Бодлогын шинжилгээний онол, арга зүйн үндэс*. Улаанбаатар : Удам соёл хэвлэлийн газар.

- Н.Бурмаа. (2018). *Төрийн хяналт хариуцлага*. Улаанбаатар: "Мөнхий үсэг" ХХК.
- С.Билгүүнзул, Б. (2020). Бүтээмж, түүнийг сайжруулах санал зөвлөмж. *Судалгааны товхимол-18, Монгол банк*, 39.
- А.Энхбат, Г. (2020). *Төрийн /нийтийн/ төсөв, санхүүгийн хяналт шалгалт: онол, практик, арга зүй, тогтолцоо, эрх зүйн орчин*. Улаанбаатар.
- Б.Мөнхцэцэг.(2023).*Аудитын ишийдвэрийн хэрэгжилтийг үнэлэх, зохистой хариу арга хэмжээ авах нь*. Улаанбаатар: Үндэсний аудитын газар .
- Ц.Самбаллхүндэв. (2002). *Төрийн захиргааны байгууллагын бүтээмж*. Улаанбаатар :Үндэсний бүтээмж, хөгжлийн төв. Үндэсний бүтээмжийн стратеги, бүх нийтийн бүтээмжийн ухамсар суулгах хөдөлгөөн.
- С.Энхбаатар. (2019). *Төрийн аудит: Арга зүй, шинжилгээ, шинэчлэл*. Улаанбаатар: "Би Си Ай" ХХК.
- С.Энхсайхан. (2010). *Төрийн бүтээмжийн удирдлага*. Улаанбаатар: "Китон принт" ХХК.
- С.Энхсайхан. (2018 II №03). Төрийн бүтээмжийн судалгаа. *Төрийн удирдлага онол, арга зүйн сэтгүүл-Удирдлагын академи*, 30.
- сэтгүүл, Т. м. (2020). Төрийн аудитын тухай хууль. *Төрийн мэдээлэл сэтгүүл*.
- ҮАГ-"Дээд боловсрол олгож буй өнөөгийн байдал, (2022). *Гүйцэтгэлийн аудитын тайлан*. Улаанбаатар: Үндэсний аудитын газар.
- ҮАГ-"Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсрол олгож буй өнөөгийн байдал,(2021). *Гүйцэтгэлийн аудитын тайлан*. Улаанбаатар: Үндэсний аудитын газар.
- ҮАГ-"Төрөөс сургуулийн өмнөх боловсрол олгож байгаа өнөөгийн байдал, (2020). *Гүйцэтгэлийн аудитын тайлан*. Улаанбаатар: Үндэсний аудитын газар.
- ҮАГ-"Төрөөс эмийн талаар баримтлах бодлогын хэрэгжилт, (2022). *Гүйцэтгэлийн аудитын тайлан*. Улаанбаатар: Үндэсний аудитын газар
- ҮАГ-"Эрүүл мэндийн даатгал үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо, (2023). *Гүйцэтгэлийн аудитын тайлан*. Улаанбаатар хот : Үндэсний аудитын газар .
- форум,(2006). *Дэлхийн өрсөлдөх чадварын тайлан*. Улаанбаатар: "Нээлттэй нийгэм форум".

SPSIRPA FORUM 2024

Poster presentation 8

Public service values





МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН АЛБАНЫ ЭРХЭМЖ

ДООСМААГИЙН ЦЭЦЭНБИЛЭГ

УЛААНБААТАР ХОТ
2024 ОН

ҮНДЭСЛЭЛ

Сайн төр гэж сайн түшмэдтэй төрийг хэлнэ гэж энгийнээр томъёолж болно. Хэрэв таныг ард иргэд чинь хүлээн зөвшөөрч итгэж хүндлэхгүй бол алхам бүхэн тань саад бэрхшээлтэй тулгарах болно гэдгийг санах ёстой, түүнчлэн төрийн албан хаагч нь төр, иргэдийг холбох гүүр болж төрийн өмнөөс иргэдтэй харилцах төлөөлөгч нь, харилцан ойлголцлыг бэхжүүлэгч нь юм (Занданшатар.Г., 2023) гэснээс төрийн албан хаагч нь үнэт зүйлийг өдөр тутмын үйл ажиллагаа, хандлага, шийдвэр гаргалтад төрийн албаны үнэт зүйлд баримжаалан, төрийн албан хаагчийн ёс болоод зарчмыг баримталж чадвал авлига, албан тушаал, ашиг сонирхлын зөрчлөөс ангид төрийн албыг төлөвшүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэхэд хувь нэмэр оруулж, нийтийн сайн сайхны төлөө ажиллах нөхцөл бүрдэнэ гэж үзэж болно.

Энэ утгаараа “Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын зорилтын 5.4-т *“Иргэндээ үйлчилдэг, мэргэшсэн, чадварлаг, ил тод, үр нөлөөтэй, ухаалаг төрийн албыг төлөвшүүлнэ”* гээд *“Төрийн албан хаагчийн ёс зүй, хандлагыг ажлын гүйцэтгэлийн үнэлгээний салшгүй чухал хэсэг болгон үнэлэх тогтолцоог хэвшүүлж, сэтгэл гарган үйлчлэх соёл бий болгоно”* (“Алсын хараа-2050”, 2023) гэсэн зорилтыг дэвшүүлсэн. Энэхүү зорилтыг биелүүлэхийн тулд тус баримт бичигт 2021-2030 оны хооронд *“Төрийн албанд ёс зүй, сахилга хариуцлагын оновчтой тогтолцоо бүрдэж, ёс зүйтэй төрийн алба төлөвшинө”*, 2031-2040 оны хооронд *“Төрийн албан хаагчид нийгэмд ёс зүй, сахилга хариуцлагаар үлгэрлэх тогтолцоо бэхэжсэн байна”* гэсэн зорилгыг тавьж 2023 онд *“Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай”* хуулийг хэрэгжүүлж эхэлсэн билээ.

Түүнчлэн “Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт 2021-2030 оны хооронд *“үнэт зүйлийн суурь, хавсарга болон гүнзгийрүүлсэн судалгаа тогтворжсон байна”* гэж тусгасан нь одоогийн байдлаар Монгол улсын хэмжээнд үндэсний нэгдмэл үнэт зүйлээ хараахан тодорхойлж ард иргэддээ таниулан сурталчилж, нийгмийг соён гэгээрүүлэх ажил эхлээгүй байна хэмээн харж болно.

Монгол улс Үндсэн Хуульдаа *“...эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно”* гэж тунхагласан нь төрийн бодлого, цаашлаад төрийн албаны үйл бодлого, төлөвлөгөө, шийдвэр, үйл ажиллагаа энэхүү эрхэм зорилгыг хангахад чиглэх нь гарцаагүй. Тийм ч учраас Төрийн албаны тухай хуулийн 5.1-д төрийн албаны эрхэм зорилгоо *“Монгол Улсын Үндсэн Хууль, бусад хуулийг чандлан баримталж, үндэсний язгуур ашиг сонирхолд захирагдан ард түмэндээ үйлчилж, төрд чин үнэнчээр зүтгэхэд оршино”* гэж томъёолжээ. Ингэхдээ Төрийн албанд Монгол Улсын Үндсэн Хуулийн нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх зарчмаас гадна ард түмэнд үйлчлэх, мэргэшсэн, тогтвортой байх, улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагч улс төрийн нам, эвслийн үйл ажиллагаанаас ангид байх, Монгол Улсын иргэн төрийн алба хаах адил тэгш боломжоор хангагдах, төрийн жинхэнэ албан тушаалд иргэнийг томилохдоо гагцхүү чадахуйн зарчмыг баримтлах, ил тод байх, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, захирах, захирагдах ёс зэрэг зарчмуудыг баримтлахыг хуульчилжээ (Төрийн албаны тухай хууль ш. н., 2017).

Тэгэхээр төрийн албан хаагч нь төрд чин үнэнчээр зүтгэж, ард түмэндээ үйлчлэхийн тулд үнэт зүйлд баримжаалж, ёс зүйн хэм хэмжээг сахиж, зарчмыг баримтлах нь хуулиар оноож өгсөн үүрэг гэдгийг ухамсарлах нь зайлшгүй юм. Үүний зэрэгцээ хуульд өөрөөр заагаагүй бол Монгол Улсын иргэн төрийн захиргааны албанд анх орохдоо *“Эх орон, ард түмнийхээ төлөө эрдэм чадлаа зориулж, Монгол Улсын хууль, ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, үндэсний язгуур ашиг сонирхолд захирагдан*

албан үүргээ үнэнч шударгаар биелүүлэхээ тангараглая. Тангаргаа няцвал хуулийн хариуцлага хүлээнэ” хэмээн тангараг өргөж баталгаажуулна гэжээ (Төрийн албаны тухай хууль ш. н., 2017). Мөн “Харьяа дээд шатны албан тушаалтны **зөвхөн хуульд нийцсэн шийдвэрийг** биелүүлэх, “удирдлагын санаа бодолд нийцэх эсэхийг үл харгалзан тэдний гаргах шийдвэрээс **үүдэн гарч болзошгүй сөрөг үр дагаврыг урьдчилан анхааруулж байх**” гэж заасан нь тухайн шийдвэрээс улс, төр, иргэд болон бусад хамаарал бүхий талууд хохирол амсахгүй байхад чиглэжээ. Тийм ч учраас төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн зорилгыг “Төрийн албан хаагч ард түмэндээ үйлчилж, төрд чин үнэнчээр зүтгэх **эрхэм зорилгоо ухамсарлаж**, төрийн ажил үүргийг гүйцэтгэхдээ **хуулиар тогтоосон ёс зүйн хэм хэмжээг чандлан биелүүлэх үнэт зүйлс, соёлыг төлөвшүүлж**, төрөө дээдлэх **ард түмний итгэлийг бэхжүүлэхэд** энэ хуулийн зорилго оршино” хэмээн томъёолсон нь санаандгүй зүйл биш юм.

Түүнчлэн төрийн албан хаагч Төрийн албаны тухай хуулийн 7.1-д заасан ард түмэндээ чин сэтгэлээсээ үйлчилж, төрийн албаны нэр хүндийг эрхэмлэх, зан харилцаа, үг, үйлдлээрээ хүний эрх, эрх чөлөө, нэр төр, алдар хүнд, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх, хууль ёс, шударга ёсыг дээдлэн сахих, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, албан үүргээ гүйцэтгэхдээ гаргасан өөрийн буруутай үйлдэл, эс үйлдэхүйн төлөө ёс зүйн хариуцлага хүлээдэг байх, төрийн улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагч улс төрийн хувьд төвийг сахиж, аливаа улс төрийн эвсэл, хөдөлгөөн, намын нөлөөллөөс ангид байх, төрийн албан хаагчийн хувьд хуулиар тогтоосон иргэний эрх, эрх чөлөөний хязгаарлалтыг хүлээн зөвшөөрөх, албан үүргээ гүйцэтгэхдээ бусдад аливаа хэлбэрээр дарамт үзүүлэхгүй байх, ялгаварлан гадуурхахгүй байх, байгууллагын соёл, дэг журам, албан харилцааны ёс зүйг чанд сахих, улсын болон байгууллагын нэр хүндэд харшилсан аливаа үйлдэл гаргахгүй байх, олон нийтэд үлгэр жишээ, манлайлал үзүүлэх, албан үүргээ гүйцэтгэхдээ нийтийн ашиг сонирхол болон хүрээлэн байгаа орчинд үзүүлэх нөлөөллийг харгалзан үзэх, багаар ажиллах, суралцах, шинэ санаачилгыг дэмжих, хамт олны итгэлцлийг эрхэмлэх, удирдах албан тушаалтны итгэлийг дааж ажиллах гэсэн зарчмуудаас гадна тус хуулийн 6 дугаар бүлэгт багтаасан хүнлэг, энэрэнгүй байх, үнэнч, шударга байх, хариуцлагатай байх, манлайлах, хамтач байх зэрэг ёс зүйн хэм хэмжээг дагахаар тусгажээ.

Эдгээр хуулийн заалтуудаас үнэт зүйл, эрхэмлэх зүйл, ёс зүйн хэм хэмжээ болон зарчмуудыг түүвэрлэвэл 1/ 1992 оны Үндсэн хуульд **6 зарчим** Ардчилсан ёс, Хууль дээдлэх, Тэгш байдал, Үндэсний эв нэгдэл, Эрх чөлөө, Шударга ёс, 2/ 2004 оны Төрийн албаны шинэтгэлийн стратегид **эрхэмлэх зүйл 3** (Үр нөлөөтэй үйлчилгээ, Үр дүн, гүйцэтгэл, Үр ашиг, хүртээмж), **зарчим 12** (Олон нийтэд үйлчлэх, Мэргэшсэн тогтвортой, Тохирсон ажилд томилох, Тэгш боломж, Эрх мэдэл, хариуцлага, Суралцагч, Стратегид суурилсан, Гарц, үр дагавар, Залж чиглүүлэх, Удирдах бололцоо, Гүйцэтгэлд суурилах, Хэмнэлттэй хэмжээтэй), 3/ 2013 оны ТАХ-ийн эрхэмлэх үнэт зүйлсэд **эрхэм зүйл 9** (Соёлтой харилцаа, Шударга ёс, Хууль ёс, Ёс зүй, Хариуцлагатай ил тод байдал, Мэдлэг, Үнэнч байдал, Шуурхай байдал, Чадвар), 2017 оны Төрийн албаны тухай хуульд **зарчим 8** (Ард түмэнд үйлчлэх, Ашиг сонирхлын зөрчилгүй, Тэгш боломж, Улс төрөөс ангид, Мэргэшсэн тогтвортой, Мерит зарчим, Захирах, захирагдах ёс, Ил тод байдал), 4/ 2023 оны Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд **ёс зүйн хэм хэмжээ 7** (Хүнлэг энэрэнгүй, Үнэнч шударга байх, Хариуцлагатай байх, Манлайлах, Хамтач байх), **зарчим 17** (Ард түмэндээ чин сэтгэлээсээ үйлчлэх, Төрийн албаны нэр хүндийг эрхэмлэх, Зан харилцаа, үг, үйлдлээрээ хүний эрх, эрх чөлөө, нэр төр, алдар хүнд, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх, Хууль ёс, шударга ёсыг дээдлэн сахих, Ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, Албан үүргээ гүйцэтгэхдээ гаргасан өөрийн буруутай үйлдэл, эс үйлдэхүйн төлөө ёс зүйн хариуцлага хүлээдэг байх, Төрийн улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагч улс төрийн хувьд төвийг сахиж, аливаа улс төрийн эвсэл, хөдөлгөөн, намын

нөлөөллөөс ангид байх, хуулиар тогтоосон иргэний эрх, эрх чөлөөний хязгаарлалтыг хүлээн зөвшөөрөх, Албан үүргээ гүйцэтгэхдээ бусдад аливаа хэлбэрээр дарамт үзүүлэхгүй байх, Ялгаварлан гадуурхахгүй байх, Байгууллагын соёл, дэг журам, албан харилцааны ёс зүйг чанд сахих, Улсын болон байгууллагын нэр хүндэд харшилсан аливаа үйлдэл гаргахгүй байх, Олон нийтэд үлгэр жишээ, манлайлал үзүүлэх, Албан үүргээ гүйцэтгэхдээ нийтийн ашиг сонирхол болон хүрээлэн байгаа орчинд үзүүлэх нөлөөллийг харгалзан үзэх, Багаар ажиллах, суралцах, шинэ санаачилгыг дэмжих, Хамт олны итгэлцлийг эрхэмлэх, Удирдах албан тушаалтны итгэлийг дааж ажиллах), 5/ Алсын хараа-2050 бодлогын баримт бичигт **зорилт 5** (Иргэндээ үйлчилдэг, Мэргэшсэн, Чадварлаг ил тод, Үр нөлөөтэй, Ухаалаг төрийн албыг төлөвшүүлнэ) зэрэг байна. Өөрөөр хэлбэл үнэт зүйл гэсэн нэршил олдсонгүй.

Мөн "Төрийн албаны үнэт зүйлд суурилсан байгууллагын соёл" (Төрийн албаны зөвлөл, НҮБХХ, 2022) сэдэвт уулзалт хийсэн ч үүндээ төрийн албаны үнэт зүйлийн тухай бус харин ТАХ-ийн ёс зүйн үнэт зүйлийг, "Монгол Улсад мэргэжлийн, иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх нь" төсөл хэрэгжиж байгаа бөгөөд энэхүү төслийн хүрээнд хийсэн уулзалтын үеэр ардчиллын үнэт зүйлсийг хамгаалах сорилт тулгарч буйг (Төрийн албаны зөвлөл, НҮБХХ, 2022), "Төрийн албаны үнэт зүйл ба стратегийн баримжаатай хүний нөөцийн удирдлага" сэдэвт сургалт (Төрийн албаны зөвлөл, НҮБХХ, 2022) болон "Төрийн албаны шинэтгэл, үнэт зүйл ба төрийн албан хаагчийн шударга, зарчимч байдал" сэдэвт сургалт, хэлэлцүүлэгт илүүтэй шинэтгэлтэй холбоотой асуудлуудыг хөнджээ (Төрийн албаны зөвлөл, НҮБХХ, 2022).

Гэтэл бид зөвхөн төрийн албан хаагчийн баримтлах зарчим, сахих ёс зүйн хэм хэмжээ, эрхэмлэх зүйлс зэргийг бодлогын болон хууль, эрх зүйн баримт бичгүүдэд тусгаснаас төрийн албаны үнэт зүйлийг тодорхойлсон нь эргэлзээтэй бөгөөд эсвэл дээрх ялгаатай нэр томъёонуудад агуулгыг нь багтаан, хамааруулан авч үзсэн байж болох юм.

Хэрэв тийм бол үнэт зүйл, эрхэмлэх зүйл, зарчим, ёс зүй зэрэг ойлголтууд нь бие даасан ялгаатай утга, агуулга илэрхийлдэг тул аль нэгийг нөгөөгөөр төлөөлүүлэн илэрхийлэх нь тухайн ойлголтын амин чанар алдагдахад хүрнэ.

Энэ бүгдээс "төрийн албаны үнэт зүйл" гэдгийг бусад ойлголтуудаас салган тодорхой болгох, "төрийн албаны үнэт зүйл" хэмээн хамтад нь нэг ойлголтоор торхлойлох, энэ нь философи, социологи, сэтгэл судлал болон бусад салбарт хэрэглэгддэг ойлголтоос өөр үү? эсвэл "төрийн алба" гэдгийн ард шууд үнэт зүйл гэх үгийг холбон ойлгох нь зөв үү? гэхчлэн эргэлзээтэй асуудлууд урган гарсныг тодруулахыг зорилоо.

СУДЛАГДСАН БАЙДЛЫН ТОЙМ

2018 онд Монгол, Солонгосын төрийн жинхэнэ албан хаагчдын үнэт зүйлс, мотивацийг харьцуулах, төрийн захиргааны албан хаагчдын талаар цаашид авч хэрэгжүүлэх төрийн бодлогын шинжлэх ухааны үндэслэлийг гаргаж ирэх зорилготой судалгаа хийгджээ. Энэхүү судалгаанд Монголын **төрийн албаны үнэт зүйлийн тогтолцооны өнөөдрийн дүр төрхийг тодорхойлох явдлыг тулгамдсан асуудал хэмээн үзэж** (Хэрлэн.Б, Түдэв.Ш, Санжмятав.Ч, 2018) тус судалгаанд орчин үеийн төрийн соён гэгээрүүлэх чиг үүрэг иргэдийнхээ сэтгэлийг засахад, ухааруулж гэгээрүүлэхэд чиглэх бөгөөд **нийгмийн тогтолцооныхоо үнэт зүйлийг** төрийн албан хаагчдын, ард иргэдийнхээ итгэл үнэмшил болгох ёстой боловч төр энэ чиг үүргээ хангалттай сайн биелүүлэхгүй байна, харин төрийн түшмэл нь төрийн албаны **эрхэмлэх зүйлсийг** өөртөө нэвт шингээж, цээрлэх ёсыг чанд сахиж чадвал төрийн эрдэнэ нь байж чадна хэмээжээ.

Мөн 1993 оноос хойш Монголын төрийн уламжлал болон социализмын үеийн төрийн албаны бюрократ зарчим, үнэт зүйлсийг халж зах зээл, менежериализм, төрийн өмчийг хувьчлах, өрсөлдөөнийг нэвтрүүлэх, эдийн засгийн үр ашиг, үйл ажиллагааны гарц үр дүн, иргэдийн оролцоо, хамтын хариуцлага, ил тод нээлттэй байдал зэрэг “либерал үнэт зүйлс” түрж орж ирсэн гэж үзжээ. Ийнхүү төрийн албаны үнэт зүйлсийн талаарх судалгааг Солонгосын ерөнхий сайдын дэргэдэх Төрийн Захиргааны Институтийн (КИПА) хэрэглэдэг “Төрийн албан хаагчийн санаа бодлыг судлах асуулт”-тай асуулгад түшиглэж хийсэн боловч судалгаанд Монгол улсын төрийн албаны үнэт зүйлийг тодорхой илэрхийлээгүй, мөн төрийн албаны үнэт зүйл, төрийн албан хаагчийн эрхэмлэх зүйл, төрийн албаны шинэ үзэл баримтлал зэрэг нэр томъёонууд нь нэг утгыг илэрхийлэх мэт боловч ялгаатай үгээр хэрэглэгдсэн нь төөрөгдөлд оруулж байна. Судалгааны эцэст төрийн албаны **шинэ үзэл баримтлал** нь ард олны, түүний дотор төрийн албан хаагчдын баттай итгэл үнэмшил болон төлөвшиж чадаагүй гэсэн дүгнэлтэд хүрчээ.

Олон улсын туршлагаас харахад аливаа улс гадаадын сайн туршлагыг хуулбарлан авахаас илүүгээр **өөрийн орны нөхцөл байдалд тохирсон, үе улиран өвлөгдөж ирсэн төрийн албаны уламжлал, түүний үнэт зүйлсийг орчин үеийн глобалчлалын хүчин зүйлстэй хослуулан хэрэглэх** нь үр дүнд хүргэж байгаа нь тодорхой байна. **Иймд, төрийн албаныхаа уламжлал, үнэт зүйлсийг түүхэн эх сурвалждаа тулгуурлан гаргаж ирэх явдал хойшлуулшгүй асуудал болж байна** (Долгоржав.Я, Цэдэндамба.С, Билэгсайхан.С, Үүрийнтуяа.Ц, Балжмаа.Х, 2021) хэмээн тулгамдсан асуудлыг дэвшүүлсэн судалгааны тайлангаас төрийн албаны үнэт зүйл нэгэн чухал судлагдахуун болох нь харагдаж байна.

Энэхүү судалгаанд үнэт зүйлийг *“олон түмний сэтгэлийг эзэмдэн цагийг элээж, ноёлох хүчийг олсон итгэл бөгөөд хүний болон хүй олны үйл ажиллагааны өдөр тутмын болон алсын чигийг зааж, тэдгээрээс өөр хоорондоо болон байгаль, нийгмийн бусад хүрээнд харилцах практик харилцааны хэм хэмжээг тохируулан тодорхой болгож, харьцангуй тогтвортой баримтлагдах зарчим болж байдаг”* гэж тодорхойлсон бөгөөд үнэт зүйлийг зарим тохиолдолд хуультай эн зэрэгцэж, зарим тохиолдолд түүнийг давах хэмжээнд хүрч болох ч ихэнхдээ түүнтэй хоршиж хэрэглэгддэг зүйл хэмээгээд үүнд нийцүүлэн судалжээ. Ингэхдээ үнэт зүйлийг судлан буй үеийн төрийн албаны түвшинд авч үзэхдээ 1. улс төрийн үнэт зүйл (бүрэн улс,), 2. хууль, эрх-зөвийн эрхэмж, дэг журам (бурхан, тэнгэрийн бошго, хууль, эрх-зөвт байх, улсын эзэн-тэргүүний байр суурийг бататгах, язгуур угсаатны эрх ашгийг эрхэмд үзэх, өвгөдийн үг үндэс-хуучны үг хууль), 3. Эв нэгдэл, итгэл үнэмшил, эрдэм, соёлын хүрээний эрхэмж, 4. Захиргаа, төрийн албаны хүрээний эрхэмж (энх тайван, түүхэн байр суурь, шаталсан удирдлага, тодорхой шалгуураар шилэх, үнэнч байдал, шатлан захирагдах-дэг журам, эмх цэгц, сахилга бат) гэсэн хэд хэдэн төрөлд хуваан, төрийн албанд мэдлэг, чадвар, эр зориг, бяр тэнхээ, овсгоо самбаа, үнэнч байдлыг харгалзан хариуцлагатай албанд томилдог байсан тухай дүгнэлт хэсэгтээ оруулжээ. Өөрөө хэлбэл “төрийн албаны үнэт зүйл” гэсэн нэгэн бүхэл ойлголтын тодорхойлолтыг бус харин төрийн албанд байх үнэт зүйлсүүдийг судалгаанд үндэслэн санал болгожээ.

2022 онд хийгдсэн “Монгол Улсын төрийн албан хаагчдын ёс зүйн үнэт зүйлсэд нийгмийн XYZ үеийн онцлог нөлөөлөх нь” судалгаанд Монгол улсын төрийн албаны ёс зүйн үнэт зүйлийн эрх зүйн зохицуулалт нь Монгол Улсын Үндсэн Хуулийн 1.2 дахь хэсэгт *“Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”*, Монгол улсын төрийн албаны шинэтгэлийн дунд хугацааны стратегид шинэтгэлийн эрхэм зорилго нь *“Иргэдэд ойр, тэдний хэрэгцээг хангахад чиглэсэн, өөрчлөгдөж буй орчинд уян хатан зохицож чаддаг бөгөөд идэвхтэй, санаачилгатай манлайлагч менежер бүхий цомхон, чадварлаг,*

эцсийн үр дүнг эрхэмлэн дээдэлсэн төрийн албыг төлөвшүүлэхэд оршино” (Монгол улсын төрийн албаны шинэтгэлийн дунд хугацааны стратеги, 2004) гэж оруулсан нь төрийн үйлчилгээг үр нөлөөтэй хүргэх, ажлын гүйцэтгэл, үр дүнг эрхэмлэн дээдлэх, үр ашигтай бөгөөд хүртэхэд хялбар байх гэсэн гурван **эрхэмлэн дээдлэх** зүйлийг, олон нийтэд үйлчлэх, төрийн алба мэргэшсэн тогтвортой байх зэрэг **12 зарчмыг**, мөн төрийн албан хаагчийн **эрхэмлэх 9 зүйл** (Мягмар.Г, 2022) зэргээр төрийн албаны үнэт зүйлийг илэрхийлжээ. Судлаач төрийн албаны үнэт зүйлийг бодлогын баримт бичгүүдэд хийсэн шинжилгээний дүнд судалгаандаа нийцүүлэн эрхэм зорилго, эрхэмлэх зүйлс, алсын хараа, ёс зүйн хэм хэмжээ, зарчим зэргүүдээс түүвэрлэн сонгож авсан нь Монгол улсад тодорхойлон гаргасан “төрийн албаны үнэт зүйл” албан ёсоор баримтжаагүйг илтгэж байна.

Өнөөдрийг хүртэл хийсэн судалгаануудад төрийн албаны үнэт зүйлийг бие даасан хүчин зүйл болгон ашигласан нь бараг үгүй бөгөөд судлаачид баримт бичигт шинжилгээ хийх замаар төрийн албаны үнэт зүйлийг өөрийн судалгааны зорилгод нийцүүлэн түүвэрлэн сонгож ашиглажээ.

Хэдийгээр төрийн албаны үнэт зүйлс нь эрт үеэс бодлого, суртал, шашин, андгай, тангараг, сахил, сахилгын зарчим, алсын хараа, эрхэм зорилго, горим дүрэм, хууль зэрэгт шингээгдэж (Удирдлагын Академи, 2022) ирсэн түүх, уламжлал, зан заншилтай байсан ч өнөөдөр бид төрийн албаны үнэт зүйлийг Монгол Улсын Үндсэн Хууль, Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн эрхэмлэх зүйлс, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Монгол Улсын Алсын Хараа-2050, Төрийн албаны шинэтгэлийн стратеги болон бусад холбогдох хууль, тогтоол зэрэг бодлогын болон эрх зүйн зарим баримт бичгүүдээс түүвэрлэн өөрийнхөөрөө ойлгон ялгаатай тусгаж авах нь төөрөгдөл үүсгэхээс гадна чухал үзэл санааг орхигдуулах бөгөөд, төрийн албан хаагчийн сэтгэлд буух төрийн албаны нэгдсэн үнэт зүйлийн төсөөлөл үүсэхгүй байгаа нь ёс зүйг зөрчих, зарчмаас ангид үйлдэх зэрэг сэдлийг үүсгэж байж болох юм.

Манай улсын хувьд үнэт зүйлийн судалгаа нь үндэстэн, төрийн алба, нийгэм, улс төр, байгууллага, хувь хүний түвшинд хийгдсэн байна. Үүнд, “Ажилтны үнэт зүйлийн баримжааг харьцуулан судалсан нь” (Оюунтунгалаг.Н, 2023), “Монгол улсын төрийн албан хаагчдын ёс зүйн үнэт зүйлсэд нийгмийн XYZ үеийн онцлог нөлөөлөх нь” (Мягмар.Г, 2022), “Монгол улсын төрийн албаны үнэт зүйлс (эрхэмж), уламжлал” (Долгоржав.Я, Цэдэндамба.С, Билэгсайхан.С, Үүрийнтуяа.Ц, Балжмаа.Х, 2021), “Монголчуудын үнэт зүйлсийн судалгаа” (СУИС, 2019), “Төрийн албаны үнэт зүйлс: тулгамдаж буй асуудлууд” (Удирдлагын Академи З.-ы. х., 2018), “Монгол хүний үнэт зүйл” (Хэрлэн.Б, 2017), “Монголчуудын үндэсний үнэт зүйлийн судалгаа” (СЭЗДС, 2015), “XIII-XIV зууны Монголчуудын ёс суртахууны үнэлэмжийн онцлог” (Золзаяа.М, 2007), Их Монгол улсын үеийн улс төрийн сэтгэлгээ, үнэт зүйлийн зарим асуудал” (Ганбат.Д, 2005), “XIII зууны Монголын төр, эрх зүйн үзэл санаа, түүний үнэт зүйл” (Сэлэнгэ.Х, 2003), “Монголчуудын үнэлэмжийн судалгааны философийн асуудал” (Баатарцогт.Ц, 2000), “Улс төрийн үнэт зүйлийн өөрчлөлт хандлагын зарим асуудал” (Оюунмандах.Б, 1999), “Нийгмийн ардчилсан үнэлэмжийн тогтолцоо” (Чулуунбаатар.Г, 1998), “Монголын залуучуудын орчин үеийн ба уламжлалт үнэт зүйлс” (Цэцэнбилэг.Ц, 1998), “Монголын өнөөгийн улс төрийн өөрчлөлт, иргэншлийн төлөвшлийн харилцан хамаарлын асуудал” (Мандах.Д, 1994) зэрэг судалгаануудад үнэт зүйлийг “үнэт зүйл”, “үнэлэмж”, “эрхэмлэх зүйл”, “эрхэмж” зэрэг ялгаатай нэршлээр нэрлэсэн байгаа бөгөөд тухайн судалгаа философи, улс төр, төрийн удирдлага, сэтгэл судлал зэрэг ялгаатай салбараас шалтгаалан тухайн үнэт зүйлд хамаарах бодит эсвэл хийсвэр ойлголтод тулгуурлан тодорхойлж байна. Эндээс, төрийн удирдлагын чиглэлд хийсэн судалгаанд “төрийн албаны үнэт зүйл” гэдгийг тодорхой болгосон хүрээ хязгаарлалт олдсонгүй.

Түүнчлэн судалгааны арга зүй талаасаа улс төрийн, төрийн албаны болон үндэстний үнэт зүйлийн талаарх судалгаануудыг ихэвчлэн түүхчлэх, логикчлох, жиших, он дараалан судлах, харьцуулах, дедукцийн арга, этнометодологи, герменевтик, детерминизм, кейс судалгааны арга, түүхэн уран зохиолыг ашиглах арга, архивын болон баримт бичгийн судалгаанд шинжилгээ хийх (документ судлал) замаар чанарын судалгаа хийгдсэн бол ТАХ болон ажилтны үнэт зүйлийг Schwarz's Value Survey-SVS, Rokeach Value survey-RVS, VSM2013, КИПА асуулга, анкетын асуулгын арга, ярилцлага, экспертийн үнэлгээ, дараалуулан шинжлэх арга (exploratory sequential design), математик статистикийн шинжилгээ зэрэг аргачлал, арга зүйг ашигласан байх бөгөөд төрийн албаны үнэт зүйлийг ихэвчлэн К.Кернаганы (Kennet Kernaghan, 2003) дөрвөн ангилалд тулгуурлан авч үзжээ.

Үнэт зүйл гэдгийг Монголд хийгдсэн судалгааны хүрээнд авч үзвэл үнэт зүйл гэдэг нь: *“Олон түмний сэтгэлийг эзэмдэн цагийг элээж, ноёлох хүчийг олсон итгэл бөгөөд хүний болон хүй олны үйл ажиллагааны өдөр тутмын болон алсын чигийг зааж, тэдгээрээс өөр хоорондоо болон байгаль, нийгмийн бусад хүрээнд харилцах практик харилцааны хэм хэмжээг тохируулан тодорхой болгож, харьцангуй тогтвортой баримтлагдах зарчим болж байдаг”* (Долгоржав.Я, Цэдэндамба.С, Билэгсайхан.С, Үүрийнтуяа.Ц, Балжмаа.Х, 2021), *“Байгаль, нийгэм, хүний амьдралын үй түмэн үзэгдэлд сэтгэн үйлдэгч тодорхой субъектийн зүгээс хандаж буй хандлага, үзэл бодол, үйл ажиллагааны нийлбэр цогцсыг хамгийн ерөнхий байдлаар нь үнэлэмж хэмээх ойлголтоор илэрхийлж болно”* (Чулуунбаатар.Г, 1998, хуудсд. 16-р тал), *“Үнэт зүйл бол хувь хүн ба бүлгийн өөрийгөө түүнтэй адилтгадаг, тэдний хувьд утга учир бүхий зүйлс, эрхэмлэж байгаа зорилго, авир үйлдлийн арга хэрэгслийн талаарх төсөөлөл”* (Цэцэнбилэг.Ц, 1998, хууд. 33), *“Тодорхой объектоор тэмдэглэн илэрхийлэгддэг, боловсруулан бүтээгдэж түүнд субьектээс өгөгдсөн, иймээс зөвхөн түүнийг өвөр хоорондоо хэрэглэгчдэд ойлгомжтой байдаг субьектив утга”* (Баатарцогт.Ц, 2000), *“Үзлийн (сэтгэлгээний) үнэт зүйл хэмээх ойлголт нь тухайн нийгэм-ахуйн бодит орчин нөхцөл, иргэншил, амьдралын хэв шинж болон нийгэм сэтгэл зүйн дүр төрх, сэтгэх онцлог зэрэг объектив, субьектив хүчний зүйлийн цогц үйлчлэлээр нөхцөлдөн бүрэлдэж бий болсон хүмүүний ертөнц, байгаль нийгэм орчноо ойлгон ухаарах, эргэцүүлэн бясалгах үзэл, төсөөллийн хамгийн гол язгуур шинжүүдийг агуулгадаа багтаасан, дахин давтагдагч, тогтвортой үйлчлэгч, тулгуур ойлголт, баримтлалын төвлөрсөн илрэл”* (Ганбат.Д, 2005, хууд. 102), *“Субьектын оюуны үйлдлээр илэрдэг өвөрмөц маягийн харилцаа мөн”* (Мандах.Д, 1994), *“Аль нэгэн соёлын хүрээнд сайн сайхны тухай төсөөлөл, зан байдал, ёс суртахууны хэм хэмжээ зэргийн тухай төсөөлөл бүрэлдэх хүмүүсийн ертөнцийг үзэх үзлийн өвөрмөц хэлбэр”* (Оюунмандах.Б, 1999, хуудсд. 20, дам ишлэв), *“Хүмүүс их төлөв нийтээр хүлээн зөвшөөрдөг, үйл хөдлөлдөө дагаж мөрддөг нийтлэг жишгүүд”* (Удирдлагын Академи З.-ы. х., Монголчуудын үнэт зүйлийг Шварцийн аргачлалаар тодорхойлсон нь, 2017, хууд. 9), *“Бие хүн юмс үзэгдэлд үнэлгээ өгч, өөрийн хувьд ач холбогдолтой хэмээн үзэж буй зүйл”* (Батсайхан.Б., Дэлгэржав.М, 2015), *“Нийгмийн субьектэд төлөвшиж тогтсон эрхэмлэн хүндэтгэдэг үзэл бодол, итгэл үнэмшилийн цогц, Бодит үйл явдлыг үнэлж цэгнэх шалгуур, Хүмүүсийн амьдрал, үйл ажиллагааны утга учрыг тодорхойлох хүчин зүйл, Нийгмийн харилцан үйлчлэлийн зохицуулагч, Хүний ертөнцийг үзэх үзэл, хандлага, төлөвшлийг чиглүүлэгч, эрхэмлэн дээдлэх дэвшилтэт үзэл баримтлал, чин эрмэлзэл, зарчим, хэм хэмжээ”* (СУИС, Монголчуудын үнэт зүйлсийн судалгаа, 2019, хууд. 13), *“Итгэл үнэмшил, аливаа үйлдэлд хөтөлж чиглүүлэх чухал хамаарал, олон төрлийн хандлага болон зан төлөвийн шалтгаан, ач холбогдлын дэс дараалал, стандарт болон шалгуур, хүсээж буй зорилгоор илэрхийлэгдсэн ямар нэг үйлдэл хийх сэдэл”* (СЭЗДС, 2015, хууд. 7), *“Хүн бүрт хийх үйлдэл, хэлэх үг, гаргах шийдвэртээ баримтлал болгож байдаг итгэл үнэмшил бий. Яаж*

амьдарвал зохилтой, юунд хүрэхийг эрмэлзүүштэй тухай итгэл үнэмшил, үзэл бодлыг үнэт зүйл гэж хэлж болно” (Хэрлэн.Б, 2017), *“Хүмүүсийн ойлголт, хандлага, зан үйлд нөлөө үзүүлдэг хүсэмжит төлөв байдлын тухай үзэл баримтлал бөгөөд субъектив шинжтэй”* (Удирдлагын Академи З.-ы. х., 2018, хууд. 43), *“Хүмүүсийн хэрэгцээтэй, хүсүүштэй, итгэл найдвар болж буй зүйлийн тухай ойлголт. Үнэт зүйлийн үнэлэмж харьцангуй тогтвортой”* (Дэлгэржаргал. Ц, 2024, хуудсд. 566-567) хэмээн тодорхойлж бүтээлүүддээ ашиглажээ. Дээрх судлаачдын үнэт зүйлийг тодорхойлсон агуулгад давтагдсан үг болон утга санааг түүвэрлэн дахин нэгтгэж үзвэл Монгол судлаачдын томъёолж буйгаар үнэт зүйл нь: **“Нийтээр хүлээн зөвшөөрсөн субъектив утга агуулсан, утга учир бүхий эрхэмлэж, дагаж мөрддөг, үйлдлийг чиглүүлэн нөлөөлдөг, харьцангуй тогтвортой итгэл үнэмшил, үзэл бодол, зарчим, хэм хэмжээ, төсөөлөл, ертөнцийг үзэх үзэл юм”**.

Харин 2009 оны 10-р сард Төрийн харилцаа, удирдлагын сургуулиудын үндэсний холбоо (NASPAA) нь төрийн харилцаа, удирдлагын чиглэлээр зэрэг олгодог хөтөлбөрүүдийн магадлан итгэмжлэлийн шинэ стандартыг батлахдаа төрийн албаны үнэт зүйлийг чухалчилж үзжээ. Үүнд уг мэргэжлээр суралцаж буй оюутнууд өдөр тутмын мэргэжлийн үйл ажиллагаандаа төрийн албаны үнэт зүйлийг анхааран үзэх арга хэрэгсэл, чадварт суралцах тухай юм. Тийм ч учраас NASPAA нь магадлан итгэмжлэх үйл явцдаа төрийн албаны үнэт зүйлийг “мэргэжлийн зүрх” хэмээн ойлгуулан таниулахыг эрмэлздэг байна (NASPAA, 2009, хууд. 4). Энэхүү судалгаа нь АНУ-ын Баруун Дундад мужид явуулсан судалгааны үр дүнг танилцуулж, төрийн захиргааны ажилтнуудын ажилд үнэт зүйлс ямар үүрэг гүйцэтгэдэг болохыг судалсан байна. Ингэхдээ асуулгадаа мөн л К.Кернаганы (Kennet Kernaghan, 2003) дөрвөн ангиллыг өргөжүүлсэн байдлаар ашиглажээ.

Төрийн захиргаанд үнэт зүйлсийг төрийн байгууллагын бүтэц, үйл явц, тогтолцоонд хэрхэн нэгтгэж болох тал дээр илүү анхаарал хандуулах хэрэгтэйг онцолсон нийтлэлд (Kernaghan, 2003) Вестминстер хэв загварын дөрвөн засгийн газрын үнэт зүйлийн агуулга болон хэлбэр, мөн үнэт зүйлсийн төрийн албаны үйл ажиллагаанд нөлөөлөх, бусад улс орнуудад сургамж өгөх зэрэг талаас нь оруулсан судалгаа, үр дүнгүүдийг нийтэлжээ. Ингэхдээ засгийн газар нь үнэт зүйлдээ төрийн албаны мөн чанарыг тусгасан байх ёстой, манлайлагчид нь үнэт зүйлд суурилсан зан үйлийн үлгэр жишээ загвар, үнэт зүйлсийн менежментийн чадварлаг мэргэжилтэн байх зэрэг үзэл санаа дэвшүүлсэн. Харин төрийн албаны үнэт зүйлийн ethical, democratic, professional болон people гэсэн 4 ангилалд авч үзжээ. Энэхүү нийтлэлд зарчим болон үнэт зүйл ялгаатай, бүх үнэт зүйл нь ёс зүйн үнэт зүйл биш, харин зөв, буруу гэсэн хандлагын тогтвортой итгэл үнэмшил гэх зэргээр ойлголтуудыг ялгаж салгасан боловч яг төрийн албаны үнэт зүйл (public service value)-ийг тодорхойлсон тодорхойлолт олдсонгүй.

Сүүлийн үед төрийн үйлчилгээг чиглүүлдэг төрийн албаны үнэт зүйлд багтах ёс зүйн үнэт зүйлийн өөрчлөлтийг их судлах болжээ. Үүний нэгэн жишээ бол ялгаатай үеийг оролцуулсан Турк улсын захирагч болон дүүргийн захирагч нарын дунд ёс зүйн үнэт зүйлд гарч буй өөрчлөлтийг илрүүлэх эмпирик судалгаа юм. Үр дүнд төрийн албаны үнэт зүйлд шинээр гарч ирсэн чиг хандлага тийм ч их байгаагүй, өөрөөр хэлбэл ажил хэрэгч үнэлэмж бий болсноор төрийн албаны уламжлалт үнэт зүйлс үнэ цэнээ алдаж, хуучирдаг гэсэн таамаглал дэмжигдээгүй болно. Энэхүү судалгаанд төрийн албаны үнэт зүйлсийг “төрийн удирдлага болон түүний үнэт зүйлийн систем” гэдэг талаас нь хараад, үнэт зүйлийг соёлын контекстийн хүрээнд авч үзэх хэрэгтэй гэжээ (Ugur Omurgonulsen, M. Kemal Oktem, 2009, хууд. 137).

West Chester их сургуулийн Төрийн удирдлагын магистрын зэрэг олгох хөтөлбөр нь ирээдүйн мэргэжилтнийг амжилттай бэлтгэхийн тулд төрийн удирдлага, олон нийтийн харилцааны боловсролын агуулгад төрийн албаны үнэт зүйл (public service

value), төрийн салбарын мэргэжлийн ур чадвар, мэдээллийн мэдлэг (information literacy) хоорондын уялдаа холбоог хангах нь зүйтэй хэмээн хийсэн энэхүү судалгаагаар дээрх гурван зүйлс уялдаатай болох нь тодорхой болжээ. Жишээ нь төрийн албаны үнэт зүйл нь ТАХ-ыг албан тушаалтай холбоотой ажил үүргээ гүйцэтгэх арга замыг тодорхойлж байдаг үнэт зүйл бол мэргэжлийн байдал нь төрийн албыг бусад мэргэшлээс ялгадаг үүрэг бүхий ерөнхий стандарт, мэргэжлийн хэтийн төлөвийг агуулдаг, харин мэдээллийн мэдлэг нь ТАХ олон нийтийн ашиг сонирхолд нийцүүлэн мэдээллийг ашиглах чадварыг хангадаг. Өөрөөр хэлбэл эдгээр гурван агуулгыг хангасан сургалтын хөтөлбөр нь чадварлаг мэргэжилтэн бэлдэхэд хувь нэмэр оруулна хэмээн үзжээ (Turner, 2015, хуудсд. 41, 51). Мөн байгууллагын соёл болон манлайлагч нь үнэт зүйлийг түгээхэд гүйцэтгэх үүргүүдийн хамааралд хийсэн маш олон судалгаа байна. Энэ утгаараа удирдах албан тушаалтны түгээж буй тэрхүү нийтлэг үнэт зүйл нь “байгууллагын нөхцөл байдал болон хүмүүс хоорондын харилцааг ойлгоход хэрэглэгдэх чимээгүй хүч болдог” гэж үздэг байна (Posner, B., & Schmidt, 1994).

Харин олон улсын судлаачдын тодорхойлолтуудыг нэгтгэн үзвэл, үнэт зүйл гэдэг нь: “Юу хүсэгдэж, зөв зүйтэй, сайн эсвэл муу байдаг вэ гэдэг талаар бодгаль хүн болон бүлэг хүний баримталдаг үзэл бодол” (Giddens, 1993, хууд. 747), А.М Лупохув “Хүн юмуу бүлэг хүмүүсийн хувьд байнгын тогтвортой байдаг байгаль, нийгмийн үзэгдэл, үзэн санаа, зарчим, хэм хэмжээ, уламжлал, соёлын өв” (СУИС, Монголчуудын үнэт зүйлсийн судалгаа, 2019, хуудсд. 8, дам ишлэв), Ричард А.Поснер “Хүнийг ямар сонголт хийх, ямар хүнд итгэх, өөрийн цаг, эрч хүчээ юунд зарцуулахад нөлөөлөхийн зэрэгцээ хүний мөн чанарыг тодорхойлдог чухал хүчин зүйл” (Мягмар.Г, 2022, хуудсд. 28, дам ишлэв), Диэн Уильямс “Тогтвортой сайхан амьдрал, сэтгэлийн жинхэнэ ханамж, ажил гүйцэтгэх дээд зэргийн түвшнийг бий болгож байгаа мэдлэг, харилцаа, чадавхи болон бүтээгдсэн зүйлийг багтаасан өргөн хүрээнд томъёолсон” (Уильямс, 2008, хууд. 21), 1 Gerhard Lenski, Jean Lenski нар “Бүлгийн гишүүд нийтээр хүлээн зөвшөөрсөн ёс суртахууны итгэл үнэмшил” (Gerhard Lenski, Jean Lenski, 1987), Smelser “Зорилгын талаарх итгэл үнэмшил” (Smelser, 1994, хууд. 50), David B. Brinkerhoff, Lynn K. White нар “Хүсээж байгаа зорилгын талаарх нэгдмэл үзэл бодол” (David B. Brinkerhoff, Lynn K. White, 1988, хууд. 60), Рэдфиелд “Олон нийтийн үзэл санаатай адилхан амьдрах хүний мөн чанар”, Морис “Амьдралын зам мөр”, Виллиамс “Эрхэмлэх зүйлсийн хэмжүүр, зан төлөвийн баталгаа”, Линтон “Дараалласан нөхцөл байдалд, мэдэгдэхүйц нийтлэг илрэх хувь хүний аливаа нэг бүрэлдэхүүн хэсэг”, Клухоон “Арга зам, бодол санаа болон үйлдлийн үр дүнгийн сонголтод нөлөөлөх хувь хүн болон нийгмийн бүлгийн хүсэн тэмүүлэх онцлог шинжийг тодорхой эсвэл далд утгаар илэрхийлсэн ухагдахуун” (Оюунтунгалаг.Н, 2023, pp. 19, дам ишлэв), Оплер “Соёлын агуулга”, Райт, Хармин, Саймон нар “Олон хувилбаруудаас эргэлзээгүйгээр сонголтыг хийдэг, олон нийтийн зөв гэж хүлээн зөвшөөрсөн, байнга давтагдаж байдаг хувь хүний мэдрэмж, хандлага, итгэл үнэмшил”, Лу Ксиаохэ “Субъектээр баталгаажсан объект”, Шукла “Бидний бие махбодийн болон сэтгэцийн хэрэгцээг хангаж байдаг материаллаг эсвэл материаллаг бус зүйл”, McGuire “Ямар ч тохиолдолд өөрчлөгдөшгүй тогтсон, бие хүний хувьд болон нийгмээрээ хүлээн зөвшөөрсөн итгэл үнэмшилийн цогц” (Оюунтунгалаг.Н, 2023, pp. 20-21, дам ишлэв),

М.Шелер “Хүний үйл ажиллагааны туршилагын хэлбэр” (Оюунмандах.Б, 1999, хуудсд. 13, дам ишлэв), К.Клакхан “Үйл ажиллагааныхаа зорилгыг хэрэгжүүлэхэд бололцоот арга хэрэгслүүдийг сонгох сонголтод нөлөөлөгч бие хүн ба бүлгүүдийн эрхэм хүслийн илэрлээр тодорхойлогдон илэрхийлэгдсэн эсвэл илэрхийлэгдэж буй тэр зүйлс мөн” (Оюунмандах.Б, 1999, хуудсд. 17, дам ишлэв), “Хүний өөртөө хамгийн ач холбогдолтойд тооцож буй тэр зүйл”, Шавьер, Стронг нар “Аливаа зүйлийн үнэ цэнийг нь үнэлэн дүгнэдэг бидний зарчим, хэм хэмжээ”, Фрэнкл “Үнэ цэнийн талаарх үзэл

санаа болон чин эрмэлзэл хоёрын нэгдэл”, Хофстэд “Үйл ажиллагаа нь тодорхой байх эрхэм зорилго”, Бэк “Хүнийг сайн сайхан амьдрахад нь дэмжин тусалж байдаг үйл ажиллагаа, үйлдэл, туршлага зэргийг хэлнэ”, Эндрью “Бидний насан туршийн амьдралд шаардлагатай байх зорилгуудын цогц, өөрөөр хэлбэл бидний амьдралыг хором тутам бүрт утга учиртай болгох гадаад, дотоод хэрэгцээ, шаардлагууд” (Оюунмандах.Б, 1999, хуудсд. 20, дам ишлэв), “Хүн ба нийгмийн зүгээс хүрээлэн буй ертөнцийн юмсын талаарх эерэг сөрөг утгыг илрүүлж байгаа нийгмийн (нийгмийн амьдрал ба байгалийн үзэгдлүүд байдаг ач тус, сайн муу зүйл, сайхан, жигшүүр) өвөрмөц тодорхойлолт” (Философийн нэвтэрхий толь, 1967), М.Рокич “Хувь хүн болон нийгмийн хувьд хүсүүштэй амьдралын талаарх тогтвортой итгэл үнэмшил” (<https://www.valuechange.eu>, 2024), Шварц Шалом “Хүний амьдралд чиглүүлэгч зарчим болдог ач холбогдлын хувьд харилцан адилгүй тогтвортой зорилго” (F. J. R. van de Vijver, A. Chasiotis, & S. M. Breugelmans (Eds.), 2011, p. 464), М. Нараламбос “Ямар нэгэн зүйлийг сайн, хүсүүштэй хэмээн үзэх итгэл үнэмшил”, Mukherjee “Төлөвшүүлэх, суралцах эсвэл нийгэмшүүлэх үйл явцаар дамжуулан бий болсон субъектив сонголт, стандарт, хүсэл эрмэлзэл болдог нийтээр хүлээн зөвшөөрсөн хүсэл, зорилго юм”, Т. W. Hippie “Ухамсартай, ухамсаргүй өдөөгч бөгөөд үйлдэл, дүгнэлтийг зөвтгөх хүчин зүйл юм” (<https://www.scribd.com>, 2024). Эдгээрээс үнэт зүйлийг **“Нийтээр хүлээн зөвшөөрсөн субъектив утга агуулсан, хүсэж тэмүүлж буй утга учир бүхий эрхэмлэж, дагаж мөрддөг үйлдлийг чиглүүлэн, сонголтод нөлөөлдөг, бүтээгдсэн харьцангуй тогтвортой итгэл үнэмшил, ёс суртахуун, үзэл бодол, зарчим, хэм хэмжээ, туршлагын хэлбэр, уламжлал, соёлын өв, сэдэл юм”** хэмээн нэгтгэн томъёолж болох юм.

Төрийн албаны үнэт зүйлийн хувьд олон тодорхойлолт байхгүй ч түүнийг тодорхойлох энэхүү оролдлогууд үүнийг үнэт зүйл гэсэн дан ойлголтоос ялгахыг зорьсонд оршиж байна. Үүнд, Dwight Waldo “Үйл ажиллагааны шалгуур” (Waldo, 1984), Eva Witesman., Lawrence C Waktors., Robert K.Christensen “Хувь хүний үйл ажиллагааны чиглэлийг ерөнхийд нь тодорхойлдог сэтгэл зүйн бүтцэд төвлөрсөн хандлага” (Eva Witesman., Lawrence C Waktors., Robert K.Christensen, 2023, хууд. 7), “Сэтгэл зүйн шинж чанартай бөгөөд олон нийтийн үнэт зүйлс болон хувь хүний үнэт зүйлсийн нийлбэр юм” (Meynhardt, 2009), “Төрийн бодлого, төрийн үйлчилгээг хүргэхэд чиглэгдсэн зарчим, итгэл үнэмшилийг хэлнэ”, “Төрөөс иргэдэд үзүүлж буй үйлчилгээний чанар, үр дүнтэй, үр ашигтай байдалд төвлөрдөг нийтийн үнэ цэнийн илүү тодорхой бөгөөд бодитой тал юм” (Pandey, 2023, хууд. 5) гэжээ. Үүнээс, эхний байдлаар төрийн албаны үнэт зүйл нь хэн нэгэн хувь хүний бодож олсон төсөөлөл, илүүд үзэж, чухалчилдаг хүсэл, хүсэмжит байдал бус харин олон нийтэд чиглэсэн байгааг харж болно.

ОНОЛЫН ХЭСЭГ

Үнэт зүйлийг нэг талаас менежментийн шинжлэх ухааны байгууллагын онолд (organizational theory) “байгууллагын соёлын чухал бүрэлдэхүүн хэсэг, зан үйлийг тодорхойлох, удирдан чиглүүлэх, мэдээлэх хэрэгсэл” хэмээн ерөнхийлөн ойлгодог (Keeley, 1983), (MacCarthaigh, 2008). Үнэт зүйл нь байгууллагын эрхэм зорилгыг бэхжүүлж, үйл ажиллагаанд шууд, эерэг нөлөө үзүүлдэг. Үнэт зүйл нь аливаа ёс зүйн дүрмээс салангид бие даасан хэсэг байх ёстой бөгөөд ёс зүйн хандлага, заавал агуулах шаардлагатай зан үйлийн тодорхойлолттой холилдож, андуурагдаж болохгүй гэж үздэг.

Нөгөө талаас үнэлэмжийн онолд (value theory) эхний үед түүнийг үндэслэгчдийн нэг германы философич Г.Риккерт (1863-1936) үнэлэмжийн тухай ойлголтыг философийн зарим ойлголтын адилаар **үл тодорхойлогдох ойлголт**, харин манай зууны эхэнд М.Вебер “үнэлэмж” гэдэг ойлголтыг тодорхойгүй утгаас хэрэглэж буйгаас үүссэн эмх замбараагүй байдлыг буруутган шүүмжилсэн, М.Натансон “өнөөдөр ч бараг жаран жилийн дараа сайндаа л байдал улам будилаантай болж байна” эрдэмтэн, философичид “үнэлэмж” гэдэг нэр томъёог нэн олон янзын утгаар хэрэглэж, үнэлэмжийн асуудлыг тойрсон маргаан төгсгөлөөсөө нэн хол байна гэжээ (Natanson, 1963, p. 351). Түүнчлэн философич Е.Холл “үнэлэмж гэж юу вэ” гэдэг номынхоо төгсгөлд үнэлэмжийн тухай ойлголтод тодорхойлолт өгөх боломжгүй байгааг дурдаад үнэлэмж гэдэг нь үнэлэмж юм хэмээн түүнийг тодорхойлолгүй орхисон байдаг (Hall, 1961). В.Виндельбанд, Г.Риккерт нарын үзсэнээр бодит байдал нь оршин буй бол үнэлэмж нь утгатай байдаг. “Үнэлэмжийн мөн чанар нь түүний баримтлаг чанар биш, харин түүний **утгат чанарт байдаг**” хэмээн Г.Риккерт бичиж үлдээжээ (Rickert, 1911, хууд. 128).

Гэтэл марксист философид үнэлэмж бол бодитойгоор орших субъектээс үл хамаарах объектын шинж, энэ бодит шинжийг субъект зөвхөн тусган авдаг бөгөөд энэ утгаар нь үнэлэмжийг субъект, объектын харилцаа хэмээн материалист байрнаас тодорхойлж иржээ, харин үүнтэй хэлбэрийн хувьд төстэй чанарын хувьд ялгаатай нэгэн үзэл болох нэгдлийн философид үнэлэмж нь субъект, объектын харилцаа, хүний хүслийг хангаж байгаа объектын шинж гэж үзсэн (Баатарцогт.Ц, 2000, хууд. 12).

Үнэлэмжийн мөн чанарыг нэг талаас түүний **утгат чанар** гэж тайлбарладаг байхад, нөгөө талаа субъект болон объектын харилцаа, объектын шинж зэрэг обьектив хандлагаар, мөн субъектив хандлагын үүднээс үнэлэмж бол “зорилгын талаарх нэгдмэл итгэл үнэмшил” (Smelser, 1994, p. 50), “хүсэж байгаа зорилгын талаарх нэгдмэл үзэл бодол” (David B. Brinkerhoff, Lynn K. White, 1988, p. 60), “бүлгийн гишүүд нийтээр хүлээн зөвшөөрсөн ёс суртахууны итгэл үнэмшил” (Gerhard Lenski, Jean Lenski, 1987), “юу хүсэгдэж, зөв зүйтэй, сайн эсвэл муу байдаг вэ гэдэг талаар бодгаль хүн болон бүлэг хүний баримталдаг үзэл бодол” (Giddens, 1993, хууд. 747) гэх зэргээр авч үзсэн судалгааны ажлууд ч мөн таарч байв.

ДЭВШҮҮЛЭХ САНАЛ

Манай улсын хувьд 1/ “Төрийн албаны үнэт зүйл”-ийг тодорхой болгон тунхагласан албан ёсны баримт бичиг байхгүй, хэдийгээр бодлогын болон бусад хууль, эрх зүйн баримт бичгүүдэд үнэт зүйл гэх нэр томъёо таарсан боловч ямар үг, өгүүлбэрээр илэрч байгааг тусгаагүй, 2/ Зарчим болон үнэт зүйл ялгаатай (Kernaghan, 2003) гэдгийг зарим судлаачид бүтээлдээ онцолсон байхад үнэт зүйл, ёс зүй, зарчим, эрхэмлэх зүйлс зэрэг агуулгад төрийн албаны үнэт зүйлийг багтаан ойлгож буй нь төөрөгдөл үүсгэж байна, 3/ “Үнэт зүйл” нь ялгаатай салбар дахь олон янзын тодорхойлолт бүхий хийсвэр ойлголт болох нь судлаачдад хүндрэл учруулдаг хэмээн үзсэнчлэн (Lepak, D. P., K. G. Smith, and

М. S. Taylor, 2007) “Төрийн албаны үнэт зүйл”-ийн мөн чанар, бүрдэл хэсэг, шинж чанар болон түүнийг илэрхийлэх холбогдох судлагдахуунуудыг шинжлэх ухааны үндэслэлтэй нарийвчлан судалж амжаагүй тул салбар шинжлэх ухаанд хэрэглэгдэх “үнэт зүйл” гэх ойлголтоос ялган төрийн удирдлагын салбарт нэгдсэн тодорхойлолтыг бий болгож түүнийг төрийн албан хаагч, иргэд, судлаачид нэгэн ойлголтоор ашиглах боломж бүрдээгүй, 4/ Төрийн албаны үнэт зүйл нь гагцхүү төрийн албан хаагчдад хамаатай, тэдний баримтлах зүйл бус (Eva Witesman., Lawrence C Waktors., Robert K.Christensen, 2023, p. 9), олон нийт, ард түмнийг ч давхар агуулдаг тул энэ асуудлыг тодорхой болгохгүй бол цаашид бидний урьдчилан харах боломжгүй сөрөг үр дагаврууд гарахыг үгүйсгэх аргагүй.

Цаашлаад, ТАХ нь нийгмийн гишүүн болохынхоо хувьд өөрийн туршлага, боловсрол, төлөвшил, мэргэжлийн сургалт, шашны уламжлал зэрэг олон төрлийн үнэт зүйлсийг өөртөө тээж байдаг (Perry, 1997) мөн төрийн албан хаагчдын ур чадвар, хандлага, зан үйлд төрийн албаны үнэт зүйл өргөнөөр илэрдэг (NASPAA, 2009, p. 392) гэсэн санааг нэгтгэн харвал тухайн төрийн албан хаагч хувь хүний үнэт зүйлдээ төрийн албаны үнэт зүйлийг шингээж, түүнд баримжаалж ажиллах хэрэгтэй гэсэн үг. Тэгэхээр тэрхүү төрийн албаны үнэт зүйл нь юу гэдгийг тодорхой болгож тунхагласнаар үнэт зүйл амь орж өөрийн үүргийг гүйцэтгэх нөхцөл бүрдэнэ. Учир нь үнэт зүйлийг өөриймшүүлэх үед ухамсартай эсвэл ухамсаргүйгээр үйл ажиллагааг удирдан чиглүүлэх, холбогдох объект, нөхцөл байдалд хандах хандлагыг төлөвшүүлэх, хадгалах, өөрийн болон бусдын үйлдэл, хандлагыг зөвтгөх, өөрийгөө болон бусдыг ёс суртахууны хувьд дүгнэх, өөрийгөө бусадтай харьцуулах стандарт буюу шалгуур нь болдог (NASPAA, 2009, p. 377) хэмээн үздэг.

Түүнчлэн, ЭЗХАХБ-ын орнуудын гуравны нэгээс илүү хувь нь сүүлийн таван жилийн хугацаанд төрийн албаны үнэт зүйлээ шинэчилж, уг шинэчлэлийн явцад улс орнууд өөрсдийн "уламжлалт" үнэт зүйлсийг дахин тодорхой болгож, түүнийг орчин үеийн агуулгаар баяжуулан, үр дүнд суурилсан төрийн үйлчилгээний соёлыг тусгахын тулд “шинэ” үнэт зүйлсийг нэмж оруулсан байна (OECD, 2000, хууд. 2). Тиймээс төрийн албан хаагчийн үнэт зүйлд баримжаалсан шийдвэр гаргалт нь тэднийг ард иргэдийнхээ сайн сайхны төлөө зүтгэж, авлигаас ангид, ёс зүйтэй, зарчмаа баримталж, тангаргаа зөрчихгүй байж, төрдөө үнэнч зүтгэх боломжийг олгох суурь болдог тул орчин цагийн төрийн удирдлагын үзэл санаанд нийцсэн, Монгол улсын эрхэм зорилгыг хангаж, алсын хараа, бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэхэд дэмнэх “төрийн албаны үнэт зүйл” хэмээх ойлголтыг шинжлэх ухааны үндэслэлтэй тодорхойлж үүнийгээ хүн төрөлхтний болон Монгол улсын нийгэм, үндэсний онцлогийг судалж төрийн албаны уламжлалтай хослуулан тодорхой болгох зайлшгүй хэрэгцээ шаардлага үүсэж байгааг дээрх бүгдээс харж болно.

Эцэст нь, 2021 онд хийсэн “Монгол улсын төрийн албаны үнэт зүйлс (эрхэмж), уламжлал” судалгаанд *“олон улсын туршлагаас харахад аливаа улс гадаадын сайн туршлагыг хуулбарлан авахаас илүүгээр өөрийн орны нөхцөл байдалд тохирсон, үе улиран өвлөгдөж ирсэн төрийн албаны уламжлал, түүний үнэт зүйлсийг орчин үеийн глобалчлалын хүчин зүйлтэй хослуулан хэрэглэх нь үр дүнд хүргэж байгаа нь тодорхой байна. Иймд, төрийн албаныхаа уламжлал, үнэт зүйлсийг түүхэн эх сурвалждаа тулгуурлан гаргаж ирэх явдал хойшлуулишгүй асуудал болж байна”* хэмээн онцолсон нь судлаачийн зүгээс дэвшүүлж буй санааг баталж байгааг нэмж дурдах нь зүйтэй санагдлаа.

НОМ ЗҮЙ

- "Алсын хараа-2050", М.-ы. у.-2. (2023). legalinfo.mn:https://legalinfo.mn/mn/detail?lawId=211058&showType=1-ээс Гаргасан
- Төрийн албаны тухай хууль, ш. н. (2017). www.legalinfo.mn:https://www.legalinfo.mn/mn/detail/13025-ээс Гаргасан
- Төрийн албаны тухай хууль, ш. н. (2017). www.legalinfo.mn:https://www.legalinfo.mn/mn/detail/13025-ээс Гаргасан
- Монгол улсын төрийн албаны шинэтгэлийн дунд хугацааны стратеги, М. У. (2004). https://mrt.d.gov.mn:https://mrt.d.gov.mn/upload/files/Hunii_Noots/Төрийн%20албаны%20шинэтгэлийн%20дунд%20хугацааны%20стратегии.pdf-ээс Гаргасан
- Занданшатар.Г., У.-ы. д. (Гүйцэтгэгч). (2023 оны 4 3). *Төр гэж юу вэ, түүний алба хаагчид ямар зарчмыг мөрдлөг болгож, эрх, үүргээ хэрэгжүүлэх ёстой вэ.* Инноваци танхим, Төрийн албаны зөвлөл, Улаанбаатар, Монгол.
- Мягмар.Г. (2022). *Монгол Улсын төрийн албан хаагчдын ёс зүйн үнэт зүйлсэд нийгмийн ХҮЗ үеийн онцлог нөлөөлөх нь.* Докторын Диссертаци, Монгол Улсын Их Сургууль, Улаанбаатар.
- Хэрлэн.Б, Түдэв.Ш, Санжмятав.Ч. (2018). *Төрийн албаны үнэт зүйлс : тулгамдаж буй асуудлууд.* Улаанбаатар: "Мөнхийн үсэг" ХХК.
- Долгоржав.Я, Цэдэндамба.С, Билэгсайхан.С, Үүрийнтуяа.Ц, Балжмаа.Х. (2021). *Монгол улсын төрийн албаны үнэт зүйлс (эрхэмж), уламжлал.* Улаанбаатар: "Мөнхийн үсэг" ХХК.
- NASPAА. (2009 оны 10 16). *Accreditation Standards for Master's Degree Programs.* <https://www.naspa.org/sites/default/files/docs/2019-04/2014-chea-application.pdf>, National Association of Schools of Public Affairs and Administration. <http://www.naspa.org/accreditation/doc/NS2009FinalVote10.16.2009.pdf-ээс> Гаргасан
- Posner, В., & Schmidt. (1994). An updated look at the values of federal government executives. *Public Administration Review*, 54(1), 24.
- Natanson, М. (1963). *Philosophy of the Social Sciences: A Reader.* New York.
- Hall, E. W. (1961). *What is value.*
- Rickert, Н. (1911). *Sciences of Nature and Sciences of Culture.*
- Smelser, N. J. (1994). *Sociology.* Blackwell ; Unesco, Cambridge, Mass., USA, [Paris], 1994.
- David В. Brinkerhoff, Lynn К. White. (1988). *Sociology.* West Publishing Company.
- Giddens, А. (1993). *Sociology.* Polity Press.
- Чулуунбаатар.Г. (1998). Нийгмийн ардчилсан үнэлэмжийн тогтолцоо. *Шинэ толь*, 3(23), 16-р тал.
- Хэрлэн.Б. (2017). Монгол хүний үнэт зүйлс. *Үнэт зүйлсийн онол практикийн хурал.*
- Цэцэнбилэг.Ц. (1998). *Монголын залуучуудын орчин үеийн ба уламжлалт үнэт зүйлс.* Диссертаци.
- Мандах.Д. (1994). *Монголын өнөөгийн улс төрийн өөрчлөлт, иргэний төлөвшилийн харилцан хамаарлын асуудал.*
- Оюунмандах.Б. (1999). *Улс төрийн үнэт зүйлийн өөрчлөлт хандлагын зарим асуудал.* Thesis, МУИС, Социологийн тэнхим, Улаанбаатар.
- Баатарцогт.Ц. (2000). *Монголчуудын үнэлэмжийн судалгааны философийн асуудал.* Монгол Улсын Их Сургууль, Философи, шашин судлалын тэнхим. Улаанбаатар: МУИС. ШУС. НУС Философи, шашин судлалын тэнхим.
- Чулуунбаатар.Г. (1998). Нийгмийн ардчилсан үнэлэмжийн тогтолцоо. *Шинэ толь*, 3(23), 16-р тал.

- Оюунтунгалаг.Н. (2023). *Ажилтны үнэт зүйлийн баримжааг харьцуулан судалсан нь*. Thesis, МУИС-НШУС, Боловсрол, Сэтгэл Судлалын Тэнхим, Улаанбаатар.
- Ганбат.Д. (2005). *Их Монгол улсын үеийн улс төрийн сэтгэлгээ, үнэт зүйлийн зарим асуудал*. Диссертаци, МУБИС.
- Удирдлагын Академи, З.-ы. х. (2017). *Монголчуудын үнэт зүйлийг Шварцийн аргачлалаар тодорхойлсон нь*. Судалгааны тайлан, Удирдлагын академи, Сэтгэл зүй, судалгааны арга зүй.
- СУИС. (2019). *Монголчуудын үнэт зүйлсийн судалгаа*. Судалгааны тайлан.
- СУИС. (2019). *Монголчуудын үнэт зүйлсийн судалгаа*. Судалгааны тайлан.
- Уильямс, Д. (2008). *Удирдан дагуулах увидас*.
- СЭЗДС. (2015). *Монголчуудын үндэсний үнэт зүйлсийн судалгаа*. Судалгааны тайлан.
- Удирдлагын Академи, З.-ы. х. (2018). *Төрийн албаны үнэт зүйл: Тулгамдаж буй асуудлууд*. Судалгааны тайлан.
- F. J. R. van de Vijver, A. Chasiotis, & S. M. Breugelmans (Eds.). (2011). *Fundamental questions in cross-cultural psychology*. S. H. Schwartz-Д, *Values: Cultural and individual*. Cambridge University Press.
- Төрийн албаны зөвлөл, НҮБХХ. (2022 оны 08 22). <https://www.old.csc.gov.mn:https://www.old.csc.gov.mn/s/44/1268-ээс> Гаргасан
- Сэлэнгэ.Х. (2003). *XIII зууны Монголын төр, эрх зүйн үзэл санаа, түүний үнэт зүйл*. Диссертаци, МУИС-ХЗИС, Эрх зүй, төрийн онол-түүх, Улаанбаатар.
- Удирдлагын Академи. (2022). *Төрийн удирдлага онол, арга зүй*(18), 11.
- Золзаяа.М. (2007). *XIII-XIV зууны Монголчуудын ёс суртахууны үнэлэмжийн онцлог*. Диссертаци, МУИС-НШУС, Философийн тэнхим, Улаанбаатар.
- Kernaghan, K. (2003). Integrating Values into Public Service: The Value Statement as Centerpiece. *Public Administration Review*, 63(6), 711-719, <https://www.jstor.org/stable/3542466>.
- Ugur Omurgonulsen, M. Kemal Oktem. (2009 оны 08 01). Is There Any Change in the Public Service Values of Different Generations of Public Administrators? The Case of Turkish Governors and District Governors. *Journal of Business Ethics*, 88(1), 137-156.
- Turner, A. H. (2015). Instilling Public Service Values and Professionalism Through Information Literacy. *Journal of Public Affairs Education*, 21(1), 41-54, Stable URL: <https://www.jstor.org/stable/24369703>.
- Дэлгэржаргал. Ц. (2024). Үнэт зүйл. А. А. Алтанчимэг.З.-Д, *Захиргааны шинжлэх ухааны нэр томъёоны тайлбар толь* (Б. 2). Улаанбаатар: Мөнхийн үсэг ХХК.
- MacCarthaigh, M. (2008). *Public Service Values*. (www.ipa.ie, Хян.) Lansdowne Road Dublin 4 Ireland: Institute of Public Administration.
- OECD, P. M. (2000). <https://www.oecd.org:https://www.oecd.org/mena/governance/35527481.pdf>-ээс Гаргасан
- Eva Witesman., Lawrence C Waktors., Robert K.Christensen. (2023). https://www.researchgate.net:https://www.researchgate.net/publication/370976671_Creating_a_public_service_topology_Mapping_public_service_motivation_public_service_ethos_and_public_service_values-ээс Гаргасан
- Meynhardt, T. (2009). Public value inside: what is public value creation? . *International Journal of Public Administration*, 32(3– 4), 192–219. Meynhardt, T. (2009) Public value inside: what is public value creation? *International Journal of Public Administration*, 32(3– 4), 192–219.-ээс Гаргасан
- Pandey, J. K. (2023 оны 10). Evaluating public service value within collaborative e-governance: a study in the Indian context. *Digital Transformation and Society*, 5, <https://www.researchgate.net/publication/375084403>.

- Gerhard Lenski, Jean Lenski. (1987). *Human Societies: An Introduction to Macrosociology*. McGraw-Hill.
- Gerhard Lenski, Jean Lenski. (1987). *Human Societies: An Introduction to Macrosociology*. McGraw-Hill.
- Философийн нэвтэрхий толь. (1967).
- (2024). <https://www.valuechange.eu>: (<https://www.valuechange.eu>, 2024)-ээс Гаргасан
- (2024). <https://www.scribd.com>: (<https://www.scribd.com>, 2024)-ээс Гаргасан
- Waldo, D. (1984). *The administrative state: A study of the political theory of public administration (2nd ed)*. New York: New York: Holmes & Meier.
- Lepak, D. P., K. G. Smith, and M. S. Taylor. (2007). Value Creation and Value Capture: A Multilevel Perspective. *Academy of Management Review* , 32(1), 180–194. <https://doi.org/10.5465/amr.2007.23464011>.
- Keeley, M. (1983). Values in organizational theory and management education. *The Academy of Management Review*, 8(3), 376–386. <https://doi.org/10.2307/257826>.
- Perry, J. (1997). Antecedents of public service motivation. *Journal of Public Administration Research and Theory*, 7(2), 181-198.
- Батсайхан.Б., Дэлгэржав.М. (2015). *Байгууллагын сэтгэл судлал*. Улаанбаатар.
- Төрийн албаны зөвлөл, НҮБХХ. (2022 оны 07 08). *Төрийн албаны үнэт зүйлд суурилсан байгууллагын соёл сэдэвт уулзалт*. <https://www.old.csc.gov.mn>: <https://www.old.csc.gov.mn/s/44/1244>-ээс Гаргасан
- Төрийн албаны зөвлөл, НҮБХХ. (2022 оны 08 01). *Үр дүнд чиглэсэн, үнэт зүйлд суурилсан хамтын ажиллагаа өргөжлөө*. <https://www.old.csc.gov.mn>: <https://www.old.csc.gov.mn/s/44/1247>-ээс Гаргасан
- Төрийн албаны зөвлөл, НҮБХХ. (2022 оны 09 10). *Хувь хүний өөрчлөлт байгууллага, салбар, хамт олны өөрчлөлтөд нөлөөлнө* . <https://www.old.csc.gov.mn>: <https://www.old.csc.gov.mn/s/44/1281>-ээс Гаргасан

SPSIRPA FORUM 2024

Poster presentation 9

Enhancing governance effectiveness on local administration



**“ОРОН НУТГИЙН ЗАСАГЛАЛЫН ҮР АШГИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ НЬ”
СУДАЛГАА**

/Монгол Улсын жишээн дээр/

СУДЛААЧ: Болдбаатарын ОЮУНБОЛД¹ /Докторант/

¹ Булган аймаг, ИТХ, Нарийн бичгийн дарга, МУИС, УТСОУХНУС, НУТ,
Докторант

СУДАЛГААНЫ АЖЛЫН ХУРААНГУЙ

Хөгжлийн тогтвортой, хүртээмжтэй өсөлтийг бий болгоход засаглалын үр ашгийг нэмэгдүүлэх асуудал нэн чухал үүрэгтэй. Ардчилсан нийгэмд шилжээд дөнгөж 32 жил болж байгаа, төрийн тогтолцооны хувьд бүрэн төлөвшөөгүй, байгалийн асар их баялагтай, хөгжлийн боломжууд ихтэй манай улсын хувьд засаглалын чанараас их зүйл хамаарна.

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс “сайн засаглал”-ын шинж байдлыг иргэдийн өргөн оролцоог хангах, хууль дээдлэх ёсонд үндэслэн шийдвэр гаргах, гүйцэтгэх засаглалын үйл ажиллагаа ил тод явагдах, нийгмийн хэрэгцээ, сонирхлыг мэдрэх, бүх иргэдэд тэгш хандах, төрийн сангийн эх үүсвэрийг үр ашигтай, үр нөлөөтэй зарцуулах, улс төрийн хариуцлагатай байх, хөгжлийн төлөвлөлтөд алсын хараатай хандах явдал хэмээн тодорхойлсон байна

Харин “сул засаглал” нь олон сувгаар дамжуулан хөрөнгө оруулалтын орчныг муутгаж, гадаадын шууд хөрөнгө оруулалтыг түлхэх, төсвийн сахилга батгүй байдлаас үүдэн улсын өр нэмэгдэх зэрэг сөрөг үр дагавар бий болно.

Энэ хүрээнд авилгыг устгах, хуулийг бүх нийтээр даган мөрддөг болох, шүүхийн шударга тогтолцоо бүрдэх, төсвийн сахилга бат, засаглалын үр ашгийг нэмэгдүүлэх, бүх шатанд үйл ажиллагааны бие даасан байдлыг бэхжүүлэх шаардлага тавигдаж байна.

Засаглал, тэр дундаа хөдөө орон нутгийн засаглалын үр ашгийг тогтмол тооцдог тусгайлсан тайлан судалгаанууд хараахан гараагүй. Өнөөдөр дэлхийн улс орнуудын засаглалын үр ашгийг Дэлхийн өрсөлдөх чадварын төв /IMD/ судалж байгаа бол, хөдөө орон нутгийн /аймгуудын/ засаглалын үр ашгийг Монгол Улсын Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв тооцон тайлагнаж байна. Эдгээр нь тухай улс орнууд болон орон нутгуудын эдийн засгийн өрсөлдөх чадварын ерөнхий тайланд нэг үзүүлэлт болон судлагдаж байна.

Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төвөөс орон нутаг буюу аймагуудын өрсөлдөх чадварын судалгааг анх 2012 оноос эхлэн гаргаж байна. Энэ нь хот хөдөөгийн ялгаа, тэгш бус байдлыг арилгах асуудалд олон нийтийн анхаарлыг хандуулах, бодлого боловсруулагчдыг судалгааны бодитой мэдээллээр хангах, улмаар аймагуудын засаглалын үр ашгийг нэмэгдүүлэх, өрсөлдөх чадварыг сайжруулахад хувь нэмрээ оруулахад зорьсон ажил хэмээн тодорхойлсон.

Орон нутгийн өрсөлдөх чадварын судалгаан дээр үндэслэн тэдгээрийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд ЗАСАГЛАЛЫН ҮР АШГИЙГ дээшлүүлэх, түүнийг бүрдүүлж буй хүчин зүйлүүд болох Институцийн тогтолцоо, Нийгмийн тогтолцоо, Бизнесийн эрх зүйн орчин, Орон нутгийн төсөвт эерэг болон сөргөөр нөлөөлж байгаа хүчин зүйлүүдийг тодорхойлох, хамгийн чухал нөлөөлөгч хүчин зүйлийг судлан, улмаар оновчтой, зөв зохицуулалттай болгох талаар дүгнэлт санал дэвшүүлэв.

Түлхүүр үгс: Өрсөлдөх чадвар, Засаглал, Үр ашиг, Зорилгоор удирдахуй, Сонгууль

I. Засаглал, түүний үр ашгийн онолын ойлголт

Засаглал хэмээх ойлголт нь ерөнхийдөө улс төр, эрх зүйн нэр томъёо юм. Түүний нэршлийн агуулгын тодорхойлолт дээр судлаачид олон төрлийн байр суурийг илэрхийлдэг.

Монгол хэлний утга зүйн хувьд авч үзвэл, "засаг" гэдэг зүйлийн үйлдэж буй явцыг "засаглал" гэж ойлгож байгаа юм. Харин орчуулгын утга зүйн хувьд "power", "governance" "кратос" гэдэг огт өөр үгнүүдийг "засаглал" гэж орчуулж байна.²

Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлалд: "Засаглал гэдэг нь улс орныг удирдах төрийн эрх барьдаг тогтолцоо юм. Засаглал нь хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх хэсгээс бүрдэнэ". хэмээх ойлголтоор тусгагдсан.

Ер нь засаглалын тухай ойлголт нь хэлбэр /Ардчилсан, Авторитар, Тоталитар/, төрлөөсөө /Хууль тогтоох, Гүйцэтгэх, Шүүх/ хамаарч янз бүрийн агуулгыг өөртөө багтаасан өргөн ойлголт юм. Эрдэмтэн Макс Вебер "Эдийн засаг ба нийгэм" номондоо "Улс төрийн үндсэн асуудал нь засаглалд оролцох, түүнийг эзэмшихтэй салшгүй холбоотой ба ЗАСАГЛАЛ бол нэг нь нөгөөгөө захирах ухагдахуун юм." хэмээн тодорхойлжээ. АНУ-ын улс төр судлаач Фрэнсис Фукуяма "Төр засаг нь өөрсдийн дагаж мөрдөх хуулиа боловсруулах, түүнийгээ хэрэгжүүлэх бас ардчилсан эсэхээс үл хамааран үйлчилгээгээ ард иргэдэд хүргэх чадвар юм" хэмээжээ.

Мөн Засаглалыг "Нэр хүнд, эрх мэдэл, албадлага зэрэг хэрэгслийн тусламжтайгаар нэг хэсэг хүмүүс нийтээрээ дагаж мөрдөх ёстой шийдвэрийг гаргах боломж чадвараар хамгаалагдсан харилцаа юм" хэмээн тодорхойлсон ч байдаг билээ.

Судлаач Д.Цэрэндорж Засаглалын тулгуур асуудлууд нийтлэлдээ: Засаглалыг эдийн засаг, улс төр, захиргааны байгууллагуудын улс орныг бүх түвшинд удирдах үйл ажиллагаа гэж үзэж болно. *Эдийн засгийн засаглал* нь улс орны эдийн засгийн үйл ажиллагаа, бусад орнуудтай тогтоосон эдийн засгийн харилцааны талаар шийдвэр гаргах үйл явцыг хамарна. Энэ нь шударга ёс, ядуурал, амьдралын түвшинд голчлон нөлөөлнө. *Улс төрийн засаглал* нь бодлого боловсруулах талаар шийдвэр гаргах үйл явц. Харин *Захиргааны засаглал* нь улс төр, нийгэм, эдийн засгийн харилцааг чиглүүлэх бүтцийг ойлгоно хэмээн тусгажээ.³

Орон нутгийн засаглалын тухайд Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулиудад зааснаар манай улсын хувьд орон нутагт засаглалын эрхийг тухайн аймаг, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, түүний харьяаны хэлтэс агентлагууд хэрэгжүүлж байна.

Иймд дээрхи институтууд нь үйл ажиллагааны ил тод байдлыг хангах, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх, гаргаж буй бодлого шийдвэрээ оновчтой тодорхойлох, түүнд олон нийтийн оролцоог хангах, хууль дүрмийг сахиулах, хариуцлага, шудрага ёсыг эрхэмлэх нь орон нутгийн засаглалын үр ашгийг нэмэгдүүлэх чухал хэмжүүр болж байна.

Дээрхи олон төрлийн үзэл баримтлалууд болон тодорхойлолтуудаас үр ашигтай засаглал гэдэг нь маш тодорхой бүтцэд хуваагдаж, нарийн зохион байгуулагдсан, уг бүтцүүд нь юу хийж чадах, ямар үр дүнд хүрэх ёстойгоо тодорхойлсон, тэдгээрийн явуулж буй үйл ажиллагаа нь алсын хараатай, бүтээмжтэй олон нийгэд хүртээмжтэй, ил тод, хариуцлагатай байх тухай ойлголт хэмээн дүгнэж байна.

II. Засаглалын үр ашгийн Олон улсын туршлагаас

Засаглалын үр ашгийг нэмэгдүүлсэн олон улсын сайн туршлагууд маш их байдаг. Миний бие энэхүү судалгааны ажлынхаа жишээ болгон Сингапур, Солонгос улсуудын жишээг энд иш татлаа.

Засаглалын үр ашгийг нэмэгдүүлсэн Сингапур улсын жишээ. 1942 оны дайнд маш ихээр нэрвэгдсэн, Япончуудын эзлэн түрэмгийлэлд ихээхэн зовлон зүдгүүр амссан, байгалийн баялаггүй, ердөө 640 км/кв газар нутагтай, цэвэр усаа хүртэл худалдаж хэрэглэдэг, үндэсний хүчтэй үзэл бүхий том улсуудаар хүрээлэгдсэн улс хэрхэн гуравдагч ертөнцийн үсрэнгүй хөгжилд хүрсэн хэд хэдэн шалтгаантай. Эдгээрийн эхнийх нь хуулийн засаглалыг дээд зэргээр сахиулсан улс юм. Аливаа том, жижиг зөрчлүүд, гадаад дотоодын иргэд, хөрөнгө оруулагчид, төрийн өндөр дээд албан тушаалтан хэн ч бай Сингапур улсын хууль бүх хүнд тэгш үйлчлэх болно гэсэн үзэл санаагаар хандсан нь энэ улсад засаглалын үр ашиг үлэмж нэмэгдэхэд нөлөөлсөн.⁴

Нэгэн жишээ: “Ерөнхий сайд Ли Куан Ю-г өөрт огт хамааралгүй нэгэн барилгын компанийн тендэртэй холбоотой асуудалд холбон парламентын хуралдаанаар авч хэлэлцэх үеэр Ли удирдагч өөрийн хэлсэн үгэндээ: *Миний бүтээж босгосон систем миний үйлдлийг шалган, дүгнэлт гаргаж байгаа нь уг системийг хараат бус, үр дүнтэй ажиллаж байгааг харуулж, хэн ч хуулиас дээгүүр эрхгүй гэдгийг баталж өглөө*” хэмээн хэлж байсан. Энэ мэт хууль ёсыг сахиулсан олон баримт жишээнүүд нь Дэлхийн Эдийн Засгийн Форумас эрхлэн гаргадаг “Дэлхийн өрсөлдөх чадварын тайлан”-д Сингапур улс “*Бизнес эрхлэхэд гэмт хэрэг, ноцтой бэрхшээл учруулдаггүй*” гэж тэмдэглэн 1-р байрт эрэмбэлэгдсэн байлаа. Мөн Удирдлагын Хөгжлийн Олон Улсын Институтээс гаргадаг “Дэлхийн өрсөлдөх чадварын жил тутмын эмхэтгэл”-д “*Өөрийн болон эд хөрөнгийн аюулгүй байдлын талаар ард иргэд нь бүрэн итгэлтэй*” гэдгээрээ Сингапур улс аюулгүй байдлын түвшнээр 1997 онд дэлхийд бас тэргүүн байр эзэлж байжээ.

Итгэлцэл. Засаглалын үр ашгийг нэмэгдүүлэхэд үлэмж ихээр нөлөөлөх бас нэгэн чухал хүчин зүйл нь итгэлцэл. Институцийн тогтолцоо бэхжих суурийг нь хүртэл итгэлцэл тавидаг юм. Засгийн газрын тэргүүн нь сайд нартаа, сайд нар нь албан тушаалтнууддаа үзүүлэх итгэл нь тэднийг шийдвэрүүдээ итгэл төгс гаргаж, цэх шударга ажиллах, улмаар төрийн байгууллагын ажилд иргэдийн итгэл нэмэгдэж, гадны орны томоохон хөрөнгө оруулагчид өөрсдийн салбаруудаа байгуулан, татварын бааз суурь, шууд ажлын байр нэмэгдэн, улс орныхоо хөгжлийн асуудлыг шийдсэн сайн туршлагыг нэрлэж болно.

Улс орон болгон өөрсдийн засаглалын үр ашгийг сайжруулсан сайн туршлагатай. Бүгд найрамдах Солонгос улсын хувьд дайны дараах жилүүдэд улс орондоо нүүрлэсэн ядуурал, өлсгөлөн, туйлын хүнд амьдралаас өнөөдрийн соёлт ертөнцийг бий болгох сайн

туршлага олон байсан. Хамгийн чухал нь сахилга баттай, сайн засаглал оршсон учраас л энэ амжилтанд хүрсэн. 1962-1979 оны хооронд тус улсыг удирдсан ноён Пак Жөнхы. *“Нэгэн үеийнхэний орших хугацаа хязгаартай ч, нэгэн улс үндэстний оршин байх хугацаа мөнх. Өнөөдөр бидний үеийн хөлсөө урсгаж бүтээн цогцлоохоор зорьж буй бүхэн зөвхөн өөрсдөө мөр бүтэн, гэдэс цатгалан явах гэсэнд бус, энэ бүгдийг хойч үедээ өвлүүлэн өгч, улс үндэстнээ мөнхөд сэргээн мандуулахын төлөөх үйлс юм шүү”* хэмээн хэлсэн нь энэ удирдагчийн үзэл санааг бүрэн илтгэн харуулах буй заа.

Пак ерөнхийлөгчийн Солонгос улсыг удирдсан 18 жилийн засаглалын нэг чухал зүйл нь “brief-ing” буюу “товч тайлан” сонсох байсан. Брифинг өөртөө 4 үе шатыг агуулдаг бөгөөд нэгдүгээр үе шат нь үндсэн чиг баримтлалаа боловсруулах юм. Өөрөөр хэлбэл өнөөдрийн нөхцөлд гол төлөв яригддаг төрийн бодлогын үндсэн чиглэл хэмээн ойлгож болно. Энэ нь өмнөд Солонгосын хөгжлийн суурь бодлого буюу эдийн засгаа хөгжүүлэх үндсэн үзэл баримтлал нь байсан. Ард иргэдийнхээ амьдралыг дээшлүүлсэн, ажлын байруудыг нэмэгдүүлж, экспортыг нэн тэргүүнд тавин улс орноо үйлдвэржүүлсэн, аж үйлдвэрүүдээ экспортын чиг баримжаатай болгосон, шинжлэх ухаан, боловсролын хөгжил, Хойд Солонгосын сөргөлдөөнд ялж, өндөр технологийг эзэмшсэн, хөгжингүй орнуудын эгнээнд элсэн орсон зэрэг бүх амжилтуудын үндэс нь үндсэн чиг баримтлалаа зөв боловсруулсан явдал юм. Хоёрдугаар үе шат нь үндсэн зарчмаа тогтоох юм. Энэ нь төрийн захиргааны хувьд “бодлого боловсруулах үе шат” хэмээн ойлгож болно. Тухайн улс орны хөгжлийн стратегийг хэрэгжүүлэх олон арга зам байж болох ч өөрийн улсын бодит байдалд хамгийн тохиромжтой, ухаалаг, үр дүнтэй хэрэгжүүлэх боломжтой арга зам нь боловсруулах үе шат мөн. Гуравдугаар үе шат нь нарийвчилсан төлөвлөгөө боловсруулах юм. Энэ төлөвлөгөө яаман дээр боловсруулагдана. Ингэж батлагдсан төлөвлөгөөг сайдын хариуцлага доор хэрэгжүүлэх бөгөөд төлөвлөгөө амжилттай хэрэгжвэл уг яамны гавьяа, бүтэлгүйтвэл хариуцлагаа хүлээх хэрэгтэй болно. Чухамдаа төсөл тэр чигтээ яамны эрх мэдэл, хариуцлага дор хэрэгжинэ. Өнөөдөр хөдөө орон нутагт, магадгүй манай улсад интитуцын тогтолцоо бэхжиж чадахгүй байгаагийн тод жишээ нь дээрхи эрх мэдэл, хариуцлагын системийг бүрэн гүйцэт нэвтрүүлэхгүй, зөвхөн удирдах албан тушаалтанд, орон нутагт бол шууд утгаараа Засаг даргад бүгдийг нь хариуцуулж байгаа нь л алдаа болж байна. Дөрөвдүгээр үе шат нь хэрэгжүүлэх үе юм. Аливаа зам харгуй, үйлдвэр, барилгын шав тавих ёслолд Пак ерөнхийлөгч өөрийн биеэр очиж, газар дээр нь асуудлыг нь сонсож, шийддэг байсан нь төрийн бүх шатанд аливаа төслийг явуулахад амар хялбар, бас үр дүнтэй хэрэгждэг шалтгаан нь болдог байсан.⁵

Энэхүү өвөрмөц засаглалын үр дүнд Бүгд Найрамдах Солонгос улс экспортын чиг баримжаатай олон том үйлдвэрүүдийг босгож, олон арван сая ажлын байр бий болгон, шинэ тосгон хөдөлгөөнөө амжилттай хэрэгжүүлэн, өөрсдийн онцлогтой хөгжлийн загвараа бүтээж чадсан юм.

² Ш.Батсүх “Төрийн захиргаа, Засаглал”. 2017

³ Д.Цэрэндорж “Засаглалын тулгуур асуудлууд” 2017

⁴ Ли Куан Ю “Сингапурын хөгжлийн нууц” 4 дэх хэвлэл 2017

⁵ О Вөнчол “Солонгосын сэргэн мандал” 2013

Ш. Орон нутгийн засаглалын үр ашигт нөлөөлж буй хүчин зүйлс, тулгамдаж буй асуудлууд

Дээр дурьдсанчлан орон нутгийн засаглалын үр ашгийг тооцох шалгуур үзүүлэлтүүдээс харахад хөдөө орон нутгуудад засаглалын үр ашиг муу байна.

Орон нутгийн засаглалын үр ашигт маш олон хүчин зүйлүүд сөргөөр нөлөөлж байгаа нь дамжиггүй. Миний хувьд “Орон нутгийн засаглалын үр ашгийг нэмэгдүүлэх нь” судалгааны хүрээнд дараахь хүчин зүйлүүд засаглалын үр ашигт сөргөөр нөлөөлж байна хэмээн үзэж байна. Үүнд:

Хүнд суртал:

Монголын Үндэсний Худалдаа аж үйлдвэрийн танхим нь 2004 оноос анх “Хүнд суртлын тайлан”-г эрхлэн гаргасан бөгөөд 2015 он хүртэл хоёр жил тутамд гаргаж ирсэн. 2018 оноос энэхүү хүнд суртлын индексийг илүү бодитой, нарийвчилж гаргах, төрийн байгууллага бүрээр хүнд суртлын индексийг тооцож, харьцуулах зорилгоор шинэ аргачлал нэвтрүүлэн ажиллаж байна. ⁶

2022 оны судалгааны үр дүнг өмнөх жилүүдийн /2018 он/ судалгааны үр дүнтэй харьцуулахад 0.18 нэгжээр буурсан буюу Бизнес эрхлэгчид цар тахлын өмнөх үетэй харьцуулахад төрийн үйлчилгээний хүнд суртал ихэссэн гэж үзжээ.

Тухайн орон нутгийн бодлого шийдвэр гаргах үйл явцад бизнес эрхлэгчдийн оролцоо хангалтгүй хэмээн дүгнэсэн бол, төрийн үйлчилгээг түргэн шуурхай, чанартай хүргэхэд төрийн албан хаагчдын ёс зүй, харилцаа хандлагын судалгаанд хамрагдсан хүмүүсийн ердөө 17 хувь нь сайн, үлдсэн 83 хувь нь ДУНД БОЛОН МУУ хэмээн дүгнэсэн бөгөөд төрийн байгууллагуудын хоорондын уялдаа хангалтгүй байна хэмээжээ.

Бизнес эрхлэгчдийн 90 орчим хувь нь төрийн нэг үйлчилгээ авахдаа дунджаар 6 баримт бичиг бүрдүүлж, 3 төрийн албан хаагчтай харьцаж, 13 хоног зарцуулж, 360 мянган төгрөгийн албан зардал гаргадаг байна. Мөн судалгаанд оролцогчдын 45% нь төрийн үйлчилгээг авахдаа ямар нэг албан бус зардал гаргасан бөгөөд дунджаар 219 мянган төгрөг зарцуулсан.

Судалгаанд оролцсон бизнес эрхлэгчдийн 15.6% буюу 94 бизнес эрхлэгч төрийн аль нэг үйлчилгээ авах явцад хууль, дүрэм журам зөрчигдсөн гэж хариулсан. Мөн эдгээр 94 аж ахуйн нэгжийн 32 нь үйлчилгээтэй холбоотой гомдол гаргасан бол тухайн гомдлын дөнгөж 8-ийг нь зохих журмын дагуу шийдвэрлэсэн.

Төрийн үйлчилгээнд барилга, зам, худалдаа, боловсрол, эрүүл мэнд, аялал жуулчлалын салбарын бизнес эрхлэгчид хамгийн муу үнэлгээ өгсөн ба эдгээр салбарын бизнесүүдэд төрийн үйлчилгээ авахад хүнд суртал илүү их байна хэмээжээ.



Эх сурвалж: МҮХАҮТ-ын 2022 оны Хүнд сурталын тайлан

Авилга хээл хахууль:

Авилгатай тэмцэх газраас жил бүр эрхлэн гаргадаг “Шудрага байдлын үнэлгээ”-ний 2022 оны тайланд аймаг, нийслэлийн 22 Засаг даргын Тамгын газрын ердөө 8 нь улсын дунджаас дээгүүр үнэлгээтэй, 14 нь доогуур үнэлгээ авчээ. ⁷

Эдгээр 22 ЗДТГ-ын үнэлгээг 2019 онтой харьцуулахад 9 байгууллагынх сайжирсан, харин үлдсэн 13 байгууллагынх буурсан байв.

Аймгуудын хувьд улсын дундаж үнэлгээнээс доогуур үзүүлэлттэй тооцогдох дараах хэдэн шалтгаан байна. Үүнд:

- Төрийн байгууллагуудын “Дотоод шудрага байдлын үнэлгээ”-ний хувьд төрийн удирдах албан тушаалтнууд төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулсан буюу төрийн байгууллагад ажиллагсдын оролцсон судалгаа
- Төрийн байгууллагуудын “Гадаад шудрага байдлын үнэлгээ”-ний хувьд шудрага, ил тод байдлын судалгаанд хангалтгүй үнэлгээ авсан буюу төрийн байгууллагаар үйлчлүүлсэн иргэдийн сэтгэл ханамжийн судалгаа
- Төрийн байгууллагуудын “Бодлогод оролцогчдын үнэлгээ”-нд тухайн байгууллагын /аймгийн ЗДТГ/ харьяа дээд байгууллагын төлөөлөл, бодлого боловсруулагч болон төрийн бус байгууллага, хувийн хэвшил, холбоодын төлөөлөл, аудитор, хяналтын ажилтан, хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтан, сэтгүүлч, эрдэмтэн, судлаачдын төлөөллийг хамруулсан. Энэхүү үнэлгээг авлигын талаарх төсөөлөл, авлигын хяналт, авлигын бодит тохиолдол, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл зэрэг үзүүлэлтүүдийн дунджаар тооцсон болно.

Эдгээр шалтгаан нөхцлүүд бол төрийн байгууллагын үйлдэл, эс үйлдэхүйгээр гарч байгаа үзүүлэлтүүд байна. Харин авилгатай холбоотой бас нэгэн асуудал нь хувийн хэвشلүүд, аж ахуйн нэгжүүдээс төрийн байгууллагад авилга өгөх асуудлыг бас ярих нь зүйтэй. Тухайлбал өөрсдийн ажлаа хурдан шуурхай амжилттай бүтээх хүсэл эрмэлзэлтэй компаниудын төрийн удирдах албан тушаалтнуудад тавих авилгын санал, түүнтэй холбоотой гомдол мэдээллийн улмаас орон нутгийн томоохон бүтээн байгуулалтууд



Эх сурвалж: АТГ, Хүнд суртлын тайлан

хугацаандаа баригдаж, ашиглалтанд орохгүй, эрх бүхий ажлынх нь хажуугаар Авилгатай тэмцэх газрын төлөвлөгөөт бус шалгалтууд тодорхой хэмжээгээр саад учруулж, орон нутгийн засаглалын үзэл санааг сулруулж байна.

Дээрхи шалтгаан нөхцлүүдээс дүгнэн үзэхэд иргэн, ААНБ-ын төлөөллийн хувьд албан хаагчдын ёс зүйгүй байдал, хүнд суртал, үйлчлүүлэгчдийн ажлаа хурдан шуурхай, амжилттай бүтээх хүсэл, авлига авсан болон өгсөн хүнд хариуцлага тооцдоггүй тогтолцоо зэрэг нь манай нийгмийн авлигын шалтгаан, нөхцөл болж байна хэмээн үзэж буй нь түлхүү ажиглагдаж байна.

Мөн ядуурал, эдийн засгийн тогтворгүй байдал, албан тушаал, эрх мэдлээ урвуулан ашигладаг байдал, хуулийн хэрэгжилт, зохицуулалт сул, улс төр, намын нөлөө их, иргэдийн авлигын талаарх мэдлэг, мэдээлэл дутмаг, ил тод бус байдал, ажилгүйдэл болон ажлын байрны хомсдол зэрэг нь авлигын шалтгаан, нөхцөл хэмээн үзэж болно.

Төрийн нэгдмэл бодлого дутмаг:

Орон нутгийн нэгдмэл бодлого дутагдаж байна. Засаглал солигдох болгонд тэргүүлэх чиглэлүүд өөрчлөгдөж, судалгаа шинжилгээгүй, эдийн засгийн үр ашиггүй хөрөнгө оруулалт, байшин барилга, хашаа саравч, худаг ус, техник тоног төхөөрөмжүүд үлдэж байна.

Орон нутгийн хөгжлийн бодлого төлөвлөлт, түүнд нийцүүлэн гаргасан бодлогын баримт бичгүүд үр дүнгүй болох, хэрэгжилтгүй байдалд хэд хэдэн хүчин зүйлүүд нөлөөлж байна.

Үүнд:

- Улс төрийн намуудын хоорондын үзэл бодлын ялгаа, асуудалд хандах хандлагын зөрүү
- Тооцоо судалгаа хангалтгүй

- Хөгжлийн бодлого төлөвлөлт, Төрийн албаны тухай хуулиудын өөрчлөлтүүдтэй цаг хугацааны хувьд давхцсан
- Монгол улсын урт хугацааны бодлогын баримт бичгүүдийн өөрчлөлт, шинэчилсэн найруулга, түүнийг даган гарсан тогтоол, журмуудын улмаас хүчингүй болсон
- Бодлогын баримт бичиг бүхэнд өөрийн орон нутгийн нэгдмэл байдал, уялдаа холбоо, бодлогын залгамж халаа зэрэг үндсэн асуудлуудаа тусгаж, өөрийн орон нутгийн ард иргэдийн нийтлэг үнэт зүйлсээ тодорхойлоогүй.

Эдгээр асуудлууд нь тухайн орон нутгийн бодлогын нэгдмэл байдал, засаглалын үр ашгийг сулруулж байгаа бөгөөд тухайн орон нутгийн ард иргэдийн зан байдал, аливаа амьдралын асуудлуудад хандах хандлага, төрийн байгууллагуудын уялдаа холбооны давуу чанаруудыг илтгэсэн нийтлэг үнэт зүйлсээ оновчтой, зөв тодорхойлж, бодлогын залгамж, халааг алдагдуулахгүй байх асуудлаар улс төрийн намууд, үе үеийн Засаг дарга нарын харилцан ойлголцол чухал байна.

Улс төрийн сонгуулийн нөлөө:

1992 оны Шинэ Үндсэн хуулийн үзэл баримтлалаар Нутгийн Өөрөө Удирдах Ёс үүсэн байгуулагдаад 8 удаагийн орон нутгийн сонгууль болсон. 7 удаагийн сонгууль нь Мажоритар буюу ердийн олонхын зарчмаар хамгийн олон санал авсан нэр дэвшигч тухайн орон нутгийн ИТХ-д суудал авдаг систем юм. Энэ системийн сул тал одоо ч Засаглалын үр ашигт сөргөөр нөлөөлж байна. Учир нь сонгогдсон төлөөллүүд өөрийн тойргийн сонгогчдод таалагдах, улс төрийн ритенгээ өсгөж, оноо авах зорилготойгоор аливаа асуудалд хэтэрхий явцуу ханддаг, урт хугацааны хөгжлийн бодлогын асуудал хэлэлцэх нь эдгээр төлөөллүүдэд эрсдэлтэй хэмээн үздэг байна.

Тийм учир хурдан хугацаанд, тодруулбал өөрсдийнх нь тухайн орон нутгийн ард иргэдийг төлөөлж буй хугацаанд /сонгуулийн 4 жил/ үр дүнгээ өгөх ажил үйлчилгээг гүйцэтгэх, хийж хэрэгжүүлэх сонирхол нь их байгаа нь ажиглагдаж байна. Тухайлбал аймгийн ИТХ нь тухайн жилийн 12 дугаар сарын 05-ны дотор багтаан өөрийн аймгийн дараа жилийн төсвөө батлах хуулийн хугацаатай. Төлөөлөгч бүр өөр, өөрийн тойрогт том жижиг асуудлуудыг шийдэх зорилгоор төсвийн асуудалд оролцдог. Энэ нь орон нутгийн тухайд бүх сум, суурин, салбаруудад хүртээх маягаар хуваарилаж, нэгдсэн төсвийг үр ашиггүй олон жижиг бараа, ажил үйлчилгээнүүдэд зарцуулж, аймгийн урт хугацааны бодлогын хэрэгжилтэнд сөргөөр нөлөөлдөг практик нөхцөл байдал үүсээд удаж байна.

Нөгөөтэйгүүр дээр дурьдсанчлан сүүлийн жилүүдэд улс төрийн сонгуулийн үр дүнгээс шалтгаалан үүсч байгаа нэг сөрөг тал нь төрийн жинхэнэ албан хаагчдыг улс төрийн шалтгаанаар үндэслэлгүйгээр ажлаас халах, чөлөөлөх асуудал байна. Тодруулбал 2012 оны сонгуулиас хойш бүр их ажиглагдах болсон. Учир нь мажоритар тогтолцооны үр дүнгээс хамаарч хөдөө орон нутгуудад нэг намын /тухайн үеийн МАХН/ засаглал олон жил болсон газруудад 2012 онд болсон сонгуулийн холимог буюу пропорциональ, мажоритар хосолсон системийн үр дүнгээр сөрөг хүчин болох

Ардчилсан нам олон аймаг, хотуудад ялалт байгуулсан. Ингээд ялсан намын Засаг даргаар томилогдсон албан тушаалтнууд өмнөх засгийн үед ажиллаж байсан төрийн албан хаагчдыг ажлаас нь чөлөөлсөн тохиолдол ихээр гарсан.

Гэхдээ бодит байдал дээр ажиглагдаж байгаа бас нэг асуудал нь дан ганц улс төрийн албан хаагчид төрийн байгууллагын тогтвор суурьшилтай байдлыг алдагдуулаагүй гэдгийг хэлэх нь зүйтэй. Төрийн албан хаагчид зарим тохиолдолд өөрсдөө улс төржиж, төрийн ажлын болон тухайн байгууллагын дотоод асуудал, нууцын зэрэглэлтэй баримт материалуудыг улс төрийн намуудад дамжуулах, мэдээллэх, төрийн албан хаагчийн тангарагаа зөрчин улс төрийн намуудын үйл хэрэгт оролцох, төрийн албан хаагчдыг улс төрийн үзэл бодлоор нь ялгаварлах, албан хаагчдыг үзэл бодлоор нь хуваан, бие бие рүү нь турхирах зэрэг ёс зүй, хэм хэмжээний доголдол гаргаж байна.

⁶ МҮХАҮТ, Хүнд суртлын тайлан. 2022

⁷ Авилгатай тэмцэх газар, Шудрага байдлын үнэлгээний тайлан. 2022

IV. Орон нутгийн засаглалын үр ашиг, өрсөлдөх чадварт тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх арга замууд

Орон нутгийн засаглалын үр ашгийг нэмэгдүүлэхэд тулгамдаж буй асуудлуудыг дараах арга замуудаар шийдвэрлэх боломжтой. Үүнд:

Удирдах албан тушаалтнуудын манлайлал:

Засаглалын үр ашгийг нэмэгдүүлэх арга замуудын хамгийн чухал нь улс төрийн албан тушаалтнуудын манлайлал юм. Ер нь удирдах ажилтны болон улс төрийн албан тушаалтнуудын манлайллын талаар олон лекц сургалтын хөтөлбөрүүд байдаг ч амьдрал дээр нотлогдож, үр дүнгээ өгч байгаа нь харагдахгүй байна. Ийм учир энэ асуудал нь ерөнхийдөө аль нэг онол, эсвэл хууль дүрмээр зохицуулагдахаас илүүтэйгээр, аливаа явуулж буй үйл хэрэгтээ тууштай баримталдаг зарчим, итгэл үнэмшил, шийдэмгий дайчин зан, уян хатан шийдвэрүүд, цаг үеийн өөрчлөлтийг даган байнга шинийг сурч, өөрчлөгдөх, өсөн дэвждэг чадвар, мятрашгүй итгэл найдвар зэрэг цэвэр хүний хүчин зүйлээс хамаарах асуудлуудыг өөртөө шингээж чадсан удирдагчдын түүх, тухайн улс орны төрт ёсны сайн уламжлал зэргээр байнга нөхөн төлжиж, түүнийгээ ургуулан баяжуулж, дараа үедээ өвлүүлэн үлдээж байдаг чанар юм.

Энэхүү манлайлал нь удирдагч хүн “Өөрийн орон нутгийн ард иргэдийн нийтлэг үнэт зүйлсийг сайтар ойлгохоос эхлээд бусдад үзүүлэх итгэл, өөрөө юу хүсч байгаагаа мэргэжилтнүүд, албан хаагчиддаа бүрэн гүйцэт ойлгуулж, тэдэнд итгэх, тэднийг өөрсдөдөө итгэх итгэлийг төрүүлэх, тэдэнтэй хамт ямар амжилт гаргах, хэн юуг хариуцах зэрэг ЗОРИЛГООР УДИРДАХУЙН ухаанд суралцах” нь туйлын чухал байна.

Түүнчлэн засаглалын үр ашгийн үзүүлэлтийг бууруулж байгаа авилга, хээл хахуулийн асуудлыг удирдах албан тушаалтнууд таслан зогсоох боломжтой. Мөн төрийн байгууллагуудын үйл ажиллагааг иргэн төвтэй, түргэн шуурхай, хүнд сурталгүй үйлчлэх нөхцлийг хангахад орон нутгийн удирдлагын манлайлал зайлшгүй хэрэгтэй.

Израйл улсын Ерөнхийлөгч асан Шимон Пэрэсийн “*Лидер хүн хэтэрхий их олон талын эрх ашгийг бодож, бөөрөнхий байгаад байхаар хөгжлийн асуулууд урагшилдаггүй*” хэмээн хэлсэнчлэн орон нутгийн удирдлагууд зөвхөн дөрвөн жилийн улс төрийн хугацааг умартан, улс төрийн янз бүрийн нөлөөнд үл автан орон нутгийн хөгжилд хамгийн чухал асуудлуудаа тодотгон, түүнийг хэрэгжүүлэхийн төлөө тууштай ажиллах нь ач холбогдолтой.

Удирдах албан тушаалтнууд дээрхи асуудлуудад манлайлж чадвал засаглалын үр ашгийн үзүүлэлтүүд нэмэгдэж, сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлүүд арилна.

Хамтын ажиллагаа, уялдаа холбоог сайжруулах.

Засаглалын үр ашгийг нэмэгдүүлэхэд бодлогын хувьд заавал дэвшил гаргаж ажиллах ёстой асуудал нь төр, иргэний нийгмийн байгууллагуудын хамтын ажиллагаа, төр, хувийн хэвшлийн түншлэл, төрийн байгууллагуудын хоорондын үйл ажиллагааны уялдааг сайжруулах явдал юм.

Иргэний нийгмийн байгууллагууд болон нутгийн захиргааны байгууллагуудын хамтын ажиллагааны үр дүнд нийгмийн өмнө тулгарч буй асуудлуудын талаарх оролцогч талуудын мэдрэмж сайжирна. Захиргааны байгууллагад иргэдийн өмнө тулгарч буй бэрхшээл асуудлын талаар олон нийтийн буюу иргэний нийгмийн байгууллагын тусламжтайгаар мэдээллийн эх сурвалж нээгддэг. Тэд тулгарч буй асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар оновчтой санал гарган улмаар захиргааны байгууллагын ачааллыг бууруулахад хувь нэмрээ оруулдаг.⁸

Харин төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд төр засгийн дэвшүүлсэн хөгжлийн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд гол цөм нь хувийн хэвшил байх ёстой. Төр нь хувийн хэвшилтэйгээ хэрхэн ил тод, нээлттэй хамтарч чадахаас хөгжлийн асуудлууд хурдацтай урагшилна. Төр өөрийн хийж хэрэгжүүлэх ажлаа хувийн хэвшлээр хийлгэх учир төсвийн ачаалал багасна. Нөгөөтэйгүүр хувийн хэвшил өөрийн бизнесээ эрсдэл багатай, урт хугацаанд явуулах орчин бүрдэнэ.⁹

Ингэснээр тухайн орон нутаг нь эдийн засаг, дэд бүтэц, хөдөлмөр эрхлэлт зэрэг асуудлаа хувийн хэвшлүүдтэй түншлэлийн хүрээнд, харин нийгмийн бусад бүхий л асуудлаа иргэний нийгмийн байгууллагуудтай хамтын ажиллагааны хүрээнд шийддэг үр дүнтэй тогтолцоонд шилжинэ. Хамгийн чухал нь орон нутгийн захиргааны байгууллага, тэдгээрийн удирдлагуудын манлайлал чухал гэдгийг мартаж болохгүй.

Засаглалын үр ашгийг нэмэгдүүлэхэд төрийн байгууллага хоорондын уялдаа холбоо чухал байна. Эрүүл мэнд, боловсрол, гэр бүл, хүүхэд залуучууд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчилгээ үзүүлдэг төрийн захиргааны байгууллагууд болон дэд

бүтэц, худалдаа үйлчилгээ зэрэг орон нутгийн татварын бааз суурийг нэмэгдүүлж, эдийн засгийг тэлэх салбаруудад бодлого боловсруулдаг, хэрэгжүүлдэг, хяналт тавьдаг төрийн захиргааны байгууллагуудын уялдааг сайтар хангах, орон нутгийн удирдлагаар хангадаг аймгийн Засаг даргын Тамгын газар нь хууль дүрмийн хүрээнд тэдний уялдаа холбоотой ажиллах чиглэлээр санаачлагатай, хурдтай шуурхай ажиллах шаардлагатай байна.

Институцын тогтолцоог бэхжүүлэх.

Засаг даргын дэргэдэх бодлогын хэлтсүүд, тэнд ажилладаг мэргэжилтнүүдийн ажил үүрэг хэтэрхий явцуу байна. Тэдэнд өөрсдөө шийдвэр гаргах эрх, хариуцлага хүлээх эрх зүйн зохицуулалтуудыг нээх шаардлагатай байна. Орон нутагт шинээр ажлын байр бий болгох, худалдаа үйлчилгээний цэгүүдэд түр болон тусгай зөвшөөрлүүдийг олгох, салбарын холбогдолтой дүрэм журмуудыг боловсруулах, түүнийгээ хурал дээр тайлагнах зэрэг эрх мэдэл, хариуцлагын тогтолцоог бий болгох шаардлагатай. Бодит байдал дээр зөвхөн бодлогын хэлтсүүд, тухайн салбарын агентлагууд, бодлогын мэргэжилтнүүд шийдчих бүрэн боломжтой маш олон асуудлууд Засаг даргын нуруун дээр ирж, ажлын бүтээмжийг зарим талаар үгүй хийж, гадаад дотоодын хөрөнгө оруулалт татах, сайн туршлагатай газруудад ажиллаж, амжилттай хэрэгжсэн төсөл хөтөлбөрүүдтэй танилцах, судлах, өөрийн орон нутгийн онцлогт нийцүүлэн хэрэгжүүлэх, улмаар ажлын байр шинээр бий болж, иргэдийн орлогыг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн гол гол ажлууд орхигдож байна.

Иймд хууль дүрмийн хүрээнд орон нутгийн удирдлага, хэлтэс агентлагууд, бодлогын мэргэжилтнүүдийн эрх мэдэл, ажил үүргийг оновчтой хуваарилаж төрийн бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх институцыг бэхжүүлэх нь төр засгийн төв байгууллагын шийдвэрлэх хүчин зүйл мөн. Хэрэвзээ институц бэхжээгүй газар бодлого шийдвэрүүд үр нөлөөгүй, цаашлаад сөрөг үр дагаварт хүргэдэг.

⁸ Н.Бурмаа. Төрийн хяналт, хариуцлага. 2022

⁹ Зууны мэдээ сонин. 228. 2 дахь тал. 2022

V. Дүгнэлт

Засаглалын тухай ойлголтыг эрдэмтэн судлаачид олон янзаар тайлбарлаж ирсэн. Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлалд: "Засаглал гэдэг нь улс орныг удирдах төрийн эрх барьдаг тогтолцоо юм. Засаглал нь хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх хэсгээс бүрдэнэ". хэмээх ойлголтоор тусгагдсан. Харин орон нутгийн засаглалын үр ашгийг нэмэгдүүлэх асуудлаар одоогоор тухайлсан судалгаа байхгүй бөгөөд олон улсын тухайд Дэлхийн өрсөлдөх чадварын төв /IMD/-ийн тухайн жилийн улс орнуудын эдийн засгийн өрсөлдөх чадварын судалгааны нэг хэсэг болж, Монгол Улсын тухайд мөн адил тухайн

жилийн эдийн засгийн өрсөлдөх чадварын нэг үзүүлэлт болгож Монгол Улсын Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төвийн тайланд тусгагдан гарч байдаг. Тэгвэл Африк тивийн зарим ядуу буурай улс орнуудад засаглалын үр ашгийг нэмэгдүүлэх тухай судалгаа хийгддэг. Гэхдээ энэ нь тухайн улсын хөгжлийн асуудалд хандсан зүйл биш, зөвхөн донор орнууд өөрсдийн тухайн улсуудад хандивладаг тусламжийн үр ашгийг тооцох зорилгоор явуулдаг байна.

Иймд орон нутгийн засаглалын үр ашгийг нэмэгдүүлэх судалгааг өрсөлдөх чадварын тоон үзүүлэлтүүдэд тулгуурлаж, энэхүү судалгаатай холбоотойгоор АТГ, МҮХАҮТ зэрэг байгууллагуудын тухайн жилийн тайланг ашигласан болно.

Орон нутгийн удирдах байгууллагын үндсэн үүрэг нь ард иргэдийн эрүүл, аюулгүй, сайн сайхан амьдралд чиглэгддэг. Орон нутгийн засаглал үр ашиг, үр нөлөөтэй ажиллаж чадахгүй байгаа хүчин зүйлсээ оновчтой тодорхойлох, сайжруулахын тулд зөв менежмент хэрэгжүүлэх шаардлагатай байна. Удирдлагын манлайллын хувьд хамгийн гол анхаарах зүйлс нь мэдлэг боловсрол, шинийг санаачлах, түүнийг үр дүнтэй хэрэгжүүлэх, хариуцлага хүлээх, харьяа хэлтэс агентлагуудад зарим тохиолдолд хууль дүрмийн хүрээнд бие даан шийдвэр гаргах эрхийг олгох нь чухал болоод байна.

Энэхүү судалгаанаас авч үзэхэд засаглалын үр ашгийг дээшлүүлэхэд тодорхой төрлийн ажлууд хийгдэж байгаа ч энэ асуудлыг цогцоор нь шийдэх, тулгамдаж буй асуудлуудыг гол цөмийг олж тогтоон, түүнийг арилгах ажлыг орон нутагт онцгой анхааралдаа авах, эрчимжүүлэх шаардлагатай байна. Хэдийгээр зарим хууль эрх зүйн зохицуулалтууд, түүнээс шалтгаалсан нийгэм, эдийн засгийн нөхцөл зэрэг гадаад хүчин зүйлсийн нөлөөлөл бусад хүчин зүйлсээсээ бага байгаа нь орон нутаг өөрийн удирдлагын манлайлал, сэтгэлгээний өөрчлөлт, төрийн байгууллагуудын хүнд суртал, хоорондын уялдаа холбоо, мөн төр хувийн хэвшлийн түншлэл, төр иргэний нийгмийн байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулахад чиглэж, ирээдүйд эдгээр асуудлуудад илүү анхаарч ажиллах шаардлагатай байгааг илтгэж байна.

Ном зүй

Монгол хэл дээрх ном, сурвалжууд:

- Монгол Улсын Их Хурал “Алсын хараа – 2050” урт хугацааны бодлогын баримт бичиг. 2020
- МУИС ОУХНУС Нийтийн удирдлагын тэнхим “Нийтийн удирдлагын үндэс”. УБ. 2018
- Н.Бурмаа “Төрийн хяналт, хариуцлага” 2022

- МУИС “Төрийн албан хаагчийн ширээний ном” 2020
- Ш.Батсүх “Төрийн захиргаа, Засаглал” 2017
- Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв “Аймгуудын өрсөлдөх чадварын тайлан” 2021
- С.Энхсайхан “Төрийн байгууллагын бүтээмж” 2018
- Т.Дорж, Я.Эрхэмбаяр “Бүтээмж ба чанарын удирдлага” 2021
- Райли, Бенжамин “Монгол Улсын сонгуулийн тогтолцооны шинэчлэл, тогтолцооны хувилбарууд” 2010 он

Орчуулгын ном, бүтээлүүд:

- Гадаад хэлний хэвлэлийн газар ХХК “ШИ Жин Пин. Төр улсыг засах тухай” 2019
- Ж.Батгөр, Л.Долгормаа, Б.Ганцэцэг “О Вөнчол. Солонгосын сэргэн мандал” 2013
- Ц.Мөнх-Оргил “Шимон Пэрэс. Томоор мөрөөд” 2017
- Н.Монголмаа “Ли Куан Ю. Сингапурын хөгжлийн нууц” 2017
- Б.Оюнчимэг “Жэймс Робинсон. Улс үндэстний уналт, доройлтын шалтгаан” 2016

Хууль эрх зүй:

- Монгол улсын үндсэн хууль. <https://www.legalinfo.mn/law/details/367>
- Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16106891904801>
- Төрийн албаны тухай хууль. <https://www.legalinfo.mn/law/details/13025>

Цахим сурвалжууд:

- Авилгатай тэмцэх газар. Авилгын төсөөллийн төсөөллийн индекс. <https://iaac.mn/post/91180>
- Монголын Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим. Хүнд сурталын индекс. https://resource4.sodonsolution.org/mongolchamber/File/2019/10/17/kgmdw7wnaabkz9hk/2_Sudalgaanii%20tailan_final_V20181224_web.pdf
- Дэлхийн өрсөлдөх чадварын төвийн 2021 оны тайлан. 2022. <https://imd.cld.bz/IMD-World-Competitiveness-Booklet-2022/22/>
- Төрийн албаны зөвлөлийн сонгон шалгаруулалтын зарлал. 2022 <https://hh.csc.gov.mn/>
- Булган аймгийн албан ёсны вэйбсайт. 2022. <http://bulgan.gov.mn/web/101.htm>